



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 8 дугаар сарын 16-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-9
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	10-237
<hr/>	
1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх	10-139
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	139-168
3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	169-230
4. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	230-233
5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлт	233-237

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
08 дугаар сарын 16-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 05 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар, Д.Ганмаа, Б.Мөнхсоёл, Б.Уянга;

Чөлөөтэй: Б.Бат-Эрдэнэ, Д.Бум-Очир, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн, Г.Хосбаяр;

Тасалсан: Э.Бат-Амгалан, Д.Батлут, Х.Баттулга, Д.Ганбат, С.Лүндэг, М.Нарантуяа-Нара;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-48 минут, О.Алтангэрэл-01 минут, С.Амарсайхан-04 минут, Ч.Анар-3 цаг 51 минут, Ц.Баатархүү-17 минут, Д.Батбаяр-03 минут, Н.Батсүмбэрэл-6 цаг 01 минут, Б.Батцэцэг-03 минут, П.Батчимэг-19 минут, Ж.Баярмаа-03 минут, Х.Болормаа-04 минут, Э.Болормаа-05 минут, Ш.Бямбасүрэн-2 цаг 10 минут, С.Бямбацогт-03 минут, Л.Гантөмөр-05 минут, Ц.Даваасүрэн-04 минут, Т.Доржханд-05 минут, Б.Дэлгэрсайхан-10 минут, Б.Жаргалан-28 минут, Д.Жаргалсайхан-50 минут, Ж.Золжаргал-10 минут, Л.Мөнхбаатар-29 минут, Ц.Мөнхбат-47 минут, Л.Мөнхбаясгалан-06 минут, О.Номинчимэг-06 минут, Э.Одбаяр-22 минут, С.Одонтуяа-01 минут, Д.Пүрэвдаваа-04 минут, Б.Тулга-2 цаг 22 минут, А.Ундраа-08 минут, Ч.Ундррам-05 минут, Н.Учрал-03 минут, Дам.Цогтбаатар-2 цаг 25 минут, С.Эрдэнэбат-58 минут.

Нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар,

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Баттулга, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Мөнхтүшиг, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Цолмон, мөн газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Л.Балчинлуvsан, мөн газрын Салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга О.Энхмөнх, Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Гадаад харилцааны яамны Америк, Ойрх дорнод, арлын орнуудын газрын захирал А.Ананд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газрын дарга Ц.Уранчимэг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Гантулга, мөн яамны Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын орон сууц санхүүжилтийн хэлтсийн дарга Э.Батболд, Зам, тээврийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Н.Наранбаатар, О.Цогтгэрэл, Ч.Ундрам, Э.Батшугар, Б.Энхбаяр, З.Мэндсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Н.Номтойбаяр, Х.Ганхуяг, А.Ариунзаяа, Д.Рэгдэл, Д.Үүрийнтуяа, Х.Баасанжаргал, Ц.Сандаг-Очир, Н.Алтанхуяг, П.Сайнзориг, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, С.Ганбаатар, Б.Пүрэвдорж, Х.Тэмүүжин, Г.Лувсанжамц, О.Амгаланбаатар, У.Отгонбаяр, Л.Мөнхбаясгалан, М.Энхцэцэг, Д.Энхтүвшин, С.Эрдэнэболд, М.Мандхай, Ж.Баярмаа, М.Бадамсүрэн, Ц.Мөнхтуяа нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Монгол Улсын сайд, Засгийн

газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Боловсролын сайд П.Наранбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу товлосон асуудлыг ажлын цагт багтаан хэлэлцэж дуусаагүй тул хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хуралдааны цагийг сунгав./16:53/

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа 17 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Б.Батбаатар, Х.Жангабыл, Э.Болормаа, Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Ц.Мөнхбат, Б.Жаргалан, Б.Бейсен, О.Цогтгэрэл, Р.Сэддорж, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, С.Замира, Л.Мөнхбаясгалан, Д.Энхтүвшин, О.Батнайрамдал, Г.Очирбат, С.Эрдэнэболд, С.Зулпхар, С.Эрдэнэбат, Ж.Галбадрах, Д.Үүрийнтуяа, А.Ганбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 18 цаг 10 минутаас хуралдааныг даргалав.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын болон бусад Байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Л.Мөнхцацрал, Ю.Энхтуяа, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Л.Отгонтуяа, Н.Ууганбаатар, Ж.Дэлгэрсайхан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

М.Санжаадорж, Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга Д.Амгалан, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Энхжин, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга М.Батбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Сангийн сайд Б.Жавхлан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Түвшин, С.Эрдэнэболд, С.Зулпхар, О.Саранчулуун, О.Цогтгэрэл, Л.Соронзонболд, Х.Баасанжаргал, Н.Наранбаатар, Б.Батбаатар, Ж.Баярмаа, Д.Пүрэвдаваа, Ж.Золжаргал, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Б.Батбаатар нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 59
Бүгд: 111
46.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул, дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ч.Анарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 57

Бүгд: 111
48.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул, дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 49
Бүгд: 111
55.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Амарбаясгалан: Горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 45
Бүгд: 111
59.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 20 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Р.Эрдэнэбүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн

сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Номин, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Шүүхийн сахилгын хорооны дарга Ц.Давхарбаяр, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Загджав, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Самбууням, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор С.Гансэлэм, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Цэвэгдорж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Л.Сонор, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга С.Сүхбат, мөн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Сангийн сайд Б.Жавхлан, Төсвийн төслийн талаарх Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус Зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 21 цаг 00 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлт, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, М.Ганхүлэг, Д.Пүрэвдаваа, С.Цэнгүүн, Э.Батшугар, Н.Наранбаатар, Ц.Идэрбат, Б.Энхбаяр, Ц.Мөнхтуяа, Б.Батбаатар, Ж.Алдаржавхлан, О.Номинчимэг, Д.Үүрийнтуяа, Ж.Золжаргал, Р.Батболд, Д.Энхтүвшин, Ж.Баярмаа, Б.Түвшин, Ө.Шижир, Б.Пунсалмаа, М.Энхцэцэг, Б.Жаргалан, П.Батчимэг нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Монгол Улсын сайд “20 минутын хот” Үндэсний хорооны дарга

Р.Эрдэнэбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан 22 цаг 12 минутаас хуралдааныг даргалав.

Хуралдаан 22 цаг 22 минутаас 22 цаг 54 минутад түр завсарлав.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Г.Уянгахишиг нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 01 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нарын 6 гишүүн 2024.08.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Наранцэцэг, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатарын тавьсан асуултад Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 01 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 01 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 14 цаг 53 минут үргэлжилж, 126 гишүүнээс 111 гишүүн хүрэлцэн ирж, 88.1 хувийн ирцтэйгээр 08 дугаар 17-ны өдрийн 01 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 16-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 05 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын ирвэл зохих 126 гишүүнээс 71 гишүүн ирж ирц 56,3 хувьтай байна. Хуралдаанаа эхлүүлье. Ингээд 8 сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдэж байна.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар дараах б асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

2 дугаарт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

3 дугаарт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

4 дүгээрт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

5 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

6 дугаарт Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэхээр байгаа.

Ингээд хэлэлцэх асуудал нэг. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хэлэлцэх асуудал. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж эхэлнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Эрхэм Монголчууд аа, Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголчууд бид парламентын ардчилсан тогтолцоонд ишлэсэнээс хойш 9 дэх удаагийн Улсын Их Хурлын сонгуулийг сонгогчдын саналыг гээхгүй байх суурь зарчимд суурилсан холимог тогтолцоогоор явуулж, хувь тэнцүүлсэн болон бүсчилсэн тойргоос сонгогдсон салбар салбарын дуу хоолой болсон 126 гишүүнтэйгээр анх удаа бүрдлээ.

Анх удаа 5 намын төлөөлөл парламентад суудалтай болж, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 25 хувь болж, бүс нутгийн дундаж үзүүлэлтээс давлаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрдэмтэн судлаачид, экспертүүд, хилийн чанадад амьдарч буй иргэдийн төлөөлөл хууль тогтоох байгууллагад сонгогдсон нь улс төрийн соёлын хувьд цоо шинэ 30 жилийг

эхлүүлж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хурдтай шийдвэрлэх шинэ хүлээлтийг нийгэмд үүсгэснийг судалгааны шат шатны үр дүнгүүд харуулж байна.

Энэхүү нийгмийн хүлээлтийг хүндэтгэж Ерөнхий сайдын хувьд сонгуулийн холимог тогтолцоог анх хамтран шийдвэрлэсэн Ардчилсан нам, ХҮН намд Засгийн газрыг хамтарч байгуулах саналыг тавьж, бусад намуудын мөрийн хөтөлбөрийн онцлох заалтуудыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг эрмэлзлээ.

Ардчилсан хувьсгалын удирдагч Санжаасүрэнгийн Зориг Улсын эрх ашиг 1 дүгээрт, улс төрийн намын эрх ашиг 2 дугаарт, хувийн эрх ашиг эцэст нь байх тухай хэлсэн үгийг суурь зарчим болгож, “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээг 3 нам байгуулж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хуралд ийнхүү өргөн барьж байна.

Энэхүү хөтөлбөр бүхэлдээ “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, намуудын мөрийн хөтөлбөрт туссан онцлог заалтуудыг нэгтгэж, хөгжлийн тулгамдсан асуудлыг хурдтай шийдвэрлэх, олон жил улс төржсөн гацсан төслүүдийн зангилааг тайлахад бүхэлдээ чиглэгдсэн гэж үзэж болно.

Дэлхийн эдийн засаг 2024 онд 3.2 хувь, 2025 онд 3.3 хувь орчимд хадгалагдах төлөвтэй байна. Харин манай бүс нутгийн хэмжээнд эдийн засаг 2023 онд 5,1 хувиар өссөн бол 2024 онд 4,8 хувь болон саарсан үзүүлэлттэй байна. Монгол Улсын хувьд эдийн засгийн дундаж өсөлт 5-8 орчим хувийн өсөлттэй байж чадвал бид энэхүү хөтөлбөрийг хамтын хүчээр бүрэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.

Олон улсын судлаачид геополитикийн хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэй худалдааны дайн, санхүүгийн хориг арга хэмжээ, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэх зэрэг асуудлаас энэхүү эдийн засгийн төсөөлөл өөрчлөгдөж болох эрсдэлийг мөн анхааруулж байгааг бид мартаж болохгүй.

Мөн Засгийн газрын ирэх 4 жилийн хөтөлбөр Аж үйлдвэрийн 5 дугаар хувьсгалын хэмжээнд өрнөж буй хүн төрөлхтний амьдралын хэв маягийг асар хурдтай өөрчлөгдөж буй хиймэл оюун ухааны эрчимтэй хөгжлийн үетэй давхцаж байгаагаараа ихээхэн онцлогтой байна. Нэг үгээр хэлбэл бидний төсөөллөөс давсан эерэг эсвэл сөрөг нөлөөлөл хэрхэн манай бүс нутаг, улс орны нийгэм, эдийн засгийн амьдралд хиймэл оюун ухаанаас үүдэн бий болох нь мөн томоохон сорилтыг бас боломжийг дагуулж болох юм.

Бид бүхэн мэднэ. Уурын хөдөлгүүр үүсэж, хүнд даацын ачаа барааг хурдтай зөөх, гар ажиллагааг орлох механикжсан технологи нэвтэрсэн аж үйлдвэрийн 1 дүгээр хувьсгалаас дотоод шаталтын хөдөлгүүр нэвтэрч, автомашин, нисэх онгоц, эрчим хүч, хэрэглээнд нэвтэрч масс үйлдвэрлэл хөгжсөн аж үйлдвэрийн 2 дугаар хувьсгал хүртэл дунджаар 100 гаруй жилийн хугацааг зарцуулсан байдаг. Тэгвэл тооцоолон бодох электрон машин буюу компьютер тоон технологид нэвтэрсэн аж үйлдвэрийн 3 дугаар хувьсгалаас интернэтийн сүлжээ ухаалаг технологид шилжсэн 4 дүгээр хувьсгал хүртэл ердөө л 30-хан жилийн хугацааг зарцуулсан байна. Шинжлэх ухаан, технологийн хурдтай хөгжил AI хиймэл оюун ухаанд суурилсан хөгжлийн цаг хугацаа үүнээс хэд дахин хурдтай өрнөж, аж үйлдвэрийн 5 дугаар хувьсгалаас цаашилаад 6 дугаар хувьсгалтай золгуулахад бид бэлэн байж чадаж байна уу гэдгийг бид одоо л бодох учиртай.

Манай улсын гол экспортын бүтээгдэхүүн болсон нүүрсний ашиглалтын цаг хугацаа дуусахад 10 хүрэхгүй жилийн хугацаа үлдэж байна. Тийм ч учраас бид эдийн засгийн төрөлжилтийн зоригтой алхмуудыг амжиж хийх ёстой. Тийм ч учраас хөгжлийг хөөж биш харин угтаж түрүүлэхийн төлөө Засгийн газрын 4 жилд 4 бүлэг, 4 үндсэн зорилготой, 4 үндсэн үйл ажиллагааны багц бүхий нийт 577 багц үйл ажиллагаатай энэхүү хөтөлбөрийг боловсруулан танилцуулж байна. Энэхүү хөтөлбөр бүхэлдээ хэрэгжихэд нийт 120 орчим их наяд төгрөгийн санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй ийм тооцооллын гаргаж байгаа юм. Харин бид нар улсын төсвийн эх үүсвэрээс энэ үнийн дүнгийн дөнгөж 12,3 хувийг л санхүүжүүлэх боломжтой байна. Тийм ч учраас энэ хөтөлбөрийн суурь үзэл санаа нь улсын төсвийн хөрөнгийг үржүүлэхийн хүрд болгон ашиглах, хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх, хөрөнгө оруулалтын эрх зүйн орчноо олон улсын түвшинд хүргэн сайжруулахад үндсэндээ чиглэгдсэн гэж үзэж болно.

Шинжлэх ухаан, технологи, боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн нийцэл олон улсын экспертүүдтэй хамтран ажиллах чадавх бүхий хүний нөөцийг цаг алдалгүй бүрдүүлж, их өгөгдөлд тулгуурласан бодлого төлөвлөлт, хурдтай шийдвэр гаргалт, ногоон технологийн дэвшилтэт шилжилтийг уул уурхай, эрчим хүч, тээвэр, логистик, хот байгуулалт, барилгын салбарт цаг алдалгүй хийснээр бид энэ хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Бүсчилсэн хөгжлийн реформын цогц асуудлаар эхэлж байгаа. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд Нийслэлийн Их, бага тойруу дахь 700 га-д төвлөрсөн төрийн эрх мэдлийг задалж, нийслэлийн

түгжрэлийн суурь зангилаа тайлагдана гэж үзлээ. Засгийн газар “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогод уялдуулж нийгмийн бүхий л үйлчилгээг 20 минутын дотор авах хүний төлөө шинэ стандарт бүхий амьд хот төлөвлөлтийн цогц шийдэл бүхий нийслэл хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040-ийг боловсруулж Улсын Их Хуралд энэ ондоо багтан өргөн барих болно.

Олон жил уягдсан нийслэлийн асуудлыг хурдтай шийдвэрлэхэд зориг хэрэгтэй. Мөн өмнөх 30 жилд нийслэлд зарцуулсан хөрөнгө оруулалтыг ирэх 3 жилд 3 дахин нэмэгдүүлэх шаардлагатай бид тулгарч байна. Нийслэлийн төвөөс Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал хүртэлх 20 минутын дотор очдог байх шаардлагын стандартыг хангах шаардлагатай. Ингэхийн тулд хотын төвөөс Хүрхрээгийн ам хүртэл “Өөдөө тэмүүлэх Монгол” буюу ган татлагат гүүр барьж, Хүрхрээгийн амнаас Номтын ам хүртэлх Хөшигийн хөндийд хос урсгалын туннел байгуулахаар энэхүү хөтөлбөрт тусгалаа. Улаанбаатар хотын замуудыг хооронд нь холбох шинэ тойрог авто замын төслийг мөн хэрэгжүүлэхээр тусгалаа. Энэ бүтээн байгуулалтыг Туул хурдны замын бүтээн байгуулалтын ажлаар эхлүүлэх нь зүйтэй гэж эрэмбэллээ.

Богд хаан уулыг тойрч Тэрэлж, Налайх, Майдар хот, Зуунмод, Хөшигийн хөндий, Аргалант, Эмээлт хот, Жаргалант, Рашаант хотыг холбосон Шинэ их тойруу хурдны зам болон LRT хөнгөн галт тэрэгний төслийг хэрэгжүүлэх төслийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах зардлыг төсвийн тодотголд тусган өргөн барилаа.

Нийслэл Улаанбаатар хотоос санаачилсан Толгойтоос Амгалан өртөө хүртэлх 17,7км метроны 1 дүгээр шугамыг ашиглалтад оруулах төслийг Засгийн газар мөн бүх талаар дэмжиж бодит ажил болгох болно. Нийслэл Улаанбаатар хотыг төвийн бүс нутагт

Хөшигийн хөндийгөөр дамжуулан тэлж, улсын төв цэгт байрлах эртний нийслэл Хархорум хотыг сэргээн босгох ажлыг Засгийн газраас эрчимжүүлэх болно.

Үндэсний баялгийн сангаар дамжуулан үндэсний орон сууцжуулалтын хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан эрчимжүүлэхээр тусгасан. Энэхүү шинэ суурьшлын их бүтээн байгуулалтыг манлайлж хувийн хэвшлийг манлайлан хувийн хэвшлийг зоригжуулахын тулд Засгийн газрын байгууллагуудыг бүсчлэн байршуулах Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээг Хөшигийн хөндий рүү шилжүүлэн байршуулах нь мөн зүйтэй хэмээн үзэж тусгалаа.

Нийслэлийн хэт төвлөрлийн үндсэн шийдэл бол улс орон бүсчлэн хөгжих гэдэг нь ойлгомжтой юм. Улсын Их Хурлын сонгуулийг анх удаа бүсчилсэн тойргоор зохион байгуулсан нь ч мөн үүнтэй л холбоотой байсан. Саяхан Улсын Их Хурлын зарим гишүүдтэй уулзаж энэхүү хөтөлбөрт тусгах талаар бүс бүрээс санал солилцож ярилцахад асуудлуудын яригдаж буй цар хүрээ гишүүдийн тавьж буй асуудлууд өмнөх жилүүдийнхээс үлэмж хэмжээнд томорсон байсан нь надад их хэмжээний урмыг өгсөн гэж бас хэлж болно.

Улсын төсвийг орон нутгийн нэгж бүхэнд тэгшитгэн хуваах улс төрийн соёл хаагдаж, бүс нутгууд бие даан хөгжих эдийн засгийн боломжоо бүрдүүлэх сэтгэлгээний хөрс суурь тавигдсанд энэ цаашидаа бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал илүү хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлсэн гэж мөн дүгнэж болно.

Засгийн газраас бүс бүрийг нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд төрөлжсөн болон дэд тэргүүлэх чиглэлтэй байхаар энэхүү хөтөлбөрт тусгалаа. Ингэж төрөлжүүлэхгүй бол бүс бүхэн адилхан болох, бүс бүхэнд ижил үйл ажиллагаанууд хийгдэх, ингэснээрээ

хөрөнгө оруулалт тарамдах, бодит үр дүн гарахгүй цаг хугацаа алдах эрсдэлийг дагуулж байна. Тийм ч учраас бид мөн л бүсчилсэн хөгжлийн төлөө хурдтай хөгжихийн тулд зориг гаргах шаардлагатай байна.

Хангайн бүсийг уламжлалт мал аж ахуйн төрөлжсөн хот байгуулалтын дэд бүс хэмээн тодорхойлж байна. Баруун бүсийг эрчимжсэн эрчим хүчний төрөлжсөн байгалийн аялал жуулчлалын дэд бүс, Хойд бүсийг байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс, Говийн бүсийг аж үйлдвэрийн төрөлжсөн ногоон эрчим хүчний дэд бүс, Төвийн бүсийг Хөдөө аж ахуйн төрөлжсөн аж үйлдвэрийн дэд бүс, Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн, эрчимжсэн Хөдөө аж ахуйн дэд бүс болгон хөгжүүлэх нь тохиромжтой хэмээн үзэж байна.

Энэхүү судалгаануудыг өнгөрсөн 30 орчим жилийн Үндэсний хөгжлийн газар болон Эдийн засаг, хөгжлийн яам эрдэмтэн судлаачдын саналд үндэслэн тодорхойлсон гэж үзэж болно. Бүсүүдийн эдийн засгийн эргэлтийг дэмжихийн тулд аймгийн төвүүдийг хилийн боомттой, мөн аймгийн төвүүдийг хооронд нь холбосон бүсчилсэн хөгжлийн 5 тойрог авто замын их бүтээн байгуулалтын ажлыг энэ 4 жилд өрнүүлэхээр тус хөтөлбөрт тусгалаа.

Бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах, өмнөх бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд хэрэгжих томоохон төсөл хөтөлбөрүүдийн техник эдийн засгийн ажлыг өнөөдрийн цаг үетэй нийцүүлэн шинэчлэх мөн зураг төсөв судалгааны ажлыг эхлүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг мөн энэхүү төсвийн тодотголд тусгалаа.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хүний хөгжлийн бодлого нь Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн цөм байх нь ойлгомжтой юм. Улсын хөгжил бол хүний хөгжлөөс ундаргатай гэдэг. Төр засагч нийгмийг бүрдүүлж буй оролцогч талуудын нэг л хэсэг нь юм. Тийм ч учраас иргэдийн оролцоонд тулгуурласан салбар салбарын дуу хоолойг нэгтгэсэн хөтөлбөр л амжилттай хэрэгждэг гэдгийг улс орнуудын хөгжлийн түүх нэгэнтээ нотолсон. Энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа олон улсад хэрэглэгддэг хүний хөгжлийн суурь индексүүдээр үнэлэхээр боловсруулагдаж хэмжигдэхүйц, хүрэхүйц эрсдэлийг тооцдог байх нийтлэг аргачлалыг ашиглалаа. Аль ч улс орны ирээдүй, ирээдүйн иргэдээ хэрхэн бэлдэхээс хамаарах нь ойлгомжтой. Монгол хүн эх хэл, түүх соёлоо эрхэмлэдэг, эрүүл чийрэг, хүмүүжил төлөвшилтэй нийгмийн хариуцлагатай иргэн, гэр бүлийн хариуцлагатай гишүүн болж төлөвших суурь нь сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын түвшинд шийдэгддэг гэдэг судалгаа байдаг. Сайн багийн гар дээр эх орны маргаашийн нар манддаг гэдэг үг ч үүнтэй л холбоотой биз ээ. Тиймээс энэхүү хөтөлбөрт багш мэргэжлийг бүх талаар дэмжиж, үндсэн нэгдмэл үнэт зүйлийг бүрдүүлэх чадамж бүхий үндэсний хөтөлбөрийг аль улсын хөрөнгө оруулалттай сургуулиас үл хамааран бүх сургууль хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн тусгалаа.

Харин дээд боловсролын хувьд улсынхаа ирээдүйн хөгжлийн асуудлыг шийдвэрлэж чадах үндэсний хүний нөөцийг бэлтгэх, ирээдүйн хөдөлмөрийн зах зээлтэй боловсролын тогтолцоо уялдах дэлхийд өрсөлдөх чадвартай иргэдийг бэлтгэх, олон улсын оюутнуудыг бэлдэж дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх эрэмбээ ахиулсан их сургуулийг хөгжүүлэхэд Засгийн газар бүх талаар дэмжин ажиллахаар тусгалаа.

Бидний өнгөрсөн хугацааны алдаа бол боловсрол, эрүүл мэндийн салбарыг тусдаа гэж үзсэн явдал юм. Хөгжил бол

хүний биетэй адил амьд цогц организм билээ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрт илрүүлэг, эмийн чанар, эмч, сувилагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхээс гадна иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарах агуулгаар энэхүү хөтөлбөрт тодорхой заалтуудыг голлон тусгасан болно.

Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй амьдралын буруу хэвшил, архи, тамхины хэрэглээг бууруулах, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг бага наснаас нь боловсролын системээр дамжуулан олгох тогтолцооны шинэчлэлийг хийх болно. Олон улсын стандартыг бүрэн нэвтрүүлэхийн зэрэгцээ эм, эмнэлгийн хэрэгслүүдийн салбар дундын мэдээллийн нэгдсэн тоог бүрдүүлж эмийн импортын асуудлыг бүрэн цахимжуулахаар энэ хөтөлбөрт тусгалаа. Иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орон зай, цаг хугацаанаас үл хамааран авах боломжийг нэмэгдүүлж, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи, хиймэл оюун ухааны эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд энэ хөтөлбөр голлон чиглэсэн. Мөн хүний хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд хувийн хэвшлийг идэвхжүүлэн оролцоог нь хангах зорилгоор мод тарих болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлэх, мөн иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх музей, театр, номын сан зэрэг соёлын үйлчилгээг дэмжихэд иргэдийн эрүүл мэндийг дэмжсэн нийтийн биеийн тамирын талбай тохижуулах, спорт цогцолборууд барих, фитнес клуб нээх зэрэг спортын байгууламжууд хүүхдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин, зуслан, парк, тоглоомын талбай, ахмад настны

хөгжлийн төв, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тохируулгад орчин бүрдүүлэх зэрэг хүний хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжид борлуулалтын орлогын 1 хувь хүртэлх албан татварыг чөлөөлөх зохицуулалтыг энэхүү хуулийн төсөлд мөн тусгалаа.

Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж уг сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, и-монголиа платформ дээр иргэн бүрд хуримтлалын данс нээгдэж, ингэснээрээ байгалийн баялгийн өгөөжийг хүний хөгжлийн төлөө зориулах шударга, хүртээмжтэй байх эдийн засгийн суурь нөхцөлийг бүрдүүлэх реформ энэ 4 жилийн хугацаанд биеллээ олох болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Энэхүү дэвшүүлсэн нийгмийн бодлогын зорилтуудаа хэрэгжүүлэхэд өмнө дурдсанчлан эдийн засгийн өсөлт дунджаар 5-6 хувьд хадгалагдах, инфляцыг 1 оронтой тоонд барих, төлбөрийн тэнцлийг эерэг байлгаж валютын нөөцийг жил бүр нэмэгдүүлэх, эдийн засгийн эрх чөлөөний байдлын болон дэлхийн инновацын үзүүлэлтийг сайжруулж 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 8-10 мянган ам.долларт хүргэх эдийн засгийн төлөвлөгөөг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлагатай болж байгаа юм.

Өнгөрсөн 4 жилд боомтын боомийг тайлж экспортыг 2 дахин нэмэгдүүлж, дотоодын нийт бүтээгдэхүүнийг 37 их наядаас 68,9 их наяд төгрөгт хүргэсэн. Тэгвэл бид ирэх 4 жилд манай эдийн засгийг хязгаарлаж буй гол хүчин зүйл болсон эрчээ алдсан эрчим хүчний салбарыг эргэн сэргээж, хөгжлийн боомийг нь тайлах зайлиггүй шаардлагатай байна. Эдийн засгийг тэлэхийн тулд Засгийн газраас дараах 14 мега төслийг онцолж байна.

1 дүгээрт, Гацуунсухайт-Ганц мод, Ханги-Мандал, Шивээ хүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам ачаа тээврийг шилжүүлэн ачих терминалыг барьж дуусгах зайлиггүй шаардлагатай байна. Ингэснээр экспортын хүчин чадлыг 40 сая тонн хүртэл, экспортын орлогыг 2 дахин, төмөр замаар нүүрс тээвэрлэх экспортын хүчин чадлыг 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. Энэ төслүүдийг бид нар хэрэгжүүлэхгүйгээр нийгэмд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэх ямар ч боломжгүй гэдгийг бид ойлгох учиртай. Энэ холболтууд хийгдсэнээр зүүн босоо тэнхлэгийн Бичигт-Эрээн цав, Баруун босоо тэнхлэгийн Шивээ хүрэн-Арцсуурын төмөр замын их бүтээн байгуулалт эхлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх юм.

Эрчим хүчний хувьд бид 2 дугаарт Тавантолгой цахилгаан станцын 450Мвт-ын дулааны станцыг барьж байгуулах ажлыг тусгалаа. Оюутолгойн хэлэлцээр үр дүнтэй болсны хувьд олон жил яригдсан энэ төсөл эдийн засгийн хувьд хөдлөх боломжтой болсон. Жилд 3,2 тэрбум квт цахилгаан станц эрчим хүч үйлдвэрлэх Оюу толгой, Тавантолгойн орд газруудыг бусад стратегийн ач холбогдол бүхий өмнөд бүсийн уул уурхайн төслийг цахилгаан эрчим хүчээр бүтэн хангах энэхүү төслийг бид нар ойрын ирээдүйн 1 жилийн дотор хөдөлгөх зайлиггүй шаардлагатай гэж үзэж байна.

Мөн Эрдэнэбүрэнгийн 9Мвт-ын усан цахилгаан станц нь жил бүхэн эрчим хүч үйлдвэрлэж, баруун бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг 100 хувь эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглүүлэхэд туйлын чухал ач холбогдолтой гэж үзнэ. Энэ төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажил үндсэндээ бүрэн хангагдсан. Энэ төсөл хэрэгжсэнээр баруун бүс нутгийн эрчим

хүчний хэрэглээний цөм нөхцөл бүрдэх боломжтой юм.

Эгийн голын 310МВт-ын усан цахилгаан станцын төслийг хэрэгжүүлснээр 25 сая ам.долларын импортын төлбөрийг хэмнэх, түүхий нүүрсний хэрэглээг жил бүр 439 мянган тонноор, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 709 мянган тонноор бууруулах ач холбогдолтой төсөл бөгөөд Эгийн голын усан цахилгаан станц манай тохируулагч станцын үүрэг гүйцэтгэх боломжтой юм. Байгаль далайд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээг яаралтай Оросын Холбооны улстай тохиролцох, энэ төсөл удааширсан тохиолдолд 3 дугаар цахилгаан станцын өргөтгөлийг барих зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх болон тархмал эх үүсвэрийг дэмжих чиглэлд бодлогын дэвшил гаргах шаардлагатай байна. Судалгаагаар Монгол Улс 2600 гегабайт сэргээгдэх эрчим хүчний нөөцтэй болох нь тогтоогдсон. Ингэснээр дотоодын цахилгаан эрчим хүчний дутагдлыг нөхөхөөс гадна эдийн засгийг төрөлжүүлэх боломж бүхий хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах нүүрсхүчлийн хийг багасгах нэмэлт орлого болох боломж нээгдэнэ гэж үзэж байгаа. Энэ төслүүдийг хэрэгжүүлэхэд эрчим хүчний либералчлалын бодлогыг хэрэгжүүлэх, өнгөрсөн хугацаанд агаарын тээврийн либералчлалыг амжилттай хийсэн шиг зоригтой алхмуудыг мөн эрчим хүчний салбарт хийх шаардлагатай байна.

Мөн говийн бүсэд зайлшгүй шаардлагатай Хэрлэн-Тоонот, Орхон-Онги ус дамжуулах шугам, Хэрлэн-Тоонот усан цогцолборыг барьж байгуулах шаардлагатай байна. Энэхүү төслийг хэрэгжүүлснээр Онги гол болон Улаан нуурыг сэргээж, усны түвшин тогтворжиж хүн ам, мал сүргийн гадаргын усаар хангах нөхцөл бүрдэх, нуурын орчны бүсийн эко систем биологийн олон янз байдал сэргээж, цөлжилт буурах чухал ач холбогдолтой

гэж үзнэ. Говийн бүс нутгийн усны асуудлыг шийдэхгүйгээр эдийн засгийн бусад томоохон төслүүдийг урагшлуулах, мөн шар шороон шуургатай тэмцэх боломжгүй юм.

Монгол Францын хамтарсан уран, атомын цахилгаан станцын төслийг мөн хэрэгжүүлэх шаардлагатай. 3 дахь хөршийн хөрөнгө оруулалтын уг төсөл жилд 2500 орчим тонн ураныг олборлон экспортлож, улс, орон нутгийн төсөвт 1 тэрбум гаруй ам.долларын татварыг оруулж, 1 мянга гаруй ажлын байрыг бий болгох тооцоолтой. Байгаль орчны үнэлгээ болон энэхүү төслийг Атомын цахилгаан станцын төсөлтэй уялдуулан хэлэлцээрийг нягт хийх учиртай. Оюутолгойн гэрээнд гаргасан алдааг давтахгүйгээр бид нягт ажиллах ёстой.

Нүүрс, хими кокос эмийн цогцолборыг байгуулах мөн шаардлагатайгаар хөтөлбөрт тусгалаа. Говийн бүс нутгийн ашигт малтмалын нөөц баялгийг түшиглэн нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, боловсруулах, үйлдвэрлэлийг нэг шат ахиулснаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, олон улсын түүхий эдийн үнээс хараат байдлыг бууруулах боломж бүрдэнэ хэмээн үзэж байгаа. Нүүрсийг дахин боловсруулах, устөрөгч болгох, нүүрсийг угаах зэрэг технологийн шийдлийг бид энэ 4 жилийн хугацаанд л амжиж асуудлыг шийдвэрлэх учиртай.

Мөн зэс боловсруулах үйлдвэр байгуулагдсанаар жилд 560 мянган тонн зэсийн баяжмалыг боловсруулах боломжтой гэдэг тооцоолол гарсан. Зэсийн үйлдвэрийн хувьд 3 байршилд байгаа. Аль нэгийг нь сонгож, байгалийн нөлөөллийн үнэлгээнд дүн шинжилгээ хийж шийдвэр гаргах шаардлагатай.

Ган боловсруулах үйлдвэр байгуулснаар бид нар дотоодын ган арматур болон бусад ган бүтээгдэхүүний хэрэгцээг дотооддоо бүрэн хангах зорилтын хүрээнд ган бэлдэц,

бүтээгдэхүүн үйлдвэрлэж, барилгын арматур, булан төмөр, төмөр утас зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, дотоодын барилгын арматур хэрэгцээгээ бүрэн хангах боломж бүрдэнэ гэж үзсэн. Мөн гангийн үйлдвэрлэл дээр яригдаж буй 3-4 байрилын аль нэгийг нь сонгож, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан ган үйлдвэрлэх асуудлыг аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд зайлиггүй шийдвэрлэх шаардлагатай байна.

Газрын тос боловсруулах цогцолбор бүрэн ашиглалтад орсноор жилд 1,5 сая тонн түүхий тосноос 1,3 сая тонн бүтээгдэхүүн гарган авч, дотоодын газрын тосны хэрэгцээний 55 хувь орчмыг дотоодоосоо хангах боломж бүрдэнэ гэж тооцоолсон. Энэ төсөл явж байгаа. Төслийн 3 дахь багцыг удахгүй эхлүүлэх шаардлагатай байгаа.

Оюутолгойд түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн энэхүү хөтөлбөрт тусгалаа. Ингэснээр баяжуулсан алтны хувь хэмжээг нэмэгдүүлэх олон улсын зах зээлд борлуулж валютын орлогыг нэмэгдүүлэх боломж бүрдэх юм. Мөн геологийн хайгуулыг эрчимжүүлж, 2 дахь Оюутолгой, 2 дахь Тавантолгойг нээн ажиллахад Засгийн газар бүх талаар анхааран ажиллах болно.

Мөн үндэсний хиймэл дагуулын сүлжээг энэ 4 жилдээ багтаж байгуулах нь зүйтэй гэж үзсэн. Ингэснээр иргэд оршин суугаа газраасаа үл хамааран интернэттэй холбогдох, мэдээллийг тэгш хүртээмжтэй хүргэх, төрийн үйлчилгээг бүрэн цахимжуулах боломжийг нээх юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улс орон урагшлан хөгжих, уруудан доройтох нь засаглалын зөв тогтолцоо хувийн эрх ашгийг хойш тавьж, улсын эрх ашгийг эхэнд тавьсан төрийн

зүтгэлтнүүдийн үйл хэрэгтэй салиггүй холбоотой байдаг билээ.

Монгол Улсын парламентын засаглалыг 1992 оноос 2024 он хүртэл, 2024 оноос хойш гэж бичигдэхээр боллоо. Тиймээс ч Монгол Улсын ардчиллын баталгаа болсон парламентын засаглалыг улам бүр бэхжүүлэх, нүдний цөцгий мэт хайрлан хамгаалах, нэр хүндийг нь өндөрт өргөх үүрэг сонгогдсон 126 төлөөлөлтэйгөөр бүрдсэн анхны парламентын гишүүн та бидний хувьд түүхэн үүрэг болж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт сонгодог парламентын засаглалыг төгөлдөржүүлэхэд чиглэсэн эрх зүйн цогц реформуудыг бүтэн дэмжихээр тусгалаа.

Хүний эрх, эрх чөлөө хуулийн байгууллагуудын хүний эрхийн мэдрэмжийн асуудал, тэр дундаа шүүхийн шатад хилсээр хэлмэгдүүлж эрүүдэн шүүх, ард түмэнд харгис хатуу, авлигачдад аядуу зөөлөн ханддаг шударга бус үйлдлийг таслан зогсоох, шүүхийн ил тод байдлыг хангасан эрх зүйн цахим реформыг хийх шаардлагатай хэмээн энэхүү хөтөлбөрт тусгалаа.

Хүнд суртлын эх үндэс болсон хуулиас давсан журмаар зохицуулагддаг харилцаа 1990 оноос хойших эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, энэ асуудлыг хамтад нь эр зориг гарган цэгцлэх асуудлаар Засгийн газар шийдвэрлэх багц асуудлыг мөн энэхүү хөтөлбөрт тусгалаа.

Төрийн өмчит компаниудын чиг үүргийн давхардлыг арилгах, цахимжуулах, гүйцэтгэл, хяналт, үнэлгээг сайжруулах, төрийн өмчийн бүтээмжийг дээшлүүлж олон улсын менежментийн багаар удирдуулах ажлыг ч зохион байгуулах нь зүйтэй хэмээн хөтөлбөрт тусгалаа.

И-Монголиа платформын хэрэглэгчдийн тоог 2,2 саяд хүргэж, хүний оролцоогүй хиймэл оюун ухаанд суурилсан технологид шилжүүлснээр төрийн албаны чиг үүргийн давхардлыг нэгтгэж, авлигын үндсийг арилгахад чухал нөлөө үзүүлнэ хэмээн мөн итгэж байна.

Төрийн албанд 5-аас дээш жил үр бүтээлтэй ажиллаж буй төрийн албан хаагчдыг гадаадад хэлний болон ахисан түвшний сургалтад хамруулж, мөн магистрын хөтөлбөрт хамруулах хөтөлбөрийг мөн тусгалаа.

Засаглалын ил тод байдлыг хангаж иргэдийн оролцоонд тулгуурласан эргэх холбоог бүрдүүлэхэд ирээдүйн удирдагчид тэр дундаа хүн амын дийлэнх хэсэг болсон залуучуудыг ойлгож, оролцоог нь хангах, хамтарч ажиллах нь манай улсын хувьд амин чухал асуудал болж байна. Төр засаг залуучууд биднийг ойлгохгүй байна гэж халхлах нь үр дүнгүй бөгөөд хуучирсан хэвшмэл ойлголт юм.

Шинэ парламент бүрдэж шинэ 30 жил шинээр эхэлж байна. Цоо шинэ хандлага бүхий шинэ мянганы залуус хаалга тогшиж байгааг бид мартаж болохгүй. Тийм ч учраас энэ өөрчлөлтийн манлайлал энэ танхимаас эхлэх ёстой. Яагаад гэвэл шинэ 30 жил бол тэднийх юм. Цагийн зүү хэзээ ч буцаж эргэдэггүй, эргэх ч ёсгүй ээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал,

дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижир танилцуулна. Индэрт урьж байна.

Ө.Шижир: *Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,*

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 35 дугаар зүйлийг баримтлан яаралтай хэлэлцүүлэх горимоор 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр хуралдаанаар хэлэлцлээ.

Тогтоолын төсөл нь 4 заалт, 2 хавсралттай бөгөөд 1 дэх заалтад Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр хавсралтаа, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг 2 дугаар хавсралтаар тус тус батлахаар, төслийн 2 дахь заалтад Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газартай үйл ажиллагаагаа уялдуулан хамтарч ажиллахыг Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт үүрэг болгохоор, мөн тус хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгахаар, түүнчлэн тогтоолын төслийн 3 дахь заалтад энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газраас бүсүүдийн эдийн засагт гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж, түүнд тулгуурлан татварын ялгаатай бодлого хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын орон зайнд хуваарилалтыг оновчтой болгох, бүс тус бүрийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтад өөрчлөлт оруулах зохицуулалтыг тусгасан байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа “Алсын хараа 2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн хөгжлийн үндсэн зорилт зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд суудал авсан Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тулгуурлан төр хувийн хэвшилд эрдэм шинжилгээ, судалгаа, иргэний нийгэм болон олон улсын байгууллагын саналыг тусган үр дүнд суурилан нэгдсэн арга зүйн дагуу боловсруулсан байна.

Мөн Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт туссан нийгмийн бодлогын шинэчлэл, бүсчилсэн хөгжлийн бодлого, авлигагүй төр, шударга ёсыг бэхжүүлэх цахим засаглал, Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт туссан хүний хөгжил, хувийн өмчийн эрхийн хамгаалалт, технологи суурьтай мэдлэгийн эдийн засаг, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, эдийн засгийн хэрэгжилтийг баталгаажуулдаг шударга төрийн зорилтууд, ХҮН намын мөрийн хөтөлбөрт туссан эрчим хүчний болон боловсролын салбарын шинэчлэл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт, төрийн худалдан авах ажиллагааны бодлогыг шинэчлэх, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтуудыг тэргүүлэх чиглэл болголоо.

Байнгын хорооны хурал дээр тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Шижир баруун бүсийг эрчим хүчний төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх үндэслэл, эрчим хүчний төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр тус бүс дотоод хэрэгцээгээ бүрэн хангах эсэх, Дотоодын нийт бүтээгдэхүүнийг хэрхэн

нэмэгдүүлэх талаар мөн Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын явц, түүний газрын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан банк санхүү, татварын шинэчлэлийг хэрхэн хийх, Багануурын дулааны цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төслийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Батбаатар Иргэний Зориг Ногоон намын мөрийн хөтөлбөрөөс Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан эсэх, шатахууны үнийн өсөлт, хуурамч шатахууны асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай, Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл мөрийн хөтөлбөрт туссан төсөл нь төсөл хөтөлбөрүүдийг хэрхэн хэрэгжүүлэх, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхдээ хувийн хэвшлийн оролцоог хэрхэн хангах, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн эсэх талаар асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Шижир Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зарим зорилт, төсөл хөтөлбөрүүдийг тодорхой болгох, бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхдээ саналаа илэрхийлсэн болно. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж болно гэж заасны дагуу Улсын Их Хурлын даргын захирамжаар “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар боллоо.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг 70 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж бол үзсэн болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ишийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Өлзийхүүгийн Шижирт баярлалаа.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотой ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол улсын ерөнхий сайд, Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын шадар сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Эрдэнэбилигийн Одбаяр Монгол улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Борхүүгийн

Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Чинбатын Номин Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд.

Ажлын хэсгийн бусад гишүүдийн танилцуулъя. Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нэргүйн Мягмар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалахын Төрийн нарийн бичгийн дарга, Эрхэмбаярын Баттулга Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сүхбаатарын Төмөрхүү, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Ханджавын Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лханаажавын Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сандагсүрэнгийн Магнайсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төмөр-Уяагийн Жамбалцэрэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Очирбат

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Пүрэвийн Зохихсүрэн Ерөнхий сайдын зөвлөх, Дорждэрэмийн Цолмон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, Шаравын Мөнхцэрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлусан Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Даваасамбуугийн Эрдэнэбаяр Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс, орон нутгийн хөгжлийн газрын дарга, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Амгалангийн Ананд Гадаад харилцааны яамны Америк, Ойрх Дорнод арлын орнуудын газрын захирал, Цэрэндоржийн Уранчимэг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлого, зохицуулалтын газрын дарга, Зинамидэрийн Батбаяр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга. Энэ зарим дарга нар ирээгүй байгаад байна уу. Доржпаламын Гантулга Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын дарга, Пүрэвийн Оюунаа Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга, Мэлсчойгийн Мэндбаяр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газрын дарга, Тогоогийн Гантогтох Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Пүрэвийн Оюунцэцэг Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга,

Отгонтогтохын Энхмөнх Эдийн засаг, хөгжлийн яамны Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын салбарын нэгдсэн бодлогын хэлтсийн дарга, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсөөллийн хэлтсийн дарга, Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Эрдэнэбатын Батболд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын Орон сууц санхүүжилтийн хэлтсийн дарга, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа төслийн төсвийн захирагч, Цэвээндоржийн Эрдэнэбат Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Бат-Ирээдүйн Мөнх-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын шинжээч.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.17-д Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй гэж заасан. Иймд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Энэ хамгийн сүүлийн гишүүний нэр хаана гарч байна. Ингээд 37 гишүүн асуулт асуухаар нэрээ өглөө. Ням-Осорын Учрал гишүүнээр тасаллаа. Нэр өгсөн

дарааллаар асуултаа асууя. Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууна.

Г.Дамдинням: Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бид нарын ирэх 4 жил барьж ажиллах үндсэн баримт бичиг орж ирж байна. Энд хэдэн тодорхой асуултууд асууя.

1 дүгээрт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Дархан арьс ширний цогцолбор гэдэг үг үсэг байхгүй болчихжээ. Өнгөрсөн 2 парламент дараалаад бид нар үндсэндээ энэ малчдынхаа ахуй амьдралыг дээшлүүлэх, малын гаралтай бараа бүтээгдэхүүнийх нь үнийг нэмэгдүүлэх, амьдрал ахуйд нь бас орлого оруулах, Монголын хөдөө талын жалгаар нэг хаягдаж байгаа малын арьс, шир, дайвар бүтээгдэхүүнүүдийг боловсруулах тухай сонгуулийн турш ярьж байгаад орж ирсэн. Тэгэхээр үүнийг яагаад тусгаагүй юм бэ. Энийг хэрэгжүүлэх юм уу, үгүй юм уу. Ер нь өнгөрсөн жилүүдэд очоогүй дарга, нээлт хийгээгүй үйл ажиллагаа байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ Монголын нийт мянга мянган малчид хараад сууж байгаа энэ ажлыг оруулчихвал зүгээр байна. Боломж байгаа юу.

2 дугаарт Дарханы хүнд аж үйлдвэрийн төслүүд дотор Дархан Төмөрлөгийн үйлдвэртэй холбоотой заалт яг нэрээрээ ороогүй байна. Зарим том төслүүд нэрээрээ орчхож. Ган гээд орох нь орсон байна. Гэхдээ яг хаана гэдэг нь тодорхойгүй байгаад байгаа юм. Тэгэхээр Дархан Төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэж байгуулах Монгол ган цогцолбор гээд өмнөх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ороод явж байсан энэ ажил хэрэгжих үү. Энийг оруулж болох уу гэсэн ийм 2 дахь асуулт.

3 дахь асуулт. Би энэ татварын орчин, эдийн засгийн орчин гээд бүх хэсгүүдийг харлаа. Өнгөрсөн сонгуулиар бид нар мөрийн хөтөлбөрөө танилцуулж явахдаа бүсүүдийн ажлын байр, эдийн

засгийг нэмэгдүүлэх, хүчирхэгжүүлэх чиглэлд бүсүүдэд тохирсон татварын таатай орчныг шаталсан, хөнгөлөлттэй орчныг хөрөнгө оруулахад таатай орчныг бүрдүүлж өгнө гэсэн ийм амлалтыг нэлээн өгч явсан. Энэ маань яг тодорхой ороогүй байгаад байна. Энийг бас тодорхой оруулчих боломж байна уу.

4 дүгээрт нь эдийн засгийн эрх чөлөө гэсэн хэсэг дээр төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн алдагдал Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангана гэсэн ийм заалт оруулж ирсэн байна. Харамсалтай нь бид нар тэр дараа нь хэлэлцэх гэж байгаа төсвийн тодотгол маань үүний тэс эсрэг байгааг энэ төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт, аудитын газрын дүгнэлт 2-оос бас харж болоод байгаа юм. Тэгэхээр 1 баримт бичгээр бид нар ийм хязгаарлана, хумина гэж яриад, төрийн оролцоог бууруулна гэж яриад нөгөө баримт бичгээрээ тэлэхээр оруулж ирээд байгаа нь ямар учиртай юм бэ. Ийм 4 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя.

1 дүгээрт Дарханы арьс ширний цогцолбор олон жил улс төржссөн төсөл. Тэгээд улс төржөөд явахгүй байгаа бол заавал Дарханд баригдах шаардлагагүй гэж үзсэн. Хангайн бүсийг уламжлалт мал аж ахуйн төрөлжссөн ийм бүс болгох шаардлагатай гэж үзсэн. Мөн бүс бүхэнд бас барих боломжтой гэж үзсэн. Тийм учраас энэ бол сонголт. Орон нутаг тухайн төслийг дэмжихгүй бол гуйгаад байх шаардлагагүй. Өөр газар яаралтай барих ийм ажлыг зохион байгуулах ёстой. 8 жилийн хугацааны улс төржилт гэдэг бол бас урт зүйл. Очоод баригдах гэхээр тухайн газар нутгийн нөхцөл байдалтай холбоотой бохирдолт үүсэх, мөн тээвэр, логистикийн асуудлууд гээд ийм олон асуудлууд яригддаг. Тэрнээс дахиад

жишээлбэл энэ асуудал улс төржөөд гацаасай гэж бодохгүй байна. Тийм учраас Эмээлт, Дархан эсвэл хангайн бүсэд аль нэг газраа эсвэл бүсүүдэд хэсэгчилсэн байдлаар баригдах нь зүйтэй гэдэг байдлаар хөтөлбөрт туссан байгаа.

Дархан төмөрлөгтэй холбоотой асуудал бол энэ Гангийн үйлдвэр гэдэг хэсэг дунд орж байгаа. Төвийн бүс бол өөрөө аж үйлдвэрийн дэд бүс болж хөгжихөөр хөтөлбөрт туссан байгаа. Тийм учраас зэс болон Гангийн үйлдвэрийн аль нэг байршил бол байх боломжтой юм. Дархан төмөрлөгийг түшиглэн ялангуяа ордыг нь түшиглэн хийгдэх боломжтой гэж үзсэн.

Орж ирж байгаа Төсвийн тодотгол яах вэ дараа нь яригдах байх. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүддээ хандаж хэлэхэд энэ зүйлийг ярьж хэлэхдээ та хэд маань өөрсдөө их бодолтой хандаарай. Яагаад гэвэл ковидын үед эдийн засаг -4,7 руу орчихсон байсан. Одоо дунджаар 5-7 хувийн өсөлттэй явах боломжтой байгаа. Зарим нэг орон зайгаа тэлэхгүйгээр юу ч хийгдэх боломжгүй шүү. Тэгээд онцгой бүрэн эрх та бүхэнд байгаа. Хэрвээ хийгдэхгүй гэвэл хийгдэхгүй явах боломжтой. Хийгдье гэвэл зориг гаргаад асуудлуудаа шийдэх боломжтой шүү гэдгийг бас хэлье.

Өмнө нь бас Төсвийн байнгын хороо дээр тэр хязгаарыг өөрчилсөн асуудал бол бас сүүлд санал хураалтаар хийгдсэн байсан шүү. Тэрийг засах гэж оруулж ирж байгаа ийм заалт шүү. Тэгэхээр тэрийг та хэд маань бас ярихдаа бас их сайн судалж байж ярихгүй бол 1 дүгээрт энэ асуудлыг ярьж байгаад нөгөө орон зайгаа тэлэх асуудлаа хаачихвал ирэх 4 жилийн хугацаанд 120 орчим их наядын томоохон төслийг оруулж ирж байгаа. Энийг нэлээн багасгахаас өөр аргагүй болно гэдгийг бас анхаарах нь зүйтэй байх.

2 дугаарт яах вэ, эдийн засаг харьцангуй тэлж, үзүүлэлтүүд сайжирч

байгаа учраас энэ өгөөжөөрөө асуудлаа шийдэхийн төлөө зориглох нь зүйтэй юм. Яагаад гэвэл хамтарсан засаг байгуулагдсан. Хурдтай хөгжлийн төлөө зориглоё л гэж бид нар гэрээнд гарын үсэг зурсан. Тийм учраас эсвэл зориглох, эсвэл ямар нэгэн байдлаар одоо ийм байна гэж байгаад одоо байгаа байдлаараа ингээд явах 2 сонголт бид нарт байгаа. Тийм ч учраас тодотгол дээр оруулж ирж байгаа. Тодотгол дээр улс төрийн шийдвэр гарсны дагуу Засгийн газар ажиллах болно.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд нэмэлт тайлбар өгье. Мөн бүсчилсэн хөгжлийн бодлого татварын асуудлаар бас хариулт өгнө. Эдийн засаг, хөгжлийн сайд. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Баярлалаа. Арьс, ширний гүн боловсруулах энэ чиглэлийн ажлууд явагдана. Үүнийгээ “Цагаан алт” гэдэг энэ том бодлогын хүрээнд энэ арьс шир, ноос ноолуур, энэ салбарыг дэмжсэн томоохон хөтөлбөр эхэлнэ. Энэ хөтөлбөрийн онцлог 2 зүйл байгаа.

1 дүгээрт хувийн хэвшилээ хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжинэ. Төрийн оролцоо бол тэр санхүүгийн хөшүүрэг буюу хүүгийн татаасыг хийж өгнө. Тэр хүүгийн татаас дэмжлэгээрээ бид 1,5 их наядын зээлийг арьс ширний гүн боловсруулалт болон ноос, ноолуур бэлтгэх, боловсруулах энэ томоохон бодлогоо нэгтгээд “Цагаан алт” гэж хөтөлбөр болгож эхлэхээр болж байгаа. Өнгөрсөн Их Хурлаар батлагдсан. Тэгэхээр тэр бодлогын хүрээндээ энэ Дарханы арьс ширний болон бусад орон нутагт байгаа паркууд явагдана. Жишээлбэл шинэ Ховд аж үйлдвэрийн парк гээд нийт 120 тэрбумын томоохон төсөвт өртөгтэй хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар явж байгаа ажил байгаа. Төр зөвхөн дэд бүтцийг барьж байгуулахад газар олголтыг шийдэхэд дэмжлэг үзүүлэх маягаар оролцож байгаа. Мөн Дарханд бол 25 га газар бүхий хөнгөн үйлдвэрийн

аж үйлдвэрийн парк гэсэн тэр том нэрийн доор дэд бүтцийн зураг, төсөл хийгдээд дууссан. Мөн төр зөвхөн хүүгийн дэмжлэг болон газар олголт дэд бүтцээр хангах ажилд нь хөрөнгө оруулалтаар дэмжээд түүн дээр барьж байгуулах асуудалд хувийн хэвилийг бол урьж оролцуулна.

Мөн Говьсүмбэрт аж үйлдвэрийн технологийн том парк хувийн хэвилийн санаачилгаар бас томоохон зураг төслүүд нь эцэслэн боловсрогдоод бас энэ маягаар явж байгаа. Эмээлтийн Арьс ширний аж үйлдвэрийн паркийн явц 60 хувьтай явж байгаа. Энэ болгоныг тоочоод байхаар хэт дэлгэрээд байгаа тул “Цагаан алт” гэсэн хөтөлбөрийнхөө хүрээнд ер нь мал, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдээ эцэслэн боловсруулья гэсэн томоохон бодлого санхүүгийн бодлоготой, зээл, хүүгийн бодлоготой цогц яваа шүү гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Дахин хэлэхэд төр өөрөө тэр дээр нь баригдах байшин, барилгад хөрөнгө оруулахгүй. Төр газрыг нь олгоно. Санхүүгийн хүүгийн дэмжлэг үзүүлнэ. Дэд бүтцэд нь шаардлагатай бол хөрөнгө оруулалт хийж өгнө. Ингээд хувийн хэвшил дээр нь салбар үйлдвэрүүдээ томоохон 1,5 их наядын зээлийн хөнгөлөлтийн хүрээнд хөрөнгө оруулалтаа хийгээд эргэлтийн зээл, хөрөнгө оруулалтын зээлээ аваад хийх хийнэ гэсэн ийм бодлого байгаа.

Д.Амарбаясгалан: Хариулт болсон уу. Татвартай холбоотой асуудлаар Гантөмөр дарга. Бүсчилсэн хөгжлийн бодлогыг татварын орчноор хэрхэн яаж дэмжих вэ гэж асуулт асууж байна лээ. Гантөмөр гишүүний микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Дамдинням гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ бүсчилсэн хөгжлийн бодлого бол ирэх 4 жилийн Засгийн газрын хамгийн чухал, тэргүүлэх чиглэл байгаа юм. Олон жил бид нар

бүсчилсэн хөгжил ярьсан. Харамсалтай нь ерөөсөө урагшаа алхаагүй. Тийм учраас энэ 4 жил зориглож, энэ бүсчилсэн хөгжлийг бодитойгоор бий болгоё гэж. Тэгэхдээ энэ дээр хийгдэж байгаа судалгаа бол дутуу байгаа. Дулимаг байгаа. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын тухай хуулиа баталчихсан, хуулийн хүрээнд татварын ялгаатай бодлогыг тогтооно гээд ингээд гарчихсан байгаа. Жишээлбэл, төвийн бүсийн үнэхээр өрсөлдөх чадварыг бид нар бүтэн дүр зургаар нь бол харж амжаагүй байна. Одоо ний нуугүй хэлэхэд. Өнөөдөр бид нар бүсийн хөгжлийн төлөвлөгөөнд тухайн бүс юуг төрөлжсөн кластер болгож хөгжих вэ гэдэг ийм томьёолол дээрээ л явж байна шүү дээ. Тэгээд бид бол нарийвчилсан судалгаануудаа хийнэ. Ондoo багтаагаад бүсийн хөгжлийн ерөнхий замын зургууд бол гарна. Ингээд гараад ирэхээр тухайн бүсэд үйлчлэх татвар болоод бусад хууль тогтоомж гэж Монгол Улсад анх удаагаа ийм шинэ сэдэв хөндөгдөх гэж байна л даа. Бид нар бол одоо нэгдсэн бодлогоор явдаг. Орон нутагт бол цалингийн нэмэгдэл болоод бусад нэмэгдлүүд оноогдож явж ирсэн ийм түүхтэй улс. Одоо бол бодитойгоор тухайн бүсэд хөгжлийн төлөө кластерынх нь төлөө тодорхой бодлогууд, тодорхой хуулиудыг тус тусад нь батлаад хэрэгжүүлээ явах ийм цаг үе ирж байгаа гэдгийг хэлмээр байна. Тэгэхээр тийм хууль тогтоомжууд бол гараад явна. Үзэл баримтлалын хууль дээрээ бол энэ тодорхой тусгагдчихсан байгаа юм. Орон нутагт нь бас тодорхой эрхийг нь олгочихсон юм байна лээ. Жишээлбэл одоо аль татварыг нь багасгах вэ, Гаалийн татварыг тодорхойлоод хэрхэн багасгах вэ. Тэгэхдээ бид нар энийг дур зоргоор нь хийж болохгүй. Кластерынх нь бүтэн зургийг гаргах хэрэгтэй. Замын зургийг нь гаргаад явах хэрэгтэй. Энэ тухай их тодорхой тусгагдсан байгаа гэдгийг хэлмээр байна.

Д.Амарбаясгалан: Дамдинням гишүүн тодруулга.

Г.Дамдинням: Тэгэхээр яах вэ, зүгээр бид нар бас нэг төрийн ажлын үргэлжлэл, залгамж халаа гэдэг утгаараа тэгээд бас энэ татвар төлөгчдийн мөнгийг олон жил зарцуулаад үр дүнгүй боллоо гээд хаяад явах бас утгагүй байх. Тэгэхээр зүгээр энэ Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөндөө Дархан арьс ширнийхээ цогцолборын асуудлыг шууд тусгаад, тэнд бол маш их ТЭЗҮ хийгдсэн, маш их судалгаа хийгдсэн. Хамгийн боломжит газар нь гэж бүх талаар судлаад тогтоогдчихсон ийм л байгаа. Тэгэхээр энийгээ энэ Хөдөө аж ахуйн сайд та бас энэ бүс нутгийн хүн байна. Тэгээд Ерөнхий сайд бас бодож энэ төлөвлөгөөнд оруулаад өгчихвөл их зүгээр байна гэсэн ийм л одоо саналтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмэлт хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Харин тийм. Би бас наадхыг чинь л яриад байна л даа. Ер нь яах вэ, 14 ийм мега төсөл гээд бид нар ингээд оруулчихсан байгаа. Ихэнх нь л дандаа орон нутгийн улс төржилт эсвэл авторын улс төржилт гэсэн нэг ийм л юмнаас болоод төсөл ер нь гацсан байгаа. Эсвэл санхүүгийн асуудал гээд. Тэгэхээр улс төржөөд гацчихаад байгаа асуудлыг Засгийн газар одоо дахин дахин хойноос нь хөөцөлдөөд л нэгэнтээ дэмжлэг байхгүй байхад нь хойноос нь явуулах гээд хэрэггүй шүү дээ. Тийм учраас яг дэмжээд явуулья гэж байгаа юм бол тэгээд дэмжээд явуулахад нөлөөлөөд хамтарч ажиллая. Үгүй бол тэгээд л өөр газар л барих ёстой шүү дээ. Өвөрхангайд барих боломжтой, өөр газруудад барих боломжтой. Тийм учраас энэ төслүүдийг ер нь тэгээд хэдүүлээ яг ийм прагматик хандах нь зүйтэй байх гэж бодож байгаа энэ 4 жилд. Баригдахгүй бол баригдахгүй, баригдвал баригдах л ёстой шүү дээ. Тэгэхгүй баригдах гээд ч байгаа юм шиг, баригдахгүй ч байгаа юм шиг, дэмжээд ч байгаа юм шиг, дэмжихгүй ч юм шиг ингэж цаг хугацаа алдаад яах вэ дээ.

Д.Амарбаясгалан: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Хамтарсан Засгийн газрын үйл ажиллагаа хөтөлбөрийн томоохон зорилт бүсчилсэн хөгжлийг цааш нь амилуулах асуудал байгаа юм. Тэгээд 2001 оны Улсын Их Хурлын 57 дугаар тогтоолоор Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлаад энэ чинь 23 дахь жилдээ явж байна. Тэгээд бүсчилсэн хөгжил маань өнөөдрийг хүртэл дорвитой хэрэгжсэн зүйл бол байхгүй. Тэгэхээр үүний нэг шалтгаан нь юу байна гэж харж байгаа вэ гэхээр зэрэг эрх зүйн орчин дутуу байгаа. Тухайлах юм бол бүсийн зөвлөл гэж ямар эрх үүрэгтэй ямар байгууллага байх юм. Бүсийн зөвлөлийн дарга гэж ямар эрх үүрэгтэй хүн байх юм. Мөн энэ бүс чинь өөрийн төсөвтэй байх юм уу, үгүй юм уу гэх мэтчилэн нэгжийн хууль, төсвийн тухай хуулиуд дээр Үндсэн хууль цаашилбал бүстэй холбоотой ер нь үг үсэг зохицуулалт байхгүйгээс болоод бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нэлээн хангалтгүй явчихсан юм. Тийм учраас цаашидаа асуух асуулт нь бол энэ бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалыг цаашидаа амжилттай хэрэгжүүлэхийн тулд энэ хууль, эрх зүйн орчнууд дээр ямар өөрчлөлтүүдийг хийхээр тусгаж байгаа вэ гэсэн ийм асуудал байна.

2 дахь асуулт үйл ажиллагааны хөтөлбөрт Хэрлэн-Тооно, Орхон-Онги гэсэн говийн бүс рүү ус явуулах энэ томоохон төслүүд оруулсанд баяртай байгаа. Тэгэхээр энэ төслүүдийг энэ ирэх 4 жилийн хугацаанд ямар ажлууд энэ төслүүдтэй холбоотой хийгдэхээр байна. Зөвхөн ТЭЗҮ, зураг төсөв эхлэлийн шатны хэмжээний ажил хийгдэхээр байна уу. Аль эсвэл төсөл бүрэн хэрэгжиж дуусахаар байна уу? Санхүүгийн эх үүсвэр нь хаанаас байхаар байна вэ. Үүнтэй уялдуулаад худалдан авах ажиллагааны тухай хууль бас их

учир дутагдалтай. Томоохон төсөл хөтөлбөрүүд гээд маргаан, асуудлаас болоод олон жил гацаж байгаа. Тийм учраас энэ Худалдан авах ажиллагааны тухай хуульд ямар өөрчлөлтүүд оруулж өгч, цаашаа энэ том төслүүдээ амжилттай явуулах гэж байна вэ гэдэг ийм 2 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал өнгөрсөн хугацаанд яагаад хэрэгжээгүй вэ гэвэл маш энгийн шалтгаан бол тойрог бүсчлэгдээгүй байсан учраас хэрэгжээгүй гэж би бодож байгаа. Яагаад гэвэл гишүүн бүхэн яг төсөв хэлэлцэх ч юм уу, яг ийм Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэх үед илүүтэй яг зөвхөн аймгийн асуудлыг бүр жижиг тойргийн хувьд бол зөвхөн 7 сумын асуудлыг ч юм уу ярьдаг. Тэр агуулгаараа төсөв тэгиштгэн хуваах зарчмаар явдаг байсан. Энэ бол одоо нууц биш ээ. Нууц биш. Одоо бол тойрог томсчхож байгаа учраас гишүүдийн харах өнцөг бол илүү бүс нутгийн интеграц өөрийн эрхгүй болж байна. Энэ бол маш том дэвшил юм. Тийм учраас бүс ямар бүтэцтэй байх вэ, цаашидаа орон нутгийн сонгууль хэрхэн явах вэ бүстэйгээ одоо интеграцад орж, бүсүүд хоорондоо яаж интеграцад орох вэ гэдэг ийм том асуудал бол энэ 4 жилийн хугацаанд том суурь тавигдана. Бүс бүхэн ялгаатай татварын орчинтой яаж байх вэ. Бүс бүхэн ялгаатай эрх зүйн орчинтой яаж бий болох вэ гэдэг энэ зүйл бол чухал. Тийм учраас би бас гишүүдээсээ хүсэхэд энэ 4 жилийн хугацаанд төрөлжсөн болон дэд бүс гэдэг яг энэ хоёрхон агуулга дээр төвлөрчхөж чадвал энэ цаашидаа ингээд ялгаатай байдал нь бий болно. Тэгэхгүй бол бүс бүхэн Хөдөө аж ахуйн бүс, бүс бүхэн аялал жуулчлалын бүс, бүс бүхэн эрчим хүчний бүс гээд байвал ялгаа байхгүй л болчихно гэсэн үг. Тийм учраас энэ дээр хэдүүлээ зориг гаргаад, тэгээд төрөлжсөн болон

дэд бүсийн статусаа илүү их ингээд бариад явчихъя. Энэ тохиолдолд аж үйлдвэрийн 1 үндсэн 2 дэд бүс зэрэг аялал жуулчлалын төрөлжсөн 3 бүстэй эд нар ингээд болоод явчих ийм боломж байгаа.

2 дугаарт чухал асуудал хөндлөө. Худалдан авах манай тендерийн хууль зөвхөн хямд үнэтэй ийм компанийг л шалгаруулдаг ийм хууль. Бид нар чанар луу алхах цаг болсон. Чанар луу алхах цаг болсон. Эдийн засаг ч бас нэг үеэ бодвол нэлээн тэллээ. Тийм учраас чанартай худалдан авалтыг хийдэг болъё. Дэлхийн түвшний том том компаниудад урилга өгч оролцуулдаг болъё гэдэг энэ эрх зүйн шинэчлэлтэй холбоотой асуудал орж ирж байгаа. Цаашилаад яг энэ асуудлыг илүү олон улсын түвшинд уялдуулж, Доржханд Шадар сайд багц байдлаар оруулж ирэхээр ийм судалгааны ажил бол хийнэ гэдэг байдлаар ингээд ярилцаад явж байгаа. Тийм учраас Солонгос, Сингапур зэрэг нийтлэг жишигт барьдаг дэлхийн том, хүчтэй компаниудыг манай Монгол улсын томоохон мега төслүүдэд ордог болгохгүй бол болохгүй. Жишээлбэл Тавантолгой цахилгаан станцын төсөл байна. Тендерийн хуулиас болж гацсан. Одоо хүртэл 2 компани хоорондоо шүүхдээд, тэр дээр нь захиргааны хэргийн хэдэн шүүгч нар оролцоод ингэж явсаар байгаад 12 жил болж байна. Одоо ч энэ шүүхийн маргаан үргэлжилж байгаа. Тийм учраас одоо бид нар төслөө явуулах уу, эсвэл тэр 2 компанийн доор Монголын эрх ашиг орох уу гэдэг ийм л сонголттой болчихоод байгаа юм. Тийм учраас бид нар эрх зүйн хувьд өөрчлөлтөө хийгээд, чадахгүй бол тэгээд том чаддаг компаниудаар нь хийлгээд явах зүйлээ хийхгүй бол ингээд хэдэн нөхдүүдийн хувийн эрх ашгаас болоод улсын эрх ашиг гацдаг зүйлийг бид нар зориг гарган шийдэх ёстой. Энэ 4 жилийн хугацаанд гэж бодож байгаа. Гэхдээ яах вэ сайн зүйл нь бол говийн бүс нутагт хэрэгжиж байгаа ихэнх төслүүдийн бүх санхүүжилт болон бусад схемүүд бий болсон. Дээрээс нь энэ устай холбоотой асуудал дээр мөрийн хөтөлбөрт говийн

бүс нутагтай зүүн бүс нутаг хэрхэн интеграцид орох вэ гэдэг ийм заалтыг зориулж оруулсан байгаа. Тэгэхээр аль аль бүс хоорондоо илүү хүндэтгэлтэй хандаж, нэг үгээр хэлбэл говь устай боллоо гэхэд бусад бүс нь яах юм бэ гэдэг энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр гишүүн. Тэргүүн шадар сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Баярлалаа. Гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ говийг усжуулах ажил бол өөрөө тийм нийгмийн чанартай төсөл бол биш. Энэ бол Монголын ирээдүйн эдийн засагт хийж байгаа хөрөнгө оруулалт. Хөрөнгө оруулалтын хэмжээ бол 3 орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдана. Ер нь бид нар өнөөдөр үйл ажиллагааны хөтөлбөр болоод ирээдүйн төсвийн төсөөлөл Монгол Улсын хөгжлийг харахдаа Монгол орон бол уул уурхайн орон гэдгээ цөмөөрөө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Уул уурхайн улс учраас дараагийн шатад бид нар эдийн засгаа төрөлжүүлэхийн тулд уул уурхайг дагасан боловсруулах үйлдвэрээ хийнэ. Энэ бол бидний ирэх 4 жилийн хамгийн том зорилт байгаа. Энэ үйлдвэрлэлийг хийхэд ус бол гарцаагүй зүйл. Энэ бол ерөөсөө уул уурхайг дагасан үйлдвэрлэл хийе гэж байгаа усны асуудлаа ишидэх хэрэгтэй. Тийм учраас энийг 4 жил ярих, ТЭЗҮ хийх, эсвэл маргалдах зүйл, сэдэв бол биш. Энэ бол цэвэр хөрөнгө оруулалт. Монгол улс үнэхээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт цаг өгье. Нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Баярлалаа. Минутаа бас мэдэрч чадахгүй байна. Уучлаарай. Тийм учраас энийг бид нар эхлүүлэх юм уу, зураг төсөл ярих хэмжээнд бол харахгүй байгаа. Энийг бол хийнэ, гүйцэтгэнэ, дуусгана. Дуусгаж чадах юм бол бид нарын тавьж байгаа тэр 10 мянган долларт хүрэх зорилт маань хэрэгжинэ. Энийг хийж чадахгүй бол

хэрэгжихгүй. Одоо аливаа асуудлын Монголын эдийн засгийг нэг нууц хүмүүс хайгаад байх шиг байгаа юм. Нууц нь бол ердөө энд л байгаа. Энэ дээр манай гишүүд гадна, дотнын улс төржилтийг тэсэж гаргах хэрэгтэй. Засгийн газар гадна, дотнын улс төржилтийг тэсэж гаргах хэрэгтэй. Ингээж чадах юм бол Монголчуудын хүсээд байгаа хөгжил дэвшил бол ирэх юм. Энэ бол говь нутгийн асуудал ерөөсөө биш шүү. Монголын хөгжлийн тухай л асуудал байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Ирэх 4 жилд Монгол Улс хаашаа алхах вэ гэдэг бодлогын баримт бичиг орж ирж байна гэж ойлгож байна. Энэ бодлого дээр 2 үндсэн сонголт байсан байх гэж боддог. 1 дүгээрт нь төрийн оролцоо ихсээд, төр олон том төслүүдийг барьж авч хэрэгжүүлээд явах нэг зам, нөгөөдөх нь илүү тийм төрийн оролцоог багасгасан ирээд бизнесүүдэд илүү боломж олгосон тэр загварыг бид нар яаж сонгох вэ гэдэг. Тэгэхээр эндээс заавал бас тодруулах ёстой нэг зүйл нь ер нь төр гэхээр л муухай юм, төр орохоор л авлигалчихдаг, төр гэдэг талаасаа бас хэлээд байгаа юм биш. Ер нь үүний цаана зээлжих зэрэглэл гээд нэг зүйлийг бид нар ерөөсөө ярьдаггүй зүйл байдаг. Энэ нь Монгол Улсын зээлжих зэрэглэл сайжирвал олон улсад тэгвэл Монгол Улсын гаднаас авах санхүүгийн эх үүсвэрүүд хямдардаг. Гадаадын хөрөнгө оруулагчид итгэж эхэлдэг. Магадгүй тэр мэргэжлийн хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын сангууд нь Монгол Улсад орж ирдэг энэ бизнесийн санхүүжилтийг чинь тэд нар хийчих тэр боломж нөхцөлийг бид нар эрэлхийлэх ёстой л гэж. Гэтэл өнөөдөр яг Монгол Улсын хувьд тэр зээлжих зэрэглэлийг сайжруулна гэдэг чинь явсаар байгаад төр нь жижгээрээд, төсвийн алдагдал нь багасаад, өр зээл нь багасаад энэ үзүүлэлтүүд гарч байж тэр зээлжих зэрэглэл нь сайжирдаг юм байна л даа.

Гэтэл бид нар төр маань улам томроод яваад байдаг. Одоо жишээ нь өнөө жил орж ирж байгаагаар төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хэмжээ 38,5 гэсэн тоо гарч байна лээ. Энэ нэн шинэ үеийн түүхэнд бараг энэ сүүлийн 30-аад жилд хамгийн өндөр тоо. Өнгөрсөн жил хамгийн өндөр гэж байсан 37,8 билүү байсан. Одоо 38,5 хувь. Тэгэхээр энэ тохиолдолд бид нарын тэр зээлжих зэрэглэл чинь сайжрахгүй. Магадгүй улам муудна. Зээлжих зэрэглэл сайжрахгүй болохоор Монгол Улсад чинь гаднаас авах мөнгө чинь тэр сүүлд гаргасан Сенчури бондын чинь үнэлгээ бараг долларын жилийн 11 болчхоод байх шиг байна лээ. Тэгэхээр ийм өндөр санхүүжилтээр хэн Монголд орж ирээд, Монгол Улсад хөрөнгө оруулж ашиг хийнэ гэж орж ирэх вэ дээ. Тэгээд яг энэ бодлогын баримт бичиг дээр бид нар бараг 120 их наядын төсөл хэрэгжүүлнэ. Үүний ихэнхийг нь төр, хувийн хэвшилээр хувийнхнаар хийлгэнэ гэж цаасан дээр биччихсэн. Ийм зээлжих зэрэглэл муутай оронд яг энэ мөнгө чинь минийхээр бол орж ирэхгүй. Дахиад эцсийн дүндээ төр энд оролцож, төсөв оролцож энэ асуудлыг шийдэхээс өөр аргагүй л болж хувирна. Тэгэхээр энэ дээр бид нар арай өөр бодлогын шийдлүүдээ, тэр зээлжих зэрэглэлээ сайжруулах чиглэлд манай энэ бодлогын сонголтууд чинь илүү явсан бол бид нарын хувьд хүрэх зорилгодоо хүрээд, эдийн засаг өсөөд, улсын өр дарамт нэмэгдэхгүй, энэ олон олон шийдлүүд бидний цаана байсан байх гэж. Тэгэхээр энэ зээлжих зэрэглэл гэдэг асуудал дээр Монгол Улсын ер нь энэ зээлжих зэрэглэлийн үнэлгээ гэдэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гантөмөр дарга. Тэргүүн Шадар сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд хариулт өгье. Тэргүүн шадар сайд Гантөмөр даргын микрофон өгье.

Л.Гантөмөр: Тэгэхээр бид нар улсынхаа эдийн засгийг томруулахгүй л бол ингээд төсөв мөнгө ярьдаг нэг тийм тулга тойрсон, хэдэн тоотой зууралддаг

ийм л амьдралтай 30 жил явж ирлээ шүү дээ. Тэгэхээр бид нарын хамгийн том зорилго бол эдийн засгаа тэлэх, эдийн засгаа томруулах. 10 мянган долларт хүрчих юм бол бид нар үнэхээр тоо, тооны тухай тодорхой ярьдаг ийм эрхтэй болно. Өнөөдөр энэ эрхээ хязгаарласан учраас бид нар Төсвийн тогтвортой байдлын тухай хууль ч юм уу, төсвийн тодорхой хязгааруудыг тавьж, нэг үгээр хэлбэл өөрөө өөрийгөө боомилдог ийм амьдралаар явж ирсэн. Зээлжих зэрэглэлийн тухай ярьж байгаа эрхэм гишүүний санал бол үнэхээр бодитой. Бид нар зээлжих зэрэглэлээ сайжруулах хэрэгтэй. Яг өнөөдрийн эдийн засаг дээр бол сайжрах ямар ч боломжгүй. Яагаад гэвэл Монголын эдийн засаг бол цэвэр түүхий эдийн экспортын эдийн засаг. Түүхий эдийн экспортын эдийн засаг дээр зээлжих зэрэглэл сайжрах тухай ойлголт ерөөсөө байхгүй. Тэр нь тогтворгүй. Яагаад тогтворгүй вэ гэхээр нэг улсын зах зээлээс хамааралтай нүүрсний эдийн засаг байгаа. Тийм учраас бид нар энэ эдийн засгаа төрөлжүүлэх нь бол зээлжих зэрэглэлээ сайжруулах эхний алхам. Тэгэхээр энэ тухайд л энэ үйл ажиллагаагаа чиглүүлье. Тэр бүсчилсэн хөгжлөө хийе гээд байгаа шалтгаан бол 1 дүгээрт энэ байгаа.

2 дугаарт бол зээлжих зэрэглэлд нөлөөлдөг хамгийн чухал зүйл бол үнийн өсөлт. Бид нар үнийн өсөлтөө уг нь бол тогтвортойгоор цаашаа аваад явах боломж бололцоог бий болгохын тулд энэ тээвэр, логистикийн асуудлаа түлхүү үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгаад байгаа юм. Тээвэр, логистикоос хамаараад энэ үнэ, үйлчилгээ гэдэг зүйл чинь нэмэгдээд байна. Энэ рүүгээ түлхүү хөрөнгө оруулалт хийе гээд Улаанбаатар хот дээр тодорхой хөрөнгө оруулалт хийж байгаа шалтгаан бол энэ үнийн өсөлтийг барих ийм бодлого байгаа. Тэгэхдээ зоригтой дуугарч чадахгүй байгаа үндсэн шалтгаан бол дэд бүтцийнхээ үнийг бид нар маш хатуу барьчихсан. Эрчим хүч, дулаан, ус. Энэ дээр тодорхой эрсдэлүүд гэх юм уу энийг

чөлөөлөх ажил бол ирэх 4 жилд хийгдэнэ. Тийм учраас бид нар энэ үнийн өсөлт гэдэг зүйл дээр бас их хатуу бодлого хэрэгжүүлэхэд төвөгтэй байгаа. Тэгээд энэ эдийн засгийн төрөлжилт. Өөр нэг асуудал бол өрийн дарамт байгаа юм. Өрнийхөө дарамтын хязгаарыг бид нар хатууруулж байгаа юм. Суллаж байгаа хэрэг ерөөсөө байхгүй. Хатууруулаад энийгээ бариад явна. 2028 онтой золгоход бид нар дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувь руу очсон өрийн хэмжээтэй байна гэсэн ийм алсын зорилго бол дэвшүүлж байгаа шүү дээ. Төсвийн урсгал зардал бол үнэхээр тэлчихсэн юм байна лээ. Энийг бол одоо бид нар цаашаага хэрхэн бид нар энэ төсвийн урсгал зардлаа хяналтад оруулах вэ гэдэг маш ойлгомжтой матрикс зохиохгүй бол дур зоргоороо зардал өсөөд яваад байдаг зүйл үнэхээр манай зээлжих зэрэглэл дээр хамгийн их гай болж байгаа юм. Бид нар бол тогтвортой байдлаа бол хадгалж чадна. Хадгалж чадна. Энэ үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлбэл тогтвортой байдлаа хадгалж чадна. Нөөцөө нэмэгдүүлээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгөх хүн байгаа юу Сангийн яамны албаны хүмүүсээс. Алга байна. Цогтгэрэл гишүүн тодруулга.

О.Цогтгэрэл: Харин зээлжих зэрэглэлийг сайжруулах чинь харин бид нараас яг улс төрийн зориг шаардсан, бид нараас их хамаарсан зүйл чинь л тэнд их байгаад байгаа байхгүй юу. Төсвийн хэмнэлтийн бодлого, төсвийн алдагдалгүй батлах, өрөө бууруулах энэ бүгд чинь зээлжих зэрэглэлд хамгийн их нөлөөлдөг үе. Бид нараас бараг шууд эдийн засаг төрөлжүүлэхээс илүү амар. Бид нарын шууд хийж чадах зүйл чинь энд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд зээлжих зэрэглэл маань сайжирчихвал харин бусад бизнесүүдэд илүү их боломж. Одоо өнөөдөр манай Монгол Улс “В” ангилалд байгаа. Би хэрвээ өнөөдрийг хөрөнгө оруулахад эрсдэлтэй орон гэдэг ангилалд л дэлхий нийтэд байж байгаа

шүү дээ. Бид нар маш өндөр эрсдэлтэй орон гэдэг. Энийг л “В” гэдэг ангилал руу орох зорилго хэрвээ бид нар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. Тэргүүн шадар сайд Лувсаннъямын Гантөмөр.

Л.Гантөмөр: Тэгэхээр харин би эдийн засгаа өсгөө гээд байгаа шалтгаан тэр л дээ. Яг өнөөдрийн манай макро эдийн засгийн үзүүлэлт бол үнэхээр зээлжих зэрэглэлийн хувьд бол тасархай сайн үзүүлэлттэй байгаа шүү дээ. Яг тоо харах юм бол эдийн засгийн өсөлт нь 6 хувьтай. Уул уурхайн салбарын өсөлт нь өнгөрсөн жил 31 хувьтай, энэ жил 14 хувьтай гарна. Тэгээд дээр нь өрийн дарамт нь бол 40 хувь руу ороод ирчихсэн. Яг өнөөгийн үнэ цэнээрээ тооцохоор ялгаа байхгүй. Өрийн дарамт нь бол асар багасчихсан. Валютын нөөц нь яг Монголын эдийн засаг дээрээ тооцох юм бол 5 тэрбум доллар луу дөхчихсэн. Гэтэл эрсдэл нь өндөр учраас эрсдэл гэдэг нь бол үйлдвэржээгүй орон учраас манай зээлжих зэрэглэл бол нэмэгдэхгүй байна. Бид бол цэвэр саяын өсөлтүүд бол уул уурхайн бүтээгдэхүүний экспорт дээр гарч ирж байгаа тоонууд. Тэгэхээр хэдүүлээ тоотойгоо зууралдах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээр түрүүн бас Ерөнхий сайд үгэндээ хэлж байна. Дэлхийд өрсөлдөх чадвартай Монгол иргэдийг бэлдэх үндэсний сургалтын хөтөлбөртэй болно гэж зорьж байгаа гэж хэлж байгаа. Энд бол маш их баяртай байна. Энэ салбарт насаараа 10 гаруй жил ажиллаж, энэ салбарыг төлөөлж өнгөрсөн 4 жил Их Хуралд суусан хүний хувьд. Тэгээд энэ дээр би бас нэг санаа зовсон юм нь энэ хөтөлбөр батлагдахаас өмнө сургуулийн өмнөх

боловсрол, бага боловсролын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг нь ингээд гарчихсан ажиллаж байгаа. Гэтэл бид нар энийг томоор нь хараад сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсрол гээд том зургаар нь хараад маш нарийн ямар, ямар хүмүүсийг энэ ажлын хэсэгт оруулах вэ, хэр энэ ажлын хэсгийн үйл ажиллагааг нээлттэй явуулах юм бэ гэдгийг бас бодолцож байж хэрэгжүүлэх ёстой гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ хөтөлбөр батлагдахаас өмнө ингээд ажил явчхаад байгаа. Энийг бид нар анхаарах ёстой шүү Ерөнхий сайд аа гэж хэлмээр байна.

Энэ хөтөлбөрийг бас боловсруулж байхдаа заах арга зүй дээрээ бид нар анхаарах ёстой байгаа юм. 2022 онд бид нар олон улсын PISA гээд үнэлгээ хийлгэж хийлгэсэн. Хүүхдүүддээ. Тэгээд 15 настай хүүхдүүдийн унших чадварыг бид нар р хэмжиж үзэхэд 81 орноос 65 дугаар байранд байгаа юм. Манай хүүхдүүд юм уншихаад уншсан юмаа ойлгодоггүй. Хурдан унших дээрээ л анхаараад байдаг. Минутаад хэдэн үг унших юм гэдгийг нь анхаараад байдаг багш нар. Уншсан юмаа ойлгодоггүй өөрсдөө. Тэгээд энэ бол эмгэнэлтэй ийм тоо баримт байгаа. 2023 онд бид нар Боловсролын яамтайгаа нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа хийлгэсэн. 7-14 настай хүүхдүүдийн 22 хувь нь энгийн эх унших чадваргүй. Тэгэхээр энэ бол бидний хойч үе, дараа үеийн чинь бичиг үсэгтэй эсэх нь, ямар түвшинд явж байгааг харуулж байгаа ийм зүйл байгаа шүү. Энэ дээр бас Их Хурлын гишүүд анхаарах байх гэж бодож байна.

2 дугаарт энэ хөтөлбөрт плажеризмтай тэмцэх, оюуны хулгайтай тэмцэх асуудлыг зайлиггүй оруулж өгмөөр байна. Бид нар бүр ингээд хуулагч үндэстэн болчхоод байна. Их сургуулийн оюутнууд ч, магистрант, докторант, 10 жилийн хүүхдүүд ч гэсэн ингээд хуулаад. Ерөөсөө сүүлийн үед Chat GPT гэдэг юм гарчихсан. Одоо тэндээс хуулдаг болчхоод байна. Тэгэхээр энэ асуудалтай

бид нар зайлиггүй тэмцэх ёстой гэж энэ хөтөлбөрт ороосой гэж энэ боловсролын салбарын хүний хувьд үзэж байгаа.

Дараагийн нэг чухал зүйл нь элсэлтийн ерөнхий шалгалтыг олон удаа авдаг болгомоор байна. Хүүхдийн хувь заяаг ганцхан өдөр нэг л шалгалтаар ирээдүйд нь шийддэг болмооргүй байна. Энэ дээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулах юм уу. Наранбаяр сайд. Зарим сайд нар бас танхимд энэ байхгүй байна. Сайд нарыг дуудаарай. Гишүүд асуулт асууж байгаа.

П.Наранбаяр: Товчхон хариулъя. Тэгэхээр энэ Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу энэ бага боловсрол, СӨБ буюу сургуулийн өмнөх боловсролын энэ хөтөлбөр боловсруулах сурах бичгийг шинээр бичих ийм ажлын хэсэг бол хуулийн дагуу байгуулагдсан. 254 хүнтэй үйл ажиллагаагаа явуулаад эхэлж байгаа. Энэ дээр бол нийт хэвлэлийн компаниуд, хувийн хэвшлийнхэн, судлаачид голлож Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн яг судлаачид голлож ажиллаж байгаа. Энэ үйл ажиллагааг эхлүүлэх нь бүх юманд бол ил тод, нээлттэй явж байгаа. Харин боловсруулж байгаа энэ үйл явц бол өөрсдөө боловсруулаад гарч ирээд ингээд явсных нь дараа бид 1 жил туршиж үзэх юм. 100 сургууль дээр туршиж үзээд, тэгээд үндэсний хэмжээнд гарч байгаа энэ юугаа бүгдийг нь зассаны дараа энэ юмаа хэрэгжүүлж эхэлнэ. Түүний дараа бүрэн дунд боловсрол буюу тэр дунд сургууль, ахлах сургуулийн хөтөлбөрүүд шинэчлэгдэх ажил ирэх жил явагдана. Ийм байгаа.

Тэр унших чадварын асуудал бол үнэхээрийн үнэн. Тэгээд PISA-ийн шалгалтаар бол 65 дугаар байранд орсон. Ийм учраас энэ удаагийн сурах бичгийн болон хөтөлбөрийн шинэчлэл дээр унших бичгийг сэргээж оруулж ирэх асуудлыг бид нар хөндөж байгаа. Унших чадварыг нэмэгдүүлэхийн тулд сурганы арга зүйн

тал дээр ч гэсэн анхаарах зүйл их бий. Миний зүгээс ч гэсэн бас багш нарт хандаж хэлж байгаа тэр минутыг нь дуржигнатал унидаг уншлагыг бол биш, ойлгож унидаг, ойлгосноо өөрөө ярьдаг, тэрийгээ хэрэглэж шинэ мэдлэг бүтээж чаддаг ийм хүүхдүүдийг гаргаж ирэх дээр онцгой анхаарах ёстой гэж үзэж байгаа. Мөн сурах бичиг нь өөрөө ялангуяа 1-5 дугаар ангийн хүүхдийн сурах бичиг бол өөрөө AR-тай, өөрөөр хэлбэл QR кодтой шууд ингэж хавсарч ажилладаг ийм сурах бичгүүд гарч ирнэ гэсэн ийм хүлээлттэй байгаа. Тэгээд тэр 22 хувь нь бол энгийн эхийг уншаад ойлгох чадваргүй гэдэг бол үнэхээр аймаар тоо. Тэгэхээр энэ бол бага сургуулийн яг энэ боловсролын гол зорилго бол уншихад чиглэх ёстой гэж бодож байна.

Оюуны хулгайтай тэмцэх энэ асуудал бол яамны хүрээнд бас яригдаж байгаа. Ерөөсөө хуульд ч бас туссан. Энэ асуудлыг бол бид нар онцгой анхаарч ажиллана. Энэ хөтөлбөр юундаа тусгах тал дээр анхааръя.

Элсэлтийн ерөнхий шалгалт буюу элсэлтийн шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулж байгаа. Одоо 12 сард, тэгээд 6 сард гэсэн байдлаар зохион байгуулж байгаа. Монгол хэлний нэг босго шалгалт гэж байгаа. Тэрийг бол 10 дугаар ангид орсон хүүхэд 10-12 дугаар ангийнхаа хугацаанд өөрөө сонгоод энэ шалгалтаа өгчихдөг болгох ийм тогтолцоо руу оруулахаар бид ярилцаж байна. Олон дахин зохион байгуулах нь бас чухал. Гэхдээ цаана нь нөгөө төсөв их явж байдаг учраас одоохондоо бол жилдээ 2 удаа зохион байгуулж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ундрам гишүүн тодруулга.

Ч.Ундрам: Энэ 254 хүнтэй ажлын хэсэгт чинь хэвлэлийн компани орж яах юм. Тэр чинь нэгэнт боловсруулчихсан юмыг хэвлээч гээд л эхээ бэлтгүүлээд л, хэвлүүлж байна шүү дээ. Тэнд хувийн компанийн эрх ашиг орчих юм биш үү.

Тэгэхээр энэ ажлын хэсэг бол Монгол Улсын ирээдүй болсон хүүхдүүдийн тархи толгойнд юу бичиж, зурах юм бэ гэдгийг шийдэх ажлын хэсэг шүү Наранбаяр сайд аа. Тэгэхээр энэ дээр хэн орох вэ, хэн орохгүй вэ гэдгийг та маш нарийн зөвлөлдөж, ганцаараа биш Ерөнхий сайдтай, Засгийн газраараа ярьж байж шийдэх ёстой шүү. Үүнээс чинь үүдэж та бидний хүүхдүүд юу сурах юм бэ, эх орондоо хэр хэмжээнд хайртай хүн болох юм, түүхээ мэддэг хүн болох юм уу, үгүй юу гэдгийг шийдэгддэг. Тэгэхээр энэ дээрээ анхаармаар байна. Тэгээд туршиж үзнэ гэдэг чинь яг ямар учиртай юм бэ. Хэн нь тэгээд туршилтын туулай болж өгөх юм.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт Ерөнхий сайд хариулах уу. Ерөнхий сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ дээр Байнгын хорооны дарга, сайд 2 маань хамтарч л ажиллах асуудал. Тийм учраас Монгол Улс үндэсний сургалтын ийм хөтөлбөртэй. Тэр дээр эх оронч үзлээс авхуулаад эрүүл мэнд, боловсрол, улсынхаа түүхийг мэддэг байх энэ бүх зүйлийн цөм агуулга сургуулийн өмнөх боловсрол дээр болон ерөнхий боловсролын сургууль дээр өрсөлдөх чадвартай холбоотой асуудал, ялангуяа хөдөлмөрийн зах зээл болон боловсролын салбар хэрхэн нийцэх вэ гэдгийг их, дээд сургууль дээр хандах ийм томоохон хөтөлбөр уялдаа холбоо явна. Энх-Амгалан сайд бас гэр бүл, нийгмийн хамгаалалтай холбоотой асуудал, боловсролын сайдаар ажиллаж байгаа. Тэгэхлээр хөдөлмөрийн зах зээлийг цахимжуулж, уялдуулах ийм асуудлууд хийгдээд явж байгаа. Тийм учраас хамтарч ажиллах энэ агуулга дээр ярилцаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхбаярын Батшугар гишүүн асуултаа асууя.

Э.Батшугар: Эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр бол ард

иргэдийн дунд маш том хүлээлт үүсгэж байгаа. Ялангуяа нийгэм, эдийн засгийн талдаа. Ерөнхий сайдын хамтарсан Засгийн газрын 14 мега төсөл бол яалт ч үгүй Монгол Улсын эдийн засгийн суурь баазыг нь бэхжүүлж, мөн эдийн засгийн тусгаар тогтнолоо олоход маш том нөлөө үзүүлнэ гэж харж байгаа юм. Энэ нь ирээдүйдээ Монгол Улсыг Төв Ази-даа 1 хүнд оногддог дотоодын нийт бүтээгдэхүүндээ хамгийн чинээлэг улс орнуудын 1 болох бололцоог нь нээж өгнө. Тэгэхдээ хамгийн чухал зүйл нь санхүүжилт байгаа юм. 120 тэрбумын санхүүжилтийг яалт ч үгүй гадаадын эх үүсвэр хэрэгтэй. Бусад улс орнуудын ч гэсэн бас мега төслүүдийг харахад бол дандаа гадаадын хөрөнгө оруулалтаар бас боссон байдаг. Хамтарч жишээлбэл, Лондоны 30 тэрбумын метроны шинэчлэл, Өмнөд Африкийн төмөр зам, Австралийн утас цэвэршүүлэх байгууламж гэх мэтчилэн. Тэгэхээр манай гадаадын хөрөнгө оруулалтаа дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулахад бол сүүлийн жилүүдэд мөн ковидын өмнө 15 хувьтай л байсан. Үүний 12 хувь нь бол уул уурхайн салбар. Үүнээс бол дийлэнх нь Оюутолгой. Тэгэхээр гадаадын хөрөнгө оруулалтыг Азийн бусад бар орнуудыг харахад бол сүүлийн 40 жил 40-60 хувьтай эзэлж байсан. Тэгэхээр энийг нэмэгдүүлэхийн тулд ямар ямар алхмууд хийх вэ гэж асуумаар байна.

2-т нь түрүүн Цогтгэрэл гишүүн ярьж байна. Зээлжих зэрэглэл бол үнэхээр чухал. Зээлжих зэрэглэлийг тогтоодог 22 шалгуур байдаг. Үүний дийлэнх нь манай макро эдийн засаг үндсэн параметр сайжраад, тэгээд дээшлүүлэх бололцоотой гэж харж байгаа юм. Яагаад гэвэл 2012 онд Монгол Улсын хамгийн анхны зээлжих зэрэглэлд Стэйбл болон “B” гэж тавьсан. Тэгэхдээ яг *standart in force* харж байхад бол *moody*-тэй бид нар тулж ажиллавал илүү бололцоотой гэж харж байна л даа. Яагаад гэвэл *moody* бол илүү уян хатан байдаг. Илүү хурдан шинэчилдэг. *Standart in force* нь арай удаан, дээрээс нь

бууруулахдаа их амархан шинэчлэл сайжруулахдаа удаан байдаг. Эдийн засгийн өсөлтийг нэг хүнд оногддог дотоодын нийт бүтээгдэхүүнээрээ 10 мянган доллар хүргэе гэвэл энэ нь хүртээмжтэй өсөлтөө яаж бий болгох вэ, *incisive growth* гэж ярьж байгаа. Энэ нь хамгийн чухал. Дан статистикийн тоогоор биш. Харин яг өрхийн орлогод оруулж, хаалгаар оруулахад.

2-т нь сая Ерөнхий сайд хэлсэн. Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний потенциал 2600 гигабайт гээд. Энэ нь бол шууд Монгол Улс эрчим хүч хүчээ экспортлох бололцоотой болж байгаа юм. Үүнтэй холбогдуулан Нанси гэж байгууллага байгаа. Холбоо. Үүнд манай Монгол Улс элсэх бололцоотой байгаа юу. Ингэснээр бид нар Зүүн хойд Азийн шууд том супер сүлжээтэй холбогдох бололцоо нь байгаа юм.

Хамгийн сүүлд нэг асуулт асуухад энэ төрийн өмчит компаниуд гадаадад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж асуух юм уу. Батиугар гишүүний нэмэлт цагийг өгчихье.

Э.Батиугар: Төрийн өмчит компаниуд IPO хийх үү. Ялангуяа бид нар “Эрдэнэт”, “Эрдэнэс Тавантолгой” гэх мэтчилэн компаниудын засаглалыг сайжруулж, бүтээмжийг нь сайжруулахын тулд яг л олон улсын жишиг дагуу менежменттэй байх ёстой. Үйл ажиллагаа нь ч гэсэн адилхан байх ёстой. Тэгэхээр хамгийн шилдэг жишээ бол IPO хийгээд, магадгүй 20 хувь, 15 хувиа зараад, зарсан мөнгөөрөө магадгүй зэс хайлуулах үйлдвэр гэх мэтчилэн зүйлүүд барих бололцоотой л доо. Төмөр замын холболт ч гэсэн гэх мэтчилэн. Тэгэхээр үүнтэй холбоотойгоор тийм төлөвлөгөө байгаа юу гэж асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Батшугар гишүүн чухал асуудал хөндлөө. Энэ бас бидний хамтын эр зоригоос л их хамаарах зүйл. Бид хэд хэдэн зүйлийг ер нь хүлээн зөвшөөрөх ёстой. Жишээлбэл 1 дүгээрт бид нар төрийн албаны бүтэц данхайлаа гэж ер нь их ярьсан. Тэгсэн мөртөө жил бүхэн данхайлгах асуудлыг өөрсдөө л ингээд хийдэг. Тийм учраас одоо бид нар нэмж агентлаг байгуулах ч юм уу ийм агуулгууд дээр Их Хурлын гишүүд маань, ялангуяа 2025 оны төсөв дээр бол эр зориг гаргаж, хатуу зарчим барьж зогсох ёстой гэдгийг бас хэлье. 2 дугаарт үнэн. Бид нар жишээлбэл төрийн албаны энэ бүтцийг багасгая гэвэл бид нар монголчилж ингэж тоо бодож багасгаад ч юм уу, эсвэл механикаар багасгах гээд бол дийлэхгүй. Жишээлбэл харж байгаад энэ хавийг нь ингээд хасаад энэ талд нь хийчихье ч гэдэг юм уу. Тэгэхээр бид нар иж бүрэн хэмжээнд их өгөгдөл дээр тулгуурласан гүйцэтгэлийн үнэлгээг том түвшинд хийх ийм зөвлөх үйлчилгээг хамтдаа авах ёстой. Хамт явах ёстой. Нийслэл Улаанбаатар хот ч гэсэн яг үүнтэй адилхан ийм зарчмын шаардлагыг бол тавьж байгаа. Хаана сургууль, цэцэрлэг барих вэ гэдгийг Их Хурлын гишүүд төлөвлөдөг байж болохгүй. Энийг их өгөгдөл дээр тулгуурлаад яг хаана хэрэгцээтэй байгаа вэ гэдгийг л тэр хүнээс үл хамаарсан технологи өөрөө шийддэг байх зүйл рүү л хийгдэх учиртай. Энэ ч агуулгаар бид нар төрийн өмчит компаниуд гээд нэг их олон том зүйл байхгүй. Зүгээр маш энгийн жишээ хэл ам болоод байгаа Тавантолгой компаниасаа эхлээд Эрдэнэт үйлдвэрээ бид нар гаднын менежментээр удирдуулах ёстой. Гаднын менежментээр удирдуулах ёстой. Эсвэл худалдан авалтыг нь бид нар тусад нь салгаж авах ёстой. Тэгэхгүй бол бид нар дараа дараагийн хүмүүсийг бас хүнд асуудал руу оруулах асуудал хийгдсээр л байх болно. Тийм учраас энэ дээр Засгийн газраас ийм менежментийн багийг бүрдүүлэх тал дээр улс төрийн шийдвэр гаргаж бас Их Хуралдаа оруулж ирнэ. Тэгээд хамгийн их мөнгөтэйгөөсөө

авхуулаад л цэгцлээд явчихвал засаглалаа сайжруулсны дараа IPO хийх боломжтой. Тэгэхгүйгээр хямдхан бас жишээлбэл энэ стратегийн том компаниудыг өгөөд, энэ нь өөрөө бас буруу зүйл болчихвол өмч хувьчлал шиг ч юм уу ийм хэл амтай зүйл болчихвол бас өөрөө Үндэсний эдийн засгийн нөхцөл байдалд бол бас нөлөөлнө гэдгийг бас хэлэх нь зүйтэй. Ингээд төрийн бүтэц ялангуяа төрийн өмчит компаниудтай холбоотой төрийг цомхон багасгахтай холбоотой ийм том зарчмын асуудлууд орж ирж байгаа. Тэгээд энэ дээр хэдүүлээ хамтдаа зориг гаргая. Засгийн газар маш нээлттэй хандах болно. Гэхдээ Монголчлохгүйгээр яг олон улсын түвшинд яг олон улсын нийтлэг жишигийнх нь дагуу хамтдаа үе шаттай энэ 4 жил хийцгээе гэж хэлэхийг хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуултаа асууя.

Б.Энхбаяр: Надад 2 асуулт байна. Эхний асуулт нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 4.1.5.1-д улс төрийн намуудыг хатуу гишүүнчлэлээс татгалзуулна гэсэн ийм заалт орж ирсэн байгаа. Тэгэхээр Засгийн газарт хамтарч байгаа 3 намын хамтын нэгдсэн бодлого гэж ойлгож болох уу гэсэн эхний асуулт байна.

2 дахь асуулт нь мөрийн хөтөлбөрийн 4.1.1.15-д Монгол Улсын Үндсэн хууль, хууль, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд төрийн байгууллагын захиалгаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх чиг үүрэг бүхий хууль судлалын институцийг байгуулна гэсэн ийм заалт байгаа юм. Тэгэхээр энэ хууль судлалын институц гэдгийг хаана байгуулах гэж, юу хийх байгууллага байгуулах гэж байна гэж ойлгож болох вэ. Энд бичсэнээр бол 2 чиг үүрэг харагдаад байгаа юм. 1 дүгээрт хууль тогтоомжийн төсөл боловсруулна

гэж байгаа юм. Энэ бол Засгийн газрын Хууль зүйн яамны өөрийнх нь үндсэн чиг үүрэг байгаа. Хууль зүйн яамнаас тусдаа хуулийн төсөл бичдэг ийм институц байгуулах гээд байна уу гэсэн нэг ийм асуулт дотор нь байгаад байгаа юм. Нөгөө талд нь болохоор Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл нөгөө парламентын хяналтыг энэ хууль судлалын хүрээлэн хэрэгжүүлэх чиг үүргийг авахаар логик уншигдаад байна л даа. Хэрвээ энэ парламентын хяналтыг авах гэж байгаа бол энэ парламентын дэргэд байх гээд байх шиг байгаа юм. Одоо энэ парламентын судалгааны хүрээлэнг татан буулгах гээд байна уу, эсвэл Хууль зүйн яамны дэргэдэх Хууль зүйн хүрээлэн Парламентын судалгааны хүрээлэн 2-ыг нэгтгэх гээд байна уу. Эсвэл Хууль зүйн хүрээлэнг өөрчлөх гээд байгаа юм уу. Хэрвээ парламентын хяналтыг гэрээгээр хийх гэж байгаа бол энэ зарчмын асуудал байна. Энийг Засгийн газар өргөн барьж шийддэг асуудал би биш гэж үзэж байна. Яагаад гэхээр парламентын хяналт гэдэг бол Засгийн газраа хянах гэж байгаа институц байхгүй юу. Парламентын хяналтын асуудлыг Засгийн газар өргөн барьж, тэр дотроо парламентын гишүүд нь өөрсдөө хянадаг байсан чинь энийг нь төрийн бус байгууллагын статустай ч юм шиг ийм газраа гэрээгээр гүйцэтгүүлэх гэж байгаа Засгийн газар өөрөө өөрийгөө парламентаар биш, парламентын гишүүдээр биш гэрээт байгууллагаар хянуулдаг болгох гэж байгаа бол энэ бол зарчмын асуудал болж хувирна.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд хариулах уу. Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл.

О.Алтангэрэл: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Улс төрийн намын хатуу гишүүнчлэлээс татгалзуулах гэдэг бол бас энэ намуудын мөрийн хөтөлбөрт орсон. Цаашидаа бол энэ чиглэлээр явахаар бас намын

удирдлагуудад тохирсон байна. Бас тодорхой түвшинд яриа хэлцэлд хүрсэн. Бид нар бол хуулиа энэ чиглэл рүү өөрчлөх ёстой. Энэ бодлого руу явах ёстой юм байна гэсэн ийм ойлголттой байгаа. Харин тэр 4.1.1.15-ын хувьд бол Энхбаяр гишүүний саналыг 100 хувь дэмжиж байна. Ер нь Парламентын хяналт шалгалтын тухай хууль, Улсын Их Хурлын тухай хууль, энэ бүх хууль тогтоомжоор парламентын хяналт шалгалтыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлнэ гэж байхгүй. Хууль зүйн яамнаас хөтөлбөрт өгсөн саналууд дотор бол байгаагүй. Харин энэ хууль тогтоомжийн төсөл боловсруулахад Улсын Их Хурлын гишүүдэд дэмжлэг үзүүлэх бүтэц нэгжсийн талаар яригдаж байсан зүйл байгаа. Тэгэхээр энэ бол томъёоллын хувьд ч тэр, зарчмын хувьд ч тэр Энхбаяр гишүүний саналыг хүлээн зөвшөөрч байна. Тэгээд ажлын хэсэг дээр энэ асуудлыг анхаараад хасаад явахад болох байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Загджавын Мэндсайхан гишүүн асуултаа асууя.

З.Мэндсайхан: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр бүсийн төрөлжсөн хөгжил гээд тэргүүлэх болон дэд чиглэлийг томъёолж оруулж ирсэн. Энэ бол их бас зөв зүйтэй бол зүйл болж байна. Энийг дагаад цаашаа бол хөрөнгө оруулалтын урсгал нь төлөвлөгдөөд явах юм байна аа гэж ойлгож байгаа. Баруун бүсийн хувьд эрчим хүчний төрөлжсөн байгалийн аялал жуулчлалын дэд бүс гэж томъёолсон байгаа юм. Тэгэхээр баруун бүсийн эрчим хүчний төрөлжсөн төв гээд үзэхээрээ яах вэ, бид нар баруун бүсэд эрчим хүчний асуудлаа, тог цахилгааны асуудлаа шийдчихээд байна. Тэгэхээр нөгөө бүсүүдийн хөгжлийн ялгаа төвийн болон хөдөөгийн бүсүүдийн хөгжлийн ялгааг арилгах гол асуудал бол хот, хөдөөгийн асуудал бол орон сууцжуулалтын асуудал байгаа. Тэгэхээр эрчим хүчний бүс гэж тэргүүлэх чиглэлээ тодорхойлчихоод энэ дулааны асуудлыг орхичхоод байна. Аймгууд мөн ялгаа

байхгүй утааны асуудал бүрэн хөндөгдөж байгаа. Тэгэхээр энэ бүс нутагт дулааны станцууд барих асуудлуудыг яагаад оруулсангүй вэ. Энэ орон нутагт чинь орон сууцжуулалт явагдаж байж тэр утаа бүс нутгийн хөгжил хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэр чинь хангагдана.

Аялал жуулчлалын гэхээсээ илүүтэй энэ баруун бүс нутагт бол үйлдвэр технологийн парк мөн эрчим хүчний дэд бүтцийн асуудал нь шийдэгдээд явж байгаа. Тэгэхээр энийг аялал жуулчлалын бүс гэж томьёолохоосоо илүү хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бүс гэж дэд бүсээ томьёолмоор байна. Энэ чиглэл рүү чинь нийт газар тариалангийн болон мал аж ахуйн салбар чинь баруун бүстээ 30 орчим хувь нь байж байна. Хил боомтын хувьд асуудал байхгүй. Тэгэхээр энэ үйлдвэр технологийн яг хэрэгжээд явж байгаа үйлдвэр технологио түшиглээд дэд чиглэлээ бол хөдөө аж ахуй хүнсний үйлдвэрлэлийн бүс болгоё гэдэг.

2 дугаарт баруун бүс нутагт одоо үйлдвэрийг хөгжүүлэхгүйгээр л ажлын байрыг бий болгож, энэ бүс нутгийн хөгжлийн ялгааг арилгана уу гэхээс биш аялал жуулчлал хөгжөөд нэг их тэр бүс нутгийн хөгжлийн орлого нэмэгдээд явчих тэр боломж нь хомс байгаа. Одоо баруун бүсэд гурилын асуудал бас их хүндрэлтэй байна. Энэ хавар тарифаар зохицуулаад явж байгаа. Тэгэхээр газар тариалангийн эргэлтийн талбай гээд үзэх юм бол Увсын Баруунтуруунд манай баруун бүсийн хамгийн том даац бүс нутаг байж байгаа. Тэгэхээр хувийн хэвшилүүд бол гурилын үйлдвэрээ бариад явчих байх. Гол асуудал бол тэнд эргэлтийн талбай буюу 30-аас 25 мянга орчим га-г л усжуулах асуудал байгаад байгаа юм. Баруун бүсийн нийт хэрэглээ чинь 15-20 мянган тонн гурил л хэрэглэж байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар тэнд 20-25 мянган га газрыг л усжуулчих юм бол хувийн хэвшилүүд маань гурилын үйлдвэрээ бариад, цаашидаа тэр бүс нутгийн хүнсний хангамжийн асуудал шийдэгдээд явах энэ боломж нь байна.

3 дахь асуудал бол аялал жуулчлал гээд тавиад өгчихсөн мөртөө замын асуудал огт хөндөгдөөгүй байна. Тэгэхээр үнэхээр аялал жуулчлалыг тийшээ чиглүүлье гэж байгаа бол бүс нутгийн авто замын асуудлыг зайлиггүй энд оруулж ирэх асуудал байна гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ 3 асуудал дээр хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бид нар амилуулах ийм 4 жил. Тийм учраас бүс бүхэн 1 тэргүүлэх буюу төрөлжссөн, тэгээд 1 ийм дэд бүсийн статустай ингээд 2 зүйл дээр төвлөрөөд явчихъя гэж байгаа. Тийм учраас энэ хэлэлцүүлгийн явцад өөрчлөгдөх боломжтой. Баруун бүс бол эрчим хүчийг ер нь экспортлох, эрчим хүчний энэ олон усан цахилгаан станцууд баригдана. Мөн Говь-Алтай аймгаас авхуулаад нар салхины том нөөц бол байгааг судалгааны дүнгүүд гаргадаг юм байна лээ. Тийм учраас бид нар эрчим хүчний 2 төрөлжссөн бүстэй. 1 төрөлжссөн, 1 дэд бүстэй байна гэж орж ирж байгаа. Дэд бүс нь бол илүү говийн бүсдээ байх ийм боломжтой юм аа гээд. Тийм учраас баруун бүс нутгийн энэ аж үйлдвэржилт эрчим хүчээ дагасан ийм том боломж бол байна гэж харж байгаа.

Байгалийн аялал жуулчлал болон аялал жуулчлалтай холбоотой бас потенциалууд бол байгаа гэж үздэг юм байна лээ. Судлаачдын хувьд. Ялангуяа өвлийн аялал жуулчлал, байгалийн аялал жуулчлал гээд Баян-Өлгий аймгаас авхуулаад маш их том, олон боломжууд бол байгаа. Тэгээд шууд бас нисэх онгоцны буудлууд заавал Улаанбаатар хотод баригдахгүйгээр шууд очих ийм чиглэлүүд бол бас байгаа. Тийм учраас үүнийг Баруун бүсийн Их Хурлын парламентын гишүүд маань ярилцаад, яг энэ хэлэлцүүлгийн үеэр аль нь төрөлжссөн

байх вэ, аль нь одоо дэд бүс байх вэ гэдэг статусаа шийдчихвэл Засгийн газар тэр дээр илүү тулгуурласан ийм бодлого явуулах боломжтой бас болох юм гэж үзэж байгаа. Тэгээд бүгдээрээ яг адилхан болчхож бол болохгүй. Тэгэх юм бол ялгаа байхгүй л болчихно гэсэн үг шүү дээ. Яг урьдын явж байснаасаа. Тийм учраас энэ дээр манай Мэндсайхан сайд өөрөө бас Засгийн газрын гишүүн байсан хүн илүү оролцоод ингээд явчихвал бас болох байх гэсэн ийм бодолтой.

Баруун бүсийн хувьд бол мэдээж хүнс болон шатахуун олон зүйл дээр бол төрөлжсөн ийм татварын орчинтой байх бол боломжтой гэж үзэж байгаа. Тэгээд энэ агуулга дээрээ ч гэсэн ярилцаад явчхаж бол болно гэсэн ийм байр суурьтай байна.

Д.Амарбаясгалан: Ж.Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Баруунтурууны сангийн аж ахуй өөрөө баруун бүсийг үр тариа, гурилаар хангах гол зорилготойгоор анх байгуулагдсан. 40 мянган га орчим эргэлтийн талбайтай. Энэ Баруунтурууны эргэлтийн талбайг бүрэн дайчилж, ашиглаж, усжуулж, эрчимжүүлж чадвал баруун 5 аймгийг үр тариа, гурилаар бүрэн хангах бололцоотой. Сая баруун 5 аймгийн нийт гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэгцээг гаргаад үзэхэд 34 мянган тонн гараад байгаа юм. Тэгэхээр энэ 40 мянган га бол яг гурилдаа тараад л зогсоно. Яамнаас 10 мянган тонны үр тарианы агуулахын төсөл хэрэгжүүлээд, ажлын гүйцэтгэл эд өрнөж байна. Ойрын үед орчих байх. Хөтөлбөрт тусгасан том бодлого бол бүсчилсэн малын тэжээлийн үйлдвэрлэлийг байгуулж, өвс тэжээл нөөцүүдийг бүрдүүлэхгүйгээр энэ уламжлалт мал аж ахуйгаа байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах бололцоог хангаж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

Ж.Энхбаяр: Ер нь нийтдээ уламжлалт мал аж ахуй маань зайлиггүй өвөл, хаврын тэр хүйтэн сэрүүн үед нэмэлт тэжээлийн шаардлага их үүсэж байгаа. Энэ баруун бүс нутгийн мал аж ахуйг эрсдэлээс хамгаалахын тулд тэр бүс нутагт атар газрыг эзэмших талбай зайлиггүй нэмж, тэжээлийн тарилтыг эрчимжүүлж, тэжээлийн нөөцийг газар нутагт нь бэлтгэх ийм бодлогыг бас хөтөлбөрт тусгаж өгсөн байгаа. Ингэснээр үүнийгээ хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдгээ мөн Атрын 4 дүгээр аяныг хэрэгжүүлнэ гэсэн том бодлогын хүрээндээ хөрс, талбай, тэжээл ингээд үр сорт гээд бүх асуудал дотроо багтаж явна. Бүгдийг бас дэлгэх бололцоогүй байгаа юм. Тэгэхээр та энэ Атрын 4 гэсэн аяныг хараад яваад байгаарай. Баруунтурууныг бол зайлиггүй усжуулалтыг онцгой анхаарах, тэр агуулах савыг нэмэх, гурилын үйлдвэрийг байгуулах энэ бодлогыг хийх юм бол сая өнгөрсөн энэ зудны бэрхшээлээр бид нар аргагүй байдалд орж гурилын импортын татварын зохицуулалт хийсэн шүү дээ. Дээрээс нь дахиж ийм байдалд орохгүйн тулд баруун бүс нутаг Баруунтурууны аж ахуйг бол дээд зэргээр яам онцгой анхаарч бэхжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт авлаа. Ер нь Энхбаяр сайд зүгээр энэ дээр бас Улсын Их Хурлын гишүүний хувьд товчхон байр суурь илэрхийлэхэд энэ аливаа асуудлыг төр хийнэ гэдэг хандлагаасаа иргэдэд хийх боломжийг нь олгоно гэдэг хандлага руу чиглээд үр тариа, гурил будаа бүх зүйл иргэд, аж ахуйн нэгжүүд өөрөө хийх нөхцөлийг хангана гэдэг агуулгаа төвлөрүүлэхгүй бол эргээд бүх зүйлийг л төр хийгээд, бүх зүйлийг хангадаг тийм ойлголт руу явж болохгүй гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх гэж. Чойжилсүрэн сайд нэмэлт хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Гишүүдийнхээ өглөөний өдрийн амрыг эрье. Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Энэ мөрийн хөтөлбөрийн 3.1.1.39 дүгээр заалт дээр “аймгуудын төв болон сум суурин газруудын дулаан хангамжийн дэд бүтцийг сайжруулах, үр ашиг өндөртэй нүүрс, сэргээгдэх эрчим хүч, технологийг ашигласан станцуудыг байгуулах суурь судалгааг хийж төслүүдийг эхлүүлнэ.” гэсэн ийм заалт байгаа. Хэт аймаг болгоны төвөөр ярих юм мөрийн хөтөлбөр маань арай сунжруу, дэлгэрэнгүй болох байсан учраас ийм заалт орсон гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Загджавын Мэндсайхан гишүүн тодруулга.

З.Мэндсайхан: Нөгөө Баруун бүсийн аялал жуулчлал гээд дэд төвөө тодорхойлоод ирэхээр авто замын асуудал байгаа. Говь-Алтай аймаг, Завхан аймаг, Увс аймаг маань жишээлбэл Баян-Өлгий аймгийн сумууд маань авто замаар хатуу хучилттай замаар холбогдоогүй байна. Тэгээд энэ асуудлыг тодорхой хариулт авмаар байдаг.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Ер нь бол авто замын олон төслүүд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл, мөн төр, хувийн хэвшлийн бас хүрээнд ингээд олон төрлөөр хийхээр Засгийн газар төлөвлөж байгаа 1 дүгээрт.

2 дугаарт энийг бол мэдээж орхигдуулахгүй. Аль болохоор эрэмбэлж байгаад хамгийн эхэнд бол бид эдийн засгийн үр өгөөж өгөх энэ ач холбогдолтой замаа эхний ээлжид барьж байгуулж дуусгая гэж байгаа юм. Энэ замд юу орох вэ гэхээр хойд Дархан, Сэлэнгийн хоорондох 113км-ийн замыг нэн тэргүүнд бариад, хойд талын 4 урсгалтай 2 эгнээ замаа 1 дүгээрт дуусгах, 2

дугаарт Замын-Үүд-Чойр, Сайншианд-Чойр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайдын микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Хөшигтийн хөндий гэсэн ийм босоо тэнхлэгийн замыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийхээр төлөвлөж байгаа. Тэгэхээр энэ том замуудаа бол бид нар юуны өмнө бол эдийн засгийн үр өгөөжтэй замаа эхэлж барьж байгуулна.

2 дугаарт бол мэдээж баруун бүсийн алслагдсан бүс нутагт ажиллаж амьдарч байгаа иргэдийн болоод тэнд аялал жуулчлалыг дагуулаад дараагийн ээлжид энэ замыг явуулна. Мөн өмнөх сайдын үед хийгдсэн Азийн хөгжлийн банкттай байгуулсан гэрээ хэлэлцээрийг үргэлжлүүлээд хэрэгжүүлнэ гэдэг ийм бодлоготой байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя. 3 минутаар өгье хугацааг.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүд маань ингээд ойлгочиход маш хялбар болно. Аймгийн төвүүд хоорондоо холбогдохыг тусгасан хөтөлбөртэй. Аймгийн төвүүд хоорондоо. Боомтуудтай аймгийн төвүүд холбогдохыг, дунд нь байгаа сумуудыг холбохыг. Тэгээд үүнийг бүсчилсэн хөгжлийн 5 тойрог зам гэж нэрлэж байгаа. Тийм учраас аймгийн төвүүд хоорондоо, боомтуудтай холбох замууд холбогдоно. Дунд нь байгаа сумууд холбогдоно гэж хариулъя.

Д.Амарбаясгалан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд 120 орчим их наяд төгрөгийн төсөвтэй 149 байсан байх төсөл хөтөлбөр орж ирж байгаа юм байна. Ямар ч л байсан ер нь тооноос их айж эмээгээд байх шаардлагагүй гэж би

үздэг л дээ. Тэгээд энэ нэр ус нь ч гэсэн зоригтой, хурдтай хөгжлийн төлөөх зориг гээд уг нь бас нэлээн том зорилт тавиад орж ирж байгаа юм байна. Хамгийн гол нь Ерөнхий сайд аа, энэ доторх механизм нь яаж хэрэгжүүлэх вэ гэдэг механизмууд чинь ерөөсөө чухал шүү дээ. Энийгээ л харж чадаж л байвал энэ маань хэрэгжих бүрэн дүүрэн бололцоотой болдог. Энэ танхимд сайхан сайхан зүйлүүд ярьдаг. Яг очоод сайд нартай нь уулзахаар далий далий юм яриад байдаг ийм тал бий шүү дээ. Жишээ нь та сая хэллээ. Бүсчилсэн хөгжлийг бид нар бас нэлээн гишүүд маань зөв харж эхэллээ гэж байна. Гэхдээ яг үндсэндээ бодит байдал дээр бол бас л худлаа. Одоо ингээд удахгүй төсөв орж ирнэ. Хүссэн хүсээгүй өөрийнхөө аймаг дээр тавиад эхэлнэ. Сая эндээс Дамдинням гишүүн хэлж байна шүү дээ. Манай сайд манай тойргоос гарсан болохоор та тэр хөгжлийнхөө асуудлаар анхаараарай гэж байгаа байхгүй юу. Яг энэ мэтчилэн буцаад дахиад нөгөө аймаг, аймаг дээр юмаа тавиад эхэлнэ. Тэгэхээр миний яриад байгаа нөгөө механизм гэдгийг чинь яаж хийх юм. Хүн л юм болохоор компьютер биш шүү дээ. Хүн л юм болохоор энэ чинь нутаг орондоо тавьдаг юмнууд чинь хэзээ ч салахгүй. Тэгэхээр энийг яах юм, магадгүй зүгээр Эдийн засаг, хөгжлийн яам дээрээ тавих юм уу. Хаанаас нь яг энэ эрх мэдлийг нь байлгах юм. Эсвэл төсвийн тэдэн хувийг нь бүсчилсэн хөгжлийн асуудлыг шийднэ ч гэдэг юм уу эсвэл бүсчилсэн хөгжлийн тэр бүсчилсэн бүсүүдийн удирдлага байх юм уу, тэндээс саналыг нь авах юм уу нэг ийм механизм хэрэгтэй байх. Тэгэхгүйгээр дахиад л удахгүй төсөв дээр бид нар дахиад энийгээ тавиад л эхэлнэ.

2 дугаарт хувийн хэвшилүүдийг хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Дахиад доторх механизм чинь яаж явах юм. Хувийн хэвшил дээр бид нар ингээд ярьсаар ярьсаар, явсаар байгаад нэг мэдэхэд тэр хамгийн сайн менежер гэдэг рүүгээ буцаад оччихдог шүү дээ. Ярихдаа бид нар муу менежер гэж яриад байдаг.

Гэтэл хувийн хэвшилээ дэмжинэ гээд байдаг. Жишээ нь бид нар сая арьс ширний үйлдвэрүүдийг барихад та хэллээ нэлээн бүсчилсэн байдлаар тавья гэж байх шиг байна. Тэгвэл бүсчилсэн байдлаар жишээ нь хангайн бүс дээр ч байдаг юм уу Өвөрхангай дээр арьс ширний үйлдвэр тавилаа гэвэл яг ийм төрлийн арьс ширний үйлдвэр тийм хүчин чадалтай тийм үйлдвэр байна шүү гэдгийг нь гаргаад, магадгүй хувийн хэвшилд нь зарлаад, ингээд мафижсан байдлаар харж байгаад хэдэн үйлдвэр байх юм тэрийгээ жишээ нь зарлаад явах юм уу. Тэгэхгүй тэгээд л яам нь дахиад л аваад явах юм дахиад л биш болоод явчихна. Нэг ийм доторх механизмууд хэрэгтэй болчихоод байгаа юм.

2 дугаарт Тендерийн тухай хууль бид нар /... ашгүй Доржханд ороод ирлээ. Би түрүүнээс хойш хайгаад байсан./ Тендерийн тухай хууль одоо надад амлах хэрэгтэй байна. Үнэ уралдуулдаггүй, чанар уралдуулдаг энэ тендерийн тухай хуулийг би түрүүний 4 жил зөндөө олон ярьсаар байгаад бид нар Тендерийн тухай хууль.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Шадар сайд Доржханд хариулт өгье.

Т.Доржханд: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр төсвийн тодотголыг дагасан хуулиуд орж ирж байгаа. Тэр хуулиудын хүрээнд бол Худалдан авах ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт байдлаар орж ирж байгаа. Тэгээд маш олон ийм асуудлууд бол байна байна. Ажил хийе гэхээр хууль дээр асуудал байна. Яагаад вэ гэхээр чанаргүй бүтээгдэхүүн оруулж ирэх тэр зохицуулалт нь байна гэсэн ийм буруу ойлголт бас яваад байна. Би бас энийг залруулчихмаар байгаа юм. Тэгээд яагаад тэнд гацаа үүсээд байна гэдэг дээр бид нар бас тодорхой ойлголттой болохгүй бол болохгүй байгаа юм. Тэгэхээр ийм шүү. Манай Худалдан авах ажиллагааны хууль маань 2000 онд хийгдсэн юм. Би өөрөө энийг анх хууль хийж байхад

Сангийн яаманд яг энэ газарт нь байсан юм. Тэгээд хуулийг нь батлуулаад, бүх бичиг баримтуудыг нь орчуулж байсан. Олон улсын байгууллага, НҮБ, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Фидик гээд бүх зарчмууд дээр суурилсан ийм зохицуулалт юм. Ингэхдээ 2 зарчим байдаг. Тендер зарлалаа бол эхлээд техникийн тодорхойлолтод шаардсан чанартай тийм бүтээгдэхүүнүүдийн саналыг хүлээж аваад, шалгаад, чанарын шаардлага хангасан тэр саналуудыг нь тусад нь нэгтгэж авч байгаад дараа нь санхүүгийн саналыг нь хийдэг байхгүй юу. Үнийг нь. Энэ бол ингээд олон улсын зарчим нь юм байгаа юм. Ингээд шаардлага хангасан тэр үнийн саналуудыг чанарын шаардлага хангасан тэр саналын үнийн саналыг нь нээгээд л хамгийн багыг нь авдаг. Энэ бол ингээд олон улсын тогтолцоо юм. Яг энэ зарчмаар манай Монгол Улсын худалдан авах ажиллагаа явдаг юм. Асуудал нь хаана байна гэхээр Бат-Эрдэнэ гишүүн ээ, нөгөө та бол мэдэж байгаа шүү дээ Төрийн нарийн бичгийн даргаар олон жил ажиллаж байсан.

Асуудал нь манай стандарт нь байхгүй байгаа байхгүй юу. Цөөхөн стандарттай тэрийгээ мөрдүүлж чаддаггүй. Дээрээс нь нөгөө ажлын хэсэгт орсон хүмүүс чинь чанартай бараа бүтээгдэхүүн авах тэр стандартаа тавьж өгөхгүйгээс болоод аягүй шаардлага муутай, чанар муутай бүтээгдэхүүний хамгийн бага үнийн саналыг нь сонгох болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хуульдаа бол тийм асуудал биш байгаа юм. Асуудал нь хаана вэ гэхээр стандартаа бид нар дээшлүүлэх хэрэгтэй байгаа. Стандартаа ашиглаж сурдаг байх хэрэгтэй. Стандартаа мэддэг төрийн албаны тэр хүмүүс нь байх ёстой байгаа юм. Тэгэхээр нийт тендерийн чинь 29 хувь нь Худалдан авах ажиллагаа нь агентлагаар яваад байгаа шүү. 71 хувь нь болохоороо яамнуудаар, хөдөө орон нутгаар бүгдээр ингээд тарж яваад байгаа. Тэнд чинь яг үүгээр мэргэжсэн

хүмүүс байхгүй болохоор чанарын асуудал гарч ирээд байгаа юм. Одоо хуульд юу гэж орж ирж байна вэ гэхээр томоохон хэмжээний бүтээн байгуулалтуудыг бол мэргэжлийн албаар нь явуулъя гэсэн байдлаар богинохон хугацаанд хурдхан шийддэг байя. Дараа нь нөгөө гомдол гаргасан өөрөөр хэлэх юм бол нөгөө тендер шалгаж чадаагүй 10 хүн орлоо гэхэд 9 нь гомдолтой гарчихдаг, 1 нь болохоор баярлаад гарчихдаг. Тэгэнгүүт бүгдээрээ очоод гомдол гаргаад шүүх дээр очоод гацаагаад хаячихдаг. Үүнээс чинь болоод ажил явахгүй байна гэдэг зүйлийг манай гишүүд өмнөх 4 жил ч гэсэн маш их ярьдаг байсан. Тэгвэл энийг нь илүү хялбарчлах байдлаар явъя гэсэн ийм байдлаар бид нар аль болох хүнээс хамааралгүйгээр цахимжсан байдлаар шийдлээ хийе гээд явж байгаа.

Харин одоо энэ төсвийн тодотголоор бол орж ирж байгаа зүйл нь юу вэ гэхээр маш богино хугацаанд бид нар шийдлүүдээ гаргаад, үүнийгээ хийчихье. Тэгээд энэ намрын чуулганаар багтаагаад таны яриад байгаа асуудлуудыг ажлын хэсэг дээрээ ярьж байгаад шийдье гэсэн байдлаар бас ингээд ажиллаж байна. Та саналаа өгөөд явахад бэлэн байгаа шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя. Дараа нь хотын дарга.

Л.Оюун-Эрдэнэ: Бат-Эрдэнэ сайдын асуултад баярлалаа. 76-тай парламент тойргоос сонгогдсон тогтолцоотойгоо түүх болж үлдсэн. Энэ бол ингээд өнгөрсөн 30 жил. 126 гишүүнтэй холимог тогтолцоогоор бүрдсэн бүсчилсэн тойргоос сонгогдсон анхны парламент Монгол Улсад 1992 оноос хойш бүрдлээ. Тийм учраас анхны төсөв. Тийм учраас би Бат-Эрдэнэ сайдтай 100 хувь санал нэг байна. Засгийн газраас бид нар 2025 оны улсын төсөв дээр зам, эрчим хүч, дэд бүтэцтэй л холбоотой асуудлыг оруулж ирнэ. Энийг Сангийн сайд бас зориг гаргаад ингээд шийдэх хэрэгтэй. Уламжлалт

байдлаараа харин гишүүд маань надад тэдэн төгрөг дээр ийм зүйл тавиад өгчих, манай аймаг дээр ийм зүйл тавиад өгчих, манай сумд ийм зүйл тавиад өгчих гэдэг зүйлээсээ 2025 ондоо татгалзчих. Тэгээд 3 жилийн хугацаанд бүтэн санхүүжих байдлаар 3 хуваагаад л хэдүүлээ санхүүгээ тавья. Тэгээд бусдыг нь хэдүүлээ хувийн хэвшил мөн хөрөнгө оруулагч дээр хийлгэх гэдэг зүйл рүүгээ эрх зүйн орчин болон бусад орчноо сайжруулъя. Ийм зоригийг л гаргахын тулд бид нар парламентыг холимог тогтолцоонд оруулсан Ийм зоригийг л гаргахын тулд хамтарч байгаа. Тийм учраас энэ реформыг 2025 он дээрээ хийчихье. Тэгээд л яг үнэн. Ярьж байгаа шигээ л байя. Ярьж байгаа шигээ л байя. Хөшигний цаана өөр юм ярихгүй байя. Яг чуулганы танхимд микрофон дээр ярьж байгаатайгаа л адилхан байя. Би яг энэтэйгээ адилхан байна. Түүнийг амлаж байна.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Хотын дарга Нямбаатар нэмж хариулт өгье гэсэн. Худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой. Индэр дээрээс хариулт өгнө. 1 дүгээр индэр.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн мэндийг эрье. Миний бие Монгол улсын төсвийн тодотгол дагасан зарим хууль тогтоомжуудыг боловсруулах ажлын хэсэгт ажилласан. Энэ утгаараа би бас өнөөдөр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд орж байгаа хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбоотой хэдэн зүйлийг нэмж хэлэхийг хүсэж байна. Би 3 зүйлийг онцолж хэлэхийг хүсэж байна.

1 дүгээрт энэ хуульд их олон жил түлхүүр гардуулах нөхцөл гэдэг зохицуулалт байсан. Сүүлд орсон өөрчлөлтөөр бэлэн шийдэл гэж томъёолж байсан. Тэгвэл бид сая анх удаагаа Фидик буюу Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооны үлгэрчилсэн дүрмийн дагуу ЕРС нөхцөлөөр тендер

сонгон шалгаруулалтын зохицуулалтыг энэ удаагийн тендерийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд оруулсан гэдгийг та бүхэнд хэлье. Ингэснээрээ бид нар олон улсын хэмжээний томоохон төсөл хөтөлбөрүүдийг олон улсад нэр хүндтэй гүйцэтгэдэг компаниудтай хамтран ажиллах ийм эрх зүйн бүрэн боломж, нөхцөл бүрдэж байгаа. Энэ дотор сая бидэнд нэлээн амьдрал дээр олон зүйл тулгамдсан. Метроны тендерийн шалгаруулалттай холбоотой. Энэ дээр гарсан бүх алдаа дутагдлуудаа бид нар бас засахыг хичээж, олон улсын жишигт нийцүүлж явж байгаа. Тухайлах юм бол төлбөрийг ямар валютаар хийх вэ, маргаан үүсвэл хаана шийдэх вэ, Фидикийн дүрмийн аль нөхцөлөөр бид нар Silver багцыг сонгох вэ, Gold багцыг сонгох вэ гэдэг энэ зохицуулалтуудыг аль болох оруулж ирэхийг хичээлээ.

2 дахь оруулж ирж байгаа гол зохицуулалт бол томоохон төсөл хөтөлбөрүүдийг бид нар үнийн дүн болон хийж гүйцэтгэх цар хүрээнээс нь шалтгаалж олон улсад нийтлэг нэрлэгддэг селектэд прокурормент гэдэг энэ зохицуулалтыг бас энэ удаагийн тендерийн тухай хуульд оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл тодорхой мега төслийг хэрэгжүүлэхэд дэлхийд эхний 5-д байдаг, 10-д байдаг нэр хүндтэй компаниудад бид нар урилга хүргүүлээд уг урилгыг хүлээж авсан аж ахуйн нэгж, байгууллагууд бидэнд эргэж хандсан тохиолдолд тэн дээр нь шалгаруулалт хийх энэ зохицуулалтыг нэлээн процессжуулж оруулж ирсэн гэдгийг хэлье.

3 дахь нь сая Бат-Эрдэнэ гишүүний асуусан чанар гэдэг зохицуулалтыг хэрхэн худалдан авах хуульд оруулж ирж байгаа вэ гэдэг дээр бид нар ялангуяа дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүд дээр тендер шалгаруулалт хийж байгаа тохиолдолд тухайн салбарын тэр төрийн захиргааны төв байгууллагаар чанарын үнэлгээг тогтоолгох, чанартай холбоотой шалгуур үзүүлэлтийг мөн тогтоодог үлгэрчилсэн дүрмүүдийг оруулж ирсэн.

Түүнээс гадна өнөөдөр яг аж ахуй эрхлэхэд тулгамдаж байгаа хэд хэдэн удаа тендер зарлаад, уг тендер сонгон шалгаруулалтад тодорхой аж ахуйн нэгж, байгууллагаас 1 ч санал ирүүлээгүй тохиолдолд олон улсын Ай Си Ди-гийн анх санаачилгаар батлуулсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бат-Эрдэнэ гишүүн тодруулга.

Ж.Бат-Эрдэнэ: Сая зүгээр тендерийнхээ тухай хуульд өөрчлөлт оруулах уу, үгүй юу тэрийгээ хэлээдэх гэсэн. Өөдөөс одоо яасан чанга байх юм эд нар гээд л эхэлж байгаа байхгүй юу. Амьдралтайгаа ойрхон байя л даа. Нямбаатар ярьж байна шүү дээ. Тэр зовлонг нь одоо үзээд байгаа байхгүй юу даа. Амьдрал дээр ондоо байгаа шүү дээ. Тэгээд наадхаа зас л даа. Өөдөөс томроод байх юм.

Ерөнхий сайдад баярлалаа. Тэр цаад талын механизмынх нь асуудлуудыг бас хараад ингээд явах нь зүйтэй байх гэж бодож байгаа шүү. 2 дугаарт хөдөө аж ахуйтай холбоотой асуудлаа ер нь яах вэ. Энэ Шинэ Зеланд, Австрали гэсэн орнуудын туршилагыг судаллаа гэсэн байна. Энэ бол жинхэнэ нөгөө хөдөө аж ахуйг чинь хөгжүүлсэн улсууд шүү дээ Энхбаяр сайд аа. Энэ дээр нэг хариулт өгөөч. Яг энэ журмаараа явж байна уу. Нөгөө хөдөө аж ахуйгаа яаж хөгжүүлэх юм, яаж мөнгөжүүлэх юм, яаж тэр хөдөө аж ахуйн ядуурлаас нь гаргах юм, яаж олон улсын түвшинд хүргэх юм. Энэ тал дээр нэг хариулт өгөөч. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулт өгье.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн салбарт томоохон бодлогууд хэрэгжихээр орсон. Эндээс ялангуяа био технологийнхоо ололт амжилтыг сайн ашиглаад, өндөр ашиг шимт махны болон сүүний үхэр сүргийг 200 мянган толгой тоонд оруулахаар орсон байгаа. Яагаад гэвэл нийт Монгол Улс маань 5 сая

үхэртэй мөртөө сүүнийхээ сүүн бүтээгдэхүүний 50 хувийг импортоор авч байгаа. Манай эрчимжсэн гэж байгаа энэ бүс нутгийн 1 үнээнээс гарч байгаа сүүний дундаж жилийн саальтай бол 1300 литр л гарч байна. Гэтэл олон улсад 10 мянган литр лүүгээ хүрчхээд байгаа. Тэгэхээр яаралтай энэ өндөр ашигт мал сүргийнхээ үржил селекцийн бодлогыг нь урагилуулъя. Мөн тэжээлийн баазыг яаралтай өргөтгөж өгье. Тэгснээр энэ бусад гахайны, тахианы, өндөгний, сүүний аж ахуйнууд хөгжих суурь гарах юм. Энэ бүх бодлогоо бол Атрын 4 дүгээр аян гэдэг хүрээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нямтайширын Номтойбаяр гишүүн асуултаа асууя.

Н.Номтойбаяр: Өдрийн мэнд хүргэе. Их Хуралд сөрөг хүчний үүрэг гүйцэтгэх Үндэсний эвслийн ирэх 4 жилд барих гэрийн даалгавар болсон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр орж ирж байна. Гар дээр ирээд 2 хонож байна. Хараахан гүйцэд танилцаж амжаагүй байна. Гэхдээ зарчмын хувьд хэд хэдэн санал, шүүмж, асуулт байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн улс төр, нийгэм, эдийн засгийн үзэл баримтлал юу вэ. Яагаад энийг асууж байна гэхээр урьдын олон олон бодлогууд Их Хурал дээр орж ирж байсан. Бодитой хэрэгжилт нь анх Их Хурал дээр орж ирсэн бодлогынхоо цаастай огт нийцэж явж байгаагүй. Энэ удаагийн Засгийн газар 3 өөр улс төрийн үзэл баримтлалтай намуудын нэгдэл бүхий эвслийн Засгийн газар. Тэгээд энэ богинохон хугацаанд энэ улс төр, нийгэм, эдийн засгийн үзэл баримтлалынхаа нэгтгэлийг яаж хийж, ямар эдийн засгийн систем тодорхойлж, энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулав 1 дүгээр асуулт. Ер нь миний зорилго ам өчиг л авчих гээд байгаа юм. Анхнаасаа.

2-т нь юу вэ гэхээр 120 их наяд доллароор бол 35 орчим тэрбум доллар. Тоон дүндээ асуудал нь ердөөсөө биш.

Нөгөө олон улсын томд тооцогдохгүй компанийн л 4 жилийн бизнес төлөвлөгөөний санхүүжилт шүү дээ. 35 тэрбум. Гэтэл саяхан, өнгөрсөн хавар бидэнтэй хөгжлөөрөө нэг их хол зөрөөгүй Узбекистан мөн л соц коммунист орон байсан. Одоо 800 тэрбум долларын хөрөнгө оруулалтын асуудал яригдаж байгаа. Учир нь юу вэ гэхээр засаглалын тогтолцоо нь маш зөв. Хууль, эрх зүйн орчин таатай нөхцөлийг бүрдүүлж чадсан. Хувийн хэвшилээ төр нь туслан дэмждэг. Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж чаддаг эрх зүйн орчинтой. Төсвийн урсгал зардал нь биднийх шиг ийм том, үрэлгэн тийм зардал ердөөсөө бараг байхгүй. Ингээд маш тийм том суурь эдийн засаг, эрх зүйн тогтолцоог тавьж чадсан учраас 800 тэрбум долларын хөрөнгө оруулалт гэдэг бол юу ч биш санагдаж л байгаа байхгүй юу. Одоо бид нар хөөрхий 35 тэрбум долларын асуудал л яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр би эндээс юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр нөгөө тоондоо биш. Бид энэ төсвийнхөө урсгал зардлыг олон төрийн өмчит ашиггүй үйл ажиллагаатай үйлдвэрийн газруудыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж авах юм уу тодруулга авах юм уу. Нэмж 1 минут.

Н.Номтойбаяр: Тэгэхээр энийгээ бид нар хармаар байгаа юм. Өөрөөр хэлбэл эргээд бид энэ 2050 гээд хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны 5 жилийн төлөвлөгөөт хөтөлбөр, өмнөх бодлогууд энэ бас алдаатай гэдгийг мэдсээр байж үүн дээр сууриалаад энэ Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр орж ирээд байгаа юм. Тэгээд эцсийн дүндээ юу вэ гэхээр энэ хөтөлбөрийн үр дүн цалин, тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, ядуурал бууралт нь хэр байх юм. Худалдан авах чадамж нь хэр байх юм. Төгрөгийн ханишийн чадамж хэр байх юм. Гадаадын хөрөнгө оруулалтын итгэл дэмжлэг, тэлэх цар хүрээ нь хэр байх юм. Дотоодын аж ахуйн нэгжүүд яах юм. Маш тодорхой тоон

үзүүлэлтүүдээр энэ гарааны эхэн дээрээ ам өчгөө аваад тогтчихмоор байгаа юм. Тэгэхээр Ерөнхий сайд энэ дээр тодорхой хариултууд өгөөч.

Мэдээж бас зарчмын санал байна. Амарбаясгалан дарга аа, энд нэг их яарах шаардлага байхгүй. Шаардлагатай бол ээлжит бус чуулганахаа хугацааг 27-оос хойш сунгачихъя. Яагаад гэхээр энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хэлэлцээд, цаашидаа хугацаанаасаа хамаараад шаардлагатай тохиолдолд чуулганаа сунгаад хуралдуулаад явж болно. Эдийн засгийн хөгжлийн бодлогын асуудлаар Тэргүүн шадар сайд хариулт өгье.

Л.Гантөмөр: Номтойбаяр гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн үзэл санаа юу юм бэ гэж. Энэ одоо хамгийн чухал зүйл энэ өнгөрсөн хугацаанд шийдэж чадаагүй хөгжлийн асуудлаа шийдье ээ л гэж байгаа юм. Ядуурлаас гаръя гэж байгаа юм. Ядуурлаас гарах эдийн засгийн шийдэж чадаагүй асуудал гэж юу вэ гэхээр хөрөнгө оруулалт татах тэр орчноо бид нар бүрдүүлж чадаагүй. Тэрийгээ бүрдүүлье, хөрөнгө оруулагчдыг хамгаалах, дэмжих орчноо бүрдүүлж чадаагүй. Тэрийгээ бүрдүүлье. Хууль, шүүхийн байгууллагын бие даасан байдлыг хийж чадаагүй. Тэрийгээ хийе. Парламентын засаглалыг жинхэнэ утгаар нь бид нар тогтоож чадаагүй. Тэрийгээ хийе. Эргэлзэж тээнгэлзэхгүйгээр бид сонгож авсан Үндсэн хуулийнхаа үзэл санааны дор тулгамдсан хөгжлийн асуудлуудаа шийдье гэдгийг бол 1 дүгээрт хэлмээр байгаа юм.

2 дугаарт бол улс төрийн намууд сонгуульд орохдоо мөрийн хөтөлбөрөө зарлаад ордог. Ард түмэн бол тэр сонгуульд орсон мөрийн хөтөлбөр дээр саналаа өгдөг. Бид хамтарсан үндсэн шалтгаан бол ард түмний өгсөн саналыг сонгогчдын өгсөн саналыг гээхгүйг л

үндэслэлээ болгож байгаа юм. Тийм учраас мөрийн хөтөлбөрт тусгагдсан заалтуудыг ажил хэрэг болгох нь өөрөө улс төрийн соёл, улс төрийн суурь зарчим. Эндээс бол Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын мөрийн хөтөлбөрийн 50-аас дээш хувь нь биелэхээр бид төлөвлөж оруулж ирж байгаа юм. Ийм зүйл байгаа гэдгийг хэлмээр байна. Тэгээд үнэндээ бид энэ төрийн оролцоог нэмэгдүүлэх гээд 140 хэдэн төсөл зарлаад байгаа хэрэг биш шүү дээ. Эндээс 30-аад нь яалт ч үгүй нийгмийн чиглэлийн дэд бүтцийн асуудлууд байгаа. Энийгээ бол төсвийн хөрөнгөөр шийднэ. Үүний 30 хувь нь хувийн хэвшил хийнэ. Хувийн хэвшил хийхдээ тэрний тодорхой хэсэг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр хийгдэнэ. Тийм учраас бид бол энэ 120 их наяд төгрөг гаргаад, тэгээд ингээд ажил хийх гээд байгаа хэрэг биш ээ. Үүндээ бас баригдах гэж байгаа хэрэг нөгөө талдаа ерөөсөө биш. Бидний стратеги бол эдийн засгийг 1 хүнд оногдож байгаа дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган долларт хүргэнэ. Энийг танд амламаар байгаа юм. Их Хурлын гишүүд бол үүний төлөө явна. Засгийн газар үүний төлөө явна гэдгийг. Ингэж явахдаа бид нар бол мэдээж нөөцөө арвижуулаад явна. 2028 онд бид нар 10 тэрбум долларын нөөцийг үлдээнэ. Дээр нь алтны нөөцтэй болно. Ингэхэд төр засаг гэхээс илүү хувийн хэвшлийн хүчийг дайчлах ёстой. Бид бол хувийн хэвшилтэйгээ нягт хамтарч ажиллана. Садаа болдог, гай болдог, дээрэлхдэг,, дарамталдаг энэ хандлагыг бүр мөсөн хална.

Түрүүн Энхбаяр гишүүн асууж байсан. Намын гишүүнчлэлийн тухайд ямар заалт ороод ирэв гэж. Үзэл бодлоос нь болоод ялгаварлан гадуурхдаг, намын гишүүнчлэлээс болоод ялгаварлан гадуурхдаг зүйлийг манай Засгийн газар бүрэн халах ийм л зорилгыг дэвшүүлж байгаа. Ерөнхий сайд бол энэ дээр маш хатуу байр суурь илэрхийлж байгаа. Ингэж бид үзэл бодлоосоо болоод улс орны эрх ашгаа уландаа гишгэдэг байдлыг

бол бид халж байж, улс орны эрх ашиг нэгд юм гэдэг зарчим дээрээ гарч ирэх юм.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Энэ өдрийн мэндийг хүргэе. Эдийн засаг, хөгжлийн яам байгуулагдсанаар бол төсөл хөтөлбөрүүд рүү бол эрэмбэлдэг болсон байх учиртай. Засгийн газрын мөрийн хөтөлбөр орж ирэхдээ төсвийн бодлоготойгоо, төсвийн хүрээний мэдэгдэлтэйгээ мөн нийгэм, эдийн засгийн үр ашгийн тооцоололтойгоо орж ирдэг баймаар байна. Гантөмөр сайдад өнөөдөр эдийн засгийг 7 хувийн өсөлттэй, 5,5 тэрбум долларын нөөцтэй, 5,7 хувийн инфляцын түвшинтэй хүлээлгэж өгсөн байгаа шүү. Хүлээлгэж өгсөн байгаа. Дараа жил цөмөөрөө үүнийхээ үр дүнг ярилцана. Яагаад энийг ярьж байна гэхээр ер нь төсөв ч байна уу, үйл ажиллагааны хөтөлбөр ч байна уу, ер нь *mass to have, nice to have* гэдгээр л ангилдаг юм л даа. Яг ямар төсөв үйл ажиллагааны хөтөлбөрөөсөө төсвөөрөө хийх юм. Заавал ч үгүй хийх юм. Аль төсөл хөтөлбөрийг бид нар төр, хувийн хэвшлийн түншлэлээрээ хийх юм. Тэр нь болохоор нийгмийн ач холбогдолтой байж болно. Эдийн засгийн буюу яг тэр үр ашигтай төслүүдээ хувийн хэвшилээр хийлгэнэ гэж байвал өнөөдрийн энэ орж ирсэн бичиг баримтуудтай хамт Хөрөнгө оруулалтын хууль чинь орчинтойгоо, тэрэнтэй уялдуулаад татварын хөнгөлөлттэйгөө орж ирэх ёстой байсан. Яг одоо энэ олон төсөл хөтөлбөрүүдээс алийг нь төр яг өөрөө хийх гэж байгаа юм. Алийг нь яг хувийн хэвшилээр хийлгэх гэж байгаа юм. Хувийн хэвшил хийвэл тэр хувийн хэвшилд ямар хөнгөлөлт өгөх юм. Тэрнээс улбаалаад эдийн засагт ямар үр ашиг авчрах юм. Эсвэл нийгэмд ямар асуудлыг шийдэх гэж байгаа нь ерөөсөө харагдахгүй байгаа байхгүй юу. Энэ дээр би ганцхан жишээ хэлэх гээд байгаа юм. Ингээд гадаадын зээл тусламжаар хиймэл дагуулын төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ гээд. Старлинг гээд компани

5, 6 мянган хиймэл дагуултай. Манайх тэр зээлээр энэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр амбицын хойноос яваад байгаа юм уу, эсвэл энэ компанитай өрсөлдөх гээд байгаа юм уу. Старлинг гэдэг компани бол тухайн орны нийгэмтэй холбоотой салбарууд дээр нь төрийн нийтийн үйлчилгээний холбоотой салбарууд дээр нь л хөнгөлөлт үзүүлдэг байхгүй юу. Сургуулийн юм уу, эмнэлгийн орон нутгаас байршсан эмнэлгүүдэд бол интернэтийг үнэ төлбөргүй үзүүлдэг. Бид нар тийм хэлэлцээрийн хойноос явах ёстой байсан. Тэгтэл энэ юунууд дээр чинь бол тийм юм харагдахгүй байгаад байна.

Мөн Засгийн газрын хөтөлбөртэй холбоотойгоор яг энэ орчны бохирдолтой холбоотой хуулиа, багц хуулиа өргөн баримаар байна. Засгийн газрын бүтцээс харах юм бол 5, 6 сайд чинь агаарын бохирдолтой тэмцээд байгаа байхгүй юу. Өнөөдөр та бүхэн маань ингээд зун хөдөө орон нутгаар явсан л байгаа байх. Хот, суурин газруудын тэр хогтоо яаж дарагдсан байна.

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Х.Ганхуяг: Хот, суурин газруудын тэр хог хаягдсан байгаа байдал, ангилахгүй байгаа байдал, өнөөдөр сэргээгдэх эрчим хүч ч байдаг юм уу, эсвэл гибрид машин ч байдаг юм уу, цахилгаан машин гээд асар их хэмжээний аккумулятор хог хаягдал гарч байна. Хог хаягдлаа ангилдаг баймаар байна. Шаардлагатай бол татаас өгдөг баймаар байна. Техникийн тохирлоо шинэчилмээр байна. Стандарттаа шинэчилмээр байна. Шаардлагатай бол тэр зөвшөөрөлцүүлэх, бүртгэлжүүлэх энэ асуудлыг шийдэхгүй бол бид нар ер нь чимээ дууны бохирдолдоо ч дарагдаад дуусаж байна. Улаанбаатар. Тоосжилтын бохирдолдоо дарагдаж байна. Монгол Улс тэр даяараа хогтоо дарагдаж байна. Нүхэн жорлондоо дарагдаж байна. Энэ асуудал дээр

дорвитой арга хэмжээ авмаар байна Засгийн газраас. Энэ орчны бохирдолтой холбоотойгоор багц хуулиа өргөн баримаар байна. Бүх талаас нь харж байгаад.

Д.Амарбаясгалан: Үг хэлчихлээ. Учрал сайд асуултад хариулъя.

Н.Учрал: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулиар энэ Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсаны дараа хэрэгжүүлэх төлөвлөгөөг Засгийн газар оруулж батална. Тэгэхээр үүн дээр бол хэрхэн ямар арга хэмжээ авах вэ гэдгийг нарийвчлан зохицуулна гэсэн. Тэгэхээр энэ 15 тэргүүлэх чиглэлийн төсөл дотор яагаад энэ сансрын үндэсний хиймэл дагуул орсон юм бэ гэхээр манай улс бол 330 сумаасаа 325 сумыг шилэн кабелиар холбосон байдаг. Одоо бараг 1680-аад баг байгаагаас гэхэд яг шилэн кабелиар холбогдсон багууд ерөөсөө 150 орчим л байна уу, үгүй юу яригдаж байна шүү дээ. Тэгэхээр бид улс эх орныхоо 26 хувь дээр нь л шилэн кабелийн интернэтийг оруулсан. Бусад 73 хувь дээр нь огт оруулаагүй. Хэрвээ малчин өрхүүдэд тэр орон нутагт интернэт оруулаа гэх юм бол 28 их наяд төгрөг шаардлагатай байгаа юм. 28 их наяд төгрөг. Тэгээгүй цагт өнөөдөр энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг нөгөө төсвийг их өгөгдөлд суурилан төлөвлөх, нөгөө орон нутагт байгаа хүмүүс дээр хиймэл оюун ухааныг ашиглаад оношилгоо шинэжилгээ хийх, интернэтийн хүртээмж, шинэ технологийг ашиглаад хөдөө орон нутагт энэ үйлчилгээг хүргэхэд бол бид 28 их наяд төгрөг зарцуулж байж л энийг хүрэх байхгүй юу. Тэгэхээр Ганхуяг гишүүний яриад байгаа энэ Старлинг гэдэг бол нам орбитын хиймэл дагуул. Үндэсний хиймэл дагуул гэдэг бол 30 мянган км-ийн цаана байршидаг. Энэ бол нэг талаасаа үндэсний аюулгүй байдлын асуудал. Бид нар бол харилцаа холбооны салбарт бие даасан байдлыг тогтооно. Дээрээс нь газрын

станц байгуулагдах юм. Одоо та бүхэн мэдэж байгаа. Наран станц гээд Орбитод байгаа. Энэ наран станц дээр түшиглэнэ. Дорнодод, Өмнөговьд, Дарханд гээд ингээд 4 газрын станц байгуулахаар нөгөө ремөүт контрол буюу тэр хиймэл дагуулаа удирддаг. Тэгж байж интернэтээр орж ирж байгаа урсгалууд нь өөрөө аюулгүй байдлаас ахидаг. Тэгэхээр нэг ёсондоо 28 их наяд төгрөг зарцуулж интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх байгаа асуудлыг хэмнэлт үүсгэж байгаа юм.

2-т манай өнөөдрийн оператор компаниуд жишээ нь *Корсан Сат* буюу Солонгосын хиймэл дагуулд жил болгон төлбөр төлдөг шүү дээ. Энэ тооцоолол нь хувийн компанийн мэдээлэл учраас нарийн ярьж болохгүй байна. Тэгэхдээ энэ бол жишээ нь зөвхөн эхний байдлаар 20 сая долларыг жилд төлж байсан. Тэгэхээр эд нар чинь юу вэ гэхээр гаднын хиймэл дагуулд төлбөр төлөөд, энгийнээр бол айлын карман өрөөг л түрээсэлж амьдарч байгаа л улс байхгүй юу. *Старлинг* гэдэг энэ нам орбитод ингээд тойрч байгаа жижиг ийм станцууд. Тэгэхээр бид нар үүнийг хянах бололцоо байхгүй. Үүнийг удирдах бололцоо байхгүй. Ямар ч бололцоо байхгүй. Тэгэхээр энэ бол нэг боломж. Харин ч өнгөрсөн Засгийн газрын үед харилцаа холбооны хуульд өөрчлөлт оруулаад, нам орбитын үйлчилгээг эрхэлж байгаа *Старлинг* компанид зөвшөөрлийг олгосон. Энэ *Старлинг* шиг маш олон нам орбитын компаниуд байдаг. Тэр компаниуд бол цаашидаа Монголд арилжааныхаа журмаар орж ирнэ. Тэрнээс биш *Старлинг*ийн хэмжээний төлбөрийг төлөөд малчин айл өрх болгон интернэтэд орно гэж байхгүй ээ. Дээрээс нь энэ чинь ямар ч хяналт байхгүй. Ямар ч давхар ашиглах бололцоо байхгүй. Тэгэхээр үндэсний хиймэл дагуултай бол модоо тоолдог улс болно. Газрын хэвлий дэх баялгаа мэддэг улс болно. Гамшигаас сэргийлнэ. Энэ чинь бол том үндэсний аюулгүй байдлын асуудал юм. Тийм учраас энэ бол маш ашигтай төсөл. Францын Засгийн газар бол энэ

төслийн 85 хувьд нь 20 жилийн хугацаатай нэн хөнгөлөлттэй зээлийг олгож байгаа. Тэгэхээр бид бол улсын төсвөөр 15 хувийг л шийднэ гэсэн ийм л төсөл ю гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Өдрийн мэнд хүргэе. 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд МАН-аас дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар ажилласан. Мөн түүнчлэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн суурь болсон хамтарсан Засгийн газарт орсон 3 намын байгуулах гэрээний техникийн ажлын хэсэгт бас орж ажилласан. Ингээд ер нь үндсэндээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Зүгээр нэг чухал заалт маань ороогүй. Энэ бодлого хэрэгжих үү, үгүй юу гэдгийг бас Сангийн яамнаас асуух гэсэн юм. Энэ болохоор суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 400 сая төгрөг болгож нэмэгдүүлнэ гэсэн энэ заалт маань өөрөө их чухал. Жижиг бизнесүүдийг тэлэхэд яг суутган төлөгчөөр бүртгэх энэ 100 саяын босго маань яг чөдөр тушаа болоод байна гэсэн ийм саналыг олон иргэд байгууллагууд ирүүлсэн учраас энэ бодлого маань цаашид хэрэгжих үү. Энэ техникийн ажлын хэсэгт байхдаа оруулсан заалт маань бас хасагдсан байна. Энийг тодруулъя 1 дүгээрт.

2 дугаарт нийгмийн бүлэгтэй холбоотой маш олон хуулийн хэрэгжилтийг хангана гэсэн заалтууд орсон. Энэ өөрөө сайн өмчийн байгууллага үл хамаараад буюу Засгийн газар ч орно, Улсын Их Хурал ч орно. 25-аас дээш ажилтантай бол 4-өөс доошгүй хувьд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулна. 50-аас дээш ажилтантай бол 2 хувьд нь ахмад настныг ажиллуулна гэсэн ийм хуулийн заалт байгаа. Бүгд үүнийг хэрэгжүүлэх үүрэгтэй. Мөн түүнчлэн ахмад настны тухай хуулиар цалингийн сангийн 3 хүртэлх хувийг

ахмадын санд зарцуулна, төлөвлөнө гэсэн ийм хуулийн заалт байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх тал дээр бас яам, тамгын газар, бүх байгууллагууд, хувийн өмч харгалзахгүй бүх байгууллагууд анхаармаар байна. Тухайн байгууллагаас тэтгэвэртээ гарсан ахмад настны хөгжлийг тухайн байгууллага өөрийнхөө цалингийн зардалдаа суулгаад явах юм бол бүх ахмадын асуудлыг хэрэгжүүлэх боломжтой байна. Энэ дээр бас анхаарч ажиллана уу гэсэн нэг хүсэлт байна.

2 дахь нь халамжаас хөдөлмөрт шилжих бодлого бас нэлээд сайн хэрэгжиж байгаад 2020 онд би бас сайдаар ажиллах завшаан тохиож байсан. Тухайн үед хүнс тэжээлийн дэмжлэг авч байгаа 264 мянган иргэн байсан. Бид жилдээ 55,5 тэрбум төгрөгийг зарцуулдаг байсан бол 97 мянган хүн 5 хүрэхгүй тэрбум төгрөгийг жилд зарцуулж байна. Энэ бодлогын хүрээнд Азийн хөгжлийн банктэй бид бас төгсөлтийн аргачлал гээд 1250 өрх дээр тусгайлсан ийм нэг төслийг хэрэгжүүлж эхэлсэн юм. Тэгээд энэ төсөл маань яг тухайн 1250 санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон өрхүүдэд хөдөлмөр эрхлэх боломжийг нь олгож 600 долларын хөрөнгө оруулалт хийж, 2 жилийн хугацаанд багштай, ментортой ажиллах ийм төслийг хэрэгжүүлсэн нь өнөөдөр үр дүнгээ хэрхэн өгч байгаа вэ. Цаашид яг энэ ядууралтай тэмцэх ажил маань өөрөө ердөөсөө л хөдөлмөр эрхлэх бодлого учраас улсын хэмжээнд хэрэгжүүлэх энэ боломж байна уу, үгүй юү гэдгийг Энх-Амгалан сайдаас бас асууж тодруулж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайд. Дараа нь Жавхлан сайд хариултууд өгье.

Л.Энх-Амгалан: Улсын Их Хурал энэ ахмад настны талаар Ахмад настны тухай хуулийг маш сайн хууль баталсан. Одоо бид нарын асуудал бол ер нь өнгөрсөн хугацаанаасаа авсан

сургамжууд бол хууль батлах нэг өөр, хуулийг хэрэгжүүлэх ийм улс төрийн зориг, эдийн засгийн чадавх, сэтгэлгээ, хандлага байна уу л гэдэг асуудал юм байна л гэж би хараад байгаа юм. Тэгэхээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль бас муу хууль биш юм байна лээ. Хамгийн гол нь хэрэгжээгүй. Хэрэгжүүлэх тэр санхүүжилтийн эх үүсвэрийг нь бид нар тавиагүй. Ахмад настны тухай хууль дээр одоо ахмадуудын хүсээж байгаа зүйл бол тэр нөгөө ахмадын сан байгуулах сангийн эх үүсвэр буюу нийт цалингийн тухайн байгууллагын 3 хүртэлх хувь гэж байгаа юм. Ариунзаяа сайд аа та сайдаар ажиллаж байсан маш сайн мэдэж байгаа. Энэ хуулийн бас концепцыг хийсэн хүн. 3 хүртэлх хувь гэж байгаа. Тэгээд бид нарын нэг ийм яг энэ хууль дээр үүрэгжүүлсэн заалт хийхдээ тооцоо судалгаа нотолгоогүйгээр ханддагийн л нэг ийм гор гарч ирж байна уу л гэж хараад байгаа юм. Баахан нийгэмд хүлээлт үүсгэчихдэг. Би яагаад ингэж хэлээд байна вэ гэхээр бараг үндсэндээ НДШ төлж байгаа энэ цалингийн санг аваад үзэхээр Монголд чинь бараг үндсэндээ 20 их наядын цалингийн сан байна гэсэн тооцоо байна л даа. 20 их наядаас бид нар 3 хувь гэх юм бараг үндсэндээ энэ чинь 600 орчим тэрбум төгрөгийн цалингийн сан үүсгэх ёстой гэсэн ийм л хууль батлаад тавьчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нарт яг ийм эдийн засгийн чадавх байна уу, байхгүй юу гэдэг асуудал. Зөвхөн төрийн албан хаагчдын цалингийн сан гэхэд чинь 6 их наяд байна. 6 их наядын чинь 1 хувь гэхэд 60 тэрбум шүү дээ. Тэгэхээр бид нар яг жил бүхэн 0,5-аар уу, 1 хувиар уу ингээд бүрдүүлээд явах уу гэдэг тооцоо судалгаагаа гаргаж байгаад ямар ч байсан нэгэнт хууль хэрэгжүүлэх үүрэгтэй учраас Ариунзаяа сайд аа, энэ ахмадын санг жил бүхэн цалингийн сангаас ахмадын санг бүрдүүлэх эх үүсвэрийг бол шийдэхээс өөр арга байхгүй. Шийдэхээс өөр аргагүй. Гэхдээ энэ ахмадуудад том хий хүлээлт үүсгэж болохгүй. Энийг үе шаттайгаар шийдэх

хамгийн зөв хэлбэр байх болов уу гэсэн ийм бодолтой байна. Ингээд Сангийн яамтайгаа бид нар бас энэ тооцоо судалгаа дээр сууж байгаа.

2 дахь асуудал та маш их чухал асуудал хөндлөө. Маш сайн төсөл эхлүүлсэн. Танд бас талархах ёстой. Энэ бол ерөөсөө бид нар ядуурал гэж олон жил яриад бараг үндсэндээ энэ чинь хүн амын 30 хувь нь ядууралтай байна гээд л бүр 30 жил ярилаа шүү дээ. Гэтэл өнөөдөр яг Монгол хүнд Монголын ядуурал гэдэг өөрөө яг юу юм бэ. Монголд байгаа ядуу хүнийг бид нар яг ямар ядуу хүн гэж хэлэх вэ. Ер нь ядуу хүн гэж хэлэх үү. Орлого багатай иргэд гэж хэлэх үү гээд нэр томъёоноосоо авхуулаад ядуурал тооцож байгаа, ажилгүйдэл тооцож байгаа, өрхийн орлогын арга энэ тооцож байгаа энэ аргачлалыг ер нь Монгол өөрийн нэг ийм онцлог дээр тохирсон нэг ийм аргачлалаа бид нар эргэж харах цаг нь болсон юм байна. Алийн болгон бид нар Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк гэдэг юм уу олон улсын аргачлалаар ингээд баахан ядуурлаа зарлаад яваад байдаг, ажилгүйдлээ зарлаад яваад байдаг энэ аргачлалыг эргэж харахгүй бол зайлшгүй ийм шаардлага үүсчихсэн юм байна гэж би харж байгаа.

Тэр юуны ядуурлаас гардаг хамгийн гол үр дүнд хүрч байгаа арга хэмжээ бол яг таны эхлүүлсэн энэ төгсөлтийн аргачлал буюу Улаанбаатар хотод хэрэгжүүлж байгаа энэ 1250 өрхийг сонгож аваад 3 жилийн хугацаатай 500-600 долларын тоног төхөөрөмж өгөөд, тэгээд хуучин бол бид нар чинь ерөөсөө энэ ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих юм чинь ерөөсөө ингээд нэг ийм жижигхэн зээл өгчихөөр л болчих юм шиг ийм буруу төсөөлөлтэй явж ирсэн байна. Гэтэл яг энэ хэрэгжүүлж байгаа төсөл бол хүнийг ядуурлаас гаргахад хамгийн багадаа 3 жил зардаг. Тийм ээ. Тэгж байж үр дүнд хүрдэг. Тэгэхээр тэр тоног төхөөрөмжийг нь өгье. Тэр зээлийг нь өгье. Тэр сургалтыг нь хийе. Дахиад дээрээс нь тэр сэтгэл зүйн

зөвлөгөөнүүдийг нь өгье гээд дэлхий нийтээр ядуурлаас гардаг нэг ийм цогц.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энх-Амгалан сайдад нэмэлт 1 минут өгье.

Л.Энх-Амгалан: Дэлхий нийтээрээ ингээд ядуурлаас гаргадаг graduation approach гэж нэрлэдэг юм байна лээ. Тэр төгсөлтийн энэ аргачлал бол Монголын хөрсөн дээр буусан ийм цогц нийгмийн үйлчилгээний арга хэлбэр юм байна лээ. Тэгээд өчигдөр бас би Азийн хөгжлийн банкны удирдлагуудтай уулзаж энэ төсөл их амжилттай хэрэгжсэн учраас Монгол Улсын хэмжээнд, аймгийн хэмжээнд, сумын хэмжээнд хэрэгжүүлбэ гэдэг саналаа тавьсан байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн сан гэхэд жишээ нь сүүлийн 7 жил гэхэд бид нар 160 тэрбум төгрөг зарсан байгаа. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас. Тэгээд 47 мянган ажлын байртай болгочихсон гэсэн статистик байгаа мөртөө тэр нь үнэхээр тогтвортой ажлын байр бий болгож чадсан юм уу гэдэг асуултын хариулыг бид нар өнөөдөр өгч чадахгүй сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр цаашидаа бид нар энэ ядуурал, ажилгүйдэл, хөдөлмөрийн зах зээлийн асуудлуудыг бол энэ их өгөгдөлд суурилсан яг л ийм зөв төлөвлөлтөөр л хийе. Бид нар ер нь нэг датагаа тоогоо статистикаа нэг зөв болгохгүй бол яам бүхэн нэг ийм ажилгүйдлийн тоо зарладаг нэг ийм буруу юутай байна. Тэгэхээр Монголын төр бол нэг тоотой болох ёстой л гэж би ойлгож байна. Ингэж байж тоо зөв байж байж бодлого зөв болно. Бодлого зөв.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Жавхлан гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Ариунзаяа гишүүний асуултад хариулъя. Бид тун удахгүй хоёрхон 7 хоногийн дараа 9 сарын 1-нд энэ жил 2025 оныхоо төсвийг өргөн барих ийм шинэ цаглаврынхаа хуваариар ажиллаж байгаа. Тодотгол, ирэх оны төсөв, хөтөлбөр гээд олон зүйлүүд

давхцаад нэлээн ачаалалтай байгаа шүү. Тэгэхдээ бид 9 сарын 1-нд 2025 оныхоо төсвийг өргөн барихдаа ирэх оноос эхлэх татварын бодлогын томоохон өөрчлөлтүүдийг цуг танилцуулна. Тэр үед. Цаг хугацааны хувьд бол ийм байгаа. Харин тэр НӨАТ-ын босго бас 2 талтай шүү Ариунзаяа сайд аа. Та Засгийн газарт ажиллаж байсан хүн энэ талаар бас их сайн ойлголттой болов уу гэж ингэж найдаж байна. 2 талтай. Яах вэ нэг талаар НӨАТ төлөгчөөс нь чөлөөлөөд, НӨАТ-ын тайлан гаргадаггүй хялбаршуулаад ингээд нэг дэмжээд байгаа юм шиг мөртөө нөгөө талаар энэ жижиг аж ахуйн нэгжүүдийг улам л харанхуй руу улам л хоцроогоод, улам л нөгөө далд эдийн засгийг дэмжсэн ийм юм руу л бид яваад орчихно шүү. Дараа нь энийгээ засах гэж бас дахиад хэдэн жил явна. Юу вэ гэхээр тэр жижиг аж ахуйн нэгжүүдийг НӨАТ төлөгч биш болгоод хаячихаар нөгөө том аж ахуйн нэгжүүд чинь харьцахаа больчихно. НӨАТ төлөгч биш учраас гээд худалдан авалт байхгүй борлуулалт нь тэрнийх нь гадуур тэр аж ахуйн нэгжүүдийг бүр хасаад хаячихна. Ингээд тэр хэд маань далд эдийн засаг руу явахаас өөр аргагүй болгочихдог ийм бид тогтолцоо руу шилжчихсэн байгаа учраас энэ тогтолцоогоо гол нь хамгаалаад, харин дэмжлэг үзүүлэхдээ бид нар маш зөв байдлаар. Өөрөөр хэлбэл НӨАТ маань өөрөө энэ чинь худалдан авалтын татвар. Тэрнээс биш аж ахуйн нэгжүүд бол энийг зөвхөн дамжуулагч нь юм байгаа юм. Татварын бодлогоор бид аль болох худалдан авалт гэхээсээ илүү яг баялаг бүтээж байгаа, орлого олж байгаа, үйлдвэрлэл явуулж байгаа энэ тал дээр нь илүү дэмжих ийм бодлого барьж явна.

Д.Амарбаясгалан: Ариунзаяа гишүүн. Аюушийн Ариунзаяа гишүүн тодруулга авъя.

А.Ариунзаяа: Сангийн яамныхаа бодлогыг дэмжилгүй яах вэ. Ойлгож байгаа. Зүгээр тухайн үедээ тэгвэл 100 саяар тогтоож байсан тухайн үеийн үнэ

цэнийг өнөөгийн үнэ цэнд шилжүүлээд яг бас бизнесийн зарчимд нь нийцүүлбэл бас зохих болов уу гэсэн ийм бодолтой байна. Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг бас дахиад хэлэхэд мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбоотой мэргэжлийн хяналтын салбар салбарын чиг үүргүүд нь яам дээр ирсэн. Тэгээд Хөдөлмөрийн яам жишээлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хяналт шалгалтын ч чиг үүргийг магадгүй үйлдвэрчний эвлэлд шилжүүлэх юм бол ажилтны эрх ашгийг хамгаалах тал дээр илүү сайн ажиллаж бас магадгүй юм байна гэсэн ийм саналыг бас гаргамаар байна. Мөн түүнчлэн Ахмад настны тухай хуулийг жишээлбэл Ахмадын холбоо, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашиг нь хамгаалагдаж байна уу, хуулийн хэрэгжилт байна уу, үгүй юу гэдгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодод нь бас шилжүүлчихвэл их тус дэмтэй ажил болох юм болов уу гэсэн, хууль илүү сайн хэрэгжих юм болов уу гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Өнөөдөр хөтөлбөрийн төсөлтэй холбогдуулаад би бол зөвхөн шинжлэх ухаан, технологи, инновацад хамаарах асуудлаар 4 асуулт байгаа юм.

1 дүгээрт энэ хөтөлбөрийн төсөлд шинжлэх ухаан, технологи, инновац гэсэн хэсэгт 8 зорилт дэвшүүлж тавьсан байгаа. 8 багц ажил. Энэ 8 багц ажил бол өнөөдөр Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн салбарт бий болсон хүний нөөц, мэдлэгийн нөөц, мэдээллийн нөөцийг улс орны эдийн засгийн хөгжилд ашиглах ийм зорилго агуулсан, ер нь нэлээн зөв томъёолсон асуудлууд байна гэж ойлгосон. Гэхдээ үүнийг бол сайн боловсруулбал 8 биш 6 болгочих бүрэн боломж байгаа. Ажлын хэсэг хамтарч ажиллавал миний бие бэлэн байна. Энэ

ашиглах чадавхыг ашиглах бодлогын зэрэгцээ аливаа улс бол төрөөс шинжлэх ухааны салбараа бодлогоор дэмжиж хөгжүүлдэг. Тэгэхээр миний 1 дүгээр асуулт бол Монгол улсын шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхийн тулд энэ төсөлд хаана, ямар бодлого, ажил төлөвлөсөн юм бэ гэж асууж байгаа юм. Яагаад вэ гэвэл Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувийг шинжлэх ухаанд зориулна гээд биччихсэн байж байгаа. Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрт бол Үндэсний баялгийн сангийн хөгжлийн сангийн 1 хувийг бас энд зарцуулна гээд биччихсэн байгаа боловч энэ хөтөлбөрт энэ талаар ерөөсөө үг ч байхгүй байна. Энэ 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт бол энэ Монгол Улсад бид нар өндөр технологийн үйлдвэрийг хөгжүүлэх ёстой. Түүрүүчийн төсөл дээр хэрэглээний биотехнологийн төвийг байгуулна гээд явж байсан. Бид нарт өгсөн энэ дээр бол байхгүй байна. Энэ хэрэглээний биотехнологийн төв бол нэг хүрээлэн биш юм. Энэ орчин үеийн PCR дээр суурилсан оношилгооны үйлдвэрлэлийг Монголд хөгжүүлж авч явах зорилготой хэрэглээний салбар. Ковидын үед би бас PCR оношилгоо ер нь яаж шаардагдаж байсан та бүхэн мэддэг. Энэ үйлдвэрлэлийн суурийг тавих зорилготой сүүлийн 3 жил янз янзаар үзээд нэг их явахгүй байгаа. Тэгээд одоо энэ хөтөлбөрийн эхний тэр төслөөс хасагдаад ороод ирсэн явдалд гайхаад байна. Энийг яагаад хассан юм бэ гэдэг ийм асуулт байгаа юм.

3 дахь асуудал бол энэ шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор байгуулах асуудал бол тусжээ. Тусахдаа дагуул хотын дэд бүтэц гэдэг хэсэгт орчихсон байна. Энэ чинь дагуул хотын асуудал биш. Дэд бүтцийн асуудал биш. Шинжлэх ухааны салбарынхны ажиллах нөхцөлийг сайжруулах зорилготой энэ шинжлэх ухаан, технологи, инновац гэдэг дээр авчрах ёстой юм. Яагаад энийг энд

тавьчихсан юм бэ гэсэн ийм л 3 асуулт байна даа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн шадар сайд хариулъя.

Л.Гантөмөр: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Ер нь үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй ажлыг Засгийн газар хийхгүй гэдэг ойлголт бол байхгүй гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа. Үйл ажиллагааны хөтөлбөрөө бид нар аль болохоор багцлаад сум, хороо, аль нэг салбарын тодорхой нэр тавилгүйгээр яг Засгийн газрын түвшинд анхаарч ажиллах том бодлогын хэмжээний баримт бичиг болгохыг зорьсон. Тэгэхдээ харамсалтай нь 100 хувь бол тэгж чадаагүй. Бид нарын анхны зорилго бол 5 хуудсанд багтаавал яасан юм бэ. Ерөнхий сайд 2 хуудсанд багтаах хэрэгтэй гээд. Тэгэхдээ бид нэгэнт мөрийн хөтөлбөр гээд зарлачихсан. Тийм учраас мөрийн хөтөлбөрөө бол яг Засгийн газрын үйл ажиллагаа болгож оруулахаас өөр аргагүй гээд ингэчихсэн байгаа юм. Тэгэхээр үйл ажиллагааны хөтөлбөр батлагдаад бид энэ хөтөлбөрөө хэрэгжүүлэх төлөвлөгөө гарна. Төлөвлөгөө дээр таны хэл хааччихав гээд байгаа тэр хэрэглээний биотехнологийн төв ч гэдэг юм уу, инновацын төв, мэдээллийн төв гээд энэ тодорхой хэрэгжүүлэх төслүүд бол тэр төлөвлөгөө дээрээ тусгана шүү эрхэм гишүүн ээ гэдгийг хэлмээр байна.

Ер нь санхүүжилтээ бид нар яг төрийн санхүүжилтийг шинжлэх ухаанд маш бодитой болгоно. Бодитой болгохын тулд бид энэ тэргүүлэх зорилтынхоо нэгэнд энэ шинжлэх ухаан, инновац, технологид суурилсан мэдлэгийн эдийн засгийг бэхжүүлнэ гэж байгаа юм. Нэг үгээр хэлбэл хөрөнгө оруулалтын тодорхой хэсэг бол, аливаа хөрөнгө оруулалтын тодорхой хэсэг бол яг шинжлэх ухаандаа зориулагдах ёстой. Аливаа хөрөнгө оруулалтын тодорхой хэсэг нь бол яг инновацдаа зориулагдах

ёстой. Тэр бүтээлүүд нь гарч ирж чаддаг тэр чадавхыг бий болгоод явъя гэж байгаа юм. Яагаад дагуул хот дээр энэ инновацын төв ороод ирэв гэхээр шинжлэх ухаан бол өөрөө Монголын хамгийн их хөрөнгө оруулалтыг татах бололцоотой салбар. Хамгийн их багтаамжтай салбар. Тэгэхээр бид энэ дагуул хот дээрээ чөлөөт бүс байгуулах ийм үзэл баримтлалтай явж байгаа шүү дээ. Чөлөөт бүс байгуулахад бол бид тэнд хамгийн том байр суурийг юу эзлээсэй гэж хүсээж байгаа вэ гэхээр шинжлэх ухааны парк нь эзлээсэй гэж бодож байгаа. Дэлхийн компаниуд манай Монголын тэр дагуул хотод чөлөөт бүс рүү орж ирэхдээ шинжлэх ухааны парк руу орж ирдэг байх тэр орчныг бүрдүүлэхийг зорьж байгаа юм. Тэгэхээр бид энэ 4 жилийн хугацаанд шинжлэх ухааныг өнөөдөр хүртэлх төсөөлж байсан төсөөллөөс объём бол хэд дахин томорсон объёмоор харж байгаа. Тэрийгээ бол үйл ажиллагааныхаа төлөвлөгөөнд тусгаад явна. Тэрийгээ хэдүүлээ 1, 1 жилээр нь хагас, хагас жилээр нь бүрэн хянаад явах учиртай. Ер нь тэгээд эдийн засгийн тэлэлт хийхийн тулд мэдлэг суурьтай эдийн засаг, технологид суурьтай эдийн засаг гэдэг зүйлээ, уул уурхайгаа дагаж, байгаль орчноо дагаж, хөдөө аж ахуйгаа дагаж гарч ирнэ гэж ингээж харж байгаа юм. Тэгэхээр энэ байгаа салбарууд, ялангуяа энэ үйлдвэрлэлийн салбар өөрөө томорч байж эдийн засаг бий болох юм байна лээ л дээ. Тэгэхээр үйлдвэрлэлийн салбарыг бид нар зүгээр хуучин уламжлалт технологи Монголд авч ирж нутагшуулахаас илүүтэйгээр Монголын шинжлэх ухаан дэлхийн шинжлэх ухааны нөөцийг шавхсан шинэ, өндөр технологи шингэсэн уул уурхайн үйлдвэрлэл, өндөр технологи шингэсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл гэдэг энэ шинэ зорилтууд руу чиглэж байж эдийн засаг бол бодитой болох юм байна лээ. Тэгэхээр бол эдийн засгийн өсөлтийн тодорхой хувь бол яг шинжлэх ухаан технологитойгоо шууд уялдаж явна гэдгийг бид харж төлөвлөж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн ерөөсөө л үндсэн цөм ийм 3 хэсэг дээр төвлөрч байгаа гэж ер нь үзэж болно.

1 дүгээрт бол ер нь экспортыг л тэлье. Ойрын ирээдүйд өөр гарц алга гээд, 2 дугаарт аж үйлдвэржих шинжлэх ухаан технологио ашигласан байдалтайгаар энэ орчин үеийн нөхцөл байдалдаа дасан зохицох энэ зүйл рүү явъя. Тийм учраас ийшийгээ хөрөнгө оруулалт хийе гэдэг ийм л зүйл рүү ер нь гол хөтөлбөр буюу үнэт зүйл нь чиглэж байгаа. Би түрүүн үгэндээ дурдсан энэ аж үйлдвэрийн 1 дүгээр хувьсгал, 2 дугаар хувьсгал 2-ын дунд жишээлбэл 100 гаруй жил, компьютер болон ухаалаг гар утас 2-ын дунд 30 жил, одоо ингээд хиймэл оюун ухаан гээд 5 дугаар хувьсгал, ингээд 6 дугаар хувьсгал гэхээр энэ ерөөсөө бараг 4-5 жил гээд маш хурдтайгаар нөгөө бидний.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж авах уу. Гүйцээж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Тэгэхээр бид нар шинжлэх ухаан технологийн асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яаман дээр авч ирдэг ч гэсэн харин үүнтэй л холбоотой байгаа юм. Зүгээр бид нар нэг салбарын асуудал гэж харж болохгүй болчихсон. Тэгвэл бид нар гүйцэгдэх болчихож байгаа юм л даа. Одоо бодлого төлөвлөлтийг ч гэсэн хүн хийх ямар ч боломжгүй болж байна. Одоо бол бид нар тоо их өгөгдөл дээрээ тулгуурлаад л хиймэл оюун ухаанаар л хийлгүүлэхгүй л бол бид нар алдаа гаргана. Одоо ногоон хөгжлийн асуудал ч гэсэн, хот байгуулалтын асуудал ч гэсэн, боловсролын шинэчлэлийн асуудал, хөдөлмөрийн зах зээл, боловсролтой уялдах тухай асуудал, сайн засаглалын асуудал, мөн жишээлбэл төрийн бүтцийг рестракчер хийхтэй холбоотой асуудлууд. Энийг бид нар

өөрсдөө л бодоод л ингэнэ гэж бодлоо л бол алдана гэсэн үг. Тийм учраас шинжлэх ухааны салбар луу бол нэлээдгүй том хэмжээний анхааралд чиглэсэн 4 жил болно. Тэгэхээс ч өөр арга байхгүй. Энэ агуулгаар сая Эдийн засгийн зөвлөлийг бас Ерөнхий сайд дэргэдээ энэ яах вэ, уламжлалт олон жилийн түүхтэй ийм зөвлөл. Энэ дээр бид нар их дээд сургууль шинжлэх ухааны салбарын төлөөллийг хувийн хэвшлийн төлөөлөлтэй хамтад нь оруулж ирж байгаагаараа бас нэлээдгүй их онцлогтой болж байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар хамтдаа энэ зөвлөх компаниудтай ажиллаад нэлээн тийм гүнзгий мэргэжлийн ийм чиг баримжаатай хөгжлийн загвараа бол орохгүй бол салбар салбар хоорондоо тоогоороо уялздаггүй, салбар салбар асуудлуудаа хоорондоо уялдуулдаггүй явах бол боломжгүй. Асуудал өөрөө цогц байдаг учраас шийдэл өөрөө цогц байхаас өөр аргагүй. Энийг бол шинжлэх ухаан технологи л өөрөө хийж чадна. Хүн бол хийж чадахгүй юм гэдгийг бол бид нар ойлгож байгаа. Тийм учраас үүн дээр тулгуурласан ийм хөтөлбөр дээр Эдийн засаг, хөгжлийн яаман дээр бүх салбарын үнэт зүйл буюу дундын үнэт зүйлийг зохицуулах гэдэг агуулгаараа шинжлэх ухааны салбар яг ингэж орсон байгаа шүү гэдгийг бас хэлчихье.

Д.Амарбаясгалан: Дүгэрийн Рэгдэл гишүүн нэмэлт тодруулга авъя.

Д.Рэгдэл: Баярлалаа. Ер нь дэлгэрэнгүй сайхан л хариулт өглөө. Тэгэхээр Ерөнхий сайдын концепцыг бол манай салбар бүрэн дэмжиж байгаа. Үнэхээр шинжлэх ухааныг Эдийн засаг, хөгжлийн яаман дээр аваачиж тавина гэдэг бол статусыг нь үндсэндээ 2 шатаар дээшлүүлсэн асуудал. Энэ бол зөв. Мааш зөв юм байна. Зүгээр Гантөмөр сайдаас ганцхан юм хүсмээр байна. Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт шинжлэх ухааны талаар тавьсан хамгийн гол том зорилт бол дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувийг өгье гэсэн. Манай олон эрдэмтэд, тэдний нөлөөлөлд

байдаг хүмүүс үүний чинь төлөө их санал өгсөн шүү. Тэгэхээр та мөрийн хөтөлбөрт энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ 1 хувь гэдгээ ямар нэгэн байдлаар тусгаад өгөөрэй л гэж хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. Тэргүүн шадар сайд Гантөмөр.

Л.Гантөмөр: Ер нь бид нар сая 1 сарын хугацаанд аль аль асуудлаа хэрхэн шийдэх вэ гээд улс төрийн намууд зөвшилцөж, яг 1 сарыг өнгөрөөлөө шүү дээ. Тэгээд аль нэгнийхээ тусгасан бодлогыг муйхарлаж тулгах боломж бол байхгүй байгаа. Аль аль тал нь хүлээн зөвшөөрөх ёстой. Тийм учраас бол танай намын заалтад энэ байгаа, энэ намын заалтад энэ байгаа. Энэ нь заавал хэрэгжүүлнэ гэхээр энэ яг тэр аль нэг тал нь өөрийнхөө хүсэл зоригийг тулгах боломжгүй байгаа гэдгийг Рэгдэл гишүүн минь бас ойлгож үзээрэй. Чадлаараа хэдүүлээ хөрөнгө оруулалтаа бол бид хүссэн хэмжээ рүүгээ түлхэж явна гэдгээ бас илэрхийлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тодорхой хариул гэсэн шүү дээ. 2 хувь гэж заасан. 1 хувь гэж заасан. Төсвийнхөө бодлогын хүрээнд. Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Үүрийнтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгэхээр эдийн засгийг тэлэх 14 мега төслийн 13-д Оюутолгой төсөлд түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулна гээд тусгасан байгаа. Технологийн хувьд бид нар баяжмалаас алтаа ялгаж аваад цэвэршүүлэхийн тулд эхлээд баяжмалаа хайлуулж боловсруулах шаардлагатай болно л доо. Өөрөөр хэлэх юм бол эхлээд баяжмалаа хайлуулснаар, боловсруулснаар катодын зэсээ бусад ашигт эрдсүүдээ, түүний дотор алтаа ялгаж авах боломж маань бүрдэх юм байгаа юм. Үүний дараагийн шатад тэр алт цэвэршүүлэх ажил хийгдэх учиртай. Тийм болохоор би Эдийн засаг, хөгжлийн

сайд, Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайдаас бас энэ асуултыг асуух гэсэн юм. Оюутолгой өнөөдөр жилдээ 5,5 тонн алт агуулсан 800 мянган тонн зэсийн баяжмал гаргаж байгаа. Энэ 14 төслийн мөрийн хөтөлбөрт тусгагдаж байгаа 14 төслийн 10-т нь зэс боловсруулах үйлдвэрийн талаар бас зэс боловсруулах цогцолборыг байгуулна гэж тусгаж өгсөн. Гэхдээ хүчин чадал, хүрэх үр дүнг нь харахад энд бол Оюутолгойн баяжмал хайлуулах талаар төлөвлөөгүй юм байна гэж харагдаж байгаа юм. Мөн манай улс үндсэн болон шороон ордоос олборлож байгаа алтаа цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ-г өмнө нь боловсруулчихсан юм байна лээ. Тэгэхээр Оюутолгой түшиглэсэн энэ алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулахад технологийн өмнөх процесс буюу зэсийн баяжмалаа хайлах асуудлыг хэрхэн тооцож оруулж байгаа юм бол. Мөн өмнө боловсруулчихсан байгаа энэ алт цэвэршүүлэх үйлдвэрийн судалгаа, ТЭЗҮ дээр та ер нь ямар байр суурьтай байгаа вэ гэдгийг тодруулах гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд Гантөмөр хариулъя.

Л.Гантөмөр: Ер нь бол бид нар алт боловсруулах, алтаа цэвэршүүлэх үйлдвэрийг барина гэсэн зорилтыг бол дэвшүүлж байгаа. Тэгээд хүмүүс гайхаж асуугаад байгаа юм. Яагаад Оюутолгойтой холбоод байгаа юм бэ гэж. Тэгэхээр аль төслийг хэрхэн, яаж санхүүжүүлэх вэ гэдэг тэр гаргалгааны тухайд энэ төслийг Оюутолгой санхүүжүүлэх юм байна гэсэн ийм хараа байгаа учраас бид нар Оюутолгой төсөлтэй холбож алт цэвэршүүлэх үйлдвэр гэж ингэж тусгаж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн тодруулж асууя.

Д.Үүрийнтуяа: Алт цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах асуудал дээр бол бүрэн дэмжиж байгаа. Бид нар бол бас зайлигүй энэ алт цэвэршүүлэх

үйлдвэрээ барьж байгуулах цаг нь болсон. Гэхдээ байршлын хувьд бол их оновчтой байршлыг сонгох ёстой. Харин яг энэ мөрийн хөтөлбөрт зөвхөн санхүүжилтийн асуудалтай нь холбож ийм агуулгаар тусгах нь зүйтэй юу, үгүй юу гэдгийг бас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маань мэргэжлийн салбарын яамны хувьд бас анхаарах шаардлагатай болов уу гэж харж байна.

Мөн энэ 14 төслийн 10-д тусгагдчихсан байгаа зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэрийг ялангуяа зэс хайлуулах цогцолбор байгуулна гээд, ард нь хүрэх үр дүн дээр тавьсан тоонууд нь бол Эрдэнэтийн үйлдвэр технологийн паркийн хүрээнд байгуулагдах зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тооцоонууд явж байгаа юм. Тэгэхээр би бол энийг бас Эрдэнэтийн зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэр, үйлдвэр технологийн паркийн хүрээнд хийгдэх юм байна гэж ингэж бодож байна. Энэ хүрээнд бол ямар ч тохиолдолд бид нар хаана энэ хайлах үйлдвэрийг, зэсийн баяжмал хайлах үйлдвэр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгье. Тэргүүн Шадар сайд Гантөмөр.

Л.Гантөмөр: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Эрдэнэт үйлдвэр, Эрдэнэс Монгол компанийн удирдлага дор хийсэн зэс хайлуулах үйлдвэрийн ерөнхий төлөвлөлтүүдтэй бол танилцаж байгаа. Тэгээд хөрөнгө оруулалтынх нь санхүүжилтийн тооцоолол, мөн технологийн шийдэл гээд бүгдийг нь харж байгаа. 2 зүйл эргэлзээ гараагүй байна. Фосфоридын хувьд тэр Хөвсгөлийн фосфоридыг ашиглах дээр бол бид нар шийдвэр гаргаж чадахгүй. Тийм учраас тэр Завхан, Говь-Алтай гэдэг бүс нутагт байгаа фосфоридын нөөцийг их тодорхой болгох учиртай юм байна лээ.

2 дахь нь бид нар энэ газрын тос боловсруулах үйлдвэрийнхээ ашиглалтад орох хугацааг харж байна. Хэрвээ газрын

тос боловсруулах үйлдвэр ашиглалтад орох хугацаа их тодорхой болчих юм бол бид нар тэр химийн орхигдож байгаа зүйлсийг тэндээ авч ашиглах ийм боломж бололцоо бол гарах юм байна лээ. Үүнтэй уялдуулж бид нар яг тэр байришлынхаа асуудлыг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Боловсрол, хүний эрх, хөдөө аж ахуй, ЖДҮ-тэй холбоотой 3 багц асуулт асууя.

1 дүгээрт хүний эрхийн асуудал дээр энэ үндсэн эрхийн маргааныг шийдвэрлэхээс гадна Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг тодотгоно гэсэн ийм заалт байна. Тэгэхээр үүний яг цаад үзэл санаа нь юу вэ. Нэг тийм үзэл санааны хувьд жаахан тодруулах хэрэгтэй байна.

2 дугаарт хоригдлын ажлын байрны асуудлыг хэд хэдэн заалт дээр тусгасан байна. Үүнтэй адилхан бас яг цэргийн ажлын байрны асуудлууд бас яригдаж байна. Тэгэхээр үүний цаана яг хүн байгаа. Тэгэхээр ямар стандарт байх вэ. Хөдөлмөрийн мөлжлөгт өртөхгүй байх талаас ямар хамгааллын бодлого байгаа вэ гэж асууя.

3 дугаарт хуульчдын холбоотой холбоотой нэг цогц заалт орсон байна. Тэгэхээр нөгөө өмгөөлөгчдийн холбоо минь яах билээ гэдэг асуудал дээр тодруулж өгөөч.

4 дүгээрт прокурорын байгууллагын томилгоотой холбоотой 1 заалт орж. Гэхдээ дээр нь нэмээд прокурор болон цагдаагийн байгууллагын шинэчлэлийн асуудал яагаад орсонгүй вэ.

5 дугаарт хүүхэд хамгааллын асуудал дээр дандаа хүүхэд хамгаалал гэдэг байдлаар томъёолж орсон байна. Тэгэхээр энэ хүрээг хүүхдийн эрхийн асуудал гэж 1 дүгээрт өргөжүүлээч. 2 дугаарт энэ иргэдийн оролцоотой хүүхэд

хамгаалал гэж тодруулсан байна. Энэ яг ямар ажил төлөвлөж байгаа вэ. Тэгээд түрүүний ядууралтай холбоотой хэлэхэд 5 хүн тутмын 2 нь 15-аас доош насны хүн байгаа буюу хүүхдүүд маш их өндөр ядууралтай байгаа гэдгийг тодотгоод хэлчихье.

2 дугаар багц асуулт боловсролтой холбоотой боловсролын салбар дээр 4 асуулт байна. СӨБ-ын хамран сургалтыг 93-100 хувь болгоно гэсэн тоо тавьсан атлаа яг одоо цахим дээр өрнөж байгаа том асуудал нь эцэг эхээс хүүхдийн хоолны мөнгийг төлбөрийг гаргуулахаар ийм шийдвэр гарч байгаа гэж ойлгож байгаа. Гэтэл энэ нь өөрөө яг бие биеийгээ үгүйсгэсэн ийм бодлогын шийдвэр болох юм биш үү. Тэгэхээр үүнийг тодруулж өгөөч. Үүнтэй холбоотой хувийн цэцэрлэгийн асуудлыг яг энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт хөндсөн нь ямар учиртай вэ гэдэг ийм асуулт.

2 дугаарт хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийг боловсролын тэгш сургах боломжийг нэмэгдүүлнэ гэсэн атлаа дахиад энэ үзүүлэлт дээр нэг ч үзүүлэлтийг нэмж орж ирээгүй. Энэ ямар учиртай вэ. Дахиад бие биеийгээ үгүйсгэсэн бодлого орж ирж байна.

3 дугаарт хүний эрхэд ээлтэй дотуур байр гэж байна. Тэгэхээр үүнтэй холбоотой ямар стандартыг нэвтрүүлэх вэ.

4 дүгээрт МСҮТ-тэй холбоотой хөтөлбөр хэрхэн сайжрах вэ. Энэ дээр яг юу хийх вэ гэдэг дээр тодорхой хариулт өгөөч.

3 дугаар багц ЖДҮ-лэл, хөдөө аж ахуйг нийлүүлээд асуучихъя. Тендерийн тухай хуулиар яг энэ хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн тэр дундаа энэ хоршооны хөдөлгөөнийг дэмжих ямар ч тийм бодлого орж ирээгүй байна. Өөрөөр хэлбэл худалдан авалттай холбоотой. Тэгэхээр өмнөх хуульд байсан сайн жишигүүд орж ирэх үү. Ер нь цаашид энэ

хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийг худалдан авалтын бодлогоор хэрхэн дэмжих вэ. Давуу байдал олгох ийм зохицуулалт бодлого бий юу гэсэн ийм асуулт асууя.

Д.Амарбаясгалан: Боловсролын сайд Наранбаяр сайд эхлээд хариулъя. Араас нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр, араас нь Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл нар хариулт өгнө.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр цэцэрлэгийн энэ хоолны асуудал бол энэ жил чинь нөгөө 500 төгрөгөөр нэмээд бас төсвөөс бүрэн гаргаад 3 мянган төгрөгт хүргэж байгаа. Гэвч энэ бол яг хоол тэжээлийнх нь илчлэгийн хэмжээний 52, 53 хувьтай л байж байгаа. Тэгэхээр Боловсролын ерөнхий хуульд өөрөө бас хуваалцах тухай орчихсон байгаа. Эцэг эх өөрсдөө бас төлнө гээд. Тэгэхээр зэрэг энэ заалтыг мөрдөж эхлэх шаардлага байгаа. 2016 оноос ярьсаар байгаад 8 жил яриагүй. Гэвч хүүхэд гэдэс нь хонхолзсон ийм байдалтай цэцэрлэгт яваад байгаа. Тэгэхээр нийслэлийн хүрээнд энэ ажлыг эхлүүлнэ. 1 мянган төгрөгөөр нэмж хоолны мөнгийг төлүүлснээр энэ нь бол хүүхэд ойролцоогоор 73 хувийн илчлэг хүртэл ингэж нэмэгдэх ийм боломжтой болно. Энэ нь сардаа 22 мянган төгрөг байгаа. Бид зорилтот бүлгийн бас энэ тооцоог гаргачихсан. Зорилтот бүлгийн хүүхдүүдэд бол энэ нь одоо төсвөөс энэ 1 мянган төгрөгийн нэмэгдлийг гаргана. Тэгэхээр эцэг эх нь өөрөө хүүхдийнхээ мөнгийг ингэж төлдөг явж эхлэх нь бол өөрөө ач холбогдолтой гэж бид харж байгаа юм. Тэгэхгүй бол хүүхдүүд бол та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Орой 5 цаг хүртэл бол нэлээн өлссөн ийм байдалтай яваад байгаа. Энэ бол 1 дүгээр асуулт.

Дотуур байранд үйлчилгээний стандарт, бас орчны стандартыг бол шинээр гаргана. Тэгээд бас мөн нүхэн жорлонг байхгүй болгох асуудал энэ урд талын парламентад ч яригдаж нэлээн

ажил хийгдсэн. Энэ ажлыг үргэлжлүүлж чанарыг нь дээшлүүлнэ гэдгийг хэлье.

Мэргэжлийн боловсролын хөтөлбөрийг бол ажлын байрны ур чадвартай нь нийцүүлж бүрэн шинэчлэх ийм ажлыг явуулна. Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад дундын цахим системийг хөгжүүлж, түүнтэй уялдуулан хөтөлбөрөө шинэчилнэ гэсэн ийм байдалтай байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Энхбаяр сайд хариулъя. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлого цаашид үргэлжилнэ. Энд гишүүдэд нэг мэдээлэл өгье. Жижиг, дунд үйлдвэрийн сан гээд нэлээн улс төржсөн ийм сэдэв өнгөрсөн жилүүдэд явагдсан. Энэ санд нийт 2009-2024 онд нийт 8947 төсөлд 1,1 их наяд төгрөгийн зээл олгогдсон. Өнөөгийн байдлаар энэ зээл бүрэн буцаан төлөгдсөн. Гадаадын зээл болон Хөгжлийн банк, Засгийн газрын бондууд бүрэн төлөгдөж нийт зээлдэгчдийн 84,4 хувь нь зээлээ бүрэн ашиглаж, бүрэн эргэн төлсөн маш сайн хэрэгжилттэй байгаа. Одоо сан маань өөрийн эх үүсвэр 200 тэрбум төгрөгөөр зээлийнхээ эргэн төлөлтөөр санхүүжилтээ олгоод, Зээлийн батлан даалтын сантайгаа хамтраад энэ жижиг, дунд үйлдвэрийн салбарт зээл олголт явагдаж байна. Мөн сая Засгийн газрын тогтоолоор шинэ хоршооны зохион байгуулалтын асуудал, тэнд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг энэ жижиг, дунд үйлдвэрийн газартай харьяанд нийлүүлж байгаа. Ингээд энэ хэмжээндээ малчид руугаа чиглэсэн нэлээн бодлого нэлээн өргөтгөх байх гэж. Мэдээж ерөөсөө төрийн худалдан авалтаар дэмжих нь энэ хөдөө аж ахуйн салбар босгох гол суурь болдог. Энд бол сүүний салбар ч тэр, арьс ширний салбар ч тэр, ноос ноолуурын салбар ч тэр бүхий л түвшинд. Тэгээд төрийн худалдан авалт дээр бид нар дүн шинжилгээ хийж байгаа. Аль салбарт ямар дотоодоос орлох бололцоотой дотоод үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг төрийн бодлогоор

дэмжих вэ гэдэг энэ судалгаанууд хийгдээд ер нь нэлээн дөхөж байна. Хөтөлбөрт бол яг энэ асуудал худалдан авалтаар дэмжинэ гэдэг ийм зүйл заалтууд сууж байгаа шүү. Нэлээн ахиц дэвшил гарах байх.

Д.Амарбаясгалан: Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл сайд хариулъя.

О.Алтангэрэл: Үндсэн хуулийн цэцээр бол энэ иргэдийн үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэдэг болъё гэж байгаа юм. Манай Баасанжаргал гишүүн бол бас энэ хүний эрхийн чиглэлээр нэлээн амжилттай ажиллаж байсан хүний хувьд бас дуу хоолойгоо оруулаад явах байх. Дээрээс нь Цэцтэй холбоотой нэг асуудал байгаа. Цэцэд гомдол мэдээлэл гаргасан хүний өргөдлийг шийдвэрлэлгүй 1 жил, 2 жил болдог. Зарим улс төржсөн ийм өргөдөл гомдлуудыг аваад хурдан шийддэг. Сүүлдээ бүр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт, өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуулийнхаа бүрэлдэхүүн хэсгийг ч тайлбарлах эрхтэй юм шиг. Зарим нэг улс төржсөн үйл ажиллагаа дээр нэг хязгааргүй том эрхтэй юм шиг захиалга аваад байгаа юм шиг. Тэгсэн мөртөө иргэдийнхээ гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тэр процесс нь тодорхойгүй. Үндсэн хууль тойрсон асуудал улам бүрдгэрсээр өдий хүрлээ. Тэгэхээр бид нар Үндсэн хуулийн цэц буюу Үндсэн хуулийнхаа шүүхийн эрх хэмжээ хаана хүрч дуусах юм. Ямар шийдвэр гаргаж болохгүй юм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 13 цаг болсон байна. Хэлэлцэх асуудал их, асуулт асуух гишүүд олон байгаа учраас үдийн цайны завсарлагагүй үргэлжлүүлээд хуралдаад явъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл сайд гүйцээж хариулъя.

О.Алтангэрэл: Тэгэхээр бид нар энэ дээр бол Үндсэн хуулийн цэцийнхээ бүрэн эрхийн хүрээ, хязгаарыг тогтооё гэж байгаа юм.

Тэр хоригдлын хөдөлмөртэй холбоотой асуудал бол үнэн. Энэ хоригдол болоод хугацаат цэргийн албан хаагчдын ер нь цэргийн алба хаагчдын хөдөлмөрийн тухай ярихдаа хөдөлмөрийн мөлжлөг гарах вий гэж байнга сэргийлдэг. Тэгэхдээ өнөөдөр яг бодит байдал дээрээ ямар байна гэхээр энэ гэмт хэргийн улмаас хохирсон хүмүүсийн хохирол төлбөрийг барагдуулахтай холбоотой асуудал туйлын хүнд байна. Бусдад хохирол учруулаад шоронд орчихдог, хохирол төлбөрөө төлдөггүй. Тэгэхээр бид нар хэдийгээр хорих ял шийтгэгдсэн ч гэсэн хөдөлмөр нь сайн дурын байх тэр зарчмыг үндэслээд хуучин Монгол Улсын хуучин нэрээр засан хүмүүжих байгууллага одоогийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, аж ахуйн үйлдвэрийн чиглэлээр зохион байгуулагддаг байсан энэ үйл явцыг үргэлжлүүлээд, тэгээд төсвийн дарамтыг багасгая гэсэн асуудал тавьж байгаа.

Хуульчдын холбооны хувьд бол бодлого тодорхой байгаа. Өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбоотой аль алинтай нь уулзсан. Тэрний үндсэн дээр оролцуулсан. Өнөөдөр жишээлбэл нийт шүүгчдийн 30 орчим хувь нь Хуульчдын холбоонд харьяатай байна гэсэн тооцоо бий. Прокурорууд бас сайн дурын шинжтэй шүүгч нар оролцдог. Энэ байдлыг өөрчилъё. Хуульчийн лицензтэй л бол холбоондоо харьяалагд. Тэр татвар юмаа төл. Тэгэхдээ холбоодоороо дамжуул. Өмгөөлөгчдийн холбоо, Шүүгчдийн холбоо, Прокурорын холбоо, Нотариатын холбоо, бусад төрлийн холбоодын гишүүнчлэлтэй хуульчтай холбоо үйл ажиллагаагаа явуулъя. Тэгээд гишүүдийн эрх ашгийг хамгаалахаас гадна энэ хууль тогтоомжийн төсөл боловсруулах болон сургалт сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах ийм байя гэж Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг өөрчилнө гэж байгаа юм.

Прокурорын байгууллагын хувьд бол томилгооны асуудал, хэтэрхий босоо

тогтолцооны асуудал бол олон жил маргаан дагуулж ирсэн. Энэ дээр томилгооны асуудлыг нь ил тод болгоё. Харин цагдаагийн байгууллагын шинэчлэлийн тухайд манай энэ мөрийн хөтөлбөр дээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг нууц мөрдөн шалгах ажиллагааны тухай, тэгээд ер нь мөрдөн шалгах чиг үүргийг нь хэрэгжүүлдэг энэ байгууллагуудын үйл ажиллагааг нэгтгэж, Мөрдөх алба байгуулах тухай гээд олон газар энэ цагдаагийн үйлдэл тэр байтугай бид нар бас энэ дотоодын цэргийн үйл ажиллагаатай холбоотой яг дотоодын цэргийн үндсэн үйл ажиллагаа, орон нутгийн өөрийгөө хамгаалах чадавхыг бэхжүүлэх, гаднынхантай зүйрлүүлбэл үндэсний гвардийн тогтолцоог хийнэ гэсэн зорилгыг тавьсан учраас энэ олон зохицуулалтуудын хүрээнд цагдаагийн байгууллагын маань шинэчлэл гэдэг зүйл шингээд орчихсон байгаа гэдгийг хариулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Түрүүнд хариулахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асуудлыг хөндсөнийг хариулаагүй өнгөрөөчхөж. Уучлаарай. Тэгэхээр өнгөрсөн хичээлийн жилд бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол хамрагдалт 80 орчим хувьд хүрсэн. Ирэх 4 жилд бол хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ тоог 96 хувьд хүргэхээр ингэж заасан. Тэгэхээр энэ болгон үйл ажиллагааны хөтөлбөрт орохдоо ийм алдаатай орсон байна. Бид нар энийг яг өөрсдийнхөө яамны төлөвлөгөөнд тусгаад ингээд явна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Үйл ажиллагааны хөтөлбөрт энэ Налайх, Багануур дүүргүүдийг нэг болохоор дүүрэг гэж яваад, нэг болохоор улсын

зэрэглэлтэй хот гэж яваад ялгаатай яваад байна. Хаврын Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулиар улсын зэрэглэлтэй хот болгосон шүү дээ. Тэгээд цаашидаа энэ ойлголтыг нэг мөр болгоод явах хэрэгтэй байна. Энэ дээр манай ажлын хэсгийнхэн анхаарч өгөөч.

Нөгөө талаараа улсын зэрэглэлтэй хот болгосноор бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд ингээд хангайн бүс, төвийн бүс, баруун бүс, зүүн бүс гээд ингээд явах нь. Харин улсын зэрэглэлтэй Налайх, Багануур дүүргүүд бас орхигдох асуудлууд бас бүрхэг байна. Тэгэхээр энэ улсын зэрэглэлтэй хот болгосны хүрээнд цаашидаа энэ бүс нутгуудыг, энэ хотуудыг, төсөв санхүүгийн хувьд, бие даасан байдлыг татварын таатай орчныг бүрдүүлэх чиглэл дээр ямар ахиц өөрчлөлт гаргах юм бэ. Энэ дээр үйл ажиллагааны хөтөлбөр дээр тодорхой асуудал бас ховор байна гэж би үзэж байна. Энэ дээр нэг хариулж өгөөч.

2-т хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт огт хөндөгдөхгүй байгаа нэг асуудал бол олон жил яригдсан энэ засаг захиргааны нэгжийн асуудал байгаа юм. Одоо энэ хамтарсан Засгийн газар байгуулагдсан дээрээ энэ зоригтой асуудлуудыг шийдье гэж байгаа дээрээ бас энэ жил одоо энд сууж байгаа танхимын гишүүдийн дийлэнх олонх нь л орон нутгаас сонгогдсон. Баахан л 100 жилээ хийж байгаа сумуудыг та бүхэн харсан байх. Өнөөдөр ямархуу байдалтай байна. Тэгвэл энэ 2 мянга хүрэхгүй байгаа энэ сумын төвүүдийг цаашидаа энэ нэгтгэх асуудлуудыг зоригтойгоор энэ бүрэн эрхийн хугацаанд шийдвэл яасан юм. Тэнд Иргэдийн хурал гээд 15 хүний бүрэлдэхүүнтэй, Иргэдийн хурлын ажлын алба гээд байх шаардлага байна уу, үгүй юу гэдгээс авхуулаад. Гэтэл Улаанбаатар хотын хороонууд чинь 30 мянган хүн амтай давсан хороод дээрээ ганцхан хорооны Засаг дарга 1 ч төгрөгийн төсөвгүй л байж байгаа шүү дээ. Ийм нэгжийн хувьд ялгаатай байдал чинь

өнөөдөр энэ орон нутгуудын анхан шатны нэгж байгууллагуудыг хөгжих асуудал дээр үнэхээр хэцүү шүү дээ. Тийм учраас энэ цаашидаа энэ нэгжийн асуудал дээр зоригтой нэг тийшээ. Тэгэхгүй орон нутгийн аймгийн Засаг дарга, орон нутгийн сумын Засаг дарга нарын өөрсдийнхөө үе дээр энэ сумаа татан буулгачихгүй байх нэг аминчхан бодол дээр суугаад л өнөөдрийг хүрч явсан шүү дээ яг үнэнийг хэлэхэд. Тэгээд энэ дээр цаашидаа ямар бодлого байна вэ гэдэг дээр 2 дахь асуулт асууя.

3 дахь дээр би энэ эрүүл мэндийн чиглэлээр асуух гэсэн юм. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд өнөөдөр бас эрүүл мэндийн сайд энэ бүсийн 6, 7 төвүүд дээрээ орчин үеийн оношилгоо эмчилгээний төвүүдийг байгуулчих асуудлыг шийдэж болохгүй юм уу. Хөдөө, орон нутгаас улсын хэдэн эмнэлгүүдийн чинь ачаалал бол үнэхээр хүнд байгаа шүү дээ. Тэгвэл энэ бүсчилсэн хөгжилтэй холбогдуулаад бүсийн төвүүд дээр нь оношилгоо эмчилгээ, хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу ирэх энэ нүүдлийг тэр бүсийн Төв.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн парламентад Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль батлагдсан. Тэгэхээр энэ Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар Багануур, Налайх дүүрэг бол улсын зэрэглэлтэй хот гэсэн статустай болж байгаа. Тэгэхээр энэ хууль бол 2026 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлнэ. Тэгэхээр улсын зэрэглэлтэй хот гэдэг статустай болсны хувиар дэргэдээ дагуул хот байгуулах, бие даан хөгжих ийм олон боломжуудаар мэдээж хангагдана. Мөн Их Хурлын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай холбогдуулан гарсан тогтоолоор бол орон нутгийн хөгжлийн төвд Багануур, Багахангай, Налайх гээд дүүргүүд багтдаг. Тэгэхээр орон нутгийн

хөгжлийн төвүүдэд энэ үзэл баримтлалын хүрээнд Их Хурлын тогтоолоор яг ингэж тооцогдсон учраас цаашидаа бол орон нутгийн хөгжлийн төвүүд хөдөө аж ахуй, хүнс, худалдаа үйлчилгээ, тээвэр логистикийн цогцолборыг кластераар хөгжүүлэх, цаашилаад төр хувийн хэвшлийн түншилэлээр дэд бүтэц болоод бусад үйл ажиллагаагаа зохион байгуулах боломжийг хуулиар ч нээсэн, дээрээс нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр ч гэсэн төр, хувийн хэвшлийн түншилэлээр энэ бие даасан улсын зэрэглэлтэй хотууд болоод орон нутгийн хөгжлийн төвүүдийг хөгжүүлэх энэ үндсэн концепцыг бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд бид бас тусгаж өгсөн. Тэгэхээр цаашидаа бол бид 2026 оны 1 сарын 1 хүртэл Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангуулж байна. Энэ төсвийн тодотголтой холбогдуулаад, мөн төр, хувийн хэвшлийн түншилэлийн хуулийг 2026 оны 1 сарын 1-ээс хэрэгжих байсны хугацааг бол наашлуулж байгаа. Тэгээд хугацааг наашлуулснаараа дэд бүтцийг хувийн хэвшилтэй хамтарч хөгжүүлэх ийм боломжуудыг нээж байгаа. Тэгэхээр улсын төсвийг заавал шаардахгүйгээр төр, хувийн хэвшлийн түншилэлээр энэ бие даасан хотууд өөрсдөө дэд бүтцээ шийдээд явах ийм боломж бололцоог бас хуулиар нээж байгаа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн алга байна. Норовын Алтанхуяа. Сандаг-Очир гишүүн тодруулж, нэмэлт тодруулга авъя гэж байна.

Ц.Сандаг-Очир: Тэр нэгжийн асуудал дээрээ бас хариулт авсангүй. 3 дахь асуудал эрүүл мэндийн асуудал дээрээ. Манай улс Засгийн газар, Эрүүл мэндийн яам ингээд Монгол Улсад эмчлэгдэхгүй 28 төрлийн өвчин гээд ингээд бас баталчихсан. Тэгээд энийг яагаад чадахгүй гэж байгаа юм. Шаардлагатай орчин үеийн тоног

төхөөрөмжийг нь олоод ирэхэд манай эмч нар бол энийг хийгээд явчих мэдлэг, боловсрол бол байгаа шүү дээ. Тийм учраас цаашидаа энэ гадагшаа урсаж байгаа эрүүл мэндийн үзлэг оношилгоонд явах гэж байгаа энэ чиглэлийн ард иргэдийн ачааллыг дотооддоо улсдаа шийддэг байх. Энэ асуудлыг ер нь цаашидаа Эрүүл мэндийн яам хийж чадахгүй, эмчилж чадахгүй гээд ингээд сууж байх юм уу. Аль болох энэ бүрэн эрхийн хугацаанд ядаж хэдийн ч гэдэг юм уу ингээд эмчилдэг болно гэдэг ийм асуудал энэ үйл ажиллагааны хөтөлбөрт яаж орж байгаа юм бэ. Байна уу, үгүй юу. Энэ дээр Эрүүл мэндийн сайд хариулт өгөөч. Нэгжгийн асуудал дээр бас хариултаа авъя.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан хариулъя.

Т.Мөнхсайхан: Тэгэхээр ер нь энэ зүйлүүд маань төвлөрлийг сааруулах, эмнэлгийн тусламж үйлчилгээг аль болох амьдарч байгаа орон нутагт нь үзүүлэх бодлого дотор ер нь ороод явж байгаа. Бид нар ер нь энэ орон нутгаас ирж байгаа урсгал маш их байгаа учраас лавлагаа шатлалын төв эмнэлгүүд маань өдөр тутмынхаа тусламж үйлчилгээнээс илүү гарахгүй байгаа учраас Монголд эмчлэгдэхгүй байгаа өвлөлүүдийг бас эмчлэхэд жоохон учир дутагдалтай зүйлүүд байгаад байгаа. Тэгэхээр тийм учраас цаашид энэ БОЭТ-үүд дээр ер нь өндөр хүчин чадалтай төвүүдийг байгуулъя гэдэг ажил маань ер нь бас эхнээсээ яригдаад эхлээд явж байгаа. Гэхдээ бид нар энэ байршлуудыг нь их тодорхой ярих ёстой. Жишээ нь зүүн аймгууд руу БОЭТ Дорнод аймагт гээд байдаг. Гэтэл Хэнтий аймгаас тусламж, үйлчилгээ авах гэж байгаа хүн Улаанбаатар луу ирэх үү, Дорнод руу явах уу гэдэг асуудал байгаа. Тэгэхээр бид нар энэ байршлууд дээр нь маш оновчтой гаргаад, ер нь 6 газар БОЭТ-ийг шинэчлээд барья гэдэг зүйлийг Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр барья гээд яриа хэлэлцээрийн асуудал

эхнээсээ явчихсан байгаа. Дархан-Уул аймагт бол Сэргээн босголтын банкнаас энэ ажил маань ер нь энэ жилээс эхлэхээр явж байгаа юм. Тэгэхээр цаашидаа орон нутагт хүрэх тусламж, үйлчилгээг бид нар маш сайн сайжруулж байж, өнөөдөр энэ яригддаг улсын 1, 2, 3 дугаар эмнэлэг, ХСҮТ, Гэмтлийн эмнэлгүүд маань Монгол Улсад эмчлэгдэхгүй байгаа энэ өвчлөлтүүд рүүгээ эмчилдэг болох чиглэл рүүгээ судалгаа шинжилгээ рүүгээ орох ёстой. Энэ ажлууд маань бас эхнээсээ хийгдээд эхэлчихсэн байж байгаа. Монгол Улсад эмчлэгдэхгүй өвчин жагсаалт 26 гэж байгаа боловч яг нарийн өвчлөл болгоны эрхтэн систем болгоноор нь аваад үзэх юм бол энэ маань үүнээс илүү тоо байгаа. Энэ болгоныг бид нар нарийвчлан гаргаад эхнээс нь боловсон хүчнүүдийн гаднын хөгжилтэй улсуудад бэлтгэх ажил маань энэ 9 сараас боловсон хүчнүүд нь явж байгаа. Шаардлагатай тоног төхөөрөмжүүд маань энэ 11 сардаа багтаад хангагдаад ирэхээр бид нар Монгол Улсад эмчлэгддэггүй өвчлөлийг ирэх 4 жилд багтаагаад ер нь бүхий л төрлийн тусламж, үйлчилгээг үзүүлдэг болох энэ боломж байна гэж харж байгаа. Энийг жил болгон үе шаттайгаар энэ 26 тоогоо бид нар илүү нарийвчилж гаргаад, жилдээ ер нь 20 орчим төрлийн Монголд эмчлэгдэхгүй байгаа зүйлүүдийг эмчилдэг болгоод явчих энэ боломж нь байна гэдэг эхний ээлжийн судалгаанууд хийгдээд, эд нар маань биеллээ олох эхлэл нь тавигдаад явж байгаа.

Тэгээд цаашидаа бид нар ер нь зөвхөн энэ эмчилдэггүй улсуудыг эмчлэхийн тулд тоног төхөөрөмж, хүний нөөцөөс гадна хэрэглэж байгаа эм, тарианууд Монгол Улсад байхгүй, олдохгүй байгаа зүйлүүд бас нэлээдгүй байгаа учраас эд нарыг нь хангах гэх мэтчилэн бид нар ер нь цогц бодлогуудыг хийж хэрэгжүүлж байж Монгол Улсын иргэд маань ямар нэгэн байдлаар эмнэлгийн тусламж авахаар гаднын улсыг зорьдоггүй болох энэ боломж бүрдэнэ гэж харж байгаа. Гэхдээ бид нар цаашидаа ер нь зөвхөн өвдсөнийх

нь дараа эмчилдэг энэ тогтолцоогоо сайжруулах биш, яаж өвчин тусахгүй байх вэ, туссан тохиолдолд бид нар хэрхэн яаж эрт илрүүлж оношлох вэ гэдэг тогтолцоогоо маш сайн оновчтой бүрдүүлж байж ирээдүйд Монгол Улсад жил болгон нэмэгдээд байгаа өвчлөлийг буурна гэж харж байгаа учраас бид нар энэ орон нутаг руу чиглэсэн Монгол Улсад эмчлэгддэггүй өвчнүүдийг эмчилдэг болгох руу чиглэсэн томоохон бодлогын ажлууд маань энэ ер нь мөрийн хөтөлбөрт ер нь тусчихсан байгаа гэж ойлгож болно.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгөх юм уу. Учрал сайд.

Н.Учрал: 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гол онцлог бол 3 нам хамтарч байгаа учраас цаашидаа аль аль улс төрийн намуудын хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох үүднээсээ хамтарсан Засгийн газрын гэрээг байгуулсан. Энэ гэрээн дээр бол яг энэ бүсчилсэн хөгжлийн асуудлаар бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагад өөрчлөлт оруулж зарим томилгоог орон нутгийн удирдлагад шилжүүлэх асуудлыг авч хэлэлцэнэ гэдэг ийм агуулгын зохицуулалтыг оруулаад гэрээнд тусгасан. Яагаад Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бас яг шууд ингэж тусгаж болохгүй байгаа вэ гэвэл мэдээж энэ бол өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой ийм том агуулга юм байна. Тийм учраас шууд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ийм өөрчлөлт, зохицуулалтыг хийх нь зохимжгүй. Энэ утгаараа бас энэ Засгийн газрын гэрээнд тусгасан. Цаашидаа мэдээж энэ үйл ажиллагааны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Норовын Алтанхуяг гишүүн асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Энэ Засгийн газрын 4 жил Засгийн газар ч юу байх вэ дээ

Монголчууд 4 жил ямархуу байдалтай амьдрах юм бэ гэдэг ийм л уг нь бодлогын бичиг баримт орж ирэх ёстой л доо. Тэгээд 3 нам нийлээд засаг барьж эхэллээ гэж байгаа юм. Одоо энэ Гантөмөр дарга миний хажууд сууж байна. Одоо энэ мөрийн хөтөлбөр дотор алдагдсан 8 жилийн алдааг засах асуудал нэлээн сайн тусгагдсан байх гэж би ойлгож байгаа. Сонгогчдод нэг юм амлалчаад энэ танхимд орж ирээд өөр юм ярьдаг байж бас болохгүй. Би их тодорхой юм асууя. Ерөнхий сайдаас асууя гэж бодож байна. Энэ хээл хахууль, авлига, мөнгө төгрөг гэдэг юмаа багасгах, устгах ийм улс төрийн зориг байна уу энэ засагт. Энэ дотор би юу асууж байгаа вэ гэхээр мөнгөний сонгуулийг устгачихвал яасан юм. Одоо энэ мөрийн хөтөлбөртөө та нар бичээгүй бол бичихвэл яасан юм. Мөнгөний сонгууль гэдэг бол одоо сонгууль чинь мөрийн хөтөлбөрийн сонгууль болохоо болиод удчихсан шүү дээ. Одоо бол цэвэр мөнгөний сонгууль явж байна. Хаанаас үүдэлтэй явж байна вэ гэхээр би яг юуг засахыг нь бас хэлчихмээр байна. Тэр нь ухуулагчдад урамшуулал өгдөг гэдгийг л хасчихмаар байна. Одоо энэ бол жинхэнэ нөгөө мөнгө тараадаг, бүр нөгөө намынхаа ухуулагч нэртэй хүмүүст мөнгө тараадаг агуу том ийм мөнгөний сонгуулийг бий болгочихжээ. Энийгээ засчхав уу. Та хэд маань энэ дээр хариулт өгөөч. Ийм хүсэл зориг байна уу.

Энэ өнгөрсөн Их Хурал дээр би бас ярьсан юм. Хэсгийн ахлагч гэж хуульд байхгүй юм бий болгоод, хэсгийн ахлагч гэдэг бол Ардын намын ухуулагч нар ингээд тайван цагт ажилладаг болчхоод байна. Энэ бол халамж иргэдийг ялгаварлах юман дээр бол галзуу сайн ажиллаж байна. Энийгээ устгачхаж болохгүй юу. Устгана гэдгээ хуулиар нь аваад хаячхаж болохгүй юу. Энэ тайван цагт ухуулагч ажиллуулаад байна.

3 дахь нь сонгуультай холбоотой санал шүү Ерөнхий сайд аа. Энэ сонгуулийг 5 дахь өдөр биш 3 дахь өдөр

гээд хуульчилчихвал яасан юм бэ. Одоо нэг ийм арга ядсан аргаар л хулгай дээрэм хийгээд байх юм даа.

Нэг аж ахуйн шинжтэй нэг чухал юм байна. Аж ахуй юу байх вэ дээ, ер нь Монгол Улсын чинь гол хөдөлгөгч гол хүчин аж ахуйн нэгжүүд шүү дээ. Энэ аж ахуйн нэгжүүдийн татварыг бууруулах ямар бодлого, чиглэл тодорхой юм энэ дээр байна вэ. Одоо өнгөрсөн Их Хурал дээр бид нар бас яриад НӨАТ-ын 2 хувийг 5 болгоё буцаан олголтыг гээд л баахан ярьсан. Тэгээд л шилний цаанаас чихэр долоолгоод л өнгөрөөсөн шүү дээ. Энийг чинь аж ахуйн нэгжүүд хүсээд байна. Хэлээд байна. Хүмүүс яриад байна. Энийг хийхгүй юм уу.

Нийгмийн даатгалын шимтгэл чинь бол хэрээс хэтэрчихсэн. Өчигдөр бас Байнгын хороон дээр ярьсан Жавхлан сайд аа. Манай энэ татвар, хураамж, орлого чинь бол хэтэрчхээд яваад байна. Энэ чинь цаанаа аж ахуйн нэгжүүд дээр дарамт учруулаад байна. Нөгөө талдаа төрийнх нь энэ мөнгөөр тоглоод байна. Энийг хумих юм энэ мөрийн хөтөлбөрт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье. Асуултаа гүйцгээе.

Н.Алтанхуяг: 3 дахь асуулт нь бол Монголд шударга үнэн юм хэлсэн хүнийг газар сайгүй хавчин хяхдаг, ажлаасаа халдаг болсон байна. Өчигдөр над руу Сонгинохайрхан дүүргийн Өнөр сургуулийн багш Сарантуяа гэдэг хүн өргөдөл ирүүлээ. Тэнд байгаа тэр заал түрээслэх, хөл бөмбөгийн талбай түрээслэх янз бүрийн санхүүгийн асуудлыг нь шүүмжилсний төлөө багшийг амарч байхад нь ажлаасаа халчихсан. Наранбаяр сайд, би түрүүн хэлсэн шүү дээ. Та нар ийм юман дээр нэг хүний асуудал гэж үзэхгүйгээр анхаарал тавиад, шалгалт шүүлгийг нь оруулаад яримаар байна шүү дээ. Би Сонгинохайрхан дүүрэгт нэр дэвшээд явж байхад төрийн албан хаагчид бүр

таг дуугүй болчихсон байна лээ. Та нар яагаад дуугардаггүй юм гэхээр ажлаас хална гээд дарамтлаад байдаг юм. Тэгээд би улс төрийн агуулгатай юм хэлээгүй зүгээр л үнэн үг хэлснийх нь төлөө хүнийг ажлаас нь халдаг ийм юм бий болчихжээ. Одоо энийг бас бид зогсоомоор байна. Би Наранбаяр сайдад өргөдлийг нь өгөөд, хүсэлт тавьчихсан байгаа юм. Шалгалт оруулаад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: 1 дүгээрт мөнгөний сонгууль өөрчлөх хүсэл эрмэлзэл байгаа юу гэж байна. Байна. Тийм ч учраас энэ Үндсэн хуулийн тогтолцоог бас өөрчилсөн. 40 хувь нь пропорциональ тогтолцоо болчихлоо. Үүн дээр өөрчлөгдөх том агуулгуудаа хийгээд явах нь зүйтэй гэж үзэж байгаа. Ухуулагчийн тоог багасгахтай санал нэг байна. Энэ дээр хэдүүлээ эрх зүйн орчноо бүрдүүлээд явчих ёстой. Сонгууль бүхний өмнө өөр өөрийн дүрмээрээ тоглодог ийм 30 жил явж ирсэн. Тэгээд энэ Үндсэн хуульд орсон өөрчлөлт учраас энэ асуудлууд ингээд цэгцлэгдэх болов уу гэж найдаж байна.

Лхагва гарагт сонгууль хийх байж болох байх. Энэ ингээд хууль дээрээ оруулаад, хууль тогтоох онцгой бүрэн эрх парламентад байгаа учраас шийдээд явчхаж болох байх гэж бодож байна.

Нэг зүйл дээр Алтанхуяг дарга аа, тантай би санал нийлэхгүй байна. Тэр бол таны үед хамтарч болоод бид нарын үед хамтарч болохгүй гэдэг өнцгөөс яриад байгаад бол санал нийлэхгүй байна. Зарчим 2 үзүүртэй ийм зүү шиг байж болохгүй. Баяр дарга, та 2 засаг хамтарч байгуулж байсан. Батболд даргатай хамтарч байгуулж байсан. Та нар тухайн үед ингэхээс өөр арга байхгүй байна. Хамтарч асуудлаа шийдэх нь зүйтэй л гэдэг зүйлийг ярьдаг байсан. Тэгэнгүүт одоо энэ чинь ингээд галав юүлээд эсвэл газар, тэнгэр өөрчлөгдчихөөд байгаа зүйл биш. Цаашидаа ч хамтарсан Засгийн

газрууд бол байна. Тийм учраас та бас Ерөнхий сайдаар ажиллаж байсан хүний хувьд энэ олон зовлон жаргалыг мэддэг геополитикийн нөхцөл байдлыг мэдэж байгаагийн хувьд миний үед бол болно. Гантөмөрийн үед бол болохгүй гэж байгаа наад хандлагаа өөрчлөөч ээ. Тэгэхгүй бол наадах чинь тэгээд бас нэг тийм юу байдалтай болоод. Тэгээд ч Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт угаасаа л байнгын хамтарсан Засгийн газар бүрдэх энэ л тогтолцоо руу бид нар Германтай адилхан орчихсон шүү дээ. Энийг бас би хэд хэдэн удаа сонсож байгаа учраас эхний 2 санал дээр чинь санал нэг байна. Сүүлчийн хандлага дээр чинь санал нэг биш байна гэж хариулья.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: 3 минут байгаа учраас маш товчхон, оршилгүй асуугаад явъя гэж бодож байна. Хүлээлт бол нэлээн өндөр байна. 3 нам хамтарч Засгийн газар барьж байгаа. Суурь асуудлууд шийдэгдэх байх гээд. Тэгэхээр энэ суурь асуудлуудын бас гол болсон зүйлүүд ерөнхийдөө энд хөндөгдөж ерөөсөө яригдахгүй байна. Өнөөдөр хувийн хэвшлийн асуудлыг шийдэхийн тулд газрын реформ явах ёстой. Ажиллах хүчний асуудлыг ярих ёстой. Энэ дэд бүтцийн бүтээн байгуулалтыг хийх ёстой. Өнөөдөр яах вэ, дэд бүтцийн асуудлууд эрчим хүч, зам дээр ч гэдэг юм уу боомтын сэргэлт дээр яригдаж байгаа боловч энэ газрын реформ явахгүйгээр уул уурхайн асуудал цаашаа бас явахгүй. Хөдөө аж ахуйн эрчимжүүлэх асуудал явахгүй. Энэ зарим аймгийн газар чинь ерөнхийдөө газрын эрхийн төвлөрөл бий болчихоод байна шүү дээ. Сэлэнгэ, Дархан ч гэдэг юм уу, ерөөсөө 1, 2 компанийн эзэмшилд орчихсон байна. Энэ малын бэлчээрүүд чинь ерөнхийдөө бас нэг цөөн тооны мянгат малчдын бас бэлчээрүүд чинь өвөлжсөө, хаваржаагаар орчихоод байна. Тэгэхээр энэ газрын хөлийн реформыг хэзээ оруулж ирэх вэ. Намрын чуулганаар ... Алтанхуяг дарга аа, би үг

хэлж болох юм уу. Эхнээс нь авч болох юм уу Амарбаясгалан дарга аа.

Д.Амарбаясгалан: Энэ асуулт нэгэнт эхэлчихсэн байна Алтанхуяг гишүүн ээ. Тэгээд араас нь нэмэлт хариулт өгүүлчихье. Харин өгүүлчихье гэж байна шүү дээ. Гишүүний асуулт эхэлчихсэн учраас асуултыг нь дуусгачихъя. Энэ дээр бухимдаад байх юм байхгүй. Хариултыг чинь нэмээд өгүүлчихье гэж байна шүү дээ. Тэнд асуулт эхэлчихсэн учраас араас нь хариултаа өгье гэхээр нь нэмээд үүний дараа өгүүлчихье гэсэн байдлаар явж байна. Бухимдах зүйл ерөөсөө байхгүй. Асуулт нь эхэлчихсэн хойноос нэмж хариулья гэж гар өргөсөн юм. Тэгээд тэгж явлаа. Ялгавартай хандсан зүйл байхгүй. Сайнзориг гишүүн асуултаа дуусгачих. Тэгээд таны асуултад хариулуулья.

П.Сайнзориг: Цаг эхнээс нь өгөх юм уу, өгөхгүй юу. 1 дүгээрт энэ газар хуулийн реформ намрын чуулганд орж ирж чадах уу. Энэ Засгийн газар яг энэ дээр нэгдсэн байр суурьтай, нэгдсэн байдлаар оруулж ирж чадах уу. Энэ газрын реформын цаана өмчийн асуудал гол яригддаг. Төрийн байгууламжийн нэгдмэл байдлын асуудал байгаа. Энийг Хууль зүй, дотоод хэргийн яам авч явах ёстой юм. Энэ бол Барилга, хот байгуулалтын яам ч юм уу үе үеийн салбарын нэг дагуул сэдэв биш юм байгаа юм. Суурь асуудал дээр реформ хийж байж өнөөдөр уул уурхай хөгжинө. Хөдөө аж ахуй хөгжинө. Энэ газрын эрхийн төвлөрөл бий болоод байгааг зогсоож чадна. Энийгээ 1 дүгээрт асуумаар байгаа юм.

2 дугаарт ... Алтанхуяг дарга аа, би энд юм яриад байна шүү дээ. Та одоо больчихье л доо. Сонсогдохгүй байна. Та чинь одоо ямар сонин хүн бэ. Одоо гараад бухимд л даа.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн асуултаа асуугаад дуусгачих.

Норовын Алтанхуяг гишүүний асуултад Жавхлан сайд хариулъя. Сая асуулт эхэлсний араас нэмж хариулъя гэж гар өргөсөн. Тийм учраас асуулт нь эхэлчихсэн байсан учраас гүйцээгээд явуулж байна. Та бас настай, намбатай хүн байна жоохон тавиртай байвал яасан юм.

Б.Жавхлан: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Алтанхуяг гишүүний Ерөнхий сайд байх үеийн татварын дэглэмд 2019 онд орсон Татварын багц хуулиар нэлээн өөрчлөлтүүд орсон. Одоо энэ удаа хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт бүр бүтэн нэг бүлэг орж байгаа. 3.2.1-3.2.1.7 гээд 8 заалттай. Таны гар дээр бүтнээрээ очсон байх гэж би найдаж байна. Ингээд би ядаж танд тоог нь хэлж байгаа учраас та нэг тогтоод харчхаарай.

Тухайлбал, энэ дотор таны хөндсөн асуудлууд бас хөндөгдсөн байна. Татвар, нийгмийн даатгалын реформ, татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах зарчим баримталж гээд, ингээд нурушин уншаад яах вэ. Ингээд 8 заалт бүхий хөтөлбөр таны гар дээр очсон байгаа. Энийг ингээд дэмжээд, батлагдаад гарваас хоёрхон 7 хоногийн дараа өргөн барих 2025 оны төсвийн хууль дагалдуулаад эдгээр өөрчлөлтүүд шат дараатай ороод тусгагдаад явна. Тэр үед 2025 оны төсөв хэлэлцсэн дагасан татварын хуулиуд дээр энийгээ хэдүүлээ тойроод бас ярилцах боломж гарах нь ээ.

Д.Амарбаясгалан: Боловсролын сайд Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ өргөдлийг би бас хүлээж авсан. Үнэхээрийн тийм харамсалтай тохиолдлыг бичсэн байна. Зүгээр сургуулийнхаа хурал дээр зарчмын шаардлага тавьсныхаа төлөө Монгол хэлний багш, бага ангийн багшийг халсан ийм явдал байна. Тэгэхээр энийг бол бид нар энэ салбарын хяналтын газар гэж байдаг. Үүгээрээ дамжуулж шалгана.

Шалгасныхаа үндсэн дээр хэрвээ үнэхээрийн гомдол нь үндэслэлтэй бол эргүүлэн ажилд нь оруулахаар явна. Ер нь бол иймэрхүү байдлаар захирлууд хууль зөрчиж ажиллаж байгаа жирийн багшийг халах явдал бас нэлээд үзэгдэж байгаад би бас харамсаж байна. Сургууль бол улс төрждөг ийм байгууллага биш. Сургууль бол хүүхдийн боловсролыг олгодог эцэг эхтэйгээ хамтран ажилладаг ийм л байгууллага. Тэгэхээрээ бид бол төрийн албаны хуулийн дагуу Төрийн албаны зөвлөлийн Боловсролын яам дахь салбар зөвлөлийн хуулийн хэрэгжилтийг бол хангаж ажиллана гэдгийг хэлье. Цаашидаа ч гэсэн ер нь энэ Боловсролын ерөнхий хуулийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах юм уу. Нэмэлт 1 минут өгчихье.

П.Наранбаяр: Тэгэхээр Боловсролын ерөнхий хуулийг бас хэлэлцэж байхад бид санал оруулж л байсан. Тэгэхдээ тэр нь ороогүй. Энэ юу вэ гэхээрээ зэрэг захирал хүн багш нараа ажилд томилдог биш. Тухайн дүүрэг, тухайн аймгийн боловсролын газар нь олон багш нар дүүрэгтээ байгаа багш нараа мэргэжил мэргэжлээр нь жагсааж байгаад, ажиллах сургуулийг нь томилж шийддэг болох нь бол өөрөө их зүйтэй ийм алхам гэж харж байгаа юм. Энэ шинэчлэл рүү аажимд нь явуулна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүний асуултад Алтангэрэл сайд хариулна. Хууль зүй, дотоод хэргийн сайд. Тэгээд нэмэлтээр асуучихъя дараа нь. Гүйцээгээд асуучихъя. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Баярлалаа би ерөөсөө нөгөө хүлээлт өндөр байна. 2 дугаарт энэ олон юмны реформууд мэдээж дэд бүтцийн хөгжлийн асуудал байгаа. 2 дугаарт газрын асуудал юм. Газрын асуудлаа энэ 3 нам хамтарч барьж байгаа дээрээ нэг мөр ойлголтоо цэгцэлчихвэл яасан юм бэ. Энийг намрын чуулганд оруулж ирж чадах уу. Энэ бас Одонтуяа

сайдтай ч хамаатай. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал оруулж ирж чадах уу. Энэ өмчийн асуудал цаана нь яригдана. Энэ өнөөдөр байгаа бүх үл хөдлөх хөрөнгүүд чинь газар дээр байгаа боловч эрхийн бүртгэлтэйгээ холбогдохгүй байгаа учраас бүгд агаар дээр байгаа мэт хууль зүйн ойлголт явж байгаа шүү дээ.

2 дугаарт энэ газрын эрхийн төвлөрөл бий боллоо. Сэлэнгэ, Дарханы район чинь хэдэн компаниудын өмчлөлд орчихлоо. Энэ малын өвөлжөө бэлчээр чинь хэдэн мянгат малчдын өмчлөлд орчихлоо. Энэ эрхийн төвлөрөл чинь явж явж цаашидаа Энэтхэгийн касстын системийг үүсгэдэг эд байхгүй юу. Тэгэхээр бид хэд энэ дээр бас өөрчлөлт хийж чадах уу.

2 дугаарт энэ ажиллах хүчний асуудал байгаа. Өнөөдөр манай жирийн компани ажиллах хүч гаднаас оруулж ирэх ямар ч бололцоогүй. Өнөөдөр 6500 гаднын хүн ажиллаж байна лээ статистикаар. Үүний 87 хувь нь үндсэндээ чөлөөлүүлчхэж байгаа юм. 13 хувьд нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чөлөөлүүлж чадахгүй, дээрээс нь жилд 1 гаднын ажиллах хүчинд 16 сая төгрөг төлж байгаа. Гэтэл Австралид 10 сая доллар хүртэлх орлоготой аж ахуйн нэгж жилд 1 хүн дээр 100 доллар төлж байгаа байхгүй юу. Ийм байдлаар бид нар бизнесийг дэмжих суурь реформуудыг хийж чадах уу. Газрын энэ юмнуудыг бас шийдээч ээ.

2 дугаарт энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээ дээр би прагматик л юм ярья. Жавхаа сайд хариулах болов уу гэж бодож байна. Энэ жишээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг аймгуудад хуваарилж өгч байгааг бүс нутгийн хэмжээндээ зарцуулах тэр шийдлийг нь гаргаж өгч болох уу. Өнөөдөр Дундговь аймгийн зам ямар байгаа билээ. Дундговиор дандаа Өмнөговийн ачаа бараа явж байгаа. Энэ замын чанар хүртээмжээсээ болоод

хүний олон амь нас эрсдээд байдаг. Өмнөговьд нь мөнгө байгаад байдаг. Дундговийн замыг засаж болдоггүй. Тэгэхээр үүгээр бүс нутгийн хөгжил, тухайн тэр нөлөөллийн бүсэд хамтдаа байгаа бол энэ тодорхой татварын хуваарилагдаж байгаа төсвийн орлогуудаар хамтдаа асуудлаа шийдэх төсвийн реформыг явахгүй бол бүсчилсэн хөгжлийн реформ чинь өмнө нь хэн нь аль аймаг нь төв байх вэ гэдэг л ийм цаасан малгай өмсөхийн тулд явсаар байгаад дууссан. Энийг бодит ажил болгоё гэвэл татварын болоод төсвийн реформоор л явах ёстой. Тэгэхээр энэ дээр одоо шийдэл байж болох уу.

2 дугаарт энэ хувийн эрх зүйг дэмжихгүйгээр цагдаажсан төр ч гэнэ үү өшөө олон юмаар нэрлэж болно. Эндээс салахгүй. Өнөөдөр бизнесийн маргааныг үр дүнтэй шийдээд өгөх цаг хугацаа багатай шийдээд өгөх энэ механизмуудыг бид нар дэмжихгүй байж байж бүх асуудал угаасаа цагдаа дээр л очно шүү дээ. 4 жил явчхаад биелэхгүй шийдвэрээр явах уу, эсвэл таньдаг цагдаа руугаа утасдаад залилангаар шалгаад өгөөч гэж асуудлыг хурцатгах уу л гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энийг үе үеийн сайд нар цагдаатай ноцолдож ерөөсөө хувийн эрх зүйг анхаардаггүй энэ байдлыг бид хэд өөрчилмөөр байгаа юм. Энэ дээр реформ явж чадах юм болов уу, үгүй юу би бас мэдмээр байгаа юм.

2 дугаарт энэ боомтын сэргэлтийн асуудал. Энэ дээр бас үе шаттай байнгын хөрөнгө оруулалтуудыг хиймээр байна. Өнөөдөр чинь бид нар нэг Чайна Энержи компанийн жилийн хэрэгцээний 5 хувийг л гаргахын тулд улсаараа ажиллаж байгаа шүү дээ. Тэгээд Ганцмод-Гашуунсухайтын төмөр замын холболтыг хийж чадахгүй бол дараагийн юмнууд удааширна. Гэтэл энэ асуудлууд чинь доор ер нь явахгүй шинжтэй байна. Оюутолгойн асуудлууд байна. Яг үүнийгээ нэгдсэн байдлаар энэ хамтарсан Засгийн газрын үед томоохон бүтээгдэхүүн хуваах гэрээ, хөрөнгө оруулалтын

гэрээнүүдийг нэг дүгнээд урагшилмаар байна. Ярьсаар л байдаг. Хөрөнгө оруулагчид нь ойлгомжгүй ийм нөхцөлтэй байна. Тэгэхээр энийг улс төржихгүйгээр, нийтлэг байдлаар авч явах энэ асуудлыг мөрийн хөтөлбөрт тусгаж цаашидаа бас нэг шийдчихмээр байгаа юм гэдэг зүйлийг бас хэлмээр байгаа юм.

2 дугаарт түрүүн Сандаг-Очир гишүүнтэй ижилхэн байна. Засаг захиргааны нэгжийн хуваарилалтыг одоо л энэ хамтарсан Засгийн газрын газрын үед яримаар байна. Үүний цаана Үндсэн хуулийн өөрчлөлтүүд ч бас яригдах ёстой. Энийг яг хамтарсан Засгийн газрын барьж байгаа энэ удирдлагууд яг ямархуу байр суурьтай байна вэ. Ер нь үүний чинь цаана нөгөө төрийн үйлчилгээний хүртээмж, чанарын асуудал маш олон асуудлууд байгаа шүү дээ.

Д.Амарбаясгалан: Одонтуяа сайд Байгаль орчны сайд Одонтуяа хариулъя.

С.Одонтуяа: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга бол бэлэн болсон байгаа. Энийг намрын чуулганаар оруулж ирэхэд бол бидний, манай яамны зүгээс бол бэлэн. Гагцхүү бид нар бас энэ Газрын тухай хуультайгаа нийцүүлэх ийм асуудлууд байгаа. Тэгээд энийг Газрын тухай хуультай нийцүүлээд аль болохоор хурдан оруулж ирж батлуулах ийм сонирхолтой байна.

Д.Амарбаясгалан: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байна уу. Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Би зарим нэг асуултад нь хариулж байя. Сайнзориг гишүүн ээ, та бас их сонирхолтой санал хэлж байна. Бид нар бас наадхыг чинь бодоод л байгаа юм. Тэгэхдээ энд нэг ийм зарчмын суурь ойлголт байгаа юм шүү. Бүсийн татварын асуудал гэж байгаа. Бүсчилсэн татварын асуудал. Та бол одоо татвараар төсвийнхөө орлого

бүрдүүлэлтээ хийгээд, буцаагаад хуваарилалтынх нь шатанд нь ярьж байна. Тэгэхээр энэ 2 жоохон өөр ойлголт шүү. Ямар ч байсан сая бид 6 сард хийсэн нэлээн хэдэн хуулийн өөрчлөлтүүд дотор энэ бүсчилсэн татварыг аймгууд өөрсдийнхөө онцлог дээр тулгуурлаж, өөрсдөө шийдвэрлэх, Иргэдийн хурлаараа оруулаад батлуулах ийм зохицуулалттай болчихсон. Гэхдээ тухайн аймгийн дарга өөрийнхөө аймаг дээр онцлог бүхий татвар тавихдаа бүс нутгийнхаа бусад аймаг, иргэдийн хурлынхантайгаа зөвшилцөж байж, нэгдсэн ойлголтод хүрч байж шийдвэрээ гаргана гэсэн ийм зохицуулалт татвар талд нь бол хийчихсэн. Тэгэхээр орлого хуваарилалт тал дээрээ бас болохгүй юм бол байхгүй. Гэхдээ одоогийн хуулийн зохицуулалтын хүрээнд бол энэ байхгүй. Өөрөөр хэлбэл бүсийн төсөв гэдэг ойлголт одоогоор бол байхгүй.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд гүйцээж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ боомтын сэргэлтийн хөтөлбөр бас амжилттай хэрэгжиж байгаа. Хамтарсан засаг байгуулагдаж байгаа бас нэг шалтгаан бол өөр өөрөөр тайлбарлагдаад байгаа энэ том төслүүд шийдлээ олоосой л гэж бас бодож байгаа. Нэг нь бол Гашуунсухайт-Ганц модны хил холболтын төмөр зам мөн. Энэ болсон үйл явдал бол ойлгомжтой. Монгол Улсын Ерөнхийлөгч Элбэгдорж Хятадад айлчлаад хэлцэл хийсэн. Түүний дараа Засгийн газрын түвшинд болохгүй гээд зогсоосон. Энэ дунд нь БНХАУ-ын тал хөрөнгө оруулалт хийгээд замаа барьчихсан. Ингээд БНХАУ-ын талаас үздэг зүйл нь юу вэ гэхээр Монгол Улсын л байр суурь гэж бид нар итгэсэн шүү дээ. Тэрнээс биш Ерөнхийлөгчийнх нь байр суурь нэг тусдаа, Засгийн газрынх нь байр суурь нэг тусдаа ийм байдаг гэж үзээгүй. Тийм учраас Гашуунсухайт-Ганц модыг холбох хүртэл бусад боомтуудтай холбоотой энэ асуудлыг идэвхжүүлэхэд бол хүнд байна гэдэг ийм л асуудал

яригдсан зүйл шүү дээ. Ер нь тэгээд би бас Батцэцэг сайд, Эдийн засаг, хөгжлийн сайдад өнгөрсөн 7 хоногийн Засгийн газрын хуралдаан дээр бас чиглэл өгсөн байгаа. Тэр нь парламентын гишүүдэд энэ 34 одоо мега төсөлтэй холбоотой бүх материалуудыг өгөөч ээ. Он, цаг, өдрийн дарааллаар ямар ямар хэлцэл хийгдсэн бэ. Яагаад гацсан бэ гэдгийг нь гаргаад өгчхөөч ээ гэдэг энэ зүйлийг хийсэн. Тэгээд Батцэцэг сайд бас парламентад яаралтай хүргэчих нь зүйтэй байх. Тэгээд хэдүүлээ ил тод нээлттэй л ярилцъя. Ер нь ихэнх тохиолдолд бид нар сайн судлахгүйгээр асуудлуудыг гаргаж тавиад, одоо энэ Эгийн голын станц ч ялгаа байхгүй. Тэгээд ингээд өөр өөрөөр ярьсаар байгаад энэ маань ингээд очоод хөрөнгө оруулагчдад бусад улсдаа буруу ойлгогдчих ийм зүйл байдаг. Гашуунсухайт-Ганц модны хил холболтын төмөр замыг хийхгүйгээр экспорт 80-100 сая тоннд хүрэх ямар ч боломжгүй. Тийм учраас энийг бид нар 1 дүгээрт эрэмбэлж оруулж ирсэн нь бол энэ. Улс төржиж гацаад 16 жил өнгөрлөө. Одоо бид нар холбох цаг болсон. Энэ төслийг шийдэхгүйгээр Ханги мандал болон 3 коридорын асуудал явахгүй ээ. Явахгүй. Тийм учраас энэ асуудлаа бид нар ярилцаад явах нь бол зүйтэй. Тийм учраас би бас баярлаж байна. Манай парламентын гишүүд ийм асуудлуудыг бас ингээд хөндөж гаргаж тавьж байгаад. Тэгээд бид нуугаад байх юм байхгүй. Шууд энэ танхимдаа ярилцаад л болно, болохгүйгээ яриад ингээд явах хэрэгтэй. Гагцхүү мэдээлэл багатайгаар буруу ойлголт төрүүлээд байх ийм тайлбарыг л популист маягаар хийхгүй байхыг л манай парламент маань анхаарч чадвал бид нар асуудлуудаа шийдээд хамтарсан Засгийн үед энэ мега.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл сайд хариулъя.

О.Алтангэрэл: Энэ газартай холбоотой асуудал, Газрын тухай

хуультай холбоотой асуудал бол нэлээн чухал асуудал. Үүнийг хүлээн зөвшөөрч байгаа. Тэгээд төрийн ажил бол залгамж чанартай байх ёстой. Нямбаатар сайдын үед, таныг ажиллаж байх үед хувийн эрх зүй дээр Монгол Улсын эрх зүйн системд хувийн эрх зүйг анхаарсан, хувийн эрх зүй рүү олон хуулийн төсөл боловсруулсан олон чухал ажил хийгдсэн. Хууль зүйн яам дээр хувийн эрх зүйн чиглэлээр ер нь боловсруулж бэлдэж байсан хуулиудыг ингээд бүлэг болгоод, тэгээд энэ үйл ажиллагаанд бас оролцоод ингээд яваач ээ гэж хуульч хүний хувьд танд бас би хувийн зүгээс урилга хүргүүлсэн байгаа.

Тэгэхээр Газрын тухай хууль бол олон харилцааны суурь болдог. Дээрээс нь олон үзэл бодол олон улс төрийн байр суурийн нэгдэл болдог чухал хууль учраас бид нар энэ дээр тал талын байр суурийг авч нэлээн няхуур хандах ёстой. Энэ бол Монголын ард түмний их анхаардаг чухал хууль гэдэг утгаар нь байгаа. Тэгээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сайнзориг гишүүн тодруулга.

П.Сайнзориг: Учрал сайд нөгөө засаг захиргааны шинэчлэлийн асуудал дээр бас нэг хэлээд өгөөрэй. Энэ бас үйл ажиллагааны хөтөлбөр дээр Оюутолгойтой дүйцэхүйц нэг төслийг хөдөлгөнө гэж байгаа юм. Энэ яг юуг хэлж байгаа вэ.

2 дугаарт хүнс, эрүүл мэндийн буюу эмийн нэгдсэн I агентлагийг байгуулж болдоггүй юм уу. Хүний ходоод руу орж байгаа энэ зүйлийг нэгдсэн удирдлагаар хангахгүй бол энэ уялдахгүй байна. Энэ дээр бодлогын асуудал дээр байна шүү гэдэг зүйлийг хэлмээр байна.

2 дугаарт энэ халамжийн асуудал байна. Яах вэ, энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас өгч байгаа, энэ зарцуулж байгаа мөнгөний бага хувь буюу 440 тэрбум төгрөг гэж байгаа боловч халамж авч байгаа иргэдийн чинь тоон

үзүүлэлтээрээ өсчөөд байна. Энэ өөрөө бид нарын амьдралын хандлагыг бас өөрчлөх дээр бас одоо л 3 нам эрх барьж байгаа дээр шийдмээр байна.

2 дугаарт энэ ноцтой хэдэн юмнууд байна лээ. 4.2.3.6 төрийн албан хаагчдыг эвлэлдэн нэгдэх асуудлыг шийднэ гэхихсэн байна. Энэ яслийн асуудал байна. 1-2 настай хүүхдүүд ер нь эцэг эхийнхээ асран хамгаалалтад байх ёстой болохоос биш ясли байгуулж байж энэ асуудлыг гэдэг ийм зүйлүүдийг эргээж хараач ээ.

2 дугаарт э ахмадуудыг ерөөсөө 2 хувийн бас бүх хувийн хэвшил дээр ажиллуулна гэж байгаа юм. Ингээж хувийн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Учрал сайд хариулъя. Тэгээд бас энэ ажиллах хүчтэй холбоотой асуудлаар асуулт тавьсан байгаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хэн хариулахаар байна. Гадаадын болон дотоодын ажиллах хүчний нөхцөл байдлын талаар.

Н.Учрал: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн асуудал энэ Засгийн газрын үед хөндөгдөхөөс өөр боломжгүй. Дахиж тийм цаг олдохгүй. Энэ цаг үе бол мөн үү гэвэл мөн. Сая өнгөрсөн парламент бид нар Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль дээр хамт ажиллалаа. Зайлшгүй эргээд харах шаардлага бол үүссэн. Гэхдээ үүнийг үндэсний хэмжээнд хэлэлцүүлэг хийж байж, зөвшилцөл хийж байж мэргэжлийн байгууллагууд холбоодын санал шүүмжийг тусгаж байж иргэдийн саналыг тусгаж байж хийнэ. Тэрнээс биш энэ бол тийм богино хугацаанд хийчих бас ажил биш учраас Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг эргээж харъя гэдгийг бол энэ хамтарсан Засгийн газрын гэрээнд бас тусгасан гэдгийг хэлэх ёстой байх гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн

нарийн бичгийн дарга Мөнхзул индэр дээрээс хариулах уу. Хэддүгээр микрофон байна. 8 дугаар микрофон өгье.

Л.Мөнхзул: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1-д заасны дагуу 2024 оноос эхлээд ерөнхийдөө шинэ сэргэлтийн бодлого хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх зохицуулалтыг Засгийн газраас гаргаад, энэ эдийн засгийн бодлогыг дэмжлэг томоохон бүтээн байгуулалтуудыг дэмжих зорилгоор ажлын байраас бас тодорхой хэмжээнд төлбөрөөс чөлөөлөх энэ асуудлуудыг Засгийн газраас бол хэрэгжүүлж ирж байгаа. Цаашидаа стратегийн ач холбогдолтой томоохон бүтээн байгуулалт дээр гадаадаас ажиллах хүч авч байгаа тохиолдолд ажлын байрны төлбөрийг нь хөнгөлж, өөрөөр хэлбэл өртөг үйл ажиллагаанд нь хөнгөлөлт үзүүлэх энэ бодлогын зорилтууд бас үйл ажиллагааны хөтөлбөрт туссан. 2022 онтой харьцуулахад бол нийт төлбөрийн хэмжээ 50 хувиар буурсан байгаа. Түүнчлэн Сайнзориг гишүүний асуултад хариулахад Ахмад настны тухай хуулиар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Болсон. Сайнзориг гишүүн асуулт асуусан. Дэгээ барина шүү бүгдээрээ. Танхимдаа хүмүүжилтэй байна шүү. Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр хөтөлбөрийн төсөл дээр 2, 3 асуулт, саналууд байгаад байгаа юм. Бид бүсчлэлийг нэлээн онцгой анхаарал хандуулж тавьж байгаа. Тэгэхээр энэ бүсийг өөрийг нь амь оруулдаг юм бол яах аргагүй хөгжлийнх нь бодлого, төлөвлөлт, дэмжлэг, удирдлага, гүйцэтгэл, хяналтынх нь асуудлыг зөв зохицуулсан механизмыг нь бий болгохгүйгээр бид явахгүй. Тийм учраас үүнийгээ түрүүн Сандаг-Очир ч хөндөнө лээ, Ж.Бат-Эрдэнэ гишүүн ч хөндөнө лээ.

Үүн дээр ер нь ямархуу байр суурь байгаад байна вэ гэдэг нэг ийм асуудал.

2 дахь зүйл дотоод бүсчлэлийг нь яах юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Одоо бол бид 3 гэдэг юм уу, 4 гэдэг юм уу аймгуудыг бүсчилсэн. Тэгвэл дотроо энэ бүсүүд чинь ямархуу байдлаар дотоод бүсчлэлтэй явж, өнөө тэргүүлэх зорилтуудаа хангах, хоорондоо зөв хослол явах боломж нь бүрдэх юм гэдэг асуудал байгаад байгаа юм л даа. Үүнийгээ ер нь ямархуу байдлаар хэдүүлээ харах ёстой вэ. Энэ дээр та бүгд юу харж байна вэ гэдэг нэг ийм зүйл байгаад байгаа гэж.

Дараагийн нэг зүйл энэ улс орны өөрийнх нь онцлог юм. Боловсролын багц хуулиа шинэчлэхдээ бид боловсролын салбарын боловсон хүчнүүдийнхээ хангалтын асуудлыг шийдчихсэн юм. Өнгөрсөн жил. Тэгвэл одоо Эрүүл мэнд, Хөдөө аж ахуйн салбар дээр боловсон хүчний хангалтыг яаж хийх вэ гэдэг юмыг зохицуулахгүйгээр бид цаашаа явахад их төвөгтэй байгаад байгаа. Би бол тэр Боловсролын хуульд орсон үзэл санаагаар нь энэ 2 салбарын боловсон хүчний хангалтыг хийвэл бидэнд энэ боловсон хүчний хүчин зүйлээс хамааралтай асуудал нэлээн нааштай болох юм биш биз гэдэг ийм санаа байгаад байна гэж. Дээр нь энэ төвийн бүсийн нэршил дээр жоохон харах юм байгаа болов уу гэж би бодоод байгаа. Анхдагч үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл 2-ыг кластераар нь авч явахгүйгээр ялгачих юм бол болохгүй байгаа юм. Бид нарын хөгжил удааширсан юм үүнд л байгаа. Тийм учраас төвийн бүс бол эрчимжсэн хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн төрөлжилт тэгээд эрчим хүчний дэд бүс л байх ёстой л гэж хараад байгаа. Яах аргагүй эрчим хүчний үйлдвэрлэлийн чинь түүхий эд буюу хүрэн нүүрс чинь энэ бүс нутаг дээр л байгаад байгаа. Одоо шинээр бий болох гээд байгаа эх үүсвэрүүд чинь энэ дээрээ байгаад байгаа. Тийм учраас үүнийг хэлэлцүүлгийн түвшинд эргэж хараад зөв шийдэл гаргах бололцоо байна уу гэсэн нэг ийм зүйл байна.

Дараагийн нэг зүйл Азийн нэлээн хөгжилтэй улс орнуудын дунд байгаад байна бид хэд. Мэдээлэл хавтгайрчихлаа. Үгүй ээ, хөдөлмөрийн үнэлэмж өндөртэй газар луугаа чиглэсэн урсгал явчхаад байна. Тэгэхээр хэдүүлээ яаж дотоодынхоо бүтээмжийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн хөлснийхөө үнэлэмжийг дээшлүүлэх вэ гэдэг асуудал л бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд асуултад хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бас Монголчуудын аж амьдралд нэлээн тийм том хэмжээнд нөлөөлөх итгэл тавьж байгаа нэг бүс бол төвийн бүс байгаа. Тэгээд энэ хөтөлбөр дээр нийслэл Улаанбаатар хоттой төвийн бүс өөрөө түрүүлж интеграцад орох ийм асуудлыг бол тусгасан байгаа. Тэгээд манай төвийн бүсээс сонгогдсон парламентын гишүүд ч гэсэн төрөлжсөн болон дэд чиглэлээ бол та бүхэн ярьж байгаад бас энэ хэлэлцүүлгийн үед тодорхойлж болно. 2-оос илүү ийм чиглэл гарвал бас дахиад тарамдах ийм зүйл рүү орно. Тийм учраас эрчимжсэн хөдөө аж ахуйтай холбоотой ийм том асуудлыг төвийн бүсийнхэн маань гаргаж тавьж байгаа. Дэмжиж байгаа. Хунс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэртэй холбоотой бас төрийн захиргааны төв байгууллагууд үе шаттайгаар шилжих асуудлыг Засгийн газар, Ерөнхий сайдын хувьд дэмжиж байгаа гэдгээ бас илэрхийлье.

Мөн нийслэл Улаанбаатар хоттой интеграцид орно гэдэг бол ямар нэгэн байдлаар газар нутгийн асуудал огт хөндөгдөхгүй шүү гэдгийг би бас төвийн бүсийн иргэд сонгогчдоод бас Их Хурлын гишүүдэд бас баталгаатай хэлье. Ийм олон газрууд байдаг. Жишээлбэл нийслэлтэйгээ нийслэлийн хажууд байгаа газрууд GPS-ийн бараг тоо л солигдоно уу гэхээс биш солигдож байгаа нь бараг мэдэгдэхгүй хэмжээнд хоорондоо интеграцад орчихсон байдаг. Тийм учраас

2 дахь том төвлөрөл бол Хөшигийн хөндий Зуунмод хот байх болно. Энд сургууль, цэцэрлэгийн асуудлыг ч ихээр шийдвэрлэх болно. Нүүлгэн шилжиж байгаа төрийн байгууллагуудын төрийн албан хаагчдын ипотекийн зээлийн хөнгөлөлтийг ч нэлээн тийм өндөр түвшинд хийгдэх болно. Мөн пассив хаус буюу ийм хаус хотхоныг Хөшигийн хөндий рүү барих болно. Үүн дээр нийслэл Улаанбаатар хотдоо явж байгаа дэд бүтцийн том төслүүд интеграцид бол орох болно. Тийм учраас Төв аймаг эрчимжсэн хөдөө аж ахуй, мөн эрчим хүч, мөн хот байгуулалтын маш том хэмжээний бүс болон хөгжих боломжтой. Энэ дээр манай Батжаргал гишүүн бас санаачилгатай, олон асуудлуудыг өнгөрсөн парламентаар бас гаргаж тавьж, эрх зүйн орчныг бүрдүүлсэнд бол талархалтай ханддаг. Бүсчилсэн хөгжлийг бас дэмжих зүйл дээр ч гэсэн манай орон нутгийн ялангуяа аймгийн даргаар ажиллаж байсан манай парламентын гишүүд бол өнгөрсөн парламент дээр маш идэвхтэй оролцож ажилласныг бол бас онцлон тэмдэглэж хэлэхийг хүсэж байна. Ингээд Засгийн газрын зүгээс бүсчилсэн хөгжил, тэр дундаа нийслэл Улаанбаатар хот, төвийн бүс хоорондоо интеграцид орох, түрүүн бас хэлсэн Дархан, Сэлэнгэ болон Орхон, Булган хоорондоо интеграцид орох энэ асуудлыг бол дэмжиж ажиллах болно. Тэгээд үе шаттай шийдээд явах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах сайд нар байна уу. Энх-Амгалан сайд асуултад хариулъя.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр Батжаргал гишүүн бол нөгөө Монгол хүний бүтээмжийн асуудлууд хөндлөө л дөө. Тэгээд ер нь яагаад манай хөдөлмөрийн зах зээл дээр нэг талдаа ажилгүйдэл 6, 7 хувьтай гээд 60, 70 мянган хүн ажилгүй байна гээд нэг тоотой. Нөгөө талдаа болохоор 30-40 мянган ажлын байр байгаад байдаг. Тэр ажлын байр дээр ажиллах хүнгүй

болчихоод байна. Хөдөлмөрийн зах зээл нэг талдаа ажилгүйдэлтэй, нэг талдаа ажиллах хүчний хомсдолтой ийм сорилттой бид нар яг үнэхээр нүүр тулчихаад байгаа юм. Тэгээд өнөөдөр яагаад цагийн хөлсийг 100 мянган төгрөг бодоод зарлаад байхад ирж хүмүүс ажиллахгүй байна вэ гээд бас хүмүүс нэлээн ярьдаг. Ажил олгогч нар. Гэтэл Монголчуудын ер нь цаашидаа бид нар энэ бүтээмжийн асуудлуудыг л шинэ шатанд гаргах ёстой юм байна. Одоо ер нь ерөнхий чиг хандлага харахад бол уул уурхайн салбар гэдэг юм уу, банкны салбар гэдэг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Энх-Амгалан сайдад цаг өгье.

Л.Энх-Амгалан: Тийм бүтээмж өндөртэй салбарууд гэдэг бол бүтээмж өндөртэй буюу цалин өндөртэй салбар гэдэг бол уур уурхай, банк, санхүүгийн салбарууд, мэдээлэл технологийн салбарууд руу илүү их тийм түлхүү залуучууд ажиллах, өндөр цалинтай ажиллах ийм сонирхол бий болж байгаа. Энэ бол ойлгомжтой. Тэгэхээр цаашидаа ер нь Монгол хүний нэг цагт бүтээж байгаа бүтээмж, нэг цагийн хөлс ер нь яг ямар байх ёстой юм бэ гэдэг бол яг л эргээд Ерөнхий сайдын яриад байгаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт бол боловсролынхоо салбартай гажчихсан энэ тогтолцоогоор их олон жил ужгирч явсан учраас энийг засах, залруулах зайлигүй шаардлага байгаа. Тийм учраас Монгол хүнийг цаашидаа хамгийн өндөр бүтээмжтэй ийм цалинтай ажлын байр дээр бий болгох энэ тогтолцоог бол бид нар дэмжиж ажиллаж байж, энэ бүтээмжийн асуудлууд ярих болов уу. Манай Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр ер нь бүтээмжийн хувьсгал гээд нэг жаахан сүртэй нэртэй, зүгээр хувьсгал гээд орчихсон байгаа юм. Гэхдээ ямар ч байсан бүтээмжийг нэмэгдүүлэх санал, санаачилгыг бол бид нар зайлигүй эхлүүлж, яг энэ мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, дээд боловсролын

тогтолцоогоо хөдөлмөрийн зах зээлтэйгээ уялдсан ийм бодлогыг л хийх зайлшгүй ийм цаг үеийн хэрэгцээ шаардлага үүсчээд байна л гэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр бас ер нь бол ахлах сургуулиа төгсөөд, их дээд сургуульд элсэж орж байгаа нь бидний ингээд харсан юугаар бол 90 орчим хувьтай. Бараг 92, 93 хувь руу орчихсон ийм өндөр байж байгаа. Тэгэхээр мэргэжлийн эрхийг ахлах сургуульд нь олгодог ийм төрлийн төрөлжсөн ахлах сургуулиуд байгуулах ийм шаардлага ургаж гарч байгаа. 9 дүгээр ангийн хүүхэд 10 дугаар ангид орохдоо ээж аавтайгаа зөвлөж яриад, их, дээд сургуулийг зорих, ахлах сургуульд орох уу, эсвэл мэргэжлийн эрх олгодог ийм ахлах сургуулиуд руу ороод явах уу гээд. Мэдээж тэнд төгссөн хүүхэд бас их, дээд сургууль руу зорьж орж болно. Гэхдээ нэг ялгаа нь мэргэжлийн эрх олоод авна. Жишээлбэл ИТ инженер ч гэдэг юм уу. Хамгийн эрэлттэй мэргэжлүүдээр ийм байдлаар хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжилтэй ийм боловсон хүчнийг эртхэн нийлүүлдэг, хариуцлагатай ийм карьерын амьдралаа өөрсдөө төлөвлөдөг боломжийг олгох ёстой гэж харж байгаа.

Түүрүүнд яслийн асуудлыг Сайнзориг гишүүн хөндсөн. Тэгэхээр энэ бол хүүхэд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд гүйцээж хариулъя.

П.Наранбаяр: Энэ ясли байгуулах асуудал биш. Харин 1-2 насанд нь цогц хөгжлийг дэмжих хувилбарт үйлчилгээг бий болгохоор ярьж байгаа. Тэгээд энэ нь болохоороо одоо байгаа Хүүхэд харах үйлчилгээгээрээ дамжуулна. Хүүхэд харах үйлчилгээнд бол цөөн цагаар суурь ур чадвар хөгжүүлэх цаг оруулах болон явуулын багш, гэрийн сургалт гэх мэт ийм

олон хувилбарт зүйлүүдийг шингээсэн байгаа шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Батжаргал гишүүн тодруулга авъя.

Ж.Батжаргал: Үгүй ээ, эрүүл мэндийн салбар, хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчний хангалтыг яаж бэлтгэх вэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Боловсролынхыг бол ноднин Боловсролын хуулиар хийчихсэн байхгүй юу. Одоо энэ 2 салбарт ер нь яаж хангалт хийх вэ хэдүүлээ. Энэ загварыг ашиглах юм биш үү гэдэг ийм л санаа байгаад байна л даа. Үүн дээр тодорхой хариу авмаар байна.

2 дугаарт би түрүүн дотоод бүсчлэл хөндсөн нь яагаад хөндсөн юм гэхээр зэрэг дотоод бүсчлэлийн төвүүдийг тодорхойлж чадах юм бол тэнд дулаан, цахилгааны энергийн хангалт, түгээлтийн шугам сүлжээ, зам харгуй, дэд бүтцийг нь хийгээд өгчих юм бол эдийн засгийн идэвхжил аяндаа бий болно. Дээр нь энэ хөндөгдөөд байгаа засаг захиргааны чинь шинэчлэлийн юмнууд хөгжлийнхөө загвараар өөрөө аажимдаа шийдэгдэх юм биш биз дээ гэдэг л санаа байгаад байгаа л даа. Тэгэхээр үүнийг л тодорхой болгож, энэ хөтөлбөр дотор авч оруулж чадвал хэдүүлээ болмоор байна гэж.

Дараагийн нэг зүйл. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадвар гэж нэг юм байгаад байгаа юм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Наранбаяр сайд нэмж хариулъя.

П.Наранбаяр: Тэгэхээр Хөдөө аж ахуйн салбарт үнэхээрийн өнөөдөр Хөдөө аж ахуйн их сургуульд гэхэд 14 мянган оюутан байхад дөрөвхөн мянга элсэж байгаа. Агрономын ангид нь гэхэд ердөө 4 хүүхэд төгсөж байгаа ийм нөхцөл байдал байгаа. Улирлын шинжтэй ажил гэж үзээд тэнд элсэлт орж ирэхгүй. Тэгэхээр давхар мэргэжлийн жишээлбэл биологийн багш нэмэх нь агрономи ч гэдэг юм ийм

байдлаар бас зохион байгуулах боломж байна гэж харж байна. Мөн төрөлжсөн ахлах сургуулиуд руу хөдөө аж ахуйн мэргэжилтэй, эрүүл мэндийн мэргэжилтнүүд ийм хүмүүсийг бэлдэх чиглэл рүү нь явуулах ёстой гэж харж байгаа шүү. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байхгүй ээ. Энх-Амгалан сайд. Гэр бүл, нийгэм, хамгаалал, хөдөлмөрийн сайд.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр бид нар энэ бий болгосон хууль, эрх зүй, тогтолцооноосоо нэг ч алхам ухарч болохгүй шүү Наранбаяр сайд аа. Тэгэхээр энэ тогтолцоог бид нар хийчихсэн юм байгаа юм. Хуулиараа. Тэгэхээр ямар тогтолцоог хийсэн бэ гэхээр Монгол Улсад өмнө нь байгаагүй...

Д.Амарбаясгалан: Асуултад хариулах гэж байна уу.

Л.Энх-Амгалан: Асуултад хариулах гэж байна. Боловсролын тогтолцоог бид нар нөгөө яг үндэсний мэргэжлийн шаталсан бүдүүвчтэйгээ уячихсан байхгүй юу.

Д.Амарбаясгалан: Микрофон хаачихлаа. Засгийн газрын гишүүд гишүүдийн асуултад хариулахаас өөрөөр дэг зөрчихгүй ээ. Эрүүл мэндийн сайд байвал асуултад хариулмаар байна. Батжаргал гишүүний. Хариулт өгөх хүн байна уу. Гантөмөр сайд хөтөлбөр боловсруулсан ажлын хэсгийн гишүүний хувьд хариултыг нэгдсэн байдлаар товч байдлаар өгье.

Л.Гантөмөр: Маш товчхон хэлье. Ер нь бол 6 макро бүс байна гэж байгаа шүү дээ. Нэмэх нь Улаанбаатар хот. Тэгээд дараа нь дунд түвшний бүс. Тэр нь бол сумдаа нэгтгэсэн 21 бүс байна. Таны санаа тавьж байгаа чинь дунд түвшний бүсээ яах юм бэ гэж. Тэгээд микро бүс байна. Тэр нь аймгийн төвүүд дээр нэмэх нь 69 сумаа бол тодорхой заачихсан юм байна лээ шүү дээ. Нөгөө хууль

батлахдаа, та хэд хууль батлахдаа заачихсан. Энэ түвшинд менежментийн уялдаа холбоог хэрхэн хийх вэ гэдгийг одоо бодлогоо гаргая гэж байгаа. Тийм учраас Шадар сайд Амарсайханы удирдлага дор яг энэ уялдаа холбоог хэрхэн хангах вэ гэдэг газрын зураг бол зурагдана. Дээр нь яг бүсүүдийн стратеги бол тодорхой гарна. Та бол нэг өөрийнхөө өнцгөөр харж байна шүү дээ. Бид бол нэг томъёолчихсон.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Гуравхан минутад Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй бүгдийг нь асууна гэхэд бол боломжгүй. Гэхдээ би 2 сэдэв дээр бас хөндөж ярьж гэж бодож байна.

1 дүгээрт, ард иргэдийн дунд хамтарсан Засгийн газраас маш том хүлээлт байгаа гэдгийг би анхдугаар чуулган дээр ч бас хэлж байсан. Тэр үед шинэ хоршоо хөтөлбөрийн цаашидын төлөвийг яаж харж байгаа вэ. Энэ бол ингээд 3 сар буужигнаад өнгөрсөн том төсөл биш байх. Малчид, иргэд бол үүнийг тэр 50, 60-аад оны нэгдэлч хөдөлгөөн, 90-ээд оны эхээр мал хувьд очсон тэр цаг үе, 3 дахь нь бол энэ малчид руу хандсан маш том реформын шинэжтэй арга хэмжээ болж байна гэж бас тухайн үед дүгнэж, хэлж, одоо үр дүнгээ хүлээж байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар над руу олон хүн ярьж байна. Арилжааны банкнууд энэ чинээлэг малчин, шинэ хоршоо хөдөлгөөний хүсэлтүүдийг авахаа больсон байна. Тэгэхээр мөрийн хөтөлбөр дээр бол энэ асуудал туссан байгаа. Төслийн нийт дүн бол 5 их наяд. Тэгэхээр энэ цаашидаа хэрэгжих төсвийн эх үүсвэрүүд бас тодорхой байгаа юу. Миний энэ асуултыг олон хүн бас хариулт нь яаж ирэх бол гэж өнөөдөр хараад сууж байгаа байх. Тэгэхээр бид мөрийн хөтөлбөр дээр туссан энэ чинь шинэ зүйл биш үргэлжлээд явж байгаа энэ процессыг цаашид тасралтгүй явуулах, малчин хүн

нэгдээд очиход эх үүсвэргүй гэдэг ийм учир шалтгааныг арилжааны банк болон бусад банкнууд хэлэхгүй байх баталгаа юу байгаа вэ гэдэг дээр 1 дүгээрт би асууя гэж бодож байна. Өнөөдөрхөн манай Хэнтий аймгаас 4 хоршооны иргэд ирээд манай өрөөнд бүр 10 цагаас хүлээж байгаад, уулзаад явлаа. Тэгэхээр энэ дээр Сангийн сайд их тодорхой хариулт хэлээрэй гэж ингэж бодож байна.

2 дугаарт энэ хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрүүд сая Ерөнхий сайд хэллээ. Үнэхээр Дарханы энэ үйлдвэрийг харж, ер нь олон хүнд худлаа ярилаа. Одоо энэ бүсчилсэн байдлаар арьс ширний үйлдвэр заавал Дарханд байх ёстой ч биш, Эмээлтэд байх ёстой ч биш. Зүүн бүсэд, бусад бүсэд нь энэ дэд бүтцийнх нь асуудлыг шийдээд өгөх тэр бололцоонуудыг бас энэ мөрийн хөтөлбөр дээр би нэлээн сайн тусгаад оруулаад өгөөсэй гэж бас хүсэж байгаа юм. Хаа байгаа Хэнтийгээс, хаа байгаа Дорнод, Сүхбаатараас наашаагаа зөөдөг ч гэж юу байх вэ. Тэгэхээр энэ дээр бол хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэр цааш нь борлуулах боомтын сэргэлтийн асуудлуудыг бол бас маш сайн тусгаж өгөх юм бол мянган км-ээс хонины мах зарах гэж Улаанбаатар луу тээх хэрэггүй л болгочоод малчид бол энийг л хүсээд байгаа юм байна лээ. Өөр юм бол байхгүй.

2 дахь асуудалд бол үндэсний баялгийн сантай холбогдуулаад амьдрах орчны асуудал бас яригдаж байна. Энэ орон сууцжуулна л гэж яриад байгаа юм. Ялангуяа аймгийн төвүүд дээр жишээ нь Дорнодод 7 мянган өрх, гэр хорооллынх, Сүхбаатарт 5 мянган өрх, Хэнтийд 6 мянган өрх гэр хороололд байгаа. Энэ 0.7 гагаа авчихсан энэ айлуудыг инженерийн дэд бүтцэд холбоод, хашаандаа сайхан амьдрах бололцоог нь л бүрдүүлээд өгчихвөл энэ орон сууцжуулах хөтөлбөрөөс хамаагүй хурдан үр дүнтэй, цаашдын үр дүн нь шал өөр дүр зураг гарах болов уу гэж бодож байгаа юм. Яг орон нутагт ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийн хувьд бол тэр хашаандаа,

газартаа эзэн болоод, тэндээ ногоо цагаагаа тариад амар түвшин амьдрах. Тэгэхээр энэ баялгийн сангийн хуулийг орон сууцжуулахаас гадна, хашаандаа нутагтаа сайхан амьдрах бололцоотой энэ төсөл хөтөлбөр лүү бас оруулбал ямар бололцоо байна вэ. Би энэ мөрийн хөтөлбөр дээрээс харахаар дандаа л зүгээр байшин барих, орон сууц барих, пассив хаус гэдэг ийм л зүйлүүд байгаад байгаа байхгүй юу. Одоо 30 сая төгрөгийн дэмжлэг эд нар гэж байгаа. Тэгэхээр бид энэ 6, 7 мянгаар нь тэр айлыг, өрхийг тавтай амьдруулахын тулд энэ баялгийн санг орон сууцжуулах.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд эхлээд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Үндэсний баялгийн сантай уялдаж орон сууцжуулалтын том реформыг хэдүүлээ хамтдаа энэ 4 жилийн хугацаанд хийнэ. Яагаад гэвэл орон сууцын асуудал хямд эх үүсвэр байдаггүй байсан учраас олигтой явж чаддаггүй байсан. 1 дүгээр үндэслэл. 2 дугаарт ер нь орон сууцад орох иргэдийн тоо бол ханачихсан. Яг одоо орон сууцад орох тийм ипотекийн зээлийн боломжийг хангаж чадахгүй байгаа иргэд маань илүү үлдчихсэн байгаа гэж ойлгож болно. Дээрээс нь ирэх жилийг Залуучуудын хөгжлийг дэмжих жил болгож Засгийн газраас зарлахаар бэлдэж байгаа. Энэ дээр бол гол нь бас орон сууцын асуудлыг хөндөнө гэдэг байдалтай явж байгаа. Тийм учраас анх удаа орон сууцад орж байгаа бол давуу байдал олгоё.

2 дугаарт хашаандаа жишээлбэл сайхан амьдрах ийм дэд бүтцийг хийе гэж байгаа бол бас давуу байдал олгож, дэмжье. Улаанбаатар хотоос орон нутгийг чиглэж нүүх шийдвэр гаргаж байгаа гэр бүлийг дэмжье. Хувийн хэвшил ажилчдаа орон сууцжуулах энэхүү хөтөлбөрт хамруулж байгаа бол дэмжье гэдэг энэ агуулгаар ингээд ийм том хэмжээний агуулга Үндэсний баялгийн сантай уялдаад хэрэгжээд явна гэдгийг бас хэлье. Энэ дээр бас эрх зүйн орчин

шаардлагатай. Засгийн газар энэ жилдээ багтаагаад Үндэсний орон сууцжуулалтын багц хуулийг оруулж ирнэ. Энийг бас Батсуурь сайд, эд нар бэлдээд явж байгаа байх гэж бодож байна.

2 дахь зүйл нь Идэрээ гишүүнтэй санал нэг байгаа. Тэр нь юу вэ гэхээр Засгийн газар одоо хөтөлбөр дэмжихгүй байгаа газруудад хөтөлбөр хүчээр хэрэгжүүлэх гэж гуйхгүй ээ. Бүсүүд хоорондоо өрсөлдөнө. Дархан үйлдвэрээ барьж чадахгүй байгаа бол тэгээд болино л биз дээ. Барьж чаддаг байгаа, хүсэлт тавиад байгаа Өвөрхангайд нь бариулчхаж болно. Эсвэл бүс бүхэн өөр өөрсдөө үйлдвэрүүдээ бариад явж болно. 4 жилийн бүрэн эрхээс дээш хугацаа олгож болохгүй. 8 жил үйлдвэр санхүүжилт нь шийдэгдчихээд байхад барьж чадахгүй байгаа газар заавал хүчээр тулгаж хөрөнгө оруулалт хийхгүй ээ. Өөр эрх зүйн орчноо бүрдүүлээд, төслөө дэмжиж байгаа төслүүдийн санхүүжилтийг эхэнд нь тавиад явна. Тэгээд өрсөлдөөн гэдэг бол өөрөө хөгжлийн суурь үндэс юм. Тийм учраас сая бас бүсийн Их Хурлын гишүүдтэй уулзахад зарим бүс ТЭЗҮ-ээ бүрдүүлчихсэн. Төслүүдээ 1-10 руу эрэмбэлчихсэн орж ирж л байна лээ. Зарим бүсүүд орж ирээд хоорондоо хэрэлдээд, тэгээд бараг нэлээн тийм хүндрэлтэй байдалтай байгаа юм харагдаж л байна лээ. Тийм учраас хоорондоо хэрэлдээд байгаа бүс дээр Засгийн газар очиж тэгж цагаа үрээд байх шаардлага бас алга. Хамгийн эв нэгдэлтэй байгаа тэр бүс рүү нь л бид нар хөрөнгө оруулалтаа хийгээд л явахгүй бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Шинэ хоршоо, чинээлэг малчин хөтөлбөр цаашаа үргэлжилнэ. Одоо оруулж ирж байгаа, өнөөдрийн хэлэлцэж байгаа энэ хөтөлбөр

дотор маш тодорхой орчихсон байгаа. 3.1 шиг санаж байна.

Мөн Засгийн газрын хөтөлбөр, гэрээний дагуу үндэслэж орж ирж байгаа төсвийн тодотгол дотор ч гэсэндээ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц дотор 123 тэрбум төгрөг гээд орчихсон байгаа. Ингээд хөтөлбөр батлагдмагц тун удахгүй өргөн барих 2025 оны төсөв дээр мөн үргэлжлээд ингээд явна. Тийм учраас банкнууд энэ дээр их итгэлтэй цаашаагаа үргэлжлүүлэх бэлтгэл ажлаа хангаж байх хэрэгтэй. Тэгэхдээ ер нь яг хавар бол энэ маш ачаалалтай байсан шүү дээ. Үнэхээр тулгамдчихсан цас зудын дараа бол маш хүнд байсан. Тэр үед бол банкнууд энэ дээр маш сайн хамтарч ажиллаж байна. Нөхцөл байдлыг их сайн ойлгож, их үр дүнтэй ажлууд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Идэрбат гишүүн тодруулга.

Ц.Идэрбат: Тийм Засгийн газраас энэ орон сууцжуулах асуудал дээр бол бас дэмжилгүй яах вэ. Дэмжиж байгаа. Олон хүн орон сууцад орж ажиллаж амьдрах орчноо сайжруулах ийм чин хүсэлтэй байгаа. Тэгэхдээ манайд бас нэг ийм онцлог байгаад байдаг нь гэр хороолол гэж яриад байдаг, сүүлдээ ч Жи хороолол ч гэх шиг тийм нэртэй болчихсон л байна. Энэ гэр хороолол руу инженерийн шугам сүлжээгээ татаад ингээд явах юм бол илүү олон айл нэгэн зэрэг орон сууцад амьдарч байгаа юм шиг ийм сайхан тохилог амьдрах ийм бололцоо бас гарна л гэж ингэж хэлж байгаа юм.

Жавхлан сайдын тодруулаас бас нэлээдгүй зүйл бас тодорхой болж байх шиг байна. Одоо арилжааны банкнууд дээр эх үүсвэргүй гээд гацчихсан байгаа тэр хоршооны талаарх хүсэлтүүд энэ төсвийн тодотгол 2, 3 хоногт хэлэлцэгдээд гарсны дараа бас үргэлжлээд явах юм байна. Он гараад дахиад энэ шинэ хоршоо, чинээлэг малчин

маань бас үргэлжлээд явах санхүүгийн эх үүсвэрүүд нь Монгол Улсын нэгдсэн төсөв дээр тусгаад явах нь гэж ингэж бас ойлголоо гэдгээ бас товчхон хэлчихье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

С.Ганбаатар: Олон реформууд хийгдэх юм байна. Энэ дээр миний эхний асуулт бол бид чинь одоо гарчиг баталж давхисаар байгаад л 30 жил болчихлоо. Энэ оруулж ирж байгаа аж үйлдвэрлэлийн томоохон бүтээн байгуулалтуудын төсөл хөтөлбөрүүдийн тал нь ТЭҮЗ-гүй гэж би мэдээлэл авсан. Тал нь ТЭЗҮ байхгүй. Ер нь Оюутолгой гэдэг юмыг чинь бид фантаздаа хөтлөгдөөд л ТЭЗҮ-г нь тоохгүй баталсан. Тэгээд тэрний горьг бид 10 хэдэн жил амсаж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ ТЭЗҮ-гүй 46 хувь нь гэж байгаа юм шүү. ТЭЗҮ байхгүй төсөл хөтөлбөрүүдийн ТЭЗҮ хэзээ орж ирэх вэ. ТЭЗҮ буюу инженер техникийн мэргэжилтнүүдийн дүгнэлт гарсны дараа дахиж ярилцах боломж байгаа юу. 1 дүгээр асуулт.

Жишээ нь, зэс хайлах үйлдвэрийг би туйлын дэмждэг. Яг ТЭЗҮ дээр нь асуулт хийхэд зэс хайлах үйлдвэрийг гацаасан юм шиг яриад байдаг. Эдийн засгийн ямар ч үр ашиггүй. 720 хэдэн сая доллар жил болгон 34 сая долларын алдагдалтай гарахаар ТЭЗҮ орж ирдэг. Энд бол би жишээ авч ярьж байгаа юм шүү. Зэс хайлах үйлдвэр хэрэгтэй. Хүхрийн хүчлийг нь яах юм. Тэр агаарт цацагдаж байгаа тэр хүхрүүдийг яах вэ гэдэг шийдэл буюу патент авах ёстой. Туршилт байхгүй.

2 дугаарт миний асуулт. Сая бол жишээ авсан асуулт. Зүгээр ТЭЗҮ яах вэ. 2 дугаар асуулт. Нүүрсгүй л болчихъё. Нүүрс ер нь хэрэггүй шүү л гээд байна. Үгүй ээ, үгүй. Дэлхий тэр чигээрээ бас нүүрснээс хараат хэвээрээ л байгаа. Хүнд үйлдвэрүүд бас дахиад 10, 20 жил байгаа. Энэ томоохон төсөл хөтөлбөрүүд яагаад

30 жил бид гацаанд ороод залгиж чадахгүй ингээд гацчихав гэвэл, туршилтын үйлдвэрүүд ерөөсөө бид барьдаггүй. Туршилт технологийн үйлдвэрлэлийн асуудлууд энэ дээр алга байна. Тэр дундаа нүүрс химийн туршилт үйлдвэрлэлийг заавал хийж байж дараа нь томыгоо хийдэг. Тэр нь бол ашигтай байж болно. Тэгэхдээ алдагдалгүй байдаг. Энэ асуудлыг би энэ дээр оруулах сонирхолтой байна. Энэ яаж орох вэ. Тэр Авид гээд химийн холбооны хүмүүс бол бас бичгээ өгсөн гэж надад ойлгуулсан шүү.

3 дугаар асуулт Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын хувьд өнгөрсөн 4 жил хэрэгжүүлэхэд хичээгээд, оролдоод бас тодорхой үр дүнд хүрсэн байх. Том том төсөл, хөтөлбөрүүдийг Засгийн газар ингээд зүтгээд л байдаг. Тэгэхдээ иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод тухайн тэр салбарын оролцогчдыг оролцуулна гэдэг бол нөгөө социал демократ гэдэг үзлийн чинь амин судас нь юм байгаа юм шүү дээ. Үүний дагуу 17 заалт орсон байна. Энэ дээр яамнууд нь, сайд нар нь өөрийгөө сайд болоод л үүнээс хойш би бүхнийг чадагч гээд л ханцуй шамлаад л дайраад байхгүйгээр, тэр тухайн салбарын оролцогч нараа яаж оролцуулах вэ гэдэг асуудал дээр 17 заалт орчихсон байгаа гэдгийг энэ дээр би магнай хагартлаа баярлан тэмдэглэж хэлээд, салбарын тэр мэргэжлийн холбоод оролцогч нараа мэдээллээр яаж хангах вэ. Энэ дээр бүтээмжийн заалт орчихсон байна лээ. Төрийн албан хаагчийн бүтээмж гээд 4.2.3.1 дээр бүтээмжээ нэмэгдүүлэхэд өөрийнхөө бүтээмж биш тэр салбарын оролцогчдын бүтээмжийг нэмэгдүүлэх тал дээр яаж ойлгож байгаа вэ. Миний одоо 3 дахь асуулт бүтээмжийг тодорхойлдог ямар аргачлал томъёолол яг байгаа вэ. 4.2.3.1 дээр холбогдуулж би асууж байгаа юм шүү.

Дахин инженерчлэл гэдэг зүйл нэлээн олон ярьсан байна. Дахин инженерчлэлийн асуудал дээр 4.2.2.1 гээд.

Энийгээ яг юу гэж ойлгож байгаа вэ. Энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр нэлээн хэрэгжсэн. Бас үр дүн гарсанууд байгаа. Бусад яамдууд энийгээ юу гэж ойлгож байгаа вэ гэсэн ийм 4 асуултыг би асууя. Хариултаа тодорхой авна гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд эхэлж хариулаад, сайд нар нэмэлт хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Үнэн. Бид нарт олон жил гацсан төслүүдээ яаж бид нар хурдтай урагшлуулах вэ гэдэг их чухал. Тэгэхийн тулд бид нар зураг төсөв, ТЭЗҮ, байгаль орчинд гарах нөлөө нөлөөлөл, мөн ямар процедураар, ямар санхүүгийн эх үүсвэрээр хийх вэ гэдэг замын зураглалаа зөв тодорхойлох нь хамгийн чухал. Тийм ч учраас энэ удаагийн төсвийн тодотгол дээр та бүхэн хэрвээ ажиглаж байгаа бол ерөөсөө л 2 зүйлийн ийм тодотгол болж байгаа гэж ойлгож болно.

1 дүгээрт энэ тодотгол бол ТЭЗҮ-ийг хэрэгжих томоохон төслүүд дээр тавьж байгаа л ийм тодотгол. Улаанбаатар хот дээр хийгдэж байгаа төслүүд, мөн өмнө нь байгаа станцын төслүүд гээд зарим нь хуучирчихсан ТЭЗҮ байгаа. Зарим нь бас арай жоохон хооронд нь нийцүүлэх ийм зураг төсвүүд байгаа. Тийм учраас зураг төсвийн санхүүжилт дээр нэлээн их тийм том хэмжээний санхүүжилт тавьж байгаа анхны ийм тодотгол болж байгаа. Тэгэхээрээ бид нар энэ жилдээ л багтааж зураг төсвүүдээ шинэчилж авахгүй бол санхүүжилтээ бид нар бол босгож чадахгүй.

2 дахь зүйл нь бид нар мэргэжлийн ийм зөвлөхүүдийг авахаас өөр гарцгүй болж байгаа юм. Жишээлбэл Монгол Улс бол хот байгуулж үзээгүй. Энийгээ бид нар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тийм учраас Нийслэл Улаанбаатар хотыг ч юм уу, цаашидаа энэ 2040-ийг эд нар

төлөвлөхдөө бид нар өөрсдөө заавал ийм байх ёстой гэж төлөвлөөд чадахгүйгээ хүлээн зөвшөөрөх ёстой. Тийм учраас чадахгүйгээ хүлээн зөвшөөрч бид нар зарим нэг зүйл дээр биднээс урд явж байгаа ийм зөвлөх үйлчилгээнүүдийг авах тал дээр энэ тодотгол бас 2 дугаарт нь нэлээн анхаарал татсан ийм дүнгүүдийг бас тавьж байгаа юм.

Нүүрс бол 10 жилийн дотор ашиглагдана. Тэр дундаа кокс нүүрс бол настай. Эрчим хүчний нүүрс бол хүндрэлтэй гэдэг талаар би үгэндээ дурдсан. 3 талт хэлэлцээр дээр Ганбаатар гишүүний саналыг би үнэхээр дэмждэг. Тэгээд бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт ч гэсэн үүний дагуу орж, өнөөдөр ХАҮТ-ын Ерөнхийлөгч, үйлдвэрчний эвлэлийн ерөнхийлөгч хоёр хоёулаа бас парламентад орж ирсэн нь Засгийн газар ажил олгогч мөн ажилчин хамтдаа бас энэ олон шийдлүүд дээр хурдтай гарц гаргалгааг гаргаж чадах энэхүү чадамж нь өөрөө энэхүү хурдтай хөгжлийн төлөөх бас зоригтой шийдлүүдийн нэг ийм том гарц байх болов уу гэж бодож байна. Тэгээд Скандинавын улс орон бүгдээрээ л хамтдаа оролцогч талуудынхаа оролцоог маш сайн хангаж, мэдээллээ солилцож чадсаны үр дүнд төслүүдээ гацаахгүйгээр их хурдтай явдаг. Тэгээд аж үйлдвэрийн олон төслүүдийг бас зориуд ингэж оруулж ирээд, зураг төсөвтэй, зураг төсөвгүй гэж ангилж байгаа нь ч гэсэн энэ бол ил тод эхнээсээ зөв дараалалтай явъя гэсэн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд. ТЭЗҮ, зэс баяжуулах үйлдвэрийн төсөл, нүүрс гэсэн асуудлуудаар асуултад хариулъя аа.

Ц.Туваан: Асуултад хариулъя. Энэ удаагийн Засгийн газар дээр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамыг Аж үйлдвэр эрдэс баялгийн яам болгож оруулж ирсэн. Энэ утга нь бол нэмүү өртөг шингээж ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийг хөгжүүлэх гэсэн агуулгаар Аж үйлдвэрийн яамаа аж

үйлдвэрийн гэж ингэж нэрлэж оруулж ирж байгаа. Мөн энэ стратегийн ордуудыг түшиглэсэн үйлдвэрлэлийн салбараа хөгжүүлэхдээ бид нар өнгөрсөн хугацаанд өнгөрсөн парламентын үед баталсан үйлдвэр технологийн паркийн хууль гэж байгаа. Энэ хуулийн хүрээндээ үйлдвэр технологийн парк буюу цогц байдлаар энэ асуудлаа шийдье. Ганцхан үйлдвэр бариад орхих биш, бэлэн бүтээгдэхүүн бий болгоод тухайлах юм бол зэс баяжуулах үйлдвэр дээр зэсийн баяжмалаа катодын зэс болгож үйлдвэрлэж гаргаж ирээд, тэндээсээ цаашаа хувийн хэвслүүдтэйгээ хамтарч бүтээгдэхүүн үйлдвэрлэх энэ үйлдвэрүүдийг хөгжүүлье. Кластер байдлаар хөгжүүлье гэсэн байдлаар асуудалд хандаж байгаа. Яг энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу Туваан сайд. Туваан сайдад нэмж 1 минут өгье.

Ц.Туваан: Үүнтэй холбоотой жишээлэх юм бол, 6 газар, 6 байришл дээр үйлдвэр технологийн паркийг Засгийн газраас лицензийг нь олгоод, энэ стратегийн ордуудаа түшиглэж байгуулах энэ үйлдвэр технологийн парк тухайлах юм бол Эрдэнэт үйлдвэр дээр байх магадлалтай зэс хайлуулах үйлдвэр, Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэж байгуулах гангийн үйлдвэр, тэгээд цаашилаад Хөтөл, Бор-Өндөр, Багануур, Эрдэнэс Тавантолгой гэх мэт ийм үйлдвэр технологийн парк байдлаар асуудлуудаа шийдээд явна гэсэн ийм зорилттой байгаа. Энэ ч талаараа энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртөө тодорхой тусгасан байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Жавхлан асуултад хариулья.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүнтэй 100 хувь санал нийлж байна. Үдээс хойш тодотгол ярьж таарах юм шиг байна. Тэгэхээр тэр үед бас та энэ тоог бас дахиж нэмж сонсох байх гэж бодож

байна. Одоо энэ томоохон төслүүд маань бидний хувьд бол бүгд шинэ болж байгаа. Тэр том гүүр, туннел, хурдны зам, цахилгаан станцууд, ялангуяа усан цахилгаан станцууд гээд энэ бүгд дээр бид ТЭЗҮ, зураг төсөв, тэгээд зөвлөх үйлчилгээ гээд бэлтгэл ажлыг хангах ажлуудаа энэ жилдээ багтааж хийж дуусгах хэрэгтэй байгаа. 2024 ондоо. Одоо хэдхэн сар үлдлээ шүү дээ. Ядаж цаад талын хугацаа 2025 оны 1 дүгээр улиралд. Ингээд 3, 4 сараас барилгын ажил эхэлмэгц энэ томоохон төслүүд яг шууд гүйцэтгэл нь эхлэхгүй бол бид нар ирэх 4 жилд ямар ч төсөв, төсөл энэ том бүтээн байгуулалтуудыг хийж амжихгүй. Тийм учраас энэ дээр том бүтээн байгуулалтуудын төлөө “Хурдтай хөгжлийн төлөө зориг” хөтөлбөрийн хүрээний дагуу 400.../минут дуусав//

Д.Амарбаясгалан: Өөр нэмэлт асуултад хариулах сайд нар чинь Ганбаатар гишүүн тодруулга авъя. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулга авъя.

С.Ганбаатар: Тодотгол дээр бас дэлгэрүүлж ярих юм байна. Ямар ч байсан ТЭЗҮ байхгүй. Тэгэхдээ тодотгол дээр ТЭЗҮ хийх хэдэн төгрөг тусгана л гэж би ойлголоо. Тэгэхээр чинь сургуулийн барилга бид тойрогтоо оруулья гэхэд чинь ямар ч зураг төсөв, ТЭЗҮ байхгүй бол энэ чинь хууль зөрчсөн асуудал болдог л доо. Тэгэхээр бид чинь 50 хувь нь мөрөөдлийн жагсаалт батлах болчихоод байгаа гэдгээ бол ойлгох ёстой. Мөрөөдлийн жагсаалт баталж байна. 2028 он хүртэл бид юу хийх вэ гэдгээ бичиж байгаа юм шүү дээ.

2 дугаарт ТЭЗҮ-ээ тойрч улс төрчид ярихгүй бол бие даасан хөндлөнгийн эрдэмтэн, шинжээч, судлаачдын дүгнэлтээ тойрч улс төрчид ярьдаггүй бол шунахай бүлэглэлүүдийн ашиг сонирхлын огтлолцол дээр бүх 30 жил бидний бүх төслүүд гацсан. Энэ

гацаанаас гаргая л гэж би хэлж байгаа юм шүү. Гаргалгаа нь.

2 дугаарт нүүрс химийн үйлдвэрлэлийн тэр туршилтын үйлдвэр гэдэг энэ асуудлыг энэ мөрийн хөтөлбөртөө оруулж өгөөч ээ. Говь комбинатыг барихдаа ч гэсэндээ туршилтын контейнерын үйлдвэрлэл анх орж ирж байсан юм шүү.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Өнөөдөр хэлэлцэх эсэх асуудал шийдэгдэнэ. Эргээд Байнгын хороонд шилжээд ажлын хэсэг байгуулагдана. Гишүүдээс гарах саналыг, зарчмын зөрүүтэй саналуудыг авч ажлын хэсэг дээрээ сайн ярилцана гэж ингэж харж байгаа. Учрал сайд Сайнхүүгийн Ганбаатар гишүүний асуултад нэмж хариулт өгье.

Н.Учрал: Тэр төрийн бүтээмжтэй холбоотой 3 тэр намын мөрийн хөтөлбөрт бол аль аль дээр нь л байсан. Тийм учраас тэр бүтээмжийн хувьсгал гэдэг нэрийг нь аваад энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулсан. Тэгэхээр бүтээмж гэдэг бол ер нь цэвэр ямар нөөцөөр ямар үр дүн гаргах вэ гэдгийг хэмжэдэг л ийм үзүүлэлт. Тийм учраас бид нар үнэлгээг буюу юу хүсээд байгаагаа тодорхойлж чадахгүй учраас эргээд үнэлгээний механизм нь тодорхойгүй байсныг дизайн хийгээд, мониторинг хийгээд хэрхэн үнэлэх вэ гэдэгтэй нь бүтээмжийг уялдуулах хүрээнд төрийн албан хаагчдыгаа ер нь бол ямар цаг ямар санхүү гаргаад, ямар үр дүнд хүрч байгаа гэдэг яг ийм орчин үеийн жишигийнх нь дагуу үнэлж байж, цаашидаа олон улсын энэ индексийн үзүүлэлт дээр ч гэсэн бид нар урагшаа ахина. Тийм учраас бол нэгдсэн зураг авалтуудыг хийнэ. Албан тушаалын тодорхойлолтуудыг бас эргээж харна. Тэгээд шаардлагатай хууль, эрх зүйн орчныг шинэчилнэ гэдгийг энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт бас тусгасан байгаа юм.

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн хугацаанд ер нь бол ард түмний төлсөн төсвийг л хөрөнгө оруулалт нэрээр л нэг өм цөм иддэг, аль эсвэл төсөв рүү орж ирэх гэж байгаа тэр орлогыг замаас нь хулгайлдаг л ийм л зүйл байдаг. Тэгээд энэ бизнесээ томруулах талаараа нэг их тийм ажил хийдэггүй, ийм л байлаа л даа. Тэгэхээр энэ 14 том төсөл, 240 нь дагасан төслүүдийг оруулж ирж, эдийн засгаа томруулах ийм ажлыг л хийхийг зорьж байна. Тэгэхээр энэ дээр бол би хамгийн багадаа 10-аад тэрбум доллар бол оруулж ирээд хийх ийм боломжтой, тэр дээр ялангуяа хөрөнгө оруулагч нарын итгэлийг олох тэр ажлаа хийгээсэй л гэж бодож байна. Тийм учраас эхний ээлжид энэ Засгийн газар юу хийх ёстой вэ гэхээр эхний 4, 5 том тэр 14 төсөл арга хэмжээний 4, 5-ыг нь л зөв хийчих. Зөв шалгаруулчих. Ингэх юм бол гадаадын хөрөнгө оруулагч нарт ямар итгэл төрөх вэ гэхээр Үндсэн хуулийн өөрчлөлтөөрөө энэ засаглалаа зөв байгуулчихсан юм байна. Хамтраад ажиллаад явах юм байна. Том намууд нь. Тэгээд харилцан хяналттай байх юм байна гэдэг ийм л итгэл үнэмшил төрөх учраас дараа дараагийн тэр төсөл хөтөлбөрүүд дээр ямарваа нэгэн асуудалгүйгээр одоо хөрөнгө оруулалтууд орж ирээд явах боломжтой л гэж би харж байгаа. Тэгээд энэ том төсөл хөтөлбөрүүд дээр бол жишээ нь тэр Улаанбадрахын Ораногийн төсөл энэ тэр дээр бол би 2 гараа өргөөд дэмжээд явахад бэлэн байгаа гэдгийг хэлье.

2 дахь асуудал нь төмөр замын асуудал байна. Нарийн царигаар төмөр замд тавих тухай асуудлыг тогтоолын төслийг өргөн барьсан. Гэвч харамсалтай нь хэлэлцэхгүй байгаа. Оросын Холбооны улс өнөөдөр Манжуураар нарийн царигийн төмөр замыг 2022 онд өргөн тавиад, одоо өдөр, шөнөгүй түүгээрээ нүүрс зөөж байгаа. Тийм учраас манайх энэ төмөр замынхаа асуудлыг нарийн шийдэх тэр ажлыг хийх ёстой. Тэгэхээр энэ Ханги мандлын төмөр замын асуудал байна л даа. Энэ Ханги мандлын төмөр

зам чинь хувийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн. Зам, тээврийн сайдынх. Зам, тээврийн сайд нь ингээд сонирхлын зөрчилтэй, хувийн замтай байж болохгүй байгаад байна л даа. Тэгэхээр ер нь бол Хятадын төмөр зам чинь бүгдээрээ төрийн өмчийнх байхгүй юу даа. Төрийн өмчийнх. Тэгэхээр энэ хувийн төмөр замыг төрийн өмчтэй холбох тухай асуудал ярихаар нөгөө Хятадууд чинь хойшоо суугаад эхэлнэ. Ханги мандлын төмөр зам чинь холбогдохгүй. Тийм учраас энэ Ханги мандлынхаа төмөр замыг, тэрүүгээр бид нар бас экспортоо гаргаж энэ эдийн засгаа дэмжих хэрэгтэй байна. Тэр дээр тэр Ханги мандлынхаа төмөр замыг төрд өг. Одоо тохирч авдаг юм уу, яадаг юм энэ асуудлаа шийдэх хэрэгтэй. Тэгж байж цаашаа явна гэдгийг хэлмээр байна.

Дараагийн асуудал нь боомтын шинэчлэлийн асуудал байна. Хөшигийн хөндий хувийн менежментийн компанийн менежментээр явж байгаа. Одоо Буянт-Ухаагаас нүүснээс хойш хэд 10 дахин нислэг нэмэгдэж байгаа. Энэ бол хувийн хэвшил тэнд үйл ажиллагаа явуулсантай бас холбоотой. Тийм учраас энэ хуурай замын боомтоор хиллэж байгаа тэр боомтын хөрөнгө оруулалтыг хувийн хэвшилд менежментээр нь өгөх, дээрээс нь тэр боомтын барилга байгууламжийг тэр хувийн хэвшилээр нь бариулах, төрд бас дарамт учруулахгүй байх тэр талаар ямар ажлыг хийж байгаа юм бэ гэдгийг бас хариулж өгөөрэй.

5 дугаарт нь газрын хоолойн асуудал чинь энэ 2050 гээд урт хугацааны хөтөлбөр дээр чинь тусгагдчихсан байсан шүү дээ. Газрын хоолойн асуудал. Гэтэл энэ 2024-2028 оны Засгийн газрын хөтөлбөр дээр чинь тавигдахгүй орхигдчих юм уу. Ийм ийм асуудлууд байна.

Тэгээд нэмж асууна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Боомтын сайдаас эхэлж хариулах уу. Тулга сайд. Боомтын өргөтгөл шинэчлэл,

төмөр замын холболт, Зам, тээврийн сайд бас энэ төмөр замын холболтын асуудал дээр хариултаа бэлдэж байгаарай. Тулга сайд хариулт өгье.

Б.Тулга: Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг эрье. Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр боомтын менежмент, хөрөнгө оруулалт дээр бас хувийн хэвшлийг оруулж ажиллуулах тал дээр бас санал гаргаж байна гэж ойлголоо. Тэгэхээр энэ санал дээр бас манай Боомтын үндэсний хорооноос боловсруулсан стратегид туссан байгаа. Яг энэ агуулгаар. Өөрөөр хэлбэл Монгол Улсад нэгэнт хэрэгжээд эхэлсэн байгаа сайн туршилага гэж үзэж болох Чингис хаан шинэ нисэх буудлын үйл ажиллагааг Японы компани менежментийг нь хийгээд аваад явж байгаа. Тэгэхээр энэ зарчмаар бас зарим боомтууд дээр туршилтын шугамаар хувийн хэвшилтэй хамтраад боомтын менежментийг төрийн хяналтын үйл ажиллагааг нь алдагдуулахгүйгээр авч явах ийм зорилтыг тавьж байгаа. Тэгэхээр энэ боомтын шинэчлэл, энэ чиглэл дээр бол хувийн хэвшилтэй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүрэн ажиллахад бэлэн байгаа. Өнөөдрийн байдлаар яг энэ боомтын сэргэлтийн Үндэсний хороо ажиллаж эхлээд гадаад, дотоодын зээл тусламжаар 7-8 боомтыг бас цогцолборыг нь шинэчилж бариад ашиглалтад оруулж байна. Яг одоогийн байдлаар Гашуунсухайт боомтын цогцолборын ажил бол бүрэн ашиглалтад ороод, 9 сард хүлээж авахаар бид нар ажиллаж байна. Үйл ажиллагаа явагдаагүй байгаа боомтууд, эд нарыг бас шинэ хувийн хэвшлийн менежментийн хамтарч бас туршиж ажиллуулах ийм туршилтуудыг бас хийх болно гэдгийг танд хэлье.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Пүрэвдорж гишүүний асууж байгаа асуултад хариулъя. Ер нь бол таны өмнө нь Их

Хурлын бүрэн эрхийн хугацаанд нарийн царигийн төмөр зам оруулж ирэх асуудлыг шийдэх хэрэгтэй гэдэг дээр би бас санал нэгтэй байгаа. Салбар хариуцаж байгаа сайдын хувьд бол 2 хөршийн царигийг 2 талаас нь оруулж ирж байж манай улс бол 1 дүгээрт энэ холболт дээр ямар нэгэн асуудалгүй болно гэж. Энэ бол бид нар нэгэнт одоо 2 том хөрш маань хоорондоо нарийн царигаар холбогдоод эхэлчихсэн юм чинь бид энийг бол бас аль ч талаасаа бодсон энийг зайлшигүй шийдэх ёстой. Тэгэхээр 10 дугаар сарын ээлжит чуулганаар таны энэ төслийг бас Их Хурал авч хэлэлцэх болов уу гэж бодож байна. Энэ бол Их Хурлын бүрэн эрхийн асуудал.

2 дугаарт Ханги мандлын төмөр замын хувьд бол концессын гэрээгээр баригдсан. Шаардлагатай.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Дараа нь Цэвэгдоржийн Туваан сайд Францын Орано групптэй хийх төслийн талаар хариулт өгөх нь ээ.

Б.Дэлгэрсайхан: Энэ бол Монгол Улсын зам. Тэгэхээр шаардлагатай гэвэл төр нь авахад бол эргэлзээд байх юм байхгүй ээ. Энд бол тэр барьсан өртөг мөнгө нь тодорхой байгаа. Тэгэхлээр өөрийн чинь хэлж байгаагаар цаад талынх нь холболтын талд Хятад талдаа бол ирж байгаа бүх зам нь төрийн өмч хийх бөгөөд төрийн өмч төрийн мэдэлд буюу төрийн өмч давамгайлсан компанийн эзэмшилд байдаг замууд байгаа учраас энэ бол улсаа бодсон ч гэсэн энийг өгөөд бол холбох нь зөв байх гэдэг дээр бол эргэлзээд байх юм алга. Надад бол эрх ашгийн ямар нэгэн амбиц, зөрчил байхгүй гэдгийг энэ таширамд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд. Францын Орано групптэй хийж байгаа төслийн талаар.

Ц.Туваан: Гишүүний асуултад хариулъя. Францын Орано корпорацитай хэлцэл 2 бүрэн эрхт дамжаад, 2 Засгийн газар дамжаад яригдаж байгаа. Саяхан ажлын хэсгийг нь шинэчлэн байгуулаад манай Учрал сайд бас ажлын хэсгийг нь ахлаад, би дэдээр нь ингээд ажиллаж байгаа. Мөн саяхан 2 улсын Ерөнхийлөгчийн уулзах хүрээнд бас энэ асуудал яригдсан. Тэгэхээр Засгийн газрын энэ удаагийн мөрийн хөтөлбөр дээр мөн тавигдсан Зөөгч овоо ордын талаар. Тэгээд энэ асуудлыг ойрын хугацаанд буюу 10 сардаа багтааж, хөрөнгө оруулалтын гэрээг хийж үйл ажиллагаанд оруулах байдлаар Засгийн газар дээр харж байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн тодруулга авъя.

Б.Пүрэвдорж: Тэр нэг газрын хоолойг Ерөнхий сайдаас асууя.

Д.Амарбаясгалан: Тэр газрын хоолой төслийн нөгөө ажлын хэсгийн дарга хариулчих юм уу Ерөнхий сайд. Ерөнхий сайдад тэгвэл хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Яах вэ, энэ дээр нөгөө яг голлож хөдөлгөх ёстой төслүүд л гээд оруулчихсан. Мэдээж нийтдээ 30 гаруй төсөл бүгдийг нь бичээд байлтай нь биш гээд Газын хоолойн төсөл бол явна. Хөтөлбөртөө орчихсон явж байгаа гэж ойлгож болно. Газын хоолойтой асуудал дээр гол маргаан нөгөө Монгол Улсын хувьд биш БНХАУ, ОХУ-ын Газфром болон Си Эн Пи Си гээд 2 группийн дундах үнийн хэлэлцээрийн асуудал байгаа. Тэгээд энэ үнийн хэлэлцээр хийгдсэний ард Монгол Улс байр сууриа илэрхийлэх ёстой болчихож байгаа учраас биднээс үл шалтгаалах ийм нөхцөл байдал байна гэдэг дээрээс энэ 14 төсөл дундаас хасчихсан юм.

Д.Амарбаясгалан: Пүрэвдорж гишүүн тодруулга асуулт авъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ Газын хоолой ямар ч байсан тэр жагсаалт 240 ч байна уу тэгээд заавал оруулаарай. Бид нар бас том зорилттой байх ёстой шүү гэдгийг хэлмээр байна. Тэгэхээр энэ Засгийн газар мэдээж том том төслүүдийг хөдөлгөнө. Үүний төлөө явах ёстой. Тэгэхээр энэ дээр бол мэдээж шинэ парламент, хамтарсан засаг бол илүү хариуцлагатай ажиллах ёстой гэж би харж байгаа. Маши их хүлээлт гадна, дотнын хөрөнгө оруулагч нараас бас байна. Дотоодын бизнесүүд ч гэсэн бас нэлээн байж байгаа. Тэгэхээр хамгийн гол нь энэ хөтөлбөрүүддээ хамгийн эхний 4, 5 хөтөлбөрийг л зөв шалгаруулаад, зөв явуулчихвал л асуудал байхгүй шүү л гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь 2 намын дарга, дээр Их Хурлын дарга байж байна. Зөвхөн засаг дээрээ хамтрах тухай биш, ерөөсөө энэ парламентын хяналт, парламентын харьяанд байдаг байгууллагууд дээрээ бас хамтарч ажиллаж энэ Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих тэр ажлууд дээрээ бас тодорхой хамтарч.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултаа асууя.

Х.Тэмүүжин: Хугацаагаа эхнээс нь авчих уу.

Д.Амарбаясгалан: 13 секунд нэмж өгөөрэй.

Х.Тэмүүжин: Надад 3 асуулт байгаа юм. Түрүүн Энхбаяр гишүүний асуулт дээр цуг гарсан тэр асуултыг асуух гээд байсан. Тэгээд манай хууль зүй, дотоод хэргийн яамнаас бичилтийн алдаа хийгээд буруу ойлгогдохоор юм ороод ирсэн юм шиг байна. Тэгээд хэлэлцүүлгийн явцад зөв ойлгогдоод, зөв томъёолоод авчих биз. Энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дотор нэг том зорилт Засгийн газар, яам, агентлагуудыг Улаанбаатар хотоос гаргаад, Богд уулын

урагшаа арай том талбай дээр хотыг шилжүүлэх төсөл ярьж байх шиг байна лээ. Тэгээд энэ хүрээнд хэрвээ Улаанбаатар хотод Засгийн газрын зарим нэг байр сав суллагдаж байгаа бол ийм хөтөлбөр хэрэгжүүлэх боломж байна уу, үгүй юу гэдгийг би асуух гэж байгаа юм. Германд тухайлбал Хууль зүйн яамны харьяанд Иргэний нийгмийг дэмжих инкубатор гэдэг нэг тийм хөтөлбөр байгаад байгаа юм. Ардчиллын боловсролыг дэмжих, иргэдийг чадавхжуулах гэх мэтчилэн иргэний нийгмийн хүний эрхийн чиглэлээр суурь чадавхжуулалттай холбоотой чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудыг чадавхжуулахын тулд 4-5 жил байраар хангаж, үйл ажиллагааг нь дэмждэг инкубатор төв байгаад байгаа байхгүй юу. Иргэний нийгмийг дэмжих гээд. Монгол Улс бол иргэд нь илүү хүчирхэг, боловсролтой чадавхтай байвал илүү хүчирхэг чадавхтай л улс орон болж хөгжинө шүү дээ. Тийм учраас бизнесийг дэмждэгтэй адилхан иргэний нийгмийг дэмждэг инкубатор төвийг байгуулах боломж байна уу. Энэ чиглэлээр явж ажиллаач гэж хүсэлт байгаа юм.

Мөн Улаанбаатар хотод энд тэнд хуучин социализмын үеийн үйлдвэрийн барилга байгууламжууд байгаад байдаг. Ашиглагддаггүй тийм байр савууд байдаг. Энэ хүрээнд бас урлаг соёлыг дэмжих инкубатор төв ажиллуулах боломж байна уу. Бээжингийн урлагийн тийм төвүүдийг бид нар бүгдээрээ л очиж үзэж байсан. Пост коммунист улс орнууд дээр яг энэ чиглэлийн контемпорари буюу орчин үеийн урлагийг дэмждэг ийм төвүүд зөндөө л байгаад байдаг. Залуучууд өөрийгөө хөгжүүлэх, сая олимпоор ч гэсэн бид бол хүний хөгжлөөрөө хэр зэрэг түвшинд байгаагаа хангалттай харлаа шүү дээ. Тийм учраас яг иргэн рүүгээ чиглэсэн хүний хөгжлийг дэмжсэн ийм төвийг коммунист центр хүртэл байгуулах хэрэгцээ Монгол Улсад байна.

3-д нь яг үүнтэй адилхан бас нэг юм. 2012-2014 онд бид нар хэрэгжүүлэх гэж оролдсон. Харамсалтай нь чадаагүй. Энэ эрүүлжүүлэх гээд Зөрчлийн хуулиар, Эрүүгийн хуулиар хүн шийтгэдэггүй мөртөө хүнийг хорьдог, эрх чөлөөг нь хязгаарладаг нэг ийм систем байгаад байгаа байхгүй юу. Энийг шийдэх гэж оролдсон чинь Монголд яваагүй. Яваагүй болсон шалтгаан юу вэ гэсэн чинь 1 сая 700 мянга орчим хүн ам төвлөрчихсөн Улаанбаатар хотод хонуулах байр байхгүй. Гэр оронгүй, янз бүрийн хамааралд автчихсан ийм хүмүүсээ нийгмийнх нь асуудлыг шийддэг хонуулах байр байдаггүй. Ийм том 1 саяас дээш хүн амтай хот чинь дор хаяж 2-3 хонуулах байртай байж байгаа шүү дээ. Дэлхий нийтээрээ. Гэтэл манайд хонуулах барихгүй. Траншейндаа найддаг. Эсвэл хамаатан саданд нь найдах гэж үлдээдэг, эсвэл гудамжинд хөлдөж үх гэж хаядаг. Бүр зэрлэг маягийн арга барил нь эрүүлжүүлэх байранд аваачаад, цагдаагийн хяналт дор шорон шиг аваачаад хийчихдэг. Тэндээ хэн нэгэн гэмт хэрэгтэн зодуулж үхвэл тэр хүний хохь болдог. Цагдаагийн албан хаагчдынхаа хүчирхийлэлд автвал хүний эрхийн зөрчил болдог. Тэгэхээр энэ асуудлуудыг шийдэх боломж байна уу. Энэ чинь дандаа хүний хөгжлийн асуудлууд байгаа байхгүй юу.

Дараагийнх нь нэг асуудал. Минутаа гүйцээгээд авчихъя.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмж өгье.

Х.Тэмүүжин: Түрүүн Сайнзориг гишүүний асуултад гарсан газрын реформтой холбоотой. Монгол Улс яг үндсэндээ энэ эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн ялгамжуудыг ерөөсөө тодорхой хөгжүүлээгүй. Монгол Улсын газар өмчлөхтэй холбоотой харилцаа 0.7 га дээр хүн амынх нь 40 хувь хүрэхгүй хэсэг дээр очоод гацчихсан. Энэ гацсан байдлаасаа болоод өнгөрсөн хавар яасан бэ гэхээр эзэмших эрхтэй хөрөнгө

оруулалтыг дэмжихтэй холбоотой асуудлыг өмчлөх эрхтэй нь хольж хутгаад бүр хөрөнгө оруулагчдаа үргээх хэмжээнд нь үгүй хийчихсэн. Одоо газрын реформ хийгээд, Монгол Улсын иргэн, бизнесийнхээ хувьд, аж ахуй эрхлэлтийнхээ хувьд, хувийнхаа амьдарч байгаагийнхаа хувьд газраа өмчилдөг энэ асуудлыг 0.7 га-аас нь томруулаад цаашаа явахгүй бол Монгол Улсын иргэдийн өмч яг түрүүн Сайнзоригийн хэлсэн шиг үл хөдлөх хөрөнгүүд дандаа агаар дээр үүсчихлээ. Газартайгаа ерөөсөө холбогдохгүй байна. Энэ чиглэлийнхээ реформыг хиймээр байна. Улаанбаатар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Ерөнхий сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Баярлалаа. Иргэний ялангуяа орон нутгийн хөгжих төвүүдийг энэ “20 минутын хот” гээд энэ концепц дунд оруулаад, ер нь бол хөтөлбөр дээр оруулж ирсэн байгаа шүү дээ. Тийм ээ. Эрдэнэбүрэн сайд энийг дэлгэрэнгүй хариулчхаж болох байх. Энэ бол маш чухал зүйл.

2 дугаарт Хууль зүйн сайдаар ажиллаж байсан хүн Засгийн газрыг хотоос гарахыг дэмжиж байгаад бол маш их баяртай байна. Яагаад гэвэл өмнө нь дандаа л нөгөө төр захиргааны байгууллагуудын төв байгууллагууд энэ Их, бага тойруу дундаа л байх ёстой гэдэг Үндсэн хуулийн заалттай гэж үзээд, үүнээсээ болоод бид нар ер нь төвлөрсөөр байгаад ингээд эндээ хашигдчихсан ийм агуулгатай. Тийм учраас манайх шиг ингээд Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчтэйгөө ингээд хамт нэг байшин дотор референтүүд нь холилдоод суучихсан. Тэгээд өдрийн хоол дээр бүгд таардаг. Ингээд гүйцэтгэх засаглал, парламентынх нь, хэвлэл мэдээллийнх нь албаны дарга нар нэг хуушуурын гуанзанд ороод байж байдаг эд нар ийм улс гэж бол байхгүй. Тийм учраас бид нар эрх мэдлийн хяналт тэнцлийнхээ дагуу салах ёстой. Энэ ч агуулгаараа парламент томорсон.

Энэ агуулгаараа Засгийн газрын ордныг одоо хэдүүлээ хамтдаа зориг гаргаж нүүлгэх хэрэгтэй. Утаанаасаа зугтаад явлаа энэ тэр гэдэг улс төр хийгээд хэрэггүй ээ. Тэгэхгүй бол ингээд байгаад л байна. Тэгэхээрээ хэдүүлээ одоо ингээд нэг юм хийе гэвэл яг хийсэн шиг хийгээд, тэгээд хийхгүй бол тэгээд яриад яг болихгүй бол тэгээд 1 хийх гээд ч байгаа юм шиг, хийлгэх гээд ч байгаа юм шиг, үгүй ч юм шиг ингээд байх юмнаас болоод л ингээд маш их цаг алддаг. Тийм учраас санал нэг байна. Тэгээд би ийм байрууд чөлөөлөгдөж байгаа бол ийм иргэний дэмжих төвүүдийг байгуулаад ингээд явах боломжтой.

Дээрээс нь Хүний хөгжлийн төвийн чиглэлээр бид нар хувийн хэвилийг дэмжинэ гэж ярьж байгаа. Та бүхэн ажиглаж байгаа бол энэ тодотгол дээр бас орж ирж байгаа. Энэ мод тарих, иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх музей, театр, номын сан, соёлын үйлчилгээ, фитнес клуб, спорт цогцолборууд, зуслан, хүүхдийн парк гээд энэ бүх зүйл дээр хэрвээ одоо ингээд дэмжлэг үзүүлээд хувийн хэвшил барьчихвал татвараас нь 1 хувь хүртэл чөлөөлье. Орлогын албан татвараас гээд. Энэ бол их тийм том хэмжээний сэдэлжүүлэлт болж байгаа. Ялангуяа том компаниудын хувьд. Заавал төр аваад бид нар хийсэн гээд байх шаардлагагүй. Автораа өөрөө ав. Тэгээд төрийн хийх ёстой зүйлийг хувийн хэвшил хийх нь зүйтэй юм гэдэг агуулга руу хэдүүлээ эрх зүйн хувьд нь дэмжээд өгчихвөл бидний яриад байгаа бүх зүйлийг төр хийх шаардлагагүй. Хувийн хэвшил харин хийх тэр боломжийг нь эрх зүйн хувьд нь нээгээд өгчихье гэдэг энэ заалт орж байгаа. Тэгээд энэ бол бас энэ 4 жил дотор бол зөвхөн төр ийм үйлчилгээг бариад байх биш, яг энэ community development center гэж яриад байгаа яг энэ иргэдийн хангасан энэ зүйлүүд дээр бол хувийн хэвшил нэлээн тийм том хэмжээнд оролцох ийм боломж эрх зүйн хувьд бол нээгдэж байгаа гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Нэмж
Эрдэнэбүрэн сайд.

Р.Эрдэнэбүрэн: Тэмүүжин гишүүний асуултад товчхон нэмье. Энэ “20 минутын хот” төлөвлөлтийн хүрээнд иргэдээ илүү амар тайван байлгах маш богино хугацаанд бусад бүх үйлчилгээнүүдийг авч байх төлөвлөлт яригдаж байгаа. Мэдээж таны ярьж байгаа энэ төвүүд, урлагийн төвүүд эд нарыг ажиглахад ялангуяа 1 хүнд ноогдох ДНБ дор хаяж 10 мянгаас дээш болчихсон ийм орнуудад их идэвхтэй хөгжчихсөн байгаа харагддаг. Тийм учраас бид нар энэ төлөвлөлтөөсөө гадна энэ орлогоо нэмэгдүүлэх тал дээрээ бүгд хамтраад бодитой болгож чадах юм бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын сайд нэмж хариулах уу. Хүний хөгжлийн төвүүд. Хуучин Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр энэ чинь төлөвлөгдөөд явж байсан community center

Л.Энх-Амгалан: Сая Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг одоо Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж эмхлэн зохион байгуулсан. Тэгэхээр ерөнхийдөө бид нар өмнө нь дандаа залуучуудын төв, ахмадын төв, хүүхдийн төв гээд ингээд дандаа салангид их явж байсан юм байна лээ. Тийм учраас цаашидаа энэ бусад улсуудад байдаг яг community center бол яг манайхаар бол гэр бүлийн хөгжлийн төвийн ийм төвүүд манайд бас их сайн жишгүүд бол байгаа шүү дээ Тэмүүжин гишүүн ээ. Тийм учраас энийг цаашидаа ер нь гэр бүл хөгжлийн төв болгож бид нар бүсчлэх аймаг, сумууд дээр, дүүргүүд дээр хүргэх бас нэг ийм концептууд бас хийгдэж байгаа.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд нэмж хариулах юм уу. Газрын хуулийн асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Алтангэрэл сайд нэмж хариулъя.

О.Алтангэрэл: Газрын реформыг бол дэмжиж байгаа. Тэгээд хуучин Барилга, хот байгуулалтын яам дээр Газрын багц хууль орж ирчихсэн байж байгаад, сая буцаагдчихсан. Одоо бол Газрын харилцаа, геодези, зураг зүйн агентлаг Ерөнхий сайдын дэргэд ирсэнтэй холбогдуулаад энд тэр хуулийн төслүүд маань байгаа. Тэгээд ер нь олон талын байр суурь орж ирдэг. Нэлээн нухацтай хандах ийм хууль учраас Ерөнхий сайд дээрээ ч байх нь зөв байх. Тэгээд бид бол энэ реформыг хийхгүйгээр дахиад цаашаагаа энэ хувийн эрх зүйн хөгжлийн талаар ярихад хүнд гэдгийг ойлгож байгаа учраас энэ реформыг хийхийн төлөө явна.

Д.Амарбаясгалан: Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуултаа асууя.

Г.Лувсанжамц: Сайн байцаана уу. Засгийн газрын хэрэгжүүлэх гэж байгаа бүсчилсэн хөгжлийн бодлого, тэр дундаа хөтөлбөрийн 1.1-д туссан байгаа Нийслэл болон Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын ажилд нэн анхаарч, төвлөрлийг задлах гэж байгаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжиж байна. Ялангуяа метроны 1 дүгээр шугам, Туулын хурдны зам, Сэлбэ болон Баянхошуу дэд төвүүдийн бүтээн байгуулалт, Яармагийн түгжрэлийг хуваах Go-Mongolia гүүр болон Хөшигийн хөндийн туннелийг барьж байгуулах ажлыг төлөвлөж байгаад баяртай байна. Сүүлийн 30 жил гаднын хөнгөлөлттэй зээл, тусламжаар барьсан зам, гүүр, шинэ нисэхээс өөр дорвитой бүтээн байгуулалт нийслэлд үнэндээ байсангүй шүү дээ. Энэ жилээс манай улс албан ёсоор дунджаас дээш орлоготой руу шилжиж орж байгаа. Шинэ 30 жилийн хөгжлийн эхлэлийг их зөв, гоё тавьж байна гэж бодож байна. Тэгээд энэ том төслүүд дээр олон улсын туршилагатай инженерийн зөвлөх үйлчилгээ авна гэж байгааг бас салбарын хүний хувьд бол дэмжиж байна. Сая Ганбаатар гишүүн үгүйсгэсэн үг хэлж байсан. ТЭЗҮ-гүй төсөл яваад байна.

Зураггүй төсөл яваад байна. Ийм их мөнгө тавиад байна гэж хэлж байсан. Ер нь бол олон улсын жишиг чинь ТЭЗҮ, зураг төсөл, төслийн менежментийг нь тэр чигт нь олон улсын туршилагатай инженерийн зөвлөх үйлчилгээний компанид өгч явдаг байгаа. Тэгэхлээр ийм олон улсын жишиг рүү шилжиж байгаа нь сайн зүйл шүү гэдгийг нь бас ойлгоосой гэж хүсэж байна.

Дараагийн зүйл бол 1.1.2.11 дээр гэр хорооллын айл өрхүүдийн дулаан алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлт бий болгох дулаалгын төслийг хэрэгжүүлнэ гэсэн байна. Энэ төслийг улсын хэмжээнд хэрэгжүүлээсэй гэж хүсэж байна. Зөвхөн Улаанбаатар биш. Утаатай болсон нь зөвхөн Улаанбаатар биш шүү дээ. Аймгийн төвүүд ч гэсэн утаатай болчихсон байгаа болохлоор энэ төслөө улсын хэмжээнд хэрэгжүүлээсэй гэж хүсэж байна.

2 асуулт байна. Эхний асуулт Эрдэнэбүрэн сайдаас “20 минутын хот”-ыг бий болгох бодлогын бичиг баримтыг зохиож, бусад яамнуудын нийгмийн болон инженерийн дэд бүтэц барьж байгуулах төслүүдийг чиглүүлэх хэрэгтэй байна гэж мэргэжлийн хүний хувьд бодож байна. Тэгэхгүй бол энэ стандарт нь зөвхөн Улаанбаатарт байх болчихоод байна л даа. Энэ хөтөлбөрийг харахлаар. Дархан, Эрдэнэт аймгийн төвүүд ч бас сургууль, цэцэрлэг, эмнэлэг гээд нийгмийн дэд бүтцийн хүртээмжийн асуудал байгаа гэдгийг бас бодолцоорой. Тэгээд шинээр төлөвлөж байгаа Шинэ Зуунмод, Шинэ Хархорум хот ч гэсэн ийм стандартаар явах юм уу, үгүй юм уу гэдгийг бас бодлогын бичиг баримтаараа зохиож чиглүүлж өгөх үү гэж асуулт байна.

2 дугаар асуулт байна. Батсуурь сайдаас. Хот төлөвлөлтийн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах, Газрын хууль, Барилгын хууль хоорондын уялдааг хангах уу. Энэ бүх төлөвлөгөөний бичиг баримтууд хоорондоо ингээд

уялдаагүй, салангид явсаар байгаад Улаанбаатар хот ингээд улсын нийслэл байж байж ийм хачин хот болоод сүүлийн 30 жил явчихлаа. Хэдүүлээ энэ шинэ 30 жилийнхээ эхлэлийг саяын хэлсэн 20 минутын стандартын бодлогын бичиг баримт болон хот төлөвлөлтийн эрх зүйн орчноо сайжруулж эхлүүлэхийг хүсэж байна. Тэгээд тэр дундаа ялангуяа төлөвлөлтийг зохиоход иргэдийн оролцоог хангадаг болох уу. Иргэдийн оролцоог хангасны үндсэн дээр иргэдийн саналаар тавьсан төслүүд дээр хөрөнгө оруулдаг төсвийн тогтолцоо руу шилжих үү. Газрын тухай хууль болон эдгээр хуулиудын шинэчлэлийг хэлэлцүүлж батлуулах уу энэ 4 жилийн хугацаанд гэдэг асуулт байна.

Дахиад 1 асуулт асууцхъя. Шинэ хоршоо хөдөлгөөний талаар. 3.3.4.1 дээр шинэ хоршоо хөдөлгөөнийг үргэлжлүүлж, чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэж байна. Шинэ хоршоо хөдөлгөөнөөр бол бид хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих, тэр нь гол зорилго гэж би бол бодож байгаа. Тэгээд энэ хөтөлбөрөөс харахад төвийн болон хангайн бүс л яг тэргүүлэх чиглэлээ тодорхойлсон байна л даа. Бусад 4 бүсийн тэргүүлэх чиглэл нь юу байх юм бол гэдгийг энэ хөтөлбөртөө бас тусгаж оруулж ирээсэй гэж хүсэж байна. Жишээлбэл, Итали улс байна шүү дээ. Бүх муж нь бяслагтай. Өөр янз янзын. Тэрийгээ дагаад наста нь бас өөр амттай, пицца нь бас өөр амттай. Тэрэнтэй адилхан Монгол улс ч гэсэн ингээд 21 аймаг нь өөр өөрсдийн жишээлбэл бяслаг ч байдаг юм уу, олон улсад гаргадаг дотоодын зах зээлээ хангадаг тийм байдал руу шилжье гэдэг тийм хүсэлт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: “20 минутын хот” Үндэсний хорооны дарга Эрдэнэбүрэн сайд асуултад хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Юуны өмнө Лувсанжамц гишүүнд энэ том төслүүд дээр олон улсын зөвлөх үйлчилгээ авах,

олон улсын стандартаар явахыг дэмжиж байгаад маш их баярлалаа. Сая бас манай хот энэ метрон дээр энэ ажлыг бас их амжилттай хийгээд ингээд явж байгаа. Тэгээд яах вэ манай зарим хүмүүст бас эргэлзээ байдаг. Энэ олон улсын зөвлөхүүдэд мөнгө хөрөнгө хэцүү байдаг гээд. Өмнө нь бас тийм туршилагууд байсан юм шиг байна лээ. Одоо харьцангуй нэг үеийг бодвол манай хот төлөвлөлтийн чиглэлээр ялангуяа танаас эхлээд ийм сайн боловсон хүчнүүд гадаадад төгссөн, Японд төгссөн ялангуяа ийм олон мэргэжилтнүүд их бий болсон байна. Тийм учраас дан ганц олон улсын зөвлөхүүдийнхээ амыг хараад, дагаад давхиад байдаг тийм зүйл бол бас байхгүй болж байгаа юм билээ.

“20 минутын хот” бодлогын бичиг баримт гэж гаргая гэж бид хэд хороо дээрээ бас ярьсан байгаа. Тэгээд энэ намрын чуулганаар хэлэлцүүлэх асуудалд оруулахаар Учрал сайдад бас би өнөөдөр дөнгөж сая албан бичгээ өгчхөөд байж байгаа.

Д.Амарбаясгалан: Хууль зүй, дотоод хэргийн сайд газартай холбоотой асуудлаар хариулт. Барилга, орон сууцжуулалтын сайд Батсуурь сайд бас нэмэлт хариулт өгье.

Ж.Батсуурь: Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Тэгэхлээр энэ метро, Туулын хурдны зам, гүүр, туннел, шинэ тойрог, шинэ суурьшлын бүс, төр захиргааны байгууллагыг бас Улаанбаатар хотоос гаргаж Улаанбаатар хотыг өөрөө бизнесийн хот болгох энэ асуудлууд бол “20 минутын хот” Үндэсний хороо, нийслэл, манай Хот байгуулалтын яамтай бол салшгүй холбоотой. Энэ ч агуулгаараа бид нар энэ ажлын хэсгүүдийг гаргаад ажиллуулж байна. Мөн намрын чуулганд хэлэлцүүлэх хуулийн жагсаалтад бол Үндэсний орон сууцжуулалтын тухай анхдагч хуулийн төсөл, Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Барилгын тухай хуулийн төслийг хэлэлцүүлнэ гээд саналаа

өгчихсөн байж байгаа. Бас ажлын хэсгүүд гаргаад судалгааны ажил явагдаж байна. Дээр нь таны яг ас асууж байгаа зүйл бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулах уу Батсуурь сайд. Нэмж хариулъя. Батсуурь сайд.

Ж.Батсуурь: Газрын тухай багц хуульд бол яг энэ барилгатай холбоотой, дахин төлөвлөлттэй холбоотой хот, сууринтай холбоотой асуудлыг бол яг өөрийнхөө салбарын зүгээс бол нарийвчилж оруулна. Газрын тухай багц хууль бол өөрөө маш том хууль. Монгол Улс ямар нутаг том нутаг дэвсгэртэй билээ. Хөдөө, гадаа бэлчээр, өвөлжсөө, хаваржаа, хот суурьшилт гээд. Энэ дотроо бол бид нар шинэ төлөвлөлт, шинэ хот, хот, суурьшлын асуудал, дахин төлөвлөлтийн асуудал бол Газрын тухай багц хуульд бол бүрэн оруулах бүрэн боломжтой гэж ингэж үзэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд нэмж хариулъя.

Н.Учрал: Энэ үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.4.3 дээр Хот байгуулалтын болон газрын багц хуулийг шинэчлэн баталж, ерөнхий төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээх эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж заасан. Дээрээс нь хаврын чуулганаар батлагдсан Хот, тосгоны эрх зүйн байдлын хуулиар “20 минутын хот” дээр тавигдах шаардлагыг хуульчлаад, ажлын хэсэг дээр бид төсвийг төлөвлөхдөө хол, ойроос үл хамаараад сургууль, цэцэрлэг, эмнэлэг, шаардлагатай үйлчилгээнүүд байхгүй бол ухаалгаар төлөвлөх ийм эрх зүйн зохицуулалтыг оруулсан. Дээрээс нь хот дээр шинэ технологи нэвтэрч байх юм бол сайнт боксын орчинд буюу нөгөө дүрэм журмын зөвшөөрөл авахгүйгээр тухайн технологийг туршаад, тэгээд зөвшөөрөл

авдаг энэ шинэ орчныг нь хуулиар бас бий болгосон. Тэгэхээр Улаанбаатар хотын хөгжлийн 2040 он хүртэл ерөнхий төлөвлөгөөг бол Их Хуралд оруулж ирэх ёстой. Үүний дагуу төлөвлөлт стандартын дагуу тэр Хот, тосгоныхоо хуулийг бариад “20 минутын хот” гэсэн энэ одоо хөгжил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Очирбатын Амгаланбаатар гишүүн асуултаа асууя.

О.Амгаланбаатар: Та бүгдэд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ одоогийн хэлэлцэгдээд байгаа зүйл чинь зөвхөн хэлэлцэх үү, үгүй юу гэдэг асуудлыг Их Хурлын дарга аа, хэлэлцэх үү, үгүй юу гэдэг асуудлыг хэлэлцэж байгаа биз дээ. Түүнээс биш дотор талын тэр гэдэс дотор, зүйл заалтыг ярих шаардлагагүй биз дээ. Гэтэл өнөөдөр ингээд 2, 3 удаа Их Хурлын сонгогдсон гишүүд маань бас л энэ агуулгаа ойлгохгүй байгаа юм уу. Тэр жижиг сажиг тэр гэдэс дотор луу л ороод л яриад байх юм. Тийм учраас энэ чинь агуулга, үзэл баримтлал нь үнэхээрийн нийцэж байна уу, үгүй юу. Энэ агуулгын хүрээнд энийг хэлэлцэх юм уу, үгүй юу. Эсвэл энэ дотор байж байгаа энэ Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр маань ямар агуулга, үзэл баримтлалтай юм бэ гэдэг асуудлыг л өнөөдөр асууж ярилцах ёстой биз дээ. Тийм ээ. Энийг асууя.

2-т гэх юм бол Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулна гэж байна. Тэгэхээр энэ ямар бүрэлдэхүүнтэй, хэдэн хүнээр байгуулах гэж байна вэ гэдгийг бол асууя.

Гол зүйл бол өнөөдрийн энэ хурлаар хэлэлцэх бид нарын хамгийн чухал зүйл бол энэ намууд хамтарч Засгийн газар байгууллаа. Ард түмний парламентад хяналт тавих. Тэр сөрөг хүчнийг байхгүй болголоо. Яагаад энэ 94 хувийг нэг талд ингэж гаргаж байгаа юм бэ. Юу өөрчлөх гээд байгаа юм бэ гэдэг асуудлыг хамгийн

түрүүнд ярих ёстой байсан байх. Яг яах гэж өнөөдөр энэ том хамтрал бий болж байгаа юм бэ. Тэгвэл тэр Үндсэн хуулийн өөрчлөлтөө энэ ердийн олонхоор хийчих ажлууд байна. Гэтэл яагаад энэ 90 хэдэн хувийг нэгтгэсэн энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт чинь тэр Үндсэн хуулийн өөрчлөлтүүд Монгол хүн 4 жилийн дараа ийм ахиц дэвшил гарна гэсэн тэр яг нэг бүрчилсэн зүйлүүд чинь байхгүй байгаад байгаа юм бэ. Бүх л зүйл бол өмнө нь 30 жил явсан тэр нэг бөөрөнхий ингэнэ, тэгнэ, үргэлжлүүлнэ гэсэн тийм ерөнхий заалтууд байна. 4 жилийн хугацаанд Монгол хүний дундаж наслалт яг тэдэнд хүргэнэ. Монголын ард түмний үр хүүхдийн боловсрол хот, хөдөөгийн ялгааг арилгана. Эсвэл энэ утааг байхгүй болгоно. Эсвэл энэ түгжрэлийг байхгүй болгоно гэсэн тийм тодорхой заалт энд нэг ч байхгүй байгаад байгаа юм бэ. Магадгүй энэ бол дараагийн тэр нэг бүрчлэн хэлэлцэх дээр явах байх гэж харж байна. Тэгээд ингээд дэс дараалуулсныг нь харахад бол 1 дүгээрт бүсчилсэн хөгжлийн бодлогыг 1 дүгээрт тавьсан байна. Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагааны нэгдүгээрх зүйл бол бүсчилсэн хөгжил юм байна. Хоёрдугаарх нь хүний хөгжил юм байна гэж ингэж анзаарагдаж байна. Хэрвээ бүсчилсэн хөгжил юм бол тэр агуулга яахаараа тэр чигээрээ Улаанбаатар хотын асуудал байдаг юм бэ. Нэг төвтэй Улаанбаатар хотыг задалъя. Энэ 30 жилийн алдаа оноогоо засъя гэж Монгол Улсын Ерөнхий сайд бол өмнө нь маш олон удаа ярьсан. Тэгвэл яг энэ 30 жилийн алдааг засах тэр том өөрчлөлтүүд энэ хөтөлбөр дотор бараг алга байна. Орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх заалт энэ дотор огт алга байна. Бүсчилсэн хөгжлийн чинь амин сүнс нь орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх. 22 агентлагтай аймагт 20-ийг нь бараг босоо яамд нь томилдог. Аймгийн Засаг дарга гэдэг, сумын Засаг дарга гэдэг морь унасан толгойгүй хүн буюу дээрээс ирсэн тэр цалин дээр бараг гарын үсэг зурдаг ийм л эрх мэдэлтэй. Монгол Улсын Үндсэн хуульд аймаг, сум нийгэм эдийн засгийн цогцолбор байна

гээд тусгаад 30 гаруй жил болчихлоо. Энэ яагаад ч хэрэгжих боломжгүй. Тэгвэл энийг яаж энэ өөрчлөлтийг хийх юм бэ. Эрх мэдлийг задлах юм уу, үгүй юу гэдэг ийм зүйлийг нэн тэргүүний асуудал болгож энэ Засгийн газар шийдэх ёстой. Юун төлөө 94 хувийг нэг талдаа гаргасан билээ гэж ингэж асуух байна. Тэгээд та бүхэн маань энэ дээр бас дэлгэрэнгүй хариулж өгөөрэй гэж хэлэх байна.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд хариулъя. Дараа нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал нэмж хариулна.

Л.Гантөмөр: Ер нь бол Амгаланбаатар гишүүний яриад байгаа санааг би ойлгож байгаа. Гол нь ингээд байгаа юм. Яг бүсчилсэн хөгжил гэж байгаа бол яг энэ төсвийн тодотголоосоо эхлээд бүсчилсэн хөгжлийн бодлого чинь хөдөө, орон нутаг руу хандсан бодлого чинь их огцом хөрөнгө оруулалтаар баяжигдах ёстой юм биш үү гэж. Улаанбаатар хот руугаа төсвийн тодотгол дээрээ их өндөр хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна. Тэгэхээр энэ дээр ялгаагаа гаргахгүй юм уу гээд байгаа юм. Тэгэхдээ би нэг зүйлийг Амгаланбаатар гишүүнд бас тайлбарлаад байгаа юм. Ер нь Улаанбаатар хотын түгжрэлийг бүрэн арилгах, Улаанбаатар хотыг утаанаас салгахын тулд бол бид нар цаг хугацааны хувьд амжиж хөдөлбө гээж байгаа юм. Амжиж хөдөлбө. Одоо бид нар гуравхан удаа төсөв батална. 3 удаа ТЭЗҮ хийнэ. Тэгэхээр нэн тэргүүнд энэ намартаа багтаагаад Улаанбаатар хотын өнгөрсөн 2 жилийн хугацаанд хийгээд, тодорхой түвшинд оччихсон байгаа ажлуудыг цаашаагаа хурдасгуурыг нь хийж өгье гэдэг ийм зүйл дээр л санал нэгдэж байгаа байхгүй юу. Түүнээс хөдөөгөө орхиё гэж байгаа зүйл ерөөсөө байхгүй. Гол нь бүсийн хөгжлийн бодлогыг ондоо багтаагаад гүйцэд гаргамаар байна.

Одоо жишээлбэл баруун бүсийн гишүүд ингээд өөр өөр зүйл ярьж байгаа юм. Баруун бүсийн яг стратеги юу юм бэ гэдгийг энэ ондоо багтаагаад хийх хэрэгтэй. Бид бол үзэл баримтлалыг нь шинэчлээд удаагүй байна л даа. Энэ I сарын хугацаанд энэ гүйцэд стратеги болоод яг тэр бодлогыг нь гаргахад бас бидэнд хугацаа байсангүй ээ. Бид бас үнэнээ хэлэх хэрэгтэй. Тэгэхдээ энэ ондоо багтаагаад бид нар энэ 6 бүсийг хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг бодлого их тодорхой болох ёстой. Энэ бодлогыг дагасан хөрөнгө оруулалтын шийдлүүд энэ бүс нутгуудын онцлогийг бий болгох тэр эрх зүйн орчнуудыг хэрхэн бүрдүүлэх вэ, ямар хууль батлах вэ, аль бүсэд нь ямар хуулийг өөрөөр хэрэглэх вэ гэдэг энэ бодлогын зүйлс гарна. Жишээлбэл бүсийн хамгийн бага нэгж гэж байгаа тэр 90 нэгж дээр хийгдэх программ их тодорхой болох ёстой. Ингэж байж төвлөрлийг бий болгох хэрэгтэй. Амгаланбаатар гишүүн энэ 5 бүсээ засаг захиргааны нэгж буюу Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад энэ 5 бүсээ ер нь зарлаад, шууд засаг захиргааны нэгжийн өөрчлөлт рүү орё гэдэг ийм санал гаргаад байгаа юм. Бид бол эхлээд бодлого нь тодорхой болоод, хөрөнгө оруулалт нь тодорхой болоод, төвлөрлийг татах тэр хууль, эрх зүйн орчин нь тодорхой болоод, кластер гараад ирэхээр аандаа Амгаланбаатар гишүүний яриад байгаа тэр Үндсэн хуулийн өөрчлөлт рүү алхана. Алхахаас өөр аргагүй болно. Энийг өнөөдөр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулахаас илүүтэйгээр парламент ялангуяа бүсүүдээс сонгогдсон гишүүд энэ дээрээ анхаараад алхаасай гэж бодож байгаа. Ингэснээр орон нутаг руу үнэхээр эрх мэдэл шилжих шилжилт бол явна. Явахаас өөр аргагүй. Бид яагаад эрчим хүчин дээр анхаарал тавьж байгаа юм. Яагаад логистик дээр анхаарал тавьж байгаа юм. Яагаад боомт дээр анхаарал тавьж байгаа юм. Яагаад экспорт дээр анхаарал тавьж байгаа вэ гэвэл Улаанбаатарыг 4 жилийн хугацаанд утаагүй болгоё л гэж байгаа юм. Манай орон нутгаас сонгогдсон гишүүд яг

адилхан нөхцөл хэлж байгаа юм. Тэгвэл аймгийн төвүүдийг бас утаанаас салга гэж. Тэгэхээр энийг хийх бодлогууд бол ялгаагүй эрчим хүчин дээрээ суурилж хийгдэнэ. Бид нүүрсийг элдэв янзаар шатааж үзлээ. Болохгүй байна. Бид дулааны хэмнэлттэй орон сууцын хөтөлбөр нэмэх нь эрчим хүч гэдэг энэ шийдлээр бид утаанаас салах юм. Магадгүй араас нь нэмэгдээд газ энэ тэр ингээд ороод ирэх бололцоотой болох байх. Тэгэхээр бид нар ямар нэгэн байдлаар өнөөдөр энд шийдвэр гаргаад алхахаас илүү бүсийн хөгжлийн бодлогыг богино хугацаанд бүх хүчээ дайчилж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд нэмж хариулах уу. Учрал сайдад нэмэлт цаг өгье.

Н.Учрал: Энэ бүсүүдийн хөгжлийн интеграцыг бий болгож байж хүн тэнд амьдрах нөхцөл бүрдэнэ. Тийм ч учраас энэ тэргүүлэх 4 чиглэл гэдэг бол яг бүсчилсэн хөгжлөөс эхэлж байгаа нь учиртай байна. Тэгэхээр нийслэл бол жишээ нь хүн амын 50 гаруй хувь нь оршин сууж байгаа энэ 700 гаруй газар төвлөрч байгаа урсгалыг хэрхэн задлах вэ гэдэг дээр бид анхаарах ёстой гэдэг утгаараа энэ бүсүүдийн хөгжлийг дэмжих чиглэлээр энэ төсвийн тодотголоор дамжуулж, эдийн засгийн хэд хэдэн төслүүдийг оруулж ирсэн. Үүнийхээ тусламжтайгаар тухайн бүсүүдэд хүн амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн тулд жишээ нь тэр бүсүүдэд байгаа аймаг, орон нутгийн Засаг дарга нар гэхэд л тухайн аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулах бүх төрлийн санал санаачилга гаргасан тохиолдолд, жишээ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 10 жил хойшлуулъя ч гэдэг юм уу ийм олон янзын хөшүүргүүдийг дагуулж орж ирж байгаа. Тэгээд хүний урсгалыг хэрхэн тийшээ задлах вэ. Тэгэхээр энэ төвлөрөл эрх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя. Амгаланбаатар гишүүний асуултад хариулъя. Юу хэлэлцэж байгаа 1 дүгээрт, 2 дугаарт ямар ажлын хэсэг гарч ажиллах гэж байгаа талаар асуулт тодруулга явсан.

Ж.Бат-Эрдэнэ: Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг батлагдаж байгаа. Тэгэхээр 1 дэх өдрөөс эхлээд ажиллана. Тодорхой саналуудыг өнөөдрийн гарсан саналуудыг ажлын хэсэг дээр ерөнхийдөө бол референтүүд маань тэмдэглээд авч байгаа. Тэгээд 1 дэх өдрөөс эхлээд энэ саналуудаа та бүхнээс, өөрөөр хэлбэл гишүүдээс гарсан саналуудаа нэгтгээд ажлын хэсэг дээр хэлэлцэнэ.

Д.Амарбаясгалан: Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуултаа асууя.

У.Отгонбаяр: Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе. Би цаг бас хэмнэх үүднээс тодорхой асуултаа шууд оршилгүйгээр асуугаад явъя.

1 дүгээр асуулт. Эдийн засгийн бодлогын хүрээнд мөрийн хөтөлбөрийн 3.3.2-т заасан боомтын шинэчлэл гээд энд олон боомтуудыг бас төмөр замаар холбож, цаашаагаа хил дамнаж хөри улсуудтайгаа холбоно гэж заагдсан. Эндээс би зүүн бүсийн босоо тэнхлэгийн төмөр замыг Боомтын сайдаас бүр албан ёсоор асуумаар байна. Энэ төмөр зам орсноор бол энэ зүүн бүсийн хөгжил, энэ бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжихэд бол нэлээн тийм далайцтай хувь нэмэр оруулах ийм стратегийн ач холбогдол бүхий ийм төмөр зам. Энэ дээр манай Боомтын үндэсний хороо 2 хөрштэйгөө ямар бодлого барьж ажиллаж байгаа вэ. Төсөл хэрэгжих болдог, нөгөө бодлого нь тодорхойгүй, аль аль талдаа тохироогүй ийм зүйл гарвал цаг хугацаа их алдана. Энэ бүгд маань параллелийн явах ёстой. Тэгж байж төсөл хөтөлбөр маань хэрэгжинэ. 1 дүгээрт.

2 дугаарт Хөдөө аж ахуйн сайдаас намын мөрийн хөтөлбөрт хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг бүх боомтоор гаргана гэж заагдсан байгаа. Зүйл, заалт орсон. Хэрвээ энэ маань яг бодит хэрэгжиж чадвал энэ бол хөдөө, орон нутагт тэр дундаа малчдын ахуй амьжиргааг дэмжих чиглэлд бол нэлээн хувь нэмэр оруулах ийм ажил болно. Энэ чиглэлээр яг ямар тодорхой ажлууд тусгагдсан бэ гэж 2 дахь асуулт.

3 дахь асуулт хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдтэй зайлигүй салиггүй холбоотой нэг зүйл бол Хөдөө аж ахуйн бирж. Энэ нэг хэсэг бол их тийм эхлэлийг нь би зөв эхлээд явсан болов уу гэж бас ойлгож байгаа юм. Одоо яг ямар түвшинд явна. Цаашидаа энэ Хөдөө аж ахуйн бирж дээр ямар бодлого барьж ажиллах вэ гэсэн ийм тодорхой 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Буяагийн Тулга хариулъя.

Б.Тулга: Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр боомтын шинэчлэл, тээвэр логистикийн бүлэг дээр бол зүүн бүсийн босоо төмөр зам, боомтын төмөр замын асуудлуудыг маш тодорхой хамгийн чухал зорилгуудын нэг болгож хэд хэдэн заалт дээр оруулсан байгаа. 3.3.2.3 дээр, 3.3.2.15 дээр, 3.3.2.17 дээр, 3.3.2.21 дээр дан Бичигт боомттой холбоотой заалтууд орсон байгаа. Бичигт боомт бол ер нь Монгол Улсын төдийгүй бүс нутгийн хувьд бас их чухал өндөр ач холбогдолтой ийм боомт байгаа. БНХАУ-ын 14 дүгээр 5 жилийн төлөвлөгөөнд хөгжүүлэх боомтуудын 1 дүгээр эгнээнд Монгол Улстай хиллэж байгаа боомтуудын 1 дүгээр эгнээнд Бичигт боомтыг тавьсан. Мөн Хятадын санаачилсан бүс ба зам санаачилгын Ази Европыг холбосон коридорын урд талын Монгол Улсын хувьд бол урд талын цэг болж ингэж орсон байгаа. Энэ ч утгаараа

бас Бичигт боомт дээр бид нар онцгой анхаарал хандуулж, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр боомтын цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг өнгөрсөн жил эхлүүлсэн. 2025 онд багтааж дуусгахаар ажиллаж байна.

Үүнээс гадна Бичигт боомт дээр хийгдсэн ерөнхий төлөвлөлтийг шинэчилж, тэр дээр төр, хувийн хэвшлийн түншлэлээр бусад төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ийм төслүүдийг шалгаруулахаар бэлдэж байгаа гэдгийг танд дуулгамаар байна. Мөн манай Зам, тээврийн яамнаас гаргасан төмөр замын бодлого дотор бол Бичиг боомт маань өөрөө зүүн бүсийн босоо тэнхлэгийн төмөр зам байгаа. Энэ төмөр зам маань хойшоогоо Чойбалсан хот, Чойбалсангаас Эрээнцав хойд талын боомтыг холбох энэ босоо тэнхлэгийн төмөр зам, мөн үндсэн манай төмөр замын сүлжээ рүү нэгдэх хөндлөн төмөр замын бодлогод орсон байгаа.

Тэгэхээр өнгөрсөн жил төмөр замын бүтээн байгуулалтыг явуулах аж ахуйн нэгжийг Зам, тээврийн яамнаас шалгаруулж ТЭЗҮ, мөн тариф дээр хэлэлцээр хийж байгаа гэдгийг танд мэдээлье.

Д.Амарбаясгалан: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбаагийн Энхбаяр сайд нэмж хариулъя.

Ж.Энхбаяр: Хөдөө аж ахуйн биржээс эхэлье. Биржийн үйл ажиллагаа ноолуурын салбар дээр жигдрээд экспортод гарч байгаа ноолуурууд бүгд Хөдөө аж ахуйн биржээр дамждаг болсон. Энэ жилээс бид нар энэ намар гэхэд үр тарианы борлуулалтыг биржээр дамжуулна. Цаашид мал, амьд мал, ноос, арьс ширний борлуулалтыг Хөдөө аж ахуйн биржээр дамжих, үүний тулд энэ шинэ хоршоо хөдөлгөөнөө маш дээд зэргээр ашиглах буюу хоршоод маань өөрөө энэ хөнгөн үйлдвэрийн паркуудаа, үйлдвэрүүдээ түүхий эдээр хангах энэ 2-

ын холбоосны дунд биржийн зохион байгуулалтыг хийгээд ингээд Хөдөө аж ахуйн гаралтай бүх бараа бүтээгдэхүүн өөрөө энэ биржийн зарчим руу шилжих бүрэн бололцоо байгаа. Шаардлагатай программ хангамж хөгжүүлэлтийг хийж байна. Хөдөө аж ахуйн салбарын экспорт 960 орчим сая долларын экспорт байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Энхбаяр сайд.

Ж.Энхбаяр: Салбарын гол тэргүүлэх зорилт бол экспортыг нэмэгдүүлэх, Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг экспортлох. Нийт 960 сая долларын экспортын түвшинд 2023 онд хүрсэн байгаа. Энэ зорилтыг цааш нь ахиулахын төлөө бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Тэргүүн ээлжид махны зах зээлийг олон улсын зах зээл рүү гаргах, олон худалдан авагчтай болгох арга хэмжээг хийж байна. Саяхан Арабын орнууд Монгол Улсын мал, мах тавьсан хориг квотууд цуцлагдсан. Төв Азийн орнуудад зах зээлийн шинэ бололцоо нээгдэж байна. Үүнтэй холбоотойгоор хамгийн гол нь энэ мал эмнэлэг, мал эмнэлгийн лабораториудын чадавхыг сайжруулах, энэ дээрээ тулгуурлаж энэ мөшигөх систем буюу тэр гарал үүслийн тодорхой баталгаатай энэ олон улсын гоц халдварт өвчнөөс ангид байх энэ том системийг бүрэн хийх ёстой. Энд бас нэг зайлиггүй хийх ёстой ажлыг мөрийн хөтөлбөрт оруулсан. Монгол Улсад байгаа цорын ганц Био Комбинатынхаа үйлдвэрийг иж бүрэн шинэчлэх, вакцины үйлдвэрлэлээ дотоодоосоо бүрэн хангах, мал сүргээ эрүүлжүүлж байж бид энэ олон улсын хориг, цээр, худалдааны саад тотгорыг давах учиртай.

Эцэст нь хэлэхэд Гадаад худалдааны хууль байхгүй байгаа. Тэгэхээр энэ бол энэ Засгийн газрын том зорилт. Энэ худалдааны зохицуулалтыг яаралтай хийж нэг мөр ойлголтод шилжихгүй бол бас гадаад худалдаа жоохон замбараагүй, зохицуулалтгүй яваад байгаа тал байгаа.

Д.Амарбаясгалан:
Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан
гишүүн асуултаа асуу.

Л.Мөнхбаясгалан: Эдийн засаг, хөгжлийн сайдаас асууя. Засгийн газрын онцгойлсон 13 том мега төсөлд Хэрлэн-Тооно, Орхон-Онги төсөл орсон байна. Үүний яг аль ТЭЗҮ-г барьж явах вэ. Хэд хэдэн ТЭЗҮ байгаад байгаа. Эрдэнэс Оюутолгой дээр 7 сарын 2-нд зарлагдсан Хэрлэн-Тооныг барьж явах уу. Хэрвээ тэндээс ямар нэгэн үр дүн гарвал. Нөгөөдөх нь Орхон-Онги дээр яг ямар ТЭЗҮ барьж ажиллах юм бэ. Нийт өртгийг нь хэлж өгөөч. Хэрэгжүүлэх яам нь юм уу, газар нь хаанах байх вэ.

Эдийн засаг, хөгжлийн сайдаас дараагийн асуулт. Өмнөх төсөл дээр чинь 1.3.4.3-д Дундговь аймгийн Цагаан суварга орчимд палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна гэсэн чинь алга болсон байна. 2024 онд 700 сая төгрөгөөр үүний ТЭЗҮ Эдийн засаг, хөгжлийн яам дээр хийгдсэн. Энэ яагаад байхгүй болчхов гэдэг асуулт байна.

Сангийн сайд гараад явчихсан байх юм. Ерөнхий сайдаас асууя даа. Ерөнхий сайд аа, бид нар говийн бүсийнхэн танаас иударга ёсыг нэхэж байна. Яагаад гэхээр энэ төсвийн тодотголоор Өмнөговь аймгаас төсвийн орлого бүрдүүлэлтийг 700-аад тэрбум төгрөгөөр нэмээд, 1,4 их наяд болгочихсон байна. Яг одоогийн байдлаар бүрдүүлэлт нь 300 гаруй тэрбум төгрөгтэй явж байгаа, 14 хувиар тасарчихсан байгаа. Сангийн сайд ороод ирсэн байна. Тэгэхээр нөгөө Өмнөговь аймгаас авч байгаа төсвийн орлого бүрдүүлэлтийг яагаад 700 тэрбумаар нэмчхэв. 14 хувиар орлого нь тасарсан байгаа гээд ИТХ буюу ЗДТГ-аас бичиг ирсэн. Та болохоор нэг тусгай аргачлал байдаг гээд Баярцогтын 20 мянган хувьсагч шиг юм ярьж байгаа. Энийгээ яг тайлбарлаад өгөөч.

Ерөнхий сайд та 2022 оны 5 сарын 27-нд Даланзадгадад очихдоо 50мвт-ын ДЦС-ыг барьж өгнө гэж амласан. Гэтэл өнөөдөр ингэж төсвийн орлогыг Өмнөговь аймаг бүрдүүлж өгөх юм бол 3 сум нь Хятадаас эрчим хүчээ авдаг юм шүү дээ. Нэмээд Даланзадгад хот эрчим хүчгүй болно. Тэгэхээр бид өнөөдөр Монгол Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтийн дийлэнх хувийг хийж байгаа хэр нь яагаад ганц 50мвт-ын ДЦС бариулах тийм боломжгүй байгаа юм бэ. Чойжилсүрэн сайд та Ардчилсан намын бүлгийн хурал дээр хэлж байсан. Тэр Даланзадгадын 50мвт-ын ДЦС ямар их их хэрэгтэйг Ерөнхий сайд, Сангийн сайд 2-т сайхан ойлгуулаад өгөөч.

Учрал сайд аа. Алтаниширээгийн газрын тосны үйлдвэр баригдахгүй удлаа. 2020 оны мөрийн хөтөлбөрт, Ардын намын мөрийн хөтөлбөрт ордог, Засгийн газар болгонд л ордог. Ажлын хэсэг гаргаад ажиллаж байгаа сураг сонсогддог. Энэ нэг үл мэдэгдэх үйлдвэр болж хувирлаа. Ингээд нийтдээ Засгийн газрын онцгойлсон 13 том мега төслийн бараг 7, 8 нь манай говийн бүсэд хэрэгжих болсонд говьчууд бид их талархалтай байгаа. Тэгэхдээ яг ажил хэрэг болгох тэр нэхэл дагалаа бид нар хийнэ. Зүүн бүсээс сонгогдсон гишүүдтэйгээ хамтарч ажиллаж ойлголцоно гэж бодож байгаа. Ялангуяа усны төсөл дээр. Усны төсөл бол Монголын асуудал болсон гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Чойжилсүрэн сайд тэр 50мвт-ын ДЦС-ыг хэлж өгөөд, энэ АЦС барина гээд байгаа. Бас Дорноговь аймагт баригдах юм шиг байна. Энэ гэрээ хэлэлцээр нь ямар шатдаа яваа юм. Төсөв хөрөнгө нь хэд юм. Хэдэн жилд баригдах ёстой юм. Та энэ талаар бас нэг товч мэдээлэл өгөөч.

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүний нэр дурдаж асуусан дарааллаар хариултаа өгье. Тэргүүн шадар сайд Гантөмөр сайд хариулна.

Л.Гантөмөр: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ

говийн бүс нутаг руу усжуулах ажил бол Монголын аж үйлдвэрийн салбарт хийж байгаа хөрөнгө оруулалт гэж ойлгож, цаашаагаа бүгдээрээ нэг бодлоготой байна шүү гэдгийг хэлмээр байна. Энэ бол цэвэр ундны усны асуудал гэхээс илүү говь бүс нутгийг бид нар аж үйлдвэрийн төрөлжсөн бүс нутаг гэж ойлгож байгаа. Тийм учраас ус хургах ажил бол өөрөө маш том хөрөнгө оруулалт, эдийн засгийн асар том өгөөжийг авчрах ийм төсөл. Хэрлэн-Тооно бол 1,6 их наядын төсөвт өртөгтэй. ТЭЗҮ-ийг Оюутолгой хийсэн байна. Мэдээж бусад газрууд дээр тодорхой ТЭЗҮ-ийг хийж байгаа. Хийсэн гэдэг мэдээллүүд байна. Эцэслэж алийг нь сонгох вэ гэдэг шийдлийг бас хараахан гаргаагүй байгаа гэдгийг хэлмээр байна. Орхон-Онги бол 1,1 их наяд төгрөгийн ТЭЗҮ хийгдсэн байгаа. Тэгэхээр энэ 2 төслийг 4 жилийн хугацаанд бид нар ТЭЗҮ хийнэ, хийхгүй гэхээс илүүтэйгээр маш хурдтайгаар явуулах ёстой. Бизнесийн төсөл гэж ойлгож байгаа учраас энийг бид нар аль болохоор компани дээр явуулах сонирхол жишээлбэл, энд одоо шийдчихсэн юм алга байна. Эдийн засгийн сайдын хувьд бол надад Эрдэнэс Монгол компани лид хийж явбал их амжилттай хэрэгжих болов уу гэж харагдаж байгаа юм. Дараагийнх нь өгөөж нь их өндөр учраас тэд ч гэсэн энд хөрөнгө оруулахад бэлэн байгаа гэдгээ илэрхийлж байна лээ.

2 дахь асуулт энэ түүх соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд тулгуурласан аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулж, жуулчдын нэвтрэх урсгалыг нэмэгдүүлнэ гээд 3.3.5.5 дээр бол бид нар үйл ажиллагааны хөтөлбөртөө түсгасан байгаа шүү гишүүн ээ. Зүгээр таны хэлж байсан тэр байршил бол энэ дээр тодорхойгүй байна. Шаардлагатай бол редакц хийгээд, та бүхэн бас ярьж байгаад тодорхой байршилүүдыг энэ дээр нэмээд оруулж болох юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Олон сайд нар асуултад хариулна. Бүгд 1 минутад

багтаж хариулна. Дэгийн тухай хуулиар хариулт 4 минут, шаардлагатай тохиолдолд нэмэлтээр 1, 1-ээр 2 удаа өгөх боломжтой гэсэн дэгийн заалт байгаа. Ингээд Жавхлан сайд төсвийн тодотголын асуудлаар.

Б.Жавхлан: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Уг нь бид хөтөлбөр ярьж байгаа. Хөтөлбөр дотор энэ төсвийн тодотголын асуудал ерөөсөө огт байхгүй байгаа. Үдээс хойш төсвийн тодотгол ярьж эхэлнэ гэж ойлгож байгаа.

Гэхдээ гишүүн асуусан учраас би мэдээлэл өгье. Ийм байдаг. Төсвийн тухай хуулийн 56.2.2 дээр тэр томъёолол гэж байгаа чинь хуульчилчихсан зүйл. Таны ярьж байгаа Баярцогт сайдын тэр зүйл чинь бол би хууль гэж ойлгохгүй байна. Та бид 2 энд хууль санаачилж, хууль мөрдүүлэх үүрэгтэй орж ирж байгаа хүмүүс. Тийм учраас хуулийн дагуу 2013 оноос хойш Монгол Улсын төсөв яг ингэж явж байгаа. Одоогоор 6 аймаг орлого төвлөрүүлдэг юм. Тэрний нэг аймаг нь Өмнөговь аймаг. Бусад аймгууд дээр таны ярьж байгаа шиг ийм асуудал гардаггүй. 56.2.2 дээр юу гэж байдаг вэ гэхээр доод шатны төсөв хэрвээ ашигтай гарвал суурь зардлынх нь 70 хувийг нь үлдээгээд, бусдыг нь дээд шатныхаа төсөв рүү төвлөрүүлнэ гэсэн ийм хуультай. Цаашидаа ч энүүгээрээ явах юм байгаа юм.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд дулааны 50мвт-ын дулааны станцын асуудал.

Б.Чойжилсүрэн: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний яам Өмнөговь аймагт баригдах энэ 50мвт-ын ДЦС-ын төслийг дэмжиж байгаа Аймгийн, орон нутгийнхаа төсвөөр хэрэгжүүлнэ гэсэн ийм зүйлүүд ярьж байгаа. Ирэх жилүүдэд энэ асуудал шийдэгдэх болов уу гэж найдаж байгаа.

Д.Амарбаясгалан: Учрал сайд. Алтаниширээгийн газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын үйл явцын талаар.

Н.Учрал: Үйлдвэр технологийн паркууд бол бас хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр явагддаг. Тэгэхээр Үйлдвэр технологийн паркийн эрх зүйн байдлын хуулийг бол бид дахиж оруулж ирж өөрчлөх шаардлагатай байгаа. Тэгэхээр энэ талаар үйл ажиллагааны хөтөлбөрт орсон. Алтаниширээтийн үйлдвэр технологийн паркийн хувьд бол хувийн хэвшлийн санхүүжилтээр хийгдээд явж байгаа. Шаардлагатай хэд хэдэн журам гаргах ёстой юм байна лээ. Тэгээд энэ асуудал дээр бол дэмжлэг үзүүлнэ.

Д.Амарбаясгалан: Сая газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын талаар асуух шиг болсон. Туваан сайд газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалт. Дээрээс нь Атомын цахилгаан станц, ураны төслийн талаар.

Ц.Туваан: Газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалт бол явагдаж байгаа. И Пи Си 1, 2, 3, 4 гээд 4 багц ажлын хүрээнд явагдаж байгаа. 1 дүгээр ажил бол улсын комисс ажиллаад хүлээж авах шатдаа явж байгаа. 2, 3 дугаар ажил бол бас энэ 2 улсын банк хоорондын асуудал дээр бас нэлээн ярих асуудлууд байгаа. Энэ Орана-тай холбоотой асуудал дээр атомын цахилгаан станцын асуудлыг бол энэ удаагийн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт оруулсан байгаа. Ганцхан бид нар энэ Зөөгч овоо төсөл дээрээ ураны олборлоод, экспортлох биш, үүнийгээ дагалдуулаад бас бидний Монголчуудын тулгамдаад байгаа асуудал болсон энэ утааны асуудлыг шийдвэрлэх АЦС-тай болно гэдэг асуудлыг бол зэрэгцүүлж тавиад явж байгаа гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Мөнхбаясгалан гишүүн хариулт болсон уу. Жавхлан сайд нэмж хариулъя.

Б.Жавхлан: Ингээд 56.2.2-оор суурь зардлынх нь 70 хувийг нь тухайн аймагт нь үлдээгээд, тэгээд үлдсэнийг нь дээд шатынх нь төсөв рүү нь төвлөрүүлдэг ийм хуультай юм Мөнхбаясгалан гишүүн ээ. Тэгэхээр одоо Өмнөговь аймгийн суурь зардал нь 76 тэрбум, үүний 70 хувь гэхээр 52 тэрбум төгрөгийг үлдээгээд, бусдыг нь дээд шатын төсөв рүү төвлөрүүлнэ. Эрдэнэт ч гэсэн ингэж явдаг. Том бүтээн байгуулалт, уул уурхайн орлого төвлөрүүлдэг бүх аймгууд ингэж явж ирсэн. Энэ хуулиараа л явна.

Тэр цахилгаан станц дээр харин нэг юм хэлье. 50мвт гэж байгаа юм. Одоо жишээ нь бид нар Дорнодод 50мвт-ыг 82 сая доллар буюу одоогийн ханшаар 260 тэрбум төгрөгөөр бүтээн байгуулаад дуусчихсан. Гэтэл Өмнөговь аймаг дээр 50мвт болохлоор ирүүлсэн санал нь 412, зөвхөн анхны ТЭЗҮ, зураг төсөв байхгүй. Магадлангаар орсон зүйл ч байхгүй. Бэлтгэл ажил хангагдаагүй байгаа гэсэн үг. Одоо 9 сарын 1-нд бид нар төсөв өргөн барина. Үүнээс өмнө би Сэддорж даргад хэлсэн. Танай төсөв яг эцэслээд, магадлангаар орж ирвэл салбарынхан сайдтай хэдүүлээ сууж ярилцаад төсвийн ямар.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

М.Энхцэцэг: Сайн байцаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ хамтарсан Засгийн газрын нэг тэргүүн зорилт бол эрчээ алдсан эрчим хүчний салбарыг сэргээх, эрүүл эрчим хүчний салбар бий болгох гэж байгаа. Өнөөдөр Ерөнхий сайд маань илтгэлдээ бас энийг дурдаж байна. Тийм учраас өнөөдөр бид нарын хэлэлцэж байгаа энэ мөрийн хөтөлбөр маань бид нарын хүсэн хүлээж байгаа энэ зорилтод хүргэх үү. Үнэхээр бид нарын одоо хүсээд байгаа эрүүл эрчим хүчний салбарыг бий болгох уу гэдэгт бид нар хариу өгөх ёстой гэж би ингэж бодож байна.

Ингээд мөрийн хөтөлбөрт тусгагдсан байгаа эрчим хүчний салбартай холбоотой асуудлуудыг судалж үзсэн. Эндээс ерөнхийдөө ийм 2 дүр зураг харагдаж байгаа. Ямар ч байсан эрчим хүчний эх үүсвэрүүдийг бол нэлээн олноор барих юм байна. Эх үүсвэрийн дутагдлаас гарах юм байна. Үнэ, тарифын хувьд бол зохих түвшинд нь хүргэх юм байна гэсэн ийм 2 дүр зураг харагдаж байгаа. Тэгэхээр энэ 2-ыг хэрэгжүүлснээрээ бид нар үнэхээр тэр хүсэн хүлээгээд байгаа эрүүл эрчим хүчний салбарыг бий болгож чадах уу гэдэгтэй бид нар өнөөдөр бас тодорхой хариултыг өгөх ёстой байх гэж ингэж би бодож байна.

Эрүүл эрчим хүчний салбар гэж бид нар юугаа хэлж байгаа юм бэ. Эрчим хүчний эрүүл салбарын наад захын зарчмууд буюу наад захын зорилтууд, бизнесийн хүнд суртлаас бид нар өнөөдөр салж чадах юм уу. Улс төрийн хараат байдлаас бид нар гарч чадах юм уу. Хэрэглэгчээ дээдэлж чадах юм уу. Ашиг алдагдал, зардлаа бид нар хянах системээ сайжруулж чадах юм уу. Үйлчилгээнийхээ чанарыг дээшлүүлж чадах юм уу. Энэ бол эрүүл эрчим хүчний салбарын энгийн, наад захын зорилтууд байх гэж бодож байна. Тэгэхээр өнөөдөр бид нар энэ 4 жилийн дараа энэ хэдэн зорилтуудад бүр 100 хувь хүрдэггүй юм гэхэд энэ зорилтод бага зэрэг ойртсон байх ёстой байх гэж бодож байна. Тэгээд бид нар эрчим хүчний реформыг 2001 онд хэрэгжүүлсэн. Вашингтоны зөвшилцөл гээд реформыг. Тэгээд энэ реформ маань маш олон улсад бол гарцаанд орсон өнөөдөр Монгол Улсад ч гэсэн мөн гацаанд орсон. Тийм ч учраас өнөөдөр бид нар эрчээ алдсан эрчим хүчний салбар гээд дуудуулаад зогсож байна. Гэхдээ өнөөдөр бид нар улс төрийн хувьд маш таатай ийм 4 жилийг бол хүлээж байна.

Тэгэхээр энэ таатай энэ улс төрийн энэ орчинд бид нар өнөөдөр яг л эрүүл эрчим хүчнийхээ салбарыг бий болгох тэр одоо хөтөлбөрийг боловсруулах ёстой л

гэж ингэж бодож байна. Тэгэхээр өнөөдөр бид нар эрчим хүчний реформыг хийх юм уу. Тэр Вашингтоны зөвшилцөл эрчим хүчний реформ гацаанд орчихжээ. Тэгвэл одоо орчин үед бусад улс орнууд ямар реформыг хэрэгжүүлээд байгаа юм. Тэрийг бид нар хийх ёстой юм уу, хийх ёсгүй юм уу. Энэ мөрийн хөтөлбөр дээр харахад энэ мөрийн хөтөлбөрийг бас төрөл төрлөөр нь ингээд ангилаад, шинжлээд үзэхэд эрчим хүчний салбарын бодлоготой холбоотой заалтууд бол маш ховор тусгагдсан байна. Үнэ тарифтай холбоотой, эрчим хүчний дүрэмтэй холбоотой, цахилгаан хангамжийн аюулгүй байдалтай холбоотой гэсэн хэд хэдэн асуудлууд тусгагдсан байна. Гэтэл эрчим хүчний реформтой холбоотой эрчим хүчний хуулийг шинэчлэхтэй холбоотой, өөрчлөлт оруулахтай холбоотой ямар ч заалтууд тусгагдаж орж ирээгүй байна гэж би ингэж харж байна. Тэгэхээр энэ талаар бас хариулт өгнө үү гэж хүсэж байна.

Мөн бид нар нэг арга барилаасаа бас цаашидаа жоохон татгалзах хэрэгтэй гэж би бас бодож байгаа. Магадгүй энэ маань бид нарын хөгжилд саад болж байгаа нэг асуудал байх. Юмыг ингэж бөөрөнхийлдөг, юмыг ингээд ерөнхийд нь тусгадаг хууль сайжруулна. Боллоо. Үнэхээр тэр хууль сайжруулснаар бид нар өнөөдөр реформ хийх гээд байгаа юм уу. Тэгэхээр ингээд жоохон точки хандвал яасан юм бэ гэж ингэж бодож байгаа. Тэгэхээр эрчим хүчний реформыг хийнэ гэдэг, эрчим хүчний хуулиа шинэчлэн сайжруулна гэсэн ийм заалтууд тусгаж оруулж ирвэл зүгээр юм биш үү гэсэн ийм асуултыг бол Эрчим хүчний сайддаа тавья гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Засгийн газраас Алсын хараа 2050-ыг хэрэгжүүлэх Үндэсний хороо байгуулагдсан. Дэд хороог Шадар сайд Доржханд ахалж байгаа юм байна. Тэгэхээр Доржханд Шадар сайд эхний асуултад хариулаад, тэгээд салбарын сайд бас нэмж хариулъя. Шадар сайд Доржханд.

Т.Доржханд: Бярлалаа. Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Зөв зөв. Би Энхцэцэг гишүүнтэй бол маш их санал нийлж байгаа. Тэгээд одоо яг бид нарын хүлээгдээд байгаа маш том реформ бол яг эрчим хүчний салбарт бол хийгдэх учиртай. Маш олон том бүтээн байгуулалтын төслүүд яригдаж байгаа. Энийгээ бид нар санхүүжүүлнэ гээд өнөөдөр ингээд Засгийн газраас оруулж ирж байна. Үүний суурь нь юу байх юм бэ гэдэг дээр эрчим хүчний нийлүүлэлтээ бид нар тавьж өгөх ёстой. Үүний тулд бол хууль, эрх зүйн орчныг нь бол тарифыг бол үе шаттайгаар шинэчлээд явах нь зүйтэй юм байна. Хажуугаар нь эх үүсвэрийн нээлтүүдийг бий болгох юм байна. Ногоон эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр гадна, дотнын хөрөнгө оруулалтуудыг дэмжсэн ийм зоригтой прагматик бодлогуудаа явуулъя гээд. Яг энэ хүрээндээ бол Засгийн газар дээр бол нэгдсэн тохиролцоонд хүрээд тэгээд мөн Улсын Их Хурал дээр сууж байгаа экспертүүдээ бас төлөөллүүдийг нь оруулаад явъя гэж байгаа. Тэгэхээр яг энэ асуудлаар бид нар Эрчим хүчний яам дээр маргааши 11 цагт уулзалт хийгээд, яг проблемуудаа тавьж байгаад тэгээд шийдлүүдээ ингээд яриад явъя гэсэн байдлаар ажил руугаа орж байгаа. Тэгээд энэ ажлын хэсэгт бол Энхцэцэг гишүүн орсон байгаа. Тэгэхээр та бас маргааши энэ асуудлуудаа, бодитой саналуудаа бол оруулж ирээд тэгээд хамтдаа шийдээд явахад бол бэлэн.

Одоо энэ том хөрөнгө оруулалтууд хаана орж ирэх вэ гэхээр эрчим хүчний салбарт л юм билээ. Тэгээд яг энэ цаг хугацааны ийм бас нүх, цонх онгойчихсон байгаа энэ мөчийг бид нар маш зөв ашиглах ёстой. Тэгэхээр үнийн реформ тарифын реформ тэгээд дээрээс нь хууль, эрх зүйн орчны асуудлыг намрын чуулган дээр бид нар бол оруулж ирээд хурдтай шийдээд явна гэсэн ийм хүлээлттэй байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд нэмж хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбар сүүлийн жилүүдэд амаргүй байгаа нь үнэн. Манай эрчим хүчний хэрэглээ жилдээ дунджаар сүүлийн жилүүдэд 7 орчим хувиар нэмэгдэж байгаа. Энергийн хувьд. Энэ дотроо 11, 12, 1, 2, 3 дугаар сарууд дээр оргил ачааллын үед бүр 11,8, 12 хувьтай өсөж байгаа. Ийм учраас чадлын дутагдалд орсон, эх үүсвэрийн дутагдалд орчихсон байгаа нь үнэн. Мөрийн хөтөлбөр дээр ямар ч байсан бид нар Алсын хараа 2030 гэдэг энэ хүрээнд 2030 он.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж минут өгье.

Б.Чойжилсүрэн: 2030 он хүртэлх манай эрэлтийг бид нар тооцож үзсэн. Мөрийн хөтөлбөр дээр суусан төслүүдийг хэрэгжүүлэх юм бол эрчим хүчний хомсдолоос 1 дүгээрт гарна.

2 дугаарт энэ бүх хөрөнгө оруулалтыг либералчлал хийхийн тулд хамгийн эхний алхам бол үнийг ямар ч байсан эхний ээлжид өртөгт нь хүргэх энэ арга хэмжээнүүдийг авна гэх мэт олон асуудлууд байгаа учраас тантай хамтарч ажиллахад бэлэн байна.

Д.Амарбаясгалан: Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Сайн байцаана уу. Дараа нь үг хэлэх боломж байгаа учраас асуултаа асуучихъя. 7 асуулт байна.

1 дүгээрт нь болохоор Хууль зүйн сайдаас энэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль дээр таслан сэргийлэх арга хэмжээг авахдаа аж ахуйн нэгжүүдийн дансыг нь хаагаад байгаа, үйл ажиллагааг нь хязгаарлаад байгаа. Тэгээд захирлуудыг нь барьж хорьж байж заавал хэргийг шийд хянаж шийдвэрлээд байгаа. Энэ дээр ямарваа

нэгэн жишээлбэл өөрчлөлтүүд орохоор төлөвлөгдөж байна уу. Энд нэлээн ерөнхийгөөр орчихсон байгаа учраас энэ заалтууд байгаа юу, үгүй юу. Тэгэхгүй бол яг энийг хэрэгжүүлж байгаа байгууллагууд нь бас яг энэ бизнесийн орчныг сайн мэдэхгүй учраас шууд л жишээлбэл дансыг нь хаачихаар бусад юм нь болчихдог юм шиг бас бодоод байгаа. Тэгэхээр энэ дээр бодитой өөрчлөлт гарахгүй бол үүнээс болоод компаниуд дампуурах хэмжээнд хүрээд байна.

2 дугаарт нь энэ мөрийн хөтөлбөр дээр их олон юмнууд дээр болохоор ашиглалтад оруулна. Тэгэхдээ зарим газар болохоор энэ үйлдвэрүүдийг хувийн хэвилийг дэмжинэ гэхчхэн байгаа. Энэ оруулна гэдэг нь өөрсдөө хийж оруулах эсвэл төсвийн хөрөнгө төрийн өмчит компаниудын оруулах юмыг хэлээд байна уу. Эсвэл энэ хувийн хэвилийг дэмжинэ гэдэг 2 өөр ойлголтууд яваад байна уу. Уг нь яг өөрсдөө хийхээр бол хийнэ. Хувийн хэвчлээр хийх гэж байгаа бол тэрийгээ тодорхой хэлчихвэл зүгээр юм шиг санагдаж байна. Энэ дээр бас хариулт хэлж өгөөч.

3 дугаарт нь боомттой холбоотой юмнууд дээр боомтууд дээр олон улсын боомт болох зайлшгүй бас шаардлага байгаа. Жишээлбэл, Ганц мод-Гашиунсухайт манай экспортын бүтээгдэхүүний гол бүтээгдэхүүнүүд гарч байгаа боомт. Экспорт хийхэд Хятадаар дамжаад транзит хийхэд энэ олон улсын боомт болохгүй бол 2 улсын боомт байгаа. Энэ дээр хийгдэж байгаа ажил байгаа юу гэдэг асуулт байна.

4 дүгээрт нь Аялал жуулчлал хариуцсан сайдаас энэ гадаадад сурталчилгаанууд хийж байгаа. Энэ дээр яг экспорттой холбоотой бүтээгдэхүүнүүдийг бас яг оруулсан агуулгыг нь оруулсан сурталчилгаануудыг хийх бололцоо байна уу. Тэгэхгүй бол аж ахуйн нэгжүүд маань бас энэ дээр бас том зах зээлийн эцсийн хэрэглэгчид хүрдэг

учраас зардлууд өндөр байгаад байна. Энэ дээр анхаараач.

Батлан хамгаалахын сайдаас хугацаат цэргийн албан хаагчийг бас энэ бүтээн байгуулалтад оруулахаар заачихсан байгаа. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас энэ хугацаат цэргийн албан хаагчаар жишээлбэл ажил гүйцэтгэвэл хүчээр ажил засгаас хийлгэж байгаа мэтээр авч үздэг. Тэгэхээр энэ экспортын бүтээгдэхүүнүүд нь хориг тавьдаг эрсдэл байдаг учраас шалтгаан болох вий дээ. Энийгээ бас хараарай. Ялангуяа манай гол экспорттой холбоотой бүтээгдэхүүнүүд дээр.

Эдийн засгийн сайдаас энэ зорилт түвшин дээр нэг хүнд ноогдох дотоодын бүтээгдэхүүнүүдийг 10 мянган доллар гээд тавьчихсан байна. Тэгэхээр GDP төгрөгөөр болохоор 6,5, 7 гэсэн мөртөө буцаад ингээд энэ доллар GDP харахаар жишээлбэл 4 дахин илүү ийм өсөлтүүд байна. Энэ тоог аргачлалыг хэлж өгөөч.

Дараа нь сүүлийн асуулт нь Эрүүл мэндийн сайдаас энэ намын мөрийн хөтөлбөр дээр болохоор Элэг бүтэн Монгол гэж бас хөтөлбөр байсан. Тэгээд энийг сүүлд лавлахаар энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр байхгүй болчихсон байсан. Энийг халдварт бус өвчнөөс сэргийлэх хөтөлбөрт оруулж байгаа гэсэн байсан. Гэхдээ энэ чинь өөрөө халдвартай өвчин учгаас яг хаана нь орж байгаа юм бэ. Эсвэл Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг хассан юм уу гэдэг ийм 7 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Тэгье. Ерөнхий сайд эхэлж хариулаад, сайд нар нэмж хариулт өгнө.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээр хэрэгжихээр энэ төслүүдийн ер 15 орчим хувь нь л улсын төсвөөс санхүүжиж чадна. Бусад нь бол үндсэндээ хэрэгжих нь зүйтэй. Тэгэхийн тулд нийгмийн оролцогч талуудын идэвхжүүлэх ийм л аргачлалаар

хувийн хэвилийнхэнтэйгээ хамтарч ажиллая л гэж байгаа юм. Тийм учраас бид нар төр, хувийн хэвилийн түншилэл гэж ер нь 30 жил л бид нар ярилаа. Хувийн хэвшилээ дэмжинэ гэж 30 жил л бид нар ярилаа. Хөрөнгө оруулалтын орчноо сайжруулна гэж 30 жил ярилаа. Тэгээд энэ парламентад энэ ч агуулгаараа танхим, шинжлэх ухааны академи, үйлдвэрчин гээд ийм төлөөллүүд, бас экспертүүдийн төлөөлөлтэй орж ирсэн анхны ийм парламент болж байгаа. Тийм учраас би Засгийн газар дээр тодорхой чиглэлийг өгсөн байгаа. Алтангэрэл сайдад бас, Эдийн засаг, хөгжлийн сайдад. Одоо хэдүүлээ 1992 оноос авхуулаад хувийн хэвшил хөгжсөөд ингээд 30 жил боллоо. Зургаа ингээд бүтнээр нь хармаар байгаа юм. Яг хэдэн журам үнэхээр болохгүй байгаад байгаа юм бэ. Энэ журмуудаа бид нар яаж өөрчлөх юм бэ гээд. Жишээлбэл бид нар төр багасгана гэж байгаа. Тэгвэл Худалдаа аж үйлдвэрийн танхимаар дамжуулаад иууд тендерийн худалдан авалтыг хийх ийм гарц дээр танхим өөрөө бэлэн үү. Мэргэжлийн холбоодоор дамжуулъя гэж байгаа. Мэргэжлийн холбоонуудаар иууд дамжихад бэлэн байна уу. Тэгвэл 2025 оны улсын төсөв дээр энийг эхэлбэл боломжтой гэдэг байдлаар бас бид нар бол ярьж байгаа.

Төр бол өөрөө нэг институц. Хувийн хэвилийнхэн маань өөрсдөө бас яг нэгдмэл ийм институцийн хэлбэрт орох ёстой болж байгаа юм. Байр сууриа яг нэгдсэн байдлаар илэрхийлдэг. Түүн дээрээ асуудлуудаа бас ярилцдаг. Макро эдийн засгийн тоонууд дээрээ ярьдаг ийм агуулгаа ингээд гаргах нь зүйтэй.

Дээрээс нь энд бас шүүх засаглалын асуудлууд гарч ирнэ. Энэ дээр бас Алтангэрэл сайд ч гэсэн нэлээн юутай байж байгаа байх. Ихэнх энэ асуудлууд шүүхийн ил тод бус байдалтай холбоотой байгаа. Шүүх засаглал ил тод бус байдалтай байгаа хууль хэрэглэж байгаа асуудлууд нь ойлгомжгүй байгаа нөхцөлд бид нар хөрөнгө оруулалтын орчныг бас

зөвхөн хууль тогтоох, гүйцэтгэх засаглал дангаараа бүрдүүлэх бас хялбар биш. Тийм учраас энэ бүх асуудлуудыг бид нар цогцоор нь аваад, магадгүй мэргэжлийн нэг тийм томоохон байгууллагуудын үнэлгээ гаргаад, ингээд хөрөнгө оруулалтын орчноо сайжруулж, эрх зүйн орчноо бүрдүүлэх чиглэлээрээ энэ мөрийн хөтөлбөрт тусаж байгаа бусад асуудлуудыг хэрэгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх нь бол зүйтэй юм гэдэг байдлаар орж ирж байгаа. Би сая бас үгэндээ ч бас онцолсон нь энэ. Тэгэхээр энэ дээр Их Хурлын гишүүдтэйгээ хамтраад нэлээн тийм хурдтай бас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн Шадар сайд Гантөмөр хариулъя.

Л.Гантөмөр: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Бид нар бол энэ дотоодын нийт бүтээгдэхүүний бодолт дээр 2 өөр аргачлал хэрэглээд байгаа юм л даа. Нэг нь бол бодит өсөлт гэдэг нэг аргачлал байгаа юм. Түүгээрээ бид нар энэ 6,5, 6 гэж гараад байгаа юм. Яагаад бодит өсөлт гэж юу хэлээд байна вэ гэхээр 2015 оны бараа бүтээгдэхүүний үнийг сууриа болгоод авчихдаг байхгүй юу. Тэр үнийг хөдөлгөдөггүй. Тэгэхээр манайд үйлдвэрлэж байгаа сүү, манайд үйлдвэрлэж байгаа нүүрс, манайд үйлдвэрлэж байгаа зэс, алт гээд энэ бүх үйлдвэрлэж бүтээж байгаа бүтээгдэхүүнийхээ үнийг 2015 он дээрээ очиж багцаалдаад байгаа юм. Тэгэхээр манай өсөлт бага, эдийн засаг бага харагдана. Нөгөө талдаа нэрлэсэн үнэ гэж байгаа. Тэр нь өнөөдрийн үнэ. Өнөөдөр алт хэд байна вэ, өнөөдөр нүүрс хэд байна вэ, энэ ондоо хэд байсан. Энэ үнээрээ бид нар 2028 онд бол 1 хүнд оногдож байгаа дотоодын нийт бүтээгдэхүүнээ 10.500 долларт хүргэнэ гэсэн ийм зорилттой. Эийгээ хэрэгжүүлэхийн тулд бол бидэнд хийх гэрийн даалгавар байгаа. Тэр гэрийн даалгавраа бид нар энэ хийх ажлын төлөвлөгөө гэж бид нар энийгээ баталж байгаа юм. Энэ ажлууд хийгдэхгүй бол

бидний энэ хүсээд байгаа тоо бол мөрөөдөл болж хувирна. Жинхэнээсээ. Тэгэхийн тулд одоо бид нар гол зүйл бол экспортыг ерөөсөө алдаж болохгүй. Экспортын хэмжээ жил болгон 10-14 хувиар өсгөж явах ёстой. Үүний төлөө бид нар тэр хилийн боомтуудыг хийж дуусгах хэрэгтэй. Тэр дамжих логистикийн асуудлуудаа шийдвэрлэх хэрэгтэй. Энэ Хятад, Оросыг холбосон дэд бүтцийг бид нар барьж байгуулах учиртай. Энэ дээр ямар хөрөнгө дайчлах вэ гэдгийг яг үйл ажиллагааны хөтөлбөр дээр бүгдийг нь тодорхой оруулаад ирэх боломж бол бидэнд бас мөхөс байна. Төслийн санхүүжилтийн хэд хэдэн хувилбар байна. Санхүүжилт өөрөө бол нэг талаас гарна гэдэг ойлголт бас алга байна. Төсвөөс хэд байх юм. Одоо Олон улсын байгууллагын буюу дэлхийн хөрөнгө оруулагчдын, банк санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулалт хэдэн хувьтай байх юм. Дээр нь төсөл хэрэгжүүлэгч өөрөө ямар хэмжээний хөрөнгө гаргах вэ гээд. Ингэхээр төр, хувийн хэвшлийн аль нь хийх юм бэ гэхээс илүү түншилэл өөрөө их олон өндөр түвшинд явна гэж та бас ойлгоорой.

Дээр нь бол өнөөдөр бид нар үйл ажиллагааны хөтөлбөрөө баталж байгаа. Үүний дараа Засгийн газар өөрөө төлөвлөгөөгөө батална. Тэр төлөвлөгөө дээр нэлээн нарийвчилж төсөл хөтөлбөрүүд эзэн биетэйгээ ороод суугаад явах юм шүү гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл сайд нэмж хариулах уу. Алтангэрэл сайдад нэмэлт минут өгье. Алтангэрэл сайдын микрофоныг өгье. Манай энэ техникийн хүмүүс яав. Алтангэрэл сайдын микрофоныг нэг минутаар өгье.

О.Алтангэрэл: Тэгээд маш товчхон нэмэлт тайлбар хийчихье. Ерөнхий сайдаас бол үүрэг өгсөн. Энэ хувийн хэвшил хүний эрхийг хангах чиглэлээр тодорхой алхмууд хий, судалгаа гарга гээд. Тэгээд ер нь бол өнөөдөр ингээд

журмаар зохицуулж байгаа болон хуулиудаар зохицуулж байгаа олон зүйлүүд байгаа. Тэр тусмаа журам их байна гээд өчигдөр чуулганы нээлтийн үеэр Амарбаясгалан даргын үгэнд гарсан. Бид нар энэ дээр бол тодорхой ажлууд хийж байгаа. Ингээд албан тушаалтнаас хамааралтай журмаар зохицуулдаг харилцаа их байгаад ирэхээр энэ албан тушаалтны үзгийн үзүүр эрх мэдэлтэй холбоотой аж ахуйн нэгж, байгууллагуудад хүндрэл учраад байна. Зөндөө олон байдлаар эрх нь хэн нэгэн эрх мэдэлтний үзгийн үзүүрээр шийдэгдэж байгаа ийм зүйлүүд байна. Нөгөө талаар аж ахуйн нэгж, байгууллагуудын дансыг хаалаа гэдэг асуудал хувийн хэвшлийн зүгээс маш их тавьж байгаа. Тэгээд яг хаана, хэчнээн аж ахуйн нэгжсийн ямар хэмжээтэй дансыг хаагаад энэ талаар статистик нэг мэдээлэл ирүүлээч гээд яг хүсэлт тавьсан аж ахуйн нэгжүүдэд хэлэхээр ийм статистик мэдээлэл бас сайн ирүүлэхгүй байгаа. Тэгээд бид бас Худалдаа аж үйлдвэрийн танхимтай нэн ялангуяа хөрөнгө оруулалт болоод бизнесийн эрх зүйн орчны чиглэлээр хамтарч ажиллах өргөн хүсэлтэй байна. Өнөөдөр Хууль зүйн яаман дээр боловсруулалтын шатдаа явж байгаа хувийн эрх зүйтэй холбоотой 10 гаруй хуулийн төсөл байна. Нэлээд эртнээс хийсэн. Энэ болгон дээр бизнесийн төлөөлөл оролцоод өөрсдийнхөө ашиггүй тусгуулаад явж болно. Тэгээд данс хаах асуудал бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хаагдаж байгаа нэг асуудал байна. Иргэний процесс буюу иргэд, аж ахуйн нэгж хоорондын аж ахуйн нэгжсийн маргааны түвшинд хаагдаж байгаа байдал байна. Дахиад татварын байгууллагатай холбоотой ийм хаагдаж байгаа асуудал байна. Тэгэхээр хаана ямар асуудал байна. Хаана төрийн хөрөнгө оролцоо их байна. Хаана энэ аж ахуйн нэгжүүдийн эрх ашиг зөрчигдөөд байна гэдгээ бид нар харах цаг болчихсон.

Гадаадын хөрөнгө оруулагчидтай холбоотой маш олон тийм муу түүхүүд

байна. Монгол Улсын шүүхээр шийдвэрлэдэг. Эрх ашгаа хангуулъя гээд шүүхийн шийдвэр гаргахаар, гарсан шүүхийн шийдвэр нь биелэгддэггүй гээд өнөөдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэр дээр ирчихсэн маш олон гадаадын хөрөнгө оруулагчидтай холбоотой гомдол байна. Тэгэхээр бид нар энэ эдийн засгаа хөгжүүлнэ, хөрөнгө оруулалтаа татна гэдэг бол зөвхөн эдийн засагчдын бөгөөд энэ санхүүгийн салбарынхны хийх ажил биш юм. Гарцаагүй энэ хууль, эрх зүйн шинэтгэл тэр дундаа одоо ярьж байгаа нь авлига, хүний эрхтэй холбоотой өөрчлөлтүүд хийж үүнд нь хувийн хэвшил өөрсдийнхөө саналыг тусгаж манлайлах үүрэгтэй оролцож байж тал талд анхаарч байж шийдэгдэх ёстой асуудал гэдгийг ойлгож байгаа. Тийм ч учраас энэ хөтөлбөрийн 4.1.3.3-д энэ иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоотой зөвшилцөл саналыг нь авах байдлаар асуудлаа шийдвэрлэнэ гэсэн байгаа. Бид цаашдаа хувийн эрх зүйн хууль тогтоомж аж ахуйн нэгж, байгууллагуудтай холбоотой бусад хууль тогтоомжийг боловсруулахдаа энэ мэргэжлийн холбоод, мэргэжлийн байгууллагуудынхаа саналыг тусгаж ажиллана.

Д.Амарбаясгалан: Тулга сайд нэмж хариулъя.

Б.Тулга: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Гацуунсухайт боомт бол манай экспортын бүтээгдэхүүний хамгийн гол ачаалал авч байгаа боомтуудын нэг. Одоогийн байдлаар ганцхан 7 хоногийн бүтэн сайнд амардаг. 8-20 цагийн хооронд уртасгасан цагаар үйл ажиллагаа явуулж байгаа. Олон улсын болох асуудлыг өнгөрсөн жил хилийн комиссын менежментийн хурлаар Хятадын талдаа хэлэлцээр, уулзалт хийх үеэр албан ёсоор тавьсан. Одоогийн байдлаар Хятадын талаас энэ дээр хариу өгөөгүй байгаа. Энэ жил хилийн комиссын хурал мөн Улаанбаатар хотноо зохион байгуулагдах ёстой. Тэгээд энэ дээр бас

дахин энэ асуудлыг тавья гэсэн ийм зорилготой ажиллаж байгаа. Ер нь ялангуяа энэ төмөр замаар холбогдож байгаа, төмөр замын бүтээн байгуулалт явагдаж байгаа, цаашдаа транзит тээврийн гол урсгал болох энэ боомтуудыг олон улсын болгох чиглэлээр горимыг нь ахиулах чиглэлээр Боомтын Үндэсний хороо бас ажиллаж байгаа гэдгийг танд хариулъя.

Д.Амарбаясгалан: Аялал жуулчлал, батлан хамгаалах, эрүүл мэндийн салбар 3-аас бас асуулт асуусан байгаа. Хариулах хүн байна уу. Эрүүл мэндийн Төрийн нарийн бичгийн дарга Очирбат индэр дээрээс хариулна. Микрофон байна уу. Дугаар байгаа юу. 2 дугаар индэр.

Д.Очирбат: Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Очирбат хариулж байна. Гишүүний асуултад хариулъя. Үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.3-д эрүүл мэнд, эрүүл шүд, хорт хавдраар урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох халдварт өвчнөөс сэргийлэх, мөн Эрүүл Монгол хөтөлбөр гэж хэрэгжүүлнэ гэж заасан байгаа. Та түрүүн асуусан Элэг бүтэн Монгол хөтөлбөр яагаад зогсчхов. Энэ цаашдаа санхүүжилт нь олгодог Д вирус, С вирусийн санхүүжилт зогссоноор энд олгодог эмийнх нь санхүүжилт зогсчих юм болов уу гэсэн ийм асуултауд их ирдэг. Тэгэхээр бид өнгөрсөн жил 12,5 тэрбум төгрөгийн шууд худалдан авалтыг АНУ-ын Гляс Сайнс гэдэг компаниас хийсэн. Энэ жил дараа жилийнхээ төлөвлөлтөд бид 20-иод тэрбум төгрөгийн шууд худалдан авалтыг С болон Д вирустэй иргэддээ зориулж худалдаа хийхээр төлөвлөөд байгаа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд Гантөмөр нэмэлт асуултад хариулъя. 1 минут.

Л.Гантөмөр: Ер нь бол Энхтүвшин гишүүний хэлж байгаа саналыг бид нар ажил хэрэг болгоно. Тэр шүүхийн шийдвэргүйгээр данс хаадаг, барьдаг

юмыг бид нар үр таслан зогсоох хэрэгтэй. Дээр нь бол өр төлбөртэй хүн гадагшаа, дотогшоо явж болдоггүйг ч гэсэн болиулах хэрэгтэй. Дампуурлын хуулийг их тодорхой болгох хэрэгтэй. Хүн бизнес хийгээд, ажил хийгээд алдаа гаргасныхаа төлөө насаараа шийтгүүлдэг юм байж болохгүй шүү дээ. Энийг бол яг хэдүүлээ ойрын үед шийдээд явах учиртай. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс ирсэн гомдлынх нь тоо 82 байгаа юм байна лээ. Тэгээд ингээд шийдэгдсэн нь болохоор 18, хүлээгдэж байгаа гомдол нь 64 байгаа. Тэгэхээр гомдол байгаа байхгүй юу. Тэгээд бид нар бол энийг мэдээгүй юм шиг, хараагүй юм шиг явж ерөөсөө болохгүй. Маш ил тод, нээлттэй яриад хөрөнгө оруулагчдынхаа асуудлыг тодорхой шийдэж чаддаг улс орон болох ёстой гэсэн ийм зорилттой байгаа.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн хариулт болсон уу. Батлан хамгаалах яамны төлөөлөл байна уу. Гэрээт цэргийн албатай холбоотой асуулт асуусан байгаа. Алга байна. Аялал жуулчлал. Ерөнхий сайдад төлөөлж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Энэ зөв зүйтэй асуудал л даа. Гэхдээ бид нар яах вэ, энийг ярьж байгаад, тэгээд яг шалгуур үзүүлэлт ямар байх вэ гэдгээ сайн ярилцаад л явчих л ёстой зүйл л дээ. Энэ нөгөө цэргийн албан хаагчдаар том бүтээн байгуулалтад оролцуулаад байгаа ийм асуудлууд байдаг. Яах вэ, нэг талаасаа харахад бол үнэхээр л хүний нөөцийн хувьд ч тэр яг батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчин орж байгаа төслүүд бол хурдтай явсан. Ийм хэд хэдэн тохиолдол гарсан нь бол бодитой. Төмөр замын хэд хэдэн төсөл дээр. Олон улсын байгууллага талаасаа энэ бол бас хөдөлмөрийн мөлжлөг гэж харах ийм эрсдэл байх ийм эрх зүйн орчин байгаа юу. Байгаа. Тэгэхээр энийг явал олон улсын байгууллагатай илүү зөв байх вэ, явал бас цэргийн албанд байгаа нөхдүүдийн маань хувьд илүү эрх зүйн орчиндоо

нийцэх үү гэдгийг аваад явчхаж бол болно. Тэгэхээр би тэмдэглээд авчихлаа.

Д.Амарбаясгалан: Энхтүвшин гишүүн тодруулга 1 минут.

Д.Энхтүвшин: Саяынх бол зүгээр эрсдэл. Манай экспортын гол бүтээгдэхүүн уул уурхайн бүтээгдэхүүн. Тэгээд дэд бүтэцтэй холбоотой эрсдэлүүд нь өөрөө төрөөс албадан хөдөлмөр хийлгэсэн гэдэг олон улсын хөдөлмөрийн байгууллагын энэ жишгээр тооцогдоод, энийг нь нэгдсэн байгууллагууд жишээлбэл шалтаг болгоод манай экспортын бүтээгдэхүүнд бас эрсдэл үүсэх вий дээ гэдэг санаагаар хэлсэн.

Түрүүн Алтангэрэл Хууль зүйн сайд дээр болохоор бас тоо асууж байна. Угаасаа нээлттэй. Одоо жишээлбэл Монполимет гэж компанийн асуудал бол ингээд сошиал дээр ил ингээд л байж л байна. Тэгэхээр яах вэ, заавал тоо асууна гэхээсээ илүү энэ чинь өөрөө нийтлэг байгаа учраас Гантөмөр сайд бас түрүүн нэлээн дэлгэрүүлж тодорхой хариуллаа. Тэгэхээр энэ бизнесийн маргаан, хэрэг шийдэхтэй холбоотой процесс дээр өөрөө их нөгөө төвөгтэй харилцаанд ордог. Бэлтгэн нийлүүлэгч, харилцагч, нэг хувьцаа эзэмшигч биш олон хувьцаа эзэмшигч нар байна. Эдийн засгийн харилцаанд орж байгаа юмнуудыг нь зогсоочихоор үйл ажиллагаа явуулах боломжгүй болчихоод байна л даа. Ялангуяа ийм хурдан өөрчлөгдөж байгаа үед бол. Тэгэхээр энийг заавал олон тоо гэхгүй яг ийм зарчмын асуудал байгаа учраас энэ дээр бас анхаарал тавих гэж байгаад баяртай байна.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал сайд нэмэлт хариулт өгье.

Н.Учрал: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 80 байгууллагаас ирсэн 1546 саналаас 1117 буюу 72 хувийг тусгасан. Үүнд Үндэсний

Худалдаа аж үйлдвэрийн танхим багтдаг. Тэгэхээр Энхтүвшин гишүүнээс би юу асуух гээд байна вэ гэхээр та ер нь танхимыг төлөөлөд байгаа юу Их Хурлын гишүүний хувиар яриад байгаа юу гэдгийг бас асуумаар байна. Яагаад гэхээр танхим 22 санал өгсөн юм. Тэр 22-ыг нь тусгасан. Гэтэл бүх саналыг нь ингээд тусгачхаад байхад өчигдөр Байнгын хороо дээр орж ирээд дэмжихгүй гээд байгаа. Тэгэхээр яг танхим төлөөлж байгаа хэвээрээ юу эсвэл Их Хурлын гишүүний хувиар ярьж байгаа юу гэдгээ нэг тодорхой болгохгүй бол нөгөө танаас авсан саналыг бид нар танхимын санал, аж ахуйн нэгжүүдийн санал гэж ойлгох юм уу, эсвэл ингээд Их Хурлын гишүүн яриад байна гэж ойлгох юм уу. Наадхаа нэг тодорхой болгож өгөөч. Яагаад гэхээр нөгөө танхимтай ажлын хэсэг маш их ажилласан байхгүй юу. Тэгээд байхаар танхимтай ажиллаад л санал тусгаад л ороод ирнэ. Энхтүвшин гишүүн маргааш шал өөр юм яриад л ороод ирэхээр энэ ойлголтоо нэг мөр болгохгүй бол.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн хариулах үүрэг хүлээхгүй. Ингээд асуултад хариулж дууслаа. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна. Энэ асуултаас өмнө бас ганц гаднын хөрөнгө оруулагч нарын хохирлоос гадна, дотоодын Засгийн газартай хамтарч ажиллачхаад шүүхийн шийдвэр нь гарсан мөртөө өнөөдрийг хүртэл өр төлбөрөө барагдуулж чаддаггүй аж ахуйн нэгжүүдийн асуудал байгаа. Тэгээд энэ аж ахуйн нэгжүүдийг жил бүр багахан хэмжээний төсөв тавиад, тэгээд Хууль зүйн сайдын шийдвэрээр хэнийх нь барагдуулах вэ гэдэг асуудал шийдэгдээд явдаг байгаа. Тэгэхээр энийг бас мөн адил зарчмаар ижил тэгш боломжоор хангаж шийдвэрлэх тал дээр бас анхаарах нь зүйтэй байх гэж бодож байна. Ингээд Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Баярлалаа. Эхний асуулт Ерөнхий сайдаас. Хөтөлбөрийн

4.4-д тусгагдсан үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх ба амар тайван нийгэм хэсэгт тусгагдсан зорилтуудыг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ энэ дээр зорилгыг хэрэгжүүлэх суурь нөхцөл нь үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал түүний эрх зүйн орчныг шинэчлэх чухал. Одоо шаардлага байгаа 14 жилийн өмнө батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зайлиггүй шинэчлэгдэх шаардлагатай геополитик орчны нөхцөл байдал бүх зүйл өөрчлөгдсөн байгаа. Энэ дээр та Засгийн газрын тэргүүний хувьд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүний хувьд бас яг энэ хөтөлбөртөө тодорхой ямар ажлуудыг хийх вэ. Хөгжлийн зургаа иж бүрэн дээр нь харья гэсэн. Мэдээж энэ нь бас аюулгүй байдалтай холбоотой сэдэв учраас детальчилж болохгүй байх. Гэхдээ энэ дээр яг ямар зүйл байна вэ.

2 дугаарт нь болохлоор Хууль зүйн сайдаас ер бид нарын энэ авлигын индекс гэдэг ойлголт чинь Трансперенси интернэйшналын индексээр ингээд жил болгон яваад байдаг. Манайх ухралттай яваад байгаа. Тэгээд хөтөлбөрийн төсөлд бол олон нийтийг авлигаас ангид байлгах гэсэн зүйл заалт харагдаж байгаа. Авлигын субъект нь олон нийт биш, албан тушаалтан гэдэг. Тэгэхээр энэ дээр яг тодорхой жишээлбэл, хэмжиж чадвал удирдаж чадна гэдэг шиг 2024 биш, 2025, 2026, 2027, 2028 он хүртэл авлигын индексийг тэдэн хувиар тэгж бууруулна гэсэн ийм детальчилж оруулах боломжтой юу. Арга зам.

3 дугаар асуулт. Эрдэнэбүрэн сайдаас дахиад л нөгөө хэмжиж чадвал удирдаж чадна гэдэг шиг энэ хоттой холбоотой асуудал дээр түгжрэлийн талаар нэлээн тодорхой заалтууд байгаа. Утааны асуудал дээр ер нь маш хийсвэр. Сүүлд тэр Тэргүүн Шадар сайдын үгэн дээрээс бүсчилсэн хөгжлийг утаатай холбож байгаа юм байна. Тэгж ойлголоо. Яг энэ утаа чинь өөрөө үндэсний аюулгүй байдал, өвчлөл, Үндсэн хуулиар эрүүл аюулгүй орчинд амьдрах заналхийлж

байгаа нөхцөл байдал болоод байгаа учраас энэ дээр яг тодорхой тоо, чанар тусгасан хэмжих нэгжтэй зүйл оруулж болох уу.

Дараагийн асуулт нь болохлоор Тэргүүн Шадар сайдаас 3 асуулт байна.

1 дүгээрт инфляцыг хязгаарлах макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах талаар хөтөлбөр тодорхой заалт, зорилтуудыг дэвшүүлсэн байна. Гэхдээ энэ хүрэн эдийн засаг буюу уул уурхайгаас хэт хамааралтай эдийн засгийг цаашид яаж жилээс жилд солонгоруулах вэ. Энэ дээр ямар нэгэн ийм нарийвчилсан заалт байж болох уу.

Дараагийн асуулт хөтөлбөрт Хөрөнгө оруулалтын тухай хууль болон бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа багц хуулиудыг шинэчилж, хөрөнгө оруулагчдын эрх зүйг хамгаалах ийм ерөнхий зорилтыг дэвшүүлчихсэн байгаа. Энэ бол сайн л даа. Гэхдээ яг саяын Их Хурлын даргын бас дурдаад байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, хувийн бизнесийн хөрөнгө оруулалтыг түлхүү нэмэгдүүлэх чиглэл дээр яг ийм тодорхой ийм зорилтууд байна уу. Ийм тунхгийн биш чанартай.

Дараагийн асуулт нь хөтөлбөрт банкны салбарын реформыг үргэлжлүүлнэ гэсэн байгаа. Бас ерөнхий байгаа. Арилжааны банкууд эрсдэл багатай хэрэглээний зээлд илүү тулгуурлаад, бизнесийн болон ипотекийн зээлээс зайлхийгээд байдаг. Болгоомжлох хандлагатай байдаг. Энэ хандлага амьдрал дээр иргэдэд төвөг, хүндрэл, бизнесийн орчныг өсөх боломжийг нь хязгаарлаад байдаг. Энэ дээр Засгийн газар хөтөлбөртөө тодорхой ийм рационал шийдвэр гаргах боломж байна уу.

Дараагийн асуулт нь татварыг ер нь цаашидаа бууруулах юм уу. Яг энэ дээр

тодорхой зүйлийг энэ зорилтдоо оруулчихвал бас сайн байна .

Дараа нь боловсролын сайдаас товчхон төрийн үйлчилгээний албан хаагчид, багш нарыг улс төрөөс хараат байдлыг багасгахад, халахад яг ямар ийм зохицуулалтыг энэ хөтөлбөрт оруулах гээд байна вэ. Энэ тодорхойгүй байна. Сургалтын байгууллагын орчны болон багш нарын чадавхын ялгааг арилгахад чиглэсэн тэр концепцоо энэ хөтөлбөрт оруулмаар байна.

Сүүлийн асуулт. Энх-Амгалан сайд. Хүүхдийн мөнгөний хөтөлбөрийг үргэлжлүүлнэ гээд ингээд ерөнхий заачихсан байгаа. Энийг бас хэмжих нэгжтэй болгомоор байна. Тэгээд хүүхдийн мөнгөөрөө амьдардаг эцэг эхчүүдийг тэр орлогын эх үүсвэр гэхээсээ илүүтэйгээр яг тухайн тэр хүүхдийн мөнгө нь хүүхдийнхээ өсөх, торних, боловсрох, мэдлэг боловсрол авах тэр чадваруудад нь хүргэхийн тулд ямар зохицуулалтыг энэ хөтөлбөр дээр хийх боломжтой вэ. Асууж дууслаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Үндэсний нэгдмэл үнэт зүйл бол Монгол Улсын иргэдийн бас ирээдүйн иргэдийн ямар үндэстэн байх дээр ямар үнэт зүйл дээр тулгуурлах вэ гэдэг энэ агуулгыг тусгасан ийм хэсэг. Алсын хараа 2050-ийн эхний бүлэг бол бас энэ байгаа. Одоо бид нар жишээлбэл боловсролын хөтөлбөрөөс авхуулаад л зарим нь япон школтай, зарим нь орос школтай, зарим нь англи, америк школтай, зарим нь хятад школтай гээд ингээд л дунд сургуулиасаа авхуулаад л бид нар үнэт зүйлийн хувьд өөр болчихож байгаа. Ингээд хот, хөдөөгийн ялгарал байна. Ингээд хөрөнгийн бас ялгарал үүсэж байна. Тэгэхээр энэ бүх зүйл маань өөрөө үндэсний нэгдмэл үнэт зүйлд нөлөөлөх хүчин зүйл болчих вий гэдэг энэ агуулга дээр энэ асуудлыг илүү яаж

цогцоор харах вэ, яаж Монгол эх оронч өрсөлдөх чадвартай ирээдүйн иргэнийг бэлдэх вэ гэдэгтэй холбоотой ийм агуулга тусгагдсан гэж ойлгож болно. Энэ бол соёлтой ч холбоотой бас ийм цогц ойлголт.

Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх гэдэг хэсэг бол өөрөө энэ геополитикийн нөхцөл байдал 4 улиралтай байгаа, далайд гарцгүй нөхцөл байдлын дунд Монгол Улс хэрхэн гэнэтийн давагдашигүй хүчин зүйлийг давж гарах вэ гэдэг ийм эрсдэлийн төлөвлөгөө гэж ойлгож бол болно. Энэ агуулгаараа бид нар энэ хөтөлбөрт адаглаад л бид нар шатахууны савтай болох талын юмыг тусгах хэрэгтэй. Хүнсний агуулах барих хэрэгтэй. Тэрийгээ гэхдээ бид нар заавал төр биш хувийн хэвшилтэйгээ хамтраад ингээд шийдээд явчих боломжтой. Эрчим хүч тасарвал яах вэ гэдгээ бид нар тооцох ёстой. Бензин шатахуунаа дотооддоо үйлдвэрлэх хэрэгтэй. Ковид шиг хил хаагдчихвал яах вэ гэдгээ тооцох ёстой. Энэ тохиолдолд бид нар хэрхэн хүнсний хангамж болон бусад асуудлыг шийдвэрлэх вэ гэдэг асуудал. Эмийн хангамжаа бас бид нар шийдвэрлэх хэрэгтэй. Стандартуудаа шийдвэрлэх хэрэгтэй. Нийслэл Улаанбаатар хотын аюулгүй байдал болон онцгой байдалтай холбоотой асуудал, гар утсанд мэдээлэл ирэхээс авхуулаад онцгой байдалтай холбоотой энэ асуудал дээр бид нар маш нарийн нягт ярилцах, нэг үгээр хэлбэл онцгой байдлын стратегиа бүтнээр нь харах ийм зайлишгүй шаардлага үүсчхээд байна. Нэг үгээр хэлбэл батлан хамгаалах салбараас салбар болон онцгой байдал, мэдээлэл солилцох чадвар эх оронч үзэл баримтлал болон үндэстэн нэгдмэл байдлаар эх орныхоо тусгаар тогтнолыг сонгож авсан хөгжлийнхөө үнэт зүйл болсон ардчилсан үнэт зүйлийг сөрөн тэсвэрлэж олон улсын геополитикийн давлагаанд аварч үлдэх нэгдмэл үнэт зүйлтэй холбоотой хэсгийг энэ 2 хэсэгт 2 хувааж оруулсан байгаа гэж хариулъя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хууль зүй, дотоод хэргийн сайд Авлигын индекс.

О.Алтангэрэл: Авлигатай тэмцэх стратегийн хувьд бол нэлээн шинэчлэл хийгдэнэ. Авлигын багц хуулийн төслийг өргөн барина. Тэгэхдээ энэ Трансперенси интернэйшнлийн гаргадаг авлигын төсөөллийн индексийн талаар түрүүнд нь энэ “5Ш” ажиллагааны хүрээнд нэлээн олон ажил хийж хэрэгжүүлсэн юм байна лээ. Эндээс үзэхээр бол авлигын индекс гэдэг бол зөвхөн хууль зүйн салбараас хамаардаггүй. Хууль зүйн салбарын дотоод хэргийн байгууллагуудаас хамаардаггүй ийм зүйл. Энд бол аж ахуй нэгжийн үйл ажиллагааны ил тод байдал, бусад их олон эрх зүйн зохицуулалт хамаардаг. Нэн ялангуяа өнөөдөр тэр 2700 журмаар зохицуулаад байгаа энэ харилцаа өөрөө хуулийн зохицуулалттай хүмүүс авлигад нөлөөлдөг юм байна лээ. Тэгээд тогтоолын 2 дугаар хавсралтаар энэ индексийг үзүүлэлт болгоод оруулчихсан байгаа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд Гантөмөр гишүүн хариулъя.

Л.Гантөмөр: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид нар бүрэн эдийн засаг дээр явж байгаа бол үнэн. Уул уурхайн эдийн засгийн орон гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Байгаа байдлаа сайн хүлээн зөвшөөрөх юм бол сайн зүйл рүү очиход одоо таны хэлдгээр хэмжисж чадвал удирдаж чадна гэдэг шиг нөхцөл байдлыг удирдах боломж бол бид нарт гарна. Тэгэхээр бид нар хэрхэн уул уурхайн эдийн засгийг давуу тал болгох вэ гэдэг ийм бодлогыг л үйл ажиллагаандаа анхааръя гэж байгаа юм. Боловсруулах үйлдвэрийнхээ хүчин чадлыг өндөр технологи ашиглаад яг энэ уул уурхайн салбараа дагасан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хийж чадах юм бол манай эдийн засаг жинхэнэ утгаараа барьцтай ийм эдийн засаг болно. Нөгөө талдаа ер нь технологи шингэсэн эдийн засгийг бий болгоё гэдэг ийм зорилтыг яг эдийн

засгийн тэлэлтийн бодлого дээрээ бид нар зарлаж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулах уу. Нэмэлт 1 минут.

Л.Гантөмөр: Надаас бас 4 асуулт асуучихсан. Би арай удаан яриад байх шиг байна. Уучлаарай. Ингээд энэ хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор бол бид нар энэ пассив технологи, яг дулааны алдагдалгүй сууц, дулааны алдагдалгүй барилга байшин гэдэг технологийг бид нар 1 дүгээр зэрэглэлийн технологи болгож дэмжиж явна гэсэн ийм зорилтыг дэвшүүлж байгаа шүү гишүүн ээ.

Банкны салбарт бол шийдэл гаргана. Бид нар олон жил ярьсан. Одоо олон улсын дэлхийн хэмжээний банкныг Монголд үйл ажиллагаа явуулах тэр боломж бололцоог бий болгож заавал хийх хэрэгтэй. Татварын реформ бол хийгдэнэ. Тэгэхдээ хугацаа гарна. Өнөөдөр яг ийм тийм гэж амлахад бол эрт байгаа. Энэ дээр бид нар бодлогын судалгаа хийнэ. Бүсчилсэн хөгжлийнхөө стратегийг их тодорхой бүс бүс дээр гаргана. Ингээд нэгдсэн.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Боловсролын сайд Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр боловсролын байгууллагыг улс төрөөс ангид байлгах асуудлыг бол хуульчлаад, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн шаардлага шалгуураа хангадаг ийм хуулийн, эрх зүйн орчин нь бүрдсэн. Өмнө нь бол Улсын Их Хурал болоод орон нутгийн сонгууль болгоноор сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчдийг хүртэл улс төрийн нөлөөллөөр сольдог. Аймаг сумдын Засаг дарга нар нь сонгуульд оролцсон хүмүүсийг шууд томилдог байсан явдлыг шинэ Боловсролын ерөнхий хуулиараа хязгаарлаж өгсөн байгаа. Их сургуулийн ректоруудыг хүртэл Удирдах зөвлөлийн дарга нь томилдог. Тэрнээс биш ийм төрийн байгууллагын зүгээс улс

төрийн нөлөөллөөр оролцох боломжгүй болгож ингэж хаасан байгаа. Цаашидаа ч энэ бодлогыг хэрэгжүүлж, энэ хуулийн заалтуудыг амьдрал дээр ягштал биелүүлэх нь чухал байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эрдэнэбүрэн сайд “20 минут хот” үндэсний хорооны дарга.

Р.Эрдэнэбүрэн: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Утааны асуудлаар тодорхой заалт оруулаагүй байна гэж байна. Хамгийн их тодорхой заалт оруулсан ийм төлөвлөгөө болсон. Яах вэ, утаа гээд бид нар хэдэн их наядоор нь үрсэн. Гэр дулаалж үзлээ, нүүрсээ сайжруулж үзлээ, тэгээд эцсийн дүндээ бол бид нар юун дээр бүгдээрээ санал нэгдэж байгаа вэ гэхээр яндан байхгүй болохгүй бол утаа бол байхгүй болохгүй юм байна гэдэг дээр бол санал нэгдэж байгаа байх гэж бодож байна. Тэгээд энэ удаагийн энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр дээр хоттой холбоотой хэсэг дээр хамгийн их инженерийн дэд бүтцийг байгуулъя гэсэн ийм үгтэй заалтууд орсон байгаа. Тэгээд ялангуяа энэ 1.1.3 дээр бол бүр яг тоогоор зааж, гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт дээр 20 мянган айлыг бол орон сууцтай болгоё. Тэр дэд бүтцийг нь хангаж өгье гэж ингэж заасан байгаа. Тэгэхээр энэ бол өөрөө цэвэр утааг байхгүй болгохын төлөө хийж байгаа бас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгөгдлөө. Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя. Дарж унтраагаад байх шиг байна. Одоо болсон.

М.Мандхай: Өдрийн мэнд. Би Хөдөө аж ахуйн сайд болон Боловсролын сайдаас асууя.

1 дүгээр асуулт нь болохоор хөтөлбөрийн 3.3.4 дээр 3.3.4.1 болохоор шинэ хоршоо хөдөлгөөнийг үргэлжлүүлж, чинээлэг малчин хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гээд үндсэндээ том 3

хөтөлбөрийг энэ 3.3.4-ийн малгайн доор хөтөлбөр доор тусгасан байсан. Гэхдээ ингээд шинэ хоршоо хөдөлгөөнийг зүгээр үргэлжлүүлнэ гээд орхичихсон. Тэгсэн мөртөө нарийн заалтуудаа болохоороо бусад нөгөө хүнсний хувьсгал болон цагаан алтын нарийн заалтуудыг тусгайлан ингээд дэлгэрэнгүй оруулчихсан байгаад байгаа юм. Шинэ хоршоо хөдөлгөөнийг болохоор зүгээр үргэлжлүүлээд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Тэгэхээр энэ 3.3.4.1 маань үндсэндээ шинэ хоршоо хөдөлгөөний чинээлэг малчин хөтөлбөрт заагдсан байгаа нарийн заалтууд нь бүгд хэрэгжинэ гэж ойлгох уу. Яагаад энийг ингээд ганцаарчилж оруулсан юм бэ. Эсрэгээрээ энэ дээр тусгайлан заасан цөөхөн хэдэн заалтууд байгаа. Тэрийг энэ хөтөлбөр дээрээ бас нарийвчилж бусад үндэсний хөтөлбөрүүдтэй нь адилхан оруулаач гэсэн саналтай байна.

2 дугаар асуулт болохоор 1.3.6 зүүн бүс түүхэн аялал жуулчлал, төрөлжсөн эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс гээд заасан байгаа. Энэ дээр 1.3.6.2 дээр Зүүн бүсийг эрчимжсэн Хөдөө аж ахуйн дэд бүсийн хувьд Хөдөө аж ахуйн экспортыг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдүүлнэ гээд маш тийм товчхон дурдчихсан. Энэ яг зүүн бүсэд яг юу хийнэ гэж төлөвлөж байгаа юм бэ. Хөдөө аж ахуйн экспортыг дэмжинэ гэхихсэн байгаад байдаг. Яг ямар төслүүд дээр энэ экспортыг дэмжих юм. Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ гэхээр ямар хөрөнгө оруулалтад ямар төслүүд дээр хөрөнгө оруулалт татаад, тэрнийхээ эрх зүйн орчныг сайжруулах гэж байгаа юм бэ гэдэг нь маш тодорхойгүй заалт байгаа учраас энийг нэг тайлбарлаж өгнө үү гэж хүсэж байна.

Боловсролын сайдаас юу асуух гэж байгаа вэ гэхээр хөдөө аж ахуйтай холбоотой маш олон одоо үндэсний хөтөлбөр бүтээн байгуулалтууд хэрэгжихээр заасан байгаа. Гэтэл энийг хэрэгжүүлэх гэж байгаа хамгийн гол одоо боловсон хүчинг хүний нөөц бол одоо яг энэ Хөдөө аж ахуйн мэргэжлийн

техникийн ажилчид байгаа. Зоотехникч, малын эмч, агрономич зэрэг. Тэгэхээр хөдөө аж ахуйн хэрэгжиж байгаа хөтөлбөртэй Хөдөө аж ахуйн яамтай Боловсролын яам яг энэ салбар дундын ямар уялдаа холбоотой ажиллах юм бэ. Тэгээд энэ хэрэгжиж байгаа хөтөлбөр дээр Боловсролын яам тусгайлсан программ гаргаж энэ боловсон хүчин, хүний нөөцөө бэлдэх үү. Үүнтэй холбоотой та мэдээллийг бас өгөөч гээд ийм асуулт асууж байна.

Хамгийн сүүлийн асуулт нь болохоороо Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн 2.1.1.23-д Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулна гээд заачихжээ. Энэ маань юу хэлж байна гэхээр манайх 2009 онд НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод бол нэгдсэн байдаг. Энийгээ бол үндсэндээ нэгдсэн байгаа заалтаа бид зөрчиж хэрэгжүүлэх гэж байна гэсэн үг. Яагаад гэхээр тусад нь төв болгоод барина гэдэг чинь ерөөсөө хөгжлийн бэрхшээлтэй болон энгийн иргэн 2-ыг тусгаарлаад тавьчихаж байна гэсэн үг л дээ. Тэгэхээр үүнийхээ оронд одоо байгаа тэр нийгэм, боловсрол, эрүүл мэндийнхээ үйлчилгээний хүртээмжийг тэлээд, ерөөсөө хөгжлийн бэрхшээлтэй болон энгийн хүмүүсийг нэг яг л үйлчилгээнд хамрагддаг, гаргаж байгаа үйлчилгээ автобус үйлчилгээ гэхэд л яг л бүгдэд нь энэ хүртээмжтэй байхаар бид нар хөгжүүлэх ёстой байтал ингээд тусгаарлаад тавьчихаар чинь бид нар ерөөсөө энэ олон улсын энэ конвенц Хүний эрх.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр асуултад хариулья.

Ж.Энхбаяр: Шинэ хоршоо хөтөлбөр улс орны хэмжээнд маш амжилттай өрнөж байгаа. Яг өнөөгийн байдлаар улс орны хэмжээнд 189,3 мянган малчин өрх дотоодын нийт бүтээгдэхүүний 11 хувийг үйлдвэрлэж байна. Мал аж ахуйн салбар.

47.500 малчин хоршиж 4.683 хоршоо өнөөдөр бий болчихоод байна. Үүнээс зээл нь судлагдаад нийт 442,6 тэрбум төгрөгийн зээлийг хоршоодын гар дээр нь очсон байна. Энэ бодлого цаашидаа 2025 ондоо мөн үргэлжилнэ. Жил бүр 500 тэрбумын түвшинд хоршоог дэмжих хөнгөлөлттэй санхүүжилт явагдана. 2025 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэл энэ арга хэмжээ үргэлжилнэ. Тэгэхээр энэ гол зорилго нь юу вэ гэвэл мал аж ахуйн гол суурь болсон малчдаа нэгдэж хөдөлмөрөөр нь хоршуулаад, нэг талдаа байгаль цаг уурын эрсдэлийг даван туулах чадавхыг бий болгох, 2 дугаарт энэ цагаан алт хүнсний хувьсгал, нэ томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд анхан шатны хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн үндсэн суурь бэлтгэлийг хоршоодоороо дамжуулж бэлдээд, үйлдвэрлэл хоршоо 2-ыг холбосноор дундын дамжлагагүйгээр чанартай үйлдвэр стандартад нийцсэн түүхий эд бэлтгэх том бодлого бас яваа юм. Нөгөө талаас малчдаа зайлиггүй хоршихоос өөр аргагүй байдал үүсээд байна. Байгаль цаг уурын өөрчлөлт, мал сүргийн бүтэц тооны хэт өсөлттэй холбоотойгоор бэлчээрийн даац маш хүндэрсэн байгаа. Улс орны хэмжээнд. Тэгээд зайлиггүй нүүдлийн мал аж ахуйд учирч болох эрсдэлийг хаахын тулд хөдөлмөрөөр нь хорших, шинэ арга ухаанд сургах, ялангуяа малын тэжээл, таримлыг тарьдаг, ургуулдаг тэр арга ухааныг энэ хоршооддоо нэлээн зааж чиглүүлэх шаардлага байгаа. Нийтдээ хоршоодын чиглэлээр 13, 14 төрлийн одоо үйл ажиллагааг яг бодлогоор дэмжиж, шаардлагатай хөрөнгө оруулалтын зээлүүдийг олгож байгаа.

Зүүн бүс өөрөө Монгол Улсын хөдөө аж ахуйн маш том үүц, нөөц. Ялангуяа Халх гол Дорнодын бүс нутаг байгаа. Энэ бүс нутгийг цэвэр экспортын зориулалтын ийм бодлогоор хөгжүүлнэ гэсэн хөтөлбөрт суусан байгаа. Энэ зорилтын хүрээнд зүүн бүсийг эрчимжсэн хөдөө аж ахуй, экспортын чиг баримжаатай хөгжүүлнэ гэж заасан байгаа.

Д.Амарбаясгалан: Боловсролын сайд Наранбаяр сайд хариулъя. Дарахгүй байж байгаарай.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлдэх энэ чинь шууд хүнс бэлдэхтэй холбоотой. Тэгээд сүүлийн жилүүдэд үнэхээр ингээд хорогдож байгаа нь би түрүүнд ч бас асуулт хариулахдаа хэлсэн. Одоо яг ингээд мэргэжлийн ангиудад 10 хүрэхгүй хүүхэдтэй ийм нөхцөл байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.5.4 дээр төвийн бүсэд ХААИС-ийн нэгдсэн хотхон кампус байгуулна гээд шууд орчихсон байгаа. Тэгэхээр энэ яаж байна вэ гэхээр яг л тэр төвийн бүс дээрээ үйлдвэрлэл, үйл ажиллагаагаа явуулж байгаа тэр газарт нь ойртуулж кампусаа барья гэсэн ийм бодлого. Энэ чиглэлээр бол яг энэ зураг төсвийг нь зохиох тал дээр бол Эдийн засгийн сайд руу хандаж бид бас хүсэлтээ явуулчихаад байгаа.

Дээд боловсрол мэргэжлийн боловсролыг бүсчилсэн хөгжлийн чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлнэ. Үүний нэг чиглэл нь бол хөдөө аж ахуй гэж орсон. Хөдөө аж ахуйн чиглэлийг тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр бол зарласан байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье. Наранбаяр сайдад нэмэлт 1 минут өгье.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ хүрээнд бол дээд боловсрол суралцах тэтгэлэг, зээлийн бодлогод нь л бүрэн хамруулахаар заасан. Түүний зэрэгцээ бас энэ ХААИС-тай хамтраад ер нь энд Хосмог ийм мэргэжлийг хосолсон ийм мэргэжлийг олгодог, зөвхөн хөдөө аж ахуйн чиглэлээр бас багшлах эрхтэй ийм болгодог хосолсон ийм тогтолцоог нэвтрүүлэх нь зүйтэй байна гэж харж байгаа. Ингэснээр элстээ нэмэгдүүлнэ, 2 дугаарт нь бас энэ чиглэлээр бас бид нар ХААИС жилдээ 2 удаа элсэлтээ авах ийм

боломжийг бас судалж үзэж байгаа. Ингэж тэнд байгаа мэргэжлийн эрэлтийг нэмэх ийм шаардлагатай гэж үзэж байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан сайд асуултад хариулъя.

Л.Энх-Амгалан: Мандхай гишүүн ээ, бид нар энэ өнгөрсөн хугацаанд энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ талаар явуулсан бодлогод бид нэг үнэлэлт дүгнэлт өгч, цаашаа ер нь ямар бодлогын шинэчлэл хийх ёстой юм бэ гэдэг дээрээ бас тодорхой нэг тогтолцоо талаас нь харъя гэж мөрийн хөтөлбөрт туссан байгаа. Тийм учраас бид нар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмээс тусгаарлаад тусад нь нэг төв дээр аваачаад байршуулах тухай асуудал биш. Энэ төвүүдээр дамжиж яг хөгжлийн бэрхшээлтэй иргэд чинь дотроо б бэрхшээлийн онцлогтой иргэдэд аль болохоор хөдөлмөрийн чадваруудыг сэргээх чиглэл рүү сургалтуудыг хийж энэ чадваруудыг бий болгож, нийгэмшүүлэх, нийгэмд оролцох оролцоог нь хангах чиглэлд бол ийм хүмүүнлэгийн бодлого явуулах энэ зарчмыг л барьж ажиллана гэж бодож байгаа шүү дээ. Бусад улс оронд ч гэсэн тийм юм байна лээ. Тийм учраас энэ Азийн хөгжлийн банкны чиглэлээр хэрэгжсэн хөгжлийн бэрхшээлтэй б хөгжлийн төвийг бүх аймгууд дээр жишиг болгож өгөх хөгжлийн төв юм байгаа юм. Чадваржуулах хөгжлийн төв юм байгаа юм. Тэгж л ойлгосон.

Д.Амарбаясгалан: Мандхай гишүүн тодруулга авъя.

М.Мандхай: Би тэр нөгөө зүүн бүс дээрх яг юу хийх гэж байгаа тодорхой хариулт бол авч чадсангүй. Боловсрол дээр ч гэсэн одоо яах вэ, ер нь бол хувийн хэвшил зах зээл яг юу хүсэж байгаа, тэрэнтэйгээ уялдуулж боловсон хүчин, хүний нөөцөө маш сайн бэлдэх ёстой. Тэгэхээр миний бодлоор яам дундын

хоорондын бас уялдаа холбоо бас их тааруу байдаг. Тийм учраас яг энд хэрэгжүүлэх гэж байгаа томоохон хөтөлбөрүүдийг Хөдөө аж ахуйн яамтай Боловсролын яам уялдаа холбоогоо маш сайн хангаж байж тэр хүсээд байгаа эрэлтэд нийцсэн хүний нөөцийг маш сайн бэлдэх шаардлага хэрэгцээ байна гэж бодож байна. Тэгээд төвийн бүс дээр ганцхан сургууль барьж байгаа яг зорилго нь яах вэ, боловсруулах үйлдвэртэйгээ ойртуулж байгаа юм шиг байна. Гэхдээ нөгөө талдаа бид нар хоршоонд хаана, хаана хоршооллыг бэлдэж байгаа вэ гэдэг анхан шатын хоршоонуудад бид нар хаана зээл олгож байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Уг нь хэлэлцэх эсэхийг л хэлэлцэх ёстой байтал одоо бүр бид нар дотоод тэр гэдэс дотор луу нь ороод л асуугаад явчихлаа. Тэгэхээр дараа яг жинхэнэ нөгөө дотор гэдсийг нь ухах үедээ юу ярих юм бол гээд гайхаад л байна л даа. Тэгээд нэгэнт тэгээд яваад эхэлчихсэн учраас би ч гэсэн бас энэ зарчмаар нь явъя гэж бодлоо. Тэгээд энэ Засгийн газрын гэрээ биш ээ, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Тэгээд энэ дээр бүр зарчмын буюу өмнөтгөл хэсэг дээрээ ийм өгүүлбэр байгаад байгаа юм.

Улсын эрх ашиг 1 дүгээрт, улс төрийн намын эрх ашиг 2 дугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх зарчмыг үнэт зүйлээ болгоно гэж байгаа юм. Би энийг бол жоохон гайхаад байна л даа. Улс төрийн намын эрх ашиг гэж яг бас юу вэ. Тэгээд энэ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орох ёстой юм уу гэдэг нэг ийм асуулт байна. Энэ ер нь жоохон философи утгаараа ч тэр, ёс зүйн талаасаа ч тэр зохимжгүй байх. Энийг ер нь авах нь зүгээр байх. Тэгээд энэ чинь Үндэсний эрх ашиг л гэж байгаа юм. Үндэсний эрх ашиг. Заавал ч үгүй дугаарлах албатай бол үндэсний эрх ашиг 1 дүгээрт, тэгээд олон нийтийн эрх ашиг

2 дугаарт ч гэдэг юм уу. Яг юуг ингээж ойлгож 2, 3 гэж дараалуулаад байгаа юм бол.

Тэгээд ер нь л үндсэн концепт бол хувийн хэвшилд тулгуурлана гэж ярьж байгаа. Төр, хувийн хэвшил гээд. Тэгээд бид нар магадгүй нэг жаахан сэтгэлгээний шинж чанартай өөрчлөлт, сэргэлт хийх хэрэгтэй байх. Тэгээд энэ дээр энэ мөрийн хөтөлбөрт ерөөсөө тэр талын юм маш бага байна. Тэгээд наад зах нь хувийн хэвшилд тулгуурлана гээд байгаа мөртөө энэ 3.3.6.6-д соёлын наадам хийнэ л гэж байгаа юм. Ариун цэврийн байгууламж бүхий цогцолбор байгуулна л гэж байгаа юм. Энэ цогцолборыг чинь Урьхан хангаад, Урьхан хийгээд яваад байгаа шүү дээ. Тэгэхээр Урьхан хийчих ажлыг төр ингээж ариун цэврийн байгууламжтай цогцолбор хийх шаардлагатай юм уу. Тэгэхээр ерөөсөө иймэрхүү маягийн цэвэр хувийн хэвшлийн ажлуудаа эндээсээ бүүр хасвал яасан юм бол. Яагаад ингээж оруулаад байдаг юм бол. Тэгэнгүүт яах вэ, өмнө нь хариулсан л даа хувийн хэвшил хийж чадахгүй тэр газарт нь хийх юм гээд. Бүх юмыг чинь зах зээл зохицуулна. Тэгэхээр нэгэнт тэнд зах зээл очихгүй байгаа юм бол тэр хэрэггүй л гэсэн үг байлтай билээ.

Тэгээд спортын гээд бас юм ороод ирсэн байгаа юм. Спортын сургалт дасгалжуулалтыг сайжруулна. Энэ чинь хэний дасгалжуулалтыг сайжруулах гээд байгаа юм гээд энэ бол ерөөсөө цэвэр тэр мэргэжлийн холбоодын хийх ажил руу ингээж орж ирээд байх юм. Эд нарыгаа бүүр хасвал яасан юм. Тэгээд энэ дээр нөгөө сэтгэлгээний өөрчлөлт гэдэг шиг төр, хувийн хэвшлийн PPP гээд яах вэ байдаг л даа. Англи дээрээ. Түншлэл гэдгээ бид нар эсрэгээрээ тэр бол магадгүй бүр хувийн хэвшил нь нэгэнт зах зээл нь ингээд бүрэлдчихсэн газарт одоо бүр ингээд тогтчихсон байх. Манайх бол дөнгөж л нөгөө зах зээлдээ бүрэн шилжих гээд л бэдэрч яваа улс шүү дээ. Тэгэхээр төр, хувийн хэвшлийн биш, хувийн хэвшил, төрийн хамтын ажиллагаа. Нэг ёсондоо

хувийн хэвшил нь дандаа санаачилгыг гаргана. Бүх санаачилга хувийн хэвшилээс гарна. Тэр дээр нь төр дэмжлэг үзүүлнэ гэдэг ийм зарчим руу шилжихийн тулд энэ нэр томъёог хүртэл бид нар бараг байрыг нь өөрчлөөд ингээд цаашаа хэрэглээд явбал яасан юм бэ.

Энэ Үндэсний Үндэсний орон сууцын корпорац байгуулна гээд. Энэ өмнөхүүд нь хэр үр дүнтэй байсан юм бэ. Одоо энийг бас дахиж байгуулж, дахиж энэ дээр ингээж ажиллагаа явуулах шаардлага байгаа юм уу. Энэ өмнөхийгөө дүгнэсэн юм уу гээд.

Эцэст нь энэ засаглалын индекс гэж гаргадаг Дэлхийн банкнаас. Тэгээд энэ дээр бол манайх бас л их хойгуур явдаг л даа. 2018 онд жишээлбэл 192 оноос 103-д явж байгаа юм. Тэгээд одоо 2022 онд 100 хувь авахаас 38 энэ тэр гээд. Тэгэхээр энэ засаглалын индексийгээ бариад явбал ер нь яадаг юм бэ. Засаглалын индексийг тэдэнд хүргэнэ гээд. Дотор нь энэ нөгөө хуулийн засаглал чинь явж байгаа юм. Хүний эрхийн асуудал явж байгаа юм. Одоо нөгөө хууль тогтоомжийн биелэлт хэр хувийн хэвшилдээ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье. Дараа нь Тэргүүн Шадар сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Гишүүний олон хувийн хэвшилтэй холбоотой, зарчимтай холбоотой асуудлууд дээр санал нэг байна. Энийг Тэргүүн Шадар сайд хариулаад явчхаж болох байх. Би зүгээр гэрээний нэр болон улсын эрх ашиг 1 дүгээрт, улс төрийн намын эрх ашиг 2 дугаарт гээд энэ агуулгаа тайлбарлая гэж бодож байна.

Би яах вэ ер нь хэлэлцүүлгийн явцад сонсож байсан л даа. Зоригийн хэлсэн энэ үгийг оруулахгүй байя гэдэг ийм саналууд энд тэндээс гарч байна. 2 дугаарт Чимгээ, Содномдаржаа нар хэлмэгдсэн асуудлыг аль болохоор бага ярмаар байна гэдэг ийм асуудлууд бас холбогдох

гишүүдээс гарч байгаа талаар юм сонсож байсан. Тийм учраас би үүнтэй холбоотой би бас өөрийнхөө улс төрийн байр суурийг илэрхийлье гэж бодож байна. Тэр нь юу вэ гэхээр энэ өнгөрсөн 30 орчим жилийн бид нарын шүүмжлэлтэй хандаж байгаа зүйл бол яг энэ эрэмбэ дараалал алдагдсанаас болсон гэж би хувьдаа боддог. Улаанбаатар хотын жишээлбэл, газрын наймааны асуудал. Энэ бол хуулиараа боломжгүй л зүйл. Хүүхдийн сургууль, цэцэрлэгийн газрыг нь үндсэндээ хууль бусаар булаагаад авчихсан л гэсэн үг шүү дээ. Ногоон байгууламжуудыг устгасан. Энэ хуулийн хүрээнд боломжгүй л зүйл. Энэ юу вэ гэхээр улс төрийн намыг ашиглаж хувьдаа завшсан ийм л асуудал. Тэгээд өнөөдөр бид нар түгжирлээ яах вэ гээд ингээд яриад сууж байна. Тийм учраас ардчилсан хувьсгалын энэ үзэл санааг бас удирдалцсан гол хүмүүсийн нэг Санжаасүрэнгийн Зориг хэмээх энэ хүний үйл хэрэг, үзэл санааг бүдгэрүүлэх аливаа алхамтай би Ерөнхий сайдын хувьд огт эвлэрэхгүй. Энэ үзэл санаанаасаа би огт ухрахгүй. Энэ эрүүдэн шүүлттэй холбоотой асуудал заавал шийдэгдэх ёстой. Хүний эрхтэй холбоотой асуудал дээр энэ хүмүүстэй холбоотой асуудал дээр хороо байгуулагдаад, цаашаа мухарлах ёстой. Улсын эрх ашиг 1 дүгээрт, улс төрийн намын эрх ашиг 2 дугаарт, эцэст нь хувийн эрх ашиг байх учиртай. Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол тангараг өргөхдөө хувийн эрх ашгаа хойноо тавина. Олон нийтийн төлөө байна гэдэг ийм тангараг шүү гэдэг энэ агуулгаар би тайлбарлаж байгаа. Гэхдээ яах вэ сая гишүүний асуудлыг энийг би албаар ингэж асуусан гэж бодохгүй байна. Гэхдээ ер нь яах вэ ийм зүгээр агуулгууд бас өмнө нь ажлын хэсэг дээр яригдаж байсан учраас би Ерөнхий сайдын хувьд тов тодорхой байр сууриа илэрхийлчихье гэж бодож байна. Бусад асуудлаар бусад сайд нар хариулна.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд Гантөмөр хариулъя.

Л.Гантөмөр: Тэгэхээр илүү хурдтай хөгжлийн төлөөх зориг гэж байгаа юм. Бид нар бол яг ардчилсан хувьсгалын удирдагч Зоригийн хэлсэн үгэн дээр үндэслэж хөтөлбөрөө гаргаж байгаа. Ажлынхаа чиглэлийг гаргаж байгаа юм. Ардчилсан хувьсгалын удирдагчаараа бид нар бахархаж байж, ардчилсан хувьсгалыг цаашаагаа бид нар баталгаажуулах, ардчилсан хувьсгалын 2 дахь давлагааг бид нар 126 гишүүнтэй парламентаар түрнэ гэж ингэж ойлгож байгаа юм. Энэ 126 гишүүнтэй Үндсэн хуулийн өөрчлөлтөөр бий болсон холимог системийг бид нар амилуулах хэрэгтэй. Сонгуулийн холимог системийг бид нар амилуулах ёстой. Тийм учраас бол зоригтой алхмуудыг хийнэ.

2 дугаарт энэ хувийн хэвилийг илүү түлхүү ажиллах орон зайг бий болгох нь бол бид нарын ухамсарт бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгөх үү. Нэмэлт хариулт Тэргүүн шадар сайд өгье гэж байна.

Л.Гантөмөр: Тийм тэр бол үнэхээр энэ хувийн хэвилээ дэмжихийг бид нар их хатуу үзэж байгаа. Тэрний хажуугаар үндэсний амбиц гэж байгаа. Үндэсний амбицыг бол Засгийн газар нь манлайлдаг гэдгийг хоцрогдсон дунд хөгжилтэй бүх улс орнууд өөрийнхөө зорилго болгож байгаа. Засгийн газар юу ч хийхгүй гээд сууна гэж бол байхгүй. Засгийн газар бол үндэсний амбицыг чиглүүлнэ. Бид бол старт ап үндэстэн болно. Бид бол инновац хийж чаддаг үндэстэн болно. Бид бол Монголын соёлыг бахархал болгож чадсан ийм манлайллыг Засгийн газар үзүүлэх юм. Түүнээс биш засаг юу ч хийхгүй, хувийн хэвшил бүгдийг хийе гэдэг ийм зүйл одоо дэлхий дээр бол байхгүй. Онол өөрөө хөгжиж байгаа, илүү биежиж байгаа, илүү ондоошиж байгаа гэдгийг бүгдээрээ ойлгох хэрэгтэй. Тэгэхээр өнөөдөр энэ геополитикийн байгаа нөхцөл байдал дээр бид нар энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан:

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя. Тодруулга авах юм уу. Байж байгаарай. Жудагийн Баярмаа гишүүн тодруулга.

Ж.Баярмаа: Ер нь бол тэр эрх ашигийн эрэмбэ дараа бол бүр ингэж нэг номлоод байх шаардлагагүй. Хүн болгоны дотор бүр ингээд суучихсан ёс суртахуунтай нь холбоотой асуудал. Энийг өнөөдөр бид нар ингээд Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт оруулж байгаа нь бол ерөнхийдөө жоохон шараа л асуудал байгаа юм л даа. Энэ чинь улс төрч хүмүүст бол хувийн эрх ашиг гэж байхгүй. Ерөөсөө үндэсний эрх ашиг, олон нийтийн төлөө л ажиллана. Олон нийтийн ашиг сонирхлыг илэрхийлнэ гэж бид явдаг учир энэ дээр тодорхойлно гэдэг бол ер нь жоохон шараа.

Тэгээд гялс 2 асуулт нэмээд асуучихъя. Алтангэрэл сайдаас энэ хүний эрхтэй холбоотой хуулиас давсан журмууд гээд байгаа юм. Гэтэл бид нар чинь нөгөө асар олон конвенцуудад нэгдчихсэн байдаг. Тэгээд харамсалтай нь тэр конвенцуудаа хуульдаа тусгаагүй. Тэгэхээр энэ хуульд тусгагдсан эсэх дээрээ аудит хийхгүй юм уу.

Ерөнхий сайдаас нөгөө сонгуулийн тухай хуульд та өөрчлөлт оруулах санаа байгаа юу. Нөгөө мөнгөнөөс хамаарлын бууруулах сонирхол байгаа юу. Төрөөс энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Би түрүүн нэг асуултад хариулчихсан. Алтанхуяг даргын асуултад. Тийм саналууд байгаа. Энэ дээр хэдүүлээ хамтдаа ажиллая гээд.

2 дугаарт шараа болох зүйл өчнөөн гарчихсан учраас л бид нар буцаж, нөгөө алдагдсан зарчим, үнэт зүйлээ сэргээе гээд байгаа юм шүү. Өнгөрсөн хугацааны

энэ олон асуудлууд, бас Хөгжлийн банк, тэр Эрдэнэт гээд. Яах вэ та өөрөө мэдээлэлтэй болоод ирэхээрээ шараагийн дээд шараа болчихсон учраас бид нар тэр ардчилсан хувьсгалынхаа анхдагч үзэл санааг сэргээе гэж зориуд тунхаглаж байгаа юм шүү.

Д.Амарбаясгалан: Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд.

О.Алтангэрэл: Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр хамтраад 2003 онд Улсын Их Хуралд 41 дүгээр тогтоолоороо хүний эрхийн үндэсний хөтөлбөр баталж байсан. Тэгээд Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт энэ хүний эрхийн үндэсний хөтөлбөрийн 2 дугаар үе шатыг эхлүүлэе гэсэн ийм зорилт тавьчхаад байгаа. Тэгээд таны хөндөж байгаа асуудлууд орно. Тэгээд энэ ер нь бид нар аливаа нэг асуудлаар шийдвэр гаргахдаа хүний эрхийн Дью дэлэжэнс хийлгэдэг. Хүний эрх талаасаа нийцэж байна уу, үгүй юу гэдэг энэ тогтолцоо руу явахыг бас хичээж байгаа.

Д.Амарбаясгалан: Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя.

М.Бадамсүрэн: 4 асуулт байна. Эхлээд Ерөнхий сайдаас 2 асуулт.

Зүүн бүсийг бүсчилсэн түүхийн аялал жуулчлалын бүс нутаг гээд Засгийн газрын тогтоол гарсан. Саяын Улсын Их Хурлын сонгуулиар ч гэсэн иргэд сонгогчид дэмжсэн. Тэгэхээр 1.3.6.1-д Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтан овоог дэд бүтцээр холбоно гээд. Энэ бол их зөв зүйтэй ажил. Манай зүүн бүсийнхэн дэмжиж байгаа гэж бодож байна. Энэ дотор 4С нисэх онгоцны буудал байгуулна гэж байгаа юм. Тухайлбал манай Халх голд 3 газрыг тусгай хэрэгцээний газар болгоод бас авчихсан байдаг. Буйр нуур, Халх гол орчимд. Усан хилээр хиллэж байгаа ганц газар бол Буйр нуур. Тэгэхээр энэ усан

боомт 4С нисэх онгоцны буудлыг Буйрт хийх үү, Дэлүүнболдогт хийх үү, Алтайн Овоонд хийх үү юу гэж төлөвлөж байгаа вэ.

2 дугаарт нь хүний хөгжлийн бодлого хэсгээс 2.4 баялагтаа эзэн Монгол гэж байгаа юм. Ер нь байгалиа хайрлаж, баялгаа ашиглаж л хүн төрөлхтөн амьдарч ирсэн. Айлын аав хүн бол цалин орлогоосоо хүүхдийнхээ сургалтын төлбөр, 2 дугаарт нь хүнс, 3-д нь тог цахилгааныхаа мөнгийг төлдөг. Тэгэхээр эндээс ямар санал хэлэх гэж байна гэхээр мэдээж Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсан. Тэгэхээр эндээс ирээдүй үеэсээ зээлж авч хөрсөн доорх баялгийг хэрэглэж байгаа учраас хүүхдээ хөгжүүлэхэд зориулъя. Жишээлбэл манай Дорнод аймаг 10 мянган хүүхдийг сард 20 мянган төгрөгөөр дуртай секц дугуйланд нь хамруулдаг. Энийг бас баялгийн өгөөжөөсөө хэрэгжүүлж байгаа юм.

2-т нь нөхөн сэргээгддэг Хүнс, хөдөө аж ахуйн салбар болон хүрээлэн буй орчноо хамгаалж зохистой ашиглан аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр хөнгөлөлттэй зээл, батлан даалт зөвлөх үйлчилгээнүүдийг хэрхэн яаж үзүүлэх вэ. Энэ дээр жоохон хөрөнгө нэммээр байна. Ер нь бол ирээдүйгээсээ зээлж байгаа учраас хүүхдээ хөгжүүлэхэд зориулъя. 2-т нь нөхөн сэргээгдэхгүй шавхагддаг баялаг учраас нөхөн сэргээгдэх хөдөө аж ахуй, аялал жуулчлал хоёртоо хувийн хэвшилээ бодлогоор хөнгөлөлттэй зээл, дэд бүтэц ингээд бусад зөвлөх үйлчилгээгээр дэмжээд яг шинэ хоршоо хөдөлгөөнтэй адилхан зарчмаар аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбартаа баялгийн өгөөжөөсөө хуваарилах энэ зарчмыг бас баримтлахад ямар байр суурьтай байгаа вэ. Засгийн газрын тэргүүний хувьд гээд.

2-т нь Тэргүүн Шадар сайдаас 1 асуулт байна. Эдийн засгийн бодлого хэсэгт зах зээлийн эдийн засаг Монголчуудын сонгосон энэ замд бол өрхийн аж ахуй, хувийн хэвшлийг дэмжих

ёстой. Эндээс бол 1 дүгээрт газар олголтыг бол хялбарчлах шаардлагатай гэж бас аймгийн Засаг даргаар олон жил ажилласан хүний хувьд бол үзэж байгаа. Ер нь бол дуудлага худалдаа гэдэг нь бол яах вэ асуудлыг шийдэх нэг гарц. Үүгээр орсон хөрөнгөөр дэд бүтэц тавина л гэдэг ийм бодлого зарчимтай. Гэхдээ бодит байдал дээр Монголчууд ялангуяа бизнес эрхлэх гэж байгаа залуучууд дуудлага худалдаагаар газар авч чадахгүй. Газаргүй учраас эндээ хөрөнгө оруулалт хийж чадахгүй байгаа. Тийм учраас газар олголтыг ер нь хялбарчилж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд энийг жоохон өөрчилмөөр байна. Одоо өргөн уудам нутагтай бид бас зөв, зохистой ашиглаад явбал болно гэж үзэж байгаа юм.

2 дугаарт нь хөнгөлөлттэй буюу урт хугацаатай, бага хүүтэй зээл. Ялангуяа хугацаа урттай зээлээр маш сайн дэмжихгүй бол энэ залуучууд жижиг дунд бизнес эрхлэхэд бол хүнд байгаа. Жилдээ аймагт 1-2 тэрбум төгрөг л ирдэг. Тэр бол юу ч болохгүй. Улсын хэмжээнд 20 хэдхэн тэрбум төгрөг.

3 дугаарт нь мэдээж дэд бүтцээр дэмжинэ. Энэ бодлого бол нэлээн явах юм шиг байна. Энэ Засгийн газрын хөтөлбөр дээр бол нэлээн сайн туссан байна.

4 дүгээрт нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас 1асуулт байна. Ашигт малтмалын ордуудад байгаль орчин, техник эдийн засгийн үнэлгээ гэж хийдэг. Гэхдээ нэг зүйлийг бид өнгөрсөн энэ 30 жилд орхигдуулж ирсэн. Энэ бол нийгмийн үнэлгээ. Өөрөөр хэлбэл өнгөрсөн цаг хугацаанд Эрдэнэт, Багануур, Бор-Өндөр гээд эхлээд төмөр замаа бариад нийгмийн соёлын төв, орон сууцаа бариад уурхайчин залуу гэрээсээ автобусаар ажилдаа явдаг гэр бүл нь сургууль, цэцэрлэгт ажилладаг, үр хүүхэд нь гэрээсээ сургууль цэцэрлэгтээ явдаг ийм зарчмаар явж байсан. Сүүлийн жилүүдэд энэ зүйл алдагдсан. Гэхдээ төр бизнес хийхгүй гэдэг зарчмаар бас ямар

өөрчлөлт байдаг юм. Гэхдээ хувийн хэвшилтэй хамтраад энийг төр хувийн хэвчлээр хэрхэн хийж болох вэ. Энийг нийгмийн үнэлгээг яаж хийх вэ. Цаашид энэ дээр Уул уурхайн сайдаас баримталж байгаа бодлого байгаа юу. Зам харилцаа дээр төр хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ. Уул уурхай газрын тос дээр. Ингээд компанид нь даалгаад орхичихдог, нөгөөдөх нь замаа барихгүй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Зүүн бүс нутаг түүхэн аялал жуулчлалын бүс нутаг болж хөгжинө гэсэн ийм хөтөлбөр энэ төрөлжсөн болон дэд бүс гэдэг энэ агуулга дээр орж ирсэн. Бид нар аялал жуулчлалыг болон хөдөө аж ахуйн салбарыг уул уурхайн салбартай хослуулж хөгжүүлэх ийм зорилтыг дэвшүүлэх ийм чиглэлтэй явж байгаа. Өөр ч тийм потенциалтай салбар манайд байхгүй. Мэдээж тээвэр логистик, мэдээлэл технологийн энэ салбар орж ирнэ. Гэхдээ яг экспортыг орлох хэмжээнд бол уул уурхай дээр нэмэх нь аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарыг л бид нар потенциалтай гэж үзнэ. Энэ агуулгаараа бид нар аялал жуулчлалын салбар гэхээр Их эзэн Чингис хааны түүхтэй холбоотой асуудал зайлшгүй яригдана. Гэтэл харамсалтай нь Дэлүүн болдог дээр очих зам ч байхгүй. Онгоцны буудал ч байхгүй. Тэнд 3 нуурын амралт гээд нэг ийм амралтын газар л байж байгаа. Бид нар бараг өөрсдөө ч ихэнх нь очиж үзээгүй байгаа. Тэгэхээр хэн гаднаас ирж үзэх вэ. Нөгөө талаараа яах вэ нуугаад байх зүйл байхгүй. Өвөр Монголд маш их олон ийм цогцолбор том ийм хөрөнгө оруулалтууд хийгдэж байгаа. Сайн зүйл. Гэхдээ н1 өдөр энэ түүхэн газар нутаг андуурагдаад ч юм уу эсвэл өөрөөр тайлбарлагдаад явчихвал бид нар энэ түүхэн газар нутгаа эдийн засгийн эргэлтэд оруулаагүйн төлөө харамсаад ч барахгүй ийм зүйл болно. Түүх гуйвах хэмжээний ийм асуудал болно. Одоо 3 бараг Дэлүүн болдогтой эд нар болчихсон

байсан. Тэгвэл 4 дэх Дэлүүн болдог хилийн чанадад гараад явчихвал ингээд л асуудал үүснэ. Тэгэхээр энэ дээр бид нар нэг их том агуулгаар бодлогоо тодорхойлоод л явах нь зүйтэй байх гэж бас бодож байгаа.

Буйр нуур бол маш их одоо потенциалтай юм байна лээ. Тэгэхээр тэр 4С онгоцны буудал баригдана гэвэл бараг Чойбалсан дээр баригдахаас илүү яг Буйр нуур дээрээ баригдах нь Халх гол, Мэнэнгийн талтайгаа ойрхон илүү ч давуу талтай байхыг бол үгүйсгэх аргагүй. Монгол Улс далайд гарцгүй гэж ярьдаг Буйр нуураар шууд БНХАУ-тай холбогддог юм байна лээ. Тийм учраас усан боомттой болох ийм боломж бас байна. Нөгөө талаараа Улаанбаатараас Буйр нуур болон бусад нууруудын чиглэлд шууд аялал жуулчлалаа холбох чиглэлтэй явах, бага оврын нисдэг тэргүүдийг ч гэсэн бид нар сайн дэмжих ийм зайлшгүй шаардлагатай. Тэгэхгүй бол заавал жуулчдыг бид нар Улаанбаатар хотод нисэж ир, тэгээд заавал Улаанбаатар хотоос өөр тийшээ яв гэж ингэж тулгаад бас хэрэггүй. Хамгийн сайхан хүсэж байгаа газраа тэр Алтай 5 богд дээрээ нисэж очиг, Буйр нуур дээрээ нисэж очиг, бусад газартаа олон улсын нисэх онгоцны буудал барих нь бол зүйтэй юм гэдэг энэ агуулгаараа ингээд яригдаад шийдэгдсэн гэдгийг бас хэлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Тэгээд энэ бүсүүдийнхээ төрөлжилтийн хүрээнд л тусгагдаад бас хэлэлцүүлгийн үед илүү яригдаад явчих боломж байгаа гэдгийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд асуултад хариулъя. Б

Л.Гантөмөр: Баярлалаа. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ газар олголтын асуудлыг хялбарчлах зүйл бол одоо яг энэ үйл ажиллагааны хөтөлбөрт орчихсон явж байгаа. Тийм ээ, газрын зохион байгуулалтын асуудлыг илүү хялбархан хялбаршуулж, тодорхой

болгож хуульчилъя гээд орсон. Миний хэлэх гэж байгаа санаа юу вэ гэхээр залуу хүмүүс бизнес эрхлэхэд хамгийн чухал зүйл бол төвлөрөл. Төвлөрөл гэдэг нь бизнес буюу гарааны бизнес эхлүүлэх тэр боломж Монгол Улсад дутмаг байна гэдэг нь судалгаагаар их тодорхой харагдаад байгаа юм. Тэгэхээр бид нар додомдож биш, жинхэнэ утгаар нь инкубатор хийх, инновацын төв байгуулах, шинжлэх ухааны парк байгуулах гээд ингээд олон жил ярьсан юмыг жинхэнэ бодитоор нь хийхийг зорих гэж, зорьж байгаа. Бодитоор. Шинэ санаатай бизнесийн идеа санаатай залуу хүн, өөрийн гэсэн патенттай, өөрийн гэсэн технологитой залуучууд.../минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Уул уурхайн сайд. Туваан сайд.

Ц.Туваан: Баярлалаа. Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ ТЭЗҮ-үүдэд нийгмийн ТЭЗҮ-г хэрхэн яадаг вэ гээд. Энэ дээр бол мэдээж одоо Монгол Улсад аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого бол энэ хариуцлагатай уул уурхай гэдэг зүйлийг барьж явах ёстой. Энэ дотор бол тухайн орон нутагт амьдарч байгаа иргэн, орон нутаг, улс, ашиглаж байгаа компани гээд бүгд үүрэг хүлээгээд, бие биедээ хүндэтгэлтэй хандах ийм асуудал байгаа. Мэдээж тэнд ажиллаж байгаа ажилчдын нийгмийн асуудлыг бол шийдэх гэдэг асуудал бол маш чухал асуудал.

Зам харилцааны асуудал дээр бол харин энэ өмнөх хугацаанд аймгийн удирдлагууд ялангуяа Бадамсүрэн дарга бол бас Засаг даргаар ажиллаж байсан нэлээдгүй шахаж, шаардаж байж энэ замуудын асуудлыг бол шийдсэн байгаа. Тэгэхээр энэ замаар дан ганц тосны машинаас гадна орон нутгийн иргэд ч гэсэн ингээд зорчоод явдаг энэ асуудлыг бол шийдсэн. Энэ дээр бол төрөөс яг тодорхой мэдэхгүй байна, цаашидаа ч гэсэн бас.../минут дуусав

Д.Амарбаясгалан: Бадамсүрэн гишүүн тодруулга.

М.Бадамсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдаас 2 дугаарт нь энэ уул уурхай, газрын тосны олборлолтын мөрөг нөлөөнд өртөж байгаа энэ орон нутагт олон улсын жишиг бол Роялтыгийн 30 хувь бол заавал хуваарилагддаг. Энэ чинь зүгээр л нэг уул уурхай байгаа гээд давуу байдал олгоод байгаа биш. Тэнд чинь амьдрах орчинд нөлөөлж байна. Үр удмаараа энд өвөг дээдсээрээ амьдран суучихсан хүн нүдэн дээр нь байгалийн баялаг хэдэн арван машинаар гараад байдаг. Нөгөө сум орон нутгийн иргэдийн амьдрал ахуй адилхан хөгжиж, дээрдэх битгий хэл дордоод байхаар чинь ямар ч иргэн эсэргүүцнэ. Тийм учраас цаашидаа энэ шинэ юм бодож олох гээд байгаа биш олон улсын жишигт байгаа энэ орон нутагт нь тодорхой хувийг нь хуваарилдаг. Тэнд нь харин хяналтаа тавиад орон нутаг нь сайхан хөгждөг, адилхан өвөг дээдсийнхээ үлдээсэн нутагтаа сайхан амьдардаг энэ боломжийг нь бүрдүүлэх ёстой. Тэгээд энийг бол аймгийн Засаг дарга байхдаа олон удаа хандсан. Тэгээд харамсалтай нь дэмжигдэж байгаагүй. Одоо бас парламентын гишүүнээр сонгогдсон хүний хувьд иргэд, сонгогчдоос олон зүйл дайсан.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Бид бол нэгдмэл улс. Тийм учраас бас бүх Монгол Улсын Дорнод аймгийн асуудал ч тэр, тэнд амьдарч байгаа иргэдийн асуудал ч тэр, Улаанбаатарын иргэдийн асуудал ч тэр хамтдаа шийдэгдэх ёстой. Тэгэхээр энэ дээр бид нар нэгдсэн бодлоготой байх ёстой. Таны асуултад байгаа тэр ашиг малтмалаа ашиглуулж байгаа орон нутгийн иргэдийн асуудал бол би түрүүн тэр хариуцлагатай уул уурхайн хүрээнд мэдээж тэнд байгаа иргэд бол маш сэтгэл ханамжтай байх ёстой. Энэ асуудлыг бол тантай санал нэг байна.

Цаашидаа ч гэсэн бид бүхэн ингэж явах ёстой. Нөгөө тэр тодорхой 30 хувь, 40 хувь гээд ярьдаг энэ буцааж орон нутагт өгөх асуудалд Сангийн сайд бас нэмээд хариулаад өгчих байх гэж бодож байна. Орж байгаа орлогоос орон нутагт нь өгөх асуудал дээр.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ дээр бид нэлээн тийм горимын, дүрмийн өөрчлөлтийг сүүлийн 2 жил хийгээд амжилттай явж байгаа. Аймгууд энийг бас нэлээн сайшаалтай хүлээж авч байгаа. Тэгэхдээ цаашидаа улам л боловсронгуй болгох ёстой.

Юу вэ гэвэл одоо уул уурхайн салбар энэ томоохон ордууд аль болох эргэлтэд оруулж ухаалаг энэ уул уурхайг, хариуцлагатай бол уурхайг орон нутагтаа дэмжиж, тэнд хөрөнгө оруулалт татах тусам илүү их роялтигаас нь буюу АМНАТ-аас нь тухайн аймагт нь илүү хуваарилагдаж очдог ийм зарчим руугаа бид шилжээд, энэ жил 3 дахь төсвөө өргөн барих гэж байгаа юм. Үүний дагуу тухайлбал Өмнөговь аймаг, Эрдэнэт, Дорноговь, говийн бүс аймгууд мөн төвийн бүс аймгууд дээр ч тэр Сэлэнгэ, Дархан гээд жижиг том уул уурхайнуудтай АМНАТ-ын орлого төвлөрүүлдэг аймгууд бол орон нутгийн хөгжлийн сан нь бол бүр 2-3 дахин нэмэгдэж очиж байгаа. 2-3 дахин нэмэгдэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Боловсролын салбарт ажиллаж байгаа 100 гаруй мянган багш ажилтны нийгмийн асуудалтай холбоотой 4 асуултыг асууя. Хууль зүйн сайдаас 1 асуулт, нийт 5 асуулт асууна.

Эхний асуултыг Ерөнхий сайд, 2 дахь асуултыг бас Ерөнхий сайдаас, 3, 4 дэх асуултыг бол Эдийн засаг, хөгжлийн сайд Гантөмөрөөс асууж байна.

1 дүгээрт нь энэ боловсролын салбарт ажиллаж байгаа багш нарын маань цалин хөлс бол маш бага байгаа. 2017 онд одоо анх бид нар 535 мянган төгрөгийн цалинтай, багш нар бол өрнөөс өрний хооронд өдөр хоногийг аргацаан амьдарч байсан. Тэр он жилүүдээс хойш даруй 7, 8 жил өнгөрсөн. Багшийн цалин 200-400 долларын хооронд л эргэлдэж байгаа. Энх-Амгалан сайд бол бас жоохон цалинг бол бас хөдөлгөсөн. Энийг бас талархаж хэлэх ёстой. Багш нарын цалинг 2023 оны 3 оны 9 сард 1 мянган долларт хүргэх Засгийн газарт бид нар бас шаардлага хүргүүлж байсан. Энэ дээр Ерөнхий сайд энэ Засгийн газрын үед багш нарын цалинг хөдөлгөж, 1 мянган долларт хүргэх боломж байгаа юу гэдгийг асууж байна.

2 дугаар асуудал бол багш нар энэ цалин бага байгаа учраас орон сууцны нөхцөл маш хүнд байдаг. Бараг 10-80 хувь нь түрээсийн байр, айлын хашаа байшин, хашаа байшинд амьдарч байна. Яг тохилог орон сууцад амьдардаг багш нар бол маш цөөхөн байгаа. Тийм учраас энэ орон сууцны асуудал, багшийн цалин хөлсийг 1 мянган долларт хүргэх асуудлыг энэ Засгийн газарт хийж хэрэгжүүлэх боломж байгаа юу гэдгийг Ерөнхий сайдаас асууя.

Сүүлийн 2 асуулт байна. Энэ болохоор багш нарын тэтгэврийн нас гэж маш их яригддаг. 2019 онд Монголын багш нарын 7 дугаар их хурал, сая 2024 онд Монголын багш нарын 8 дугаар их хурал гээд ингээд 2 их хурал дамжаад яригдсан хамгийн чухал асуудал бол мөн Боловсролын ерөнхий хуулийг хэлэлцэгдэж байхад Монголын багш нарын бараг 80-90 хувь нь тэтгэврийн насыг хүсвэл эрэгтэй 55, эмэгтэй 50 настай тэтгэвэрт гаръя гэсэн энэ хүсэлтээ илэрхийлж байсан. Гэтэл энэ асуудал ерөөсөө Боловсролын ерөнхий хуульдаа ороогүй. Энэ дээр бол багш нар маш их гомдолтой байгаа. Энэ асуудлыг Гантөмөр сайд бас хариулж өгнө үү.

Хамгийн сүүлийн асуудал бол багш нарын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж өгөх энэ боломж байна уу гэдгийг Гантөмөр сайдаас асууя.

5 дугаар асуултыг бол Хууль зүйн сайд Алтангэрэлээс асууя. 2017 оны 12 дугаар сард төрийн албан хаагчдын улс төрийн эрхийг хаачихсан байгаа. Үг, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх, жагсаал цуглаан хийх энэ бүх эрхүүдийг 2017 оны 12 сард Төрийн албаны тухай хуулиар хаасан. Энийг эргүүлээд өөрчлөх боломж байна уу гэдгийг Алтангэрэл сайдаас асууж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цалин нэмэх нөхцөл боломжтой холбоотойгоор Эдийн засаг, хөгжлийн сайд бөгөөд Тэргүүн Шадар сайд Гантөмөр дарга эхний 3 асуултад хариулах юм байна. Тэтгэврийн настай холбоотой асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хариулт хийх юм байна. Ерөнхий сайд эхлээд хариулт өгөх үү.

Л.Оюун-Эрдэнэ: Чухал асуудлыг хөндлөө. Үнэхээр бүх хөгжлийн гол асуудал бол боловсролын салбартай холбоотой. Тэр дундаа багш нартай холбоотой. Боловсролын салбар бол ирээдүйн иргэдийн асуудал. Боловсролын салбар бол ирээдүйн манай хүний нөөцийн асуудал. Боловсролын салбар бол бас эдийн засаг хэрхэн тэлэх вэ гэдэгтэй ч холбоотой ийм асуудал. Тэгэхээр ирээдүйн иргэдийг багш бэлдэж байгаа. Тийм учраас багш нараа бүх талаар дэмжих ийм чиглэлд бол хөтөлбөр хэрэгжинэ. Цалинтай холбоотой асуудал дээр ер нь бид нарт 2 л арга зам байгаа.

1 дүгээрт боловсролын салбар урсгал зардлаа хасаж, хэмнэлт гаргаж чадвал багш нарын цалинг нэмэх ийм орон зай гарна.

2 дугаарт зөвхөн багш нарын цалинг дангаар нь салгаж аваад нэмж, хасдаг

ийм зүйл бол байж болохгүй. Тийм учраас нийт төрийн албан хаагчдын цалин яригдах учиртай гэдэг нь төрийн албан хаагчдын бид нар тоог багасгана гэж ярьж байгаа. Тэгэхээр тэр давхцалуудыг бид нарын хувьд багасгаж, аль болохоор цөөхөн чанартай хүмүүс өндөр цалинтай ажиллах энэ реформыг бол хамтдаа хийнэ гэдэг энэ агуулгаар явж байгаа. Энх-Амгалан сайд энэ дээр. Ер нь яах вэ, гишүүддээ бас хандаж хэлэхэд цалинтай холбоотой асуудлыг салбар бүр ингэж ярьж ер нь бол болохгүй. Яагаад гэвэл багш, эмч 2 тэгээд бусад мэргэжилтэй адилхан л байх учиртай. Тийм учраас салбарын хууль дээр цалингийн асуудлыг шийддэг ч юм уу нэг ийм салбарын хууль оруулж ирээд ард нь цалин бие дааж шийддэг ийм агуулга явснаас болж салбарууд хоорондоо сайд нарыгаа цалин нэмсэн сайдыгаа хамгийн сайн гэж үздэг ийм агуулга руу ингээд уралдаанд орчихсон. Энэ уралдаан бол өөрөө чөтгөрийн тойрог шүү. Яагаад гэхлээр бид нар ингэж асуудлыг шийдэж чадахгүй. Тийм учраас одоо бол улсын хэмжээнд байгаа хөдөлмөр эрхлэлт, цалинтай холбоотой асуудлыг ганцхан цалинг хариуцаж байгаа төрийн захиргааны төв байгууллага өөрөө л шийдэх ёстой. Тийм учраас төрийн албан хаагчдын цалинтай холбоотой асуудал дээр ямар бодлого барьж байгаагаа Энх-Амгалан сайдад хариулах нь зүйтэй гэж үзэж байн.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Миний хариулт бол Ерөнхий сайдтай адилхан байна. Мөнхтуяа гишүүний санал санаачилгыг бид нар бүгд дэмжиж байгаа. Ер нь боловсролын салбараараа дамжиж байж улс орон хөгжинө гэдэг нь их тодорхой байгаа. Үүнээс өөр арга байхгүй. Тэгэхээр боловсролын салбарын хөгжил яг эндээс гарч ирж байгаа хүний хөгжлийн асуудлыг бид нар ингээд цогцоор нь харах учиртай. Цогцоор нь харахад энэ дотор байгаа багш гэдэг яг тэр сургалтыг

удирдаж байгаа хүмүүсийн үйл ажиллагааг бид нар маш ойлгомжтой болгох хэрэгтэй. Дээр нь энэ хүмүүсийн үнэлэмжийг нэмэгдүүлэх ёстой. Тэгэхээр ингэхийн тулд хамгийн түрүүнд хийх ажил бол боловсролын үнэлэмжийг нэмэгдүүлэх. Боловсролын үнэлэмжийг тодорхой болгох ёстой. Түрүүн тэр Ундрам гишүүн ярьж байсан. Мастер, докторын ажлыг ил тод болгоё гэж. Эндээс эхэлнэ. Докторын зэрэг хамгаалсан бүх хүний ажлыг ил.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан. Тэтгэврийн настай холбоотой асуудлаар мөн цалингийн нэмэгдэл.

Л.Энх-Амгалан: Тэгэхээр ерөнхийдөө энэ төрийн албан хаагчдын цалингийн цалин хөлсний тогтолцоо, нийгмийн хамгааллын тогтолцоог ерөнхийдөө бид нар тогтолцооных нь хувьд нэг харж үзэх ийм болсон юм байгаа юм. Тэгээд тухайн тухайн салбарынхаа багц хуулиудаар дагаад ингээд 33 хуулиудаар ингээд салбар салбаруудын цалин зэрэглэл ангиллууд хөрөөний ир шиг болчихсон байсан. Бараг үндсэндээ энэ чинь 295 ажил мэргэжлүүд нь хоорондоо ийм ялгаатай болчихсон байсныг ингээд тэгшитгээд явж байгаа. Цаашидаа бол бид нар боловсролын салбар чинь бол үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжсэн. Эрүүл мэндийн салбар үр дүнд суурилсан санхүүжилтэд шилжсэн. Тийм учраас сайн багш хамгийн өндөр цалин авдаг, сайн эмч хамгийн өндөр цалин авдаг энэ тогтолцоо руугаа л бүгдээрээ урагшаа хамт болох ёстой юм байгаа юм. Тэгээд цаашидаа бол манай Засгийн газрын барьж байгаа гол бодлого энэ төрийн албан хаагчдынхаа ер нь цалин хөлс, урамшуулал, нийгмийн баталгааны асуудал дээр ийм тогтолцооны шинэчлэл хийх ийм судалгаанууд хийгдэж байна. Тэгээд бид нар бодлогын.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ингээд Мөнхтуяа гишүүн тодруулга. Алтангэрэл сайд бас хариулт байгаа тийм ээ.

О.Алтангэрэл: Гишүүний асуултад хариулахад, хөтөлбөрийн 4.1.1-д хүний эрх, эрх чөлөөг хэрхэн хангах вэ гэдгээ заагаад тэгээд 4.1.1.3-д иргэний улс төрийн эрх чөлөөг бүрэн хангах баталгааг бүрдүүлнэ гэж заасан. Одоогийн Төрийн албаны тухай хуулийн 37, 39 дүгээр зүйл гэж санаж байна. Төрийн албан хаагч улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох, улс төрийн намын дэргэдэх байгууллагын үйл ажиллагаанд оролцох, тэр байтугай шашны байгууллагын үйл ажиллагаанд оролцох нь хориотой байгаа. Тэгэхдээ бид нар энэ бодлогоо бас эргэж харах цаг болсон байх гэж бодож байгаа. Нэн ялангуяа энэ академик чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг их дээд сургууль болон дунд сургуулийн багш нарт энэ эрхээс алийг нь нээж өгөх вэ гэдгээ бодох ёстой. Бидэнд бас хүрээ хязгаар байх ёстой. Улс төрийн сонгуулийн үеэр хууль сахиулагчид жишигээр үзэл бодлоо илэрхийлж байгаа нэрийн дор ингээд явж байвал яах вэ гэсэн ийм асуудлын үндсэн дээр энэ хаалт хийгдсэн байдаг. Тэгээд таны саналыг анхаарч тусгая. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулга 1 минут.

Ц.Мөнхтуяа: Боловсролын салбарын багш нар энэ хичээлийн жилд гэхэд 4200 багш дутагдалтай байна гэдгийг Оюун-Эрдэнэ сайд өөрөө мэдэж байгаа юу. 4200 багш дутагдалтай байгаа. Багш нар яагаад гараад байна гэхээр байрны урьдчилгаа хийх гэж Солонгосыг зорьж байгаа шүү. Маш олон багш нар байрны урьдчилгаа хийх гээд ажлаасаа гараад Солонгос руу явж байгаа. Тэгэхээр энэ дээр ерөөсөө л хамгийн гол юм цалин хөлс шүү гэдгийг л дахин дахин хэлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд нэрээ өгөхийг хүсье. Орохгүй байна уу. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлэх гишүүдийг нэрээ өгөхийг хүсье. Дахиад алга тогичихъя. Дэгийнхээ дагуу явагдаж байна. Үг хэлэх гишүүд нэрээ өгье. Ингээд 25 гишүүн. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүнээр тасаллаа. Ирцийнхээ дарааллын дагуу үг хэлнэ.

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн үгээ хэлье.

Х.Тэмүүжин: Үнэхээр хамтарсан Засгийн газар байгуулагдаад энэ 4 жил юу хийх вэ гэдэг ажлын замын зураг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй ярилцаж байна. Олон нийтийн дунд бол 2 хуваагдсан. Тээнэгэлзэл байгаа.

1 дүгээрт бол яагаад Засгийн газар заавал ингэж хамтарч байгаа юм бэ. Сөрөг хүчин хаачсан юм бэ. Яагаад 3 нам нийлж байж энэ ажлуудыг хийх ёстой юм бэ. Бидэнд бол таалагдахгүй байна гэдэг байр суурьтай олон нийт бол бас байгаа. Нөгөө талаар хэрвээ үнэхээр 3 нам нийлээд хамтраад ажиллах гэж байгаа бол 1 нам шийдэж чадахгүй байсан ажлаа хийгээрэй, зориг гаргаарай гэдэг тийм хүлээлт бол байгаа. Миний хувьд ч гэсэн тийм хүлээлт байгаа. Засгийн газар анх хамтарч байгуулахад би таатай байгаагүй. Нэгэнт байгуулагдсан Засгийн газраас бол 3 хүлээлт байна.

1 дүгээрт Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам гээд 3 нам Засгийн газар хамтран байгуулсан. Баруун төвийн үзэлтэй 2 нам Ардын намтай нийлж Засгийн газар байгуулж байгаа. Баруун төвийн үзэл бүхий намын эрхэмлэдэг эхний нэг зүйл бол ерөөсөө бизнесийн эрх чөлөө байгаа. Энэ Засгийн газар бизнес эрхлэгчдэд ямар ээлтэй орчин үүсгэх юм бэ. Яаж иргэний

санаачилга хувийн хэвшил хувийн өмчийг эрхэмлэсэн эдийн засгийн бүтэц босгох юм бэ. Өнгөрсөн 8 жил бол даргын эдийн засаг ноёлсон. Төрийн өмч дээр суурилсан даргын гарын үсэг дээр тулгуурласан мөнгө олох уралдаан руу явсан. Энэ эдийн засгийн буруу тогтолцоог зогсоож чадах юм уу. Хувийн хэвшлийг хэтэрхий дээрээс харсан хяхаж хавчсан үйл ажиллагаа хуулийн байгууллагатайгаа нийлж явуулсан. Энийгээ зогсоолгох юм уу. Татварын дарамт үл ойлгогдох байдал болон хүнд суртлаараа хувийн хэвшилд авлига өгөхгүй бол эсвэл нэг төрийн өндөр албан тушаалтантай түншилэхгүй бол мөрөөдлөө биелүүлж чадахгүй, зорилгоо хангаж чадахгүй хэмжээнд хайрцаглаж авсан. Энэ хайрцагаа эвдэх юм уу гэдэг асуултыг тавьж байгаа. Татварын дарамт, өндөр хүүтэй мөнгө, дээр нь үл ойлгогдох төрийн үйл ажиллагаанаас чинь болоод хувийн хэвшил олон үйл ажиллагаагаа зогсооход хүрсэн шүү.

2-т нь Монгол Улс үнэхээр эдийн засгаа босгоё гэж байгаа бол том араануудаа хөдөлгөх ёстой. Том төслүүдээ зоригтой эхлүүлээрэй, урагшлуулаарай гэдэг хүлээлт байгаа. Том төсөл урагшаа явахгүй бол томорсон компаниуд чинь жижиг дундаа идээд дуусаж байгаа шүү. Тийм учраас үнэхээр эрчим хүчнийхээ хараат бус байдлаас гарах юм уу. Томоохон уул уурхайн төслүүдээ урагшлуулах юм уу. Урагшлуулж байгаа энэ цонхон дээрээ эрчим хүчний үйлдвэрлэгч улс болж хувирах юм уу гэх мэтчилэн энэ асуултуудыг иргэд бол тавьж байгаа шүү.

3-д нь эдийн засгаа дэмжье гэвэл энэ нохой шиг болчихсон хууль хүчний байгууллагуудаа засах юм уу. Хүний эрхийн нөхцөл байдал чинь бол үнэхээр шалан дээр унасан шүү. Хэн нэгэн улс төрч үнэнийг хэлэхэд бараг ардчилал энэ шийдвэр гаргах чадваргүй болсон шүү. Бизнес эрхлэгчид мөрөөдөл биелүүлэх чадваргүй болсон. Тагнаж, чагнадаг хуулийн нэр бариад сүрдүүлж айлган

сүрдүүлэлт хийдэг, бизнесийг нь тонон дээрэмддэг улс төрчдийг кармандаа оруулдаг энэ хуулийнхаа системийн гажсан цагдаажсан энэ төрийнх нь тогтолцоог эвдэх юм уу гэдэг асуултыг тавьж байгаа шүү. Энд чинь зориг хэрэгтэй.

Ихэнх улс төрчид чинь улс төрийн намын шийдвэр гаргагчид чинь хуулийн байгууллагуудын халаасанд оччихсон байгаа шүү. Энэ халаасыг нь суллах юм уу. Энэ чинь зориг хэрэгтэй шүү. Үнэхээр Зориг гэдэг хүний гоё үгээр мессеж хийж л байгаа юм бол хуулийн байгууллагын цагдаажсан төрөөсөө, даргын эдийн засгаасаа салах энэ.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 4 минут хүртэл хугацаанд үг хэлнэ гишүүд. Болж өгвөл товчхон хэлбэл бас зүгээр байх гэж бодож байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт ер нь өнөөдөр хэлэлцэх асуудал олон байгаа. Цаг сунгаж хуралдаж таарна. Тэгэхээр заавал 18 цаг дээр очиж санал хураахгүйгээр одоо саналаа хураагаад, сунгаж хуралдана гэдгээ шийдчихвэл болж байна уу гишүүдээс асуухад. Болно. Тийм ээ. Тэгвэл дэмжиж байгаа гишүүд саналаа өгөхийг хүсье. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонхын саналаар шийдэгдэх учраас ... 60 гаруй гишүүд байна. 60 гаруй гишүүд байна. Тэгэхээр гишүүд саналаа өгөхийг хүсье. Санал төхөөрөмжөөр явагдана л даа. Энэ чинь ахиж горимын санал гаргаж байж гар өргөх. Тэгэхээр нээрээ нэр өгчихсөн байгаа юу. Тэгвэл алив нэг нь гар өргөөд санал хураачихаар чинь дэг зөрчигдөнө дөө. Яах вэ шийдээд алх цохиж болно, болно. Тэгвэл ингээд танхимд байгаа гишүүдийн олонхын саналаар сунгаж хуралдъя гээд цохилоо. Цохилоо шүү. Эсэргүүцсэн хүн байхгүй биз. Ингээд өнөөдөр хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дуусаж байж чуулган өндөрлөнө. Ингээд үгээ хэлье. Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн доторх зүйл, заалт хэрэгжүүлэх төсөл төлөвлөгөөнүүдийг гишүүд нэлээн асуугаад ярьчихлаа. Үзэл баримтлалынхаа хувьд ярьж байгаа учраас ганц 2 зүйлийг хэлмээр байна. Энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөр гэдэг маань Засгийн газар бусдад ажил хийж өгөх гээд байгаа хэрэг биш шүү дээ. Засгийн газар Монгол Улсад юу хэрэгжүүлэх вэ гэдгээ хийх гэж байгаа. Тэгэхээр энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бүтцэд нь жаахан өөрчлөлт оруулмаар байгаа юм. 2002 онд дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хүнд 566 доллар байх үед ядуурал 36 хувьтай байсан. 2012 онд 4281 болоход 27 хувь, 2022 онд 5033 болоход мөн 27 хувь байсан. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөөд өсөөд ядуурал арилахгүй байна. Дундаж давхарга нэмэгдэхгүй байна. Тийм болохоор амьжиргааны түвшин, амьдралын чанарыг сайжруулах энэ нийгмийн асуудлаа Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн эхэнд нь тавимаар байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүн 10 мянган доллар боллоо гээд ядуурал нь хэвээрээ байвал энэ мөрийн хөтөлбөрийн утга учир тэр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ямар ч хамааралгүй болчхож байгаа юм.

Мөн Эдийн засаг, хөгжлийн сайд гээд байж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам гээд байж байгаа. Энэ Эдийн засаг, хөгжлийн сайд дээр ядуурлын эсрэг гэдэг үгийг нэммээр юм байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрөөр ядуурлыг 2 дахин бууруулна гэж байна. 2022 оныхоор харахад бол 914 мянган ядуу иргэн байна гэсэн. Үүний 457 мянган хүнийг ядуурлаас гаргана гэсэн үг. Жилд 150 мянган иргэнийг ядуурлаас гаргана гээд. Эдийн засаг, хөгжлийн Тэргүүн Шадар сайдын тэр яаманд нь сайдынх нь нэрэнд нь ядуурлын эсрэг гэдэг тэр хийгдэх ажлыг нь зааж өгмөөр юм байна. Тодорхой тоотой нэг жилд хэдэн хүнийг ядуурлаас гаргах юм. Аль аймаг, сум, дүүрэг ямар салбараас салбарын мэргэжилтнүүд ямар хүмүүсийг ядуурлаас гаргах юм бэ

гэдгийгээ тодорхой болгож оруулах нь зүйтэй юм байна гэж үзэж байна.

Мөн цаашид бид нар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Иргэний Зориг Ногоон нам өөрсдийнхөө зарчмын зөрүүтэй саналууд болон мөрийн хөтөлбөрт өөрчлөх саналуудаа хэлэлцэх явцад хэлэлцүүлэг дээр Байнгын хороод дээр өгөөд явна. Тийм болохоор тэр тухай тухайн үед нь ярья.

Нөгөө талдаа Их Хурлын тухайд бас нэг ярих юм байна. Энэ Засгийн газрыг бүрдүүлж байгаа 118 гишүүнтэй бүдүүн бүлэг байж байгаа. Энэ дээр бас Үндсэн хууль болон Их Хурлын тухай хууль эд нар дээр асуудал үүсэж магадгүй. Засгийн газрыг бол хуулиар байгуулдаг. Хуулиар Засгийн газрын гишүүдийг томилж байгаа. Тийм болохоор Их Хурлын дарга энэ дээрээ анхаарахгүй бол Их Хурал бол ард түмний төлөөлөл шүү. Засгийн газар биш. Цэц дээр очих асуудал үүсэх вий гэдэг дээрээ анхаараарай. Бид нар энэ дээр бол ер нь цаашид үргэлжлүүлэн ажиллана.

Нөгөөтээгүүр Зоригийн хэргийг улс төржүүлэхгүй. Иргэний Зориг ногоон нам Зоригийн хэргийг илрүүлэх тухай түр хороо байгуулж ажиллана.

Д.Амарбаясгалан: Тилеуханы Аубакир гишүүн үг хэлнэ.

Т.Аубакир: Баярлалаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бүхэлд нь дэмжиж байгаа. Гишүүд асуултаа асууж, саналаа хэлж байж энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт өөрсдийнхөө тойргийн асуудлууд, энэ улс эх орны асуудлуудыг шигтгэж өгдөг учраас зайлшгүй асуулт асууж, санал хэлэх шаардлагатай болж байгаа юм.

1 дүгээр асуудал миний ярих гэж байгаа зүйл бол өндөр цалинтай салбар гэхээсээ илүү энэ салбар хоорондын цалингийн ялгааг арилгах тал дээр төрийн

бодлогоо чиглүүлмээр юм шиг санагдаж байгаа юм. Үүний үр дүнд үүсэж байгаа маш олон асуудлууд байна. Жишээлбэл, хөдөө аж ахуйн салбарт боловсон хүчний хүрэлцээ дутмаг болсон. Багшийн хомсдол бий болсон. Хөдөө, орон нутагт эрүүл мэндийн мэргэжилтнүүд дутагдалтай болж эхэлж байгаа юм. Мэргэжилтнүүд дутагдалтай болохтой нь зэрэгцээд эргээд өндөр насны тэтгэвэрт гарах үед тэтгэврийн зөрүү бас өндөр ялгаатай болж эхэлдэг. Тийм учраас энэ цалингуудынхаа суурь цалингуудаа цалингийнхаа бодлого дээр маш бодолтой зөв авч явахгүй бол одоо жишээлбэл хөдөө аж ахуйн салбарт ажиллах мэргэжилтэн, сонирхолтой ажиллах мэргэжилтэн хомсдолтой болчихлоо шүү дээ. 14 мянга орчим оюутантай байх ёстой Хөдөө Аж Ахуйн сургууль маань өнөөдөр 4 мянган оюутантай сууж байна. Сая Боловсролын сайд маань бас хэлж байгаа нь Агрономын ангийг дөрөвхөн хүн төгсөж байна гэдэг чинь юу гэсэн үг вэ. Газар тариалангийн салбарт хамгийн их эрэлт хэрэгцээтэй байгаа агрономыг бэлтгэх энэ систем чинь өөрөө доголдоод эхэлчихсэн юм биш үү. Энэ чинь нөгөө суурь цалинтай холбоотой юм биш үү. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал маань Дэлгэрсайхан сайдад албан ёсны нэг ийм санал, хүсэлт тавимаар байгаа юм. Энэ алслагдсан аймгуудын нислэг, хуваарьт нислэгүүдийн тоог нэммээр байна. Одоо та бүхэн маань энэ Баян-Өлгийн, Ховдын билет ч үндсэндээ олдохоо байлаа шүү дээ. Аялал жуулчлалын салбар, жуулчид нисэж чаддаггүй. Яг тэр орон нутгийн иргэд нь нисэж чаддаггүй. Билетийн үнийг бол өнгөрсөн засгийн үед Бямбацогт сайд маш амжилттай буулгаж чадсан. МИАТ бол үйл ажиллагаа нь маш сайн сайжирч ирж байгаа. Илүү сайжруулах бодлогыг Дэлгэрсайхан сайд маань бас анхаараад явах нь зөв байх гэж. Энэ сайд нараа дуудахгүй бол Хурлын дарга аа, яг л одоо энэ Засгийн газрын үйл ажиллагааны

хөтөлбөрийг ярьж байгаа үед сайд нар маань гараад явчих юм. Энхбаяр сайдаас бусад нь байна уу. Боловсролын сайд алга. Энэ алслагдсан аймгуудын онгоцны тоог нэмэгдүүлэхийг ирэх 4 жилдээ маш богино хугацаанд сайжруулмаар байна.

Боомтын сайдад бид нар бас нөгөө бүлгийн хурал дээр ярьсан. Манайд боомтын сэргэлтийн хүрээнд манай Баян-Өлгий аймгийн баруун хязгаарын босоо тэнхлэгтэй шууд транзит Орос, Хятад 2-ыг холбосон гол үүд болсон Даяангийн боомтын засмал замын асуудлыг энэ үйл ажиллагааны хөтөлбөр, мөрийн хөтөлбөр дээрээсээ заавал хөтөлбөр дээрээ суулгаад явахыг дахиад хэлье чуулган дээр.

3 дахь асуудал маань энэ хөдөө аж ахуйн салбарт зоригтой хөрөнгө оруулалт хиймээр байна. Яг энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг харахаар ерөөсөө маш учир дутагдалтай байна.

Энхбаяр сайд маань яг өөрөө энэ салбарын хүн хичээгээд ажиллаад байгаа. Гэтэл яг энэ үйл ажиллагааны хөтөлбөр дээрээ эргэлзээтэй заалтууд ороод ирсэн байгаа юм. Хөдөө аж ахуйн салбар дахь төрийн оролцоог хязгаарлаж, татаас дэмжлэгийг боловсруулах шатны үйлдвэрлэл рүү чиглүүлнэ гээд биччихсэн байгаа нь одоо яг олгогдож байгаа б төрлийн урамшууллыг маань хасаад хаячих юм биш биз дээ. Сүүний урамшуулал, арьс ширний урамшуулал, ноосны урамшуулал, хүнсний ногооны урамшуулал, улаан буудайн урамшуулал. Эдгээр урамшууллын бодлогыг зайлшгүй авч явахгүй бол энэ хөдөө аж ахуйн салбар гэдэг бол хүнс бэлдэж байгаа салбар шүү дээ. Зах зээлтэйгээ өрсөлд, Орсстой өрсөлд гээд хаяж болохгүй. Тийм учраас эдгээр энэ бодлогуудыг хөдөө аж ахуйн салбар дээр илүүтэй анхаарах нь зөв байх гэж бодож байна. Ерөнхийлөгчийн гаргасан хүнсний хувьсгалын хүрээнд ч гэсэн 4 минутад юу ч ярьж амжихгүй юм байна даа дарга аа.

Д.Амарбаясгалан: Зөндөө л их юм ярилаа. Хажсекберийн Жангабыл гишүүн үг хэлнэ.

Х.Жангабыл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 4 бодлого дэвшүүлсэн байна. Бүхэлд нь ерөнхийдөө дэмжиж байгаа. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд баруун бүсэд хэрэгжүүлэх төсөл ажил ажлууд ерөнхийдөө агуулгаараа хөтөлбөрт орсон байна. Гэхдээ ороогүй ажлууд байна. Сая Ерөнхий сайд маань аймгуудын төв болон боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох талаар ярилаа. Мөн Тулга сайд Даяангийн боомтыг сайн мэдэж байгаа бөгөөд хэрэгжүүлэх зүйтэй гэж хөгжүүлэх нь зүйтэй гэж илэрхийлж байсан. Иймд Баян-Өлгий аймгийг хөгжүүлэх хөшүүрэг бол зураг төсөл нь бэлэн болсон Даяангийн боомтыг аймгийн төвтэй хатуу хучилттай автозамаар холбоно гэж Засгийн газрын хөтөлбөрийн 2024 оноос 2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.2.20 дахь заалт болгон тодорхой тусгаж өгөхийг хүсэж байна. Ийм саналтай байна.

Д.Амарбаясгалан: Энхбатын Болормаа гишүүн.

Э.Болормаа: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгээд 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг бэлдсэн Засгийн газрын гишүүд болон ажлын хэсгийнхэндээ бас юуны өмнө талархал илэрхийлье. Бүтнээр нь дэмжиж байгаа. Миний хэлэх санал бол энэ үйл ажиллагааны хөтөлбөрт юу орсон бэ гэхээсээ илүү үүнийгээ яаж хэрэгжүүлэхтэй холбоотой санал байгаа. Тэгэхээр санхүү мөнгө болон боловсон хүчинтэй шууд холбоотой гэсэн үг. Санхүү талдаа бол 2024 онд эхний хагас жилдээ Монгол Улсын эдийн засаг 5,6 хувийн өсөлттэй гарсан. Энэ бол энэ өвлийн зуднаар най 8 сая гаруй мал хэрвээ хоргогдоогүй байсан бол 9 гаруй хувьтай гарах байсан ийм өндөр үзүүлэлт. Цаашидаа ч олон улсын байгууллагууд

гадаад эрсдэлгүйгээр 6-8 хувийн эдийн засгийн өсөлттэй байна гэсэн ийм эерэг үзүүлэлтийг харуулж байгаа. Тэгэхээр энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх бас төсвийн шинэчлэлийг Сангийн яам 2025 оны төсөв дээр оруулж ирээсэй гэж хүсэж байна. Онцгойлон о татварын бодлого, НДШ, НӨАТ, тэтгэврийн реформ гэх мэтчилэн эдгээр шинэчлэлүүдийг санхүүтэй холбоотойгоор энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр оруулж ирээсэй гэдэг саналыг хэлмээр байна.

2 дахь санал бол боловсон хүчинтэй иууд холбоотой. Энэ бидний хэлэлцэж байгаа үйл ажиллагааны хөтөлбөрийг 126 Улсын Их Хурлын гишүүн хэрэгжүүлэхгүй, дан ганц 23 сайд хэрэгжүүлэхгүй, 280 гаруй мянган төрөөс цалин авч ажиллаж байгаа төрийн албан хаагчид хэрэгжүүлэх байгаа. Тэгэхээр төрийн албаны шинэчлэлгүйгээр энэ үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжихгүй байх гэж бодож байна. Өнөөдөр Монгол төрийн албаны соёл өөрөө иргэн төвтэй бус, дарга төвтэй болсон байна. Төрийн албанд бүтээмж, ур чадварыг эрхэмлэхээс илүү төрийн албан хаагчдаас бол цаг наргүй тайлан үйлдвэрлэхийг шаардаж байна. Ийм нөхцөл байдалтай ийм соёлтойгоор энэ үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжинэ гэдгийг бол үнэхээр төсөөлөхөд бас бэрх байна. Тэгэхээр энэхүү үйл ажиллагааны хөтөлбөрийг цаасан дээр царцсан зүйл болохоос илүүтэйгээр яг бодит байлгахын тулд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар мөн Төрийн албаны зөвлөл энэ төрийн албаны шинэчлэл гэдэг зүйлийг зоригтойхон хийгээсэй гэдэг саналыг хэлмээр байна. Энэ дунд бүр онцгойлон хэлэхэд мерит зарчим гэдэг зүйлийг үнэхээр маш хязгаарлагдмалаар зөвхөн төрийн албанд ажилласан он жилүүдээр тооцож байгаа нь олон залуучуудын бас боломжийг хязгаарлаж байгаа. Мерит гэдэг нь Монголоор орчуулахад чадавхуй гэж орчуулж байгаа. Тэгэхээр ур чадвар, туршлага үүнээс гадна ёс зүй, бүтээмж гээд олон зүйл мерит зарчмыг бол нийтэд

нь бүрдүүлнэ гэж бодож байна. Тэгэхээр энэ Монгол төр энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг магадгүй хэрэгжүүлэхийн тулд олон чадвартай, зоригтой, сэтгэлтэй, ёс зүйтэй ийм залуучууд бэлэн байгаа. Өнөөдөр төрийн албанд орохын тулд заавал нэг улс төрч юм уу, даргыг гуйж байж төрийн албанд ордог биш. Яг тодорхой зөв эрүүл соёлтой ийм төрийн албаны системтэйгээр энэ үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжинэ. Тэгэхээр өнөөдрийн байгаа магадгүй сайныг оруулахгүй, мууг гаргадаггүй энэ системийг халж, шинэчилж байж энэ үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжих байх гэж бодож байна. Тэгэхээр өнөөдрийн энэ үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжиж байна. Энэ маань заавал хэрэгжээс гэж бодож байна. Тэгээд ингэхийн тулд хамгийн том эрсдэлүүдийн нэг нь хэрвээ төрийн албаны шинэчлэлийг хийж чадахгүй бол энэ хэрэгжихгүй байх гэж бодож байна. Тэгээд энэ дээр анхаараасай гэж хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан. Алдаржавхлан гишүүний микрофоныг өгье.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа. Манай Их Хурлын гишүүд чинь бараг өөртэй ярьж байгаад л гарчих шиг боллоо доо. Засгийн газрын гишүүд бас ганц нэг улсууд байгаа учраас 2, 3 үг хэлье.

Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ 3 зүйлийг би бас анхаарч үзээсэй гэж хүсэж байна. Монгол хүн хэзээ аз жаргалтай байх вэ гэхээр 1 дүгээрт цалин нь хангалттай байх ёстой. 2-т нь амьдрах орчин нь бас аюулгүй, тааламжтай байх ёстой. 3 дугаарт нь эрүүл саруул байх л юм бол Монгол хүмүүс аз жаргалтай байна гэж боддог. Тийм учраас 1 дүгээрт миний хувьд энэ цалингийн асуудал дээр бас ирэх 4 жилд онцгой анхаар гэж хүсэж байгаа.

Сая манай хот нийтийн аж ахуйн ажилтнууд ТҮК-ийн ажилтнууд чинь 3

сая 500 мянган төгрөгийн цалинтай болчихсон шүү дээ. Тэгэхээр ядаж нийт төрийн албан хаагчдынхаа цалинг энэ түвшинд хүрэх талаар манай Засгийн газар маань ирэх 4 жилд анхаараасай гэж хүсэж байна. Тэгвэл хүмүүс үнэхээрийн ажилдаа бас идэвхтэй, сэтгэлтэй ажилладаг юм байна лээ.

2 дугаарт нь зас засаг захиргааны шинэчлэлээ зайлиггүй хийгээсэй гэж хүсэж байна. Улаанбаатар хотыг 14 хот болгохоор бид нар төлөвлөсөн байгаа. Миний хувьд энэ 20 минутын хот гэдэг анхлан 2 жилийн өмнө санаачилж явсан. Тэгээд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсонд би их баяртай байгаа. Би орон нутагт ажиллаж байсан хүний хувьд энэ хотуудын асуудлыг заавал оруулах ёстой гэж үзэж байгаа. Тэгээд Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт болж өгвөл нэрийг нь бүр дурдаад явчихмаар байгаа юм. Тэгэхгүй бол сүүлд нь больчих вий гэсэн айдас байгаа. Тийм учраас энэ засаг захиргааныхаа шинэчлэлийг зайлиггүй хийгээсэй гэж хүсэж байна.

3-д нь хамгийн сүүлд нь энэ нэг сонин асуудал бол үлдчихээд байгаа юм. Энэ Монгол бичгийн асуудлыг Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт оруулахгүй бол 2025 оны 1 сарын 1-ээс бид нар чинь 2 бичигтэй болох ёстой гэсэн шүү дээ. Албан бичиг чинь төрийн бүхий л байгууллагууд Монгол бичгээр албан бичгээ хөтлөх ёстой гэсэн. Улсын Их Хурлын бүх гишүүд албан бичгээ 2025 оны 1 сарын 1-ээс Монгол бичгээр давхар явах ёстой юм байна лээ. Тэгэхээр энийгээ ер нь яах юм бол. Цаашаа үргэлжлүүлэх юм уу яах юм. Энийг Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт бас тодорхой оруулж өгөхгүй бол ер нь тэгээд энд яг Монгол бичгээр бичдэг хүн хэд байгаа юм бол. Шууд кирилл шигээ уншдаг хүн хэд байгаа юм бол энэ төрийн албан хаагч дотор чинь. Тэгэхээр энэ Монгол бичгийнхээ асуудлыг бас Засгийн газрынхаа мөрийн хөтөлбөрт анхаараад, тодруулж оруулаасай гэж хүсэж байна. Байнгын хороо дээр мөрийн хөтөлбөр яригдахад

миний хувьд энэ асуудлыг бас хөндөж гаргаж тавина гэж бодож байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг бол дэмжиж байна. Бүхий л салбарыг хамрах гэж үзсэн байна. Баярлалаа. 1 минут 30 секунд хэллээ шүү.

Х.Булгантуяа: Ренчиндоржийн Батболд гишүүн.

Р.Батболд: Оройн мэнд хүргэе. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийн өсөлт, эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой сэргээгдэх эрчим хүч, дэд бүтцийн асуудлууд орж ирсэн байна. Тэгээд ер нь бол хэлэлцэх асуудлыг дэмжиж байна. Тэгэхдээ энд 2, 3 санаа хэлчихмээр байна.

Ер нь эцсийн бүлэгтээ бид нарын гол зорилт бол ер нь ард түмний амьжиргааны түвшинээ л өсгөх асуудал гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ нийгмийн салбарт явуулах бодлого, тэрэнд хүрэх үзүүлэлт энэ асуудлаа ер нь 1 дүгээрт эрэмбэлээд явж болдоггүй юм уу. Энд хүрэхийн тулд ямар эдийн засгийн бодлого, ямар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх вэ гэдэг нь 2 дугаар асуудал болов уу л гэж бодож байна. Тэгэхээр энэ нийгмийн салбарынхаа асуудлыг 1 дүгээрт эрэмбэлээд явахгүй юм уу гэдэг юм. Тэгээд дараа нь бол Алсын хараа 2050 гээд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан Нийгмийн хөгжил амьдралын чанараараа Ази-д тэргүүлэгч орнуудын 1 болно гэсэн энэ зорилт. Энэ зорилт дотор тусаагүй харагдаад байгаа юм.

Тэгээд 2 дахь асуудал нь гэвэл урьд нь хэрэгжиж байсан төсөв, төсөл, хөтөлбөрүүд энд орж ирээгүй харагдаад байна. Тэгээд Засгийн газрын тэргүүн маань бас түрүүн улс төрөө дийлэхгүй. Одоо хийлгэхгүй гэж байгаа бол наана чинь хийхгүй өөр газар хэрэгжүүлээд явна гэсэн ийм нэг ганц нэг төслүүд байгаад байх шиг байх юм. Тэгэхээр одоо бид нар энд том том төслүүдээ оруулж ирээд, энийгээ хөдөлгөөд явъя гэж ярьж байдаг.

Тэгээд алсдаа дахиад л наад улс төрийг чинь дийлэхгүй юм байна, одоо больё, энийгээ больё, өөр газар хийгээд явъя гэдэг асуудал гараад байх юм уу, үгүй юу гэдэг нэг асуудал байгаа юм. Тэгэхээр аль болох урьд нь хэрэгжиж байсан төслүүдээ цааши нь хэрэгжүүлээд, тэр төслүүдээ дуусгаад, бас үр шимийг нь хүртээд явах талаар анхаарч ажиллах байх гэж бодож байна. Тэгээд боловсролын салбартай холбоотой уг нь сайд нь байсан бол ганц нэг юм хэлчихмээр байна. Энэ англи хэл гэдэг зүйлийг л их өндөрт тавиад яваад байх шиг байна. Одоо энэ Монгол хэл, Уран зохиолын асуудлыг ер нь яаж авч үзэх гээд байгаа юм бол. Одоо 3 дугаар ангиас эхлээд л байнга англи хэл заагаад л явчих юм шиг байна. Тэгээд энэ ер нь МАН, Ардын нам, ХҮН намын нийлсэн энэ Засгийн газарт ер нь ямархуу бодлого байдаг юм бол гэдэг асуудал. Бодлого гэж ер нь ер нь юу юм бэ. Хаана төвлөрөөд яваад байгаа юм бэ гэдэг асуудал байгаа юм. Энийг би боловсролтой холбож хамгийн гол нь яриад байгаа юм. Юу вэ гэхээр одоо газрын тосны үйлдвэр 2027 онд ашиглалтад орох ийм төлөвлөгөөтэй яваад байгаа. Гэтэл энд гарч ирж байгаа түүхий эд, бүтээгдэхүүн, тэнд ажиллах боловсон хүчин нь байгаа юм уу. Энэ газрын тосны үйлдвэртэй холбоотой бид нарт маш олон химичид, физикчид хэрэгтэй болох байх. Тэгэхээр энийгээ бэлдэх тал дээр өнөөдрөөс эхлээд ажиллахгүй юм уу. 2027 онд газрын тосны үйлдвэр нь ашиглалтад орчихоор бид нарт ийм боловсон хүчин хэрэгтэй юм байна шүү дээ гээд хөөцөлдөөд явах юм уу гэдэг нэг ийм. Тэгэхээр энэ тал дээр бас анхаарч ажиллаач гэдэг л саналуудыг хэлье.

Х.Булгантуяа: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн.

Ц.Мөнхбат: Энэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр хэлэлцэж байгаатай холбогдуулаад өөрсдийн бүс нутагтай холбоотой асуудлуудыг зайлиггүй ярихгүй байхын бас аргагүй байгаа юм. Жишээ нь, түрүүн

Эдийн засаг, хөгжлийн сайдаас Мөнхбаясгалан гишүүн асуусан. Дундговь аймгийн Цагаан суварга орчмын палеонтологийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна гээд. Тэгээд энэ мөрийн хөтөлбөр дээр хэлэлцэгдэж явж байгаад яг өнөөдрийн танилцуулагдаж байгаа мөрийн хөтөлбөрөөс хасагдчих юм. Тэгээд энэ дээр тодорхой хариулт бас өгсөнгүй. Редакцын засвар хийгээд оруулчихна гэхчээ үү, түрүүн юу гэхчээ ээ. Тэгэхээр энэ дээр нэг тийм тодорхой хариулт өгөх хэрэгтэй. Энийг бол суулгах хэрэгтэй. Эдийн засгийн яам өөрөө өнгөрсөн жил 700 гаруй сая төгрөгөөр ТЭЗҮ-ийг нь боловсруулсан шүү дээ. Тэгээд дараа нь энийгээ мөрийн хөтөлбөрөөсөө аваад хаячихаар энэ чинь тэгээд хэрэгжинэ гэсэн үг юм уу, тэгээд хайран одоо салхинд хийсгэсэн ТЭЗҮ болоод үлдэх юм уу. Энийг зайлиггүй тусгах шаардлагатай гэж ингэж үзэж байна.

2 дугаарт нь энэ эдийн засгийн ач холбогдолтой бүс нутгууд руу авто замын шинэчлэлийн асуудлууд байгаа. Улаанбаатар, Мандалговь, Даланзадгад чиглэлийн авто замыг ирэх 4 жилийн хугацаанд хос болгоно, 2 эгнээтэй болгоно гэсэн ийм сайхан зорилт орсонд бол баяртай байгаа юм. Гэхдээ энийг ТЭЗҮ, зураг төсөв боловсруулаад 2 жил болно. Дараа нь хөрөнгө мөнгийг нь олоод явуулах гэж байтал бас нэг хугацаа орно. Үгүй ээ, наана нь нөгөө зам засварын шинэчлэх, их засвар хийх энэ юм чинь энэ мөрийн хөтөлбөр дээр ороогүй байна. Тэгэхээрээ зэрэг энийг бол зайлиггүй оруулах хэрэгтэй. Өдөр болгон энэ зам засварын асуудлууд чинь улам их эвдрэл, гэмтэл бий болж байна. Үүнээс болоод энэ говийн бүс нутаг руу зорчиж байгаа иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө сүйдэж байгаа ийм олон асуудлууд ард нь дагаж явдаг. Тэгэхээр энийг бол зайлиггүй энэ мөрийн хөтөлбөрт оруулаад явах ёстой гэж ингэж үзэж байгаа юм.

3 дугаарт энэ сум, орон нутагт сумын төвийн шинэчлэлийн асуудал дээр бас тодорхой зүйлүүд бас тусгагдахгүй байна. Ерөнхий тусгагдаад байна. Энэ сумын төвүүдийг шинэчилж байж энэ дээр бид нар хөрөнгө мөнгө гаргаж байж Улаанбаатар хот руу шилжин ирэгсдийн тоо чинь өөрөө багасах, хотын хүн амын өсөлт чинь саарах ийм боломж нөхцөлүүд нь олдоно. Бид нар ойролцоогоор 1 сумыг 10 орчим тэрбум төгрөгөөр шинэчилнэ гэхэд 330 сум 3 их наяд л төгрөг байхаар шүү дээ. Жил болгон ингээд хуваагаад тавиад энэ 4 жилд 1 их наядыг жилд тавиад явахад бол 4 жилд энэ сумын төвүүдийг бүрэн дэд бүтэцтэй болгох ийм боломж бид нарт байгаа шүү дээ. Тэгэхээр энэ сумын төвийн шинэчлэлийн асуудлыг бол энд бас зайлиггүй оруулах ёстой гэж ингэж бодож байгаа юм.

Тэгээд мөрийн хөтөлбөрийн үндсэн одоо шинэ том төслүүд эхлүүлэх гэж байгаа энэ зүйлүүдийг бол дэмжиж байгаа. Баярлалаа.

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн гишүүд энэ гишүүдээс гаргаж байгаа саналуудыг та бүхэн маань сайн тэмдэглэж аваарай. Энд Засгийн газрын гишүүдээс 4 сайд л байна. Ер нь салбар салбарын асуудлуудыг ярьж байна. 2025 оны 1 сарын 1-ээс хэрэгж эхлэх гэж байгаа Монгол бичгийн асуудлыг, нийгмийн салбарын хөгжлийн асуудлыг, төрийн бодлогын залгамж халаа тууштай байх ёстой. Бодлого, төлөвлөлт яг хаанаас хийгдэж байгаа. Эдийн засаг, хөгжлийн яамнаас хийгдэх үү. Салбарын сайд нь уг нь энэ саналыг тавьж байна гэсэн. Боловсролын салбарын асуудлаар сайд нь байхгүй байгаад байна. Улсын Их Хурлын төлөвлөгөө дээр дутуу үлдсэн асуудлууд дээр Улсын Их Хурлын гишүүд маань бас Байнгын хороо дээр ороод хэлэлцэх явцад саналаа гаргах боломжтой байгаа. Та бүхэн өөрийнхөө харьяалагдах Байнгын хорооноос гадна бусад Байнгын хороо дээр ч гэсэн Их Хурлын гишүүний хувьд бол ороод саналаа гаргаад явах бүрэн боломжтой. Тийм учраас хэлэлцэгдэж

эхлэхэд холбогдох Байнгын хороо дээр нь та бүхэн маань бас ороод ажиллахад Мөнхбат гишүүн бас боломжтой байгаа шүү.

Дараагийн гишүүн Бадамсүрэн гишүүн байхгүй байна. Батбаярын Жаргалан гишүүн.

Б.Жаргалан: Шинэ парламент байгуулагдаад сар хагасын хугацаа өнгөрч байна. Шинэ Засгийн газар өнөөдөр мөрийн хөтөлбөрөө оруулж ирээд, үйл ажиллагааны хөтөлбөрөө оруулж ирээд бид хэлэлцэж байгаа. Энэхүү шинэ парламент болон хамтарсан Засгийн газраас иргэдийн хүлээлт бол маш өндөр байгаа. Мөн маш их шүүмжлэлтэй хандаж байгаа гэдгийг бид нар бас бүгдээрээ ойлгож байгаа.

Монгол Улсын өмнө тулгамдсан маш олон асуудлууд байна. Бид бол өнгөрсөн хугацаанд ардчиллаас ухарсан, эдийн засаг нь төрөөс хараат болсон, хүний эрхийн зөрчил газар авсан, хүний эрх битгий хэл иргэдийн амьд явах эрх аюул заналд учирч байна. Утаа түгжэрлээс авхуулаад л эрүүл мэндийн тогтолцоо хүнд байна. Боловсролын тогтолцоо хүнд байна гэх мэтчилэн бид нарт бол шийдвэрлэх шаардлагатай маш олон асуудлууд байна. Тэгэхээр энэ 4 жилийн хугацаанд шинэ Улсын Их Хурал бөгөөд шинэ хамтарсан Засгийн газар энэ бүх асуудлуудаа ингээд оновчтой томъёолоод, урагшаа бас зориг гаргаад явна гэдэгт итгэж байгаа, найдаж байгаа. Тэгээд яг энийг бас давхар сануулахыг хүсэж байна.

Бас харамсалтай нь хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тэргүүлэх чиглэлээ болгож байгаа зарим нэг зүйл заалтууд, нэн ялангуяа бас хамгийн их ач холбогдол өгч байгаа мэтээр хамгийн түрүүнд тавьж байгаа зарим зүйл дээр бол ингээд бас өрөөсгөл асуудлууд их байна. Жишээлэх юм бол бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд өөдөө тэмүүлэх Монгол буюу Go

Mongolia, Ган татлагат гүүрний төсөл, Хөшигийн хөндийн туннелийн төслийг хэрэгжүүлнэ гээд энийгээ бас давхар төсвийн тодотгол дээр бараг 83,9 тэрбум төгрөгийн ТЭЗҮ-ийн зардал тавиад ороод ирж байна. Мөн Хөшигийн хөндий төр захиргааны нэгдсэн байрыг барьж ашиглалтад оруулна гээд 676 тэрбум тавиад бас ороод ирж байгаа юм. Тэгэхээр бид ингээд өмнө нь дурдсан тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх бус бас ийм нөгөө цагаан заан гэж нэрлэгддэг үр өгөөж багатай, маш их зардал бүхий хэн нэгэн улс төрийн лидерийн сүүр хүч, эрх мэдлийг илтгэх ийм төслүүд дээр ийм их мөнгө бас тавьж орж ирнэ гэдэг нь бол бас учир дутагдалтай санагдаж байгаа юм. Тэгэхээр Засгийн газар бас үйл ажиллагааныхаа дараалал дээр анхаарч, яг одоо иргэдэд хүрсэн энэ ажлуудаа түрүүлж явуулаад ийм рекламн шинж чанартай төслүүдээ магадгүй эрэмбийн хувьд хойгуур оруулдаг юм уу нэг тийм санал бас хэлэхийг хүсэж байна.

Тэгээд манай энэ парламентын гол зорилго бол энэ дарга ангийн дарангуйллын яг халж, давхар стандартыг үгүй болгож, иргэдийн амьдралыг сайжруулах, эдийн засгаа өөд нь татах ийм л зорилго агуулж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхээр төсвийн үр өгөөжтэй байдалдаа маш их анхаарах ёстой байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тавигдаж байгаа энэ олон мөрөөдлийн шинж чанартай төсөл хөтөлбөрүүдийн жагсаалтын бас эрэмбэ дэс дараа дээр нь бас анхаармаар байна.

Тэгээд хамгийн гол нь бас Их Хурлын гишүүний хувиар Засгийн газрын гишүүд бөгөөд энэ үйл ажиллагааны хөтөлбөртэй холбогдуулж юу гэж хэлэх байна вэ гэхээр энэ 4 жилд бид институц хоорондын хяналтыг маш ихээр сайжруулах хэрэгтэй байна. Тэгэхээр энэ парламент бол сөрөг хүчингүй парламент гэж та нар бодуузай. Ямагт бол парламентын хяналт бол тавигдана. Засгийн газрын гишүүд тэр хариуцлагаа

бас ухамсарлаж ажиллаасай гэдгийг хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: *Бөхчулууны Пүрэвдорж гишүүн байхгүй байна. Буланы Бейсен гишүүн.*

Б.Бейсен: *Энэ хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй танилцлаа л даа. Гол нь Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгалыг эрчимжүүлэх тал дээр онцгой анхаарах ёстой. Учир нь энэ маань сайн хэрэгжжихгүй байна. Хүнсний ногоогоо бид нар гадаадаас авч байна. Эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнсээр ард иргэдээ хангах ёстой. Гурил будаа нь болж байна. Цаад тал нь хүнсний ногоо ихэнхийг нь урд хөршөөс авч байна. Хүнсний аюулгүй байдал бүрэн алдагдсан. Үүнтэй холбоотой хавдар маш ихсэж байна. Залуужиж байна. Энэ цэвэр хүнстэй холбоотой. 80 хувь нь хүнстэй холбоотой байгаа юм. Тийм учраас энэ дээр онцгой анхаараад, мөрийн хөтөлбөртөө тусгах ёстой гэж бодож байна.*

2 дахь нь эрүүл мэндийн салбар. Эрүүл мэндийн салбарт Засгийн газар онцгой анхаарах ёстой. Хэдэн сайдуудаа л загнаад л байдаг, яамныхнаа, эмнэлгийн дарга нараа загнадаг. Гэтэл энэ салбарын ажилчдын цалин бага. Цалингийн сүлжээг нь 2 дахин нэмэх шаардлагатай. Ажил нь хүнд. 87 хувь нь цалингийн зээлтэй. Зээлээ нөхөх гээд Солонгос явж байна. Одоо хотын клиник эмнэлгүүд мэргэжилтнүүд дутагдалтай байна. Сувилагчийн дутагдалтай байна. Тийм учраас энэ цалингийн сүлжээг нэмж байж энэ салбарт анхаарахгүй бол болохгүй нь ээ.

Эмийн чанар бас алдагдсан. Эмийнхээ 70 хувийг импортоор авдаг. 20 хувь витамин шингэнээ л дотооддоо хийдэг. Тариа, антибиотик үйлдвэрлэж чаддаггүй. Үндэсний үйлдвэрлэлээ дэмждэггүй. Эрүүл мэндийн салбар 100 жил болоход эмийн үйлдвэр хөгжихгүй байна шүү дээ. Энэ дээр Засгийн газар энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой учраас энэ дээр онцгой анхаарах ёстой.

Энэ мөрийн хөтөлбөрт тодорхой тусгах хэрэгтэй гэж бодож байна.

Дараа нь хотын клиникийн эмнэлгүүдийн ачаалал их байна. Аймгийн нэгдсэн эмнэлэг мөн адилхан. Энэ оношилгооны төвүүдтэй холбоотой. Аймаг болгонд хотын хэмжээний оношилгооны төв байгуулах ёстой гэж бодож байна. Одоо хотын клиникийн эмнэлгүүдээр яваад судалгаа хийгээд үзсэн. Бид нар бараг 50-60 хувь нь хөдөөгийн иргэд байна шүү дээ. Оношилгоо шинжилгээ хийлгэх гээд энд ирж байна. Ачаалал их байна. Тийм учраас аймаг болгонд оношилгооны төв байгуулах асуудлыг Засгийн газар мөрийн хөтөлбөрт тодорхой тусгах ёстой гэж бодож байна.

Дараа нь чөлөөт бүсийн асуудал байж байна. Бараг 15 жил ажил байхгүй хашаад л байж байгаа. Тэгээд ажилчид нь хий дэмий цалин аваад л хотод байж байгаа шүү дээ. Чөлөөт бүсийн захиргаа нь. Энийг хөгжүүл хөгжүүлсэн шиг хөгжүүлээд, хөгжүүлэхгүй бол татан буулгах хэрэгтэй. Тэртээ тэргүй энэ чинь айл өрхийн түвшинд чөлөөт бүс, чөлөөт худалдаа явагдаж байгаа шүү дээ. Бүх хүнс, барилгын материал, нефть шатахуун бүгд орж ирж байгаа. Энийг Засгийн газар маань онцгой анхаараад, мөрийн хөтөлбөр тодорхой тусгаад хөгжүүлэх шаардлагатай байгаа.../минут дуусав/

Х.Булгантуяа: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Уг нь энэ гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, мөрийн хөтөлбөрөөр л байр сууриа илэрхийлээд байх юм. Засгийн газрын гишүүдээс нь бараг хүн алга. Хаданд хаширч байгаа ч юм уу бүү мэд. Энэ хурал даргалагч гишүүдээ, сайд нараа энд хуралдаа оролцуулмаар байна. Одоо 20, 30-аад гишүүн үг хэлэхээр нэр өгчихсөн. Тэгээд хэнд хандаж юу ч яриад байгаа юм бүү мэд.

Тэгээд зүгээр миний хэлэх гэсэн санаа бол бид нар шинэ 4 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө хэлэлцэж байна л даа. Тэгэхээр ер нь манай засагт нэг зүйл дутагдаад байгаа нь өмнөх явж ирсэн замдаа нэг тийм үнэлгээ хийх яам бүхэн бараг эхлээд нэг юм хийгээд нөхцөл байдлаа үнэлээд, алдаа маань хаана байна вэ гэхээд урагшаа явдаг биз дээ. Бид нар төлөвлөлт дээрээ алдаад байгаа юм уу. Өчнөөн олон төсөл эхэлчихсэн. Нөгөө төслүүд нь нөгөө нефтийн үйлдвэр жишээ нь хааччихсан юм. Нөгөө арьс ширний үйлдвэр хааччихсан юм. Юун дээрээ гол нь алдаад байгаа юм. Төлөвлөлтөө бид нар дутуу дулимаг юм хийчихээр ийм юм болчихоод байгаа юм уу. Зөв төлөвлөчихсөн зүйлийг гүйцэтгэл дээрээ алдчихаад байгаа юм уу. Зөв төлөвлөөд гүйцэтгэчихсэн юмыг ашиглалт дээрээ алдчихаад байгаа юм уу. Хаана бид нарын яг тэр алдаа байна вэ гэдэг дээр бодитой үнэлгээ, дүгнэлт гаргачхаад, энэ үнэлгээ, дүгнэлт дээрээ шинэ төсөл төлөвлөгөөгөө ярихгүй бол нэг ийм 0-ээс шинээр эхэлж байгаа улс орон шиг л бид нар баахан зураг төсөл, ТЭЗҮ хийгээд л эхэлж байгаа. Урьд өмнө энэ чинь нэг Монгол Улс гэж байгаа, төр засаг гэж байсан л байж таарна биз дээ. Энэ хаанаасаа юу нь үргэлжилж байгаа юм. Юундаа ямар дүгнэлт хийж байгаа юм гэдэг энэ нөхцөл байдлыг арга барилдаа жаахан оруулахгүй бол яг үнэндээ бид нар төсөл, ТЭЗҮ, макет, зураг төсөлд ер нь Монгол Улс хэчнээн 100 тэрбумыг зарцуулчихаад өнөөдөр тэр нь байгууллага бүрийн сейфт нэг зузаан цаас болоод хэвтэж байгаа өчнөөн л юм байгаа.

Дахиад дээрээс нь энэ төсвийн хөрөнгө оруулалтад өгөөж гэдэг нэг юм уг нь байх ёстой. Төсвийн хөрөнгө оруулалтад өгөөж. Хэзээ ч бид нар төсвийн хөрөнгө, төрийн мөнгөний өгөөжийг бид нар тооцож үзэж байгаагүй. Ярьдаг ч үгүй энийг. Баахан хөрөнгө оруулалт, баахан юм тавиад л, дахиад шинээр юу хийх вэ, шинээр юу хийх

вэ гэдэг л юм хайдаг болохоос биш тэр сургуулийн ангийн дүүргэлт хүртэл энэ төрийн болоод төсвийн мөнгөний өгөөж шүү дээ. Тэр тавьсан замаар хэдэн машин явж байгаа нь хүртэл өгөөж шүү дээ. Яагаад бид нар төрийн төсвийн мөнгөнийхөө хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцдог улс орон бас байж болдоггүй юм бэ. Тийм их хязгааргүй баян улс орон мөн юм уу, биш юм уу бид нар. Энэ бүгдийн чинь цаана л дахиад л олон олон зүйл, төсвийн тэлэлт, энэ бүгдийн чинь цаана нөгөө алдартай авлига, олон олон зүйл л үүний цаана явж л байдаг шүү дээ. Тэгэхээр тэр ер нь энэ яам бүхэн засаг болоод энэ төсөв төлөвлөгөө хөтөлбөр дээр шинээр тавьж байгаа зүйлийнхээ үндэслэлийг, тэр үнэлгээг хаанаа бид нар алдаж оноод байна вэ гэдэг дээрээ оношилгоогоо хийгээд, энэ рүүгээ чиглэсэн тэр чадавхыг нь анхаарлаа илүү хандуулахгүй л юм бол одоо зүгээр л нэг цоо шинээр ажил эхэлж байгаа улс орон юм шиг л нэг ийм л нөхцөл байдал ажиглагдаж байгааг бас хэлэх гэсэн юм.

Х.Булгантуяа: Засгийн газрын сайд нар чуулгандаа орж ирж суугаарай. Одоо ахиад бараг 20-иод гишүүн үг хэлэхээр байна. Энд нийтдээ 5 сайд л сууж байна. Тэгэхээр нэмж дахиад 20-иод гишүүн үг хэлнэ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй холбоотой л саналыг хэлж байна. Бид яаж дэмжих вэ, яаж Улсын Их Хурал хамтран ажиллах вэ гэдэг саналуудыг хэлж байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд. Үгүй ээ, манай Засгийн газрын сайд нар энэ дээр бас санал хэлэх шаардлага байхгүй байлгүй дээ. Сайд нар бие биеэсээ асуулт асуугаад, санал хэлээд байх бол зохимжгүй байх. Хэрвээ асуулт саналтай бол Засгийн газрынхаа хурал дээр хэлээд явсан нь зүйтэй. Ренчинбямбын Сэددорж гишүүн.

Р.Сэددорж: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. 3 нам анх удаа ингээд нэгдээд үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрөө батлах гэж байна. Тэгээд биелэлтээ их бодитой гаргаарай гэдгийг бас энэ дээр хэлье. Ер нь бол биелэлтийг

бол маш өндөр тоотой гаргадаг. Бодит байдал дээр хэдэн хувьтай байдаг вэ гэдгийг хүмүүс бол сайн мэдэж байгаа. Судлаачид, судалгааны байгууллагууд бол сайн мэддэг. Тэгээд энэ хэрэгжилтийг 80 хувь руу дөхүүлэх тал дээр хичээж ажиллахыг хүсье. Говийн бүсийн тэр дулааны цахилгаан станц гээд маш чухал. Тэгээд энийг 1 аймгийн 1 бүсийн юм шиг яриад ойлгоод байх шиг байна. Даланзадгадын станц баригдвал говийн бүсийн өмнөд бүсийн эрчим хүчний системд маш хэрэгтэй. Тэгээд энийг бас нэрээр нь оруулчихаач гэдгийг хэлье. Тэгээд мөрийн хөтөлбөр бол энэ төвлөрлийг сааруулсан сүүлийн 30-аад жилийн бодлого, эрх мэдлийг төвлөрүүлснээ буцааж тараах энэ чиглэл рүү ажиллах хэрэгтэй байна. Аймгуудад эрх мэдлийг нь өгье гээд их ярьсан боловч сүүлийн жилүүдэд бол энэ эсрэгээрээ байсан. Тэгэхээр аймаг өөрөө өөрийгөө авч явах тал дээр эрх мэдлийг нь өгөхгүй бол ерөөсөө болохгүй. Энэ аймаг чинь аймаг болгон өөр өөрийн онцлогтой, өөр өөрийн давуу талтай, өөр өөрийн уул уурхайтай. Ийм учраас аймаг өөрөө өөрийгөө авч явах энэ боломжийг нь хангаач ээ. Ингэвэл аймаг өөрийн орон нутгийн өмчийн компани эд нар байгуулах эрхийг нь өгөөд явбал засгийн ачаалал бол маш хөнгөрнө гэдгийг хэлье.

Тэгээд энэ говийн бүсийн усны асуудлыг бол зөвхөн говийн бүсийн асуудал гэж бас бодоод байх шиг байна. Энэ ус очвол Монгол Улсын эдийн засаг хэдэн хувиар нэмэгдэхийг судлаачид гаргаж ирж чадна. Дээрээс нь энэ үг үсгээр зөвхөн цөлжилтийг бууруулах мод тарих тухай орсон байна. Энэ бол дээрээс нь бол эрүүл хүнсний ногоо тариалах асар их боломжтой. Хамгийн их нартай бүс нутаг. Тэгээд тэр усны хоолойнуудыг дагаад 15км тутамдаа эрүүл хүнсний ногоо тариалах, жимс жимсгэнэ ч тариалах ийм бүс нутаг эрүүл хүнсний асуудал энд орж ирэх юм гэдгийг хэлье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн. Пунсалмаа гишүүний микрофоныг өгье.

Б.Пунсалмаа: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Ерөнхий агуулгаар нь бол улс орны чанартай томоохон төслүүдийг хөдөлгөх гэж байгааг дэмжиж байна. Тэгэхдээ энэ их хөрөнгө оруулалтууд эдийн засагт маш ихээр төсөв урсгал зардал орж ирээд инфляцыг дахиад хөөрөгдчих вий. Инфляцаар дамжигдаад арилжааны банкнуудаар олгогддог зээлүүд багасчих вий гэж сэрэмжилж байна. Тэгэхээр арилжааны банкнуудаар бага хүүтэй олгогдож байгаа энэ зээл бол аж ахуйн нэгжүүдийн ерөөсөө хөгжлийн суурь байдаг юм. Аливаа нэгэн төсөл хөтөлбөр, жижиг, дунд үйлдвэрлэл, ноос янз бүрийн хөтөлбөрүүдтэйгээ зэрэгцүүлээд арилжааны банкнуудын бага өртөгтэй энэ боломжоо бид нар давхар хөгжүүлж авч явах нь энэ олон, 170 гаруй мянган аж ахуйн нэгжүүдэд хөгжлийн суурь шүү гэж ингэж хэлмээр байна.

2 дугаарт нь энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу 14 том мега төсөл 2024 оны мянга гаруй төсөл хөтөлбөрүүдэд үндэсний компаниудаа яаж дэмжиж оруулж ирэх гэж байгаа юм. Магадгүй мега төслүүдэд гадаадын компаниудын хийж гүйцэтгэх ажлууд байгаа байх. Тэгсэн ч гэсэн үндэсний компаниуд бол эдгээр ажлуудад илүү тэргүүн эгнээнд оролцох энэ боломжийг нээж өгмөөр байна. Энэ их бүтээн байгуулалтаар дамжуулаад үндэснийхээ компаниудыг чадавхжуулж авах ийм чухал он жилүүд байгаасай гэж ингэж бодож байна.

3 дугаарт нь. Ер нь төсвийн төсөөлөл болон төсвийн хүрээний хуулиуддаа бид нар дотооддоо үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүнийг жил тутам дэмжих хэмжээгээ зарлаж өгмөөр байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүний тэдэн хувийг нь 2024 ондоо, 2025, 2026 ондоо тэдэн хувийг нь дотоодын үндэсний бүтээгдэхүүнийг импортыг орлуулж бид нар дэмжиж, Засгийн газраас хөрөнгө оруулалт болон худалдан авалтаар дэмжлэг болж оролцоно гэдгээ зарлаж өгөх юм үүний цаана үндэсний маш олон компаниуд тоног төхөөрөмжийнхөө хөрөнгө оруулалтыг хийгээд, үйл ажиллагаагаа өсгөөд ингээд эдийн засаг өсөх энэ боломж бололцоо бий болно. Ингэж байж иргэдийн өрхийн орлогод шууд нэмэртэй, иргэдийн цалин хөлсний хэмжээ өсөх ийм зүйлээ бид нар бас анхаармаар байна гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн.

Л.Соронзонболд: Гишүүдийнхээ оройн мэндийг эрье. Ерөнхийдөө Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг бол дэмжиж байгаа. Тэгэхдээ бас хэд хэдэн зүйлийг заавал дурдаж хэлэх ёстой болов уу гэж бодож байгаа. Өнөөдөр нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан шинээр бүрдүүлэхээр мөрийн хөтөлбөрт тусгачихсан байгаа. Гэтэл одоо бид нар өнөөдөр хүн болгонд тэтгэврийн нэрийн данс нээгээд, тэр дээр нь ингээд бас өөрсдөд нь ийм мөнгө байгаа юм шиг харуулаад явдаг. Энийг бол улс маань өөрөө ингээд өр дээрээ бүртгэдэггүй. Энэ хаана ч байдаггүй нэг ийм асуудал байгаа. Тэгэхээр энийг бас цаашидаа яг ямар байдлаар шийдэх вэ гэдэг дээр энэ талыг хариуцсан яамд бол анхаарч ажиллах ёстой болов уу гэж бодож байна.

2 дугаар асуудал болохоор одоо дэлхий даяар ногоон шилжилтийг эрчимжүүлэх тухай их яригдаж байна. Монгол Улсын хувьд ч гэсэн энэ дээр бол бид нар Үндэсний ногоон такс номоо батлаад ингээд явж байгаа. Тийм учраас ялангуяа Барилга, хот байгуулалтын яам дээр ногоон орон сууцын зээл, зээлийн хүү

нь энгийн орон сууцын зээлийн хүүгээс ялгаатай байдаг. Мөн гэр хороолол хөдөө орон нутагт хүмүүс бие даасан ногоон шийдэлтэй амины орон сууцыг барьж, ашиглаж амьдрах энэ нөхцөлийг нь хангах тал дээр экосистемийг нь бүрдүүлэх дээр илүү анхаарах ёстой юм болов уу гэж бодож байгаа.

3 дугаарт болохоор бол ер нь банк санхүүгийн системд хийх өөрчлөлтийн хүрээнд гадаадын банкны салбар оруулж ирнэ гэж ярьж, бичсэн байна. Гэхдээ бид Монгол Улс маань яг одоо олон улсын түвшинд банкны санхүүгийн үйлчилгээгээрээ бол дэлхийд бол тэргүүн байранд орж байгаа. Бид яг аль салбар сегмент дээрээ оруулж ирэх вэ гэдэг дээр бас нэлээн нарийн бодох ёстой болов уу гэж бодож байгаа. Өөрөөр хэлбэл Монголчууд өөрсдөө хийж чаддаг салбар дээр гадаадын банкны салбар оруулж ирэх үү гэдгийгээ бол бодох ёстой болов уу. Өнөөдөр яагаад хүү өндөр байгаа вэ гэхээр зөвхөн банкнуудаас хамаарахгүй. Энд бол Монгол Улсын маань өөрийнх нь эрсдэлийн түвшин ийм өндөр түвшинд байгаа. Тэгэхээр энэ эрсдэлийн түвшнийг өндөр болгоод байгаа орчныг бууруулах дээр л манай төр засаг бид бүгдээрээ ажиллах ёстой гэж бодож байна. Эдгээр асуудлыг бас хариуцсан хүмүүс нь анхаараарай гэж хэлмээр байна. Баярлалаа.

Х.Булгантуяа: Сонгобайн Замира гишүүн.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй танилцлаа. Маши том төлөвлөгөө гаргасан байна. Тэгэхдээ энд зарим нэг юмнуудыг тодорхой болгосон нь дээр болов уу гээд боддог юм. Монгол Улсад бол ер нь ахуй үйлчилгээний салбар гэж байсан нь дээр үед. Ахуй үйлчилгээний салбар нь юу хийх байсан гэхээр нь бүх Монголын ард түмний өмсөх хувцас хунар, гутал, энэ бүгдийг нь өөрсдөө үйлдвэрлэдэг байсан. Тэр салбар байхгүй болсноор манай Монгол Улсын

эдийн засаг, мөнгө санхүү гадагшаа уурсаж байна. Урагшаа, хойшоо уурсаж байна. Бүх хувцсыг бид нар гадаадаас аваад өмсөж байна. Тэгэхээр энэ салбарыг сэргээх тал дээр тодорхой юм зааж өгвөл яасан юм бэ. Одоо аймаг, сум, хот, тэгээд ахуйн үйлчилгээний салбарын ажилчид гээд булан буланд энд тэнд хүйтэн газар байр хөлсөлсөн, өөрсдөө нэг машинтай. Тэгээд тэрүүгээр нэг юм оёсон болоод, захиалсан юм хийсэн болоод л тэгээд цалинжаад өөрсдийгөө амьдралыг аваад л явж байна л даа. Одоо энэ ахуй үйлчилгээний асуудлыг сэргээснээр Монгол оронд бол 2 сайн тал байгаа.

1 дүгээрт нэлээд хүмүүс ажилтай болно. Ажилтай албатай, орлоготой болно. 1 дүгээрт.

2 дугаарт болохоор эдийн засаг гадагшаа урсгахгүй, дотогшоо ороод өөрсдөө тэгээд энэ бүх хувцас хунар өөрсдөө оёдог болно. Одоо хүүхдийн формоос эхлээд гадаадаас оруулж ирж байна шүү дээ. Энийг л ер нь зогсоож өгвөл энэ Засгийн газар яг бодитой юм хийвэл яасан юм бэ гэсэн санал байна.

2 дугаарт аялал жуулчлал хөгжүүлнэ гээд ярьж байгаа энэ сайн талтай. Маш их хэрэгтэй юм байгаа манай энэ Монгол оронд. Манай Баян-Өлгий аймгийн хувьд Алтай 5 богд гээд Сергал гээд нэлээд гоё, сайхан газрууд байгаа. Тэр Цагаан гол гээд. Тэгээд тэр газарт очиж байгаа жуулчлал машинууд яаж байгаа гэхээр нь Баян-Өлгийгөөс зам маш их эвдэрч байгаа. Газар маш их эвдэрч байгаа. Очиж байгаа жуулчид ч хэцүү байгаа. Тэгээд явж байгаа машин тэрэгт ч хэцүү байгаа. Энэ замыг бол Даянгийн боомтыг нээх тал дээр өнгөрсөн он жилүүдэд Ерөнхий сайд нар очиж биеэрээ үзээд, энэ дээр зам тавьж олон улсын энэ юу хийнэ гээд өөрөө хэлсэн байдаг юм. Тэр замыг нь тэгээд Баян-Өлгий Лангос гээд тавьж өгвөл яасан юм бэ. Нэг талаас нь аялал жуулчлал, нөгөө

талаас нь гадаад харилцаа хөгжих хэрэгтэй юм байгаа юм даа.

Тэгээд 3 дугаарт болохоор бага ангид англи хэл заана гээд яриад байх юм. Энэ бага ангийн хүүхдүүдийн ачаалал гэдэг чинь даахаа байсан шүү дээ. Тэгээд эхний бага ангид бол үндэсний хэл соёлоо сургаад л, тэгээд дунд ангиас эхлээд гадаад хэл гэж оруулж өгөөч ээ энийг хүсэж байна Боловсролын сайд аа.

Тэгээд 4 дүгээрт болохоор аутизмтай гээд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал манайд орхигдсон байна. Энэ хүмүүсийн Улаанбаатарт бол нэг төв байгаа юм шиг байна. Бусад аймаг сумдад юу ямар ч юм байхгүй. Цэцэрлэг ч байхгүй, сургууль ч байхгүй. Тэгээд энд сүүлийн үед энэ хоол ундаатай холбоотой юм уу, агаарт холбоотой юм уу ийм хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ихэссэн байна Монгол оронд. Энэ дээр нэг албан ёсны цэцэрлэг, сургуулийг нь нээж өгөх тал дээр нь бас бодолцож өгөөч ээ гээд.

Тэгээд 5 дугаарт болохоор энэ банкны систем гээд манайд болохоор яг одоогийн банкны хүүгээрээ бизнесменүүд явна гэсэн юу байхгүй, боломж байхгүй. Маш өндөр хүүтэй. Энэ хүүг нь буулгах юм уу эсвэл гадаадаас жилдээ нэг өчнөөн хувийн хүү авдаг нэг юу байдаг шүү дээ. Тийм банк оруулж ирэх юм уу.../минут дуусав/

Х.Булгантуяа: Үг дээр бол нэмж цаг байхгүй байгаа шүү. Асуулт асуухад нэмж тодотгож асууж болохоор байгаа. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн.

Л.Мөнхбаясгалан: Өнгөрсөн 34 жилийн алтыг нь аваад авдрыг нь хаядгийн жишээ бол говийн бүсэд хэрэгжсэн. Жишээ нь үүний хамгийн том жишээ бол Өмнөговь аймаг. Өмнөговь аймгаас өнөөдөр сангийн авдраа дүүргэдэг хэр нь энэ аймгийг хамгийн баян аймаг, хөгжиж байна гэж яриад байдаг. Гэтэл Өмнөговь аймаг маань

усгүй болсон, болж байгаа эхний аймаг байхгүй юу. Тэгэхээр энэ төлөөсийг экологийн тэнцвэр алдагдаж байгааг байгаль орон нутгаа сүйрүүлээд Монгол Улсын төрөөс ямар ч бодлого хэрэгждэггүйн гайг өнөөдөр говийн ард түмэн аж амьдралаараа үүрч, ядуурч харуулж байгаа. Эдийн засаг, хөгжлийн сайдын хэлсэн үг ер нь энэ Засгийн газрын бид нарын өмнө тавьсан мөрийн хөтөлбөрийг харахад жаахан гэрэл гэгээ харагдаад байгаа юм. Говийн усны төслийг хэрэгжүүлэхэд 3 их наяд л байна гэж ойлголоо. Хэрвээ тийм юм бол энийгээ хийчихье. Хамтраад хийчихье. Энэ дээр чинь хяналт тавья. Урд, хойно нь гарч гүйж яах ёстой юм бол тэр бүгдийг чинь хийгээд ус авчрах юм бол Монголын эдийн засаг хэд дахин нэмэгдэнэ гэж ойлголоо. Тэгээд Өмнөговь аймгийн тэр төсвийг нэмсэн гэдгийг бол дараа тэр тодотгол дээр хэлэлцье.

Ашгүй Алтангэрэл сайд байна. Хүний эрх Монгол Улсад одоо хэрэгжиж байгаа хуульд нийтдээ 810 заалт хүний эрхийг зөрчдөг гэж Улсын Их Хурлын дарга хэлсэн. Алтангэрэл сайд анхаарч үзээрэй. Дорноговь, Говьсүмбэр аймгийн засаг дарга нар авлигын хэрэгт холбогдсон хэр нь одоо хүртэл шалгуулдаггүй. Ямар ч хариуцлага хүлээдэггүй. Энд ерөөсөө төрийн албан хаагчдын эрх зүйн байдал дордсоор байгаа. Тэд нар үг хэлэх эрхгүй байдаг юм шүү дээ. Айгаад. Гарч сонгуулиа өгөх эрхгүй байдаг юм шүү дээ.

...Та харин би энд Алтангэрэл сайдад үг хэлж байна Дэлгэрсайхан гишүүн ээ. Та бол маш сайн мэдэж байгаа байх. Хоёулаа хамтарч ажиллаад энэ асуудлыг зогсооно. Яг ийм байдаг. Үг хэлэх эрхгүй. Одоо энд Их Хурлын гишүүн хүртэл үг хэлэх эрхгүй байна. Дэлгэрсайхан сайд бол шууд загнаж байна. Би энд үг хэлж байна. Бүр яг ийм болсон юм байна. Их Хурлын гишүүн нь хүртэл говийн бүсээс сонгогдсон Их Хурлын гишүүн нь хүртэл үг хэлэх эрхгүй л болчихсон юм байна.

Төрийн албан хаагчид өнөөдөр сонгуулиа өгөх эрхгүй, үгээ хэлэх эрхгүй байгаа.

Тэгээд хамтарсан Засгийн газрын 13 том мега төслийн 8 нь манай говийн бүсэд хэрэгжих юм байна. Говийн бүсэд ус авчрахгүй бол энэ том үйлдвэрүүд чинь химийн үйлдвэр, гангийн үйлдвэр, газрын тосны үйлдвэр, алтны үйлдвэр, атомын цахилгаан станц гээд энэ том гоё төслүүд чинь хэрэгжихгүй юм шүү. Тэгэхээр манай сайд нар энэ дээр анхаарч ажиллаарай.

Алтангэрэл сайд түрүүний тэр хүний эрх дээр 810 заалт хүний эрхийг зөрчиж байгаа гэсэн. Тэрийг анхаарч Их Хурлын хянан шалгах ажиллагаанд анхаарлаа тавьж ажиллаарай. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт амжилт хүсье. Гэхдээ Засгийн газарт хяналт тавьж ажиллах нь Их Хурлын гишүүдийн эрх, үүрэг учраас та бүхнийг бас хангалттай сайн хянаж ажиллана. Баярлалаа.

Х.Булгантуяа: *Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн.*

Д.Энхтүвшин: *Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн танилцуулгын эхэнд эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгож чадаагүй байна. Түүхий эдээс хамааралтай байна. Солонгоруулж чадаагүй байна гэдэг ийм асуудлуудыг эхэнд нь тавьсан байсан. Тэгээд сонгуулийн дараа 3 нам эвсэхэд бас хүлээлт өндөр байсан. Өөрөөр хэлбэл зүүний буюу нийгмийн социал демократ үзэл баримтлалтай Монгол Ардын намын энэ удаагийн сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөрүүд нь ихэнх нь төрийг жижгэрүүлэх, тухайлбал, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагыг 25 хувь болгож буулгах, гадаад өрийг бас хязгаарласан, одоогийн түвшинээсээ нэмэхгүй гэсэн ер нь бол хувийн хэвилийг дэмжсэн нэлээн олон заалтууд байсан. Тэгэхээр яах вэ, Ардын нам болон ХҮН намын хувьд энэ бодлогуудыг нэлээн дэмжиж ажиллах*

болов уу гэсэн тийм хүлээлттэй байсан. Тэгэхдээ одоо бодит байдал дээр саяын тэр хэлсэн эдийн засгийн тогтворгүй өсөлт бий болсноос болоод жижиг компаниуд ер нь үйл ажиллагаа явуулж чадахаа больж байна. Дунд компаниуд байхгүй болж байна. Хэдэн том компани, төрийн компаниуд үлдэх ийм шинжтэй байгаад байгаа учраас энэ дээр энэ мөрийн хөтөлбөр дээрээс нэлээн хүлээлтүүд байсан гэхдээ өшөө сайжруулах хэрэгтэй юмнууд байгаа харагдаж байна.

Энд бол хамгийн том чухал юм татвар, нийгмийн даатгалын реформ гэж байгаа юм. Энэ дээр орж ирсэн яах вэ түрүүн Жавхлан сайд 7 зүйл байгаа гэж хэлсэн. Гэхдээ тэр зүйлийг харахад бол хангалттай реформын шинжтэй байхгүй байна. Тэгэхээр энэ дээр бол Засгийн газраар энэ татвар, нийгмийн даатгалын реформыг хийлгэх биш, Улсын Их Хуралд байгаа Эдийн засгийн байнгын хороогоороо дамжуулж, гишүүд үүнийг санаачилж, энэ реформын шинжтэй саналуудыг Улсын Их Хуралд өргөн барих нь зөв юм уу гэсэн тийм бодолтой байна.

Дээр нь хувийн хэвшилд бас тулгарч байгаа нэг асуудал нь болохоор хүний нөөцтэй холбоотой асуудал бүтээмжтэй, ур чадвартай холбоотой асуудал байгаа юм. Тэгэхээр уг нь гаднаас ажилтан авах, ажиллах хүчний тоонд хязгаарлалт тавихгүй байх төлбөрөөс чөлөөлөх тухай бодлого гарчихсан гэж байгаа боловч яг энэ дээр бас нэлээн бөөрөнхийлсөн маягтай байдалтай байна. Тэгэхээр энийг тодорхой яг ингээд чөлөөлнө. Татвараас нь чөлөөлнө, хязгаарлалтыг нь чөлөөлнө гээд оруулчихвал яасан юм бэ гэсэн ийм бодол байна. Тэгэхгүй бол энэ сангаас бий болж байгаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан бол бас ер нь авлигын уурхай байдаг. Миний албан бус мэдээ энийг баталгаажуулбал бас нэлээн өндөр жишээлбэл, 60 хувийн авлига авдаг энэ сан бол жишээлбэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас мөнгө авахын тулд 60

хувийн авлига авдаг гэсэн ийм ноцтой мэдээ сонссон. Тэгэхээр энийг бас шалгах хэрэгтэй байгаа. Тэгэхээр ийм эх үүсвэрт оруулахын тулд энийг жишээлбэл ийм бүдэг болгосон юм уу гэж хардахаар байна. Тэгэхээр энийг чөлөөлөх ёстой гэж бодож байна. Дээр нь энэ мөрийн хөтөлбөр дээр бас нэг асуудал болохоор хувийн хэвилийг зах зээл дэх төрийн оролцоог багасгана гэсэн байгаа. Тэгэхээр энэ зорилтот түвшин дээр дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувийн хэвилийн хувь гэдэг юм уу иймэрхүү зүйл заалт оруулбал зүгээр юм уу гэсэн ийм саналууд байна.

Х.Булгантуяа: Отгоншиарын Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Баярлалаа. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Тэгэхээр хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 14 томоохон мега төслүүдээ эрэмбэлээд орж ирж байгаа нь бол өндөр ач холбогдолтой гэж бодож байгаа. Тэгэхээр энийг цаашаа ажил болгоод дуусгахад бол хамгийн гол нь эргээд нөгөө ур чадвартай, менежментийн туршилагатай баг заавал хэрэг болно. Тэгэхээр ер нь энэ 14 төслийг ингээд аваад үзэх юм бол ер нь томоохон мега төслийг хэрэгжүүлэхэд ч гэсэн ер нь зүгээр нэг яам ч юм уу, яамдын хоорондын ажлын хэсэг хийчхэж байна гэдэг ойлголтоос бол салах ёстой л доо. Тэгэхээр энийг ер нь аливаа бусад орны томоохон мега төслүүдийг аваад үзсэн ч гэсэн дандаа мэргэжлийн менежментийн баг хийх ёстой. Тэгэхээр Монгол Улсад байгаа яг одоогийн нөхцөл байдал бүтцийг аваад үзэх юм бол энийг “Эрдэнэс Монгол” гэж харж байгаа юм. Тэгэхээр “Эрдэнэс Монгол” түүний охин компаниуд, цаашид энэ томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэх ур чадвар туршилагатай баг бас зайлигүй цаашаагаа хэрэг болно гэсэн үг. Тэгэхээр сая Ерөнхий сайд ч гэсэн үгэндээ хэлж байна. Цаашид ер нь “Эрдэнэс Монгол” охин компаниудыг бас

гаднын менежмент авч явуулах гэсэн агуулгыг бас хэллээ. Тэгэхээр цаашид энэ том мега төслүүдийг явуулахад ч гэсэн бас зайлигүй тийм туршилагатай ур чадвартай баг заавал хэрэг болно. Яагаад гэхээр нэг мега төсөл хэрэгжихэд бол 15-20 томоохон оролцогч талуудыг нэг ширээн дээр авчирч байж томоохон хэлцлүүд явагддаг. Амжилттай хэрэгждэг. Тэгэхээр энийг бас Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө бас маш ойлгомжтой тусгаасай гэж бодож байгаа юм.

2 дугаарт нь энэ 14 мега төслийн 13 дугаарт орсон Оюутолгой төсөлд түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэр гэж орсон байгаа юм. Тэгэхээр энийг жсоохон тодорхой болгомоор байгаа юм. Яагаад гэхээр энэ 14 мега төсөл бүгдээрээ гаднын хөрөнгө оруулалтаар л бүтэх 14 мега төсөл. Тэгэхээр хөрөнгө оруулагч талаасаа ч гэсэн маш ойлгомжтой байх ёстой. Оюутолгой бол өөрөө зэсийн баяжмал боловсруулдаг. Дайвар бүтээгдэхүүнээр алт, мөнгө, молибденум гэх дайвар бүтээгдэхүүнүүд гардаг. Тэгэхээр үндсэн бүтээгдэхүүнээ цэвэршүүлэхгүйгээр дайвар бүтээгдэхүүн алтыг цэвэршүүлнэ гэдэг нь технологийн хувьд ч, зардлын хувьд ч өөрөө боломжгүй зүйл л дээ. Тэгэхээр Оюутолгойг түшиглэсэн алт цэвэршүүлэх үйлдвэрийн гэдэг нь үндсэн бүтээгдэхүүний Оюутолгой зэс баяжуулах, боловсруулах үйлдвэрээ хэлж байгаа юм уу. Энийгээ маш ойлгомжтой болгох ёстой. Энэ 2 өөр технологи яригдаж байна гэсэн үг л дээ.

Бас нэг зүйл нь түрүүн 2 ч гишүүн бас хэллээ л дээ. Эдийн засгийн бодлогын хүрээнд бол гаднын банк салбарын нэгжийг дотоодын зах зээлд нэвтрүүлж илүү өрсөлдөөн оруулж хүүг бууруулна гэж оруулсан байгаа юм. Тэгэхээр хэрвээ төр гаднын банк оруулж ирэх ганц боломж нь бол өөрөө гаднаас цоо шинэ банк орж ирээд жишээлбэл, Монгол банкнаас лиценз аваад үйл ажиллагаагаа эхнээс эхэлнэ гэж хэзээ ч байхгүй. Ер нь

бусад жишээлбэл дэлхийн үндэстэн дамнасан томоохон банкнууд аливаа шинэ зах зээл дээр орж ирдэг нь дандаа *mergers and acquisition* буюу компанийн хоорондын нэгдлээр орж ирдэг. Компанийн хоорондын ... гишүүд ээ, үгээ дуусгаж болох уу. Компанийн хоорондын нэгдлээр орж ирдэг гэсэн үг. Тэгэхээр хэрвээ төр гаднын банкиг оруулж ирье гэж Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртөө хэрвээ Засгийн газар тусгаж байгаа бол хамгийн эхний үйл ажиллагаа юу вэ гэхээрээ төрд байгаа Төрийн банкиг л хувьчлах гэсэн үг. Гаднын банк Монгол Улсын зах зээлд ганцхан нөхцөлд орж ирнэ. Энэ бол өөрөө Монгол Улсад худалдаж авах том банк байх ёстой л гэсэн үг. Тэгэхээр төрд банк байх нь зохистой юу, үгүй юу гэдэг бас нэг асуудал байх. Тэгэхээр цаашидаа гаднын банк оруулж ирэх ганц нөхцөл бол Төрийн банкиг буцаад гаднын банканд худалдах энэ боломж нөхцөлийг энэ улс төрийн шийдвэрийг гаргах ёстой. Хэрвээ тэгж чадах юм бол гаднын.../минут дуусав/

Х.Булгантуяа: Очирбатын Амгаланбаатар гишүүн. Амгаланбаатар гишүүн Амгаланбаатар гишүүн байхгүй байна. Ганбатын Очирбат гишүүн.

Г.Очирбат: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг бол бүрэн дэмжиж байгаа. Энэ удаагийн сонгуулиар Үндсэн хуулийн өөрчлөлтөөр 126 Их Хурлын гишүүнтэй болсон. Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэг, бүх газраас бас энд сууж байгаа парламентын Их Хурлын гишүүдийг бас харж байгаа. Их Хурлын гишүүд бас засгаа ямар мөрийн хөтөлбөртөө оруулж ирэх вэ гэдэг дээр нэлээн бас сууж бүлгүүд бас ажилласан. Их Хурлын гишүүнийхээ хувьд бас саналуудаа илэрхийлсэн байгаа.

Тэгээд ихэвчлэн аж ахуйн нэгжүүдээ дэмжих гэдэг дээр саналаа илэрхийлсэн. Тэгээд ихэнх нь орж ирсэн байна. Бас их талархаж байна. Засгийн газрын сайд нартаа нэг бүрчлэн амжилт

хүсье. Яагаад гэхээр одоо яг энэ цаг мөчөөс хойш энд тусгагдсан байгаа 149 ажил тэр дундаа тэргүүлэх 14 төсөл бол Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг үсрэнгүй бас хөгжүүлнэ гэдэгт итгэж найдаж байгаа. Яагаад гэхээр тэргүүлэх зорилт, ялангуяа Засгийн газрын зорилго бол нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган долларт хүргэнэ гэдэг бол их том амбицтай зорилго дэвшүүлж байгаа. Монгол Улсын хөгжлийг бас үсрэнгүй зоригтойгоор цаашиа хөгжүүлнэ гэж бас Засгийн газрын гишүүд маань болон Ерөнхий сайд маань бас хэлж байна. Тэгэхээр энэ чиглэлийн бүх ажлуудыг гишүүнийхээ хувьд бол дэмжээд явна. Мөн дээрээс нь хяналтыг бол бас их сайн хийж ажиллана гэж бодож байгаа. Сайд нар бас энэ дээр бүгд дэмжээд гараад явчхангуут Их Хурлын гишүүд маань орхичихно гэж битгий бодоорой. Сайд нэг бүрчлэн дээр, мөн дээрээс нь энэ оруулж ирж байгаа ажил болгон дээр нь биечилж хувь гишүүний хувьд бол нэлээн араас нь хөөж ажиллана гэж бодож байгаа. Тэгээд Засгийн газрынхаа 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан нийт хамт олон Засгийн газрын гишүүддээ амжилт хүсье. Баярлалаа.

Х.Булгантуяа: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Баярлалаа. 2024 оны сонгуулиас өмнө намууд сонгуульд өрсөлдөх мөрийн хөтөлбөрөө гаргахад, тэр мөрийн хөтөлбөрийг аудитаас хянасан. Хянахдаа алсын хараа 2050 хөгжлийн хөтөлбөр болон бусад хөтөлбөрүүдэд нийцэж байна уу эсэх талаар хянасан байгаа. Ингээд 2024-2028 он гээд яг тодорхой он заасан 48 сарын Засгийн газрын хөтөлбөр нь дахиад нөгөө Алсын хараа 2050 шигээ хөгжлийн зорилт байдлаар орж ирээд байгаа юм. Хэл найруулгын хувьд гэхээс илүүтэйгээр логикийн хувьд гэж ойлгож болно. Тэгэхээр одоо ямаар байна гэхээр Тэргүүн шадар сайд байж байгаа. Түүрүүн бас та хэлж байна лээ. Тэр бүсийн

асуудал дээр 1 сарын хугацаанд амжаагүй учраас ондоо багтаад яг ингээд нарийн төлөвлөгөөнүүдээ оруулна гээд хэлж байна лээ. Яг энэ шигээ яг ингээд ийм зорилтын чанартай зүйлүүд чинь дахиад л ингээд утаа болох магадлалтай. Тухайлбал үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 2010 онд батлагдсан үзэл баримтлал дээр 2020 он гэхэд бид нар дотооддоо шатахуунаа бүрэн хангадаг болно. Эрчим хүчний бие даасан байдалтай болно эд нар гээд баахан зорилтууд тавьчихсан. Тэр зорилт нь хэрэгжээгүй 4 жил өнгөрчихсөн байх жишээтэй. Тэгэхээр бид нарт ийм тунхгийн шинж чанартай бодлогын бичиг баримтууд бол хангалттай байгаа. Тэгэхээр яг он заасан юм бол тэр яг хэмжих нэгжийг нь тодорхой болгох ёстой. Түрүүн би Эрдэнэбүрэн сайдад хэлсэн санаа болохоороо утааны хоруу чанарыг 2025 он гэхэд хэд болгох юм, 2026 он гэхэд хэд болгох юм, 2027 он гэхэд хэд болгох юм. Эндээс үүдэж бий болж байгаа өвчлөл, эндээс үүдэж бий болж байгаа энэ гамшигийн байдал чинь яаж буурах юм бэ гэдэг ийм детальчилсан зүйлүүдийг оруулмаар байгаа юм. Тэгэхгүй болохоор бид нар ерөнхийдөө ингээд тайлбарлаад ярихаар ингээд ойлгогдоод байгаа. Яг цаасан дээр болохоор ингээд тайлбарлах шаардлагатай байгаад байгаа юм. Тийм учраас өнөөдөр төгс юм шаардаагүй. Он дуустал ч гэдэг юм уу энэ төсөв батлагдсаны ар дээрээс маш нарийн мэргэжлийн байдлаар энэ дээр хандаж, төлөвлөгөөнүүдээ яг шинжлэх ухаач суурьтайгаар ингэж оруулж ирэх шаардлагатай байгаад байгаа юм. Энэ дээр ч гэсэн бас дан Засгийн газар, Их Хурал гээд 2 талд гаралгүйгээр энэ дээр Их Хурлын гишүүд ч гэсэн өөрсдөө хамтарч ажиллах ёстой гэж бодож байгаа.

2 товчхон зүйл дээр хэлэхэд бол тэр хувийн хэвилийг хаадаг барьдаг, зогсоодог, үйлдвэрийг нь хаадаг тэр Монполимет эд нар гэдэг асуудал дээр Энхтүвшин гишүүн л 2 удаа хэлээд байгаа

харагдана л дээ. Энэ дээр ер нь Засгийн газар ийм шийдэмгий байвал яасан юм юм бэ. Одоо ингээд өчнөөн хүмүүсийн ажлын байрыг байхгүй болгоод, баялаг бүтээгчдээ ингээд шууд төр хаачихдаг байж болохгүй шүү дээ. Энэ дээр бол ингээд нэг бөөрөнхийлөөд байхгүй, шууд ингээд шийдвэр гаргачихдаг баймаар байна. Яах вэ Хууль зүйн сайд бол хэлж байна л даа. 3, 4 шалтгаанаар ингэдэг юм гээд. Зөвхөн энэ Хууль зүйн яамтай холбоотой асуудал биш гээд хэлж байгаа. Тэгэхдээ энийг нөгөө түрүүн Ерөнхий сайдын хэлсэнчлэн хөгжлийн зургаа бүгдээрээ томоор нь бүтнээр нь хараад хоорондын уялдааг нь хангая гэж байгаа дээр нь л хэдүүлээ төвлөрч ажилламаар байгаа юм.

Дээрээс нь сая бас манай зарим гишүүд Герман руу очоод туршилага судлаад ирсэн. Германд энэ хамтарсан Засгийн газрын хөтөлбөр дээр заримдаа жил тойрон заримдаа хэдэн сараар ингэж үргэлжилж явдаг шүү дээ. Тэгэхээр бид нар бол ерөнхий ингээд концепцынхоо асуудлыг энэ дээр баталж байгаа боловч яг араас нь хийж, детальчилж, дээрээс нь хөдөлмөр зарж, хөлс урсгаж, тооцоо судалгаан дээрээс ингээд сэтгэлийн хөдөлгөөнөө хойш нь тавьж байгаад улс төржихгүйгээр шийдэх асуудлууд дээрээ нэлээн төвлөрөх шаардлагатай юм байна гэж харж байна.

Дээрээс нь тэр нэг цэлмэг тэнгэр гээд хэд хоногийн өмнө бас хувийн хэвилийнхэн Улаанбаатарын утааг бууруулах юм яриад байсан. Тэрийг бас салбарын сайд мэдсэн үү. Мэдсэн тэрийг бас энэ хөтөлбөртөө тусгах талаар анхаараарай гэдэг санааг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Х.Булгантуяа: Дамдины Жаргалсайхан гишүүн байхгүй байна. Сархадын Зулхар гишүү.

С.Зулхар: Гишүүдийн энэ оройны амар амгаланг айлтган мэндчилье. 8 санал байгаа юм. Гэхдээ эхнийх нь

ерөнхий санал, 7 тусгай санал. Заримыг нь яах вэ Байнгын хороон дээр хэлэх юм шиг байна.

Эхний санал би Тэргүүн Шадар сайд бас энд сууж байгаа. Ажлын хэсгээ ахалж байгаа учраас Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг боловсруулахтай холбоотой тогтсон арга зүй бий. Тэр арга зүйгээ барьж байгаа гэдэгт бол эргэлзэхгүй байна. Гэхдээ бас яах вэ энд их асуулт гараад байна. Тэрийг оруулах ёстой, энийг оруулах ёстой гээд. Тэгээд тэр арга зүйгээр явж байгаа байх гэж бодож байна. Арга зүй бол өөрөө зорилгоо тодорхой болгоод, зорилгын дагуу зорилтууд, тэгээд тэрний дагуу дэд зорилтууд, үндсэн ерөнхий арга хэмжээнүүдээ л тавьсан ийм л баримт бичиг байдаг. Үүгээр хийхгүй бол бас тухайлсан зүйл шаардаж байгаа бол шаардагдаж байгаа нь бол бас гарцаа байхгүй болж байна гэж байгаа юм. Тэгэхээр энийг бас гишүүд маань зөвөөр ойлгох ёстой байх. Саяын хэлээд байгаа зарим тухайлсан ажлууд бол Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө дээр орно. Тэр төлөвлөгөө дээр тодорхой тусгагдах ёстой. Тэгэхээр энэ энийг ажлын хэсэг анхаарч бас энэ ялгаа заагийг нь хэлж өгөхгүй бол болохгүй байх гэж бодож байна. Тэгэхгүй бол одоо сая бол бид тэгж байна шүү дээ. Зарим зүйлийг оруулах ёстой гэж байна. Тухайлбал, би энэ мөрийн хөтөлбөрүүдээс харахаар зэрэг тийм л байна л даа. Тэр боомтуудыг холбосон хатуу хучилттай авто замыг заримыг нь оруулаад заримыг нь оруулаагүй болохоор зэрэг асуугдаад байгаа байхгүй юу. Жишээ нь Даяныхыг бол оруулж л таарна. Даян хүртэлх боомтын хатуу хучилттай авто замыг. Гэхдээ тэрийг бол хөтөлбөртөө оруулах уу, төлөвлөгөөнд оруулах уу гэдгээ бол салгаад л ингээд л тайлбарлаад явчихмаар байна гэж байгаа юм. Ингээд энэ арга зүйгээ та бүхэн бариад явах байх гэж найдаж байна.

Тухайлсан саналууд байна. Мэдээж хэрэг их олон санал янз янзын хэл найруулга, нэр томьёо, ойлголттой холбоотой, зөрүүтэй холбоотой зүйлүүд их гарах юм шиг байна. Угаасаа ч гардаг юм. Тэгээд тэрийг засаад явах байх гэж бодож байна. Эхний асуудал энэ. Орон нутгийн хөгжил дээр энэ төрийн захиргааны албан хаагчдын цалингийн 20 хувийн нэмэгдэлтэй холбоотой ийм зүйлийг цааш нь үргэлжлүүлнэ гэчихжээ. Засгийн газрын 82 дугаар тогтоол гарчихсан энэ жилийн. Тэр тогтоолоор бол сум нь жишээ нь хөдөөгийн сум байх уу, аймгийн төвийн сум байх уу гэдгээс шалтгаалаад ялгаатай тогтоосон байхгүй юу. Тэгсэн чинь энэ дээр 20 гэчихсэн байна. Хэрвээ үүгээр явах юм бол нөгөө цалин хөлсийг дордуулсан байдал руу ороод энэ ахиад буцаад хуулийн зөрчил болчих учраас энэ томьёолуудыг хараач гэж байгаа юм.

Сая бол бас зарим гишүүд хэлж байна. Цалин хөлстэй холбоотой салбар салбарынхан л хэлж байна л даа. Ер нь тэр хойно бол засаглалын реформ хэсэгт бол төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг ерөнхий зорилт болгоод оруулчихсан нь зөв байх гэж бодож байна. Энэ тэгэх ч ёстой. Тэгж байж бэлэн болж байгаа хуулийг нь ярих байх гэсэн ийм бодолтой байна.

Дараагийн 3 дахь зүйл. Төрийн албаны реформтой холбоотой зүйл дээр сүүлийн үед нэг ийм үг гараад ерөөсөө тэр бол бас хүмүүсийг санааг нь зовоогоод байна. Төрийн алба цомхон байх ёстой гэсэн. Мэдээж чадварлаг, чадавхуйн зарчимд суурилсан байх нь бол эргэлзээгүй. Гэтэл бол та бүхэн мэдэж байгаа айгаа. Алсын хараа 2050-ыг боловсруулах үед эрдэмтэд судлаачдын жишээ нь бүрэлдэхүүн ажиллаад цомхон байх тухай асуудал бол биш. Оновчтой буюу жишээ нь зохистой бүтэц байх тухай гэдэг ийм зорилтыг тавьчихсан байхгүй юу. Тэгэхээр энийгээ хэдүүлээ цааш нь аваад явахгүй бол тэгээд л 226

мянган төрийн албан хаагч байгаа юм чинь тэрийг багасгана гэдэг асуудал их тийм механик байдлаар ярьж байна. Ер нь бол зорилгодоо нийцсэн бүтэц тэрэндээ тохирсон бүрэлдэхүүн байдаг. Тэрийг бол тухайн үед нь уян хатан байдлаар шийдээд явдаг учраас энэ нэр томъёонуудыг нэг тийш нь болгох дээр бас анхаарах байх. Ажлын хэсэг дээр бол бид саналуудаа бас тухайлаад хэлээд явна гэж бодож байна.

4 дэх зүйл энэ төрийн албаны сургалттай холбоотой саналыг бол ерөөсөө олон улсын жишигт нийцүүлнэ гэгчсэн байгаа юм. Төрийн албаны сургалт бол угаасаа олон улсын жишигт нийцээд явж байгаа. Тэр битгий хэл бараг шууд хуулиа тэгж байсан цаг үе ч бол байгаа. Харин энийг бидний өнгөрсөн Алсын хараа 2050-ийг боловсруулах үед ч гэсэн тавьж байсан зорилт бол төрийн албаны шинэчлэлтэй уялдуулсан байдлаар л авч явна гээд ингээд томъёолчихсон байгаа юм. Тэгэхээр энэ тогтсон томъёоллуудыг яагаад ингээд гэнэт гэнэт өөрчлөөд байгаа юм. Тэгээд энэ чинь өөрчилнө гэдэг чинь цаана бол бүтэн философ нь өөрчлөгдөнө, зохион байгуулалт нь өөрчлөгдөнө, арга нь өөрчлөгдөнө. Тэгээд үр дүн нь бас өөрчлөгдөнө гэдэг ийм зүйлийг бас бодох ёстой байх.

Хөдөлмөр эрхлэлтийн холбоотой зүйл дээр нэг зорилт дутуу байна. Энэ бол хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой зорилтыг бол сая гишүүд ч гэсэн ярьж байна. Энийг тухайлсан зорилт болгоод оруулчихвал.../минут дуусав/

Х.Булгантуяа: Гишүүд энэ дутуу үлдээсэн асуудлуудыг та бүхэн маань тухайн Байнгын хороон дээр нь томъёолоод, зарчмын зөрүүтэй санал болгоод санал хураалтад оруулаад бас явах боломжтой байгаа шүү. 18 цаг болж байна. 18 цаг өнгөрчихлөө. Өнөөдөр бид үйл ажиллагааны хөтөлбөрөөс гадна төсвийн тодотгол гэх мэтчилэн

нэлээдгүй олон асуудлууд хэлэлцэхээр байгаа. Улсын Их Хурлын дарга өнөөдөр 6 асуудлаа хэлэлцэж дуустал хуралдъя гэж хурлаа эхэлж байхад хэлж байсан. Энэ дагуу 18 цагаас үргэлжлүүлээд хурлаа үргэлжлүүлээд хуралдъя. Дараа нь Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ олон бүтээн байгуулалт ер нь манай улсад төсвөөс хамааралтай байж байгаа энэ Тендерийн хуульд өөрчлөлт оруулъя гээд өмнөх парламентаа арай бараагүй юм. Булгантуяа сайд бас бид нар хэлж байгаад олон улсын байгууллагуудын шинж чанарыг ер нь танай эдийн засаг өсөж болно. 2 дахин өснө гээд тавьчихсан байна. 5 мянган долларыг 10 мянган доллар болгоё гээд. Гэхдээ энэ чинь хэдэн айл, хэдэн аж ахуйн нэгж байгууллага, хэдэн дан болон шууд үр шим хүртэгч нарт нөлөөлөх юм бэ гэдэг энэ тооцооллыг сайн гаргаж хийхгүй бол бид нар 4 жилийн дараа маш олон ажил хийдэг. Эдийн засгийн хүртээмжтэй байдал гэдэг зүйлийг нийт улс орнуудад бас чиглэл болгож НҮБ болон түүний төрөлжсөн байгууллага их ярьдаг болсон. Би өмнө нь энэ банкнуудад олгосон зээлийн талаар нэг асууж үзсэн юм. Хэдэн их наяд ч билээ тэр Хөгжлийн банк гээд. Хэчнээн ажлын байр бий болгосон юм. Хэдэн хүний байнгын чанартай ажлын байр бий болсон юм. Хэдэн дагасан ЖДҮ-лэлүүд бий болсон юм бэ гэсэн. Банк нь өөрөө мэднэ гэж надад хариулт ирж байсан. Тэгэхээр одоо бол тэгж явмааргүй байгаа юм.

2 дугаар асуудал бол нэг хүнд ноогдох дотоодын бүтээгдэхүүн 2 дахин өснө гэсэн. Зарим намуудын мөрийн хөтөлбөрт бол коэффициентыг сайжруулна гэдэг ийм юу байсан. Нөгөө баялгийн шударга хуваарилалтын хэмжүүрийн асуудлыг бол энэ дагасан юунуудаа бас нарийн оруулж өгөөрэй гэдгийг бол хэлмээр байна.

3 дугаарт тэр цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж үүнийгээ дагаад өсөх үү.

Дотоодын бүтээгдэхүүн 2 дахин өссөн. Цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн хамгаалал, улсын дундаж цалин, нэг цагт ноогдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь хэвээрээ байж байх юм бол энэ бол эдийн засгийн гол зорилт ерөөсөө биш ээ. Татварын асуудал дээр бол өчигдөр Гантөмөр сайд ярьж байсан. Би бас дэмжиж байгаа. Тэр өрх өрхийн гишүүдийнх нь юутай хамаарал. Тэр бол олон улсын жишиг шүү дээ. Гишүүдийн болон нэг хүнд ноогдох орлого нь тэр хүнд хэр зэрэг хүртэж байна гэдгээс нь авхуулж олон шатлалын тийм татваруудыг бол хийдэг. Тэр бол одоо бас их чухал бодлогын асуудал гэдгийг бол хэлмээр байна. Энийгээ хийхдээ бас нийгмийн түнш байгууллагуудтай бас яриарай.

Тэгээд дараагийнхаа асуудал нийгмийн түншлэлийн асуудал гэж байгаа. Ер нь бүх шатанд манай шинэ сайд нар маань салбар салбарынхаа ажилчдыг нэг хүлээж аваад, төлөөллийг нь аваад, ажил олгогчдыг нь аваад энэ төсөв хэлэлцэхийг уг нь хамгийн анх тэд нараар илүү их яриулмаар байгаад байгаа юм. Байгууллага байгууллага дээрээ ярьдаг баймаар байгаа юм. Тэгж байж ийшээ орж ирэхгүй бол бүх салбарын асуудлыг мэдэхгүй байж байж бид бүхэн таамгаараа өөр өөрсдийнхөө тойргийн асуудлыг ч гэдэг юм уу оруулж тавьчхаад ингээд нийт дүнгээр нь баталдаг. Баталсан шийдвэрүүд нь араасаа нийгмийн шүүмжлэлийг маш их дагуулдаг юм. Тийм учраас энэ тал дээр манай шинэ сайд нар маань илүү түншлэлийг шинэ шатад гаргах талаар бол ажиллаарай гэдгийг бас хэлмээр байна.

Тэгээд намын хатуу гишүүнчлэлийг байхгүй болгоно гэдэг дээр бол бас магадгүй энэ парламентын хамгийн зоригтой шийдвэрүүдийн нэг. Ер нь бол цаашдаа бодлогын нам больё. Та бүгд мэдэж байгаа. Хөдөө суманд очно, аймагт очно, намаараа талцчихсан. Монголын нөгөө ард түмний эв нэгдлийн асуудал гэдэг чинь намууд бараг 2 талд нь

хувааж байгаа юм шиг юм болчихсон байгаад байдаг. Тийм учраас энэ удаагийн эвслийн Засгийн газар бол ард түмнийхээ эв нэгдлийг хангах асуудал дээр бол намын хэт хатуу гишүүнчлэл, хэт давамгайл гэдэг юм уу ийм эрх зүйн асуудал дээр нь бол анхаарна гэж оруулж ирж байгаа дээр бол бас таатай байна.

Тэгээд жагсаал цуглаан хийх гэдэг энэ хуулийг бол бас Хууль зүйн сайдад хандаж хэлэхэд үндэсний ард түмнээсээ авсан санал асуулга руу энийг бол ер нь бол зөвшөөрөл авдаг гэдэг юм чинь ер нь бол байж болохгүй. Би бол олон удаа жагсаал цуглаан хийж үзсэн. Тэгээд зөвшөөрөл өгнө, өгөхгүй гээд л нэг юм байгаад байдаг. Харин тэр үндэсний аюулгүй байдалд буруу өөр сонирхол байна уу гэдгийг нь тогтоогоод шийддэг байх хэрэгтэй гэж.

Тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд эхлэхдээ биш дуусахдаа эв нэгдэлтэй.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Жанчивын Галбадрах үг хэлнэ.

Ж.Галбадрах: Та бүхэндээ оройн мэнд хүргэе. Хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь гол зорилтууд нь мега төслүүдийг хэрэгжүүлэхэд оришиж байна гээд бид нар өглөөнөөс хойш ярьж байна. Тэгээд энэ бол туннел, хурдны зам, цахилгаан станц ч гэдэг юм уу ийм бүтээн байгуулалтын асуудлууд яригдаад байна. Тэгвэл энэ төслүүдийг хийх хүн нь байна уу. Хүний нөөц нь байна уу. Инженерүүд нь байна уу. Мэргэжилтнүүд нь байна уу гэдэг асуудал. Хамгийн 1 дүгээрт энийг тавьж байж бид нар энэ асуудлаа ярих ёстой. Өөрөөр хэлбэл хүнээ эхэлж ярих ёстой. Өнөөдөр яг Монгол улсад Байгалийн ухаанаас зугтах гэдэг үзэгдэл бол газар авсан байгаа. Өөрөөр хэлбэл байгалийн ухааны мэргэжлээр инженерээр сурдаг хүүхэд, төгсөгч бол ердөө 10 хувь ч хүрэхгүй болчихсон байж байгаа. Тэгээд

инженер бэлдэхэд тэгвэл бид нар хөрөнгө оруулах тухай энд яагаад яригдахгүй байна. Тэгээд боловсрол маань өөрөө тэргүүлэх салбар болчихсон байгаа. Тэгэхээр энэ боловсролд бид нар энэ мега төсөл хийж байгаа шиг яагаад энэ мега 14 төсөл байна гэдэг дээр нэмэх нь боловсролын нэг мега төсөл яагаад энд яригдаж болохгүй гэж. Тэгэхдээ өнөөдөр яг боловсролын мега төсөл бол тийм өндөр хэдэн их наядаар нь, хэдэн 100 тэрбумаар нь яригдах ийм төслүүд бол биш гэж ингэж бодож байгаа. Тэгээд салбар маань үнэхээр яг үнэндээ бол яг дампуурлын ирмэгт л ирчихсэн байж байгаа. Би энийг өөрөө энэ төрийн сургуулиуд дээр төсөл хөтөлбөр хийгээд явж байгаа хүний хувьд сайн мэддэг, ойлгодог. Тэгээд маш олон асуудал байгаа. Тэгээд энэ парламентад боловсролын салбарын экспертүүд бас олон орж ирсэн байгаа. Маш олон бодит саналууд тэр хүмүүст байгаа гэж бодож байна. Тэгээд өнөөдөр ингээд төсвийг харлаа л даа. Төсөв ингээд харахаар Наранбаяр сайдын төсвийг харахаар ерөөсөө л урсгал засвар нь 80 хувьтай. Тэгээд хөрөнгийн зардал нь 20 хувьтай. Тэр хөрөнгийн зардал нь 386 цэцэрлэг, сургуулийн өргөтгөл барилгыг гүйцээж барих гэсэн л ийм юм ороод, ерөөсөө тэр багшаа хөгжүүлэх хүндээ чиглэсэн юм бол ерөөсөө байхгүй байна. Тэгээд би энэ одоо мега төсөл больё гэхэд салбарын төслөө төсвөө яаж нэмэх вэ гэдэг дээр л санал хэлье гэж бодож байна.

Тэгэхээр одоо дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх манай салбарын хувийг бол өсгөх хэрэгтэй байна. Бид нар өнөөдөр 5,2 хувь л байна. Энд ерөөсөө сэтгэл ханахгүй. Ерөөсөө боловсролоо хөгжүүлэе гэвэл ядаж бид нар 7-8 хувьд хүргэх тал дээр хатуу зогсох хэрэгтэй байна. Нийт улсын төсөвт боловсролын салбарын эзлэх хувь нь дөнгөж 12 хувьтай байна. Энэ хувийг бид нар өсгөөд 15-18 болгоё гэдэг юмыг энэ төсөл дээр, энэ хэлэлцүүлэг дээр, энэ удаагийнх дээр бид нар энийг л барих хэрэгтэй байна. Тэгээд одоо яаж энэ төсөв мөнгийг гаргах вэ гэвэл сая би хэлсэнчлэн маш олон төсөл

хөтөлбөрийн санаа, хүнээ хөгжүүлэх тал дээр хийгдэх зөвхөн нэг сургалт хийгээд багшид цалин өгөөд явах зүйл бол биш. Мэдээж багшийн цалин хамгийн өндөр байх ёстой гэдэг дээр бол би байр суурьтай байгаа. Гэхдээ багшийг зөвхөн цалингаар биш, тэр багшийн ажлын байрны нөхцөлийг сайжруулах, тэр янз бүрийн сургалтын орчныг сайжруулах, удирдлагыг нь дээшлүүлэх гэсэн энэ бүх чиглэл дээр хийх юмнууд их байна. Тэгээд төсөл хөтөлбөр, санаа тэр хийгдэж байгаа юмнууд нь нэгж сургууль руугаа бас чиглэмээр байна. Сумын сургууль руу, аймгийн сургууль руу. Түүнээс бид нар нэг төсөл гаргадаг, тэр нь нэг тухайгийн тухай ярьдаг. Эсвэл гаднын жишээ ярьсаар байгаад тэнгэрийн юм яриад дуусчихдаг. Тэгвэл үнэхээр боловсролд өөрийн гэсэн онцлогтой хөгжил хэрэгтэй боловсролын маань салбарын бодит байдал байгааг бид нар сайн мэдэх хэрэгтэй. Одоо 4200 багш дутагдана гээд л яриад байна. Удахгүй 2030 он болоход ерөөсөө удахгүй хэдэн жилийн дараа багшгүй сургуулиуд гарна шүү. Тэгэхээр бид нар багшид л хөрөнгө оруулах хэрэгтэй байна. Багш нарын тэр орчин нөхцөл, тэр нийгмийн халамж энэ бүгд дээр юм оруулах хэрэгтэй байна.

Д.Амарбаясгалан: 2 гишүүн үг хэлсний дараа 2 дахь хэлэлцэх асуудал руугаа орно. Тэгэхээр Засгийн газрын гишүүдэд, холбогдох албаны хүмүүст зар мэдээлэл өгөөрэй. Ингээд Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Юуны өмнө Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг бүхэлд нь дэмжиж байгаа гэдгээ илэрхийлье. Эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа 14 мега төслүүдийг хэрэгжүүлж чадах юм бид эдийн засгаа тэлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, ЖДҮ-лэлийг дэмжих, мөн ЖДҮ-лэл нь том үйлдвэрлэлтэйгээ хамтдаа кластераар хөгжих энэ боломжийг бүрдүүлэх том гарц гэж харж байна. Харин энэ 14 төслийг их ойлгомжтой тусгаж бүх түвшинд

ойлголтоо нэгтгэхгүй бол бас ойлголтын зөрүү үүсчих вий гэж болгоомжилж байгаа юм. Тухайлах юм бол алт цэвэршүүлэх үйлдвэр Гантөмөр сайдын хэлдгээр Оюутолгойн төслийн хөрөнгө оруулалтаар, санхүүжилтээр энэ үйлдвэрийг барихаар төлөвлөж байгаа бол энэ үйлдвэр өөрөө хаана баригдах юм, хэзээ баригдах юм, ямар хүчин чадалтай байх юм гээд энэ бүх зүйлийг тодорхой болгомоор байгаа юм. Мөн зэсийн баяжмал хайлах боловсруулах үйлдвэрийн талаар бид бас нэг ойлголтын зөрүүтэй хаана хаанаа байгаад байна. Бүх түвшиндээ. Тийм учраас энэ үйлдвэрийн ТЭЗҮ өнөөдөр хийгдэж байгаа судалгааны талаар бүх түвшиндээ бас ойлголтоо нэгтгэмээр байна. Та бол Бүрэн хааны ордыг ашиглаж болохгүй, нөгөө талдаа бас ялангуяа энэ газрын тосны үйлдвэртэй холбоотойгоор хүлээгдэх хэмжээний асуудлуудыг ярьж байна. Гэтэл өнөөдөр энэ мөрийн хөтөлбөрийн 10-д тусчихсан байгаа зэс боловсруулах үйлдвэрийн үр дүн дээр бол хүхэрлэг хий биш элементийн хүхэр үйлдвэрлэхээр бүр тоо хэмжээг нь зааж өгөөд тусгачихсан байгаа. Тэгэхээр элементийн хүхэр үйлдвэрлэнэ гэдэг бол технологийн хувьд энд фосфоритын орд шаардлагагүй юм. Энэ технологи нь өөр юм. Элементийн хүхэр үйлдвэрлэх технологи нь. Хэрвээ хүхрийн хүчил үйлдвэрлэх юм бол бид нарт фосфоритын орд хэрэгтэй. Тийм учраас өнөөдөр бол Эрдэнэт үйлдвэр яг энэ чиглэлээр тодорхой судалгаа шинжилгээний ажлуудыг гадна дотнын компаниудтай хамтарч хийгээд, Монгол Улсад байхгүй тэр нүүрсний хийгээр хүхэрлэг хийг хольж, саармагжуулж хүхэрлэг хийнээс хүхрийн хүчил биш хүхэрлэг элементийн хүхэр буюу нунтаг хүхэр гаргах энэ лабораторийн туршилтын ажил нь амжилттай хэрэгжчихсэн явж байна. Үйлдвэрлэлийн туршилт хийгдээд явж байна. Энэ ТЭЗҮ маань 10 номерт эрэмбэлэгдчихсэн төслийн ард байгаад байгаа ТЭЗҮ-ийн тоонууд маань үндсэндээ элементийн хүхэр үйлдвэрлэхээр явж байгаа учраас

фосфоритийн ордын тухай энд дурдах ёсгүй юм шүү гэдгийг би бас онцолж хэлмээр байна.

Нөгөө талдаа газрын тосны үйлдвэртээ зэс хайлах үйлдвэр ерөөсөө хамааралгүй. Хамааралгүй юм байгаа юм. Тийм учраас хэрвээ газрын тосны үйлдвэр барьсны дараа зэсийн баяжмал хайлах боловсруулах үйлдвэрийн төсөл явна гэвэл энэ төсөл хэрэгжихгүй. Ёстой мөрөөдлийн жагсаалт болно. Тийм учраас та бид хаана хаанаа энэ ойлголтоо нэгтгэж бүх түвшиндээ адил мэдээлэлтэй байж байж энэ том төслүүдээ бодлогоор хөдөлгөх тал дээр анхаарах хэрэгтэй шүү гэдгийг би бас онцолж хэлэхийг хүсэж байгаа юм.

Ер нь бид байршил дээр хугацаа алдах нь бидэнд бол ашиггүй байна гэж би харж байна. Яагаад гэвэл Эрдэнэтэд энэ зэсийн баяжмал хайлах боловсруулах үйлдвэрийг байлгах эсэх талаар маш олон жил судалгаа хийсэн. Маш олон жил ярьж байгаа. Яагаад өнөөдөр хэрэгжиж чадахгүй байсан гэвэл технологийн шийдэл байсан. Тэгвэл өнөөдөр технологийн шийдлээ гаргачихлаа. Үйлдвэр технологийн паркийн хүрээнд энэ зэсийн баяжмал хайлах, боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан. ТЭЗҮ нь боловсруулагдчихсан дэд бүтцүүд нь хийгдчихсэн. Энэ онд ихэнх нь ашиглалтад ороод дуусна. Эрчим хүчний асуудал л үлдэж байгаа. Ийм нөхцөлд бид нар хамгийн хурдан бэлтгэл хангагчихсан байгаа энэ үйлдвэрээ дэмжээд 2027 онд ашиглалтад оруулаад авчих юм бол том төслөө хэрэгжүүлэх бас нэг гол одоо хөшүүрэг механизм болох юм биш үү. Энэ нөхцөлд магадгүй Оюутолгойн зарим баяжмалын зарим хэсгийг зөвөөрлөж тэнд боловсруулах тухай асуудал ч яригдахыг үгүйсгэхгүй юм. Газрын тос боловсруулах цогцолборыг бас тусгасан байна. Энд бид түүхий эд болох түүхий нефтээр энэ газрын тосны үйлдвэрээ хэрхэн хангах юм бэ гэдгээ одоогоос бодох ёстой. Өнөөдөр шугам хоолой Дорнодоос

Дорноговь руу татагдаж байгаа. Гэтэл шугамаа татаад үйлдвэрээ барьчихдаг нөгөө түүхий нефтгүй байж байдаг ийм асуудал үүсэх вий. Тийм учраас энэ төлөвлөж байгаа том төслүүдийнхээ түүхий эдэд онцгой анхаараарай гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан:

Амгаланбаатарын Ганбаатар гишүүн үг хэлнэ. Гишүүддээ зар хүргэе. Засгийн газрын гишүүдэд зар хүргэе. Нэг хүн үг хэлээд Төсвийн хүрээний мэдэгдэл дараачийн асуудал руу орно шүү. Ганбаатар гишүүн үгээ хэлье.

А.Ганбаатар: Баярлалаа. Тэгээд юуны өмнө Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг дэмжиж байгаагаа илэрхийлье. Тэгээд энэ улс төрийн намууд нэгдсэн хамтарсан Засгийн газар гэдэг бол том том төслүүдийг явуулах ийм цаг үе. Тэгэхээр энийг бид нар бол олзуурхаж хүлээж авч, Монголын хөгжлийн төлөө, Монгол хүний төлөө бол улс төрийн намууд нэгдээд парламент, Засгийн газар алхам хийж байна гэж харж байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн хэлэлцүүлгийн дараа ер нь энэ хуралдааны үеэр Их Хурал, Их хурлын гишүүд маань дэмжиж гаргах юм байна гэж харж байна. Энэ хөтөлбөрөөс энэ том том төслүүд явснаар Монгол хүн, Монгол компаниуд, Монгол Улс хожих ёстой. Энэ төслийн гол оролцогч нь бол Монгол компани, Монгол хүмүүс байх ёстой гэж хараад байгаа юм.

Надад нэг төсөөлөл төрж байна л даа. Эдийн засгийн тэлэлт ирэх юм байна. Бүсчилсэн зүйн хөгжил бол буцлах юм байна. Кластераар хөгжөөд эхлэх юм байна. Үүнийхээ нөгөө жигүүрт нь бол бас хүний хөгжил яригдаж байна. Хүний хөгжил дотроо бас ахиад хүний эрхийн асуудлуудыг дээдэлсэн гээд ингээд 2 жигүүртэй ажил бол явах нь гээд. Бүсчилсэн хөгжил яваад ирэхээр том том төслүүд нь орон нутагт бас тухай

тухайн бүсдээ ажил хийгдээд явна. Үүнийгээ дагаад Монгол компани, мэргэжлийн компаниуд ороод ажиллахаар түүнийгээ дагасан дагавар үйлчилгээ бизнесүүд ороод ирнэ. Тэгээд тэнд ажиллах мэргэжилтэн боловсон хүчнүүд бол Засгийн газрын энэ тавьж байгаа саналыг маш тодорхой харах юм бол нүүдэл үүснэ л дээ. Хотоосоо одоо баруун бүсэд ажиллая. Баруун бүсэд миний мэргэжил, миний амьдрал, миний орлого нэмэгдэх юм байна гэсэн байдлаар. Говийн бүсэд би ажиллах юм бол энэ хөтөлбөрт нь би хамрагдаад, манай компани орлого ашгаа олох юм байна. Бид бол тийшээ нүүж ажиллах зөв юм байна гэсэн. Магадгүй хотоосоо бүс рүүгээ нүүх ийм хөдөлгөөн харагдаад байгаа юм. Энэ нь бол нөгөө сонгуулийн үеийн царцаанаас шал өөр ийм органик нүүдэл харагдаж байна. Тэгэхээр энэ нүүх гэж байгаа энэ хөтөлбөрийг сонсоод Их Хурлын дараа батлагдсаны дараа Засгийн газар зарлаад эхлэхээр компаниуд сонголт хийнэ. Хувь хүмүүс сонголтоо хийнэ. Тэгээд амьдралынхаа бараг сонголтыг хийж байгаа. Ашиг орлогын төлөө компани босгоё, том болгоё гэсэн сонголтоо хийж байгаа юм. Ийм сонголтод хэдэн зүйлийг бэлдэх ёстой санагдаад байна л даа. Ерөнхийдөө топ төслүүд явахад мэдээж цаг хугацаа мэргэжилтнүүд ажиллаад ТЭЗҮ бэлэн болоод явж байна гэж байна. Тэгээд энэ төсвийн тодотголын дараа ТЭЗҮ маань бүрэн боловсрогдчих байх. Тэгэхээр Их Хурлын дараа жинхэнэ оролцогч тал буюу хувийн хэвшлийнхэнтэйгээ, гадаад, дотоод оролцогчтойгоо тэр оролцёё гэж байгаа иргэдтэйгээ танилцуулга хийх, сурталчилгаа хийх маш шаардлагатай байна гэж харж байна. Үүний гол юм нь бол ТЭЗҮ нь тодорхой байх ёстой. 14 төсөл бүр их гоё ялгачихсан байсан. Аятайхан ялгачихсан байсан. Эдийн засгийн топ 10, нийгмийн топ 10 гээд. Үүнийхээ яг тэргүүлэх чиглэлийн 1-3-ыг нэрлэж өгөөч. Нийгмийн 1-3-ыг нэрлэж өгөөч. Ингээд яг голлох бүрэн болчихсон, ТЭЗҮ нь бүрэн болчихсон, асуудал нь бүрэн болчихсон том том төслүүдээ

түлхэх юм бол үүний чинь дараа бусад төслүүд бол тахианы өндөг шиг явна. Тэгэхээр 1 дор бүгдийг нь гэхээсээ илүүтэйгээр дараалал ач холбогдлоо өгөөд томоос нь эхлээд бүтэхээс нь эхлээд явуулах юм бол хүн бол дагаад явна. Хөгжил бол дагаад ирнэ. Үүн дээр бас анхаараасай гэсэн ийм бодол байна.

Дараагийн 1 юм бол мэдээллийн чанартай тухайн тухайн бүсдээ очиж, том том төслүүдээ сурталчлах ажлыг бол бас хийх ёстой. Тэгэхгүй бол том төсөл явахаар нутгийн иргэд болон бас бус тэмцэл хөдөл.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ингээд Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын болон бусад Байнгын хороодод шилжүүлээ.

18.24 цаг.

Ингээд дараагийн асуудалд оръё.

Хэлэлцэх асуудал 2.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд хуулийн төслүүдийн хэлэлцэх хэлэлцүүлгийг эхлүүлье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жавхлан: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулагдаж, улс төрийн намуудад ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн хамтарсан Засгийн газар байгуулагдаж “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” үнэт зүйлд нэгдэж, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлээд байна.

Энэ хүрээнд 3 намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилтод суурилсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан билээ.

Ийнхүү бид Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал, сорилтыг ишийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг хурдтай, зоригтой, бодитой хэрэгжүүлж эхлэх үндсэн суурийг тавьж байна.

Ирэх 4 жилд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 120 орчимд их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр шаардлагатай байна. Гэвч улсын төсвийн эх үүсвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дөнгөж 12,3 хувийг л санхүүжүүлэх боломж бий.

Тийм ч учраас нэн тэргүүнд хөрөнгө оруулалтын орчноо сайжруулах, гадаадын зээл ашиглалтыг нэмэгдүүлэх, оновчтой болгох, хувийн хэвшлийг дэмжих эрх зүйн цогц реформыг олон улсын жишигт нийцүүлэх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын дараагийн 30 жилийн хөгжлийн шинэ загварт тохирсон эдийн засгийн нөөцөөр үсрэнгүй хөгжилд чиглэсэн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн

төсвийн шинэчлэлийн хүрээнд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагуудыг олон улсын сайн жишигт нийцүүлэн боловсронгуй болгон өргөн барилаа.

Олон улсын практикаас харвал улс орнууд өөрсдийн эдийн засгийн нөөц бололцоо, улс орны онцлогуудтай уялдуулан төсвийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилгынхоо хүрээнд төсвийн дүрмүүдийг хэрэглэдэг бөгөөд ялгаатай төсвийн дүрмүүдийг хэрэглэдэг бөгөөд хөгжлийн үе шат, эдийн засгийн үеийн нөхцөл байдалд тохируулан төсвийн дүрмийг сайжруулан тогтоож ирсэн нийтлэг жишиг байна.

Монгол Улс анх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг уул уурхайн салбарын эрчимтэй өсөлтийн эхэн үе болох 2010 онд баталж, 2013 оноос бүрэн хэрэгжүүлж эхэлснээр нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн удирдлагын зарчим төсвийн тусгай шаардлагууд үйлчилж эхэлсэн. Уг хуулийн зорилго нь эдийн засгийг уул уурхайн мөчлөг дагасан савлагаанаас хамгаалж, төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ба төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн зарчмаар тооцож, тодорхой хэсгийг төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах, төсвийн зарлагын өсөлтийг уул уурхайн бус дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөөр хязгаарлах. Нэгдсэн төсвийн тэнцэл Засгийн газрын өрийн хязгаарыг тогтоох замаар хэрэгжүүлж ирлээ.

Тухайн үед буюу 2013 онд манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 19,2 их наяд төгрөг байжээ. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 5,9 их наяд төгрөг, гадаад худалдааны нийт эргэлт 6,1 тэрбум ам.доллар байсан бол 2023 оны эцсийн байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 3,7 дахин өсөж, 70 их наяд гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 4 дахин өсөж, 23,3 их наяд төгрөг боллоо. Гадаад худалдааны нийт эргэлт 2,3 дахин өсөж, 24,4 тэрбум долларт хүрч, эдийн засгийн багтаамж 3 дахин тэлснийг харуулж байна. Мөн дахин сэргээгдэхгүй уул уурхайн баялгаас орж ирэх орлогыг өнөө ба хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах Ирээдүйн өв санд 3,4 их наяд төгрөг уул уурхайн үнийн хэлбэлзлээс хамгаалж, төсвийг тогтворжуулах зорилготой Тогтворжуулалтын санд 1,3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагууд, төсвийн тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд түүхэн үүргээ гүйцэтгэснийг харуулж байна.

Монгол Улсын хөгжлийн шинэ үе шатанд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан Тогтвортой байдлын тухай хуульд туссан голлох зарчмын өөрчлөлтийг авч үзвэл:

1 дүгээрт, нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, байнгын шинжтэй тогтмол гардаг төсвийн урсгал зардлыг эдийн засгийн багтаамжийн тодорхой хувиар хязгаарласнаар төсвийн эдийн засаг дахь оролцоог хязгаарлах, хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, төсвийн орон зай үүсэх нөхцөл бүрдэнэ.

2 дугаарт, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь буюу түүнээс дээш хувийн ашигтай байлгаж, дотоодын эдийн засгийн нөөц сууриас бүрдсэн тэнцвэржүүлсэн орлогын эх үүсвэрээр төсвийн зардлыг хязгаарлаж, суурь тэнцлийн ашгийг тооцох ба эх үүсвэрээр энэ уг эх үүсвэрээр зөвхөн өрийн үндсэн төлбөрийг төлөхөд зарцуулна. Ингэснээр ирээдүйд өрийн дарамтад орох эрсдэлээс бүрэн сэргийлэх боломж бүрдэнэ.

3 дугаарт, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр тооцоноор дэлхий

дахинд Засгийн газрын өрийн хязгаарыг мөрддөг 72 улсын 65 улстай ижил аргачлалтай болж, эдгээр орнуудын нийтлэг аргачлалд шилжсэнээр харьцуулах боломж нэмэгдэхийн зэрэгцээ олон нийтэд ойлгомжтой болж хяналт тавихад хялбар болох юм.

Дээрх өөрчлөлтүүдийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай хуульд оруулснаар бид шинэ 30 жилийн хөгжлийг эхлүүлэх томоохон төслүүдийг гадаадын зээл тусламж, үнэт цаас, төр хувийн хэвшлийн түншлэл хувийн секторын эх үүсвэрээр шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, шинэ сэргэлтийн бодлогод тусгасан зорилтууддаа хүрнэ. Түүнчлэн 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан зарим өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор хуулийн төсөлд зохицуулалт хийхээр танилцуулж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээг 27,3 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34,4, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,6 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувийг ашигтай байж, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн хэмжээг 47,5 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиар хязгаарлаж тооцлоо.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт урья.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурал яаралтай горимоор хэлэлцэхээр шийдвэрлэж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Хууль санаачлагчаас Улсын Их Хурлын 2024 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан хамтарсан Засгийн газрын гэрээ, үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулсантай холбогдуулан улсын хөгжлийн тулгамдсан асуудал, сорилтыг шийдвэрлэх, эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, гадаад зээл, тусламжийн төслүүдийг хугацаанд нь дуусгаж ашиглалтад оруулах, эдгээр төслүүдийг эрэмбэлж өндөр ач холбогдолтой төслүүдийн ашиглалтыг ирэх жилүүдэд нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага бий болсон тул төсвийн тогтвортой байдлыг дунд болон урт хугацаанд хадгалах, төсвийн шинэчлэлийг эхлүүлж төсвийн тогтвортой байдлын тусгай шалгууруудыг боловсронгуй болгох,

төсвийн бодлоготой нийцүүлэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг өөрчлөн найруулах нь зүйтэй гэж үзэн холбогдох хуулийн төслүүдийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн төсвийн суурь зарлага, төсвийн суурь тэнцэл гэсэн шинэ ойлголтыг бий болгож байгаа нь төсвийн тогтвортой байдал үгүй болох, өр зээлийг хэмжээгүй нэмэх, хяналтгүй зардал гаргах эрсдэлийг бий болгохоор байгаа тул одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд нийцүүлж төсвийн тодотгол хийх,

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан үндсэн зарчмыг хөндөж, төрийн албыг тэлсэнтэй холбоотой урсгал зардал нь төсвийн зардлыг нэмэгдүүлж байгаа талаар,

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй талаар,

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан зардлын ангилал өөрчлөгдсөнөөр Засгийн газрын өр төсвийн гадуур бүртгэгдэх эсэх, аймаг, нийслэл бонд гаргах нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцэх эсэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд байнга өөрчлөлт оруулснаар тогтворгүй байдал бий болж байгаа талаар, төсвийн урсгал зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 39 хувийг эзэлж байгаа талаар,

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин урсгал зардлыг багасгах, дотоодын нийт бүтээгдэхүүнийг 30 хувиас хэтрүүлэхгүй байх, Төсвийн тогтвортой байдлын

тухай хуулийг төсвийн тодотголтой холбогдуулан өөрчлөхгүй байх,

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Засгийн газрын өрийг нэрлэсэн үнэ цэнээр бүртгэснээр Засгийн газрын өр хэрхэн нэмэгдэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа хамтарсан Засгийн газар байгуулагдсан тул өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгагдсан бодлого нь 3 намын нэгдсэн байр суурь мөн эсэх,

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд нэгдсэн төсвийн суурь зардал гэх ойлголт нь төсвийн сахилга батыг алдагдуулах эсэх, хуулийн өөрчлөлтийн хүрээнд бүртгэлийн хувьд бусад хуульд өөрчлөлт оруулах эсэх, урсгал зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнийг 30 хувиас хэтрүүлэхгүй болгох боломжийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн Хуулийн төслийг дэмжих нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж, хэлэлцүүлгийн явцад боловсронгуй болгоход анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулахгүйгээр төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөлд өөрчлөлт оруулах, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Төсвийн төсөөлөл өөдрөг байгаа боловч, 2025 оны улсын төсвийн төслийг боловсруулахад анхаарах, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд хувийн хэвилийг дэмжих, авлигаас урьдчилан сэргийлэх талаар тусгах, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат төсвийн хуулийн төсөлд нийгэм, эдийн засгийн үнэлгээ хийж, үр нөлөөг тооцдог болох, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн төсвийн тухай хууль тусгай шаардлагыг дахин нягталж үзэх, төсвийн зардал нэмэгдэж байгааг анхаарах нь зүйтэй гэсэн саналуудыг гаргасан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсвүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээвэр хөгжлийн сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ланганы Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ядамын Самбууням Монгол Улсын

Ерөнхий аудитын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лувсандагвын Мөнхцацрал Үндэсний аудитын газрын аудитын менежер, Юрагийн Энхтуяа Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер, Бат-Ирээдүйн Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамьяншиаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Дугаржавын Амгалан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Болдбаатарын Энхжин Нийслэлийн Засаг даргын Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Мөнхөөгийн Батбаяр Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 64.1-д “Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуульд заасан хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу хэлэлцэж, эцэслэн батална.” гэж заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хуулийн төсөл хэлэлцэх ердийн дэгээр хэлэлцэнэ.

Иймд Улсын Их Хурлын гишүүд намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууна.

Ингээд нийт 22 гишүүний нэр ирсэн байгаа. Дарааллын дагуу асуултаа асууж эхэлнэ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя. Ирсэн ирцээрээ эрэмбэлэгдэж байгаа.

С.Ганбаатар: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл дотор хуудас 12-т дахин сэргээгдэхгүй уул уурхайн баялгаас орж ирэх орлогыг өнөө ба хойч үеийнхтэй тэнцвэртэй хуваарилалт, Ирээдүйн өв санд 3,4 их наяд төгрөг уул уурхайн үнийн хэлбэлзлээс нь хамгаалж төсвийг тогтворжуулах зорилготой Тогтворжуулалтын санд 1,3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь гэсэн үг байгаа. Миний 1 дүгээр асуулт бол энэ мөнгө бичилт үү, яг мөнгөөрөө байгаа юу. Мааш тодорхой асуултад та нар хариулт өгнө үү.

2 дугаар асуулт их олон хүмүүсээс бас ярьж л байгаа асуудал л даа. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4.1.12-т нэгдсэн төсвийн суурь зарлага гэж нийт зарлагаас үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг хасаж тооцсон дүнг хэлнэ гэж байгаа.

Энэ бол би яах вэ, Засгийн газар хамтарч байна. Тэгээд тэр үйл ажиллагааны хөтөлбөрийг нь бид дэмжээд баталчих шиг боллоо. Одоо тэгээд төсвийг нь батлахаас өөр аргагүй. Аль болохоор дэмжихийг хичээж байгаа. Тэгэхдээ болохгүй байгаа зүйлийг хэлэхээс өөр аргагүй. Энэ бол үндсэндээ нэгдсэн төсвийн суурь зарлага хэмээх энэ шинэ ойлголт бол уг суурь тэнцлийг тооцоход үнэт цаас болон гадаад зээлээр

санхүүжих зардлыг оруулахгүй байх энэ зохицуулалт бол маш том эрсдэлийг бий болгож байна. Энийг яаж хааж байгаа вэ. Одоо бол энэ засаг төр чинь бол зүгээр өр зээлдээ баригдаж байсан ч бидэнд падгүй боллоо гэсэн санаа. Би энэ 4.1.12 дугаар заалтыг тодруулж асууж байна. Энэ бол нягтлан бодох бүртгэлийн стандартыг зөрчсөн 1 дүгээрт, 2 дугаарт эрсдэлийн гол эх үүсвэр болох Засгийн газрын зээлийн жилийн өсөлтийг хяналтын гадна гаргаж байна гэж би ойлгож байна. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2 хувиас илүү алдагдалтай байх нөхцөлийг нээж өгч байна. Энэ ингээд 5 шалтгаан байгаа. Энэ дээр зүгээр тайлбараа өгнө үү. 2 дугаар асуулт.

3 дугаар зүйл үндсэндээ өнөөгийн үнэ цэн, ирээдүйн үнэ цэн гэж тодорхойлсон байгаа. Энийгээ бас надад нэг тайлбарлаад өгнө үү. Энэ дээр Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 1 дүгээр зүйл дээр 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн өнөөгийн үнэ цэнээр гэснийг нэрлэсэн дүнгээр гэж тус тус өөрчилсүгэй гэж байна. Энэ дотор том луйвар явж байгаа гэж би ойлгож байна. Миний минут дуусах байх шиг байна. Тэгэхээр энэ дээр тодруулж би хариултаа авсны дараа бас тайлбар өгнө гэж ойлгож байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Жавхлан.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Сүүлийнхээс нь эхэлье. Өнөөгийн үнэ цэн эрлэсэн үнээр гээд. Ингээж бид маш том дэвшил гаргаж байгаа юм. Энийг маш олон жил ОУВС, Дэлхийн банк гээд бид нарын нэгдэж орсон энэ дэлхийн стандартыг тодорхойлдог байгууллагууд биднээс шаардаж байгаа. Үе үеийн парламент дахь цөөнхүүд бас энийг шаарддаг. Та нар өнөөгийн үнэ цэнээр гээд өөрсдийгөө аргалаад, одоо байгаа зээлийнхээ, өрнийхөө үлдэгдлийг багаар тооцуулахын тулд ингээд байна гээд. Бодитоор нэрлэсэн үнэ цэнээр буюу тохиргоо хийсэн

хамгийн өндөр эрсдэлтэйгээр нь тооцож, өөрөөр хэлбэл тэр хэмжээгээр эрсдэлээ багасгаж тооцдог ийм аргачлал руугаа бид олон улсын жишигээр шилжиж байгаа гэсэн үг Ганбаатар гишүүн ээ. Харин ч таны бодож байгаагаар яг эсрэгээрээ шүү. Бүр ч их том дэвшилтэт ангилал руу орж байгаа юм. Яах вэ энэ бол буурай орнууд ер нь голцуу энэ аргыг хэрэглэдэг. Бид нар энэ жилээс эхлээд албан ёсоор Дэлхийн банк, ОУВС-ийн ангиллаар буурай орноос хөгжиж буй орны жагсаалт руу орсон. Илүү их хариуцлагатай байхыг бид нар олон улс, санхүүгийн зах зээл, бид нараас шаардаж эхэлж байгаа. Тийм учраас олон улсын жишигт нийцсэн том дэвшил гарч байгаа гэж ойлгоорой.

Тэр 4.1.12-т та, эсвэл би буруу ойлгочхов уу. Энэ 2013 онд орсон өөрчлөлтөөрөө хэвээрээ байгаа заалт шүү. Энийг бол хөнддөггүй. Энэ чинь өөр заалт дээр байгаа. Та андуурчхав уу, яав. Хэрвээ буруу ойлгосон бол дахиад асуугаарай.

Тэр урсгал зардал, суурь тэнцэл гэдэг бол энэ нягтлан бодох бүртгэлийн ойлголт биш шүү. Нягтлан бодох бүртгэл дээр бол ямар ч өөрчлөлт гарахгүй. Энэ зөвхөн Засгийн газар өөрөө санхүүгийнхээ төлөвлөлтийг хийхдээ ашиглаж байгаа нэр томъёолол юм байгаа юм. Энэ бүртгэл олон улсын жишиг стандарттай ямар ч хамаагүй асуудал.

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгөх хүн байгаа юу. Алга байна. Ганбаатар гишүүн тодруулна гэсэн үү. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулга. 1 минут.

С.Ганбаатар: Үндсэндээ суурь тэнцлийг тооцоход үнэт цаас болон гадаад зээлээр санхүүжих зардлыг оруулахгүй байх зохицуулалтыг тусгасан байгаа гэж би хэлсэн. Үгүй ээ, тэгээд гадаад зээл, тусламжийг бид зарлагадаа ерөөсөө оруулахгүй байх юм бол тэрийг чинь ямар нэгэн байдлаар Монголын ард

түмэн дараа нь төлнө. Улсын Их Хурлын хамгийн том эрх мэдэл бол төсөв батлах. Бидний суга доогуур манай улс ямар ч зээл авсан хамаагүй гадаад зээл тусламж одоо энэ дээр би нэр томъёогоор нь хэлээд байгаа шүү дээ. Суурь тэнцлийг тооцоход гадаад зээлээр санхүүжих зардлыг оруулахгүй байх гэж байгаа. Энэ бол том эрсдэлтэй асуудал бий болгоно. Энийг хэрвээ яг энэ чигээрээ орох юм бол энэ төсвийн хүрээний мэдэгдэл болон энэ хууль дээр ноцтой асуудал гарна. Энийг өөрчилнө гэж би ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүн ээ, та одоо олон жил Улсын Их Хурлын гишүүнээр ирж байгаа их хариуцлагатай улс төрч хүн шүү. Яг иймэрхүү мэдэгдэл хийх юм бол хүмүүс энийг чинь шууд ойлгоод л авчихна. Зарлагад оруулж тооцохгүй гэдэг ойлголт байхгүй шүү дээ. Зардлын суурь хязгаар тооцох аргачлалд өөрчлөлт орж байгаа болохоос биш энэ төсвийн тэнцэлд оруулаад, тэнцлээс гадуур бүртгэж байгаа тийм асуудал байж болохгүй. Хэрхэвч байж болохгүй. Та ингээд хэмжээгүй өр зээл яриад явчихлаа. Энэ төсвийн тогтвортой байдлын хуулийн чинь тусгай шаардлага 4.1.4 дээр Монгол Улсын Засгийн газрын өр 60 хувийн хязгаартаа багтах ёстой гэдэг ийм заалт нь хэвээрээ байж байгаа. Энэ хязгаар дотроо л баригдах ёстой. Гэхдээ энэ талаар маш ноцтой өөрчлөлтүүд өмнө нь хийгдсэнийг би дараагийн хариулт дээрээ 5 минут авахдаа би хэлье.

Ер нь яагаад Засгийн газар ийм юм өргөн барьсныг үнэнийг нь хэлэхгүй бол өчигдрийн Байнгын хорооноос хойш хүмүүст маш буруу .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн нэмэлтээр хариулт өгнө. 1 минут.

Ц.Даваасүрэн: Ганбаатар гишүүний яриад байгаа асуудлыг Төсвийн байнгын хороо дээр бас ярьсан. Тэгэхдээ бид нар бас үнэн зөв мэдээлэл өгөх хэрэгтэй Жавхлан сайд аа. Тэгээд хасаж тооцох асуудал байгаа. Тэгэхдээ энийг Их Хурлын гишүүд бид яриад энэ асуудлыг нэг тийш нь бас ажлын хэсэг дээр ярьж шийдье гэсэн байгаа. Гэхдээ 1 зүйл байгаа Ганбаа гишүүн ээ. Тэр нөгөө өрийн гол шалгуур болсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх гэдэг заалт нь бол хэвээрээ. Тэгэхээр Засгийн газар хэчнээн зээл авлаа ч, үнэт цаас гаргалаа ч тэр хязгаартаа бол баригдана. Зүгээр бүртгэл дээр тийм асуудал байгаа юм. Тэгэхдээ би энэ дээр бас тодорхой саналыг ажлын хэсэгт тавина. Тэгээд ажлын хэсэг дээр ярилцаад шийднэ. Та нар өөрсдөө бас оролцоод яваарай. Энэ дээр нэг их санаа зовох зүйл байхгүй. Яагаад гэвэл өрийн дээд хязгаарыг багтаасан шалгуур үзүүлэлт нь бол хэвээрээ 60 гэдэгтээ баригдахаар байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүн Банзрагчийн Түвшин асуулт асууна.

Б.Түвшин: Эрхэм хүндэт Их Хурлын гишүүддээ энэ оройны мэндийг хүргэе. Тэгээд өчигдөр Төсвийн байнгын хорооны хурал дээр гол санаануудаа ярьчихсан. Тийм учраас товчхон 2, 3 асуулт асууя. Үндэсний Аудитын газраас асууя. Төсвийн тусгай шаардлагыг оруулж ирж байгаа тодотгол хангасан байна гээд энэ 5, 6 үзүүлэлтүүдийг ингээд өгсөн ийм тайлан өгчээ. Энэ хангасан гэсэн тайланг гаргахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон төсвийн тусгай шаардлагуудыг шинээр өөрчилж оруулж ирснээр нь тооцсон уу. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаагаар тооцсон уу гэдэг дээр Үндэсний Аудитын газраас асууя. Хэрвээ одоо мөрдөгдөж байгаагаар тооцсон бол энэ тайланг үзэж болох юм. Хэрвээ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон тусгай шаардлагыг өөрчлөхөөр оруулж

ирснээр нь тооцсон бол одоо байгаагаар нь хариулаад өгөөч гэж хүсэх байна 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт. Ер нь манай төсвийн нийт зарлагын хэдэн хувь нь урсгал зардал, хэдэн хувь нь хөрөнгийн зардал, одоо бид нарын оруулж ирээд байгаа энэ хөрөнгө оруулалтын зардлын дотор дахиад саяын энэ дээр нэмэх нь зам нь хэдэн хувь юм. Барилга нь хэдэн хувь юм. Өөрөөр хэлбэл ирээдүйд мөнгө өгөхгүй, өнөөдөр бид нарын бөглөрөл зэрэг асуудлыг шийдэж байгаа шинж чанартай хөрөнгө оруулалт гэж нэрлэгдсэн зардлууд нь нийт төсвийн зардлын хэдэн хувийг эзэлж байна вэ. Миний л харснаар нефть боловсруулах үйлдвэрээс бусад бүх энэ зардлууд ирээдүйдээ хөрөнгө оруулалтаа нөхөхгүй буюу зардлын шинж чанартай харагдаад байгаа. Тийм учраас энэ бүх зардал яаж эдийн засагт нөлөөлөх юм бэ. Энэ дээр мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт гаргасан уу. Хэн батлан дааж байгаа юм бэ.

Дараагийн асуудал ер нь энэ Засгийн газар өөрчлөгдсөн учраас төсвийн тодотгол хийх боломжтой, хийх л ёстой байх. Гэхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон тусгай шаардлагуудыг өөрчлөхгүйгээр энэ тодотголоо хийх боломж байна уу гэдэг асуудлыг асуух гэсэн юм.

3 дугаарт. Ер нь бол олон улсын жишигээр манай дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн орлого зардал өндөр байгаа. Төсвийн орлого зардал дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлдэг дундаж орнуудынхаас өндөр байгаа нь улсын төсөв буюу төрийн оролцоо, бусад жишигүүдээс өндөр байна. Энийг буулгах юм бол ялангуяа хувийн хэвшлүүд болон эдийн засаг өсөх буюу буцаагаад дотоодын нийт бүтээгдэхүүн чинь өснө. Буцаагаад дотоодын нийт бүтээгдэхүүн чинь өсөх юм бол төсвийн зардлаа өсгөж болно. Тийм учраас буцаагаад дотоодын нийт бүтээгдэхүүнээ өсгөхөд дотоодын нийт

бүтээгдэхүүнийг зардлын аргаар тооцох, иргэд, аж ахуйн нэгжүүдийн зардлыг өсгөх арга нь бол үндсэндээ тэд нараас хурааж авч байгаа нэмэгдсэн өртгийн татвар руу нь нийгмийн даатгалыг бууруулчих боломжтой. Энэ нь буцаагаад дотоодын нийт бүтээгдэхүүнээ өсгөөд, эргээд төсвийн зардлаа өсгөж болох юм биш үү. Тийм учраас энэ удаа Төсвийн тогтвортой байдлын хуулийг өөрчлөхгүйгээр төсвийн тодотголудаа оруулж ирэх боломжтой байна уу гэсэн ийм 3, 4 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Аудитын ерөнхий газраас хэн хариулт өгөх вэ. Эхлээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье. Араас нь Аудитын ерөнхий газраас. Энэ ердийн дэгээр явж байгаа хууль хэлэлцэгдэж байгаа. Ердийн дэгээр. Нийт хэлэлцэх хугацаа 2 цаг 30 минут. Тэгэхээр үндсэн хариулж байгаа хүн 3 минутаар, нэмэлтээр хариулж байгаа хүн 1 минутаар хариулж байгаа. Тэгэхээр Болдын Жавхлан сайд үндсэн хариулт өгөх нь ээ.

Д.Амарбаясгалан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Одоо зарим нэг мэдээллийг ил ярихаас өөр аргагүй болж байна. Уучлаарай. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн ч гэсэн анхааралтай сонсож байгаарай. Өнгөрсөн парламентын сүүлийн хуралдааны өдрүүдэд буюу 6 сарын 5-нд Төсвийн тогтвортой байдлын хуульд өөрчлөлт орсон. Нэмэлт, өөрчлөлт орсон. Төсвийн байнгын хорооны дарга санаачлаад Төсвийн байнгын хорооны гишүүд энэ өөрчлөлтүүдийг оруулсан. Засгийн газраас 4 сард санал авсан юм. Засгийн газар 4 сард хариулт өгөхдөө 1 ч заалтыг нь дэмжээгүй. Энэ боломжгүй гээд. Гэтэл Улсын Их Хурлаар яг тэр хэлэлцэх үеэр санал авсан жагсаалтдаа оруулаагүй саналуудыг оруулж ирээд Улсын Их Хурлаар нэвт батлуулсан. Нэвт дэмжүүлээд. Тэрний үр дүнд одоо Монгол Улс төсвийн тогтвортой байдлын 4 дүрмийнхээ 2 нь байхгүй болчихсон. Монгол Улс өнөөдөр ямар нэг өрийн

хязгааргүй болчихсон. Тэнцэл нь алдагдлын хязгааргүй болчихсон явж байгаа. Энийг бид хэзээ мэдсэн бэ гэхээр одоо батлагдсан хуулиуд төрийн хэвлэл дээр гараад, веб дээр гарснаас хойш албажаад явдаг. Тэнд гарснаас хойш л бид нар хэдхэн хоногийн өмнө мэдлээ. Төсвийн тодотголоо өргөн барихаас өмнө. Тэрийг засаж оруулж ирж байгаа юм. Энэ тодотголоор. Тэр 60 хувийн хязгаар гэдгийг буцааж яг тэр заалтыг нь хөндсөнөөр Улсын Их Хурал энэ алдаагаа засах ийм боломж бүрдэж байгаа юм.

6.1.2 буюу одоо тэнцвэржүүлсэн тэнцэл маань -2 хувийн алдагдлаас хэтрүүлж болохгүй. Үүнээс сайжрах ёстой. Эсвэл нэмэх байх ёстой гэдэг энэ хязгаар байхгүй болчихсон явж байгаа өнөөдөр Монгол улсад. Монгол Улс ийм 2 хязгааргүй болчихсон явж байгаа шүү. Энийг зээлжих зэрэглэл тогтоодог олон улсын байгууллагууд, ОУВС, Дэлхийн банк гээд гадна талаас бид нарын санхүүгийн зах зээл дээр, олон улсын санхүүгийн зах зээл дээр харж байгаа энэ байгууллагууд сонсох юм бол ухаан алдаж унана. Манайхан ч гэсэн энийг сонсоод зүрх муутай, даралт ихтэй хүмүүс бол эмээ уугаарай. Энийг янзалж оруулж ирж байгаа ийм л заалтууд байгаа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг орон тооных болгох гээд, байнгын болгох гээд орж ирсэн өөрчлөлтүүдтэй хамт энэ заалт ороод батлагдчихсан байна лээ. Мааш харамсалтай. Мааш олон Улсын Их Хурлын гишүүд энийг бас мэдээгүй, ойлгоогүй байна. Ийм өөрчлөлтүүд бий болчихсон шүү. Энийг Засгийн газар харин яаралтай янзлах ёстой гээд энэ төсвийн тодотголоо дагуулаад хэд хэдэн заалтуудыг өөрчилж, нэмж оруулж ирж байгаа ийм л юм байгаа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гээд мааш харамсалтай байна. Улс төрчдийн захиалгаар улс төрийн дүгнэлт хийдэг нэг ийм л байгууллага юм шиг өчигдөр тийм юм уничижна лээ. Та нар

одоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт. Жавхлан сайдад нэмэлт 1 минут нэмэлт өгье.

Б.Жавхлан: Тэгээд ийм засвар хийж байгаа гол ийм өөрчлөлтүүдээ оруулж ирж байгаа. Дээрээс нь Засгийн газар хамтарч байна. Өнөөдөр ингээд хөтөлбөрөө танилцууллаа. Гэрээ хийгдсэн. “Хурдтай хөгжлийн төлөө зориг” энэ том 4 жилийн үсрэнгүй хөгжлийн амбицтай ийм хөтөлбөрөө оруулж ирж байна. Юм л хийе гэж байгаа. Юм хийе. Тэгэхдээ бид нар нэлээн боловсронгуй, орчин үеийн шаардлага, стандартад нийцсэн. Хязгааруудаа хөндөхгүй, харин ч буцааж тэр 60 гээд байхгүй болгочихсоныг оруулж ирж байгаа юм. Доороос нь нэрлэсэн үнээр гээд дахиад өшөө их эрсдэлтэй 40 хувь байгаагаа 44 болгоод, доороос нь сойгоод, дээрээс нь ингээд таазыг нь тавиад өгчихөөр харин ч бүр нарийн болж ирж байгаа байхгүй юу. Тооцооллын аргачлал дээрээ бид нар өөрчлөлтүүд хийж байгаа. Суурь тэнцлээ бүр ашигтай болгож байгаа юм. Юун алдагдал. Ашигтай болоод 2 хувь гэдэг бол өнөөдрийнхөөр бол 1,5 их наяд юм байгаа юм. Жил бүр 1,5 их наядыг цааш нь хийнэ. Энэ мөнгөөр зээлээ төлнө. Бид нар жил болгон ийм дүнгээр төлж чаддаггүй. Ингээд ерөнхийдөө балансаа бариад явна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Нэмэлт нэг минут өгчихье.

Б.Жавхлан: Өрийн удирдлагын тухай хууль дээр энэ заалтуудыг оруулаад ирчихсэн байгаа юм. Нөгөө -2 хувийн алдагдалтай гэдгийг чинь байхгүй болгочихсон байгаа. Тэгвэл тэрний оронд +2 хувийн суурь тэнцэлтэй явна шүү. Энийгээ жил бүр зөвхөн өр төлөхдөө ашиглана шүү гээд ийм заалт оруулаад өгчихсөн байгаа юм. Хамаагүй дэвшилттэй. Тэгэхдээ нөгөө талдаа энэ Засгийн газрыг бас юм хийх, бүтээн

байгуулалт хийх орон зайг нь гаргаж өгөөд ингээд явж байгаа ийм зохицуулалтууд байхгүй юу. Яах вэ, өчигдөр над руу баахан дайрцаасан л даа. Засгийн газар луу баахан дайрцаасан. Яах вэ, би ёс зүй бодоод өнгөрсөн парламент, өнгөрсөн Төсвийн байнгын хорооны нөхдүүдээ бодоод би хамаагүй энэ асуудлыг хөндөөгүй, хөндөөгүй. Өнөөдөр ярихаас өөр аргагүй болж байна. Өчигдрөөс хойш баахан л энэ талаар суртал ухуулга гадуур хийлээ. Олон нийтэд маш буруу ойлголт өгөх гээд байна. Тийм учраас Засгийн газрынхаа үйл ажиллагаа бүх энэ 4 жилийнхээ суурийг тавих гэж байж энийг би ярихаас өөр аргагүй болж ирж байна. Хэрвээ энэ өөрчлөлтүүдийг хийхгүй бол ядаж л энэ жил хардаа, одоо тэр нефть боловсруулах үйлдвэрийн санхүүжилтийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Түвшин гишүүн асуулт асууж, хариулт авлаа. Болсон тийм ээ. Аудитаас хариулт 1 минутаар өгье. Хариултын хугацаа ер нь нийт дүнгээрээ 5 минутад байна гэдгийг хариулт өгч байгаа хүмүүс маань анхаарч, дэгийн дагуу ажиллах шаардлага байгаа шүү. Аудит хэддүгээр микрофон байна. Индэр дээрээс, 2 дугаар индэрт хариулт өгье.

Ц.Наранчимэг: Түвшин гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Төрийн аудитын байгууллага төсвийн тодотголд дүгнэлт гаргахдаа Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагыг хангасан эсэх буюу бодлогод нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаж, Улсын Их Хуралд хүргүүлсэн байгаа. Бид энэ төсвийн тодотголд дүгнэлтийг гаргахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орсон голлох өөрчлөлтүүдийг баримталж дүгнэлтээ гаргаж хүргүүлсэн. Авч дүгнэлтээ гаргаж хүргүүлсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Шаардлага нь энэ дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэх ойлгож байгаа. Гадаадын зээл тусламжийн төслүүдийг хугацаанд нь дуусгаж, ашиглалтад оруулах ойлгож байгаа. Төслүүдийг эрэмбэлж ач холбогдол өндөр төслүүдийн ашиглалтыг ирэх жилүүдэд нэмэгдүүлэх, энэ шаардлагуудыг ойлгож байгаа. Зориулалт нь болохоор шинээр эхлэх бүтээн байгуулалтын төслийн судалгаа, ТЭЗҮ боловсруулах дээр их хэмжээний мөнгө зарцуулагдаж байна. Энийг ойлгож байна. Өмнө нь эхэлсэн хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлын төсвийг нэмэгдүүлэх. Энийг ойлгоё. Урсгал зардлыг нэмэгдүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд шилжүүлэх гээд энийг ойлгож байна.

Тэгэхээр анхаарах 3, 4 асуудал байгаа.

Нэгд, шинээр эхэлж байгаа бүтээн байгуулалтын судалгаа, ТЭЗҮ-ийг их хэмжээний мөнгөөр хийлгэлээ гэхэд цаашид тэр нь бодитой хэрэгжих баталгаа хэр байгаа юм бол. Бид нар энэ дээр маш их алдаа гаргадаг. Энэ талаар хариулт.

2-т нь өмнө нь эхэлсэн, дуусаагүй байгаа бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлүүдэд тийм ээ, бодитой мониторинг хийж, дүгнэлт гаргасан эсэх. Ер нь энэ дээр статистик байвал хэлж өгөөч. Эдгээрт төсвийн тодотголоор мөнгө заавал нэмж өгөх шаардлага талаас нь.

Дараа нь болохоор төрийн албан хаагчийн орон тоог 10 хувиар тогтмол бууруулна гэсэн зорилт ер нь хэр хэрэгжих боломжтой, бодитой вэ. Энэ дээр ямар төсөөлөл байгаа вэ. Шинээр эхлэх том төслүүд дээр эрсдэлийн үнэлгээ ер нь давхар хэр хийгдэж байгаа юм бол. Энэ дээр ийм статистик байна уу гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Худалдан авах үйл ажиллагаатай холбоотой Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Бүгд тодотголд байгаа учраас би хариулчихъя. Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Бид нарын өмнө яг ижилхэн сорилт байгаа байхгүй юу. Шинэ төслүүд бол маш том бүтээн байгуулалтын мега төслүүд бүгдийг нь бид 0-ээс эхэлж байна. Тэгэхдээ бидэнд бас энийг хийчихье, бүтээчихье, энэ 4 жил үнэхээр нэг ард түмнээ сэргэлт эрхээр ийм хөгжлийг авчиръя гэдэг ийм амбицтай байгаа. Төслүүд бол ерөөсөө одоо тэр хөтөлбөр дээр танилцуулж байгаа 120 их наяд шаардлагатай байгаа төслүүд бол ер нь дөнгөж 10 хувийг нь л төр төсвийн хөрөнгө оруулалтаа хийж чадна. Цаана нь үлдэж байгаа 90 хувь бол төр, хувийн хэвшлийн түншилэл, гадаадын шууд хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийнхний хөрөнгө оруулалт, магадгүй Хөгжлийн банкны боломжууд байвал ингээд олон эх үүсвэрүүд явна. Төсвөөс хийх 10 хувь нь бол ерөөсөө л дэд бүтэц хийгдэнэ. Дэд бүтэц, дэд бүтэц, дэд бүтэц. Өөрөөр хэлбэл бусад 90 хувийнхаа бүтээн байгуулалт хийх, баялаг бүтээх боломжийг нь суурийг нь тавьж тавьж өгч байгаа ийм үндсэн зарчим гэсэн үг.

Тодотгол дээр нэмж өгч байгаа 984 тэрбум бол гарцаагүй бид нар хийнэ. Яагаад гэвэл бид энийг хийнэ гээд Улсын Их Хурал дээр энэ зээлийг авч болно гээд баталчихсан. Ингээд зээлийг нь аваад хэрэглээд эхэлчихсэн төслүүд. Одоо томоос нь дурдъя. Нефть боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэний УЦС, ингээд Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламж гээд энэ 3 чинь 984-ийн бараг 700 нь болчихож байгаа байхгүй юу. Одоо энийг дундаас нь сэглээд бид нар хаяж болохгүй. Аль болох зээлийг нь аваад, бушуухан төлөөд, ашиглалтад эргэлтэд оруулаад, бид нар үр шимийг нь авч явах ёстой байхгүй юу. Тийм үүднээс энийгээ оруулж ирж байгаа юм.

Тэр Эрдэнэбүрэний усан цахилгаан станц байна. Одоо Их Хурлаар орж ирнэ. Авах эсэхийг нь энд шийднэ. Та шийднэ, та бүгд шийднэ. Ав гэвэл маргааш нь эхлээд урьдчилгааг нь шилжүүлэхгүй бол энэ Эрдэнэбүрэний УЦС хойтон ажил нь эхэлж чадахгүй юм байгаа юм. Ийм дүнгүүдээ тавьчихсан байгаа учраас энэ гарцаагүй хийх ёстой ийм гадаад зээлийн ашиглалт шүү. Нэмж зээл авах гэж байгаа гэж ойлгож болохгүй шүү. Урьд нь зөвшөөрчихсөн, аваад эхэлчихсэн зээлийнхээ энэ жил ашиглалтыг үргэлжлүүлэх гэж байгаа гэсэн үг. Энэ жил 1,2 их наядыг тавьсан. Хагас жилээр 96 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Эдийн засгийн идэвхжил өндөр байгаа учраас барилгын салбарын гүйцэтгэл бас яг энэ гүйцэтгэгч нар их сайн ажиллаж байна гэсэн үг. Бушуухан дуусгах хэрэгтэй. Энэ 984-ийг хэзээ нэгэн цагт хийнэ. Тийм учраас боломж байгаад өнөөдөр хийчихлээ гэхэд хойтонгийн төсвийнхөө ачааллыг тэр хэмжээгээр багасгаж байна гэж харах хэрэгтэй. Тийм учраас энэ бүгдийг бол хийгээд явна. Нарийн тэр мониторинг энийг бол төсөл бүрийг захиалагч яамнуудад хэлэх нь зөв.

Төрийн албан хаагч нарыг 10 хувиас, 10 хувиар жил бүр багасгана гэж байгаа. Энийг хамтарсан Засгийн газар дээр энийг маш сайн ярилцах хэрэгтэй. Тойрог тойргоос сонгогдсон улс төрч нар ч гэсэн энийг ингээд оролцоод явах хэрэгтэй. Тэгэхдээ төрийн албан хаагч гэдэг чинь бас л хүн, өрх тэжээгч нар байдаг шүү. Тийм учраас ер нь бол цаашидаа бид аль болох орон тоо нэмэхгүй, данхайхгүй л байх хэрэгтэй. Манай хүн ам бол өснө шүү дээ. Хүн ам өснө. Хүн ам өсөх хэрээр 1 хүнд ноогдох төрийн албан хаагч нарын харьцаагаа барих хэрэгтэй. Өсгөхгүй, одоо байгаа хэмжээнд нь өссөн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн асуултаа асуучихъя.

С.Зулпхар: Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүдийн энэ оройн амгаланг айлтгая. 2 асуулт байна.

Өнгөрсөн жил 7 сарын 7-нд бид төсвийн тодотгол хийсэн. Улсын Их Хурал дээрээс. Тэнд бол 1,9 их наяд төгрөг яригдаж байсан. Тухайн үеийн төсвийн тодотгол бол маш их шүүмжлэл дагуулж байсан юм. Анх баталж байх үедээ урсгал зардал нь тухайн үеийн тэр тодотгол бол их шүүмжлэл дагуулж байсан. Урсгал зардал их болчихлоо гэж. Ер нь бол 1,9 их наядын 72, 73 хувь нь урсгал зардал байсан юм л даа. Тэтгэвэр, тэтгэмж, цалин гэх мэтчилэн. 23 хувь нь л үндсэндээ хөрөнгийн зардал байсан. Одоо энэ удаа бол тодотголоор 3,1 их наяд орж ирж байна. Үүний 58 хувь нь хөрөнгийн зардал болчихож. Одоо сайн байна л гэж ойлгож байна л даа. Би эндээс яах вэ өөрийнхөөрөө л бодчихсон байгаа байх. Та хэд бол нарийн бодсон байх. Ингээд нэмэгдээд явж байна.

Тэгэхээр эхний асуулт бол өмнөх жилийн тодотголттой харьцуулах юм бол энэ жилийн тодотгол бол эдийн засгийн ач холбогдол, үр өгөөжөө илүү тооцсон ийм тодотгол болчихсон, боломжийн цаг үеэ олсон тодотгол боллоо гэж үзэж байна. Энэ зөв үү гэж байгаа юм. Гэхдээ өнгөрсөн жилийнхийг муу гэж байгаа юм биш. Өнгөрсөн жилийнх чинь өрхийн амьжиргааг дэмжихэд бол маш чухал үр нөлөө үзүүлчихсэн шүү дээ. Тэгээд дагаад нийгэм, эдийн засгийн үр нөлөөтэй, үр өгөөжтэй ийм тодотгол болсон гэдгийг хэлсэн. Тэгэхээр энэ дээр 1 хариулт авъя.

2 дахь зүйл энэ яах вэ, мэдээж хэрэг төслүүд хэрэгжих нь их чухал. Бид угаасаа ингэж хэрэгжээсэй ч гэж бодож байгаа. Гэхдээ төслийн хэрэгжилттэй холбоотой бас энэ дээр би ялангуяа Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбортой холбоотой энэ төслийн 1 дүгээрт бол энэ тодотголоор дамжуулаад, 2024 ондоо багтаагаад ТЭЗҮ, зураг төслийг боловсруулаад барилга угсралтын ажлыг эхлүүлнэ

гэчихсэн байгаа юм. 100 тэрбум төгрөгийг нь тавьчихсан. Техник эдийн засгийн үндэслэл болон зураг төсвийг бол боловсруулах хугацаа байж болох байх. Заримдаа ч бас амжихгүй ч байж магадгүй. Энэ барилга угсралтын ажил эхлэх боломжтой юу. Тэгэхээр энийг ахиад жишээ нь нарийвчилж та бүхэнд тооцож байж 100 тэрбумаа бүрэн хэрэглэж чадах уу гэдэг талаас нь тооцоолол хийсэн үү гэдэг ийм асуулт байна.

3 дахь бас асуулт байна. Энэ их олон техник эдийн засгийн үндэслэлүүд гаргах юм байна. Маш сайн. Угаасаа тэгж байж л цаашаа явах юм чинь энэ дээр одоо их том том дүнтэй мөн дүнгүүд тавьчихсан. Бас янз янзын шүүмжлэл дагуулдаг. Шүүмжлэл дагуулах нь бол хамаагүй, угаасаа дагуулж л байдаг юм чинь. Энэ яг ямар жишгээр тавигдсан дүнгүүд вэ гэдэг дээр бид энийг нөгөө уншихаар мэдээлэл аваагүй учраас энэ дээр та бүхэн бас бидэнд мэдээлэл өгөөч ээ гэж байгаа юм.

Төгсгөлд нь нэг жижиг асуулт байна. Тэр нь бол яах вэ, энэ хойно хавсралтаар байж байгаа. Төсвүүд гээд. Гэхдээ энэ тодотголтой бол шууд холбоотой биш байх. Энэ 6 аймагт, 12 сумд ийм иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга гээд ийм барилга бариад эхэлсэн юм байна. Цаашидаа яах юм 330 сумд ийм барилга баригдах юм уу гэдэг ийм асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан, араас нь Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн.

Б.Жавхлан: Зулхар гишүүнд баярлалаа. Дэмжиж үг хэлж байгаад. Эхний юун дээр ер нь 75 хувь нь бүр яг дэд бүтцийн хөрөнгө оруулалтуудаар эхлүүлчихсэн байгаа төслүүдийн санхүүжилтийг энэ жил үйл ажиллагаа тэр нөгөө барилгын ажил нь зогсоочихгүйн төлөө гаргаж байгаа ийм

зардал юм. Тэгэхээр яах аргагүй эдгээр төслүүд бэлэн болоод, эргэлтэд орсноор яг баялаг бүтээгч, шууд хөрөнгө оруулагч нарыг дэмжих ийм суурь дэд бүтцүүд тавигдана гэж ойлгох ёстой. ТЭЗҮ энэ жил 484 тэрбум төгрөгийн ийм ТЭЗҮ урьдчилсан бэлтгэл ажлын ийм санхүүжилтийн дүн орж ирж байгаа юм. Орж ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол голдуу нөгөө дэд бүтцүүд байгаа учраас ЭХЯ, ЗТЯ, нийслэл Улаанбаатар хот, “20 минутын хот” Үндэсний хорооны сайд гээд эдгээр Засгийн газрын бүрэлдэхүүн нийслэлд оролцоод тус бүрдээ тооцож гаргаж ирсэн ийм дүнгүүд юм байгаа юм шүү. Та яг онцгойлон асууж байвал манай сайд нар энэ дээр тодруулж нэмж хариулаарай. Тэр 12 сумынхыг Дэлгэржаргал хариулах уу. Санжаа хариулах уу.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүний микрофон өгье.

Ц.Даваасүрэн: Төсвийн зардлын асуудал дээр бас Байнгын хороон дээр бид ярьсан юм. Бас анхаарах шаардлага бол бий. Яагаад гэвэл 2023 онд төсвийн зардал 12 их наяд байсан. 2024 онд 2 дахин өссөн, 24 их наяд. Одоо төсвийн тодотголоор 30 их наяд болж өсөж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ бол бас цаанаа том эрсдэл бол бий. Яагаад гэвэл манай эдийн засаг өөрөө зөвхөн дан ганц нүүрснээс хамаарч байна шүү дээ. Өнгөрсөн жил 9 тэрбум гаруй, тэрбум орчим долларын нүүрс орж ирж байж л энэ бүгд чинь голлож бүрдэж байгаа. Эдийн засгийн чинь 80 гаруй хувь нь уул уурхайн салбар байна. Тийм учраас уул уурхайн бүтээгдэхүүний үнэ унах юм бол маш том эрсдэл гарч болзошгүй гэдэг зүйлийг бол Байнгын хорооны хурал дээр бид хэлсэн байгаа. Тийм учраас бид нар Засгийн газар хамтарч байгаа энэ үедээ том бүтээн байгуулалтыг хийхийн тулд юун дээр анхаарах ёстой гэвэл .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр одоо бол бид нар энэ мөрийн хөтөлбөр хийх гэж ерөөсөө маш оновчтой төслүүд, эдийн засаг дэмжсэн дэд бүтцийн төслүүд гэсэн маш чухал төслүүд дээр ярихгүй бол энэ том том төслүүдийг бүгдийнх нь ард гарна гэвэл энэ худлаа. Өнөөдөр нэг триллионы эдийн засагтай Индонез, Солонгос нийслэлээ шилжүүлэх гээд хүч мөхсөдөж байна шүү дээ. Хүнд байна шүү дээ. Тэгэхэд 100 дахин бага эдийн засагтай Монгол бол Хөшигтийн хөндийг Хар хоринтой бариад явна гэдэг бас л хүнд л байж таарна. Тийм учраас маш сонголттойгоор зөв эдийн засгийн дэд бүтцийнхээ асуудлуудыг л авч явахгүй бол бас бүгдийг барьж аваад хийчихнэ гээд ингээд байгаа нь бол эдийн засгийн тооцоолол, таамаглал бас сайн хийгдээгүй л гэсэн үг л гэж би хараад байгаа шүү. Тийм учраас бас анхааралтай хандах ёстой.

Д.Амарбаясгалан: Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Та бүхэндээ оройн мэндийг хүргэе. 2025-2026 оны төсвийн төсөөлөл дээр жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт хэрхэн хийгдсэн бэ. Тийм ойлголт ер нь байдаг болов уу. 2 дугаарт нь Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн эрхийг хэрхэн хангах талаар төсвийн ерөнхийлөн захирагч нарт тухайлсан төсөвт тусгагдах боломж ер нь байгаа болов уу.

Дараагийн асуулт нь Төсвийн тухай хуулийн 28.2 дээр иргэдийн болон иргэний нийгмийн байгууллага хувийн хэвшлийг оролцож санал авна гэсэн нэг ийм нээлттэй олон нийтийн санал гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь манай улсын энэ төсөв дээр хувийн хэвшил, иргэд оролцоод санал авч байсан ийм статистик тоон үзүүлэлт, туршлага ер нь байдаг юм болов уу.

Хамгийн сүүлийн асуулт нь энэ төсвийн саналыг иргэд, олон нийтийг оролцуулахдаа зөвхөн ингээд Сангийн

яамны цахим дээр мэдээлэл тавихаас гадна салбар яамнууд өөрсдөө ерөнхийдөө энэ оролцоог хангадаг юм уу. Яагаад гэвэл энэ өргөн мэдүүлсэн энэ төслийн хуудасны 24 дээр олон нийтэд хэлэлцүүлгийг явуулсан. Гэхдээ санал ирээгүй байна гээд ийм 2 материал байна л даа. Тэгэхээр хэрвээ санал авагдахгүй юм бол яг ингээд авах гэж ингэж бичих ийм зүйл байх хэрэг байдаг юм болов уу. Эсвэл иргэдийг энэ саналд сайн болгохын тулд эсвэл мэргэжилтнүүдийг оролцуулахын тулд ямар нэгэн олон улсын сайн сэдэлжүүлдэг тийм механизм төлөвлөгөөг оруулах боломж байгаа болов уу гэсэн ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Энэ удаа бид төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдэл ярьж байгаа юм шүү. Хүрээний мэдэгдэл өөрөөр хэлбэл батлагдчихсан байгаа 2024 оны төсвийн энэ том 9 ширхэг макро тоонуудын дандаа хязгаар юмнуудыг нь ярьж байгаа. Урсгал зардлын хязгаар, орлогын хязгаар гээд. Тийм учраас тэр хязгаар дотор байгаа төсвийн ерөнхийлөн захирагч нарын салбар салбарын бодлого бол өнөөдөр энд яригдахгүй. Харин удахгүй хэдхэн хоногийн дараа 2025 оны бүтэн төсөв өргөн баригдана. Тэр дотор бол сайд нарын өөр өөрсдийн чиглэлийн нарийн бодлогууд, тэрийг хангах, санхүүжүүлэх төсөв орж ирнэ. Тэр үед энэ талаар дэлгэрэнгүй ярилцана.

Улсын төсөв хууль яригдаад эхлэхээр энийг олон нийтээр санал авах, хэлэлцүүлэх ийм шинэ дэгтэй болсон. Энэ жилээс эхлээд. Тэр горимоороо явна.

Д.Амарбаясгалан: Дараагийн хүн асуулт асууя. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Төсвийн тодотгол, төсвийн хүрээний мэдэгдэл харж байна л даа. Энэ дээр төсвийг 3 их наядаар

тэлээд, төсвийн зарлагыг 30 их наяд болгох. Тэгэхдээ энэ нь төсвийн орлого давж биелсэн учраас гэсэн тайлбартай байх шиг байсан. Тэгэхээр энэ хуудаснуудыг аваад харсан чинь хэд хэдэн тоонууд гараад байна л даа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр өнгөрсөн жил 44 их наядын өрийн хязгаартай байж нэрлэсэн дүнгээрээ. Тэгсэн чинь одоо 47,5 буюу 3 их наядаар өр зээл нэмэгдэх боломжтой болох юм байна. Дахиад энэ төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүн дэх тоог харсан чинь 38,5 гэж байна л даа. Энэ өөрөө ингээд төсвийн зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хэмжээ 38,5. Энэ өөрөө миний мэдэх лав сүүлийн 10 гаруй жилийн хамгийн өндөр, хамгийн өндөр тоо. Төсөв төрийн эдийн засаг дахь оролцоо яг энэ тодотголоор түүхэн хамгийн өндөрт хүрч байгаа юм байна. Тэгээд тэр төрийн албан хаагчийн тоо 250 мянгаас хэд ч болж байгаа юм. Бас түүхэн хамгийн өндөрт л хүрч байгаа байх. Тэгэхлээр эндээс уг нь энэ Ардын Намын мөрийн хөтөлбөрт төрийн оролцоог, төсвийн оролцоог бууруулна. Бүр 25 билүү хувь болгоно гэсний тоо харагдаж байсан. Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт бас юм байдаг. Бодвол ХҮН намын мөрийн хөтөлбөрт бас байдаг байх. Тэгэхээр 3 нам чинь энэ төрийн оролцоогоо, төсвийн оролцоогоо багасгаад, иргэдэд бизнесүүдэд боломж олгоно гэсэн 3 намын мөрийн та нар ингээд төсөв өргөн барихлаараа яагаад ингээд түүхэн, түүхэн хамгийн өндөр төрийн оролцоо өндөртэй ингээд төсөв рүү төсвийн хүрээний мэдэгдэл чинь ингэж орж ирээд байгаа юм бэ. Төсөв маань ингэж орж ирээд байгаа юм бэ. 38,5 гэдэг ийм тоо энд харагдаж байна.

Дахиад тэр төсвийн хүрээний мэдэгдэл дээр 47,5 их наяд Засгийн газрын өрийн хэмжээ болно. Тэгэхдээ авчихсан гэсэн үг биш байх л даа бодвол. Энэ хязгаар нь байх шиг байна. Тэгэхдээ 3 их наядаар өр зээл нэмж болно гэдэг тоо энд харагдаж л байх шиг байх юм. Би буруу, зөв хараад байна уу. Яаж хараад байна.

Гэтэл та нар чинь орлого давж биелсэн гэдэг нэг үг бас хэлээд байдаг. Тэгээд энэ энэ бүгдэд тайлбар өгөөч. Яагаад ингэж өр зээл нь ихээр нэмэгдээд, та нар тэр 60 хувь энэ тэр тоо хэлэх л байх. Тэгэхдээ үүний чинь цаана 38,5 буюу түүхэн хамгийн өндөр төрийн, төсвийн оролцоотой төсвийн төслийг та бүхэн ингээд өргөн барьжээ. Тодотголоор. Энэ бүхэн дээрээ нэг тайлбар өгөөч.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Та ноднин бас яг энэ асуултыг тавьж байсан. Би яг л ижилхэн хариулт өгөх нь дээ. Энэ удаа бол энэ чинь төсвийн хүрээний хязгаар шүү дээ. Хязгаар. Үгүй ээ, тэгээд хязгаар тоогоо хэлэх болохоос энэ чинь гүйцэтгэл биш байхгүй юу. Хязгаар маань 60 хувь. Дотоодын нийт бүтээгдэхүүнээс тооцдог энэ 60 хувь чинь өөрөө дотоодын нийт бүтээгдэхүүн нь тэлэхээр энэ боломж чинь дагаад тэлнэ шүү дээ. Бид 75 их наяд гэж баталсан. 76. Одоо ингээд 79 буюу 3 их наядаар ингээд нэмэгдчихээр чинь тэрийг дагаад нөгөө харьцуулсан тоо чинь нэмэгдэнэ шүү дээ. Тэрнээс энд хүртэл өр ав гэж байгаа, зээл нэмэгдүүл гэж байгаа үг биш. 1 долларын долларын өр авах байсан ч, зээл авах байсан ч Улсын Их Хурал батална. Та шийднэ энд. Тийм учраас өр нэмж байгаа асуудал биш. Харин машинаар бол энэ чинь бид нарын даац нэмэгдээд байна гэсэн үг. Даац нэмэгдэнэ. Монгол Улсын эдийн засгийн даац нэмэгдэж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн нь өсчихсөн юм байна. Зээлдэх чадвар нь нэмэгдэж байгаа юм байна. Зээлдэх хэмжээ нь нэмэгдэж байгаа юм байна гэдэг чинь сайн үзүүлэлт байхгүй юу. Суурь зардал ч гэсэн тэр. Би ноднин танд яг ингэж хариулж байсан. Дотоодын нийт бүтээгдэхүүн тэлэх тусам энэ суурь зардлын хязгаар нь энэ хэмжээнд хэрэглэ гэсэн үг биш, хязгаар нь тэр хэмжээгээрээ ингээд л нэмэгдээд л явна. Боломж нь. Жил ирэх тусам шинэ тоонууд гарч ирнэ. Ийм л юм шүү дээ.

Орлогын хувьд бид сүүлийн 5 жил орлого дээрээ, төлөвлөлт дээрээ огт алдаагүй. Дандаа бид нарын орлого давж биелж байгаа. Давсан хэсгээрээ дандаа зардлаа бууруулаад, алдагдлаа бууруулаад, ингээд маш сайн үр дүнтэй сахилга баттай явж байгаа. Энэ жилийн хувьд 3 их наяд төгрөгөөр давж орлого гарахаар байна. Үүнээс ч гүйцэтгэл илүү ч гарч магадгүй байгаа. Энийг хоёулаа 12 сарын 31-нд ярья. Гэхдээ ямар ч байсан давж орох орлогынхоо хэмжээнд бүтээн байгуулалтуудынхаа суурийг нь, бэлтгэл ажлыг нь энэ ондоо багтаагаад хийгээд авъя л гэж байгаа юм. Энэ Засгийн газар, шинэ Засгийн газар жоохон юм хийгээд авъя. Хугацаа алдмааргүй байна. 1 өдөр ч, 1 сар ч гэсэн маш чухал байгаа юм шүү. Тэгэхээр юуны түрүүнд энэ хагас жилийг ашиглаад, ядаж бэлтгэл ажлуудаа энэ тодотголоор оруулж аваад хийгээд авъя л гэж байгаа юм. Тэрнээс биш энэ цалин нэмээгүй, тэтгэвэр нэмээгүй, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр нэмэгдсэн юм байхгүй, халамж нэмэгдээгүй. Дандаа бүтээн байгуулалтын ийм суурь, бэлтгэл ажлыг хангах ийм зүйлүүд байгаа.

Түрүүн Даваасүрэн сайдын хэлсэн тэр тоонууд дээр жоохон зөрүүтэй тоо хэлчих шиг боллоо. Зүгээр би засаад хэлчихье. Тэр 2022 онд 18,2 их наяд, 2023 онд 22,5 их наяд, 2024 онд 27,4 их наяд гээд, дунджаар 2-3 их наядын хэмжээтэйгээр жил бүр ингээд тэлээд явж байгаа. Тэр таны хэлсэн 11,7 их наяд бол 2019 оны тоо шүү. 2019 оноос хойш дотоодын нийт бүтээгдэхүүн бараг 2,2 дахин нэмэгдчихээд байгаа шүү.

Д.Амарбаясгалан: Цогтгэрэл гишүүн тодруулга авъя.

О.Цогтгэрэл: Та бас л нөгөө гол юмыг нь л хариулж өгөхгүй байгаад байна л даа. Тэр өр зээлийн 60 хувийн тэрийг ингээд тойруулж ярих нэг хэрэг. Яагаад энэ бүгд чинь бүгд өр зээлтэйгээ нийлж байгаад, яагаад энэ бүгд чинь 38,5 буюу түүхэн хамгийн дээд төсвийн хувь процент болчих, хувь процент яриад

байна л даа. Бас энэ 30 их наядын их багын тухай яриа биш. 38,5 буюу хамгийн өндөр төрийн оролцоотой төсөв гэж хэлж болох. Хамгийн өндөр. 1 дүгээрт нь.

2 дугаарт нь дахиад тэр 47 их наядын Засгийн газрын өр дээр ч гэсэн тэр нөгөө нэг юу байдаг биз дээ. Лам юмыг яаж мэдэх вэ гэж боожгойтой төрдөг гэдэг шиг. Үгүй ээ, тэгээд энэ 3 их наядын үнэхээр шаардлагагүй юм бол тэгвэл энэ 3 их наядаар энэ өрийн хязгаараа тэгвэл нэмэхгүй л бай л даа. Давж биелж байгаа бол. Тэрний цаана чинь дахиад 44, 47 их наяд гээд л хязгаар тавьчихсан л байна шүү дээ бас.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Жавхлан сайд 1 минут.

Б.Жавхлан: Үгүй ээ, одоо би ойлгуулж чадахгүй байх шиг байна. Энэ чинь төсвийн хүрээ хязгаар гэдэг чинь өөр ойлголт шүү дээ. Хоёулаа энэ дээр төсөв яриагүй. Хоёулаа төсөв яриагүй. Төсвийн гүйцэтгэл яриагүй. Дотоодын нийт бүтээгдэхүүн чинь өсөж байгаа учраас бүх хязгаарууд чинь энийгээ дагаад хөдөлнө, тэлээд явна. Хойтон ч гэсэн 38-аас давсан тоо гарна. Одоо энд 38 гараад, юуныхаа энэ чинь 79 болчихоод 79-өөс тооцсон хязгаарынхаа дагуу тооцсон дүрмээрээ ингээд энэ тоо чинь гараад ирж байгаа байхгүй юу. Гүйцэтгэл бол заавал 38 гарахгүй шүү дээ. Бага гараад л явна. 36, 37 орчим гараад явах байх. Өмнөх жилүүдтэйгээ харьцуулахад. Энэ хязгаарыг чинь алив дүрмийг нь уншаад өг дөө Санжаа дарга. Ээнэ хуулиар тавьчихсан дүрэм байж байгаа юм. Томьёо байгаа. Тэрүүгээр тооцоод л гараад ирсэн тоо. 79-өөс.

Д.Амарбаясгалан: Ухнаагийн Отгонбаяр гишүүн алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Энэ ер нь нөгөө төсвийн хүрээний мэдэгдэл дээрээс нэг тодруулах асуудал байгаа юм. Яах вэ

нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ бол 30,5 их наяд байх юм байна гэж ойлгож байгаа. 2024 онд болохоор нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ нь болохоор 27 гээд, тэгэхээр ерөнхийдөө ингээд харахаар зөрүү нь 3 их наяд. Тэр зөрөө 3 их наяд нь болохоор одоо бидний яриад байгаа үнэт цаас, гадаад зээл, тусламжийн эх үүсвэр гэж ойлгож болох уу гэдэг ийм асуулт байна.

Ер нь болохоор Монгол Улс эдийн засгаа цаашид өсгөхийн тулд ялангуяа бид нарын өсөлтийг боомилж байгаа дэд бүтцийн бүтээн байгуулалтуудыг явуулах шаардлагатай байгаа. Тэрний тулд энэ тусгай шаардлагуудыг тодорхой хэмжээнд сулруулж байна гэж ойлгож байгаа. Тийм учраас бол ерөнхийд нь бол дэмжиж байгаа. Энэ асуултад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд. Хэн хариулах юм. Хариулт өгөх хүн байна уу. Ажлын хэсгийн гишүүд. Хэн хариулах вэ. Хэд дэх микрофон юм. 5 номерын микрофон өгье. Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Төсвийн хүрээ дээр бол зарлагын дээд хэмжээ 3 их наяд төгрөгөөр бол нэмэгдэж орж ирж байгаа. Үүнээс 1,2 их наяд нь бол урсгал зардал, үлдсэн нь бол хөрөнгө оруулалтын зардлууд байгаа. Урсгал зардлыг тоймлон хэлэх юм бол 4 том зардал байгаа. Нийслэлийн бүтээн байгуулалттай холбоотойгоор Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалттай холбоотойгоор бол 584 тэрбум төгрөг тусгагдсан байгаа. Дээр нь эрчим хүчний шилжилттэй холбоотойгоор 131 тэрбум төгрөг тусгагдсан байгаа. Дээрээс нь мөн гадаад зээл тусламжтай холбоотой хэрэгжүүлэх төслийн нэгжүүдийн урсгал зардал бол 120 орчим тэрбум төгрөг тусгагдсан байгаа. Дээр нь нэмээд малчдын зээл болон хоршооны зээлтэй холбоотойгоор мөн Цагаан алт хөтөлбөрийг хэрэгжүүлэх гээд одоо

уначхаад байгаа Хөдөө аж ахуйн салбараа сэргээхэд шаардлагатай зардал дээр мөн 120 орчим тэрбум төгрөг туссан байгаа. Ингээд урсгал зардал бол болж байгаа. Үлдсэн нь бол хөрөнгийн зардлууд дээр бол улсын төсвөөс санхүүжих сургууль цэцэрлэг гэх мэт жижиг хөрөнгө оруулалтын зардлууд бол огт тусаагүй. Зөвхөн том хөгжлийн хөрөнгө оруулалтын төслүүдийг бол хэрэгжүүлэхээр тусгаж зардал бол туссан байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя.

Х.Баасанжаргал: Би Жавхлан сайдаас асуух гэж байсан. Тэгэхээр сая бол хангалттай Жавхлан сайд нэлээн тайлбар хэллээ. Тэгэхээр энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болоод Үндэсний аудитын газар 2 бас хариулбал зүгээр болов уу гэж бодож байна. Сая бол Жавхлан сайдын хувьд энэ төсвийн тогтвортой байдлын гаргасан дүгнэлт бол нэлээн буруу, үндэслэлгүй, тэгээд тэр дундаа бас нэлээн тийм улс төрийн шинжтэй ийм мэдэгдэл хийлээ. Тэгэхээр төсвийн тогтвортой байдал өөрөө энэ дээр бас хариулт хэлэх нь зөв байх. 1 дүгээрт.

2 дугаарт яг сая хэлсэн Жавхлан сайдын мэдэгдэлтэй холбоотойгоор энэ дүгнэлтэд дахиж өөрчлөлт орох уу гэдэг 2 дахь асуулт.

3 дугаарт ганцхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ийм дүгнэлт хийчхээд байгаа юм уу гэхээр Үндэсний аудитын газрын энэ дүгнэлтийн 2 дугаар хэсэг дээр ч гэсэн мөн адилхан төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахгүй байх нь зүйтэй гэсэн ийм бас дүгнэлтийг биччихсэн байна. Тэгэхээр бас Үндэсний аудитын газар энэ дээр бас ямар байр суурьтай байгаа вэ. Саяын Жавхлан сайдын өгсөн тайлбартай холбоотой гэсэн үг. Тодруулья.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хэн хариулах вэ. Тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албаны дарга Энхбаяр. 8 дугаар микрофон.

Н.Энхбаяр: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд 2024 оны 1 дүгээр сард Улсын Их Хурлаас томилогдсон. Орон тооны гишүүд байгаа. Сонгон шалгаруулалтаар томилогдсон. Бүгдээрээ Улсын Их Хурлаас тавигдсан шаардлагыг хангаад томилогдсон. Миний хувьд 32 жил төрийн албыг хашиж байна. 1995 онд төрийн албаны тангаргаа өргөсөн. Төрийн албаны тангаргаа 1995 онд өргөсөн, төрийн албан хаагч. Бид хуулиараа хараат бусаар дүгнэлтээ гаргах ёстой. Хараат бусаар дүгнэлтээ гаргасан.

Улсын Их Хурлын Тамгын газраас өгсөн чиглэлийн дагуу дүгнэлтээ өнөөдөр унших юм байна гэсэн ойлголттой л явж байгаа. Өчигдрийн Байнгын хороонд орохдоо хүртэл. Унших ёстой дүгнэлтээ энд аваад явж байгаа. Өчигдөр дүгнэлтээ хураангуй байдлаар хэлсэн унш гэж хэлээгүй. Төсвийн байнгын хороо дүгнэлтээ унш гэж хэлээгүй. Байнгын хорооноос бид нарт ямар ч тийм чиглэл өгөөгүй. Улсын Их Хурлын чуулган дээр унш гэж хэлсэн.

Би төрийн албанд 32 жил ажиллахдаа ямар ч өнөөгийн нөхцөлд хэн нь ч улс төрчийн ямар нэг захиалгаар ажиллаж байгаагүй. Хуулиар хүлээсэн үүргийн дагуу л дүгнэлтээ гаргаад л танилцуулж байна. Би өчигдөр санал бодлоо л илэрхийлсэн. Унших гээд уншиж байгаа дүгнэлт маань энд явж байна. Байнгын хорооны зохион байгуулалтын дагуу л бид нар оролцоод л явж байгаа. Бид бүгд хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Таны дурдаад байгаа энэ хуулийн өөрчлөлтийг Улсын Их Хурал өөрөө хуулийнхаа өөрчлөлтийг хариуцдаг. Бид нар энэ хуулийн өөрчлөлтөд ямар ч оролцоогүй. Улсын Их Хурлын Тамгын

газар энэ дээр хариугаа өгөх байх. Тэгэхээр бид хараат бусаар зохих дүгнэлтээ гаргасан гэдгээ л хэлж байна.

Д.Амарбаясгалан: Үндэсний аудитын газар 2 дугаар индрээс Наранчимэг.

Ц.Наранчимэг: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг. Бид энэ төсвийн тодотголд дүгнэлт хийхдээ Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж буй Төсвийн суурь зарлага гэдэг ойлголтыг нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын бүртгэлд бол ямар нэгэн асуудал байхгүй. Энд бол зөрчигдсөн асуудал байхгүй. Тийм учраас бид Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 23 дугаар зүйлийг баримтлахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу тусгай шаардлагыг хангасан байна гэсэн ийм өөрчлөлтийг хүлээж авч, Төрийн аудитын байгууллага дүгнэлтээ гаргасан. Бид нарын өгсөн энэ ерөнхий дүгнэлтэд байгаа 2 дугаар асуудал дээр нэгэнт бид төсөвтөө Засгийн газар маань энэ том реформ шинэчлэлийг хийж, шинэ төсөв өргөн барьж байгаа учраас цаашид гэдэг энэ үгийг оруулж ирж цаашид энэ дунд хугацааны төсвийн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт хариулт өгөх хугацаа дууссан даа. Энэ асуулт дээр. Дараагийн хүний асуулт дээр нэмж хариулах уу. Асуулт Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Асуулт Норовын Алтанхуяг гишүүн алга байна. Асуулт Гонгорын Дамдинням алга байна. Асуулт Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн алга байна. Асуулт Пүрэвжавын Ганзориг гишүүн алга байна. Асуулт Батын Батбаатар гишүүн. Дарааллаараа явна Батбаатар гишүүн ээ.

Б.Батбаатар: 2024 оны төсвийн тодотголын асуудлаас ингээд харахад энэ

хүлээгдэж байгаа гүйцэтгэлээрээ бол дотоодын нийт бүтээгдэхүүний 28,7 хувь гээд явж байгаа. Тэгэхдээ нэгдсэн төсвийнхөө нийт зарлагын 37 хувийг эзэлж байна гээд. Энийгээ уг нь бол жоохон танай цомхон бүтээмжтэй байлгах чиглэлээр анхаармаар юм ишг байгаа юм.

Ардын намын 2024 оны Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрт төсвийн зарлагыг дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувьд барина гэдэг зүйл явж байсан. Ардчилсан намынх дээр төсвийн зардлыг 20 хувиар танана гэж байгаа. ХҮН намынх дээр болохоор тэлэлтийг нь хязгаарлаад, төсвийн алдагдлыг бууруулна гээд. Үүгээрээ бодоод ингээд үзэхээр нийт дотоодын нийт бүтээгдэхүүнтэйгээ ингээд харьцуулаад үзэхээр 20-22 их наядаас дээд тал нь төсвийн зардал чинь хэтэрч болохгүй болчихоод байдаг. Тэгээд нөгөө Засгийн газрын мөрийн хөтөлбөр, 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн тодотгол гээд хамгийн эхний Засгийн газрын хэлэлцээд оруулж ирж байгаа тодотголоороо мөрийн хөтөлбөрөө даваад гараад явчихсан. Уг нь бол 20-22 их наядаар гээд, 22 их наяд гээд, тэгээд 27 их наяд болоод батлахдаа нэмэгдүүлээд төсвийн хүрээний мэдэгдлээсээ давуулаад, одоо бол бүр 30 их наяд дээр хүрээд ирж байгаа шүү дээ. Төсвийн нийт зардал. Энэ асуудал нь ингэж болж байгаа юм уу. Энийгээ нэмээд байж болж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг.

Дараагийнхаа асуудал нь тэр гүүрэн байгууламж 28 тэрбум, Хөшигийн хөндийн туннел 55 тэрбум, тэгээд ТЭЗҮ, зураг төсөл 8 багцад нийлээд 392,6 тэрбум төгрөг тодотголоор оруулж ирж байна. Хэтэрхий их дүнтэй байгаад байгаа юм. Хөшигийн хөндийд Засгийн газрын 1 цэгийн үйлчилгээний цогцолборын барина гээд Хөшигийн хөндийд очиж 1 цэгийн цогцолборын үйлчилгээг өнөөдөртөө одоохондоо цаг хугацааны хувьд түрүүлж авах тийм үйлчлүүлэгч иргэд хэдэн хүн байх юм.

Тэгэхээр нөгөө эрэмбэ дараа аль ажлуудаа эхэлж хийх юм. Эхний хөрөнгө оруулалтаа яаж шийдэх юм гэдэг зүйлүүд чинь яаж явж байгаа юм бэ. Эрэмбийн дараалал нь болж байна уу гээд.

Гадаадын зээл тусламжаар хэрэгжих 11 төсөл, бүтээн байгуулалтад 984 тэрбум төгрөг тусгачихсан байдаг. Бид нарын өр 34 тэрбум доллар давчхаад байгаа шүү дээ. Монгол Улсын. Тэгээд Энэтхэгийн тэр Эксим банкныхаар гэхэд 1 сая 200 хэд байлаа. 1 сая 230 биш ээ, тэрбум 236 сая доллароор газрын тосны үйлдвэр барина гэж. Энэ төслүүд маань юу болж байна вэ. Ажил нь явж өгдөггүй, гарч өгдөггүй. Хэзээ хийгдэх юм. Төсвийн тодотгол оруулахдаа эдийн засгийнхаа энэ гадаад дотоод шокуудаа яаж бодсон юм бэ.

Д.Амарбаясгалан: 1 минут нэмэх юм уу. Нэмэлт нэг минутаа авъя Батын Батбаатар гишүүн.

Б.Батбаатар: Тэгээд энэ 2023 онд төсвийн хүрээний мэдэгдлийг болохоор 20,4 их наядаар түрүүн би хэлж байсан. Тэгээд 2024 оны төсвийн зардлын төсөөлөлдөө 22,4 болгосон. Дараа нь төсвийн хүрээний мэдэгдэл 27,4 их наяд болгосон. Одоо 30,5 их наяд болоод энэ төсвүүдийг ингээд нэмээд яваад байдаг. Дэлхийн 90 гаруй улс орнууд инфляцтай нөхцөл байдалтай, мөнгөний бодлого нь хатуурч байгаа. Манай энэ төсөв яваад ирэхээр чинь Монгол банкны мөнгөний бодлого хатуураад ирэхээр чинь эргээд нөгөө эдийн засгаа тэлэлт, бизнес эрхэлж байгаа иргэд санхүү эх үүсвэр олоход хүндрэлтэй болно. Энийг яаж бодож байгаа юм бэ.

Орлого олноо гэхэд 23 ая их наядыг аж ахуйн нэгж, иргэдээс авах татвар дээрээ тавьчихсан байгаа шүү дээ. 92,9 хувь нь.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Ингээж байна шүү. Тэр бүтээн байгуулалтуудыг бол манай чиглэл чиглэл хариуцсан сайд нар бол илүү сайн ярих ёстой юм байгаа юм. Ямар ч байсан хамтарсан Засгийн газрын хүрээнд энэ томоохон төслүүд гэж эрэмбэлсэн эдгээр зүйлүүдээ бид зөв гэж харж байгаа юм. Зөв гэж харж байгаа.

Та бол төслүүдээс зүгээр тэр нөгөө өмнө төрийн үйлчилгээний 1 цэгийн үйлчилгээ гэдэг бүтээн байгуулалтыг ярьчихлаа. Товчхондоо бол энэ 700-аад дотор манай түгжрэлийн бүх шалтгаан байх шиг байгаа юм. Улаанбаатар хотын энэ дотор. 70 мянган м² төрийн үйлчилгээ үзүүлдэг төв байгууллагууд энэ дотор байна. Улаанбаатар хотын түгжрэл дандаа ийшийгээ тэмүүлж байдаг. Дандаа ийшийгээ тэмүүлж байна. Эндээс үйлчилгээ авдаг, энийг тойрч паркинг хайж түгжирч байдаг. Хамгийн том шалтгаан нь. 70, 80 хувийн шалтгаан нь энэ байна. Гэхдээ эдгээр шилжилт нь 100 хувь түгжрэлийг бас шийдэхгүй. Тэгэхдээ томоохон хэсгийг нь шийднэ гэж харж байгаа. Өөрөөр хэлбэл энэ түгжрэлийг аваад, 15 километрийн цаана, 15 минутын цаана байгаа 700 битгий хэл хэдэн мянган га газар луу энэ түгжрэлийг авч нүүх ийм л том зорилт байгаа юм. Ийм бүтээн байгуулалтуудыг хийгээд явна. Мэдээж энийг дагаад тэнд том Шинэ зуун мод, Аэро сити. Тийм томоохон суурин бүс үүснэ. Энийг дагаад тэнд нийгмийн бүхий л үйлчилгээ, хүн ам амьдрах ийм орчин бүрдэнэ гэж төлөвлөж байгаа.

984 тэрбум төгрөг. Та сая хэллээ шүү дээ. Ингээд л бүтээн байгуулалтад явдаггүй. Одоо яг хэрвээ тийм шүүмжлэл гараад байгаа бол тэрийг чинь л хурдан явуулах гээд байгаа байхгүй юу. Энэ жил 1,2 их наяд гэсэн чинь хагас жилийн дотор бүгдийг нь ажлаа хийгээд дуусчихсан байж байна. Одоо үргэлжлүүлэхийн тулд энийгээ нэмж авч хэрэглэх хэрэгтэй. Тэрнээс биш өрөө нэмэх гээд байгаа юм биш шүү дээ.

Гэрээлчихсэн, эхэлчихсэн зээлээ авч ашиглалтаа нэмэх гээд байгаа. Энэ маань одоо бид заавал төсвөөрөө дамжуулж, ингээж зарлага талдаа бичиж байж явдаг учраас энэ чинь тодотгол хийж, Улсын Их Хурал дээр тайлагнаж, зөвшөөрөл авч батлуулж байж ингээж явдаг юм байгаа юм.

Тодорхой хэмжээний эдийн засгийн өсөлт, тэлэлт бол мөн инфляц дагуулдаг. Дагуулдаг. Харин бодит өсөлт нь инфляцаасаа л доогуур орж болохгүй. Энэ инфляцыг бол тодорхой өсөлтөө өөрөө шингээгээд, тэгээд мөнгөний бодлоготойгоо уялдаад явдаг ийм л одоо хөгжлийн зарчимтай. Сая харин ковидын үед бол манай өсөлтүүд энэ инфляцаасаа хамаагүй хоцорсон. Одоо бол давж эхэлж байгаа. 2023 онд давсан, 2024 онд бид өсөлтөө бид нар 7, 8 гэж 7 хувьд гэж харж байна. Одоо инфляц 5,6 хувь байна. Тэгэхээр яг зөрүүгээрээ эерэг буюу бодит өсөлт рүүгээ бид ороод ирсэн. Тийм учраас тодорхой хэмжээний инфляцын эрсдэлийг бол өсөлтөөрөө шингээгээд аваад явна гэсэн ийм төлөвлөлттэй байна.

Цогтгэрэл гишүүний асуулт дээр нэмж хариулахад тэр 38,5 хувь бол яг хувь хэмжээгээрээ дээд хэмжээ, дээд рекорд хэмжээ бол биш шүү. Абсолют дүнгээр нь харах юм бол өссөн дүн гарч ирнэ. Бид бүр энэ чинь 2016 онд шүү бүр 40 хувь хүрч байсан ч тийм түүх байдаг. Сүүлийн 10 жилийг харах юм бол. Тэгэхээр энийг бас 2 талтай хараарай.

Д.Амарбаясгалан: Төсвийн байнгын хорооны дарга Даваасүрэн гишүүн нэмж хариулт өгнө. 1 минут.

Ц.Даваасүрэн: Би аудит, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн талаар хууль, эрх зүйн талаас нь бас нэг тайлбар өгчих нь зүйтэй юм болов уу гэж бодлоо.

Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шалгуурыг хангасан эсэх талаар Үндэсний

Аудитын газар мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргах ёстой. Дээгийн тухай хуулийн 70.1-д зааснаар мөн энэ дүгнэлтүүдээ төсвийн эхний хэлэлцүүлэг дээр танилцуулах ёстой. Улсын Их Хурал бол төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл аль алинд нь хяналт тавих ёстой. Тэгээд энэ байгууллагууд бол Их хурлын дэргэдэх байгууллагууд. Тийм учраас энэ байгууллагын гарсан дүгнэлтийг тийм байна, ийм байна гээд хоорондоо тэгээд байхгүй, аль болох ойлголцож ажиллаасай гэж би одоо та бүхэнд хэлье.

Би Энхбаярыг сайн мэднэ. Надтай бас олон жил хамт ажиллаж байсан ийм хүн.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмэлт 1 минут. Нэмэлт хариулт өгье.

Б.Жавхлан: Би энэ одоо мөрдөж байгаа хуулиа л яриад байгаа юм шүү. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, аудит ч тэр ер нь төсөв дээр, өргөн барьсан төсөв төсвийн тодотгол дээр бол дүгнэлт уншдаг. Дүгнэлт тараадаг. Одоо бид чинь энд хүрээ ярьж байна шүү дээ. Өчигдөр ч гэсэн Төсвийн байнгын хороо дээр хүрээ ярьсан. Тэр дээр ямар нэг дүгнэлт унших ёсгүй. Дүгнэлт танилцуулах ёсгүй. Дүгнэлт гаргадаг зүйл ч биш. Дээрээс нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөнд би дахиад нэг зүйл хэлье. Улсын Их Хурлыг ингэж доромжилж болохгүй шүү. Та нар Улсын Их Хурлын бүтцийн байгууллага. Одоо байгаа, мөрдөж байгаа хууль дээрээ суурилж та нар дүгнэлт, зөвлөмжөө гаргаж байх ёстой. Гэтэл Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр чинь энэ 6.1.2, 6.1.4 гэдэг энэ 2 заалт чинь байхгүй болчихоод байна. Та нар байгаа юм шиг энэ дээр нь суурилж өчигдөр тийм нэг улс төрийн дүгнэлт уншихна лээ. Энийгээ эргэж хараарай. Бүр байхгүй болчихсон заалт шүү. Тэрийг чинь харин хөндөөд эргэж оруулж ирж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Энэ асуудал бол түрүүнээс хойш нэг шинэ нэр томьёо, категори орж ирсэн гэдэгт л яриад байна. Суурь зарлага гээд. Өмнө нь байгаагүй ийм ойлголт орж ирсэн гээд. Энэ дээр бол энэ орж ирснээр гарах сөрөг үр дагавруудыг маш тодорхой л бичсэн байна л даа. Мэдээж нөгөө бид нарын зориод байгаа хувийн хэвшлийг дэмжих гэдгийн одоо эсрэг болж хувирах гэж байна. Төрийг том болгох гэж байна гэж байна. Тэгээд мэдээж нөгөө төсвийн тусгай шаардлагын дүрэм, журмыг зөрчиж байна гэж байна. Бас нэг нягтлан бодох бүртгэлийн стандартыг зөрчиж байна гээд. Яах вэ, би энэ Төсвийн тогтвортой байдлын дүгнэлтийг л бас нэлээн, нэлээн юу байх вэ уншлаа л даа. Тэгээд энэ дээр бол маш тодорхой тодорхой эрсдэл бөгөөд зөрчлүүдийг тусгасан байна.

Тэгээд мөн сая Жавхлан сайд бас тайлбарлаж л байна л даа. Тэгэхээр энэ ер нь манай Монгол Улс олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг ягштал мөрддөг үү. Эсвэл зүгээр хуульдаа мөрдөнө гээд ингээд оруулж орхихоод мөр бүтэхгүй байгаад байдаг юм уу. Ер нь бол энэ хуулиа тэр чигт нь олон улсын нягтлан бодох бүртгэлийн энэ системийг гэх юм уу тэр чигт нь ингээд авчаж болдоггүй юм уу. Зүгээр нийцүүлнэ гээд орхихоор ингээд нийцүүлэхгүй тохиолдлууд асар их гараад байдаг юм биш үү гэж бодогдлоо. Тэгээд энд яах вэ, мэдээж нөгөө Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор төсөвт тодотгол хийх шаардлагатай гэж үзэж байгаа юм байна. Тэгэхээр ямар нэгэн төсвийн эрсдэлийг бий болгохгүйгээр төсөвт тодотгол хийж болохгүй юм уу. Тэгээд энд бол тодорхой улсуудыг жишээ болгосон байна л даа. Тэгэхээр энэ улсуудын энэ төсөвтөө дарамт учруулахгүй, төсвийн эрсдэл бий болгохгүйгээр тодотгол хийдэг энэ

жишээнүүдийг, загварыг манайхан авч хэрэгжүүлдэг юм уу. Ер нь та энд оруулчихаад байгаа шинэ нэр томъёо бүхий тэр төсвийн суурь зарлага гээд байгаа, энийгээ хаанахын ямар улсын, ямар практикаас авсан юм бол гэж асууж байна.

Тэгээд энэ чинь нэг хяналтын л юм л яригдаад байх шиг байна л даа. Тэгэхээр энэ нөгөө хөрөнгийн зардлаа ер нь яаж хянах юм бол. Хөрөнгийн зардлаа. Энийг чинь ингээд ангид нь тусгай гаргачихаар хяналт байхгүй болчихоод байна гэж эндээс би бол уншиж хараад байна. Тэгэхээр тэрийгээ тэр хөрөнгийн зарлагаа яаж хянах юм бол. Ямар олон улсын практик, ямар улсад яг энийг хэрэглэдэг юм бол. Тэгээд энд дурдсан энэ улсуудын сайн жишээг авч болох байсан эсэх. Мөн олон улсын нягтлан бодох бүртгэлийн дүрэм журмыг ягштал мөрддөг эсэх. Энэ хуульдаа ер нь яаж тусгагдсан байдаг юм бол. Ийм асуултууд байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан, араас нь Төсвийн байнгын хорооны дарга Цэрэнпилийн Даваасүрэн.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Урсгал зардал буюу энэ төрийн үйлчилгээг санхүүжүүлдэг энэ төсвийн зардал бол жил ирэх тусам манай хүн ам тэлж байна, дотоодын нийт бүтээгдэхүүн тэлж байна, төрийн үйлчилгээнүүд бас тэр хэмжээгээр тэлж байгаа шүү дээ. Тэгээд тэрийг санхүүжүүлэхтэй холбоотойгоор урсгал зардал бол нэмэгдэж байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан энэ жилийн тодотголоор оруулж ирж байгаа энэ өсөлт бол 3,1 их наядын 2,5 их наяд буюу 75 хувь нь хөрөнгө оруулалтын зардал л байгаа юм. Хөрөнгө оруулалтын зардал. Өөрөөр хэлбэл нөгөө томоохон бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах болон нийслэл дээр тавигдсан бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлэх зөвшөөрөл өгч байгаа гэсэн үг. Зөвшөөрөл

өгч байгаа гэсэн үг. Тийм учраас энэ урсгал зардал гэж магадгүй олон нийтийн ойлгож байгаа цалин пүнлүү, тэтгэвэр тэтгэмж, халамжийн тийм урсгал зардал бол энэ дотор тусгагдаагүй. Тодотгол дотор гэдгийг хэлье.

Нягтлан бодох бүртгэлийн хувьд бол хувийн сектор, төрийн байгууллагууд бүгд бид олон улсын стандарт руу нэгдээд энэ чинь 20 гаруй жил болж байгаа. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль гэдэг бид тусдаа хуультай. Төрийн чиг үүргээр Засгийн газрын бүтцийн хуулиараа энэ бодлогыг нь Сангийн яам хариуцаж явдаг юм байгаа юм. Тийм учраас энэ удаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийнхөн маань хаанаас ямар захиалга аваад, тэгээд яриад байгаа юм. Нягтлан бодох бүртгэл, төсвийн төлөвлөлт 2 чинь шал 2 өөр асуудал. Бүртгэл, төсөвлөлт 2. Бид нар янз бүрийн эрсдэл тооцохдоо тооцож байгаа аргачлалууд дээрээ ямар ч нэр томъёо хэрэглэж болно. Энэ тухайн улс орнуудын хөгжлийн бас эдийн засгийн ээдрээтэй уналт босолттой сүүлийн 7, 8 жил дотор бид нар чинь маш том сорилт дундуур явж байна шүү дээ. Энэ бүхэн дээр өөр өөрсдийнхөө онцлогт нийцүүлж, өөрсдийнхөө хөгжлийг бас нэг боомилчихгүйхэн шиг бас хамаагүй эрсдэлд орчихгүйхэн шиг ингээд бас хэлэлцэж ярилцаж байгаад манайх чинь парламентын засаглалтай улс. Харин ч эндээ дэлхий нийтийн өмнө ил тод энийгээ яриад, ингээд явж байгаа нь суурь үндсэн зарчмаа бид эвдээгүй л гэж ингэж харж байна.

Тэр хөрөнгийн зардлыг гадуур нь гаргаж тавиад, нягтлан бодох бүртгэлийн тийм суурь зарчим өөрчлөгдөж байгаа юм юу ч байхгүй шүү. Хөрөнгийн зардал гэж ойлгож байгаагаа ингэж ойлгох хэрэгтэй. Зээлийн ашиглалтын зардал. Зээлийн ашиглалтын зардлыг бид нар суурь урсгал зардлаасаа тусдаа авч явъя. Тэгэхгүй нийт хязгаарлалт дотроо ороод бид нар нөгөө бүтээн байгуулалтынхаа ажлуудаа суурь

урсгал зардалтайгаа холиод, нийлүүлж хаяад бүр ингээд түгжчихээд байна. Харин тэр өр нэмэгдэх хязгаарыгаа 60 хувиар нь хязгаарлая. Доороос нь нэрлэсэн үнэ дээр зээлээ тооцож байх ийм сойлт хийе гэж байгаа юм. Ийм хязгааруудаа Улсын Их Хурал манаад сууж байхад Засгийн газрынхаа өрийн асуудлыг бүтэн хяначихна гэж ингэж харж байгаа.

Д.Амарбаясгалан: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн нэмэлт хариулт өгнө.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр ийм зүйл гарсан байгаад байгаа юм. Зүгээр төсвийн хүрээний мэдэгдлийн 2 шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт орсон байгаа. Одоо бид бодитой л ярих ёстой шүү дээ. Та нар Их Хурлын гишүүд Засгийн газар үнэн зөв мэдээлэл өгөх ёстой. Хуулиараа тийм. Тэгэхдээ хөрөнгө оруулалтын тэр дээд хязгаар нь байхгүй болчихсон байгаа болохоос биш тэр хөрөнгө оруулалтыг яасан юм бол байхгүй юм. Өрийн хувьд санаа зовоод байгаа зүйл нь юун дээр үүсээд байна вэ гэвэл тэр суурь зардал гэж юм гаргаж ирээд суурь зардалдаа үнэт цаас, зээлийг тооцохгүй байгаа явдал байхгүй юу. Тэгэхээр энэ дээр л, гэхдээ өрийн шалгуур үзүүлэлт нь байгаа юу байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүн 60 хувиас хэтрэхгүй байна гэдэг нь бол байгаа. Тэгэхээр өр дээр хэчнээн зээл авлаа ч энэ шалгуур үзүүлэлт дээр бол багтана гэж ингэж ойлгож болно. Зүгээр балансын хувьд тэр нягтлан бодох бүртгэлийн хувьд бас олон улсын тэр аргачлал, нягтлан ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүнд нэмэлт 1 минут өгье.

Ц.Даваасүрэн: Ер нь ОУВС энэ чиглэл дээр гарсан бас аргачлалууд бий. Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн. Гапын аргачлалууд байна. Тэгээд тэрний дагуу бид нар төсвөө гаргах ёстой. Төсвийнхөө үзүүлэлтүүдийг гаргах ёстой. Тийм учраас манай төсвийн гаргаж байгаа баланс, энэ төсвийн үзүүлэлтүүд олон улсын аргачлалын бус гэж бас хэлж болохгүй. Яагаад гэвэл энэ яг олон улсын

аргачлалынхаа дагуу явах ёстой. Валютын сангаас жил бүр бүх улс орнуудын төсвийн үзүүлэлтүүдээр бол товхимол гаргаж байдаг. Тэрэнд нь бид нийцсэн мэдээллийг гаргаж өгч байх ийм шаардлагатай.

Д.Амарбаясгалан: Асуулт Хөххүүгийн Болормаа гишүүн алга байна. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя.

Д.Пүрэвдаваа: Их Хурлын гишүүд болон ажлын хэсгийнхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өчигдөр Байнгын хорооны хурал дээр бас техникийн саатал гараад зарим зүйлүүд тодорхойгүй бас асууж амжаагүй. Дээрээс нь энэ Их Хурлын үйл ажиллагаа ирэгдэд ил тод мэдээллийг өгөх үүрэгтэй гэж харж байна.

1 дүгээрт Жавхлан сайдын хувьд бол маш тодорхой байр суурийг илэрхийлж байгаа. Өнгөрсөн сонгуулиар баруун төвийн үзэлтэй 2 нам бол сонгуулийнхаа сурталчилгааны үеэр энэ төсвийг бол аль болохоор цомхон байлгана. Төсвийн тэлэлтийг хязгаарлана гэсэн ийм мөрийн хөтөлбөртэй байсан. Тэгээд Монгол Ардын нам, ХҮН нам, Ардчилсан нам энэ 3 нам нийлээд, гэрээнийхээ нөхцөлийн дагуу 4 жилийн мөрийн хөтөлбөрөө дэвшүүлсэн. 120 их наяд төгрөгийг ирэх 4 жилд зарах юм байна. Тэрнийхээ бэлтгэл ажил болгоод 2024 оны төсвийн тодотголыг өргөн барьж байна. Бас холбогдох энэ хуульд өөрчлөлт оруулж байгаа юм байна гэж ойлгож байгаа юм. Тэгээд эндээс өнөөдрийн энэ Их Хурлын уур амьсгалыг харахаар энэ гэрээ байгуулж хамтарч ажиллаж байгаа Ардчилсан нам болон ХҮН намын зарим хүмүүс нь энэ өргөн барьж байгаа хуулийнхаа төсөлтэй бас санал нийцэхгүй байгаа юм байна гэж ойлгогдож байна. Тэгэхээр энэ ажлын хэсгийнхнээс хэд хэдэн зүйлүүдийг асуумаар байгаа юм. Өргөн баригдсан төслүүд дээр аудит хийлгэсэн юм уу. Энэ онд хэрэгжих 9 төсөл байна. Нийт 149 төсөл гэж байгаа

юм. Үндэсний аудитын газраас хэзээ аудит хийсэн юм. Хэрхэн хийсэн юм гэдгийг тодруулмаар байна.

Тэгээд инфляц бодож байгаа. Дээрээс нь дотоодын нийт бүтээгдэхүүнийг маш өөдрөгөөр харж байгаа. Дотоодын нийт бүтээгдэхүүний дийлэнх хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлдэг. Баялаг бүтээж байгаа, ажлын байр бүтээж байгаа, татвар төлдөг энэ цөөхөн аж ахуйн нэгжүүдээ хэрхэн дэмжих бодлого энд тусгагдсан бэ гэдгийг бас тодорхой асуумаар байна.

Тэгээд өнгөрсөн энэ хугацаанд ковидын хүнд хэцүү цаг үеийг ер нь бол татвар төлөгчдийн татварыг төлөхийг нь хойшлуулсан болохоос биш хөнгөлөлт бол эдлүүлээгүй. Тэгэхээр энэ дээр санхүүгийн болон эдийн засгийн өгөөжийг яаж тооцсон бэ гэдгийг асуумаар байна. Нэмэлт нэг минутаа авчихъя дарга аа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут.

Д.Пүрэвдаваа: Тэгээд Ардчилсан намаас гээд хяналтын сайд хүртэл томилогдсон байгаа шүү дээ. Тэгээд хяналтын сайд энэ жишээгээр энэ төсвийн тодотгол дээр ямар явцын хяналтыг яаж тавих юм бэ. Тэр үйл явцын талаар огт мэдээлэл байхгүй байна. Тэгээд хэрэглээний, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн бол үнийн өсөлт маш өндөр байгаа. Гэтэл төсөөллөө бол бид нар 6,5 их өөдрөгөөр харсан байгаа. Иргэддээ бид нар ямар учраас энэ үнийн өсөлтийг хэвийн байдалтай байна гэдэг тайлбарыгаа бас зөв өгөх ёстой юм болов уу гэдгийг бас асуумаар байна.

Тэгээд энэ бодсон аргачлалыг Улсын Их Хурлын гишүүний хувиар энэ бодсон аргачлалуудыг цаасан хэлбэрээр авч болох уу гэж асуумаар байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үндэсний Аудитын газраас Ерөнхий аудиторын

орлогч Самбууням хариулах уу. 4 номерын микрофон.

Я.Самбууням: Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Самбууням байна. Гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагаас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд дүгнэлт гаргаж, дараагийн хэлэлцэх асуудал дээр танилцуулна. Энэ удаад бол төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид тухайлсан дүгнэлт гаргаагүй. Энэ төсвийн тухай хуульд орж байгаа өөрчлөлттэй холбогдуулсан хөрөнгө оруулалт дээр тавигдсан 14 төсөл арга хэмжээг Улсын Их Хуралд төсөв нь өргөн баригдсан тохиолдолд бид төсвийн шаардлагыг хангасан эсэхэд нь аудит хийж, дүгнэлт гаргадаг ийм эрх зүйн зохицуулалттай байгаа. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: 2 дахь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх чиг үүргээ хариуцаж Одбаяр сайдаас асуух шиг болсон. Пүрэвдаваа гишүүн Одбаяр сайдын хариуцаж байгаа чиг үүрэг санхүүгийн хяналт шалгалтын чиг үүрэг огт хариуцахгүй. Засгийн газраас өгөгдсөн үүрэг даалгавар, түүний хэрэгжилт гэдэг чиглэл дээрээ хяналт шалгалтын чиг үүргийг хүлээж, хуулиар хүлээж ажиллаж байгаа. Тийм учраас энэ дээр хариулах боломжгүй байна. Төрийн аудитын байгууллага санхүүгийн үйл ажиллагаанд бүрэн хяналт тавьж, дүгнэлт гаргах эрх үүрэгтэй байгаа. И

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргал асуултаа асууя. Микрофон нээж өгнө үү. Та суудлаа солиод сольчихсон юм шиг байх юм. Цаад талын чинь микрофон асаад байна.

Ж.Золжаргал: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаж байгаа нөгөө томоохон төслүүд ер нь шинэ зүйлүүд биш бас олон жил хүлээгдчихсэн, хэрэгжүүлэх шаардлагатай гэдэг дээр бол ерөнхийдөө

дэмжиж байгаа. Гэхдээ үүнийгээ хэрэгжүүлэхдээ яаж санхүүжүүлж яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр нь асуудал байгаад байна л даа. Эрх зүйн орчин, татварын орчноо сайжруулаад, нөгөө хөрөнгө оруулалтыг дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг татдаг. Татах замаар үүнийгээ хийх. Үгүй бол төсвийнхөө зарлагыг нэмээд хийх. Энэ төсвийн зарлага нэмэх рүүгээ илүү хандлага нь тэгж явж харагдаад байна. Уг нь бол бид нар чинь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, бизнесийг дэмжих гэж яриад байгаа шүү дээ. Тэгээд үүнтэй холбоотой зардал нь хүрэхгүй болохоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тэр тусгай шаардлагын 2 хязгаарынх нь 1-ийг нь байхгүй болгож байгаад, сулруулж байгаад, тэгээд 60 хувь дээрээ л ер нь барина гэсэн тийм хандлага харагдаж байгаа юм. Надад бол тэгж харагдаад байна. Яагаад ингэж бодож байна гэхээр энэ 6 сарын 5-нд хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 2 хувь, нөгөө алдагдлын 2 хувиас илүүгүй. 6.1.2-ыг 2025 он хүртэл хүчинтэй, нөгөөх нь 60 хувь гэдгийг болохоор 2025 оноос хойш үйлчилнэ гээд ингээд хуваачихсан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл 2025 оноос хойш энэ өөрчлөлтөөр бол зөвхөн 60 хувь нь үлдэх юм байна. Одоогийн энэ санал дээр -2-ыг +2 гэж болгоод, гэхдээ нөгөө зээлийн зардлыг нь хасаж байгаад, ингээд чангалж байгаа юм шиг мөртөө хөнгөвчилчихсэн харагдаж орж ирээд, тэгээд энийг ингэж хэлэлцэж байгаад өөрчиллөө гэхэд 6.1.2-ыг өөрчилчихлөө гэхэд нөгөө 6.4 нь буюу үйлчлэх хугацаа нь 2025 оны төсвийн жил хүртэл гэдэг нь үлдчихэж байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь 2025 оноос хойш зөвхөн 60 хувь нь л үлдэнэ гэсэн үг болоод байна шүү дээ. Тэгэхээр ер нь бол санаа нь бол тэр +/-2-ыг угаасаа байхгүй болгочихъё гэсэн санаатай яваад байгаа юм байна. Зөвхөн 60 дээрээ байгаа юм байна гэсэн санаа уншигдаж байна. Энэ зөв үү.

Тэгээд үүнтэй холбоотойгоор хэрвээ энэ Төсвийн тогтвортой байдлын

тухай хуульд бас нэлээн серъёзны үр дагавартай зүйл болох байх. Төслийн сахилга батын хувьд бол. Тэгэхээр үүнийг ярьж байгаа бол заавал энэ 2024 оны тодотголтой хамт ярих шаардлага байсан юм болов уу. Энэ 25 оныхоо төсөвтэй хамт яривал яасан юм бэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Эхлээд Болдын Жавхлан Сангийн сайд хариулт хийе Дараа нь Цэрэнпилийн Даваасүрэн Байнгын хорооны дарга хийе. Хуулийн тайлбарыг Их Хурлын Тамгын газраас хийнэ.

Б.Жавхлан: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Та их зөв, нюанстай их нарийн сайн харсан байна. Ер нь яг наад асуудал чинь л болчихоод байгаа байхгүй юу. Одоо өөрөөр хэлбэл Засгийн газар энэ төсөв юмаа хариуцдаг Сангийн сайд нь төрийн төв хэвлэл дээр гарч ирэхэд л ийм айхтар юм болчихсоныг олж мэдлээ. Энэ бол маш ноцтой асуудал байхгүй юу. Одоо надад байна уу, хаана байгаа юм бүү мэд. 6 сарын 5-нд нэлээн олон хуулиуд батлагдсан л даа. Тэгэхдээ Төсвийн байнгын хорооны дарга өөрөө санаачлаад, бариад явсан энэ батлуулсан хуулийг Засгийн газраас санал авахдаа яг энэ заалт нь байгаагүй байхгүй юу. Байгаагүй юм. Байсан бүх заалтууд нь боломжгүй. Дэмжих боломжгүй гээд Засгийн газраас албан ёсоор 4 сарын 23-нд хариугаа өгчихсөн юм. Тэгээд бид нар санаа амар байж байсан. Гэтэл сая ингээд харсан чинь ийм заалт орж ирээд батлагдчихсан. Ингээд Монгол Улс 2025 оны 1 сарын 1-ээс төсвийн алдагдлын хязгаар байхгүй болчихсон. Яг өнөөдөр бид нар 60 хувь гэдэг өрийн хязгааргүй болчихсон явж байгаа. Ийм айхавтар юм болчихсон байна л даа. Тэгээд энийг засах гээд л энэ төсвийн тодотголыг бид ер нь өргөн барьж байна. Тэгээд 6.1.2-ыг бол шинэ аргачлалаар буцааж сэргээж оруулж ирж байна. 6.1.4-ийг бол хөндсөн байгаа. Өнөөгийн үнэ цэнээр биш, нэрлэсэн үнэ цэнээр тооцно гэдгийг хөндсөн, оруулж ирж байгаа. Гэхдээ

Улсын Их Хурлын баталчихсан тэр хугацаануудыг бол бид нар хөндөх арга эрх байхгүй Засгийн газрын хувьд. Тийм учраас энийг Улсын Их Хурал санаачлаад, бид бүхэн ямар бүтцээр, яаж явах ёстой юм. Одоо хуулийн дүгнэлтийг нь сонсьё. Энийг яаралтай бид нар энийг янзалж, өөрчлөхгүй бол яг энэ хуулиар бол бид ер нь маш хүнд нөхцөл байдалд орно шүү. Бид нар 2025 оныхоо төсвийг ч бид нар хийж чадахгүй. Маш тодорхой тодорхойгүй байдал үүснэ. Одоо ингээд бид чинь дэлхий нийтэд ил тод энийгээ ярьж байна шүү дээ. Одоо ингээд маргаашаас зээлжих зээл тогтоодог агентууд орж ирнэ. Бид нараас асууна. Юу болчихсон бэ та нар гээд. ОУВС-аас өнөө шөнөдөө бараг и-мэйл ирэх байх. Тэгэхээр энийгээ яах вэ, алдаж болно. Тэгэхдээ засаж бас болно шүү дээ. Тийм учраас энийгээ бушуухан засаад, ингээд бид төсвийн тусгай шаардлагуудыгаа буцааж сэргээгээд ингээд цаашаа явах нь зүйтэй. Би нэлээн ойлгомжтой хариулт өгсөн болов уу гэж ингэж ойлгож байна. Тэгэхээр 2 заалтыг байхгүй болгох гээд, 1-ийг нь байхгүй болгох гээд байгаа юм биш. Ер нь 2 заалт маань өөрөө бараг байхгүй болчихоод байгаа байхгүй юу. Бид нар тийм хууль дээр одоо ажиллаад байна гэсэн үг. Энийгээ буцааж сэргээж оруулж ирж байна гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Нэмэлт асуулт. Золжаргал гишүүнд нэмэлт 1 минут.

Ж.Золжаргал: Тэгэхээр нөгөө -2-ыг +2 болгоод, суурь зардал гэдэг шинэ томъёолол болгож орж ирсэн ч гэсэндээ хязгаарлалт ингээд орчихлоо гэж бодоход нөгөө 6.4 чинь 2025 он хүртэл гээд заачихсан байгаа шүү дээ. Тэгэхээр хэрвээ бид нар энийгээ хүлээж авна гэх юм бол 6.4-ийн тэр заалтыг хүчингүй болгох хуулийн төсөл дээр орж ирэх ёстой гэсэн үг. Одоо бол орж ирээгүй байгаа. Зөв ойлгож байна уу. Тэгэхээр энийг бид нар залруулах шаардлагатай л гэж болж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Даваасүрэн гишүүн нэмэлт хариулт.

Ц.Даваасүрэн: Тэр төсвийн алдагдлын хязгаар тэдээс дээшээ байх болов уу гэсэн заалтыг тэр яг энэ сонгуулийн өмнөхөн өөрчилсөн ийм асуудал бол байгаа юм шиг байна лээ. Тийм учраас энэ асуудлыг бид бас ажлын хэсэг дээр ярихдаа хууль хоорондын зөрчил байдлаар бас авч үзнэ. Ийм зүйл байх шиг байна. Ер нь зүгээр энэ Тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг хууль бус гэж үзэж болохгүй. Яагаад гэвэл Тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулчихсан байгаа учраас эд нар дүгнэлт оруулж ирсэн. Тийм учраас би тэр дүгнэлтийг нь Байнгын хороо дээр сонсох бүрэн эрхтэй. Байнгын хороо ийм эрхтэй. Тэгээд ч өнөөдөр энэ гишүүд Тогтвортой байдлын тухай хууль, төсвийн хүрээний мэдэгдлийг дагаж өргөн баригдаад өөрчлөөд ороод ирсэн учраас гишүүд ч энийг сонсох эрхтэй. Яагаад гэвэл тэр хуулийг хөндчихсэн байгаа учраас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2-оор эд нар энэ асуудлыг оруулж ирэх эрхтэй.

Д.Амарбаясгалан: Хариултын хугацаа дуусчихсан даа. Дэг нэг үйлчлэхгүй бол болохгүй. Дараагийн асуулт дээр. Тамгын газраас саяын хуулийн заалттай холбоотой асуудал дээр тайлбар хийх үү. Ерөнхий нарийн бичгийн дарга Баасандорж.

Б.Баасандорж: Баасандорж асуултад хариулъя. Ер нь Тамгын газраас Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зааснаар анхдагч хууль болон бие даасан хууль дээр эрх зүйн дүгнэлт гаргаж, Байнгын хорооны түвшинд танилцуулдаг хуультай. Яг чуулганы нэгдсэн хуралдаанаар орсон, одоо яригдаж байгаа асуудал дээр яг Дэгийн хууль болон Их Хурлын тухай хуулиар ямар нэгэн дүгнэлт танилцуулах зохицуулалт бол байхгүй. Гэхдээ саяын гишүүдийн ярьж байгаа зүйл дээр бол энэ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн өөрчлөлтөөр 6.1.2-ыг бол хөндөж орж ирсэн. Тэгэхээр энийг сая Даваасүрэн даргын хэлснээр ажлын хэсгийн түвшинд, Байнгын хорооны түвшинд яриад үнэхээр хууль хоорондын зөрчил байгаа бол 6.4-ийг хөндөх асуудал бол яригдаж болно. Ажлын хэсэг, Байнгын хорооны түвшинд.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Асуух гэж байсан асуултыг түрүүн бас хариулчихлаа. Дээрээс нь нэмээд тодотгоод 1 зүйлийг бас хэлье гэж бодож байна.

Худалдан авах үйл ажиллагааны газрын тухай хууль дагаж байгаа хуульд энэ тендертэй холбоотой, маргаантай холбоотой сунжирсан байдлаас болоод төсвийн өөрийнх нь зарлага маш их нэмэгддэг юм байна лээ. Жил, хэдэн жил дараалаад шүүхдчихдэг. Арай гэж нэг юм шийдэхээр тэр анхных нь төсөвт өртөг нь хэд дахин бараг ингээд өсчихдөг энэ хугацаанд. Тийм учраас бол энэ дээр бас засаж залруулж орж ирж байна. Гэхдээ тодорхой шаардлага хангасан бэлтгэн нийлүүлэгчийг шууд бараа үйлчилгээг нь сонгож, санал хүргүүлж болно гэж байгаа. Тэгэхээр яг тэр шаардлагад нийцсэн гэдэг үзүүлэлтийг яг хуулиар яаж тогтоож өгөх вэ. Дагасан журмаар шийдэх юм уу гэдгийг бол тодруулж асуумаар байна.

Дээрээс нь бас олон хүн бас сонирхож байсан нэг асуулт. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 22.9.7.өөрийн ажилтнаас бусад оюутнуудад дэмжлэг үзүүлсэн бол татвар ноогдох орлогоос хөнгөлнө гээд тавьчихсан. Түрүүн яах вэ Төсвийн байнгын хороон дээр Жавхлан сайд хэлж байсан. 9 сарын 1-нд дахиад энэ аж ахуйн нэгж, байгууллагуудын орлогын албан татварын хөнгөлөлтүүдийн асуудлыг нэг мөр оруулж ирнэ гэж хэлсэн. Тэгээд энэ асуудлуудыг яах вэ дараа оруулж ирнэ

гэвэл энэ асуудлууд бас яригдах уу гэдэг энэ 2 асуултыг л асууя.

Д.Амарбаясгалан: Хэн хариулах вэ. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тэр юу шүү. Тухайн аж ахуйн нэгж өөрийнхөө ажилтнуудын нийгмийн асуудлуудыг ишидсэний төлөө татварын хөнгөлөлт авах бол хэт хавтгайрсан, арай хэтэрсэн юм болно. Яг нийгэм рүү чиглэсэн, өөрийнхөө ажилтнаасаа гадуур яг төрөөс ачааллыг нь хуваалцаад, тэнд СӨБ-ын чиглэлийн ч СӨБ ч бай, ЕБС ч бай, эсвэл гадаадын их дээд сургууль, хэлний сургууль ч байдаг юм уу иймэрхүү сургалтын хөтөлбөрт хамрагдуулаад туслаад явж байвал тэрийг нь татвар ноогдуулах орлогоос нь хасаж тооцдог ч юм уу иймэрхүү байдлаар дэмжлэг үзүүлье, урамшуулъя гэдэг ийм л санаа юм байгаа юм. Тэрийг бас хэдүүлээ хэт хавтгайруулж бас болохгүй. Нямбаатар сайд хариулах уу. Манайхаас хариулах юм уу. Тэр худалдан авах ажиллагаатай холбоотой юмыг.

Дээрээс нь тэгээд би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд хандаж бас нэг юм хэлье. Би бас Их хурлын гишүүн. Энэ эрхээ эдлэх үүрэгтэй. Улсын Их Хурал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл бас мэдээлэл, зөвлөмжийг гаргаж байх үүрэгтэй гэж би ингэж ойлгож байгаа. Тэгвэл 6 сарын 5-нд ийм айхтар өөрчлөлт орчихжээ. 6.4. Та 2 бол энийг маш сайн мэдэж байгаа. Цуг өөрчлөлтийг нь бараг хийж өгсөн байх. Энэ дээрээ дүгнэлт гаргаж өгөөч. Ингээд нөгөө тусгай шаардлагын 4-ийн чинь бүр 2 нь, 1 нь одоо байхгүй болчихсон. 1 нь удахгүй 1 сарын 1-ээс байхгүй болох гэж байна. Байхгүй болчихсон энэ юмнууд дээрээ та 2 дүгнэлт гаргаж, мэдээлэл зөвлөмж .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа. Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн

нэрсийн дарааллын дагуу Улсын Их Хурлын гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж, үг хэлнэ. Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх зөвшөөрлийг олгоно. Нэрсээ оруулъя. Саруулсайханы Цэнгүүн гишүүн үг хэлнэ. Индрээс үг хэлнэ. 2 дугаар индрээс.

С.Цэнгүүн: Тэгэхээр бүгдэд нь оройн мэнд хүргэе. Сая яригдаж байгаа энэ төсвийн мэдүүлгийн тухай асуудал дээр бид нар нэг зүйлийг харах хэрэгтэй байгаад байгаа юм. Баруун төвийн 2 нам бол энэ Засгийн газарт орж ажиллаж байгаа. Тэгэхээр баруун төвийн намууд орсон зүйл дээр 1 зүйлийг хармаар байгаа нь 2024 оны төсөвт тусгахдаа бол 1233 төсөл, арга хэмжээнээс бол ингээд дурдчихсан байгаа юм. Тэгэхээр энэ олон төсөл, арга хэмжээнүүдээс бид нар ердөө 97 төсөл, арга хэмжээг царцаагаад, тэгээд харахад 927 тэрбум төгрөг хэмнэгдэх боломж бас бид нарт харагдаж байна. Тэгэхээр энэ их дүнгээр бид нар Засгийн газраас зайлиггүй нэн шаардлагатай хэрэгжүүлэх боломжтой гээд байгаа 14 төслөө хүртэл санхүүжүүлэх боломж харагдаж байна.

Тэгэхээр эндээс хараад үзэхээр үнэхээр манай энэ төсөв дээр бол хэмнэх боломжтой маш олон зүйлүүд харагдаад байгаа юм. Тэгээд энэ зүйлүүдийг заавал 3 их наядаар нэмэгдүүлж орохоос илүүтэйгээр бид нар энэ төсөв дээрээ хэмнэлтийг хийж дахин ярилцах шаардлагатай гэж үзэж байна. Тэгээд би Ардчилсан намаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний хувьд энэ дээр бол дэмжихгүй гэдэг саналтайгаа илэрхийлье.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн 1 дүгээр индрээс үг хэлье. Байна уу. Алга байна. Батын Батбаатар гишүүн 2 дугаар индрээс үг хэлье.

Б.Батбаатар: Энэ индэр эд нар чинь ер нь зөв юм уу даа. Ингээд тойрч явж байх нь. Төсөв хэлэлцэхдээ бид нар сая нэлээн ярилаа. Олон асуудлууд байж байна гэж байна. Сая протоколд ороогүй

Сангийн сайдаас энэ төсөв батлагдвал, төсвийн тодотгол батлагдвал Монголбанкны мөнгөний бодлого хатуурах уу гэж асуусан. Хатуурахгүй гэж хэлж чадах уу гэсэн хатуурахгүй л гэж байна лээ. Протоколд ороогүй үг учраас би зүгээр өөрөө оруулах гээд энд хэлчихлээ. Яах вэ, засаж болно. Тэгэхээр үгүй ээ, үгүй сая зүгээр олны дунд л ярьсан шүү дээ. Бүгдээрээ л сонсож байсан. Тэгээд энэ бол юу гэхээр Монгол банкны мөнгөний бодлого хатуурна гэдэг эдийн засагт мөнгө олдохоо болино гэсэн үг. Бизнес эрхлэгчид, иргэд, аж ахуй эрхлэгчид, ард иргэдэд мөнгө олдохгүй байна гэдэг чинь өөрөө ядуурал руугаа өндөр хүүтэй мөнгөний дарамтад орно гэсэн үг. Энэ тухай бол бид нар бодох ёстой болж байгаа. Тэгээд одоо энэ эдийн засгийнхаа гадаад болон дотоод орчны шок, энэ дэлхийн олон улс орон инфляцтай байгаа, мөнгөний бодлого нь хатуурч байгаа энэ нөхцөл байдалд бид нар энэ төсвийнхөө тэлэлтийг жоохон хямгадаж өгөхгүй бол болохгүй. Төсвийн хөрөнгө оруулалт нь үр ашигтай орлого олдог, тэр хөрөнгө оруулалт нь төсвийг тэлдэг үр ашгийг дотоодын нийт бүтээгдэхүүнийг тэлдэг тэр чиглэл рүүгээ анхаарах ёстой. Мөнгө санхүүгийнхээ энэ залгамж байдлуудаа бид нар бас цаашид бодох хэрэгтэй. Энэ жил бол төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл тэгээд, төсөв батлах явцад бол хэд хэдэн их наядаар нэмэгдсээр байгаад, 5 их наядаар өмнө нь нэмэгдсэн төсөв батлагдахад. Одоо ингээд тодотгол хийхэд дахиад нэмэгдээд ингээд 7, 8 их наядаар нийт дүндээ анхны төсөөллөөсөө 2 жилийн өмнөх төсөөллөөсөө нэмэгдэж ингэж батлагдаж байна. Энэ бол бид нарт дахиад асуудал үүсгэнэ.

Манай Иргэний Зориг Ногоон нам бол энэ төсвийн зардал, төсвийн бүтэц бол 1 дүгээрт үр ашигтай хөрөнгө оруулалт нь эргээд орлого бий болгодог хөрөнгө оруулалт. 2 дугаарт нь дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт иргэдэд наалддаг, амьдралын чанар хүртээмжийг

сайжруулдаг тэр тойргийн эдийн засаг гэдэг ийм байдлаар хийгдэх хэрэгтэй гэж үзэж байгаа. Тийм болохоор энэ төсвийн хүрээний тодотгол дээр хэлэлцэж байгаатай холбогдуулаад энэхүү зүйлүүдийг гишүүдийг бас анхаарч өгөөсэй гэж хүсэж байна.

Цаашид ер нь энэ төсвийн төсвийг батлах, төсвийг төсөвлөх хугацаанд бол хөндлөнгийн аудит, аудитын байгууллага болон Их Хурлын гишүүдийн оролцоотойгоор Сангийн яам дээр энэ явцын хяналт хийдэг. Төсөв хэрхэн боож, хэрхэн тэр төсвийн төсөөллөө оруулж ирж байгаа юм гэдэг дээр нь ажилладаг ийм байдалтайгаа явахгүй бол бид нар нөгөө цаг нь тулсан мэдээлэл дээр төсөв хэлэлцэж баталдаг бол өөрөө тийм сайн арга биш болчихоод байна гэж дүгнэж байна.

Д.Амарбаясгалан: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн индрээс үг хэлнэ.

Д.Пүрэвдаваа: Их Хурлын гишүүд та бүхэндээ анхаарал хандуулахыг хүсье. 1 дүгээрт яаралтай горимоор гэдэг ийм мэдээллийн дагуу мэдээллийг маш тулгаж өгсөн. Ялангуяа 4 жилийн мөрийн хөтөлбөр, дээрээс нь үүнтэй уялдуулаад төсвийн тодотгол, тэгээд төсвийн тодотголттой уялдуулаад дагалдах энэ хуулийн өөрчлөлтүүдийг зайлигүй хийх нь зүйтэй ю гэдэг тэр мэдээллийг бол 2 хоногийн өмнө авсан. Үндэсний эвслээс төлөөлөөд миний бие хэд хэдэн зүйл дээр байр сууриа илэрхийлье.

1 дүгээрт энэ тараасан бичиг баримт дээр нь бол нэг харахаар Шинэ 30 жил эхэлж байгаа. Шинэ 30 жилийн эхлэл учраас энэ ирэх 4 жилийг бид нар өөдрөгөөр харж байна гэдэг ийм үг үсэг бол энэ ажлын хэсгийн мэдээлэл дээр маш их байсан. Тэгэхээр 1 дүгээрт энэ 3 нам нийлээд гэрээ байгуулаад, тэр гэрээний үндсэн дээр энэ бүх өөрчлөлтийг хийж байгаа гэдэг тайлбарыг бол тавьсан. Тэгэхээр гишүүний хувиар тодруулж асуухад ердөөсөө тодорхой хариулт авч

чадахгүй байгаа юм. 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх 149 төсөл хөтөлбөр байна. 120 их наяд. Тэрний бэлтгэл ажлыг энэ 3 намын төлөөлөл нийлж байгаад өнөөдөр хуульдаа өөрчлөлт оруулах энэ үйл ажиллагааг явуулж байгаа юм байна гэж ойлголоо.

Дараагийнх нь зүйл юу вэ гэхээр зэрэг дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ эзлэх хувийг тодорхой бас өгсөнгүй. Жишээгээр, уул уурхайн бүтээгдэхүүн бол дийлэнх хувийг нь эзэлдэг. Тэгээд бусад энэ татвар төлөгч, ажлын байр бий болгодог аж ахуйн нэгжүүдээ дэмжсэн бодлого, дээрээс нь төрийн хэмнэлтийн бодлого хэрхэн яаж уялдсан юм бэ. Тэр дээр яаж аудит хийгдсэн юм бэ гэдэг дээр бол мэдээлэл авч чадсангүй.

Тэгээд хамгийн сүүлд нь олонхоороо бол батлах юм шиг байна. Энэ 118 Улсын Их Хурлын гишүүд нэг талдаа ингээд хамтарсан бүх энэ сонгуулийн хугацаанд санал болгосон мөрийн хөтөлбөрөө нийлүүлээд, энэ мөрийн хөтөлбөрийг ингээд өргөн барьж байгаа юм байна. Тэгэхээр зэрэг Иргэний Зориг ногоон нам болон Үндэсний эвсэл бол сөрөг хүчний үүргийг гүйцэтгэх ёстой. Гэтэл Төсвийн байнгын хороо дээр хүртэл Зардлын хяналтын дэд хорооны асуудал гэхэд Ардчилсан намаас төсвийн захирагч талаасаа томилохоор зохион байгуулалтыг хийж байгаад бол хувь гишүүний хувиар харамсаж байгаагаа илэрхийлмээр байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Улсын Их Хурлын гишүүдийг чуулганы танхимд цуглуулъя. Санал хураалт явагдана.

Байнгын хорооны саналаар, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт эхлүүлье. Санал хураалтын төхөөрөмж дугарсангүй. Саналыг хүчингүй болгоё. Дахин санал хураалт эхлүүлье. Төхөөрөмжөө шалгаад. Бэлэн болсон уу. Эхлүүлэх үү. Санал хураалтыг эхлүүлье. Санал хураалтын дүн. 52 гишүүн дэмжиж, санал өгсөн буюу 46,8 хувиар унасан байна. Хэрлэн гишүүн, Аюушийн Ариунзаяа гишүүн гар өргөж байна. Хэрлэн гишүүний микрофоныг өгье. Анар гишүүн горимын санал гаргах юм байна. Микрофон өгье. Анар гишүүний микрофон. Дарахгүй байж байя.

Ч.Анар: Горимын санал гаргая. Миний санал татгалзсанаар орчихсон байна. Төхөөрөмж ажиллаагүйн улмаас дахин санал хураалт явуулах хүсэлтийг Их Хурлын даргад гаргаж байна.

Д.Амарбаясгалан: Анар гишүүний гаргасан горимын саналаар, саналаа дэмжсэнээр өгсөн боловч эсрэг гарсан учраас саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргасан байна. Горимын саналаар санал хураалт явуулъя. Хүчингүй болгох саналын хураалт.

Алдаржавхлан гишүүн сая саналаа өгсөн юм уу. Төхөөрөмжтэйгөө харьцаж сурмаар байна хэдүүлээ. 15 секундийн хугацаа өгч байгаа шүү дээ уг нь. Наад төхөөрөмжтэйгөө зөв харьцаад сурчих. Алдаржавхлан гишүүн горимын санал гаргая.

Ж.Алдаржавхлан: Би төхөөрөмж дээр хуруугаа дарсан боловч ажилласангүй. Тийм учраас дахин санал хураалгаж өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Амарбаясгалан: Энэ гишүүдийн хурууны хээ уних төхөөрөмж маань бас жоохон доголдол гарсан учраас санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулах горимын санал гарсан.

Тэгэхээр өмнө явуулсан санал хураалтыг хүчингүй болгоё гэж санал хураалтыг эхлүүлье. Энэ санал хураалтыг цуцлаад, шинээр санал хураалт явуулъя. Хонх дуугарахгүй байна. Түр пауз авч байгаад яахгүй бол энэ төхөөрөмж нь ингээд олон давтаж ачаалаад бас гацаад унадаг юм байна лээ. Тэгэхээр энэ санал хураалт цуцлагдчихсан. Дүн гараагүй. Сая цуцалъя гээд дүн гарахаас өмнө хэлчихсэн учраас. Тэгэхээр техникийн өрөөнөөс бэлэн болонгуутаа наашаа мэдэгдье. Санал хураалтыг шинээр эхлүүлье.

Тэгэхээр энэ санал хураалт эхлээгүй биз дээ. Тэгэхээр түрүүн санал хураалт явагдаад дэмжиж санал өгсөн гишүүдийн санал эсрэг гарсан учраас санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргасан. Горимын саналаар санал хураалтыг дахиж явуулъя. Эхний явуулсан санал хураалтыг хүчингүй болгох горимын санал хураалт 55,9 хувиар дэмжигдлээ.

Үндсэн санал хураалт буюу 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалтад оролцсон гишүүдийн 59,5 хувь нь дэмжсэнээр хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

20.23 цаг.

Дараагийн асуудал руугаа оръё. Хэлэлцэх асуудал 3.

Монгол Улс Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /нэг дэх хэлэлцүүлэг/-ийг хийнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Л.Оюун-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэхээр дэмжсэн Их Хурлын гишүүд та бүхэнд талархаж байна. Одоо бид хурдтай шийдлийн төлөө хөтөлбөрт туссан асуудлуудын ТЭЗҮ, зураг төсөв олон улсын зөвлөх үйлчилгээний асуудлууд болон олон улсын эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын зөвлөх, зөвлөмж авах асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж 2024 оны төсвийн тодотголын төслийг оруулж ирж байгаа юм.

Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудал сорилтыг шийдвэрлэх эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх, нэн яаралтай арга хэмжээ авахад шаардлагатай зарим эрх зүйн зохицуулалтыг мөн тусгалаа.

Энэ удаагийн төсвийн тодотгол нь дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн улс орны өмнө тулгарч буй сорилт, тулгамдаж буй асуудлуудыг зоригтой шийдэх, шинэ 30 жилийн хөгжлийн гарааг эхлүүлэх, олон жил гацсан мега төслүүдийг бодитой хэрэгжүүлж гацааг гаргах, үндсэн суурийг тавьж, төсвийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хадгалах төсвийн шинэчлэл болж байгаа онцлогтой гэж үзэж байна.

Миний бие Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн талаар танилцуулахдаа энэхүү төсвийн тодотголын онцлог ач холбогдлын талаар дэлгэрэнгүй танилцуулгыг хийсэн билээ.

Тийм учраас 2024 оны төсвийн тодотгол болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайд Болдын Жавхлан та бүхэнд пресентац хэлбэрээр танилцуулах нь илүү өгөөжтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-аас 2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн хуулийн төсөл болон эдгээртэй холбогдуулан боловсруулсан бусад хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхланг индэрт урьж байна. Мөн танхимд байхгүй байгаа Засгийн газрын гишүүдийг танхимд дуудъя.

Б.Жавхлан: Уучлаарай дэлгэц нь бэлэн болтол уншиж танилцуулж байя.

Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хууль болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, Улсын Их Хурлын

чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байна.

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөлөө арилж, улс орнуудын мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр инфляц саарсан нь ажил эрхлэлт, өрхийн хэрэглээг дэмжиж, дэлхийн эдийн засаг 2023 онд 3,3 хувиар өслөө. Дэлхийн эдийн засгийн өсөлтийг ОУВС 2024 онд 3,2, 2025 онд 3,3 хувь орчим тогтвортой байхаар тооцож байна. Инфляцын бууралт мөнгөний бодлогыг сулруулж, эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр байна. Хөгжингүй орнуудын эдийн засаг ирэх 4 жилд 1,8-2 хувь орчимд, хөгжиж буй орнуудын эдийн засаг 3,9-4,2 орчим хувиар өсөх төлөвтэй байна гэж мэргэжилтнүүд үзэж, судлаачид дүгнэлт гаргасан байна.

Манай Улсын хувьд уул уурхайн салбарын экспортын сэргэлт 2023 онд үргэлжилж, төсөв, төлбөрийн тэнцэл түүхэнд байгаагүй ашигтай гарсан нь эдийн засаг 7,4 хувиар өсөх нөхцөл болсон. 2024 оны эхний улирлын байдлаар эдийн засаг 7,8 хувиар өссөн ба энэ онд 5,6 хувиар өсөх төлөвтэй байна. Үүнд, зудын улмаас улсын хэмжээнд 8,1 сая толгой мал хорогдож, Хөдөө аж ахуйн салбарт агишилт үүссэн ч уул уурхайн салбарын сэргэлт нь бодит өсөлтийг тэтгэх үндсэн хүчин зүйл болж байна.

2024 оны эхний 7 сард нүүрсний экспорт өмнөх оноос 34 хувиар өсөж, нийт 47,5 сая тоннд хүрсэн ба оны эцэст 78 сая тоннд хүрэх, Оюутолгойн төслийн гүний уурхайн олборлолт эхэлсэн зэрэг хүчин зүйлийн нөлөөгөөр уул уурхайн салбар энэ онд 13,5 хувиар өсөх хүлээлттэй байна. Мөн уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээврийн өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр 2024 оны сүүлийн хагас жилд аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлт бий боллоо.

Монгол Улсын 2023 оны төсвийн тодотгол, 2024 оны 2 дугаар улирлаас нэмэгдсэн цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нөлөө өрхийн хэрэглээг дэмжиж, дотоод эргэлтийг урамшуулснаар худалдаа үйлчилгээний борлуулалт нэмэгдсэн. Эдийн засгийн өсөлт мөн эерэг нөлөө үзүүлж байна. Импортын инфляцын нийт инфляцад үзүүлэх нөлөө 2023 оноос алгуур буурч тогтворжсоноор инфляцын түвшин саарч, 2024 оны 6 дугаар сард 5,1 хувь буюу мөнгөний бодлогын зорилтот түвшинд хүрээд байна.

Олон Улсын байгууллагууд манай улсын эдийн засгийг дунд хугацаанд 6-8 хувиар өсөх төлөвтэй гэж үзэж байгаа хэдий ч дэлхийн болон бүсийн эдийн засагт үүсээд буй тодорхой бус байдлаас шалтгаалан уул уурхайн голлох бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд нь манай улсад орох хөрөнгийн урсгал, гадаадын хөрөнгө оруулалтыг бууруулах, уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг анхааруулж байна. Эдгээр гадаад орчны тодорхой бус байдал, эрсдэлт цаг үед улс орны өмнө тулгарч буй сорилт тулгамдаж буй асуудлуудыг шийдэхийн зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг 6 хувь тогтворжуулах, дотоодын нийт бүтээгдэхүүнийг 47,6 тэрбум ам.долларт 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган ам.долларт хүргэх, ядуурлын 2 дахин бууруулах зэрэг урт хугацааны хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд хурдтай, зоригтой, эрс шийдвэрүүдийг гаргаж, шинэ 30 жилийн хөгжлийг гарааг эхлүүлэх шаардлага бидэнд байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлтийн дагуу сонгуулийн холимог тогтолцоогоор анхны 126 төлөөлөл бүхий Улсын Их Хурал байгуулагдаж, улс төрийн намууд ард түмний дэмжлэг авсан иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дээр Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын

төлөөллөөс бүрдсэн хамтарсан Засгийн газар байгуулагдаад байна. Энэ хүрээнд 3 намын мөрийн хөтөлбөрт туссан нийтлэг зорилтод суурилсан “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын гэрээ байгуулагдаж, хамтын ажиллагааны зарчим, хүрээ, тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг тодорхойлсон.

Уг гэрээнд үндэслэн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын хөгжлийг тулгамдсан асуудал, зорилтыг шийдвэрлэх эдийн засгийн суурийг тэлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн томоохон төслүүдийг үр дүнд хэрэгжүүлэх цаг үе ирлээ. Мөн хувийн хэвшил гадаадын шууд хөрөнгө оруулалтад ил тод, нээлттэй байж, тэднийг дэмжих төсвийн бодлогыг бид маш хүчтэй, зоримог тавих шаардлага бий болж байна.

Түүнчлэн, хүн амын өсөлт, шилжих хөдөлгөөний эрчим нь газар олголт, гэр хорооллын тэлэлт, тээврийн хэрэгслийн тооны өсөлтөөс улбаатай орчны бохирдол, авто замын түгжрэл, цахилгааны болон дулаан хангамжийн дутагдал, гамшигийн эрсдэл, хөдөөгийн хөгжлийн хоцрогдол зэрэг асуудлууд нь хүн амын эрүүл мэнд, амьдралын чанар, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгааг хамтарсан Засгийн газар онцгой анхаарч, шийдвэрлэх зорилт тавин ажиллаж байна.

Дээр дурдсан хөгжлийн асуудлуудыг дан ганц төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжгүй тул хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж шийдвэрлэх болно. Гадаадын шууд хөрөнгө оруулалтуудыг дэмжих болно.

Хамтарсан Засгийн газрын хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөгжлийг урамшуулах томоохон төслүүдийг бодитой хэрэгжүүлэх зорилгоор нэгдсэн төсвийн зарлага, төсвийн тэнцэл, Засгийн газрын өрийн

тусгай шаардлагын бүтэц, агуулгыг шинэчилж, олон улсын жишигт нийцүүлэх тогтолцооны суурь реформыг эхлүүлэх шаардлага бидний өмнө мөн тулгарч байна.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөгжлийн мега төслүүд болон бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын төслүүдийн бэлтгэл ажлыг хангах, судалгаа хийх, ТЭЗҮ боловсруулах, зураг төсөвт шаардлагатай эхний ээлжийн санхүүжилтийг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар энэ жилдээ бид хийхээр зорилоо.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлт болон Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсанаар төлөвлөгдсөн төсөл хөтөлбөрүүдийн ажил шууд эхэлнэ гэж ойлгож болно. Цаашид Монгол Улсын 2025 оноос эхлэн жил бүрийн төсөвт бусад шаардлагатай санхүүжилтийг үе шаттайгаар тусгаснаар төслүүд саадгүй хэрэгжих, дуусах бид зорилт тавьж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн бүсчилсэн хөгжлийн бодлогын зорилт, арга хэмжээний хүрээнд 15 төслийн 885,2 тэрбум төгрөг, эдийн засгийн бодлогын зорилт, арга хэмжээний хүрээнд 3 төслийн 378,3 тэрбум төгрөг, Хөгжлийн бодлогын хүрээнд 3 төслийн 222,6 тэрбум төгрөгийг тус тус төсвийн тодотголд тусгалаа.

“Алсын хараа 2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой хэрэгжүүлж хөгжлийн тулгамдсан асуудлуудыг цаг алдалгүй хурдтай шийдвэрлэхэд чиглэсэн дараах багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр танилцуулж байна. Үүнд:

1 дүгээрт, Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд нийслэлийн Их, бага тойруу дахь төрийн эрх мэдлийн хэт төвлөрлийг задалж, Өөдөө тэмүүлэх Монгол буюу Go Mongolia, Ган татлагат гүүр, Хөшигийн хөндийн туннел, Хөшигийн хөндийн төр захиргааны нэгдсэн байр, аймгийн төв, сумд болон хилийн боомтуудыг холбох шинэ сэргэлтийн 5 тойрог авто замын төсөл, шинэ Хархорум, Шинэ Зуунмод хот, Туулын хурдны зам зэрэг төслүүдийг Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийн төсвийн тодотголд тусгалаа.

2 дугаарт, гадаадын зээл, зээлийн эх үүсвэрээр санхүүжиж буй бүсчилэн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг 984 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотголд тусгалаа. Үүний 87 хувь нь дэд бүтэц, эрчим хүч, орон сууцжуулах төслүүд байна. Тухайлбал, жилд 1,5 сая тонн бүхий түүхий тосноос 1.5 сая тонн бүхий түүхий тосноос 1.3 сая тонн бүтээгдэхүүн гаргах дотоодын газрын тосны хэрэглээний 55 орчим хувийг дотоодоос хангах газрын тос боловсруулах цогцолбор, мөн нийслэлийн цэвэрлэх байгууламжийг үргэлжлүүлэх, Эрдэнэбүрэн цахилгаан станцыг мөн энэ жилдээ эхлүүлэх зэрэг томоохон төслүүд багтсан болно.

3 дугаарт, 30 жил хэл хүлээгдсэн эрчим хүчний салбарын үнэ тарифын реформыг цаг алдалгүй эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, либералчлах хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлж, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эх үүсвэрийг гадаадын иууд хөрөнгө оруулалт болон хувийн хэвилийнхний сонирхлыг татахуйц либералчлах нь бидний өмнө тулгамдсан зорилт болоод байна. Өөрөөр хэлбэл энэ өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээг

төсвийн хөрөнгө оруулалтаар бид ойрын хугацаанд яагаад ч нөхөж чадахгүй юм. Тийм учраас зайлигүй бид энэ өөрчлөлтийг эхлүүлэх шаардлага бий болж байна.

4 дүгээрт, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай болон холбогдох бусад хууль, тогтоолын төслүүд батлагдсан. Дээрх хуулиуд батлагдсанаар зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжсэн. Шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болсон. Мөн зарим яам, агентлагийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д заасны дагуу Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд төсвийн зохицуулалт хийх хуулийн шаардлага үүссэн.

5 дугаарт, төсвийн тодотголын төсөлтэй хамт 13 хуулийн төсөл, 2 Улсын Их Хурлын тогтоолын төслийг хамт өргөн мэдүүлж байна. Дагалдах хууль, тогтоомжийн төсөлд туссан онцлох өөрчлөлтийг дурдвал. Үүнд, Монгол Улсын өмнө хэрэгжүүлж байгаагүй томоохон бүтээн байгуулалтын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтыг чадавхад суурилсан хэлэлцээний аргаар зохион байгуулахаар хуулийн төсөлд тусгалаа. Нэр хүнд бүхий, чадавх бүхий дотоодын болон гадаадын аж ахуйн нэгжүүдийг түүний туршилага, санхүүгийн болон техникийн чадавхад үндэслэн урилгаар оролцуулж, хэлэлцээ хийх нөхцөлийг бүрдүүлж байна. Ингэснээр бүтээн байгуулалтын төсөл хэлбэрийг шуурхай хэрэгжүүлэх боломж бий болно гэж үзэж байна.

Хувийн хэвшил нийгмийн хариуцлагын хүрээнд байгалийн нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх, нийгмийн суурь салбарууд болох боловсрол, эрүүл мэнд, спорт, соёл гэх мэт салбаруудад бүтээн байгуулалт хийж, бодитойгоор төрийн

ачааллаас хуваалцаж байгаа эдгээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтуудыг тодорхой хэмжээнд татварын хөнгөлөлт үзүүлэх ийм зохицуулалтуудыг ч мөн нэмж орууллаа.

Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дараагийн 30 жилийн энэхүү хөгжлийн шинэ загварт нийцсэн төсвийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хадгалах төсвийн шинэчлэлийг эхлүүлж байна. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай болон дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ингээд та бүхэн дэлгэцэд анхаарлаа хандуулна уу. Сая уншиж танилцуулсан танилцуулгын хүрээнд та бүхэнд холбогдох тоонуудыг танилцуулъя.

Д.Амарбаясгалан: Жавхлан сайдын микрофоныг өгье. Товчлоод явахгүй бол.

Б.Жавхлан: Тэгье тэгье. Энэ ер нь 1 цаг гаруй явдаг танилцуулах юм байгаа юм шүү. Тэгээд 20 минутад багтаахыг хичээе. Ингээд бид энэ удаагийн төсөв маань хэдийгээр тодотгол боловч шинэ Их Хурлын, шинэ Засгийн газрын анхны төсөв юм.

Тийм учраас бид гол суурь макро тоонууд дээрээсээ эхлэх ёстой. Ингээд 2024 оны төсвийн гол макро тоонууд дээр төсөөллүүд хүлээлтүүд өөрчлөгдөж байгаа. 3 гол том өөрчлөлт орж байгаа. Үүнд, хамгийн 1 дүгээрт нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн маань 74 их наядаар батлагдаж байсан бол тэр 16,4 их наяд гэдэг нь 1 дүгээр улирлынхаар шүү. 2 дугаар улирлынх бол гараагүй байгаа. Нөгөө цаглавартай холбоотой асуудал чинь эндээс үүсэж байгаа байхгүй юу. Бид нар хагас жилийнхээ дүнг хараагүй байж байж ирэх жилийнхээ

тоог бид нар яагаад ч гаргаж тавихгүй. Тавьж чадахгүй байгаад байгаа юм. Ямар ч байсан ингээд энэ жилийнхээ тоог бол төсөөллөө ингээд гаргачихлаа. Ингээд 80 их наяд орчим буюу 79 их наяд 216 тэрбум дээр хүрэхээр ийм төлөвлөлттэй байна. Энэ бол мэдээж төсвийн орлогод бол шууд нөлөөлнө. Сүүлийн 5 жилийн хугацаанд бид төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 1 төгрөгөөр ч зөрүүлээгүй. Дандаа зөв төлөвлөсөн, дандаа давж биелсэн. Энэ хэмжээгээр тухайн жил бүрд төсөв сайжирч гарч байсан.

Эдийн засгийн өсөлт маань сая 1, 2 дугаар улиралд гарсан цас зудтай холбоотой, ялангуяа Хөдөө аж ахуйн салбарт бий болсон энэ уналтаас шалтгаалж, төсөөлж байсан 7 хувь маань 5,6 хувь дээр. Гэхдээ бидний төлөвлөж байгаа 5-7 хувь гэдэг ийм депозон дотроо байх нь ээ. Инфляц зорилтот түвшин рүүгээ буюу Монголбанкны 6 дээр +/-2 ийм депозон дотроо бол орж ирсэн байгаа. Ингээд нийт экспорт, импорт маань бол бас нэлээн нэмэгдэхээр шинжтэй байна. Ер нь бол нийтдээ бид энэ жил 24 гэж харж байсан бол 27 болж ингээж биет хэмжээгээр өсөж байна. Түүхий эдүүдийн экспортын хувьд нүүрс дээр нэлээн өсөлттэй гарахаар байна. Бид 60 сая тонн гэж тооцоолж байсан бол жилийн эцэс рүү 78 бараг 80 сая тонн руу дөхөж гарахаар байна. Одоо бууралттай байдаг энэ зуны сезонд өсөлт биет хэмжээгээр гарч байгаа юм чинь сүүлийн улирал, 2 улиралд бол нэлээн өсөлттэй байхаар байна гэсэн ийм хүлээлттэй байна. Гол түүхий эдүүдийн үнийн хувьд нүүрс дээр бага хэмжээний уналттай, зэс бол харьцангуй өндөр байна. Төмрийн хүдэр дээр тогтвортой байгаа. Ийм гол макро тоонууд дээр өөрчлөлт гарч байгаа учраас төсвийн тодотгол хийх эдийн засгийн ийм боломж гарч ирж байна гэсэн үг.

Дараагийн дэлгэц дээр гол тоонууд л байгаа. Энэ ерөөсөө 6 тоо дээр л гол тодотгол яригдана. Ингээд энэ жилийн

саяын тэр дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн хүрээнд энийг бий болгож байгаа төсвийн тэнцвэржүүлсэн орлого 3,1 их наяд орчмоор нэмэгдэхээр гарч байгаа. Багадаа. Тийм учраас яг энэ бодит орлого дээрээ уялдуулж дараах хөрөнгө оруулалт болон тодорхой хэмжээний урсгал зардлууд дээр тодотгол хийгдэнэ гэсэн үг.

Ингээд эхний та бүхэн 3 тоог хараарай. Нийлээд 2,5 их наяд. Энэ бол яг шууд бүтээн байгуулалтуудтай холбоотой ийм зардлууд байгаа. Нийслэлийн бонд энд 1 их наяд гэж байгаа. Энэ жил нийслэл дээр бонд гаргах, үнэт цаас гаргах эрх зүй нь бол нээгдсэн байгаа. Үүнийхээ дагуу 3 транч бонд гаргана. 500 тэрбумаар 2 удаа, жилийн эцэс рүү 200 сая доллар буюу зориулалт дээр метро руугаа оруулахаар ингээд төлөвлөж байгаа. Эхний транч нь 500 тэрбум төгрөг гараад ирчихсэн. Ингээд явж байгаа. Одоо зарцуулалт нь эхлэх ёстой. Ингэхийн тулд тодотгол дээр орж эрхээ нээлгэнэ. Зарцуулалттайгаа эрхийг нээлгэх ийм тодотгол хийгдэж байгаа гэсэн үг. Нийслэлийн газар чөлөөлөлт дээр 584 тэрбум төгрөг. Энэ Сэлбэ сэргэлт болон тэр орчмын голын хөндийг дагасан Улаанбаатар хотын төвөөс хойшоо Чингэлтэй дүүрэг хүртэлх газар чөлөөлөлт, шинэ бүтээн байгуулалт, дахин төлөвлөлт ийм ажлуудыг энэ жилдээ багтааж хурдтай хийхээр ингэж орж ирж байгаа. Үүний дагуу нийслэл дараа нь тодотголоо хийх ёстой.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бүтээн байгуулалт. Энэ яригдаад байгаа томоохон бүтээн байгуулалтууд байгаа. Энийг ард нь би нэг бүрчлэн тоонуудыг нь харуулна. Энэ дээр шаардагдах урьдчилсан бэлтгэл ажлыг хангах, ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний нийт зардал 474. Бид нар ер нь яг ийм эдийн засгийн ангиллаар хөрөнгө оруулалтыг анх удаа ийм том дүнтэй тавигдаж байгаа. Тэгэхээр сайд нар маань, шинэ

Засгийн газар энэ дээр, гүйцэтгэл дээр бид онцгой анхаарах шаардлагатай байгаа. Түрүүн бол гишүүд энэ талаар ярьж байна лээ шүү.

Гадаад зээлээр хэрэгжүүлэх бүтээн байгуулалт 984. Энийг арын хуудсан дээр нэг бүрчлэн харуулна. Энэ 11 төсөл байгаа.

Малчин хоршоо, зээлийн хүүгийн зардал, цагаан алт хөтөлбөр гээд энэ дээр хөтөлбөр дотор орсон байгаа. Малчны зээл, шинэ хоршоо, чинээлэг малчны хөтөлбөрүүдийг үргэлжлүүлнэ гээд. Үүнтэй холбоотой мөн тодотголын дүн байна.

Эрчим хүчний үнэ тарифыг чөлөөлөх шилжилтийн зардал буюу 131,1. Одоо үнэхээр олон жил зангираад байгаа энэ өр зээлийн асуудлуудыг 1 удаагийн татаасаар, өмнө бол өмнөх жилүүдэд ч бас хийж ирсэн. Ингээд ер нь чиглэлийн салбарын сайдын хэлж байгаагаар ер нь сүүлийн татаас байж болно. Үүнээс цааш ингээд тарифаа чөлөөлөөд энэ салбар өөрөө өөрийгөө аваад явах, өөрөөр хэлбэл ийм өртөгтэйгөөр энэ олон жил хуримтлагдсан энэ том салбарын асуудлыг шийдчих юм бол маш сайн зүйл болно гэж ингэж бид төсвийн талаас харж, дэмжиж байгаа.

Ингээд цөөхөн хэдэн төслүүдээ та бүхэн дэлгэц дээр харж эхэллээ. Өөдөө тэмүүлэх Монгол Go Mongolia ган татлагат гүүр. Энийг янз янзаар л нэрлэдэг юм байна лээ. Ингээд 2024 ондоо багтааж зураг төсөв, ТЭЗҮ-г хийе. Ингээд 2025-2028 онд бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ гээд ингээд 28,6 тэрбум төгрөг тавьсан байна. Энэ дүн энэ судалгааг бол Зам, тээврийн яам, “20 минут хот” Үндэсний Хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийлж ирсэн ийм санал байгаа. Ингээд бүтнээрээ тусгагдсан гэсэн үг.

Хөшигийн хөндийн туннел төсөл. Мөн 55,3 тэрбум төгрөгөөр урьдчилсан

бэлтгэл ажлаа энэ жил хийж гүйцэтгэе гэсэн ийм нэгдсэн санал ирсэн. Ингээд бүтэн дүнгээрээ тавигдсан.

Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор. Хөшигийн хөндийд баригдах. Мөн энэ ондоо багтааж, 100 тэрбум төгрөгөөр бэлтгэл ажлаа хангана. Тэгээд ямар ч байсан бүтээн байгуулалтын ажлыг болбол эхлүүлэх бас ийм өндөр зорилт тавьж, ажиллаж эхэлж байна.

Шинэ их тойруу хурдны зам 23 тэрбум төгрөгийн ийм төсөвтэй. Энийг Зам, тээврийн сайдын багц дээр буюу эдний яамнаас бэлтгэл ажлыг хангахаар ингээд үүрэг аваад ажилдаа орж байна.

Бүсийн хөгжлийг дэмжих, бүтээн байгуулалтын төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөв гээд. Энэ бол цоо шинэ орж ирж байгаа ийм эдийн засгийн ангилал бүхий хөрөнгө оруулалтын зардал байна. Юуны тулд бид нар энэ 4 жил гол том хөтөлбөрийн маань хэсэг болж байна. Засгийн газрын бүтцэд өөрчлөлт ороод, бүр бүсчилсэн хөгжлийг хариуцсан сайдтай болсон. Ингээд нэг бүсэд дунджаар 10 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлыг хангах, зураг төсөв, ТЭЗҮ-д зориулагдсан ийм дүн байгаа. Энийг бас гишүүд нэлээн сонирхож асууж байсан. Хаана, яаж төлөвлөгдөж явах юм бэ гээд.

Хүрээлэн байгуулагдаж байгаа. Бүсчилсэн хөгжлийн хүрээлэн гээд 40 гаруй хүнтэй. Тэр дээр бүс бүсийн гишүүд, төлөөллүүд орон нутгийн төрийн бүтцүүдтэй хамтарч ажиллаж, эхний ээлжид эрэмбэлэгдэж хийгдэх ажлууд руугаа нэлээн орж ажиллах болов уу. Ялангуяа жишээ нь говийн гишүүд ярьж байгаа. Тэнд бий болох цахилгаан эрчим хүчний нэмэлт эх үүсвэрийн бүтээн байгуулалт, тэр лүү хамгийн түрүүнд орж таарах байх.

Төвийн бүс дээр ч гэсэн мөн нэлээн олон бэлтгэгдсэн ажлууд байх

жишээтэй. Ингээд явна. Энэ дотор мөн нийслэл ч орчихсон байгаа гэж ойлгоорой. Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээ гээд. Энэ Монгол Улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга, Монгол Улсын сайд дээр тавигдсан ийм төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ гээд нийслэл хоттой хамтарч хийгдэнэ. Манай асуудал хариуцсан сайд нар маань төсвийн ерөнхийлөн захирагч хэдий ч яг ингээд бүх дүнгээ зарцуулаад өөрсдөө аваад явах ийм бүтэц байдаггүй учраас хэдийгээр энэ дүн тавигдаж байгаа ч гэсэн хамтарч хэрэгжих ийм зүйлүүд байгаа.

Нийслэлийн газар чөлөөлөлт. Энэ нийслэлийн газар чөлөөлөлт дээр нийслэлийн гишүүд энэ дээр онцгой анхаараарай. Энэ урьд өмнө тавигдаж байгаагүй ийм том дэмжлэг нийслэл дээр очиж байгаа. Тэгэхээр энэ 4 жил нийслэлийн энэ түгжрэлийн асуудлыг бол ер нь бүрэн шийдэх ёстой шүү. Нийслэл Улаанбаатар энэ жил бол 230 тэрбум төгрөгийг улсын нэгдсэн төсөвт орлогод төвлөрүүлэх байх ёстой. Эндээс үндсэндээ 211 тэрбум төгрөгийг чөлөөлж байгаа. Ингээд 19,6 тэрбум төгрөгийг улсын төсөвт өгнө. Дээрээс нь зөрүү тавигдаад, нийтдээ 584 тэрбум төгрөгөөр нийслэлийн төсвийн суурь зардал нэмэгдэж байгаа гэсэн үг.

Дараагийнх нь. Эрчим хүчийг түрүүн ярьчихсан. Энэ 131,1 тэрбум төгрөг. Яах вэ дараа Чойжилсүрэн сайд дутуу байвал нэмж мэдээлэл өгнө биз. Ер нь бол бөглөрчхөөд байгаа 1 гаруй их наяд төгрөгийн асуудал энэ салбарт байгаа. Энэ удаа ер нь нэг ийм татаас өгчихвөл бид цаашаагаа энийг либералчлаад, чөлөөт тарифын систем рүүгээ орчхож болох юм гэж хэлж байгаа дүн нь 230 тэрбум төгрөг гэж юм ирсэн. Эндээс бид нэлээн судалгаа хийж, 131,1 байхад болно. Бусдыг нь тэгээд тариф руугаа шилжээд, өөрсдөө өөрсдийгөө яаж аваад явах эхлээд тавиагч ээ гэж ингэж байгаа. Тэгээд одоо энийг яг өрхийн хэрэглээнийх,

аж ахуйн нэгжийн хэрэглээнийх, уул уурхайн хэрэглээнийх гээд, тэр дээр бас уян хатан байдлаар эхлээд шууд шилжих юм уу, яах юм гэдэг энэ бодлогоо бол салбарын сайд өөрөө дэлгэрэнгүй танилцуулах нь зүйтэй.

Нөгөө 984 чинь энэ төслүүд байгаа шүү. Одоо ингээд л хамгийн том нь тэр Эрдэнэбүрэнгийн УЦС, нефть боловсруулах үйлдвэр, Нийслэлийн цэвэрлэх байгууламж, 10 аймгийн дулааны станцуудыг үргэлжлүүлэх санхүүжилт гээд ийм яг дэд бүтцийн 87 хувь нь ийм төслүүд байгаа. Ингээд энэ жил энийгээ бушуухан хийгээд, бушуухан ойрын хугацаандаа дуусгая. Ингээд энэ төслүүдээ бушуухан эргэлтэд оруулъя. Нэгэнт Улсын Их Хурлаас энэ зээлийг ав гээд шийдчихсэн, Засгийн газар төслөө аваад, хэрэгжүүлээд эхэлчихсэн ийм чухал төслүүдээ яаралтай дуусгая гэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ 984-ийг хэзээ нэгэн цагт хийнэ. Бид нар аягүй бол хойтон хийнэ. Тийм учраас энэ жил боломж байгаа учраас хойтонгийнхоо ачааллыг бууруулаад энэ жил татаад хойтон мөн энэ хэмжээгээр энийгээ үргэлжлүүлэх ийм боломжийг нөгөө түрүүний яриад байгаа тэр Төсвийн тогтвортой байдлын хуульд оруулж байгаа өөрчлөлтүүдээр эд нарыгаа л хийх гээд байгаа л ийм л зүйлүүд байгаа шүү.

Ингээд эдгээр өөрчлөлтүүдийн дараа төсвийн тэнцэл маань ингээж гарч ирж байна. 25 их наядоор батлагдсан төсвийн тэнцвэржүүлсэн орлого маань 28 болно. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл маань 21 их наяд байгаа урсгал зардал гээд энийг асуугаад байдаг гишүүд маань 1,2 их наядоор нэмэгдээд, 22,4 их наяд болж байгаа. Ингээд нэгдсэн яг төсвийн суурь тэнцэл маань одоо байгаа, одоо алга болчихоод байгаа нөгөө 2,2 хувь гэдгийгээ бид нар энэ дээр байхгүй хэдий ч барьж орж байгаа. 2 хувийнхаа алдагдлыг бариад орж байгаа. Өөрөөр хэлбэл нэмэгдэж байгаа орлогынхоо хүрээнд одоо яг зардлаа тавьж байгаа. Саяын тэр 984 гэдэг бол сайд нараас 3,7

их наяд гэж хүсэлт нь ирсэн. 4 дахин багыг л бид оруулж багтааж чадаж байгаа гэсэн үг. Ингээд суурь тэнцлээ бид нар бүх хязгаарууд дээрээ багтаагаад орж байгаа. Суурь тэнцлээ 2 хувь нэмэхдээ төсвийн нэгдсэн тэнцлээ 2 хувь дээрээ бариад, -2 хувь дээрээ ингээд бариад орж байгаа.

Дараагийнх нь дагасан хуулиуд байх. Энэ ингээд гишүүд асуувал бид хариулахаар нэмэлт мэдээллүүдийг өгье. Энэ ингээд нэлээн техникийн шинжтэй задлаад явчхаж байгаа юм. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Сангийн сайд Болдын Жавхланд баярлалаа. Төсвийн төслийн талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджав танилцуулна. Төв индэр дээр урьж байна.

Д.Загджав: Та бүхэндээ энэ үдшийн мэнд дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас дараах 3 шаардлагыг хангасан эсэхэд аудит хийж, дүгнэлтийг танилцуулж байна.

Нэгд, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заасан төсвийн төсөл нь Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх:

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны

төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн бодлоготой нийцэж байна.

Мөн Засгийн газрын өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх харьцаа нь 2024 онд 44,7 хувьд хүрэх төсөөлөлтэй байхаар тооцоолон тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд байна.

Хоёрт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2-т заасан төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгууруудыг хангасан эсэх:

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.1-д Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагыг баримтлахгүй байх нөхцөл байдал үүссэн. 34.1.4-д төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх гэж тус тус заасныг үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 28 их наяд 872,5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 36,4 хуьт, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30 их наяд 487,9 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 38,5 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 615,4 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувь байхаар төлөвлөжээ.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд орж буй төсвийн суурь зарлага гэдэг ойлголт нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн бүртгэлийн зарчим болон улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай зөрчсөн асуудал байхгүй байгаа юм.

Харин суурь зарлагын зарлагыг төсвийн тусгай шаардлагад оруулж тусгасан нь урсгал зарлагын хэт өсөлтийг хязгаарлах эерэг талтай боловч хөрөнгө оруулалтын зардлыг эцсийн эдийн засагт үр өгөөж бий болгохгүй төсөл арга хэмжээнд зарцуулах санхүүгийн болон төсвийн сахилга бат алдагдах эрсдэл үүсгэж болзошгүй байгаа юм.

Гуравт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.3-д заасан Хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан дээрх өөрчлөлтүүд нь “Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлүүдтэй нийцсэн байна.

Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг 6 бүлэг, 8 тэргүүлэх чиглэлийн 24 зорилтын хүрээнд 194 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсөв 2 их наяд 705,6 тэрбум төгрөг, бусад эх үүсвэр 1 их наяд 589 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 247 тэрбум төгрөг, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалт 4 их наяд 747,6 тэрбум төгрөг, төр, хувийн хэвшлийн түншлэл 4 их наяд 515,1 тэрбум төгрөг, нийт 13 их

наяд 885,2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хөгжлийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болох ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, төсвийн хөрөнгө оруулалтыг бүсчилсэн хөгжил, Улаанбаатар хотын хэт төвлөрөл, түгжрэлийг бууруулах, Туул голоос Хөшигийн хөндий рүү чиглэсэн шинэ тойруу дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэсэн байна. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төсөвт өртгийн тооцооллыг хангалтгүй гүйцэтгэсэн. ТЭЗҮ боловсруулах ажлын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, зарцуулах зардлын төсвийг тооцож төлөвлөхөд баримтлах жишиг үнэ, ажлын даалгавар боловсруулахад тавигдах шаардлага, хүлээн авахтай холбоотой эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу гаргаж буй аудитын дүгнэлт, төсвийн тодотголыг Улсын Их Хуралд хүргүүлэхэд цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байгаа нь төрийн аудитын байгууллага аудитын стандартад заасан төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах горим сорил хэрэгжүүлэх, дүгнэлт гаргахад эрсдэл үүсэж байгаа тул цаглавартай болгох шаардлагатайг анхаарч үзэхийг уламжилъя.

Төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Монгол Улсын Ерөнхий аудитор Дэлэгийн Загджавд баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Н.Энхбаяр: Улсын Их Хурлын эрх эрхэм дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зүгээс өгсөн дүгнэлтийг та бүхэнд товч танилцуулъя.

Шинээр байгуулагдсан Улсын Их Хурал, Засгийн газар нь Эдийн засгийн урт болон дунд хугацааны тогтвортой өсөлтийг хангах “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, бүсчилсэн хөгжил, шинэ сэргэлтийн бодлогын дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэх бодлогыг дэмжиж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 2024 оны 3 дугаар сард дунд хугацааны макро эдийн засгийн төсөөллийг боловсруулж, түүнд үндэслэн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн талаарх саналаа Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн.

Тухайн баримт бичгийн хүрээнд бид төсвийн төлөлтийг хязгаарлах замаар төрийн оролцоо буюу дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн зарлагын хувь хэмжээг бууруулах, төсвийн алдагдлыг багасган урт хугацаанд өсөх өрийн дарамт, төсвийн эрсдэлээс сэргийлэх байр суурийг илэрхийлж, Монгол Улсын төсвийн орлого уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлаас болж ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлээс хамгаалах тухай дүгнэлтийг өгч байсан.

Монгол Улсын 2024 оны төсвийн тодотголд тусгагдсан хөгжлийн хөрөнгө оруулалтын тухайд товч дүгнэлтээ танилцуулъя.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 1 их наяд 603,5 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх ашигтай байхаар, мөн 2024 оны нэгдсэн төсвийн орлого, тусламж 30 их наяд 639,5 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан дүнгээс 2 их наяд 917,4 тэрбум төгрөгөөр, тэнцвэржүүлсэн орлого, тусламж 28 их наяд 872,5 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан дүнгээс 3 их наяд 17,3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр, нэгдсэн төсвийн нийт зарлага, цэвэр зээл 30 их наяд 487,9 тэрбум төгрөгт хүрч, батлагдсан дүнгээс 3 их наяд 127,4 тэрбум төгрөгөөр, нэгдсэн төсвийн тэнцэл 1 их наяд 615,4 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх алдагдалтай байхаар тусгажээ. Үүний дотор нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 8 их наяд 71 тэрбум төгрөг болж, батлагдсан дүнгээс 1 их наяд 797,7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Төсвийн тодотголын танилцуулгад тусгаснаар хөгжлийн хөрөнгө оруулалтад хамаарах улсын төсвийн хөрөнгө оруулалтын дүн 442,6 тэрбум төгрөг, гадаад зээл тусламжаар хэрэгжих хөгжлийн бүтээн байгуулалтын төслүүдийн Монголын талаас гаргах санхүүжилтийн дүн 911,4 тэрбум төгрөг тус тус байна. Эдгээр хөрөнгө оруулалтын нийт дүн 1 их наяд 354 тэрбум төгрөг болж байгаа бол зөрүү 443,7 тэрбум төгрөг чухам юунд зарцуулагдах, нэмэгдэж буй нийт хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлэх нь тодорхойгүй байна.

Түүнчлэн 2024 онд батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл одоогийн байдлаар 24,6

хувьтай байна гэсэн мэдээлэлтэй байгаа нь цаашид шинээр хэрэгжих төслийн хөрөнгө оруулалтууд цаг хугацаандаа хэрэгжих үү гэдэг ийм эргэлзээ төрүүлж байна. Ингээд дүгнэлтээ танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотойгоор тодорхой төсвийн тодотголыг хязгаарлагдмал хүрээнд хийж болох боловч Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан төсөл нь төсвийн дунд хугацааны бодлогын бичиг баримт, төсвийн тогтвортой байдлын эрх зүйн орчин, төсвийн бодлогын томоохон өөрчлөлтийг агуулсан байна. Иймээс Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн дагуу өмнө баталсан хөгжлийн бодлогын бичиг баримттай нийцүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Төсвийн тогтвортой байдлын гол үндэс болсон төсвийн тусгай шаардлагын агуулга хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах магадлалтай гэж үзэж байна. Төсвийн тэлэлт алдагдал нэмэгдэх боломжийг нээж, төсвийн эрсдэлийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөтэй гэж Төсвийн тогтвортой байдлаас дүгнэж байна. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Энхбаяр даргад баярлалаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Монгол Улсын Ерөнхий сайд, Лувсаннъямын Гантөмөр Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Эрдэнэбилэгийн Одбаяр Монгол улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга, Буяагийн Тулга Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга, Равжихын Эрдэнэбүрэн Монгол Улсын сайд, “20

минутын хот” Үндэсний хорооны дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Оюунсайханы Алтангэрэл Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цэвэгдоржийн Туваан Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Сандагийн Бямбацогт Батлан хамгаалахын сайд, Салдангийн Одонтуяа Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Жамбын Батсуурь Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндийн Баатархүү Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Тогтмолын Мөнхсайхан Эрүүл мэндийн сайд, Хишгээгийн Нямбаатар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Лхагвын Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Лхагвадоржийн Энхбилэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Цэвээнсүрэнгийн Давхарбаяр Шүүхийн сахилгын хорооны дарга, Дэлэгийн Загджав Монгол Улсын Ерөнхий аудитор, Пүрэвээгийн Дэлгэрнаран Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Барсүрэнгийн Баасандорж Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Дэмбэрэлдашийн Баярсайхан Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Дугарын Сүнжид Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, Даньхүүгийн Баянбилэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ядамын Самбууням Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Үндэсний аудитын газрын

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Дэлгэрийн Энхболд Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, Доржсүрэнгийн Саруул Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга, Сүрэнжавын Гансэлэм Улсын ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чимэдцэрэнгийн Цэвэгдорж Соёл, спорт, аялал жуулчлал залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дашичиваагийн Ариунболд Үндэсний аюулгүй байдлын ажлын албаны дарга, Доржсүрэнгийн Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга, Заграагийн Баасанням Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын дарга, Лувсандоржийн Сонор Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Сүхбаатарын Сүхбат Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хүнд үйлдвэр бодлогын газрын дарга, Болдын Отгонцэцэг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга.

Нэлээн олон ажлын хэсгийн гишүүд ирээгүй байна. Тэгэхээр энэ дээр зөвхөн төсвийн тодотголд өөрчлөлт орж байгаа албан газрууд биш, өөр төсвийн хэрэгжилттэй холбоотой асуултууд гишүүдээс гарах болно. Тийм учраас ирцийг сайжруулаарай гэж хэлмээр байна.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.17-д улсын төсвийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй гэж заасны дагуу илтгэл, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөгчийн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Цагаанхүүгийн Мөнхбатаар, нийтдээ 26 гишүүн үг хэлэх юм байна. Батчимэг гишүүнийхийг оруулаарай. Жаргалан гишүүнийг оруулъя. Жаргалсайхан гишүүн. Ингээд 3 гишүүнийг оруулаад үг хэлэх гишүүдийг тасаллаа. Жадамбаагийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Тодотгол дагаж нэлээн олон хууль орж ирж байх шиг байна. Тэгээд энд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэж байна. Үндсэндээ бол нэмэлтээр тодорхой бүр саналууд орж ирж байх шиг байна. Тэгээд энэ хуулийн 36¹ дүгээр зүйл гээд чадавхад суурилсан хэлэлцээний арга гээд нэг ийм ерөөсөө ойлгомжгүй юм орж ирсэн байх юм. Тэгээд энэ дээр нь болохоор юу гэж байна гэхээр бараа, ажил, үйлчилгээний цар хүрээ, төсөвт өртөг өндөр, хоорондоо уялдаа холбоо бүхий хэд хэдэн бараа, ажил, үйлчилгээг цогцоор нь гүйцэтгэх шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай аж ахуй эрхлэгчийн тоо хязгаарлагдмал тохиолдолд гүйцэтгэгчийг энэ зүйлд заасан аргаар сонгон шалгаруулна гээд. Энэ нэлээн том заалт орж ирж байх шиг байх юм. Тэгээд энэ доторхыг нь ингээд үзэхээр ерөөсөө ойлгомжтой асуудал ерөөсөө алга. Миний үзэж байгаагаар бол энэ нөгөө юу гэдэг билээ. Чоно борооноор гэдэг шиг нэг ийм л юм харагдаж байх юм. Энэ хуультай холбоотой түрүүн Нямбаатар дарга бас 2, 3 санал хэлээд байх шиг байна лээ.

Хийх гэж байгаа үйл ажиллагаа, бүтээн байгуулалттай холбоотой асуудлуудыг хялбарчлах, зайлиггүй нэг иймэрхүү хууль оруулах нь зүйн асуудал байж болох л юм л даа. Гэхдээ дахиад хэлэхэд, бид нарын хуучны Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу яагаад явж болохгүй байсан юм. Зайлиггүй ийм зүйл хийх ёстой байсан юм уу. Энэ дотор заалтуудыг чинь эргээд харахаар ерөөсөө ойлгомжтой заалт нэг ч алга. Мэдэхгүй би лав ойлгохгүй юм байна. Тэгээд ингээд бие биеийгээ хэлэлцээний шатанд дараах нөхцөлийг оролцогчтой харилцан тохиролцож болно л гэж байх юм. Чадавхад суурилсан хэлэлцээний арга гэж байх юм. Тэгээд ингээд дотор нь ингээд эргээд харахад захиалагчтай хэлэлцээ хийх асуудлуудыг хооронд нь хэлэлцэж болно, тохирч болно гээд ингээд бүх асуудлуудаа хялбарчлаад, хялбарчлаад явчихсан нэг ийм асуудал харагдаад байгаа юм. Бид нар ерөөсөө ногоон автобустай холбоотой асуудал сөхөгдөөд ерөөсөө удаагүй байна шүү дээ. 2, 3 сарын асуудал өнгөрч байна. Тэр ногоон автобустай холбоотой асуудлын хүрээнд юу яригдаж байсан гэхээр ерөөсөө л тендерийн хуулийг тойрсон асуудал яригдаж байсан шүү дээ. Тойрч байгаад тэгээд баригдаад болохгүй болчихсон. Одоо дахиад тойрохгүйгээр засчхаад оруулж ирж байгаа юм уу гэсэн л ойлголт харагдаж байна л даа. Тендерийнхээ хуулийг засчхаад ороод ирж байгаа юм уу. Шинэ нэмэлт оруулчхаад ороод ирж байгаа юм уу л гэсэн. Тайлбар хэл дээ энэ дээр. Сонсьё.

Б.Пүрэвдорж: Гишүүд яг энэ 2024 оны төсвийн тодотголтой холбоотой, энэ хуулийн төсөлтэй холбоотой асууна шүү. Та бол яг төсвийн дагасан хуулиудтай холбоотой асууж байна. Тийм учраас дараагийн хууль дээр асуучих. Тэгэхдээ сая асуулт дээр Сангийн сайд, Улаанбаатар хотын захирагч Нямбаатар хариулна. 2 номер.

Х.Нямбаатар: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүний асуултад маш товчхон хариулахыг хичээе. Би яагаад хариулж байгаа вэ гэхээр төсвийг дагасан хуулиудыг боловсруулах ажлын хэсэгт гишүүнээр ажилласан хүний хувиар хариулж байна. Энэ удаагийн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуульд дараах 4 гол зохицуулалтыг шинээр оруулж ирж байгаа.

1 дүгээрт сонголтод тендер гэдэг энэ зохицуулалт орж ирж байгаа. Энэ нь томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэхэд тухайн төслийг хэрэгжүүлэхүйц дэлхийн өндөр хүчин чадалтай ийм компаниудад эрэмбэлж байгаад, ранкийг нь харж байгаад тодорхой тооны урилгуудыг тэдгээр компаниудад нэгэн зэрэг хүргүүлнэ. Ингээд хүргүүлсэн тохиолдолд тухай чадавх бүхий компани нь тендерт санал ирүүлнэ. Ирүүлсэн саналуудаас үнэлэлт өгч, сонгон шалгаруулалт хийх арга буюу олон улсын нэршил нь *selected procurement* гэдэг энэ аргыг оруулж ирж байгаа. Энэ аргын үргэлжлэл нь хэлэлцээр хийх эрх зүйг бас оруулж ирж байгаа. Өөрөөр хэлбэл сонголтод тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй хэлэлцээрийн түвшинд цаашид худалдан авах ажиллагааг илүү үр дүнд хүргэх энэ эрх зүйг оруулж ирж байгаа гэсэн 1 дэх ийм зохицуулалт орж ирж байгаа юм.

2 дахь зохицуулалт нь болохоор бүтээн байгуулалт, том бүтээн байгуулалт явуулах гэж байгаатай холбоотойгоор олон улсын зөвлөх инженерүүдийн холбооны үлгэрчилсэн дүрмийн дагуу *ЕРС нөхцөлөөр буюу engineering procurement construction* гэдэг энэ нөхцөлөөр бүтээн байгуулалтыг хийх энэ эрх зүйн зохицуулалтыг үе шаттай нь худалдан авах хуульд оруулж ирж байгаа юм. Энэ дотор концепт дизайн гаргах РМС буюу зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах, зөвлөх үйлчилгээ нь тэр фидикийн дүрмийн аль багцаар одоо зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх, тэр үе

шатыг оруулж ирж байгаа. Үүний дараа *ЕРС* гэдэг нөхцөлөөр буюу түлхүүр гардуулах нөхцөлөөр бүтээн байгуулалтыг хийх энэ харилцааг худалдан авах хуульд оруулж ирж байгаа.

3 дахь гол зохицуулалт бол энэ бараа бүтээгдэхүүнийг сонгон шалгаруулахдаа чанар гэдэг энэ зүйлийг илүү тавихын тулд тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага буюу яам, агентлагууд тухайн чанарын шалгуур үзүүлэлтүүдэд нь үнэлэлт, дүгнэлт өгөх ийм зохицуулалтыг төрийн худалдан авах ажиллагааны хуульд оруулж ирж байгаа гэдгийг х

Тэлье. таны түрүүний асуусан тэр нөгөө 2 удаа тендерийг зарлаад нээлттэй тендер зарлаад, ямар ч санал ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчит компаниар гүйцэтгүүлэх 1 зохицуулалт орж ирж байгаа. Нөгөөх зохицуулалт нь болохоор 2 удаа тендер зарлахад аж ахуйн нэгжүүд оролцсон боловч тендерийн шаардлага хангаагүй гэж үнэлгээний хороо үнэлсэн тохиолдолд үргэлжлүүлээд ажлын 5, 5 хоногоор тасралтгүй зарлах зохицуулалт орж ирж байгаа. Өөрөөр хэлбэл энийг *ОСТ*-ийн санаачилгаар *Станбулын авлигын эсрэг баримт бичигт дурдсанаар захиалагч манипуляц хийж удаа дараа унагааж, шууд гэрээ хийхээс урьдчилан сэргийлэх энэ баримт бичигт манай улс нэгдэж орсон учраас үргэлжлүүлж тухайн тендерт санал өгөөд байгаа тохиолдолд ажлын 5, 5 хоногийн зайтайгаар үргэлжлүүлэн зарлаж тасралтгүй нээлттэйгээр сонгон шалгаруулах энэ олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ бид нар энэ худалдан авах хуульд хэвээр үлдээсэн.*

Саяын таны ярьж байгаа ногоон автобустай холбоотой энэ тэр харилцаа бол нээлттэй тендер зохион байгуулагдаагүй зүйл байгаа. Одоо энэ саяын бид нарын ярьж байгаа тохиолдолд бол нээлттэй тендер дандаа

зохион байгуулах, зарлах асуудал яригдаж байгаа. Жишээлбэл.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тэгэхээр би өнөөдөр анх удаагаа чуулган даргалж үзэж байгаа учраас маш их эелдэг байгаа. Хэдийгээр өөр асуудал асуусан ч гэсэн дахиад тодруулах эрхийг Бат-Эрдэнэ гишүүнд өгч байна.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ асуудлуудыг чинь яах вэ дараа нь би андуурсан юм байна. Зүгээр ингээд л үзээд байхад хамгийн түрүүнд нүдэнд тусаж байгаа асуудал чинь ерөөсөө л энэ байгаа байхгүй юу даа. Энэ дотор. Бид нар энэ тендертэй холбоотой асуудал гэж байна. Сая Нямбаатар дарга хэлж байх шиг байна. ЕРС-ээр явуулдаг гэж. ЕРС-ээр чинь бид нар түлхүүр гардуулах нөхцөлөөр хуучин тендерээр ч гэсэн явж байсан тийм түүх бол байгаа шүү дээ. Яах вэ, хүндрэлүүд байж болох юм. Одоо нөхцөл байдал өөрчлөгдсөн байж болох юм. Тэгэхдээ 1 зүйлийг бид нар буцаад эргээд харах хэрэгтэй. Аливаа зүйлийг өөрчлөөд, аливаа зүйлийг хялбарчлахад номоор нь явж болохгүй бол өөрчилчихдөг, хуульдаа өөрчлөлт оруулдаг. Ингэж явсаар байгаад бид нар дараа нь асуудалд ордог шүү. Дараа нь асуудалд ордог шүү. Энийгээ л анхаараарай. Түүнээс биш дөнгөж тэдийн тэдийн тэдийг тэгж өөрчилсүгэй гэсэн энэ асуудлуудыг чинь би тэр дор нь их хуультай нь тулгаж чадахгүй байгаа болохоор би зүгээр энд гайхширал төрөөд л асууж байгаа асуулт шүү. Их хууль нь байхгүй болохоор энэ асуудлуудыг чинь ерөөсөө үзэж болохгүй байна. Ер нь ингээд харахад зүгээр хөнгөвчилсэн арга хэмжээ .../минут дуусав

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууж, хариулт авна.

С.Ганбаатар: Хуулийг би төсвийн тодотголыг бол дэмжихийн төлөө л яриад байгаа юм. Тэгээд түрүүн тэр Тогтвортой байдлын зөвлөлөөс бол яг

түрүүний миний ярьсан эрсдэлийг ярьж байна шүү дээ. Үг, үсгээр нь ярьж байна шүү дээ. Эрсдэлтэй асуудал байна шүү наана чинь гэдгийг үг, үсгээр нь ярилаа. Хэлэлцүүлгийн явцад засна гэж би найдаж байгаа. Дараа нь энийг ярилцахын оронд. Хамгийн гол 6 асуулт байна.

Хамгийн гол зүйл. Улсын төсвийн урсгал зарлагын 3.2.1-ийн хуудас 39 дээр шилжилтийн хугацаанд хэрэгжүүлэх цогц арга хэмжээний үр дүнд улсын төсвөөс эрчим хүчний алдагдлын татаас олгохгүй байхаар тооцож байна гэж байна. 125 найзууд минь ээ, та нар чинь сонгогчдоо жаргаана гэж орж ирсэн шүү. Одоо эрчим хүчний үнийг нэмнэ гэж энд орж ирчихсэн байгаа. Эрчим хүчний үнийг нэмнэ гэсэн үг, тэр чөлөөлнө гэдэг чинь. Энийг ярихаас өмнө энэ эрчим хүчний салбарт явдаг том том, булай булай мафийн структуртай том том компаниудын цөм цөм иддэг тэр тендерүүдийн асуудлыг шийдсэн үү. Өнөөдөр ханины зардлаа, ханины өсөлтөө бид дийлэхгүй байж байж ард түмний нуруун дээр цахилгааны үнэ хэлбэрээр тавих гэж байна. Доллар 1300 байхад авсан эрчим хүчний том төхөөрөмжүүд одоо доллар 3400 болчихсон үед тэд нарын нуруун дээр эрчим хүчний үнээр зодох гэж байна. Энийгээ эргэж хараарай. Ийм төсөв батална гэж байхгүй гэдгийг уламжилъя.

2 дугаар асуулт төсвийн орлоготой холбогдуулж ярья. Орлого өссөн. Агуу агуу. Үнэхээр давуу талтай. Төсвийн орлогын өсөлт 2,9 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн байгаа. Түүний 58,6 хувь нь ААНОАТ байгаа шүү. 1,7 их наяд. Энэ бүтээмж нэмэгдээд явчхав уу, тэр компаниуд гэнэт сайхан ажиллачхав уу. Яагаад татварын орлого 1,7 их наядоор нэмэгдсэн бэ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн үү, үйлдвэрлэл үйлчилгээний орлогын өсөлт үү, эсвэл инфляц уу. 2 дугаар асуултаа би асуучихлаа.

3 дугаарт төсвийн орлогын өсөлттэй холбоотойгоор маш сонин асуулт байна. Энэ ХХОАТ-ыг 539 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Шалтгаан нь юу вэ. Энэ дунд хамгийн сонирхолтой юм нь төрийн албан хаагчдын цалинг 111,2 тэрбум төгрөгөөр бууруулсан байгаа. Энэ цомхотгол явчихсан уу. Эсвэл одоо цалин нэмээд л байх шиг санагдсан. Баахан орон тоонуудыг нь байхгүй болгочихсон юм уу. Энэ эсвэл тооцооны алдаа юу.

4 дүгээр асуулт Төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн нийт зарлагын 3,1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсний 1,7 их наяд төгрөг нь хөрөнгийн зардал, 1,2 их наяд нь төгрөг нь урсгал зардал байна. Одоо 4 сар үлдчихсэн шүү дээ. 4 сар үлдсэн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Эхний асуулт дээр Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Эрчим хүчний салбар хүнд байгаа нь үнэн. Одоо чинь ингээд 102 жил, 103 жилийн түүхтэй салбар байгаа юм. 1990 оноос хойш сүүлийн 34 жилийн хугацаанд бол үнэхээр зах зээл маань бид нар макро тэнцвэрээ хадгалж чадаагүйгээс шалтгаалаад таны яриад байгаа ханшийн нөлөөлөлд орж байгаа нь үнэн. Бид нар нөгөө эрчим хүчний үнийг улсаас зохицуулалттай. Тариф, үнэ биш. Зах зээлийн үнэ биш, тариф болгож мөрдсөнөөс шалтгаалаад алдагдалтай ажилсан байна. Өнөөдрийн байдлаар 2,3 их наяд төгрөгийн эрчим хүчний салбарын төрийн өмчит компаниудын өр ийм байна. Үүнээс 470 орчим тэрбум төгрөг нь богино хугацаатай өр төлбөр, цаана нь 1,8, 1,9 орчим их наяд төгрөг нь урт хугацаатай ийм өр дамжуулан зээлдүүлэх ийм өр байгаа. Зах зээлийг эрчим хүчний салбарыг энэ удаан тарифыг хөнгөлөхгүй явснаас шалтгаалаад манай салбар үнэхээр хүнд байдалд орчихсон. Энэ жилийн тухайд 2024 оны тухайд 218 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай

ажиллахаар байгаа. Үнэ тарифыг бид нар 2022 оны 12 сарын 1-нд 1 удаа нэмэгдүүлсэн. Бас нэлээн их эсэргүүцэлтэй хүндрэлтэй тулсан. 2020, 2021, 2022 онуудад бол дэлхий нийт хүн төрөлхтөн бүгдээрээ ковид цар тахал өвчинд нэрвэгдэж байсныг та санаж байгаа. Өнгөрсөн 2023 онд арай гайгүй эдийн засаг өссөн. Экспорт 15 хувьд хүрсэн, эдийн засаг 7 хувьд хүрсэн. Эдийн засгийн өсөлт иргэдийн орлогод нөлөөлтөл 6-18 сарын хоцрогдолтой явдаг ийм тогтолцоо байгаа учраас энэ оны төгсгөл, ирэх оны эхнээс эрчим хүчний үнийг өртөгт нь хүргэх зайлишгүй шаардлага тулсан нь үнэн.

Ийм учраас хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 1 нөхцөл нь бол энэ эрчим хүчний салбарыг либералчилъя. Үнийг доор хаяж өртөгт нь хүргэдэг ийм тогтолцоо, ийм шийдвэр гаргая гэсэн ийм хүнд хэцүү шийдвэр бид нарт хүлээгдэж байгаа нь үнэн. Ингэхгүй бол манай энэ салбар өсөлт, тэлэлт байхгүй. Сүүлийн жилүүдэд эдийн засаг 7 хувьтай өсөхөд цахилгаан эрчим хүчний хэрэглээ жилийн дүнгээрээ энергийн хувьд 6,8 хувьтай. Яг чадлын хувьд 11, 12, 1, 2, 3 дугаар сарууд дээр бол 11,8 хувьтай өсөж байгаа ийм хүндрэлтэй нөхцөлүүд байгаа учраас энийг бол та яг зөв хэллээ. Ийм асуудал байна.

2 дахь асуудал нь эрчим хүчний салбар дээр байгаа компаниуд мөнгө угаадаг, хуульд завхруулдаг ийм хардлага та ярилаа. Яг тодорхой мэдээлэл байвал Улсын Их Хурал дээр бас шалгах эрх нь байгаа шүү дээ. Хяналт шалгалт. Энийг ингээд тантай хамтраад шалгахад бэлэн байна.

Б.Пүрэвдорж: Дараагийн төсвийн орлого, өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжийн орлого, хүн амын орлогын нэмэгдэл яагаад ийм өндөр болсон юм. Дээрээс нь төрийн албан хаагчдын цалингийн зардлын бууралтын талаар 5 номер Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. 2024 оны төсвийг бид нар төлөвлөж байхдаа бол макро эдийн засгийн бодлогуудаа бол төлөвлөж байхдаа бол дотоодын нийт бүтээгдэхүүнийг бид энэ жилийн хувьд бол 74 их наяд, дээрээс нь бид бол эдийн засгийн өсөлтийг бол 7, дээрээс нь нүүрсний экспортыг бол 60 сая тонноор гарна гэж тооцож байсан.

Эхний 1 дүгээр улирлын байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн бол 16,4 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь бол өмнөх жилийн яг 1 дүгээр улиралтай харьцуулах юм бол 19,3 хувь буюу бараг 20 орчим хувиар нэмэгдчихээд байгаа юм. Сая 2 дугаар улирлаар бол эдийн засаг 5,6 хувьд хүрсэн. Нүүрс яг өнөөдрийн байдлаар бол 51 сая тонн гарчхаад байгаа. Өөрөөр хэлбэл энэ жилийн бид нар энэ төлөвлөж байсан хэмжээндээ бараг ингээд дөхчихсөн.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үндсэн асуулт бол уг нь Санжаадоржоос асуусан. Тийм учраас 3 номерын микрофоныг дахиад өгье.

М.Санжаадорж: Тийм орлогын хувьд бол эдийн засгийн идэвхжил явсан. Татварын хувь хэмжээ бол огт нэмэгдээгүй. Харин эдийн засгийн идэвхжил явж бидний тооцоолж байснаас илүү идэвхтэйгээр экспорт нэмэгдсэн байгаа. Үүнтэй холбоотойгоор бол ХХОАТ нэмэгдсэн. Энэ нь өөрөө бид нар энэ жил дунджаас дээгүүр өр орлоготой улсын хэмжээнд орсон. Манай өрхийн орлого нэмэгдсэнтэй холбоотой өөрөөр хэлбэл цалин хөлсний нэмэгдэл бол бидний тооцож байснаас өндөр байсан. Энэ хувийн сектор дээр илүү их харагдсан. Төрийн сектор дээр бол ижилхэн байгаа. Мөн Эрдэнэс Тавантолгойгоос ноогдол ашиг бол хуваарилсан байгаа. Энэ жилийн хувьд. Энэ бол бид нарын тооцоонд бас орж ирээгүй байсан. Энэ ноогдол ашгийн хувь хүний орлогын албан дотор бол бас нэмэгдсэн байгаа. Дийлэнх нь ер нь уул уурхайтай холбоотойгоор экспортын

орлоготой холбоотойгоор ААНОАТ бол нэмэгдэл орж ирж байгаа.

Б.Пүрэвдорж: Гүйцээгээд Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ер нь би ч гэсэн бас сая наадхад чинь санаа зовж л байна. Гэхдээ бид маш том үүрэг хариуцлага авч байгаа. Энэ Их хурал, Их Хурлаас байгуулагдсан хамтарсан Засгийн газар маш том үүрэг авч байгаа. Бидэнд нэг өдөр ч гэсэн маш чухал байгаа. Тийм учраас ийм том зорилт тавиад, тэгээд л үзнэ дээ. Сайд нар маань энэ дээр том төсөл хариуцаж байгаа сайд нар маань бас энэ дээр нэмж хэлбэл сайн байна. Ер нь амжуулна л гэж бүх хүчин чадлаараа л ажиллана.

Б.Пүрэвдорж: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулна.

С.Ганбаатар: Чойжилсүрэн сайд аа, тэгээд ханшийн өсөлт бол цахилгаантай ямар ч хамаагүй. Тэр Монгол банк нь хариуцах ёстой. Тэр булиа булиа тендерүүдийн асуудал Монгол орон даяар ярьдаг. Тэрийг нягталж тодорхой болгож, ямар ч хулгайгүй байсан юм гэдгээ тодорхой болгоод, дараагийн асуудлыг яриарай. Цахилгааны өсөлтийг нэмэхээс өмнө митигэйшин гэж ярьдаг зөөллөх бодлого, урьдчилсан бодлогоо заавал хийхгүйгээр дараа нь гал болов.

2 дахь зүйл гэвэл 7 том төсөл ярьж байгаа. Энэ тодотголоор орж ирж байгаа. Аж үйлдвэржилттэй холбоотой мөнгөөр мөнгө хийдэг төсөл нэг ч байхгүй. Бүгд дүүжин гүүр гэнэ үү, туннел гэнэ үү, дэд бүтцийн төслүүд. Мөнгөөр мөнгө хийдэг юм байхгүй. Аж үйлдвэржилтийн 1 ч төсөл энэ дотор байхгүй байгаа. Тэгээд 2,9 их наяд төгрөгийг гадаадын зээл, санхүүжилтийн санхүүжүүлж байгаа. Энэ талаар бас дүгнэж нягталж ярих цаг болсон гэдгийг бас үг хэлэх дээрээ л явж байх шиг.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ.
Мөнгөнцогийн Ганхүлэг асуулт асууна.

М.Ганхүлэг: Гишүүддээ болон ажлын хэсгийн гишүүддээ бас оройн мэндийг хүргэе. Олон нийт маш өндөр хүлээлттэйгээр бид бүхнийг бас ажиглаж байгаа. Ер нь залуучууд ч тэр ажлаа хийхийг л ерөнхийдөө шаардаад байгаа. Бодитой үр дүнг бас хүлээгээд байгаа. Энэ утгаараа энэ удаагийн хамтарсан Засгийн газрын хамгийн том давуу тал нь бол тодорхой үр дүнг гаргах, урт хугацааны томоохон төслүүдээ явуулах, энэ ажлуудыг бас хийнэ гэдэгт бол бас итгэл найдвар бас өгч байгаа юм. Энэ утгаараа нэлээн ажил хэрэгчээр хандаж урт хугацааны томоохон төслүүдийг техник-эдийн засгийн үндэслэлүүд энэ боловсруулах чиглэлээр бас орж ирж байгаад бол талархалтай байна. Энэхүү төсвийн тодотгол явснаараа нийслэлийн олон асуудлууд бас эхлэх нь гэж харж байна. Газар чөлөөлөлтийн асуудал болон бусад томоохон ТЭЗҮ-үүд бас явах нь. Энэ дундаас ирэх 2025 оны хөгжлийн бас гол төсөв чиглэх гол ажил бол энэ бүсчилсэн хөгжлийн зорилтын ажил байгаа юм. Тэгэхээр үүн дээр бол 70 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг тавиад, ингээд бүс болгон дээр 10, 10-аар нь бас ингээд хувааж байгаа юм байна. Тэгэхээр яг үүний зарцуулалт, зохион байгуулалтын хэлбэр нь аль газраа явах вэ. Аль Шадар сайд хариуцах вэ. Иргэд олон нийтийн саналуудыг авах, дээрээс нь гишүүд бас ямар байдалтай бас оролцох, мөн одоо бас цаг хожиж орж ирж байгаагийн хувьд бол энэ 2025 оны бас төсөвт тодорхой эхний бүсүүд дээр тавигдсан энэ бүтээн байгуулалтын ажлуудыг бас оруулах боломж байх уу. Тэгж харж бас тодотгоод оруулж оруулж ирж байна уу гэдэг эхний асуулт байгаа юм.

2 дахь нь орон нутгийн иргэдийн хувьд бол Шинэ хоршоо хөдөлгөөнтэй холбогдолтой нэлээн их асуулттай байна. Өдөр тутам бас ирж байгаа асуултуудын дийлэнх нь бол үүнтэй

холбогдолтой. Энэ хөдөлгөөн 2024 оны 4 сарын 19-нд батлагдсан хуулиас эхлээд бол эхэлсэн. Ингээд 1343 хөдөө аж ахуйн хоршоо байсан бол өнөөдөр бол 3900 орчим 4000 орчим болж нэмэгдсэн байгаа. 2, 3 сарын дотор тодорхой үр дүнгүүд бол гарсан. Энэ жилийн тодорхой бас амлалтууд бас байгаа. Энэхүү амлалтын тодорхой зээлүүдийг энэ тодотголд орж ирсэн санхүүжилтээр бүрэн хийх боломжтой гэж үзэж байгаа юу. Өшөө бас нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагууд бас байна. Тэгэхээр энэ дээр бас анхаарал хандуулсан байдлыг нь бас дэлгэрүүлж асууя.

Мөн дээрээс нь цаашидын зохион байгуулалт, менежментийн чиглэлийг нь бас ХААЯ руу шилжиж байгаа гэж ойлгосон. Хэчнээн хүний бүрэлдэхүүнтэй, ямар байдлаар ажиллах вэ гэдэг энэ чиглэлийн бас мэдээллийг бас асууя.

Мөн газар тариалангийн салбарынханд амласан 100 тэрбум төгрөгийн бас санхүүжилтийн асуудал байгаа. Тэгээд энэ асуудлыг тодотгол дээр оруулж ирсэн үү. Тухайн үед бас энэ гурилын үнийг буулгахтай холбогдолтой асуудал дээр ийм амлалтыг бас өгч байсныг бас санаж байна.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Ганхүлэг гишүүний асуултад Сангийн сайд Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Шинэ хоршоо, чинээлэг малчин төслүүд Засгийн газрын хөтөлбөр дотор орсон байгаа. Тэгээд энэ хөтөлбөр батлагдмагц энэ санхүүжилт саадгүй үргэлжлүүлээд явна. Тодотгол дээр энэ 123 тэрбум төгрөгийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багцад нэмэгдэж байгаа энэ дүн дотор орчихсон явж байгаа. Ер нь бол энэ жилдээ 500-аад тэрбум төгрөгийн зээл, хөрөнгө оруулалт очих болов уу гэж бид төсөөлж байсан. Одоо бараг 400 гарчихсан явж байна. Тэгэхээр энэ үлдэж байгаа 100 хүрэхгүй дүнд хүүгийн

хөнгөлөлт татаас дээр бол энэ дотор байгаа 40 гаруй тэрбум төгрөг бол бүр хангалттай хүрнэ. Хангалттай хүрэх учраас одоо гол нь зүгээр хөтөлбөр дээр батлагдаад л цаашаа явах л илүү их баталгаа нь болно гэсэн үг. Төсөв талдаа бол санаа зовох зүйлгүй. Шинэ төслүүдийн хувьд бол бид энэ удаа тодотголоо оруулж ирж байгаа. Шадар сайд маань нэмж хариулбал нэмэлт мэдээлэл өгнө биз. Эрэмбэлж байгаад хамгийн шаардлагатай, нэн тэргүүний 5 том төслөө оруулж ирж байгаа.

Мөн одоо 2 том төслийг нийслэл өөрсдөө тэндээ хариуцаад төр, хувийн хэвилийн түншилэл болон бусад төсөв дээрээ өөрсдөө ачааллаа аваад явъя гэсэн нэлээн том бас хариуцлага авч байгаа. Тэгэхээр өөр төслүүд бол дараа дараагийн төсвүүд дээр яригдаад явна. Энэ удаа бол яг та бүхэнтэй танилцуулсан энэ төслийнхөө хүрээнд л явна.

Газар тариалан дээр ямар амлалт байсан юм бол доо. Ямар нэг амлалттай холбоотой хавар өгч байсан газар тариалантай холбоотой энэ төсвийн тодотгол дээр бол юм байхгүй. Энэ төсвийн жилд хэрэгжиж байгаа, бүтэн хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдтэй л холбоотой ийм зүйлүүд байгаа.

Хэрвээ та зүгээр тариалан, улаан буудай худалдаж авах асуудалтай холбож ярьж байгаа бол нөөц бүрдүүлэх, нөөцийн бодлогын хүрээнд л байна уу гэхээс зах зээлийн үнэ унаснаас болоод зөрөө алдагдлыг нь нөхөж өгдөг татвар төлөгчдийн мөнгөөр энийг нөхдөг тийм зүйл рүү бид явж орж болохгүй. Бид нар чинь зах зээлийн нийгэмд ороод 34 жил болж байгаа шүү дээ. Тийм учраас ийм зүйл рүү бол бид нар явж орж болохгүй. Зөвхөн нөөцийн хэмжээний бодлогын хүрээнд л арга хэмжээ авах төсөв нь 2024 онд аль хэдийн тавигдчихсан. Энэ хүрээндээ төсвийн ерөнхийлөн захирагч, сайд энэ ажил нь байх гэж ингэж бодож байна. Тэр бүтэц аль бүтцийг асуусан бэ.

Шинэ хоршоо юу. Тэр Хүнс, хөдөө аж ахуйн сайд дээр багтсан. Шилжиж байгаа.

Б.Пүрэвдорж: Энд чинь одоо ингээд Ардчилсан намаас сонгогдсон 4 сайд, Ардын намаас сонгогдсон 2 сайд сууж байна. Тийм учраас энэ сайд нарын оролцоог сайжруул. Дээрээс нь Ганхүлэг гишүүн чинь Хүнс, хөдөө аж ахуйн яамны асуудлыг асуугаад байна шүү дээ. Ганхүлэг гишүүн дахиад тодруулъя.

М.Ганхүлэг: Жавхлан сайд аа, иргэд олон нийтийн хүсэлт бол нэлээн их байгаа шүү. Одоо төслүүдээ бүх банкнууд бол хаачихсан байгаа. Шинэ хоршоо хөтөлбөрийн хүрээнд хоршоод бол нэлээдгүй хэмжээгээр байгуулагдсан. Одоо хамгийн сүүлийн мэдээллээр бол 500 тэрбум бол аль хэдийн давчихсан байгаад байгаа юм. Тэгэхээр бас 12 сарыг дуусталх энэ хугацаа бас нэлээдгүй байгаад байгаа. Тэгэхээр бид нарын бас тооцсон энэ төсөвт хэмжээг нэмэгдүүлэх, илүү энэ асуудал дээрээ малчид бол зээлээ тэглүүлъя. 1 удаагийн халамж авъя гэж хэлэхгүй байгаа шүү дээ. Энийг бол үндсэндээ өөрсдөө ашиглаад, тодорхой одоо асуудлаа шийдээд, энэ өвлийн нөхцөл байдлыг даван туулах энэ чадвараа сайжруулъя гэдэг. Тэгээд 1 их тодорхой болсон зүйл нь бол нэгдэхгүй юм байна, хамтрахгүй юм байна гэдэг энэ ойлголт бол үгүй юм байна гэдгийг бол сая энэ 2, 3 сарын дотор бас харууллаа л даа. Маах их хэмжээгээр бол малчид нэгдэж, нийлээд одоо ингээд жосоохон дэмжлэг юмнуудаа нэмээч ээ гэдэг ийм зүйл байгаа юм. Тэгэхээр асуулт нь бол өшөө жосоохон нэмэгдүүлээд өгөх.../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуулт асууна.

Д.Пүрэвдаваа: Хэд хэдэн асуулт байна. 1 дүгээрт энэ статистикийн талаар асуумаар байна. Одоо төсөв ингээд харахаар зэрэг 22 их наяд байсан

төсөв нэг жилийн дотор 27 болоод 3-аар нь нэмээд тодотгоод, 30 болгох гэж байгаа юм. 2023 онд 22 байсан. Сонгуулийн жилийнх гээд нэлээн хэл ам дагуулсан. Тэгээд нэлээн ч үсрэнгүй гэнэт өссөн ийм төсөв болсон. Тэгээд яг үүнээс улбаалаад энэ ажилгүйдэл ядуурал хэдэн хувиар буурчхав. 1 дүгээрт.

2 дугаарт яг энэ эдийн засгийн 7 хувийн өсөлт чинь иргэдийн хөргөгчид ер нь яаж өөрчлөлт ороод байгаа юм бэ. Тэрийг маш ойлгомжтойгоор нэг хариулж өгнө үү гэж хүсэх байна.

Дараагийнх нь энэ хэмнэлтийн асуудлыг бас яримаар байна. Төрийн хэмнэлтийн тухай хууль гэж байдаг гэж ойлгосон. Тэгээд энэ сонгууль хийгээд төрийн байгууллагууд төрийнхөө ажлыг ер нь төрийн энэ мөнгөө бараг сайн үрээгүй байх гэж төсөөлж байна. Тийм учраас энэ төрийн байгууллагууд дээр байгаа дансны үлдэгдэл, тэгээд энэ ирэх 4, 5 сард үрэгдэхгүй, хэрэгжихгүй болсон төслийн тоо хэмжээ, эд нарыгаа яаж тооцсон юм бэ гэдгийг бас асуумаар байна. Жишээгээр энэ төсөл дээр орж ирж байна л даа. Манай Улсын Их Хурлын төсөвт тэр 5 тэрбум төгрөгөөр сургалт гээд тодотгол дээр орж ирж байна. Энэ нөгөө гадаад явдаг төсөв үү. Эсвэл өөр төсөв үү. Мөн энэ ирэх 4 сард Их Хурал маань юу сурдаг юм. 4 сард 5 тэрбум төгрөгөөр.

Тэгээд халамжид сонгууль дууссан юм чинь би энэ халамжийн сайдаас юм асуумаар байна. Жишээгээр энэ Социал д Демократ нам бол энийгээ хийх нь зөв байх. Одоо тэгээд бас нэг жоохон барууны намтай нийлсэн юм чинь энэ халамжийн бодлого нь хэдэн хувиар буурсан юм. Нийт давхардсан тоогоор 2 сая хүн халамж авдаг юм гэсэн. Тэрийг тодорхой асуумаар байна. Тэгээд энэ төслүүдээ эрэмбэлэхдээ хэрхэн, ямар хөндлөнгийн байгууллагаар хянагдаж эрэмбэлэгдсэн юм бэ. Нийслэлд бол би дүүргийн болон нийслэлийн төлөөлөгчөөр ажиллаж байсан хүний хувьд нийслэлд

хөрөнгө тавих дээр бол 100 хувь санал нийлж байна. 1 минутаа авчихъя.

Б.Пүрэвдорж: 1 минут Пүрэвдаваа гишүүнд.

Д.Пүрэвдаваа: Тэгээд энэ асуудлыг эрэмбэлэхдээ их учиртай эрэмбэлмээр байна. Одоо бүхний л ил байгаа шүү дээ. Энэ Яармаг, Зайсан гэхээр л хөрөнгө оруулалт нь ёстой хангалттай тавигддаг. Одоо Улаанбаатар хотоо дүгнэх юм бол гэр хороолол гээд нэг тусдаа кластер, Яармаг, Зайсан гэдэг нь тусдаа бүр хэт хөгжчихсөн хэсэг. Ингээд дундаж хэсэг гэдэг шиг ийм ангилагдсан хэсэг байгаа. Тэгээд энэ гэр хороолол ялангуяа энэ сонгогдсон зарим удирдлагуудаасаа хамаараад энэ Баянзүрх дүүрэг бол орхичихсон байдаг юм. Төсөл хөтөлбөр хэрэгждэггүй. Нэг тийм ялгавартай хандаад байгаа юм шиг санагддаг юм. Буруу, зөрүү ярьсан бол бас авах гээхийн ухаанаар хандана биз. Тэгээд энэ төсөл хөтөлбөрөө маш сайн эрэмбэлэх асуудлаа тодорхой хариулж өгнө үү. Тэгээд нийслэл дээр хөрөнгө тавьж байгаад бол талархаж байгаагаа дахин дахин хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Пүрэвдаваа гишүүний асуултад хариулъя. Тэр төсвийн өсөлтүүдийг та тоонуудаа түрүүн миний хэлснээс дутуу харчхав уу, яав. Тийм 5 их наяд, 6 их наядын өсөлт байхгүй шүү. Ер нь жилд дунджаар 2,5-3,3 их наяд орчмын ийм өсөлттэй, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэйгөө уялдаж ингэж явж байгаа ийм төсөв юм байгаа юм. Ер нь бол дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ ер нь 33-35 хувийн орчимд сүүлийн 6 жил явж байгаа. Абсолют дүнгээр нэмэгдэж байгаа болохоор ингээд нэмэгдэж байна гээд энэ дээр ингээд улс төрийн хэллэг орж ирээд байдаг юм. Тэрнээс биш дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ өсөлттэй уялдсан, өөрөөр хэлбэл эдийн засгийн өсөлтөө дэмжсэн байдлаар төсөв маань ингэж

шилжилт хийж явж байгаа гэдгийг би товчхон хэлье.

Энэ Батдаваа дарга байгаа байх тийм ээ. Энэ өрхийн орлогыг бол Статистикийн ерөнхий газраас гаргадаг байгаа. Тэгэхээр тэрийг бид юу гэдэг юм өөрсдөө төсвийн өсөлттэй холбоотойгоор өрхийн орлогууд ингэж нэмэгдэж байгаа гэж ингэж тайлбарлах нь бол утгагүй. Тийм учраас хөндлөнгийн энэ статистик гаргадаг газраас бодит тоонуудыг хэлж өгнө үү.

Ерөнхийдөө бол төрийн албан хаагч нар цалин болон бусад ингээд нэмэгдэл тэтгэмжүүдээрээ ингээд өрхийн орлогод бол шууд нөлөөлөөд явдаг. Энэ төсвийн энэ хөрөнгө оруулалт гэж байгаа зүйлүүд чинь бүгд аж ахуй нэгжүүдээр дамжаад, энэ цалингийн орлогоор дамжаад, мөн дамжсан худалдан авалтуудаараа дамжаад ер нь жилдээ 20-30 мянган аж ахуйн нэгж дээр энэ төрөл бүрийн орлого болж очдог. Энэ бол эдийн засагтаа хамгийн эцэстээ иргэд дээр шингэж очдог ийм зүйлүүд байгаа юм. Харин бид ер нь зорилтот бүлгийг бол энэ төсвийн бодлогоор нийгмийн халамжийн чиглэлээр бид хэзээ ч хаяж болохгүй. Түүрхэн энэ талаар Энх-Амгалан сайдаас асуусан. Одоо гүйж орж ирээд хариулах байх гэж найдаж байна.

Хэмнэлт. Хэмнэлтийн хуулийг бид нар 2022 оны 4 сард гаргасан амжилттай гаргасан. Үе үеийн Сангийн сайд нар л Хэмнэлтийн хууль гаргачих юм сан гэж бодож явж байсан байх. Энэ хууль түүхэн үүргээ гүйцэтгэж байгаа. Одоо бид харин их амархан мартчихаад байдаг юм. Нэг жилийн л ой санамжтай юм шиг байгаа юм. Одоо хэмнэлтийн хууль болохгүй хууль болчихсон байна. Энэ хэмнэлтийн хуулиас болоод зарим төрийн үйл ажиллагаа гацахад хурч байна гэсэн ийм зүйлүүд их гарах болсон. Харин үүнээс давлагаан доор тэгээд энэ хэмнэлтийн хуулиа цуцлаад хаячих вий. Энэ хуулиа хэдүүлээ хадгална шүү. Энэ дээр та бүхэн

дэмжээд, хамгаалаад явна байх гэж ингэж бодож байна.

Төрийн байгууллагуудын дансны үлдэгдэл гэж бид төрийн сан буюу нэгдсэн дансны ийм томоохон өөрчлөлт рүү ороод энэ чинь одоо бараг 14 жил болчхов уу даа. Тэгэхээр төрийн байгууллагууд өөрсдөө ийм данс нээлгээд, тэндээ үлдэгдэлтэй байдаг тийм үе бол өнгөрсөн. Төрийн сан бүгдийг нь хянаад, 1 дансанд төвлөрүүлээд ингээд явдаг болсон байгаа шүү. Яах вэ, төсвийн ерөнхийлөн захирагч нарын гүйцэтгэл, тэдгээрийн төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой, ийм гүйцэтгэлтэй холбоотой, тэдгээрээр дамждаг, түр байдаг ийм үлдэгдлүүд бол байдаг. Тэрнээс биш тухайн жилийн төсөвтэй холбоотой, урсгал данстай холбоотой, орлоготой нь холбоотой энэ дансны үлдэгдлийг нэгдсэн байдлаар төрийн сан дээр бас удирддаг болоод бид удаж байгаа.

Мөн Их Хурлын Батбаатар дарга байх шиг байсан. Сургалтын 5 тэрбум төгрөгийг юунд зарцуулах вэ. Ядуурал буурсан уу. Энх-Амгалан сайд хариулах ёстой.

Төслүүдээ яаж эрэмбэлэх вэ. Хөндлөнгийн байгууллагаар эрэмбэлүүлэх үү гээд. Хэрвээ хөндлөнгийн байгууллагаар эрэмбэлүүлээд хийдэг ер нь Засгийн газар гэж байгаад ч яах вэ дээ. Төсвийн ерөнхийлөн захирагч нар сайд нар гээд байгаад ч яах вэ. Тийм учраас энийгээ бүрэн Засгийн газар өөрсдөө нэг .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Одоо Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

С.Цэнгүүн: Тэгэхээр төрийн мөнгө гэж байдаггүй, татвар төлөгч нарын л мөнгө гэж байгаа юм. Тэгэхээр бид нар зайлшгүй гарах шаардлагагүй онцын ач холбогдолгүй төслүүдийг царцааж байгаад, одоо энэ шинэ Засгийн газраас гаргаж хийх үнэхээр нийгмийн реформын

чанартай том төслүүдээ хөдөлгөө гэдэг байдлаар энэ хамтарсан Засгийг байгуулсан байгаа. Тэгэхээр эндээс ингээд хараад үзэхээр 2024-2026 оны хооронд 24 сумд шинээр соёлын төв барина гэж оруулсан байгаа юм. Тэгэхээр үүний нийт зардал нь бол 100 тэрбум төгрөг байгаа байхгүй юу. Тэгэнгүүт шинэ Засгийн үед төлөвлөж байгаа эрчим хүчний либералчлахтай холбоотой зардлыг жишээ дийлэнх нь эндээс гаргаад авчхаж болж байгаа бид нар. Тэгэхээр 1 сумд соёлын төв барина гэдэг чинь ганцхан бариад зогсохгүй, үүний дараагаас нь улсын төсөв дээр урсгал зардал нь гээд л маш их мөнгө гараад л явдаг. Бид нар энийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхээр бид нар одоо энэ зардлыгаа царцаагаад, шилжүүлэх байдлаар жишээ нь оруулах боломж байгаа юу гэдэг нэг асуулт байна.

Дараагийн асуулт нь болохоороо ихэнх гишүүд бол одоо иргэдийн болон иргэдийн анхаардаг зүйл нь болохоороо бүтээн байгуулалттай холбоотой. Бид нарын өнөөдөр хэлэлцүүлж байгаа юун дээр бол 8 их наядын дотор бол яриад дууссан. Гэтэл 22 их наядар тоологдож байгаа Засгийн газрын урсгал зардал дотор маш их зүйлүүд байна. Тэгэхээр энэ дотор жишээ дурдаад харахад бол нийгмийн халамжийн сангийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж гэж байна. Тэгэхээр энэ дотор бол 2023 оноос 50 хувь нэмэгдүүлээд, 2024 он дээр бол 84 тэрбум болгоод оруулаад ирсэн байгаа. Тэгэхээр энэ мөнгөн тэтгэмжийн зарцуулалт нь юу болсон бол. Тэгээд үргэлжлүүлээд хэрвээ зарцуулж дуусаагүй байх юм бол энийгээ үргэлжлүүлээд өгөх гэж байгаа юм уу.

Ингээд Ерөнхий сайд ч гэсэн хэлж байгаа. Бид нар халамжийн улс биш, ажил хийдэг хөдөлмөрч улс болъё гэж нэрлээд байгаа юм. Тэгээд тийм юм бол ийм мөнгөн тэтгэмж гэсэн нэртэй 2024 ондоо 50 хувиар нэмэгдүүлээд ороод ирчихсэн байгаа энэ зүйлийгээ танах боломж байгаа юу гэж асууя.

Б.Пүрэвдорж: Цэнгүүн гишүүний асуултад Сангийн сайд Болдын Жавхлан хариулна.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Ихэнх зүйлүүдтэй нь чинь ерөөсөө санал нийлэхгүй байна. Төсвийн хуулийг 1 уншихвал зүгээр юм байна. Одоо 2025 оны бүтэн төсөв ороод ирэхээс өмнө энэ Төсвийн хууль дээр нэлээн хэд хэдэн өөрчлөлтүүд байгаа. Таны асуусан асуулттай холбоотой. 29.3.6 гээд заалтыг уншаарай. Өмнө нь бол яах вэ бид Засгийн газраас 2023 онд оруулсан өөрчлөлт 1 санал байсан юм. Тэр нь төсвийн жилийн хагас жилээр төсвийн гүйцэтгэл муу явж байгаа, тендер нь зарлагдаагүй, амжаа ч үгүй бүр ийм төслүүдийг ер нь зогсоогоод, ингээд төсвийн хэмнэлт хийгээд явъя гэдэг ийм санал оруулж ирж байсан. Гэхдээ энэ бол тэгээд хууль тогтоох дээд байгууллага, парламент дээр бол дэмжигдээгүй. Төсвийн дундуур нэг ч төсөл зогсоож болохгүй гэдэг ийм заалттай. 29.3.6. Энэ 1 дүгээрт ингээд яг хууль нь өөрөө зөрчигдөж байгаа учраас энэ боломжгүй.

2 дугаарт та тэр соёлын төвийг жишээ авах юм. Бодвол та Улаанбаатар хотод төрж өссөн хүүхэд юм шиг байна. Хөдөө гадаа явдаг уу, үгүй юу. Хөдөө суманд очихоор энэ Соёлын төв гэдэг чинь тэр сумын ард түмний цугладаг ганц газар байдаг шүү дээ. Одоо энэ орон нутгаас сонгогдсон гишүүд очихоороо соёлын төв нь хаана вэ гээд л хамгийн түрүүнд хайгаад л давхидаг. Улаанбаатар хотын иргэд соёлын үйлчилгээ авах болохлоороо их гоё театрт очоод соёлын үйлчилгээгээ авдаг. Сумд очихоороо та тэгээд бүх Соёлын төвүүдийг нь зогсоож хаяад яах вэ, нөгөө даавуу татаж байгаад, тэгээд тэр дээр кино үзэх үү. Гадаа цуглаж байгаад соёлын үйлчилгээ үзэх үү. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалт энэ төр өөрөө ард түмэндээ хүргэх ёстой, ялангуяа нийгмийн суурь үйлчилгээнүүдийг, энийг чиглэсэн яг хүн дагасан ийм хөрөнгө оруулалтын бодлого байдаг юм. Тэрийг

татаж авчраад Улаанбаатар хотод л ерөөсөө ийм соёлын үйлчилгээ юмнууд байх ёстой. Хөдөө орон нутагт байхгүй гээд. Яах вэ харамсалтай нь урд талын төслүүдийг ярьж байхад бас нэг иймэрхүү санаанууд цухалзаад л байдаг байсан юм. Тэгээд шинэ парламент цуглаад бас эхнийх нь та боллоо. Энд манай Соёлын сайд байсан бол нэлээн л юм хэлэх байх. Тийм учраас иймэрхүү төслүүдийг нэр дурдаж байгаад энийг гацаана гэдэг бас бүр байж болохгүй зүйл шүү.

Одоо би нэг хэдэн жишээ хэлье. Алтанхуяг Ерөнхий сайд байхдаа нэлээн олон төслүүдийг гацаасан юм. Янз янзын нэр өгч байгаад гацаасан юм. Ер нь тэгээд тэд нараас ер нь ихэнх нь замхарсандаа. Одоо балгас болоод үлдсэн. Хэдхэн төслүүд голцуу соёлын болон спортын ийм цогцолборууд байсан. Хэнтий аймгийн Соёлын төв Дархан-Уул аймагт энэ жил амжилттай ашиглалтад орсон, 14 жилийн дараа ашиглалтад орсон спорт цогцолбор гэх мэт. Харин цаашидаа бүр төрөөс энийг хариуцаж бүтээн байгуулалт хийх ачаалал улам их нэмэгдэнэ. Харин тэрэнтэй холбогдуулж хувийн хэвшил шууд хөрөнгө оруулалтаар, төр, хувийн хэвшлийн түншлэлээр ч юм уу ийм хөрөнгө оруулалтуудыг хийгээд, театр бариад, соёлын цогцолборууд, спортын цогцолборууд бариад ингээд явах юм бол төрөөс татварын бодлогоор дэмжих цоо шинэ ийм бас шийдлүүдийг энэ тодотгол дагуулж ингэж орж ирж байгаа. Тийм учраас та тэр сумд тавигдаж байгаа соёлын төвүүдийг ер нь жоохон хайрлаарай. Нөгөө хөдөө сум руу жоохон явж үзээрэй. Тэгээд болохгүй бол тэнд Соёлын төвүүдээр ороод бас үйлчилгээ тэнд юу явдаг юм, ард түмэн өөрөө тэнд яасан цуглах дуртай байдаг юм. Ямар чухал, чухал төрийн үйлчилгээнүүд тэнд бий болдог юм, очдог юм мэдрэх байх.

Б.Пүрэвдорж: Цэнгүүн гишүүн тодруулна.

С.Цэнгүүн: Тэгэхээр ер нь энэ соёлын төвтэй жишээ болгож татаж хэллээ л дээ. Бид нар ингээд хараад үзэхээр нийслэл хотод маань хүн амын дийлэнх маань амьдарч байгаа. Тэгэхээр нийслэл хот төдийгүй би эрчим хүчний тухай асуудлыг дөнгөж сая дурдаж хэлсэн л дээ асуултдаа. Тэгээд байж байхаар нийгмийн шинж чанартай бид бүхний бүгдийнх нь сумд амьдарч байна уу, хотод амьдарч байна уу ялгаагүй бүгдэд нь хамааралтай байгаа эрчим хүчний салбар луу хэзээ ч мөнгө хийхгүй яваад байсан хэр нь өнгөрсөн хугацаанд маш олон бүтээн байгуулалтуудыг бол хийгээд явчихсан байдаг. Тэгэхээр бид нар өнөөдөр хамтарсан Засгийн газар байгуулаад ийм нийгмийн шинж чанартай том реформуудаа хөдөлгөө гэж байгаа учраас бид нар зарим тэвчиж болох зардлуудыг 1, 2 жилдээ тэвчиж байгаад, сүүлд нь дараа нь орлуулах байдлаараа хийх боломжтой. Боломжтой болоод ирсэн тохиолдолд гэдэг байдлаар. Тэгэхээр нөгөө төслүүдийнхээ та ч гэсэн өмнө нь хэлж байсан ач холбогдлоор нь хэдүүлээ дараалуулаад үзье гээд тэгж байсан. Тэгэхээр яг энэ дээрээ хараад үзэх хэрэгтэй гэж бодож байна. Дээрээс нь бид нар ер нь энэ 3 их наяд гээд 30 .../минут дуусав/

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2024 оны төсвийг ярьж байх үед би Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргын хувьд нийтдээ 97 төсөл, арга хэмжээг зайлиггүй шаардлагатай биш, 97 төсөл, арга хэмжээг царцаах юм бол 927 тэрбум төгрөгийг хэмнэх боломжтой байна гэж хэлж байсан. Тэгэхээр ер нь бол 2024 оны төсөв бол Их Хурлын сонгуультай холбоотойгоор бас нэг тийм үрэлгэн зардал ихтэй, онгогчдын саналыг татах зорилгоор олон олон хөрөнгө оруулалтууд тавигдсан шүү гэдгийг бас Цэнгүүн гишүүн бас шүүмжилж яриад байна шүү дээ. Тэгэхээр сая Цэнгүүн гишүүн бол үг хэллээ.

Одоо Энхбаярын Батиугар гишүүн асуулт асууна.

Э.Батиугар: Баярлалаа. Эрхэм гишүүддээ энэ оройн мэндийг хүргэе. Өнөөдөр өглөө бид нар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцсэн. Үүнтэй холбоотойгоор улсын төсвийн тодотгол орж ирж байна. Тэгэхээр харж байхад бол энэ үйл ажиллагааны хөтөлбөр болон тодотголд бол яг нийцэж байна гэж хэлж болно. Ялангуяа маш олон суурь нийгмийн зохицуулалт болон эдийн засгийн суурь бүтцүүд маш их хэмжээний хөрөнгө оруулалт тавигдаж байна. Би сая бүх эрчим хүч болон дулааны холбоотой хөрөнгө оруулалтуудыг нэгтгэж үзэхэд бол 3,4 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт Монгол улс даяар хийгдэж байгаа юм байна. Мөн Улаанбаатар хотын нийслэлийн иргэд бол бас амьдралын чанар нь дээшлэх том том бололцоонууд олгогдож байна. Солонго 1, 2 хорооллын хөрөнгө оруулалт, дээрээс нь нэмээд энэ шинэ тойрог зам, Туул голыг дагасан хурдны зам гэх мэтчилэн.

Мөн хамгийн чухал зүйл нь бол Улаанбаатар хот өнөөдөр бол яг 4 уулын дунд хавчигдсан байдаг. Үүнийгээ тэлээд урагшаага тэлэх бололцоо нээгдэж байгаа юм. Эдийн засагч хүний хувьд бол 1 санаа зовох зүйл байгаа юм. Энэ нь бол манай мөнгөний нийлүүлэлт бол M2 42 их наяд төгрөгт хүрчихсэн. Улсын төсөв 30 их наяд зарлага. Тэгэхээр яг энэ коэффициент нь харахад бол 71 хувьтай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ юунд муу вэ гэвэл нэг ёсны онолоор бол liquidity trap гэж нэрлэдэг юм. Нэг ёсны хөрвөх чадвар болон бэлэн мөнгөний хомсдолд орох. Тэгэхээр 30 их наяд нь Засгийн газар болон улсын төсөвтэй холбоотой болоод, 10 их наяд нь бол цэвэр сул эргэлдэж байгаа мөнгө гэж хэлж болно. Энэ нь ямар эрсдэл дагуулдаг вэ гэхээр 1 дүгээрт бол шууд төлбөрийн тэнцлээр тодорхой хэмжээний дарамт ирдэг, 2 дугаарт инфляцыг өдөөх том юу гэдэг юм өдөөгч болж явдаг. Тэгэхээр үүнийгээ дагаад Монголбанк мөчлөгийн эсрэг бодлого

баримтлахын тулд бодлогын хүүгээ өндөр байлгах тийм нөхцөл үүсчхэж байгаа юм. Тэгэхээр бодлогын хүү өндөр байна гэдэг чинь бодлогын хүү бол Монгол банкнаас авах зээл, банкнуудын зээл болон Төв банкны үнэт цаасны -1, +1 хувийн депозон нь. Тэгэхээр шууд дагаад зээлийн хүү дээр бол дам дамаар нөлөөлнө. Тэгэхээр зээлийн хүү бас өндөр байх нөхцөл байдал үүсээд байгаа юм. Тэгэхээр бид нар ер нь Монгол Улсынхаа эдийн засгаа яа тогтвортой, макро менежментээ хийх юм. Яаж Монгол банкны мөнгөний бодлого болон төсвийн харилцаагаа зөв зохицуулах вэ гэдэг л асуудал гараад байна л даа.

Хөгжиж байгаа улс орнуудын одоо мөнгөний бодлого болон төсвийг нь харахад бол 25-30 хувьтай. Хөгжссөн улс орнуудыг харахад бол энэ нь 10 хувиас доош байдаг. 60-аас дээш коэффициенттэй улс орон ердөө Монгол Улс, Зимбабве, Венесуэль байгаад байгаа юм. Тэгээд ирээдүйдээ ер нь бид нар яг мөнгөний бодлогоо төсвийн бодлоготой уялдуулаад яаж тэгэхдээ хэт халаахгүйгээр эдийн засгаа мөнгөний бодлогынхоо бодлогын хүүг бууруулж, зээлийн хүүгээ.../минут дуусах/

Б.Пүрэвдорж: Болдын Жавхлан гишүүн хариулна.

Б.Жавхлан: Батиугар гишүүн санал хэлчих шиг боллоо доо. Ер нь онолын талын асуудал ярьчихлаа. Ер нь бол яг бид нарын өмнө гарч ирж байгаа сорилт бол дараагийн 4 жилийн гол сорилт бол яг энэ. Нэлээн эдийн засгийн өсөлттэй, ер нь байнгын эдийн засгийн халалтын эрсдэл өндөр ингэж ер нь бол нэг улайсчихсан төмөр шиг л ингэж явна. Энэ бүхэн бол мэдээж мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх орон зайг гаргах ер нь л их л өндөр эрсдэлтэй болж ирж байгаа юм. Тэгэхээр энийг уялдуулна гэдэг маань эдийн засгийн өсөлт дотроо энэ инфляцынхаа өсөлтийг шингээгээд, мөнгөний бодлогоо энд таарсан уян хатан бодлогоо төлөвлөөд явах нь л хамгийн чухал юм байгаа юм. Чухал юм байгаа юм.

Тэрнээс биш бид ганц инфляцаа онилоод, эдийн засгийнхаа өсөлтийг хумиад, тоормослоод байж болохгүй. Тийм учраас энэ дээр маш уян хатан үнэхээр яг төсвийн бодлого, мөнгөний бодлого 2-ыг уялдуулж явах нь бол хамгийн чухал. Сүүлийн 4 жил энэ дээр хамгийн юу гэдэг юм бэ дээ сонгодог утгаар төсвийн бодлого мөнгөний бодлого 2-ыг уялдуулж ирсэн. Өөрөөр хэлбэл төсвийн орлогын өсөлтүүдийг бид тэр хэмжээгээр нь зарлагаддаггүй. Дандаа алдагдлаа бууруулж, Төв банкны хатуу бодлоготой уялдуулж мөнгийг бол энэ дээр төсвөөс чадах хэмжээгээр бол хумьж ирсэн байдаг. 1 дүгээрт.

2 дугаарт би түрүүн тэр эрчим хүчний салбар луу дахиад ороход эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын асуудлыг ярих юм бол урагшаагаа ухрааж 4 жилийн хөрөнгө оруулалтын хэмжээг ярих хэрэгтэй. Энийг харах хэрэгтэй Цэнгүүн гишүүн ээ. Энэ жил жишээ нь гадаадын зээл тусламж, төсвийн хөрөнгө оруулалтаар ингээд тооцох юм бол эрчим хүчний салбар нь манай дэд бүтцийн салбаруудаас хамгийн өндөр хөрөнгө оруулалттай буюу 3,4 их их наяд байгаа. Зам, тээвэр 2 их наяд орчим байгаа. Тэгэхээр эрчим хүчний салбарын асуудал бол хөрөнгө оруулалтын хэмжээндээ ч 1 их биш байгаа юм. Олон жил хүчээр барьж ирсэн энэ тарифын асуудал дээр байгаа. Ее үеийн Засгийн газар л энэ тарифыг маш хүчтэй барьж ирснээс үүдэлтэй энэ салбарын хамгийн том хүндрэлийн асуудал л энэ байгаа. Тийм учраас энийгээ ойрын хугацаанд шийдье гэж Засгийн газрын тавьж байгаа маш том эрсдэлтэй ч гэсэн том амбиц зорилт байгаа гэж харж байгаа.

Б.Пүрэвдорж: Одоо Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Гишүүдэд оройн мэнд хүргэе. Тодотголын төсөлд Сангийн яамнаас асууя. Дараа нь аудитаас асууя. Сангийн яамны Орлого төлөвлөлтийн газрын даргаас. Аймгуудаас төвлөрүүлэх

орлогыг 1,5 их наяд болгочихсон. Түүний 1,4-ийг нь 4 буюу 90 хэдэн хувийг нь Өмнөговь аймгаас дангаараа төвлөрүүлэхээр болгочихсон. Уг нь 2004 оны төсөвт 2024 оны төсөвт 720 тэрбум төгрөгийг л төвлөрүүлнэ гэж байсан. 700-гаар нэмээд, 2 дахин нэмээд 1,4 их наяд болгоод өсгөчихсөн байгаа юм. Тэгэхээр энэ ямар үндэслэлээр ингэж өсгөсөн юм. Аймгийн орлогын төлөвлөгөө нь тэгж их давж биелсэн юм уу. Ямар ямар орлогууд дээр нь нэмээд ингээд 700 тэрбум төгрөг нэмчихсэн юм бэ. Үүний орлогынхоо тооцооллыг хэлж өгөөч.

2-т нь аудитын дүгнэлтэд бас тусгасан байна л даа. Орон нутгаас ингэж их дайчилж төвлөрүүлэх нь эргээд орон нутгийн төсөв, төсвийн төлөвлөгөөний биелэлтэд бас хүндрэл учруулах магадлалтай гэсэн ийм дүгнэлт өгсөн байна. Тэгэхээр энэ нь ямар үндэслэлээр бас ингэж дүгнэлт өгсөн юм бэ гэдэг тал дээр бас нэг тайлбар авчихъя гэж бодсон юм.

Тэгэхээр эргээд орлого өндөр төвлөрүүлж байгаа аймгуудад буцаагаад хөрөнгө оруулалт тавьж байгаа энэ бусад аймгуудтай харьцуулахад бол маш бага хэмжээнд тавигдаад байгаа. Тэгээд түрүүн бид нар ярьж байсан. Зарим говиос сонгогдсон гишүүд хэлж байсан. Хөрөнгө оруулалт зайлигүй хийх шаардлагатай тулчихсан асуудлууд байна. Тухайлбал Даланзадгадад ДЦС-ын асуудал. Говь нутгийн цөлжилтийн асуудал. Улаанбаатар, Мандалговь, Даланзадгад чиглэлийн зам засварын асуудал гээд л олон тулгамдсан асуудлууд, бусад аймгууд ч гэсэн энэ дулааны станцын хүндрэлтэй байгаа асуудал гээд. Тэгээд энэ болгонд чинь хөрөнгө, төсөв тавьж бас орон нутаг бие дааж асуудлуудаа шийдэх гэхээр ингээд хамаг хөрөнгө төсөв орлогыг нь дээш нь дайчлаад байх юм. Тэгэхээр орон нутаг чинь цаашаа яаж хөгжих юм. Энэ орон нутгийг бие дааж хөгжүүлнэ, орон нутгийн хөгжил, эрх мэдлийг нэмэгдүүлнэ гээд байдаг эсрэгээрээ буцаагаад хумиад,

төвлөрүүлээд байдаг нэг ийм юм руу одоо явчих юм. Тэгэхээр энэ орлогыг нэмэгдүүлж дайчилж байгаа энэ тооцоолол үндэслэлийг тайлбарлаж өгөөч. Хэрвээ энийг төвлөрүүлж чадахгүй бол орон нутгийн цаашидаа оны эцэс рүү орон нутгийн төсөв, орлого тасрах, төлөвлөсөн ажлууд гацах ийм эрсдэлтэй нөхцөл байдал руу орох гэж байгаа юм биш үү гэж ингэж харж байна. Энэ дээр тайлбар авъя. Тэгээд дараа нь тодруулъя.

Б.Пүрэвдорж: Хэддүгээр микрофон бэ. Хэд юм. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Гишүүн маань өөрөө Засаг дарга байсан. Энэ аймгийн төсвийн, улсын төсөвтэй харьцдаг энэ харилцааг хамгийн сайн мэдэж байгаа. Сэддорж гишүүн маань ч хамгийн сайн мэдэж байгаа. Энэ Сангийн яам, Татварын ерөнхий газраас үзэмжээрээ төвлөрүүлээд татаад байдаг асуудал огт биш шүү дээ. Үзэмжээрээ татаад байдаг юм шиг л манай 2 гишүүн бүр байнга ингэж ярьж ойлгуулаад байгаа юм. Өөрсдөө цаад учраа бол мэдээд байгаа л даа. Тэгээд гишүүдийн нөгөө сонгогчдоо харж ярьж байгаа учраас болдоггүй юм шиг байгаа юм. Ойлгож байна, ойлгож байна. Энд чинь хардаа Өмнөговь аймгийн энэ жилийн суурь зардал 76 тэрбум л байгаа. 76 тэрбум төгрөг. Одоо орчихсон байгаа орлого нь 700 тэрбум төгрөг. Ямар юмных нь юм гацах вэ дээ. Бүр 10 дахин илүү орлого орчихсон явж байгаа байхгүй юу. Гэхдээ энд бас учир байна. 2022 онд орсон нэгжгийн тухай хуульд орсон өөрчлөлттэй Татварын хууль дээр өөрчлөлт оруулаад тухайн орон нутагт байршиж байгаа аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварын 40 хувийг нь буцаагаад аймаг руу нь хуваарилдаг болчихсон юм. Тэрнээс биш Өмнөговь аймгийн татварын алба 14 тэрбум төгрөгийн л татвар цуглуулж байгаа. 14 тэрбумын шүү. Харин Улаанбаатар хотод Татварын ерөнхий газрын том аж

ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар төвлөрүүлдэг тэр алба дээр Өмнөговь аймагт байрладаг 10 уул уурхайн компаниудын аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 40 хувийг нь энэ Улаанбаатараас Өмнөговь руу хийж өгч байгаа юм. Тэр орлого байхгүй юу. Энийгээ буцаагаад татахдаа мөн тэр татварын хуулийн 56.3 гэсэн заалт байгаа шүү дээ. Танай суурь зардлаас чинь давбал аль багынх нь 70 хувийг нь үлдээгээд, бусдыг нь татдаг. Тэгэхээр танай суурь зардал чинь 76, тэндээс 70 хувь гэхээр энэ 53 тэрбум болж байгаа. Тэрийг чинь үлдээгээд, бусдыг нь хуулийн дагуу буцаагаад татаад, тэгээд улс орон даяар хаашаа ямар төсвийн зарлага хөрөнгө оруулалтууд нэн шаардлагатай байна. Ингээд хуваарилалтаа хийгээд явдаг байгаа.

Харин цаашидаа ингээд андуураад байх юм бол тэр 40 хувийг буцааж тавьдгийг ялангуяа стратегийн том ордуудтай ийм аж ахуйн нэгжүүдийг бол болимоор юм байна лээ. Эрдэнэт хэзээ ч ингэдэггүй шүү дээ. Эрдэнэт хэзээ ч ингэж байгаагүй. Тэр танай Өмнөговь аймгийн нөхдүүд орлого тасарсан эд нар гэж одоо зарим гишүүддээ мэдээлж, тэгж худлаа ярьж болохгүй шүү. Худлаа ярьж болохгүй. Тэрийг Сангийн яамнаас анхааруулсаар байтал зөвхөн улсын төсөв дээр тодотгол хийсний дараа орлого дээр тодотгол хийх ёстой шүү гэж үүрэг өгсөөр байтал дураараа өөрсдөө иргэдийн Хурал дээрээ орлогоо нэмчихсэн. Тэгчхээд одоо тэрийгээ дутуу байгаа. Энэ сарынх, сүүлийн сарынх эд нар тасарсан гэсэн мэдээлэл өгсөн байна лээ. Хэдэн хувиар давуулж биелэхийг Өмнөговийн татварын алба биш, иргэдийн Хурлаар ч мэдэхгүй. Энийг Улаанбаатар хотод Татварын ерөнхий газрын том аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татвар төвлөрүүлдэг тэнд энэ бодлогын асуудал нь хэмжээ нь шийдэгдэнэ. Тэндээс гарсан тооцооллоор давж ийм хэмжээгээр давахаар ийм төлөвтэй байгаа учраас энийг хуулийнх нь

дагуу буцааж төвлөрүүлж байгаа ийм л асуудал байгаа.

Харин одоо уул уурхайн өндөр эргэлттэй байгаа АМНАТ томоохон хэмжээгээр төвлөрүүлдэг аж ахуйн нэгжүүд газар зүйн хувьд байрладаг ийм аймгууд дээр орон нутгийн хөгжлийн сангаар нь дамжуулж харин ч одоо илүү их хөрөнгө оруулалтыг буцааж хуваарилж байгаа. Өмнөговь энэ дүрэм рүү шилжсэнээс хойш орон нутгийн хөгжлийн сан нь бараг 2-3 дахин нэмэгдэж байгаа шүү дээ. Ийм бодлого. Бодлого юу байх вэ, ерөөсөө хуулийн хэрэгжилт ийм байгаа юм.

Б.Пүрэвдорж: Наранбаатар гишүүний асуултад Наранчимэг захирал, Энхболд захирлын аль нь хариулах юм. Индрийн 2 дугаар микрофон. Наранчимэг захирал хариулъя. Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг.

Ц.Наранчимэг: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. 2024 оны төсвийн тодотголоор орон нутгийн төсөв төвлөрүүлэхээр 7 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын өөрчлөлт оруулж байгаа. Үүнээс 3 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналыг бол төвлөрүүлэх орлогыг бууруулж, үлдсэн аймгуудын төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэхээр ингэж төсвийн төсөлд оруулсанд аудит хийсэн. Үүнээс Өмнөговь аймгийн төсвийн төвлөрүүлэх орлого 2023 онд 456,4 тэрбум орлогыг төвлөрүүлж байсан. 2023 оны төсвөөр бол 719,9 тэрбумыг төвлөрүүлээд, тодотголоор 1,4 их наяд төгрөгийг төвлөрүүлэхээр төсөвлөсөн. Үүнийгээ өргөн барьсан төсвийн төсөлд Өмнөговь аймаг дахь үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг өсөхөөр тооцож, төвлөрүүлэх орлогыг тооцсоныг аудитаар бид энэ төвлөрүүлэх орлогыг бас бусад нэлээд өндөр хэмжээгээр тооцсон учраас энэ орлогын төлөвлөгөө төвлөрүүлэх орлого маань

жилийн эцэст биелэгдэхгүй байх магадлалтай байна гэдгийг аудитын дүгнэлтэд хүргүүлсэн. Дүгнэлтийн 3.8-д бол бид дүгнэлтээ өгсөн байгаа.

Б.Пүрэвдорж: Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгэхээр аудит болохоор зэрэг төвлөрүүлэхгүй байх, орлого биелэхгүй байх боломжтой эрсдэлтэй гэж хэлээд, дүгнэлтээ хэлчээд байдаг. Сангийн яам болохоор болно гээд байдаг. Би тэгээд тодорхой уг нь асуулт асуусан юм. Ямар орлогууд нь давсан болоод тэр орлогууд дээр нь нэмэгдүүлж, 700 тэрбум төгрөг тавьчихав. 700 тэрбум төгрөгийнхөө задаргааг хэлээдэх л гэсэн шүү дээ.

Б.Пүрэвдорж: 3 номер Санжаадорж.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж. Өмнөговь аймгийн суурь орлого бол төсвийн тодотголоор 701 тэрбум 969,7 сая төгрөгөөр нэмэгдэхээр бол бид тооцоолсон байгаа. Үүнээс хувь ХХОАТ 21,3 тэрбум төгрөгөөр, ААНОАТ 520 тэрбум төгрөгөөр давахаар бид тооцсон. Мөн үл хөдлөх хөрөнгийн албан татвар 50 тэрбум төгрөгөөр, хувьцааны ноогдол ашиг 107,5 тэрбум төгрөгөөр, бусад орлогыг 2,8 тэрбум төгрөгөөр бол бид нар өсөхөөр тооцсон. Энэ бол хагас жилээр хийсэн гүйцэтгэл дээр үндэслэж гаргасан байгаа. Хувь хүний орлогын албан татвар бол хагас жилийн гүйцэтгэлээр бол энэ жилийн төлөвлөгөөнд бол хүрчихсэн. Мөн ААНОАТ бол энэ жилийн төлөвлөгөөгөө даваад 260 тэрбум төгрөгөөр давчихсан байгаа. Өөрөөр хэлбэл бид үлдсэн хагас жилд дахиад 260 орчим тийм тэрбум төгрөгөөр давж орох нь гэж тооцож байгаа. Түрүүний 520 тэрбумаар нэмэгдүүлсний 260 нь бол аль хэдийнээ ... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд оройн мэнд хүргэе. Энэ удаагийн төсвийн тодотголыг бол бас дэмжиж байгаа. Яагаад гэвэл Монгол Улс цаашаа хөгжих ёстой. Үнэхээр бид зөвхөн татварынхаа хүрээнд асуудлаа ярих юм бол 2 намын хэдэн хүн сайд болсон, энэ 126 хүн улсаараа бүжигнаж байгаад гишүүн болоод өнгөрсөн. 4 жилийн дараа улс орны хэмжээнд энийг шийдлээ гэж хэлэх дорвитойхон төсөл хөтөлбөр байхгүй, ард түмний амьдралын чанар сайжирсан юм байхгүй, нэг ийм л сонгуулийн үр дүн гарах учраас харин ч төсвийн тодотголоор ирэх жилүүдэд хийгдэх томоохон хөрөнгө оруулалтуудын ТЭЗҮ, энэ хамаг юмнуудыг бас урьдчилаад ингээд хийж байгаа нь нэлээн цаг хожиг байгаа асуудал гэж ингэж бас харж байгаа.

Би энэ дээр нэг зүйлийг онцолж бас хэлэхийг хүсээд байгаа юм. Одоо бидэнд танилцуулагдаж байгаа энэ тоо баримтууд дундаас Монгол Улс өнөөдөр Шадар сайд, Тэргүүн шадар сайд ч бас хэлж байсан. Уул уурхайн орон гэдгийг бид нар хүлээн зөвшөөрөх ёстой гэж. Энэ уул уурхайн салбараас орж байгаа орлого маань бидний өнөөдөр ярьж байгаа энэ улсын төсвийн орлогын 30 гаруй хувийг бүрдүүлээд ингээд явж байгаа. Тэгээд өнгөрсөн 2020 оноос 2024 оны парламентаар Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлж оруулсан. Монгол Улсын Ерөнхий сайд манлайлж байгаад энийг батлуулсан. Парламент бас маш сайн дэмжсэн нэг том хууль бол энэ Баялгийн сангийн хууль. Энэ баялгийн сангийн хууль 4 сарын 19-нд батлагдсаны дараа энэ ашигт малтмалын салбарт олгогдсон лицензтэй холбоотой, ашиглалттай холбоотой нийтийн сонсгол явагдаад, 6 сарын 5-нд энэ сонсголын үр дүнг хэлэлцэж, Улсын Их Хурлын тогтоол гарсан байгаа. Энэ тогтоол дээр нэлээдгүй зүйлүүдийг бас тусгахаар ингэж заасан. Тэгэхээр би

эндээс бас энэ хамтарсан Засгийн газар бүрдэж, энэ улс орны хэмжээнд томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлбэ гэсэн энэ түүхэн цаг үеэ ашиглаж, энэ баялгийн сантай холбоотой бас яригдаад одоохондоо бас эргээд зоонон чимээгүй болчихоод байгаа энэ стратегийн 16 орд, түүний цаана байгаа 35 ордын асуудлыг энэ Засгийн газар, энэ парламент Монголын ард түмэнд бас ээлтэй, одоо байгаа аж ахуйн нэгжүүдтэйгээ хамтраад цаашаа явах энэ хуулийн гаргалгааг өшөө төгөлдөржүүлээд, өнөөдрийн 2024, 2025, 2026 оны төсөв хэлэлцэхдээ бас тусгаад явбал ямар бололцоо байдаг юм бол гэж ингэж харж байгаа юм. Тийм учраас үүнтэй холбогдуулаад энэ ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулга одоо 3 дахь сайдынхаа нүүрийг үзэж байгаа байх. Энэ асуудал парламентаар хэзээ орж ирэх вэ. Энэ Тамсагийн асуудал, энэ Сүхбаатарын Эрдэнэцагааны тэр асуудлууд гээд олон зүйлүүд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Энийг Туваан сайд хариулбал уг нь зүгээр байх юм. Яг тодотголтой холбоогүй, бодлогын асуудал яригдчихлаа. Би хариулж мэдэхгүй байна.

Д.Амарбаясгалан: Засгийн газрын гишүүд алга байна шүү дээ. Орж орж иртэл нь завсарлах юм уу түр. Дараагийн гишүүн асуултаа асууж байя. Идэрбат гишүүний асуултад Туваан сайд орж ирээд хариулъя. Бас Улсын Их Хурлын гишүүн асуусан. Төсвийн тодотгол явж байгаа учраас. Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: 1 асуулт, 1 санал байна. Төсвийн хууль тодотголоос асуухын тулд төсөв дагасан хуультай нь холбогдож байгаа учраас төсөв дагасан хуультай нь холбогдуулж бас асуултаа асууна. Тийм учраас энийг бас ойлгож хүлээж аваарай

гэж хүсье. Энэ төсвийн тодотголын гол асуудал бол хамтарсан Засгийн газрын ид шид бол томоохон бүтээн байгуулалтуудыг зориг гаргаж эхлүүлэх зарчим байгаа. Тэгээд энэ зарчмыг дэмжиж байгаа.

Зорилго бол хүрэхийн тулд ямар ч хамаагүй аргаар хүрнэ гэдэг зарчим бол байж болохгүй. Тэр арга бол өөрөө хуулийн хүрээнд, дараа нь тэр эхэлсэн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд эргэж саад болохооргүй, эргэж ухагдахааргүй, эргэж гогодуулахааргүй, эргэж шоронгийн хаалга татахааргүй байх ёстой. Тэр утгаар миний асуулт чиглэнэ. Дагасан төр, хувийн хэвилийн түншлэлийн хууль дээр энэ хууль үйлчлэхээс өмнө зарласан тохиолдолд шалгарсан этгээдтэй Концессын тухай хуулийн дагуу концессын гэрээ, дагалдах гэрээг байгуулна гэдэг ийм хуулийн өөрчлөлт орж ирсэн. Монгол Улсад өнөөдөр Концессын тухай хууль гэж байхгүй байгаа. Энэ хууль хүчингүй болчихсон. Тийм учраас үхсэн хүнийг амилуулна гэж байхгүй. Хууль зүйн техникт хүчингүй болчихсон хуулийг хэрэглэнэ гэдэг ойлголт байдаггүй. Тийм учраас Засгийн газар энэ хуулийн төслөө 1 дүгээрт татаж авах ёстой гэсэн шууд саналтай байна. Авахгүй бол Улсын Их Хурал энэ хуулийг шууд буцаах ёстой гэсэн ийм саналтай байна.

Энэ хууль хүчингүй болчихсон хуулийг хэрэглэхээр орж ирсэн төсөвт ямар нэгэн тооцоо байгаа юу. Арга хэмжээ байгаа юу гэсэн эхний асуулт байгаа юм.

2-т нь энэ томоохон бүтээн байгуулалтууд гээд бид задгай яриад байгаа энэ төсөл арга хэмжээнүүдээс яг хэдэн төсөл улсын төсвөөс яг хэдэн төгрөг нийт дүнгээрээ суух юм. Төр хувийн хэвилийн түншлэлийн хүрээнд хэд нь суух юм. Гадаадын зээл тусламжаар хэдэн суух юм бэ гэдэг нэг ийм тоо, 3 тоо байгаа юу гэсэн ийм асуулт байна. Тэгээд тэр дүнгээс энэ тодотголоор улсын

төсөвт суухаас нь яг хэдэн төгрөг нь сууж байгаа вэ гэсэн ийм 2 дахь асуулт байна.

3 дахь нь бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энхбаяр гишүүн 1 минутаа авчих. Тэгэхдээ энэ дагасан хууль чинь 6 дахь асуудал байгаа тийм ээ. Энхбаяр гишүүнд 1 минут нэмээд өгчихье.

Б.Энхбаяр: 2 дугаарт ийм дагасан хууль дээр яг 48.9 дээр 1 ийм заалт байгаа. Тэр тендерийн хуулийн өөрчлөлтийн 48.9.хуулийн 36¹-д заасан жагсаалтад багтсан төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг санхүүжилтийн эх үүсвэр батлагдахаас өмнө эхлүүлж болно гэдэг ийм хуулийн заалт байгаа юм. Энэ төсвийн тодотголын хууль батлагдахаас өмнө тендерийг нь зарлачихсан юм байгаад байгаа юм уу. Ийм хууль байж болдог юм уу. Улсын Их Хурал төсвийг нь батлахаас өмнө тендерийг нь зарлаж болдог юм уу. Ийм хуулийн заалт орж ирчхээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ төсвийн тодотголд тийм ямар арга хэмжээ орж ирчхээд энэ хуулийн заалтыг оруулж ирэх гээд байгаа юм бэ гэсэн асуулт байна.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Хэн хариулах вэ. Үлдсэнийг нь хэн хариулах вэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга хаана байна. Энэ сайд нарыгаа чуулганы танхимд орж ирж энэ асуултад хариул гэж хэлмээр байна. Засгийн газрын гишүүд. Хэрэг эрхлэх газрын дарга энийгээ зохион байгуулъя. Жавхлан сайд хариултаа өгье.

Б.Жавхлан: Би яг тодотголтой холбоотой хэсгийг нь хариулъя. Зураг төсөв, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээ бол бэлтгэл ажил хангахад нийтдээ 484 тэрбум төгрөг байгаа. 4 төсвийн ерөнхийлөн захирагч дээр гэсэн үг. Энд Зам, тээврийн хөгжлийн сайд, Эрчим хүчний сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга бөгөөд Засгийн газрын сайд эдгээр хүмүүс дээр ингээд хуваагдаад ингээд тавьж

байгаа. Яг эдгээр төслүүдтэй холбоотойгоор санхүүжилтийн схем төрөл нь бол одоогоор эцэслэж тодорхойлогдоогүй байгаа. Энэ бэлтгэл ажил, зураг, ТЭЗҮ, төсөв энэ зөвлөх үйлчилгээний бүх юм гарсны дараа нөгөө даалгавар гарна. Тэрэнтэй уялдуулж алийг нь төр, хувийн хэвшлийн түншлэлээр явуулах уу. Одоо өөрөөр хэлбэл гаднын хөрөнгө оруулагч нар ямар хэмжээ сонирхлыг нь татах нь вэ, эсвэл шууд хөрөнгө оруулалтаар явах нь уу, эсвэл Хөгжлийн банкны санхүүжилтээр явах нь уу, эсвэл холимог байдлаар явах нь уу, эсвэл аль нэг төрийн компани, аж ахуйн нэгж энийг хийх нь үү гээд маш олон ийм хувилбар боломжууд байгаа. Энийг манай шинэ Засгийн газрын бүтцээ Эдийн засаг, хөгжлийн яаман дээр боловсруулдаг болсон. Ингээд тэндээс эцсийн шийдвэр гарна.

1 тодорхой юм байгаа. Энэ яригдаж байгаа 4-5 том төсөл дээр бүтэн яг дуустал нь төсөв санхүүжүүлж дийлэх нэг ч төсөл байхгүй. 1 ч төсөл байхгүй. Доор хаяж төр, хувийн хэвшлийн түншлэл эсвэл гаднын шууд хөрөнгө оруулалтууд, эсвэл холимог байдлаар л явна. Харин бэлтгэл ажлыг нь хангах дээр төсвөөс чадан ядан бид энэ удаагийн 2024 оны төсвийн тодотгол дээрээ ямар нэг цаг алдахгүйгээр бид энэ том хамтарсан Засгийн газрын хөтөлбөр, энэ одоо том амбицтай гэрээгээ хийсэн нь юу билээ. Ингээд ажил хийгээдэхье л гэж байгаа. Ийм тодотгол орж ирж байгаа юм шүү. Тэр бусад хууль, тэр нөгөө төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлаар санал оруулж ирсэн Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулчихвал зүгээр байна. Тэр тендертэй холбоотой ч гэсэн Эдийн засаг, хөгжлийн яамнаас хариулчихвал зүгээр байна.

Д.Амарбаясгалан: Өөр нэмж хариулах хүн байна уу. Байхгүй. Энэ сайд нарыг дууд. Албаны хүмүүсээ дууд. Нэгэнт Улсын Их Хурлын чуулган үргэлжилж байхад сайд нарыг иртэл 20 минут завсарлалаа.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Завсарлага дууслаа. Гишүүдийг танхимд урьж байна. Ажлын хэсгийн хүмүүсийг суудлаа эзлэхийг урья. Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн барьсан хуулийн төслүүдийг хэлэлцэж байгаа. Засгийн газрын гишүүд танхимдаа бүрэн байгаад, асуудалдаа бүрэн дүүрэн хариулаад явахгүй бол гишүүдийн асуулт дутуу хаягдаж байгаа учраас бас гишүүд энд бухимдалтай байна. Дараагийн гишүүн асуулт руугаа оръё. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхтуяа: Түрүүн миний асуултад Ерөнхий сайд маш хангалтгүй хариулт өгсөн. Одоо урсгал зардлаасаа танаж, цалин хөлсөө нэмэх арга хай гэсэн. Урсгал зардлаас танах тийм их хөрөнгө манай боловсролын салбарт харамсалтай нь байхгүй. Харин тэр гүйцэтгэлийн үнэлгээг гүйцэтгэлийн үнэлгээний төсвийг багш нар үндсэн цалиндаа шилжүүлэхийг бас хүсэж байгаа шүү. Энийг бас анхааралдаа аваарай гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт нь түрүүн Оюун-Эрдэнэ сайд хэлсэн. Зөвхөн багш нарын цалинг нэмэх талаар ярьж болохгүй гээд байгаа юм. Тэгсэн мөртөө автобусны жолооч, ТҮК-ийн ажилчдын цалин 3,5 саяд хүрчихсэн байгаа. Энэ бол барьцаад байгаа юм биш л дээ. Ер нь бол яг салбар салбараараа ярьж болохгүй гэххэд иймэрхүү асуудлууд байна. Хууль шүүхийнхэн 3-5 сая төгрөгийн цалин авч болоод байна. Гэтэл Монголын боловсрол, боловсролын салбарт ажиллаж байгаа багш нарын цалин яагаад 1,4 сая, татвараа өгөөд ганцхан сая төгрөг гар дээрээ авч байна шүү дээ. Энэ дээр нэг хариулт өгөөч ээ эрх мэдэл бүхий дарга нар аа. Тэгээд энэ бол үнэхээр харамсалтай. Боловсролын салбарын багш нарын цалин 1,4 сая төгрөг, гар дээрээ 1 сая төгрөг гэдгийг бол дахин бүр онцлон хэлмээр байна.

2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллөөс харахад Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 2024 онд 79 их наяд, 2025 онд 95 их наяд, 2026 онд 104,8 их наяд гээд өсөөд явах юм байна. Гэтэл сүүлийн жилүүдэд боловсролын салбарын төсөв дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувиас л хэтрэхгүй байгаа. 2024 онд мөн адилхан 5 хувь дээрээ л байна. Гэтэл боловсролын чанараар дэлхийд тэргүүлж байгаа улс орнууд дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 7-10 хувийг боловсролдоо зарцуулдаг. Олон улсад нэвтэрсэн энэ жишиг рүү манайх ороход багийн цалинг нэмэх, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, зардлаа босгоно гэж харагдаж байгаа юм. Ганцхан жишээ хэлэхэд боловсролын төсвийг 2025 онд 5 хувиас 7 хувь болгоход 4,1 их наядаас 6,6 их наяд болж нэмэгдэж байгаа юм. Тэгэхээр 2,5 их наядаар юу хийж болох вэ. Энэ 2-ын зөрүү дээрээс. Боловсролын салбарын цалингийн сан 2,3 их наяд, цалинг 50 хувь нэмэхэд 1,2 их наяд төгрөг хэрэгтэй. Үлдсэнээр нь сургууль, цэцэрлэгийн барилга, тоног төхөөрөмжөө сайжруулах ийм боломжууд харагдаж байна. Ийм улс төрийн манлайлал эр, зориг гаргаж чадах уу гэдгийг асууж байна. Боловсролд зарцуулсан 1 доллар буцаж ирэхдээ 12 доллар болж өгөөж нь өсөж ирдэг гэдэг. Тэгвэл бид боловсролоосоо, ирээдүйгээсээ, багш нараасаа, хүүхдүүдээсээ харамламааргүй байна. Энэ л.../минут дуусав/.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Хэн хариулах вэ. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Л.Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Би Боловсролын сайд байсан 1 сарын өмнө. Тэгээд бид нар ингээд нийгэмд тэр тусмаа Мөнхтуяа гишүүн маань ороод ирлээ. Галбадрах гишүүн маань багш нарын төлөөллийг оруулаад ирлээ. Одоо цөмөөрөө гашиун үнэн буюу үнэн тоогоо л ярья. Одоо ингээд

Улаанбаатар хотод тээврийн автобусны жолооч нарын цалин 3 сая 500 мянган төгрөг болгочихлоо гэж байгаа юм. Яг зөв үнэн бид нар багш нарынхаа цалинг бас 3 сая 500 болгох ёстой. Би үүнтэй яг санал нэг байгаа. Тэгэхдээ өнөөдөр Улаанбаатар хотод байгаа автобусны жолооч нар яг хэд билээ Мөнхтуяа гишүүн ээ. Хэдэн хүний цалинг бид нар 3 сая 500 болгож байгаа билээ. 640 хүн. Би андуураагүй бол. Өнөөдөр шүүгч нарын цалин 3 сая 500 байгаа үнэн. Өнөөдөр Монгол Улсад шүүгч нар 340 шүүгч байгаа. Өнөөдөр бид нар яг энэ багш нарынхаа цалинг нэмэхгүй гэсэн нэг ч хүн энэ танхимд байхгүй болов уу гэж би бодож байгаа юм. Өнөөдөр 38 мянган хүний цалинг 3 сая 500 болгох, 340 хүний цалинг 3 сая 500 болгох арай жаахан өөр.

Тийм учраас өнөөдөр бид нар энэ нийгэмд үүссэн асуудлууд, манай дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн өсөлт, төсвийн хязгаар, өрийн хязгаар гээд бүх зүйл байдаг учраас бид нар энд нэг жаахан. Тийм ч учраас би таныг орж ирсэнд их талархаж байгаа юм. Өнөөдөр гудамжинд биш, үйлдвэрчний эвлэл биш ингээд орж ирээд яг Монгол Улсын төсөв, ирэх 3 жил Монгол Улсын төсвийн орлого яг ямар байх вэ, эдийн засгийн өсөлт яг ямар байх вэ, төсвийн зардал ямар байх вэ, төсвийн алдагдал ямар байх вэ гээд энэ бүх тоог өнөөдөр ингээд харин та яг энгийн үгээр багш нарт ингээд ойлгуулж өгмөөр байгаа юм.

Намайг ажил авахад боловсролын салбарын санхүүжилт 2,1 их наяд байсан. Би Наранбаяр сайдад ажил өгөхөд боловсролын салбарын санхүүжилт 5,2 их наяд болсон. Тэгээд энэ мэтчилнээр өнгөрсөн жилд ингээд жишээ нь эрүүл мэндийн салбар байна. Монгол Улсын төрийн албанд ажиллаж байгаа өнөөдөр 226 мянган хүн байгаа. 226 мянган хүний 70 хувь нь өнөөдөр төрийн үйлчилгээний албанд, 30 хувь нь өнөөдөр төрийн захиргааны албанд байна. Тийм учраас ингээд бид нар 226 мянган хүний цалинг

нэмэх тухай асуудал бүгдээрээ яриад, өнөөдөр эмч нарыг төлөөлж орж ирсэн хүмүүс байгаа шүү дээ. Яг таны дараа үг хэлэх гэж байгаа хүмүүс байх шиг байна. Яг ингээд эмч нарынхаа цалинг 3,5 сая, багш нарынхаа цалинг 3,5 сая, автобусны жолооч нарынхаа цалинг 3,5 сая, төрийн үйлчилгээнийхээ цалинг 2,5 сая болгоё гээд ингэж яах юм бол өнөөдрийн бид нарын яг ийм бодитой потенциал, ийм боломжууд байна уу гэдгийг л бид нар нэгд ярих ёстой.

2 дугаар асуудал Монгол Улсад цалингийн өсөлт ярихад одоо бид нар бүтээмж ярих ёстой. Тийм учраас өнөөдөр та яриад байна шүү дээ. Монголын багш нарын цалинг мянган доллар болгоно. Яг мянган долларын хэмжээнд цалин авч байгаа багш нар өнөөдөр 1280 багш нар байгаа шүү. 1280 багш нар. Хамгийн өндөр гүйцэтгэл авсан ийм багш нар байгаа юм. Тийм учраас бүх багш нар яг 1 мянган долларын хэмжээнд 3,8 сая төгрөгийн цалин авч байгаа 1280 багш нарын хэмжээнд би хүрээсэй л гэж ойлгож байгаа юм. Өнөөдөр 5,8 сая төгрөгийн цалин авч байгаа эмч байгаа. Тийм учраас энэ 30 мянган эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа улсууд яг энэ хүмүүс шиг ийм гүйцэтгэлтэй, ийм өндөр гүйцэтгэлтэй, ийм өндөр ур чадвартай, ийм эмч нартай, ийм багш нартай болохын төлөө л бид нар зорьж ажиллах ёстой. Бид нар өнөөдөр энэ танхимд сонгогдсон 126 гишүүн бүгдээрээ багш нарынхаа цалинг 3,5 сая, бүгдээрээ эмч нарынхаа цалин хамгийн багадаа сувилагч нарынхаа цалин 3,5 сая болох хүсэл тэмүүллийн төлөө бид нар орж ирсэн гэж ойлгож байгаа. Тийм учраас.../минут дуусав.

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут. Хариултаа гүйцээе.

Л.Энх-Амгалан: Тийм учраас бид нар эдийн засгийнхаа өсөлтийг ирэх 4 жилд 5-8 хувьд барья. 1 хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг өнөөдөр 6 мянган долларыг бид нар одоо 8-18

мянган долларт хүргэе гэдэг зорилтыг бид нар дэвшүүлж байна. Энэ зорилтыг бид нар хүрч чадах юм бол өнөөдрийн багш нарын цалин өнөөдөр 3,5 сая биш, магадгүй мянган доллар биш 1500, 1800, 2000 долларт очих энэ боломжийн төлөө л бид нар өнөөдөр ирэх 4 жилд энэ Засгийн газар ийм ийм том мега төслүүдийг хэрэгжүүлье. Ийм эдийн засгийн өсөлтийг хангаж ажиллая. Үүний тулд ийм сорилтууд байна гэдэг зүйлээ л бид нар өнөөдөр яриад, одоо өнөөдөр бид нар төсвийнхөө өнөөдрийн та бид нарын өнөөдөр ярьж байгаа чинь төсвийн тодотгол хийж байгаа шүү дээ. Энэ асуудал бол 2025 оны төсөв, 2026 оны төсөв, 2027 оны төсөв дээр бид нар энэ орон зайгаа л ярих ёстой болов уу л гэж би ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнхтуяа гишүүн тодруулга.

Ц.Мөнхтуяа: Ер нь бол багшийн хомсдолд орчхоод байгаагаа та нар ер нь юу гэж ойлгож байна. 4200 багш дутагдалтай байгаа гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хүмүүс чинь цалин байхгүй, цалингаа голоод дүрвэхээд байгаа. Тэгэхээр энэ дээр ямар бодлого хэрэгжүүлж, яаралтай ажил хийх вэ. Бид нар ажил хийнэ гэж энэ төрд орж ирсэн байх гэж ойлгож байгаа. Тэрнээс асуудал яриад байвал бид нар асуудлыг тоочоод дуусахгүй. Энэ дээр сэтгэл гаргаад, улс төрийн манлайлал гаргаад, зориг гаргаад, энэ боловсролын салбарынхаа багш, ажилчдын нийгмийн асуудал дээр дорвитой ажил хийхгүй бол багшгүй боллоо шүү дээ. Яг үнэндээ. Хөрсөн дээрээ буусан юм ярихгүй, дандаа агаарын юм яриад байна та нар. Тийм болохоор энэ багш нарынхаа цалин хөлсийг дорвитой нэмэх аргаа л хайя. Бид нар ингээд болохгүй болохгүй гээд байвал болохгүй. Болгоё гээд байвал болгох юм бас байгаа гэдгийг бас хэлчихье.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Л.Энх-Амгалан сайдад микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Мөнхтуяа гишүүн ээ, Төрийн албан хаагч нарын ер нь нийгмийн баталгааны тухай хууль гэдгийг бид нар ярьж байгаа. Ганцхан өнөөдөр бид нар багш нарын цалингийн асуудал ярих биш, ганцхан багш нарын асуудал биш. Төрийн албан хаагч нарын нийгмийн баталгааны асуудал, орон сууцын асуудлууд, эрүүл мэндийн асуудлууд гэх мэтчилнээр энэ бүх асуудлыг бид нар бас цогцоор нь харж үзэх ийм шаардлага гарсан байна гэж үзэж, өнөөдөр Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн үзэл баримтлал дээр сууж байна. Тийм учраас таныг бас энэ дээр оролцохыг хүсэж байна. Тэгээд ганцхан багш нар өнөөдөр цалин нэхээгүй, эрүүл мэндийн их сайн үйлчилгээ хэрэгтэй, орон сууцаар бид нар хангах ёстой. Цаашаа бид нар төрийн албан хаагч нар буюу сайн багш нар, сайн эмч нарыг бид нар ингээд гадаадын их дээд сургуульд сурах боломжуудаар хангах энэ бүх зүйлүүдийг л бид нар цогцоор нь харах ёстой л гэж би ойлгож байгаа.

Д.Амарбаясгалан: Тодруулга болчихсон байгаа. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Бараг 6, 7 асуулт байх шиг байна. Болж өгвөл гүйцэд хариулаад өгөөрэй гэж хүсье. Хөрөнгө оруулалт дээр төсвийн тодотголтой холбоотойгоор бас хөрөнгө оруулалт нэлээн нэмэгдэж байгаа. Хөрөнгө оруулалт маань энэ орлого олдог хөрөнгө оруулалт, нөгөө орлогын бааз, татварын бааз бүрдүүлдэг хөрөнгө оруулалтын өгөөжтэй тэр хөрөнгө оруулалт нь хэдэн хувьтай байгаа вэ. Төсвийн тодотголоор.

2-т нь мөнгөний бодлого яаж төсөөлөгдөж байна вэ. Мөнгөний бодлого одоо энэ төсвийн тодотгол хийгдсэнээр ямар байдалтай болох юм. Монголбанк мөнгөний бодлогоо хатууруулах юм уу, зөөлрүүлэх юм уу. Эдийн засгийн гадаад, дотоод шокийн асуудлууд байж байна. Дайн байлдаан дэлхий нийтээр 90 орчим улс нь инфляцын түвшинд байж байдаг.

Мөнгөний бодлогоо хатууруулаад байж байдаг. Энэ дээр үүнийгээ тооцож бодсон юм уу. Манай мөнгөний орлого чинь маш цөөхөн хэдэн зүйлээс гол нь бүрдэж байгаа шүү дээ.

Төсвийн тодотголоор л цалингийн өсөлтийг нь асуугаагүй шүү. Энэ төсвийн тодотголоор төрийн албан хаагчийн тоо хэдээр нэмэгдэж байгаа вэ. Хуучнаараа хадгалагдаж байгаа юу, үгүй юу.

Аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдэд бага хүүтэй эх үүсвэр, санхүүжилт босгох тухайд төсвийн тодотголд орсон уу, үгүй юу. Өр, зээлийн менежмент дээр төсөвт яаж сууж байгаа вэ. Гадаад болон дотоод өрүүд дээр. Төрийн өмчит компани, аж ахуйн нэгжүүд, төрийн өмчит байгууллагууд, хувийн хэвшлийнхнээр ажил хийлгэгчхээд мөнгийг нь өгөхгүй, тэр төрийн өмчит байгууллага дээр очиж хэдэн хувийг нь чи өгч байж мөнгөө авдаг ийм зүйл бол хавтгайдаа байгаа шүү дээ. Бизнес эрхлэгчдийг хохироож байгаа асуудал.

Сангийн сайд түрүүн үгэндээ хөндлөнгийн аудит, мониторинг хийлгэх сонирхолгүй. Сангийн яам нь, Засгийн газар нь ажлаа хийдэг байх нь зүйтэй гэдэг зүйл илэрхийлэх шиг болсон. Тэр дээр буруу ойлгогчхов уу, зөв ойлгов уу гэдгийг мэдмээр байна.

Хэдийгээр төсвийн тодотгол ярьж байгаа ч гэсэн түрүүн санал дээр мөрийн хөтөлбөр дээр санал дээр хэлсэн. Энэ Эдийн засаг, хөгжлийн сайдыг Эдийн засаг, хөгжил, ядуурлын эсрэг сайд гэж өөрчлөх боломж байгаа болов уу. Бид нар ядууралтай 900 гаруй мянган иргэд 27 хувьтай байж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөж байгаа хэр нь ядуурлын дүн буух буурахгүй байгаа. Энэ асуудлуудад хариулт авъя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Жавхлан сайд хариулт.

Б.Жавхлан: Батбаатар гишүүний асуултад хариулъя. Мөнгө олдог төслүүд гэж байна. Та экспорт хийдэг ийм томоохон аж ахуйн нэгж, юу гэдэг юм энэ бидний гол экспортын салбарын хөнгөн болон хүнд аж үйлдвэрүүд дээрээ улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийгээд, үйлдвэр байгуулаад, мөнгө олоод байна л гээд байх шиг байна. Үгүй ээ. Бид нар энэ тал руугаа явах юм бол буцаад л нөгөө социализм руугаа явна шүү. Тийм учраас бид нар мөнгө олдог биш, харин мөнгө олдог баялаг бүтээгчдийгээ хувийн сектор гаднын хөрөнгө оруулагч нарыг бид нар дэмжих ёстой юм байгаа юм. Дэмжихийн тулд бид нарын ганц хийх ёстой стратегийн хувьд төр заавал оролцох ёстой зүйл нь ерөөсөө л дэд бүтэц. Дэд бүтэц, дэд бүтэц бас дахин дэд бүтэц. Тэгээд өнөөдрийн хийгдэж байгаа ажлууд чинь бүгд дэд бүтэц. 80 хувь нь дэд бүтэц байгаа. Та энийг хагас сайн, бүтэн сайнд бас сайхан цаг гаргаад тайван бас юмнууд хараарай.

Мөнгөний бодлогыг Монголбанк хариуцдаг байгаа. Цалингийн өсөлт энэ удаа байхгүй ээ. Цалингийн өсөлт байхгүй. Тэгэхдээ таны өмнөх гишүүн цалинг өсөөч гээд тэглээ. Одоо тэгээд хэдүүлээ хамтраад сайхан тэгээд ярилцаад явна.

Орон тоо өссөн эсэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хариулчихвал уг нь их зүгээр байна.

Саяын ингээд Засгийн газрын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ганц нэг цөөхөн нэмэгдсэн зүйлүүд бол байгаа. Хороо хариуцаж байгаа сайд нар маань 10-15 ажлын албатай болсон. Энэ нийлээд 100 дотор л байгаа байх. Тэгээд энэ их том эрсдэл авчрахаар зүйл болохгүй байх. Хамтарсан Засгийн газар ажлаа хийхэд бүхий л нөхцөл боломжоор бид хангах ёстой юм байгаа юм.

Бага хүүтэй, урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл энэ тэр гээд энэ төсвийн тодотголоор бид нар ер нь бүх

юмаа шийднэ гэж байхгүй шүү дээ. Бүх юмаа шийдэх юм бол энэ байдлаар хэдүүлээ ер нь 1 шөнө биш, ер нь хэдэн шөнө хэлэлцэхээр юм шиг байна. Тэгэхээр 2025 оны төсөв орж ирэхэд бас энэ талаар хэдүүлээ ярилцъя.

Өр зээлийн менежмент дээр бол одоо бид нар нэгэнт авчихсан байгаа өрүүдээ бушуухан хэрэглээд, эргэлтэд оруулах хэрэгтэй байна. Нөгөө дэд бүтэц рүүгээ аваачаад. Энийг энэ удаа оруулж ирж байна. Мөн жил бүр дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэх буюу одоогийн дотоодын нийт бүтээгдэхүүнээр бол 1,5 их наядын ашигтай гарч байж, үүнийгээ хадгалаад, үүгээрээ дараа жилийнхээ юм уу, тухайн жилийнхээ өр зээлийг гадаадын өр зээлээсээ үүгээр хорогдуулаад явах ийм хуулийн зохицуулалт орж ирж байгаа. Энэ бол урьд өмнө байгаагүй маш том урагшаага алах болно. Бид нар хэзээ ч ингэж жил бүр 1,5 их наядаар зээл төлбөрүүдээ хийж байгаагүй. Амжаа ч үгүй. Одоо ийм боломж гарч ирж байна. Хуулийн ийм хязгааруудын зохицуулалт оруулж ирж байна.

Төрийн өмчийн байгууллагуудын тэр мөнгө төгрөгөө өгдөггүй, ажил хийлгэчихээд гэж байна. Үүнтэй ёстой тэгээд л бүгдээрээ хамтраад л тэмцэнэ. Энэ одоо үеийн үед л тэмцэж явж ирсэн. Төрийн өмчийн компаниудын, төрийн өмчит үйлдвэрийн газрууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг ер нь шинэчлэл хийх, татан буулгахыг нь татан буулгах, нэг ямар ч байсан үлгэн салган яваад байгааг нь үнэхээр нийгэм, эдийн засгийн үр ашигтай гэвэл бирж рүү гаргаж, олон нийтийн хяналтад оруулах гээд ийм өөрчлөлтүүдийг бол сүүлийн 2-3 жилийн дотор бол хийсэн. Ялангуяа Сангийн яамны харьяа байдаг төрийн өмчийн үйлдвэрийн газрууд болох бирж, Төрийн банк, эдгээрийг бирж рүү гаргаж, биржийг хүртэл өөрийнх нь хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалсан ийм шилжилтүүдийг, бүтцийн

өөрчлөлтүүдийг амжилттай хийж байгаа. Шат дараатай хийнэ.

Хөндлөнгийн мониторинг гэж та их зөв сонссон байна. Зөв ч ойлгосон байна. Засгийн газар томоохон бүтээн байгуулалтуудыг хийхдээ, энд юуны тулд энэ чинь том том салбар яамнууд байгаа билээ. Мэргэжилтэн, үндэсний мэргэжилтнүүд байгаа билээ. Тэрийгээ эрэмбэлэх хэмжээний ажлыг бол өөрсдөө эрсдэл хариуцлагаа хүлээгээд яамнууд, Засгийн газар өөрсдөө хийх хэрэгтэй. Энэ зөв үү, буруу юу энийг шийдээд өгөөч гээд.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одоо Жуковын Алдаржавхлан. Тодруулах юм уу. Батын Батбаатар гишүүн тодруулга.

Б.Батбаатар: Үгүй ээ, яах вэ. Би зөв, буруу гэдэг талаас нь илүү Сангийн сайдын Засгийн газрын байр суурийг л сонсъя гэсэн юм л даа. Тэрэнд болж өгвөл эмзэглэхгүй байвал зүгээр байна. Төсвийн тодотгол хэдийгээр мөн боловч Эдийн засаг, хөгжлийн сайд ядуурлын эсрэг гэдэг нэршлийг нэмж авч болдоггүй юм уу. Одоо бид нар нэгэнт мөрийн хөтөлбөр ингээд л төсөвтэйгөө хамт хэлэлцээд л явж байгаа учраас энэ тухай асуугаад, дээрээс нь түрүүн бас Сангийн сайд нэг зүйл буруу ойлгочихлоо. Би нөгөө цалин нэмэгдсэн нэмэгдлийг асуугаагүй шүү. Зүгээр хүний орон тоо нэмэгдсэн өөрчлөлт орсон уу гэж асуусан. Тэгээд тодруулж асууж байгаа тиймэрхүү зүйлүүд дээр эмзэглэхгүй байвал их зүгээр байна.

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя. Тэргүүн шадар сайд Гантөмөр сайд хариулъя.

Л.Гантөмөр: Яах вэ, Бид нар бол энд Засгийн газрын байр суурийг илэрхийлж байгаа гэдгийг манай гишүүд маш сайн ойлгож байгаа байх гэж бодож байна. Засгийн газар бол бүхэлдээ ядуурлын өмнө хариуцлагаа хүлээнэ. Бид бол кабинетынхаа байр суурийг л энд

хэлнэ. Энд бол өнөөдөр өргөн барьсан төсвийн тодотгол бол аль нэг яамны төсвийн тодотгол биш. Аль нэг яамны бодлогыг бол энд өнөөдөр одоо яг энэ цаг мөчид бол ярихгүй байгаа. Тийм учраас хэн нэгэн сайдад ямар нэгэн нэр хоч өгснөөрөө асуудал бол шийдэгдэхгүй. Бид бол ядуурлыг 2 дахин буулгана гээд Засгийн газар бол ийм зорилгыг таны түрүүн хэлсэн хуулийн хүрээнд бол танилцуулгаа хийчихлээ шүү дээ. Үгүй ээ, нэр хоч л өгч байна л даа. Тэгэхдээ бид.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн асуултаа асууя. Гишүүд дэгээ барина шүү.

Ж.Алдаржавхлан: Би асуултаа асуучихъя. Байж байгаарай би асуултаа асуучихъя. Батбаатар гуай байж байгаарай. Би Хот байгуулалт, орон сууцын сайдаас нэг зүйл асуух гэсэн юм. Танай яамнаас 150 тэрбум төгрөг төсвийн тодотголд оруулсан байна. Солонго 1, 2 гэж хороолол байгаа. Тэр дээр би таныг бас надтай хамт очоосой гэж хүсэж байгаа. Тэр орон сууцын хороолол Засгийн газрын бодлогын эсрэг тийм орон сууцын хороолол баригдаж байгаа. 5002 айлын орон сууц, 18 мянган хүн амьдрах гэж байгаа. Сургууль, цэцэрлэг бараг байхгүй. Нэг жижигхэн сургуультай. Тэгээд яаж тэр бодлогын яам, сургууль, цэцэрлэггүй тийм хорооллыг бодож олж санхүүжүүлдэг юм. Тэгээд тэнд орсон тэр 18 мянган хүн 5 мянга орчим сургуулийн насны хүүхдийг хаана хичээллэнэ гэж бодож байгаа юм. Тэгэхээр та энэ орон сууцын хороолол дээр очиж үзэж, энэ төслөө ер нь эргэж харахгүй бол хайран 150 тэрбум төгрөг явах вий дээ гэсэн ийм асуулт байгаа юм. Тэгээд би танай яамныхантай утасдаж асуусан. Үгүй ээ, энэ орон сууцын хороолол чинь сургуульгүй байна шүү дээ гэсэн чинь аль дээр ашиглалтад ороод хүүхэд нь дүүрчихсэн сургуулийг зааж байгаа байхгүй юу. Энд орох ёстой гээд. Танай яамныхан мэдэж байгаа. Тэгэхээр энэ орон сууцын төслийг та Засгийн

газрынхаа бодлогод нийцүүлж, энийг өөрчилж өгөөч. Концепцын хувьд өөрчилж өгөөч гэж би ийм хүсэлтийг тавьж байна. Та одоо үнэхээр зав байвал ирэх 7 хоногт энэ дээр очиж, газар дээр нь өөрийн нүдээрээ хараасай гэж хүсэж байгаа.

2 дугаарт нь төсвийн зарлагын танилцуулах хэсэг дотор төрийн албан хаагчдыг жил бүр тоог нь 10 хувиар бууруулна гэсэн байна. Энэ үнэн юм уу. Яаж бууруулах юм бэ. 226 мянга арай ч буурахгүй байх. Багш энэ тэрээ хасах юм бол 100 мянган хүнээ жилд 10 хувь бууруулна гэхлээр 10 мянган хүн бууруулах юм уу. Энэ яаж тооцсон юм бэ. Ийм 2 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Батсуурь сайд.

Ж.Батсуурь: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Ажил аваад яг өнөөдөр 30 хонож байна. Тийм болохоор тэр хорооллыг бол 30 хоногт эхлүүлэх юм уу, барьчих боломжгүйг бол та өөрөө мэдэж байгаа. Гэхдээ газар дээр нь очиж үзсэн. Яг нөхцөл байдлыг үзсэн. Бас 50, 60 хувьтай явж байгаа. Зарим хэсэг нь 70, 80 хувь хүрчихсэн ийм бүтээн байгуулалт явж байна. Тэгээд тэрийг бол тэр чигээр нь орхих ямар ч боломж байхгүй. Тэгээд бид нарын мэддэгээр бол Буянт-Ухаа 1, Буянт-Ухаа 2 гээд тэр ойр хорооллууд байна. Дээр нь хувийн хэвшилээс бас том том хорооллууд бий болж байна. Тийм учраас ерөнхийдөө цаашид бол концепцыг нь өөрчлөх, дараагийн орон сууцын бодлого бол төрийн мөнгөөр, төслийн мөнгөөр орон сууц барина гэхээсээ илүү газрын доорх систем, нийтийн ахуйн тэр системийн асуудлууд руу Хот байгуулалт, барилга, орон сууцын яам бол бодлогоо чиглүүлнэ. Гэхдээ одоо энэ эхэлчхээд байгаа төслүүдийг бол өмнө нь буруу эрхэлсэн, зөв эхэлсэн гэх нь бол одоогоос хэлэх тийм боломжгүй. Нэгэнт эхэлчихсэн. Тэрийг дуусгах л ёстой. Дахиж алдаатай зүйл байх юм бол дараагийн хорооллууд,

дараагийн төслүүдийг алдаагүй байлгах талаас нь бол онцгой анхаарч ажиллана гэж ингэж бодож байгаа юм.

Ер нь бас дахин төлөвлөлт, орон сууцын шинэ хорооллуудтай асуудлуудын алдаа оноотой талууд дээр бол дүгнэлт хийж, бид нар ажлын хэсэг гаргаж ажиллаж байна. Шинэ Зуунмод гээд, Хөшигийн хөндийн хот байгуулалт, Хархорины хот байгуулалт, мөн аймгийн чанартай хотууд, улсын чанартай хотуудын цааш нь өргөтгөх ажлууд дээр бол онцгой анхаарч ажиллаж гэж ингэж бодож байна. Ер нь бол орон сууцын ерөнхий барьж байгаа концепцыг бол таны хэлдгийн дагуу өөрчлөөд сайжруулаад явна гэж ингэж ойлгож болно. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд. Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

Л.Энх-Амгалан: Төрийн албан хаагч нарын тоог жил бүхэн 10 хувь гээд тэгэхээр одоо төрийн албан хаагч нар чинь 226 мянга, 228 мянга гэсэн ийм тоо байгаад байгаа юм. Тэгээд энэ тоогоо бас бид нар нягтлах ёстой. Нийт яах вэ, үндсэндээ бол 70 орчим хувь нь төрийн үйлчилгээний албанд байгаа. 30 орчим хувь нь бол төрийн захиргааны албанд байгаа. Тэгээд энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссан гол асуудал бол төр заавал ч үгүй бүх зүйлийг хийх албагүй. Аль болохоор хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын мэргэшсэн ... гэхдээ мэргэшсэн шүү, мэргэшсэн чадавхжсан төрийн бус байгууллагуудаар төрийн зарим үүргүүдийг гүйцэтгүүлэх ийм зорилготой, ийм хүсэл тэмүүлэлтэй ингэж ажиллаж л гэсэн ийм л юу байгаа юм. Тэрнээс биш юу гэдэг юм.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг асуулт асууя. Алдаржавхлан гишүүн тодруулга авъя.

Ж.Алдаржавхлан: Батсуурь сайд аа, тэгвэл юу яая. Ингээд зүгээр орхиж болохгүй юм байна лээ. Тэр чинь ингээд энийг дуусгачихъя гээд орхичих юм бол тэр гамшиг болох гээд байгаа юм. Зүгээр л бетон ширэнгэ. Тэгэхээр та хэд маань энэ нийслэлтэйгээ хамтраад, хажууд нь газар хайж олоод, тэр төслийнхөө хүрээнд сургууль, цэцэрлэгийг гэрийн хажууд байх хамгийн сайн гээд байгаа шүү дээ. 20 минутын хотын чинь үндсэн концепц нь хүн гэрээсээ гараад л сургуульдаа очдог байх ёстой л гэсэн концепц байна. Тэгэхээр тэр байхгүй болчихоод байгаа байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг орхиж болохгүй байгаа юм. Өмнөх хүн хийсэн юм чинь надад хамаагүй гэж орхиж болохгүй. Тийм учраас таныг би нийслэлтэйгээ хамтраад хажууд нь газар энэ тэр шинээр олоод сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нь сайжруулж өгөөч гэж хүсэж байна. Би Хан-Уулчууд энийг сонсож байгаа гэж хүсэж байна.

Тэр 10 хувийг бас манай Сангийн яамныхан танилцуулга бичсэн байлгүй дээ. Бас бодож байгаад хийсэн байлгүй. Нэлээн бас тийм ноцтой тоо явж байна лээ шүү. Энийгээ бас та хэд маань эргэж хараасай гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуултаа асууя.

О.Номинчимэг: Та бүхэнд энэ оройны мэндийг хүргэе. Энэ удаагийн төсвийн тодотгол ерөнхийдөө бас Улаанбаатар хотод тулгамдаж байгаа асуудал замын сүлжээ, түгжрэлийг бууруулахтай холбоотой чухал ач холбогдолтой бүтээн байгуулалтын төслүүд, Туулын хурдны зам, тойрог зам гэх мэт. Мөн гэр хорооллын агаар орчны бохирдлыг бууруулахад бас дорвитой эхлэл болох Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлт гэх мэтчилэн нийслэл хотод тулгамдаж байгаа Монгол Улсын хүн амын тал хувь нь амьдарч байгаа энэ хотынхоо асуудлыг бүтээн байгуулалтад ингээд анхаарч орж ирж байгаад бол баяртай байна. Дэмжиж байна. Харин

энэ төсвийн тодотголтой холбоотойгоор дагалдаж орж ирсэн Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлэх, тухайлбал Тавантолгой түши компани.

Тэгэхээр яах вэ, энэ Тавантолгой түши компани бол мэдээж хэрэглэгчид нь нийслэлийн иргэд байгаа. Ийм ч учраас иргэддээ илүү чанартай технологийн шинэчлэл хийсэн, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн нь чанарын хяналтыг нь хангалттай хийдэг, цаашидаа энэ Тавантолгой түши үйлдвэр бол өөрөө ашигтай ажиллах ёстой. Энэ бүгдийг нэг эзэнтэй болгоод, өдий хүртэл явж ирсэн эзэнгүй юм шиг эсвэл хэн нэгэнд харьяалагддаггүй юм шиг ингэж явж ирсэн байдлыг цэгцлээд бас нийслэлд шилжүүлж, нэг эзэнтэй болгож энийгээ ингээд тодорхой болгож байгаа нь бол зөв байх гэж бодож байна.

Зүгээр энэ дээр төрийн өмчийг нийслэлийн өмчид шилжүүлж байгаа асуудал дээр энэ танилцуулга дээр бичсэнээр Тавантолгой түши компани маань өөрөө одоогоор 790 тэрбум төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай байгаа. Тэгэхээр энэ компани өөрөө энэ хуримтлагдсан алдагдалтайгаа тэр чигээрээ нийслэлд очих юм бол нийслэлийн санхүүгийн нөхцөл байдалд нэлээн одоо бас өөрчлөлт, дарамт ирэхээр байна гэж харж байгаа юм. Нэг талаараа төсвийн тодотгол маань нийслэлийн бүтээн байгуулалт, төсвийн хөрөнгө оруулалт, өөрийнх нь хөрөнгө оруулалтад дэм болсон ийм төсөв орж ирж байгаа боловч нөгөө талаараа автоматаар энэ тогтоолоор бол 790 тэрбум төгрөгийн өрийг тавьчихаж байгаа юм. Тэгэхээр энэ төсвийн тодотгол дээр гарч байгаа нийслэлийн бондод зориулсан зарлага гээд 1 их наяд. Цаашилбал Сэлбэ дэд төвийн бүтээн байгуулалт, орон сууцжуулалт дээр зориулж нийслэл бас гадаад бонд гаргахаар бэлдэж байгаа. Энэ болгон дээр нь бүгд санхүүгийн үзүүлэлтүүдийг олон улсын байгууллагаас рейтинг хийж

дүгнэдэг. Тэгэхээр энэ бүгдийг ингээд өртэй нь шилжүүлчих юм бол энд ч гэсэн нөлөө үзүүлээд, нөгөө нийслэлийн цааш цаашдын бид нарын зорьж байгаа бүтээн байгуулалтад бол саад учрах юм гэж харж байгаа юм. Тэгэхээр яах вэ, энийг бол уг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас би асуумаар байсан. Тэгэхээр байхгүй байна. Ер нь бол энэ компанийн өрийг Тавантолгой Эрдэнэс Тавантолгой гэдэг компанитай бол өрийн харилцаатай гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ өрийн харилцаан дээр өрийг нь илүү шилжүүлэх байдлаар шилжээд, нийслэлд өргүй шилжүүлэхэд төсвийн харилцаан дээр ямар нэгэн өөрчлөлт орохгүй. Энэ төсвийн тодотгол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулъя. Хотын дарга хэддүгээр микрофон бэ. 2 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Баярлалаа. Номинчимэг гишүүн бид хэд сая бас Ерөнхий сайдад өргөн барьсны дараа энэ асуудлаар ярьчихсан. Ажлын хэсэг дээр энийг нэг тогтоолын төсөл дээр байх 3 заалт оруулъя гэж ярьсан байгаа. Таны хэлдэг яг зөв. Нийслэл Улаанбаатар хот удахгүй гадаад бонд гаргах бэлтгэл ажил хангагдаж байгаа. Үүнтэй холбоотой нөгөө зохих шалгалтын ажлууд хийгдэж байгаа. Тэгэхээр бид хэрвээ энэ шалгалтын явцад нөгөө бонд сонирхож байгаа байгууллагууд маань манай нийслэлийн төсөв дээр ийм их хэмжээний хуримтлагдсан өр, алдагдал байгаа гэж үзсэн тохиолдолд бондод эрсдэл үүсэх нөхцөл байдал байгаа учраас үүнтэй холбоотой харилцаа дээр тэр саяын ярьсан өрийг “Эрдэнэс Тавантолгой” дээр, тэгээд цаашиаад цаашид “Эрдэнэс Тавантолгой”-г алдагдалгүй ажиллуулахыг нийслэл Улаанбаатар хотод даалгасан ийм 2 заалтыг оруулаад явъя гэсэн ийм байдалтай байгаа. Бид нар удахгүй бас өвөлжилтийн бэлтгэлийг хангах, түли нөөцлөх, технологийг сайжруулах гэх мэт ийм хүлээгдэж байгаа ажлууд байгаа учраас энэ удаагийн төсвийн тодотгол дагуулаад

Улсын Их Хурлын тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хуульд заасны дагуу төрийн өмчийг орон нутагт шилжүүлэх ийм тогтоолын төсөл дээр ажлын хэсэг дээр саяын ярьснаар ярилцъя гэдэг ийм ойлголтод хүрчхээд байгаа.

Д.Амарбаясгалан: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуух 3 асуулт байна.

1 дүгээрт энэ хөрөнгө оруулалтын зардал дээр шинээр хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 9 арга хэмжээнээс 8 арга хэмжээг 2024 онд бүрэн хийж хэрэгжүүлж санхүүжүүлнэ гэж. Нэг төслийг 3 жилийн хугацаанд хэрэгжүүлэх, ингэхдээ 2024 онд нийт төсвийн 15 хувийг санхүүжүүлнэ гэж. Нийтдээ 384 тэрбум төгрөгийг 2024 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Энэ ажлууд энэ ондоо дуусах боломжтой юу. Ажлын төвөгшил, объём ер нь ямар хэмжээнд гарна гэж тооцож төлөвлөсөн бэ. Санхүүжилтийг бүрэн гарна гэж төлөвлөж байгаа нь ер нь хэр бодитой юм бэ гэдэг асуулт байна. 1 дүгээрт.

2-т нь эдгээр төслүүдийн ТЭЗҮ боловсруулах ажилд зарцуулах тэр зардал, төсвийг тооцож одоо төлөвлөхдөө ямар арга аргачлал, жишиг үнийг баримталж боловсруулсан бэ гэдэг асуулт.

3 дугаарт нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн энэ арга хэмжээнүүдийн зураг төсөв нь ер нь бүгд батлагдаж, магадлалд орсон болов уу. Ийм 3 асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Манай 5 сайд төсвийн ерөнхийлөн захирагч нарын хувьд энэ том

бүтээн байгуулалтуудтай холбоотой энэ жилийн хувьд бэлтгэл ажлыг хангах, саяын таны хэлсэн дүн бүхий зураг төсөв, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээтэй холбоотой ийм төсвүүд тавигдсан байгаа. Сайд нар маань, яамнууд маань бүгдээрээ л хамтарсан Засгийн газрын ид шид энэ дээр гарах ёстой гээд бүгд өөрсөд дээрээ томоохон амбицтай, томоохон зорилго тавиад эрч хүчтэй ингээд л ажилдаа орцгооё гэж байгаа юм.

Тийм учраас хэдүүлээ ингээд л уг нь дэмжээд л энэ хамтарсан Засгийн газрынхаа ид шидийг гаргах л хэрэгтэй байгаа юм. Тэгээд сайд нар маань бас хэлнэ биз дээ. Ямар ч байсан ингээд Их Хурал маань бас дэмжинэ болов уу гэж ингэж найдаж байна. Ингээд нэлээн том ийм бас урьд өмнө байгаагүй ийм бэлтгэл ажил хангах төсөв тавигдаж байгаа учраас бүгдээрээ хамтраад, бие биеийгээ дэмжээд сайхан ажиллацгаана гэж бодож байна.

Тэр ТЭЗҮ, жишиг үнэ нь ямар байсан бэ гээд энэ талаар бас манай сайд нар бас нэг ганц нэг томуудаасаа хэлчихвэл их зүгээр байна.

Нийслэлийн зураг төсвийг Нямбаатар сайд хариулчих уу.

Д.Амарбаясгалан: Хотын дарга Нямбаатар хариулъя. Нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Би 3 дахь асуултад нь хариулт өгье. Нийслэл Улаанбаатар хот дотоод бонд 1 их наядыг гаргахаар Засгийн газраас зөвшөөрлөө авсан. Эхний транчаар 500 тэрбум төгрөг босгоод байгаа. Ер нь 1 их наяд төгрөгөөр яг юу хийх гэж байгаа вэ гэдэг тал дээр Их Хурлын гишүүдэд маш товчхон мэдээлэл өгье. Үүний 600 тэрбум төгрөг нь эрчим хүчний 2 төслийг санхүүжүүлж байгаа. 300 тэрбумаар Бөөрөлжүүтийн төсөлд дамжуулан зээл олгож байгаа. Бөөрөлжүүтийн төслийг бүхэлд нь нийслэл өөрөө барьцаалаад, төслийг 1 дүгээр үе шатыг нь энэ 10 дугаар сарын 1

гэхэд дуусгаж, төвийн эрчим хүчний системд 150МВт-ыг нийлүүлэх ийм гэрээтэй байгаа.

2 дахь үе шат нь ирэх жил 150МВт-ыг мөн 10 сарын 1-нд 2025 оны 10 сарын 1-нд буюу ингэснээр төвийн эрчим хүчний систем 300МВт-аар нийлүүлэгдэх Тэц 3-аас том ийм чадал үйлдвэрлэх ийм төсөл дээр хөрөнгө оруулалт оруулж байгаа.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Х.Нямбаатар: 2 дахь эрчим хүчний төсөл бол мөн энэ 11 дүгээр сарын 1-ээс өмнө 50МВт-ын батарей станцыг нийлүүлэх ийм нээлттэй тендер зарлагдаад, гүйцэтгэгч нь шалгараад гэрээлээд явж байгаа. Ингээд энэ жил бид нар дутагдаж байгаа 200МВт-аа энэ өвлөөс өмнө нөхнө гэдэг ийм агуулгатай байгаа. Үлдсэн 400-ын 270 нь замын зураг төсөлтэй замууд дээр оруулсан. 130 нь Туул 1 коллектор, гэр хорооллын орон сууцжуулах хүрээнд зураг төсөлтэй инженерийн шугам сүлжээ, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцнуудтай 2014, 2015 онд байгуулагдсан шугам сүлжээг санхүүжүүлэх ийм ажлуудад зарцуулагдаж байгаа. Одоогоор эхний 500-г нь босгосон байгаа. Үлдсэнийг нь гүйцэтгэл гарахаар санхүүжүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Учир нь урьдчилаад бондоо босгочихвол зээлийн хүү тоологдоно гэдэг ийм зарчмаар ажиллаж байгаа.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Энэ том төслүүдээс Зам, тээврийн яаманд харьяалагдаж байгаа 1 том төсөл дээр жишээ авч яривал туннелийн бүтээн байгуулалтын ажил байгаа юм. Туннелийг бол бид гэнэт сая ингээд хамтарсан Засгийн газар гарч ирээд ярьж байгаа юм биш. Ер нь бол өнгөрсөн оны бараг 10

сараас эхэлж яригдсан. Өөрөөр хэлбэл миний бие хотод Түгжрэлийн сайд хийж байсан тэр үеэс эхэлж, хотын түгжрэлээс яаж гаргах вэ гэдэг хүрээнд бол туннелийн асуудал яригдаж эхэлсэн тэр цагаас хойш. Тэгээд энэ туннелийг хийх зардал мөнгөний асуудлаар бол нэлээн олон компаниудтай уулзалт хийж, ер нь ямар төслөөр босох вэ, бид уралдаант шалгаруулалт хийвэл ямар үнийн дүн гарах вэ гэдэг ийм судалгааг бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут.

Б.Дэлгэрсайхан: Олон газруудаас авч байсан. Тэгээд жишээлбэл ганц жишиг үнэ, нийтлэг жишиг үнэ яривал 15,3 км туннел өөрөө машинаар хийвэл 1,2 тэрбум ам доллар болж байгаа юм. Зүгээр яг дотор нь тэсэлгээ хийгээд явбал 700 сая доллар болох жишээтэй. Тэгэхээр зэрэг өөрийн чинь асууж байгаа энэ зураг төсөл, төсвийн урьдчилсан РМС зориулагдаж байгаа үнийн дүн нь уг баригдах үнийн дүнгийн олон улсын жишигээр бол 4-5 хувьтай нь л хийж байгаа гэсэн үг. Бусад төслүүд бүгд л тийм явж байгаа гэж. Тэгэхээр зэрэг энэ дээр бол ийм хариулт өгье гэж бодож байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үүрийнтуяа гишүүн тодруулга.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Яах вэ нэгтгээд саналаа 1 минутдаа багтаагаад хэлчихье. Хийж хэрэгжүүлж байгаа, төлөвлөж байгаа том төслүүдийг бодлогын хувьд бол дэмжиж байгаа. Ийм хэмжээний хөрөнгө оруулалт ойрын жилүүдэд ялангуяа нийслэлд маань ингээж төлөвлөгдөж улс төрийн зориг гаргаж орж ирж байгаагүйг ойлгож, дэмжиж байна. Гэхдээ бид төлөвлөлтөө оновчтой хийж, санхүүжилтийн хувьд бодитой тооцоо судалгаа дээрээ мөнгөн урсгалаа зөв төлөвлөөсэй гэдэг үүднээс тодруулга авч асуулт асуулаа.

Тэгэхээр Үндэсний аудитын газраас өгсөн энэ зөвлөмж дээр байгаа анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудлууд байна лээ. Энэ дээр та бүхэн маань бас анхаарч ажиллаарай гэдгийг хүсье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Жаргалсайханы Золжаргал гишүүн асуултаа асууя. 3

Ж.Золжаргал: Инновац, шинэ технологи нэвтэрч байгаа олон улсын туршилагыг харах юм бол их сургуулиудын дэргэдэх хүрээлэнгүүдээс их явдгийг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа байх. Тэгээд манай энэ шинэ хуваарилалтаар их сургуулиудын харьяаны 17 хүрээлэн байгаа нь чиг үүргийнхээ хувьд Эдийн засаг, хөгжлийн яам руу шилжчихсэн. Үйл ажиллагааны хувьд Боловсролынхоо яам дээр байдаг. Санхүү нь болохоор нөгөө талдаа оччихсон байгаад байгаа юм. Тэгээд энэ их төвөгтэй байдлыг үүсгэхээр харагдаад байна. Ялангуяа энэ салбарын хүмүүс нь бол бүгд их тийм том асуултын тэмдэг болчихсон байдалтай яваад байна. Тэр их сургуулийн харьяанд байгаа эрдэм шинжилгээний хүрээлэн дээр чинь старт ап компаниуд байна. Инновац хийж байгаа гарааны компаниуд байна. Тэгээд сургуулийнх нь судлаачид, багш нар, эрдэмтэд нь, оюутан судлаачид нь тэндээ хамтарч ажилладаг ийм тогтолцоо байдаг. Тэгээд нөгөөх нь Эдийн засгийн яам дээр очоод нэг түшмэлээс нөгөө төсвийн хуваарилалтаа авна. Цаадах нь болохоор шал өөр салбарын өөр хүн бүр наад зах нь ойлголцохоос өгсүүлээд асуудал байгаа. Тэгэхээр энийг хэлэлцүүлгийн явцад шийдэж өгөх боломжтой юу гэж нэг асуулт.

2 дугаарт нь Цахим хөгжлийн талаар энэ 19.1.3 гээд хавсралт 2-ын алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтцэд төсөв байгаа 10 тэрбум төгрөгийн тодотгол байна лээ. Тэгээд энэ нөгөө холбоо харилцааны гэж ойлгож байна. Интернэтийн хүртээмж маш муу байна. Монгол Улсын 600 гаруй сургуулийн ерөөсөө 56 хувь нь 5-10 мВт

секунд буюу бараг тэр цахим сургалт ерөөсөө боломжгүй гэсэн үг. Тэгэхээр энийг энэ мөнгөн дүнгийнхээ 10 хувийг нь ч юм уу зарцуулаад яахад бүрэн бүрэн хангагдчихаар нэг хэсэг нь ядаж хөдөлгөөнт шийдлээр болохоор байгаа юм. Тэгээд энийг тусгаж өгөх боломжтой болов уу.

Бас нэг асуулт. Засгийн газрын хөтөлбөрт 11,9км BRT тусгай замын автобус барина гээд оруулчихсан байгаа юм. Хамгийн хямдхан өртгөөр хурдхан шиг хийгдэх боломжтой ийм тээврийн хэрэгсэл. Түгжрэл шийдэл болж чадахуйц. Үүний үнэ энэ төсвийн тодотгол дээр бол харагдаагүй. 2025, 2026 оны юунд бас байхгүй байна. Тэгэхээр энийг эсвэл би олж харсангүй юу, эсвэл ерөөсөө хойш нь оруулчихсан байгаа юу. Тэгээд ТЭЗҮ-үүд дээр нийт дүнг нь би сая нэмээд үзсэн. Эхний танилцуулга дээр байгаа ТЭЗҮ нь 280 тэрбум болж байна. Тэгэхдээ тэнд бол Туулын хурдны зам, 2 тойрог замууд, дулааны станцууд, гэр хорооллын дэд бүтэц гээд эд нарыг хасаад, нөгөө юуны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 2 дугаар микрофон. Хотын дарга Нямбаатар хариулна.

Х.Нямбаатар: Би хариулъя. Энэ удаагийн төсвийн тодотгол дээр Улаанбаатар хотын хэрэгжүүлэх дэд бүтцийн 2 том төслийн зөвлөх үйлчилгээний зардлыг шууд тусгаагүй. Учир нь юу вэ гэвэл Туулын хурдны замын зураг төсөв батлагдчихсан. Одоо энэ 9 дүгээр сард тэр, хувийн хэвшлийн түншилэлээр олон улсын нээлттэй тендер зарлахаар бэлтгэл ажил хангагдаж байна. Ингэхээр зөвлөх үйлчилгээний зураг төслийн тендер зарлах шаардлагагүй байгаа. 2 дугаарт түүнтэй холбогдох Улаанбаатар хотын тойрог хурдны замын зөвлөх үйлчилгээний тендерийг бид эхний ээлжид урьдчилсан ТЭЗҮ гаргах тендерийг нийслэлийн төсвийн хөрөнгөөр зарлахаар төлөвлөсөн байгаа. Урьдчилсан ТЭЗҮ гарч ирсний дараа, зөвлөх

үйлчилгээний багийг сонгон шалгаруулна. Үүний дараа ямар эх үүсвэрээр шийдэх вэ, өөрөөр хэлбэл BOT-ээр явах уу, эсвэл хөгжлийн сангаас нийслэлд зээллэгээ аваад эргээд нөгөө тоолуураа төлөх үү гэдэг ийм тооцоолол судалгааг манай дээр хийгээд ажиллаж байгаа гэдгийг хэлье. Өөр ямар асуулт асуулаа.

BRT дээр хариулъя. Манай дээр хэрэгжүүлж байгаа энэ BRT төслийн судалгааны ажлууд хийгдээд энх тайвны өргөн чөлөөгөөр явагдах BRT-г хойд тойруу буюу бидний нэрлэж заншсанаар хойд тойруугаар явуулахаар ингээд судалгааны ажлууд хийгдээд явж байгаа. BRT гэдэг дээр зүгээр маш энгийн ойлголт өгөхөөр энэ бол тусгай замын автобусны л асуудал яригдаж байгаа. Өөрөөр хэлбэл одоогийн авто замтай давхцахгүй тусгай замын голоор явдаг ийм автобусны чиглэл маршрутыг бий болгох асуудал яригдаж байгаа. Энэ дээр тусгайлсан өөрийн гэсэн автобусны буудалтай тусгайлсан замтай байдаг. Тэгээд бид нар хойд тал дээр одоо газар чөлөөлөлтийн тооцоо судалгааг манай төслийн нэгжийнхэн хийгээд явж байгаа. Энэ бол газар чөлөөлөлтийн асуудал орон нутгийн төсөв дээр суугдана. Төсөл хэрэгжүүлэх үндсэн санхүүжилт нь төслөөсөө гарахаар ийм төлөвлөгөөтэй явж байгаа. 2 дугаар шугамыг бол бас босоо шугамдаа байж болох талаарх урьдчилсан тооцоо судалгаа хийгдээд явж байгаа. Энэ BRT-ийн төслийг зогссон зүйл байхгүй. Төсөл хуваарийн дагуу явж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Тодруулга авах юм уу. Золжаргал гишүүн тодруулга авъя.

Ж.Золжаргал: Нөгөө өмнө 2 асуулт байгаа. Тэрийг хариулж өгнө үү. Тэгээд саяын асуулт дээр тэр тойрог замуудыг зайлшгүй хэрэгтэй. Бусад нөгөө том төслүүд Хархорум, өөдөө тэмүүлэх Монгол энэ тэрийг заавал хийх шаардлагатай юм болов уу ТЭЗҮ-г тусгаж гэсэн тийм л асуулт байсан юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хотын дарга Нямбаатар нэмж хариулъя. 2 дугаар микрофон.

Х.Нямбаатар: Их Хурлын дарга аа, яг надаас бол асуусангүй. Хотын 2 төслийг Золжаргал гишүүн маш зөв зүйтэй төсөл гэж сая хэлсэн гэж ойлголоо. Ер нь бол бид нар нийслэлийн санхүүгийн тооцооллуудыг 2028 он хүртэлх тооцооллуудыг гаргаад ажиллаж байгаа. Мөнгөн урсгал, зээлийн эргэн төлөлт гээд бүх хүчин зүйлүүдээ тооцоод, саяын энэ тойрог хурдны зам болон Туулын хурдны замыг төсөвт дарамт учруулахгүй байдлаар бид зохион байгуулахаар төлөвлөж байгаа. Тухайлбал эхний Туулын хурдны зам гээд 33 км урт үргэлжлэх урттай нийтдээ одоогийн зураг төсвөөрөө 425 сая ам.доллар-ын төсөвт өртөг бүхий энэ зам бол баруунаас зүүн тийшээ Улаанбаатар хотын хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх энэ замыг барьж, ашиглаж, шилжүүлэх нөхцөлтэйгөөр төр, хувийн хэвшлийн түншлэлээр зарлахаар бэлтгэл ажил хангагдсан гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Саяын Золжаргал гишүүний асуултад Равжихын Эрдэнэбүрэн гишүүн, Монгол улсын сайд, “20 минутын хот” Үндэсний хорооны дарга хариулах юм байна.

Р.Эрдэнэбүрэн: Тэр Хархоринтой асуудлыг Батсуурь сайд хариулах байх. Тэр Өөдөө тэмүүлэх Монгол гүүр хэрэгтэй юм уу гээд асууж байх шиг байна. Энэ гүүр татлагат гүүр гэж бид нар нэрлэж байгаа. Гүүр туннел, цаашаа гараад Зуунмод, Шинэ Зуунмод хот, энэ бүгдээрээ Засгийн газрын нэгдсэн байр гээд бүгдээрээ ийм хоорондоо уялдаа холбоотой төслүүд байгаа юм. Бие биетэйгээ холбоотой. Тийм учраас энэ төслүүд дээр нэгдсэн байдлаар зөвлөх үйлчилгээ авах шаардлагатай гэж манай хорооны гишүүн сайд нар үзээд, тэгээд яах вэ тус тусдаа зөвлөх үйлчилгээний мөнгийг тавиулчихсан байгаа. Ер нь бол миний бодож байгаагаар энэ дээр энэ

төслүүд дээр бүгд дээр нь нэгдсэн байдлаар олон улсын зөвлөх авах байх. Тэгээд бүх сайд нар зэрэг зураад, тус тусдаа тавигдсан санхүүжилтээ бол нэг байдлаар нэгдсэн байдлаар гэрээ хийж таарах бай гэж ингэж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батсуурь сайд бас хариулах болчхов уу. Сайд нар маань яг хариуцаж байгаа асуудлуудаа сонсоод та бүхэн маань гараа өргөөд хариултаа өгөхгүй бол тойрч яваад байх шиг байна. Батсуурь сайд хариулъя. Баатархүү сайд хариулах юм уу. Баатархүү сайд хариулъя. Баатархүү сайдын микрофоныг өгье.

Ц.Баатархүү: Золжаргал гишүүний асуултад хариулъя. Золжаргал гишүүний 1 асуулт бол 2024 оны улсын төсөв дээр 20 тэрбум төгрөг шилжихээр суусан байгаа. Энэ бол алслагдсан сум, багуудад шилэн кабелийн хүртээмжийг нэмэгдүүлэх ийм төсөвт суугаад 2024 ондоо 10 тэрбум төгрөгийг тухайн үеийн төсөвт тусгаж, 2025 ондоо 10 тэрбум төгрөгийг бол одоогоор шилэн кабель холбогдоогүй байгаа сумуудад хүргэх ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. 2025 оны тухайн үед суусан 10 тэрбум төгрөгийн энэ шилэн кабелийн төсөвт одоогоор интернэтийн кабель хүрэлцээгүй байгаа Монгол Улсад бол 5 сум байгаа. Нийт нутаг дэвсгэрийн 26,8 хувь нь бол 4G сүлжээтэй. Монгол Улсын хэмжээнд 50 мянган км орчим сүлжээ бид нар холбох ийм шаардлага байгаа учраас Улсын Их Хурлын гишүүд бол.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Тэргүүн шадар сайд Гантөмөр хариулъя. Нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Баярлалаа. Золжаргал гишүүн Засгийн газрын өргөн барьсан төсөл дээрээ ямар нэгэн байдлаар өөрчлөлт оруулахыг та бүхэн юу гэж бодож байна вэ л гэсэн асуулт. Жишээлбэл шинжлэх ухааны санхүүжилтээр асууж байна л даа. Энд байгаа сайд нар бол Засгийн газрынхаа гаргасан шийдвэрийг л хамгаалах

үүрэгтэй. Тэрийгээ л тайлбарлах үүрэгтэй. Түүнээс биш бид нар ингээд төсвийн хэлэлцүүлэг болж байна. Би өөрийнхөө яамны ямар нэгэн лобби хийе. Эсвэл аль нэг яамны бодлогыг ингээж өөрчилье ч гэдэг юм уу эсвэл Эдийн засаг, хөгжлийн сайдын бодол ийм байна гэж энд бид нар ямар нэгэн байдлаар тайлбарлах боломжгүй шүү гишүүд ээ. Бид бол төсвийн тодотголоо өргөн барьчихсан. Их ойлгомжтой хэлж байгаа. Одоо авч байгаа, авахаар шийдчихсэн Их Хурлаараа баталчихсан, тодорхой гаднын зээл тусламж байна. Энийгээ бид нар авмаар байна. Тэр нь 950 тэрбум төгрөг байна. Улаанбаатар хот.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ренчиндоржийн Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: Гишүүдэд оройн мэнд хүргэе. Тэгэхээр төсвийн тодотголоор орж ирж байгаа энэ хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бол ерөнхийд нь дэмжээд байна. Тэгэхдээ энд хөгжлийн хөрөнгө оруулалт гэсэн хэсэг дээр байгаа хөрөнгө оруулалтын асуудал дээр хэдэн асуулт асууя. Энэ төслүүдийн зураг төсөв, ТЭЗҮ-г боловсруулахад шаардлагатай хөрөнгө оруулалтын талаар асуух гээд байгаа юм. Энэ бид нар шинэ Хархорум энэ нь юу гэхээр ямар арга тооцоолуураар тооцсон юм бэ. Тэгээд энийгээ ерөөсөө тоотой нь өгчхөж болох уу гэдэг нэг асуудал байна. Энийг яагаад асуугаад байна гэхээр Шинэ Хархорум гэдэг хотыг байгуулахад зураг төсөл, ТЭЗҮ-г боловсруулахад 30 тэрбум гээд заачихсан байгаа. Тэгсэн чинь өөдөө тэмүүлэх Монгол гэдэг төсөл дээр 28,6 тэрбум. Энэ чинь бид нар 500 мянган хүн амтай хотын зураг төсөл, ТЭЗҮ хийхэд шаардлагатай хөрөнгө оруулалт чинь 4,7км зам, 900 метр гүүр, 80 метр гүүрэн гарц дээр тавигдчихаад байгаа юм биш үү. Энийг ямар аргаар тооцоод байгаа юм бэ гэдэг нэг юм байна.

Одоо цаашилаад Хөшигийн хөндийн туннел бас 55,3 тэрбум гээд ингээд яваад байна. Шинэ тойрог авто зам 16,9,

тэгээд л Шинэ их тойруу хурдны зам 23 тэрбум гээд. Тэгэхээр энийг ямар тооцоолуураар тооцоод байгаа юм бэ гэдэг нэг асуудал байгаад байгаа юм.

2 дугаарт нь гэх юм бол тэр бүсчилсэн бүтээн байгуулалтын төслүүдийн бэлтгэл ажлыг хангана гэж төсөв тавьсан байна. Энэ яг ямар ямар төслүүд байгаад байгаа юм бэ. Энэ 70 тэрбум төгрөг тавьчихсан. Энэ яг ямар ямар төслүүдийг, ямар ямар төслүүдийн ТЭЗҮ, зураг төсөв байгаад байгаа юм бэ гэдэг нь тодорхой биш байгаад байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах гээд бас тавьчихсан. 60 тэрбум төгрөг тавьчихсан. Энэ яг ямар ажил, арга хэмжээний бэлтгэл ажил юм бэ гэдэг асуудал.

3 дугаарт нь энэ төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээний санхүүжилтэд гээд бас 50 тэрбум төгрөг тавьчихаад байгаа юм. Энэ манай яамдын сайд нар, агентлагийн дарга нар байдаг юм уу энэ менежментээ өөрсдөө хийгээд явчих боломж байдаггүй юм уу. Заавал гаднаас ийм зөвлөх үйлчилгээний санхүүжилт гээд зөвлөх үйлчилгээ авах ёстой юм уу гэдэг асуудал байгаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: Хариулъя. Эрдэнэбүрэн сайд хариулъя.

Р.Эрдэнэбүрэн: Тэр Хархоринтой холбоотой хэсэг нь Батсуурь сайд хариулах байх. Энэ яах вэ өдөр бас Ерөнхий сайд ч гэсэн үгэндээ бас нэлээн хэлэх шиг болсон. Бид нар бол энэ 700 га газартай дэд бүтэц, 700 га газартаа л сүүлийн хэдэн жил маш их хөрөнгө оруулалт хийж ирлээ. Одоо ч цаашидаа ч хийхээр байх шиг байна. Хийж ч байна. Тэгээд үүний үр дүнд юу болж байгаа вэ гэхээр ийшээ л цуглаад байгаа. Тэгэхээр ер нь энэ Богд уулын урагшаа гарч Улаанбаатар хотыг задалъя гэдэг яриа бол бүр нэлээн олон жилийн өмнөөс яригдаж байсан. Лав л миний санахын

намайг Барилгын яаманд ажиллаж байхад л энэ Богд-Уул тойруулсан замын трассыг чөлөөлөөд л хэрүүл ам болж байсан. Тойруулаад хэд хэдэн жижиг хотууд Майдар сити, Шинэ Зуунмод гээд, өөр Хөшигийн хөндий гээд хэд хэдэн хотууд үүсэхээр болж байгаа. Ингэж ч задлахаас өөр аргагүй гэдэг дээр бол бүгд санал нэгдэж байгаа байх. Ингээд ийшээ бол хамгийн хурдан яавал тэнд хот үүсээд задарч чадах вэ гэхээр хамгийн хурдан яаж очих вэ л гэдэг асуудал байгаа юм. Тэгэхлээр энэ тунелийн асуудал яригдсан. Тэгээд 20 минутад хотын төвөөс очихоор ийм тооцоотой байгаа юм. Тэгээд энэ бас гэнэт одоо Засгийн газар байгуулагдсаны дараа хэдэн хүн яриад ингээд шийдчихсэн асуудал биш. Жилийн өмнөөс туннел явах ёстой юм байна. Гүүр байх ёстой юм байна. Цаана нь тэнд хот руу нүүцгээхийн тулд төр захиргааны байгууллагууд нүүж очвол илүү хурдан байгаад хот үүсэх юм байна гэдэг ийм тооцоо судалгаа яригдаад, тэгээд ялангуяа Дэлгэрсайхан сайд маш их судалгаа хийлгэсэн юм байна лээ. Энэ 4 дээр дөрвүүлэн дээр нь. Тэгэхдээ энэ ажлыг бол бид мэдэхгүй ээ. Тэр зарим юугаа бол хүлээн зөвшөөрөх хэрэгтэй байх. Олон улсын энэ чиглэлээр ажилладаг, зөвлөгөө өгдөг, зураг төсөл гаргадаг, хөрөнгө босгодог, менежментийг нь хийдэг тийм зөвлөх үйлчилгээ зайлигүй шаардлагатай. Бидний одоо энэ туннелийн асуудлаар, том гүүрний асуудлаар ямар вэ гэдгийг бид бол сайн өөрсдийгөө бол сайн мэдэж байгаа байх гэж ингэж бодож байгаа. Тэгээд энэ төслүүд бол нэгдсэн уялдаа холбоотой учраас бүгд дээр нь нэгдсэн байдлаар зөвлөх үйлчилгээ авъя. Тэгэхгүй бол ингээд тус тусдаа явахаар хоорондоо нэг туннелтэй болдог, гүүр байхгүй бол нөгөө туннел рүүгээ очиж чадахаа болино. Гүүртэй болдог туннел байхгүй бол цаашаа ямар ч юмгүй болно. Ингээд нөгөө мухар төмөр зам гэдэг шиг ийм юм болох юм. Тийм учраас тэр цаана нь гарах тэр төр захиргааны байгууллага цаана нь үүсэх тэр Шинэ Зуунмод хот бүгдийг нь нэгдсэн байдлаар нь менежмент бүх

юмыг нь хийж явах ийм нэгдсэн зөвлөх үйлчилгээ хэрэгтэй юм байна гэж манай хорооны сайд нар тохирсон. Ингээд яах вэ, мэдээж энэ хорооны даргын хувьд бас нэг онцлог нь миний хувьд бол над дээр тавигдсан мөнгийг би өөрөө гэрээ хэлэлцээр хийгээд явдаггүй юм байна лээ. Энэ яамтай сайдуудаараа хэрэгжүүлээд ингээд цаашаа явдаг. Тэгээд олон улсын зөвлөх үйлчилгээ аваад, цаг алдалгүйгээр явах нь зөв юм байна гэдэг дээр бүгдээрээ санал нэгдсэн. Энэ жишээ бол байгаа юм. Ялангуяа сая Улаанбаатарын метро дээр бол.../минут дуусае/

Д.Амарбаясгалан: Сайд нар товч, тодорхой хариулбал их зүгээр байна. Нэмэлт 1 минут өгье.

Р.Эрдэнэбүрэн: Олон улсын зөвлөх үйлчилгээ аваад ингээд амжилттай явагдаж байгаа. хэдийгээр бид нар олон улсын зөвлөх үйлчилгээ авах гэж байгаа ч гэсэн бас энэ сүүлийн үед манай хот байгуулалтын чиглэлээр ялангуяа Японд төгссөн маш олон хүмүүс хот, бусад газрууд дээр Их Хуралд ч гэсэн орж ирсэн. Тийм учраас яг бас ингээд зөвлөхийнхөө амыг дагаад давхиад байхааргүй тийм байдалтай байгаа. Тийм учраас энэ талаас нь бас бодож дэмжээсэй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Батсуурь сайд Шинэ Хархорин хотын зураг төсөлтэй холбоотой асуултад хариулъя.

Ж.Батсуурь: Ер нь өнөөдөр Улаанбаатар хотыг ямар болчхоод байгааг бол бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Тийм болохоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн зорилтод нийцүүлээд Шинэ Зуунмод хот, Шинэ Хархорин хотыг байгуулах, тэгээд энд одоогийн энэ Улаанбаатар хотод гарсан алдаануудыг ахиж гаргахгүй байх ийм л зорилтыг тавьж ажиллаж байгаа юм. Тийм болохоор шинэ Хархорин хот бол ер нь ямар байх ёстой вэ гээд дэлхийн олон оронд нээлттэй ийм саналуудыг явуулсан. Тэгээд саяхан дэлхийн 18 улсын 200-аад

хүнтэй ийм багууд 36 төсөл, арга хэмжээнүүдийг бол авчирсан байгаа юм. Тэгээд тэр бол ерөнхийдөө ийм байж болох юм. Түүхийн талаасаа, архитекторын талаасаа, ногоон хөгжил талаасаа ер нь Монгол Улсын шинэ хот бол ийм байж болох юм. Эртний түүхтэй гэсэн энэ санаа оноонууд бол гарч ирсэн. Тэгээд энийг цааш нь ТЭЗҮ-г боловсруулж урт хугацааны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Ж.Батсуурь: Энэ агуулгаар нь иж бүрэн төслийг хийх зорилгоор энэ мөнгө тавьсан. Тэгээд сая Сангийн сайд хэлж байна. Илүү тодруулъя гэвэл Хархорины захиргааных нь дарга байж байгаа. Зүгээр тэр төслийн удирдагч нар дээр төсөв тавьж болохгүй учраас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төсөв дээр л энэ төсөв нь тавигдсан гэж ойлгох ёстой.

Д.Амарбаясгалан: Дашицэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Хотын бондоор санхүүжүүлэх эрчим хүчтэй холбоотой хэд хэдэн төслүүд байна. Тэгээд үүнтэй холбоотойгоор хот дээр эрчим хүчний асуудал дээр жишээлбэл, батарей өмчлөл нь хот дээр байх юм уу, эрчим хүчний энэ төрийн өмчид бүртгэгдэх хөрөнгө оруулалт уу. Тэгээд үүнтэй холбоотой Эрчим хүчний яам, хот 2 дээр яаж зохицохоор ажиллаж байгаа вэ гэдэг тийм асуулт байна.

2 дугаарт нь товчхон асуулт. Эдийн засгийн өсөлт уул уурхайн бус өсөлтийг яаж төсөөлж байгаа вэ. 7 хувь гэж төсөөлж байснаа 5,6 хувь болж буурна гэж байсан юм. Тэгээд энэ дотор уул уурхайн бус эдийн засгийн өсөлт нь хэд байгаа гэдэг тоог хэлж өгөөч.

3 дугаарт нь энэ хоттой холбоотой зарим төслүүд дээр эдийн засгийн миний

зүгээр өмнө бас санаж байхад зарим нэг төслүүд дээр эдийн засгийн хувьд ашиггүй байж магадгүй тийм тооцоонууд гарч ирсэн төслүүд байгаа. Ялангуяа энэ шинэ тойруутай холбоотой. Тэгээд их тойрогтой холбоотой. Тэгэхээр энэ дээр тарифыг нь хэдээр тооцоод тэгээд ямаруу эргэлт байж байж ашигтай байх вэ гэсэн урьдчилсан мэдээж тооцоонууд хийсэн байх. Энэ талаар мэдээлэл өгч болох уу гэдэг.

4 дүгээрт нь нүүрсний үнэ бас нэлээн унаад байгаа. Тэгээд анх эхэлж 140 гэж төлөвлөж байснаа 115 болгохоор тодотгол дээр орж ирсэн байна. Тэгэхээр 10 доллароор буухад 1 их наядын жишээлбэл бараг 30 сая тонн гэвэл нөлөөлөл орохоор байна. Тэгэхээр энэ нүүрс дээр 115-аас дахиж хэлбэлзэх магадлалыг яаж харж байгаа вэ гэсэн ийм асуултууд байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн шадар сайд Гантөмөр сайд хариулах уу. Уул уурхайн бүс, эдийн засгийн өсөлт хэдэн хувьтай байгаа талаар тодруулж байна. Хотын дарга дараа нь хот дээр хэрэгжих төслүүдийн эдийн засгийн үр өгөөжтэй холбоотой асуудлаар товч хариулт өгье. Гантөмөр сайдын микрофоныг өгье.

Л.Гантөмөр: Оны эхэн дээр уул уурхайн ер нь бол оны эхлээд 8 хувийн өсөлттэй гэдэг 2024 оныхоо төсвийг батлахдаа төсөөлсөн. Харамсалтай нь зуд болсон байгаа. Зудаас болоод хөдөө аж ахуйн салбарын өсөлт бол -31 хувьтай байгаа. -31 хувьтай. Үүнээсээ хамаараад уул уурхайн бус салбарын өсөлтийг 4,5 хувь гэж гарч байгаа байх. 4,5. Хүлээгдэж байгаа гүйцэтгэлээрээ 4,5, 2023 онд бол уул уурхайн бус салбарын өсөлт бол 5,3 хувь байсан. Нүүрсний үнэ бол мэдээж багасаж байгаа. Тэгэхдээ хэмжээ бол 2024 оны төсвийн төсөөллөөсөө давчихсан байгаа. Одоо бол 51 сая тонн 8 сарын өнөөдөр хэдэн билээ 15, 16-нд 51 сая тонн. Бид нар хүлээгдэж байгаагаар бол 78 сая тонныг экспортолно. Үнэ бол ер нь анхнаасаа бас их тийм өндөр

тавиагүй юм байна лээ. Оны эхэнд бол их өндөр байсан тэгээд 100 хэдтэй байгаа билээ Сандагаа. Одоо тооцоолж байгаа нь төсвийн тодотголоор хэдээр тооцоолж байгаа билээ. 110-аар тооцоолж байгаа юм. Тэгээд оныхоо яг дундаж үнийг авах юм бол энийгээ бараг бариад орчих байх гэж. Тэгээд ер нь 8 сард ингээд буураад, 9 сараас буцаагаад өсдөг гэдэг ийм динамик бол урьд, өмнөх жилүүдийн юм бол харагдаад байгаа юм.

Д.Амарбаясгалан: 2 дугаар микрофон. Хотын дарга хариулъя.

Х.Нямбаатар: Батарей станцын хувьд бид хотын гаргах 300 орчим тэрбум төгрөгийн дотоод бондыг хаалттай байдлаар IFC буюу ОУСК-д худалдаалахаар тохирсон. Ингэхдээ зээлийн хүүг ногоон зээлийн тэр багцад багтааж урт хугацаатай ийм зээл авахаар одоо хэлэлцээр яг үргэлжилж байна. Үүнтэй зэрэгцээд батарей станцынхаа тендерийг зарлаад, нээлттэй тендерт шалгаруулалт хийгдээд, гэрээ хийгдээд явж байгаа. Бид нарын их сайнаар урьдчилж тооцож үзэхэд 11 сардаа багтаагаад батарей станцыг ашиглалтад оруулаад, шууд төв шугам сүлжээнд нийлүүлэхээр ажиллаж байгаа. Ингээд батарей станц өөрөө шугам сүлжээнд эрчим хүч нийлүүлж эхэлснээрээ өөрөө IFC-ийнхээ эргэн төлөлтийг урт хугацаандаа өөрөө дааж, төлж явах ийм агуулгатай төсөл байгаа. Энэ бас.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Х.Нямбаатар: Тойрог хурдны замын тухайд би таныг яг ямар төсөл дээр урьдчилж судалгаа хийснийг мэдэхгүй байна. Бид сүүлд манай төслийн нэгжийнхэн 2 ийм тойрог замын урьдчилсан төсөөллийг гаргаад, урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил энэ төсвийн тодотголын дараа хийгдэх гэж байгаа. 1 дүгээр тойрог хурдны замыг бид нар Туулын хурдны замтай холбогдох

саран хэлбэртэй, ойролцоогоор 20 орчим километр байхаар төлөвлөж байгаа. Гаднах тойрог замыг нь бид нар 55км байхаар төлөвлөж байгаа. Тэгээд иргэдийн хувьд сонголтоороо. 1 дүгээр түвшинээрээ явж болно. 2 дугаар түвшинд шууд тойрог зам дээрээ төлбөрөө төлөөд, саадгүй хотыг бүтэн тойроод явах ийм байдалтай учраас тухайн үед тарифыг эдийн засгийн тооцооллын урьдчилсан ТЭЗҮ, үндсэн ТЭЗҮ-ийн дараа тарифыг тогтоох ажил явагдана. Батарей станцын өмчлөгч нь нийслэлийн өмчит үйлдвэрийн газар байж байж IFC-ийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн алга байна. Жудагийн Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Нөгөө л өчигдрөөс л эхлээд л яриад байгаа нөгөө суурь зарлага гээд. Тэр чинь одоо л яг гараад ирлээ л дээ. Би сая тэмдэглэж байсан яачхав. Тэгээд энэ суурь зарлага гэхээрээ зарлага биш болчихоод байгаа юм уу. Яагаад байгаа юм. Тэрийг ерөөсөө ойлгохгүй байна. Тэгээд бонд, газар чөлөөлөлт гээд ийм 2 зүйл ороод ирсэн байгаа. Энэ суурь зарлага дотор. Тэгээд энэ уг нь энэ суурь зарлага гэдгийг тогтоогоогүй бол -2 ингээд байх гээд байгаа. Тэгээд тэр 2-ыг хасангуут хасахгүй болчихоод байгаа юм. Тэгээд энэ ямар учиртай юм бол гээд гайхаад байгаа юм. Цаана нь нөгөө зээл авах тэр боломжоо нээхийн тулд ингэж нэмэхтэй гаргаж харуулах гээд байгаа юм уу гэсэн ийм хар байна.

2 дугаарт иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга гээд асар их ийм барилгууд байна л даа. Тэгэхээр энэ анхны төсөвт өртөг гэж бол байхгүй байгаад байна. Тэгэхээр цоо шинээр эд нарыг гаргаж байгаа юм уу. Тэгээд дээрээс нь энд бас юунууд байна. Гүүрний ажлууд гээд л байна. Ерөөсөө анхны төсөвт өртөг гэж юу ч байхгүй. Тэгэхээр энэ тодотголоор цоо шинээр орж ирж байна гэсэн үг юм болов уу гэсэн ийм асуулт байна.

Тэгээд өдөр нөгөө ярьж байсан асуулт руу л эргэж орох гээд байна л даа. Тэгээд баахан гүүр, гүүрний ийм төсөв тавьчихсан цоо шинээр оруулаад ирж байгаа юм уу. Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга гээд оруулаад ирж байгаа юм уу. Одоо манайх чинь чухамхүү и-монголиа болоод асар олон платформууд байгаад байгаа шүү дээ мэдээллийн. Тэгээд ер нь бол сумын төвийн иргэд бол бүх мэдээллээ бараг фэйсбүүкээс авч байгаа байх. Тэгэхээр фэйсбүүкээс бараг авчхаж байгаа мэдээллийг энд бүр ийм том мэдээллийн төвийн барилга байгуулах ямар шаардлага байгаа юм бол. Ямар хэрэгцээ байгаа юм бол. Энэ төсвөө хэмнэх юм бол нөгөө яригдаад байгаа багш нарын чинь цалин гараад ирэх юм биш үү гээд. Энэ мэдээллийн төвийн зорилгыг сайн ойлгохгүй байна. Тэгээд бас ингээд гайхаад л байна л даа. Энэ орон нутгийн сонгууль болох гэж байгаа. Тэгэхээр ингээд төсвийн тодотголоор сонгуульд зориулсан баахан ийм тууз хайчлахад чиглэгдсэн ийм юмнууд ороод ирж байгаа юм биш байгаа гэж бас бодоод байна.

Тэгээд ер нь төсөвт тодотгол хийнэ гэдэг чинь өчигдөрхөн уржигдархан би асууж байсан. Одоо тийм онцын шаардлага байгаа юм уу гээд. Тэгээд нэгэнт Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж байгаа учраас хийхээс өөр замгүй гээд. Тэгвэл тэрэнтэйгээ холбоотой зардлуудаа л тооцоолоод явдаггүй юм уу. Цоо шинэ ийм зардлууд гаргаж ирээд байдаг нь ямар учиртай юм бол. 2025 оны одоо төсөлд ор төсөвт оруулж болохгүй байсан юм уу? Одоо ердөө 1, 2 сарын л асуудал байна шүү дээ.

Д.Амарбаясгалан: 3 дугаар микрофон Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Санжаадорж хариулъя.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга гишүүний асуултад хариулъя. Төсөв хийх үндсэн шалтгаанаас нь эхэлье.

Төсвийн тухай хуулийн 34.1.4 дээр бол хэрвээ төсвийн ерөнхийлөн захирагчид хооронд зохицуулалт хийх шаардлага үүссэн бол төсөвт тодотгол хийнэ гэж байгаа. Та одоо батлагдсан байгаа Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг харах юм бол жишээ нь Соёлын сайд гээд биччихсэн байгаа. Тэгэхээр тэр сайд маань Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай хуулиараа өөрчлөгдөөд, нэр нь өөрчлөгдөөд, чиг үүрэг нь өөрчлөгдөөд явчихсан учраас тэр сайдыг бид нар энд оруулж ирэхийн тулд бүтэц бүрэлдэхүүнийг өөрчилж байгаа ийм зүйл болж байгаа. Энэ бол үндсэн шалтгаан болчихоод байгаа юм.

2 дахь төсөвт тодотгол хийж байгаа гол шалтгаан бол шинээр парламент байгуулагдаад, шинээр Засгийн газар бий болоод, шинээр мөрийн хөтөлбөрөө оруулж ирсэн. Энэ мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлж байгаа энэ 7 сарын эхнээс 4 жил нь тоологдож байгаа энэ парламентын, энэ Засгийн газрын хэрэгжүүлж байгаа мөрийн хөтөлбөрийн эхний төсөв болж байгаа гэдэг энэ нөхцөлөөрөө бол хөгжлийн хөрөнгө оруулалтын төслүүд бол орж ирж байгаа. Түрүүний таны уншдаг энэ хөрөнгө оруулалтын жагсаалт дээр байгаа жагсаалтууд бол 2024 оны төсвийн тухай хууль анх батлагдахдаа байсан энэ жагсаалтууд болчихоод байгаа юм. Түрүүн та бас энэ жагсаалт дээр байгаа зарим хөрөнгө оруулалтын зардлуудыг хасаж болдоггүй юм уу гэж хэлсэн. Одоо байгаа төсвийн тухай хуулийн 29.3.6-аар бол төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын санхүүжих дүнг бууруулж болохгүй гээд заачхаад байгаа юм. Тэгэхээр бид нар төслийг нь хасаж болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ хуулийн хүрээнд бид энэ хөрөнгө оруулалтыг хасах боломжгүй болчихоод байгаа юм.

Дараагийн ээлжид бол тэнцлийн асуудал дээр суурь зарлага гэдэг асуудлыг бол ярьж байна. Бид бол -2 хувийн тэнцвэржүүлсэн тэнцэл гэдэг тооцоогоо

бас давхар бариад энэ 2024 оны төсвийн тухай хуулийг бол өргөн барьсан. -2 хувийн алдагдал дотроо бариад, энэ дотроо бид нар урсгал зардал маань 30 хувиас хэтрэхгүй гэж энийг оруулаад, урсгал зардал гэдэг маань цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэгээд энэ зардал дээрээ нэмээд бид нар улсын төсвийн хөрөнгө оруулалтаа нэмж оруулж ирээд суурь зарлага гээд байгаа юм. Энэ суурь зарлага маань бол бид нарын дотоод эдийн засгаасаа хурааж байгаа татвар, хураамжийн орлогоос бол 100 хувь санхүүжих ёстой. Ингэхдээ +2 хувийн ашигтай буюу 2 хувийг хуримтлуулах ёстой. Энэ 2 хувиараа бид нар үндсэн өр төлбөрөө төлөх ёстой гэдэг ийм зарчим л оруулж ирж байгаа юм. Тэгэхлээр +2 хувь, -2 хувийн хооронд бол дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувийн орон зай гарч байгаа. Энэ хэсгээрээ бид нар өөрөөр хэлбэл хөгжлийн хөрөнгө оруулалт гэдгээ хийе л гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл орон зайндаа бид нар гаргаж байгаа ийм асуудал болж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Баярмаа гишүүний асуултад нэмж хариулъя. Энэ орж байгаа өөрчлөлт маань тэр +2 хувь гээд байгаа чинь зээл шинээр нэмж авах гээд байгаа холбоотой асуудал огт биш. Зээлийн хязгаар 60 хувь гэдэг одоо алга болчихсон байгаа юмыг бид нар оруулж ирж байгаа. Тэгэхээр тэр 60 хувь дотроо одоо манай гүйцэтгэл жишээ нь 39 хувьтай байгаа. 20 хувийн орон зайн дотроо зээл авах асуудал Засгийн газар дээр нээлттэй байгаа. Одоо ч нээлттэй ямар ч өөрчлөлт хийх шаардлагагүй. Тэрийг нь зөвшөөрөх эсэх нь Их Хурал дээр нээлттэй байгаа. Гагцхүү энэ орж ирж байгаа өөрчлөлт чинь энэ зээлийнхээ ашиглалтыг л нэмэх гээд байгаа юм. Ашиглалтыг. Авчихсан зээл дээр ч тэр. Одоо бид нар хэрвээ энэ зохицуулалтыг хийж чадахгүй бол ингээд Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцыг бид нар энэ жил эхлүүлж чадахгүй. Нефть боловсруулах үйлдвэрийг

үргэлжлүүлж чадахгүй. Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг үргэлжлүүлж, бид нар зээлийн ашиглалтаа 1 төгрөг, 1 доллар ч нэмж чадахгүй байгаа байхгүй юу. Тийм учраас энэ боломжуудыг хэдүүлээ тавиад, тэр өрнийхөө хязгаарыг алга болгож хэзээ ч болохгүй. Одоо буцааж оруулж ирэх ёстой.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайдын микрофоныг 1 минут нэмж өгье.

Б.Жавхлан: Тэгээд Ардчилсан намын гишүүд маань энэ хөдөө, орон нутагт тэр суманд байгаа төрийн үйлчилгээний хэдэн байшингуудад яасан дургүй юм бэ. Соёлын төвийг байхгүй болго л гэх юм. Иргэдийн мэдээллийн төвийг байхгүй болго гэх юм. Үгүй ээ, түрүүн чинь соёлын төвийг байхгүй бол устга гэсэн шүү дээ. Тэгээд одоо иргэдийн мэдээллийн төвийг бас байхгүй болго гэх юм. Тэгээд хотод байдаг иргэд энд сайхан дүүргийн тэр сайхан сайхан байшингуудад очоод иргэдийн үйлчилгээгээ аваад, хөдөө орон нутагт байгаа малчид яах юм тэгээд малын бэлчээр дээрээ сууж байгаад утасгүй нь яах вэ тэгээд. Үгүй ээ, тэд нарыг тэгж хаяж болохгүй шүү дээ. Монголын хүн амын чинь тал нь тэнд амьдарч байна шүү дээ. Ер нь би танд нэг ийм санал больё. Хэдүүлээ 9 сарын 1-ээс хойш жоохон зав гарвал нийлээд сайхан хөдөө явъя. Тэгээд хөдөө очоод, тэр сумд очоод 7 хоног ажиллаад, тэгээд ард иргэдэд юу хэрэгтэй байдаг юм тэрийг нь сайхан судлаадхаарай.

Д.Амарбаясгалан: Дэгээ барья. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Та бүхэндээ оройн мэндийг хүргэе. Тэгээд Засгийн газраас оруулж ирсэн түргэвчилсэн гэдэг горимоор хэдүүлээ хоёрхон хоногийн дотор 13 хууль өөрчлөөд, төсвийнхөө тодотгол гэдэг нэрийн дор 13 хууль, 2

тогтоол. Тэр дотроо Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, тусгай шаардлагуудыг өөрчлөөд, тэгээд төсвийнхөө орлогыг 3 их наядаар нэмж, зарлагаа 3 их наядаар нэмээд, төсвийн алдагдлаа 110 саяар нэмээд, ингээд дотоодын нийт бүтээгдэхүүнд тооцдог нийт төсвийн алдагдал хуучнаар нь тооцвол -2 хувь, шинэ аргачлалыг нь өөрчилж байгаад +2 хувийн ашигтай юм шиг сайхан харагдуулаад, томилогдоод 30-аадхан хонож байгаа сайд нар энэ бүх олон төсвүүдийг оруулж ирээд хийх гэж байгаа ажил маань болохоороо гүүрэн байгууламж, шинэ тойрог авто зам, Хөшигийн хөндий бүгдийнх нь ТЭЗҮ, үйлчилгээ, дээрээс нь эрчим хүчний татварын алдагдлын 131,1 тэрбум гэх мэтийн ийм ажлуудыг хийгээд, одоо ингээд өнөөдөр шөнөдөө дуусгаад ингээд явах гэж байна л гэж би дүгнэж харж байна.

Тэгэхээр ер нь энэ яагаад ийм яаравчилсан байдлаар орж ирсэн юм. Яагаад тэр Засгийн газрын бүтэц өөрчлөгдөж байгаа бол түүнтэй холбоотой урсгал зардлаа оруулж ирэхгүй, яагаад энэ том том хуулиудын өөрчлөлт оруулж ирсэн юм. Дээрээс нь Жавхлан сайд тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн буюу тэр тусгай шаардлагууд алга болчихсон л гээд байна лээ. Энэ манай хуульч гишүүд гаргаж ирэхгүй юм. Хэзээ, хэзээ өөрчлөгдсөн юм. Хэзээ, хаана байсан юм. Хамгийн сүүлийн баримтаараа хэзээ өөрчлөгддөг юм гэдгийг уг нь ингээд олчих хугацаа болчихлоо л доо. Тэгэхлээр одоо яг миний энэ дүгнэж яриад байгаа дотроос тэр юу 2-ыг нь өөрчлөхгүй байж болдоггүй юм уу. Төсвийн тогтвортой хуулийн өөрчлөхгүйгээр их л зөөлрүүлж үзээд байгаа шүү дээ. Дээрээс нь тэр төсвийн тусгай шаардлагыг өөрчлөхгүйгээр хуучнаар нь оруулаад тэгээд одоо алдагдлыг нь хуучнаар нь ч юм уу, эсвэл арай багаар оруулаад ирж болдоггүй юм уу. Яагаад ингээж алдагдлыг ч гэсэн ашиг болгож харуулах ийм тооцоолол, яагаад тэр төсвийн үндсэн хууль болох

тогтвортой байдлын хуулиа 2 хоногийн дотор энэ шинэ парламентын гишүүдээр ингээж яаралтай өөрчлүүлээд байгаа юм. Энэ парламентын түүхэнд ч гэсэн бас их сонин юм болох нь байна шүү дээ. 126-лаа орж ирээд юугаа ч мэдэхгүй байж байгаад ийм том хуулиудыг өөрчлөөд, дараа нь энэ төсвийн гадуур тооцох гэж байгаа тэр суурь зардал, нийт зардал 2-ын гадуурх зардал чинь хэд болох юм. Өсөх юм уу, үгүй юм уу. Тэнд ямар зардлын нэр томъёонууд байж байгаа юм. Мэдэж байгаа юм байхгүй шүү дээ. Ямартай ч байсан хоёрхон нэр томъёо өөрчлөхөд л /- / алдагдалтай байсан юм /+ / болчихдог юм байна.

Тийм учраас Жавхлан сайдаас дахиад асууя. Үүнээс хойш асуух зав гарахгүй л юм шиг байна. Ер нь бол Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, төсвийн тусгай шаардлагуудыг өөрчлөхгүйгээр бусад юмаа оруулаад ирж болдоггүй юм уу.

Д.Амарбаясгалан: Хариулъя Сангийн сайд Болдын Жавхлан.

Б.Жавхлан: Түвшин гишүүний асуултад хариулъя. Ер нь ард түмний сонголт яг энэ дээр байсан л гэж би бол сүүлд итгэх итгэл үнэмшилтэй болж ирж байгаа. Засгийн газар хамтраад явж байгаа бол энэ түүхэн цаг хугацаа. Бүтээн байгуулалтууд хийх, хөгжлийнхөө дунд, урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах тэр баттай суурийг тавьж авах ийм алтан мөч гэж ингээж харж байгаа. Тийм ч учраас “Хурдтай хөгжлийн зориг” энэ мөрийн хөтөлбөрөө оруулж ирлээ. Мөрийн хөтөлбөрөө дагасан төсвийн тодотголоо оруулж ирлээ. Энэ бүтээн байгуулалтуудыг явуулахад та энэ Ардчилсан намын гишүүн хүн, та бүхэн хамтрах, хамтрахгүй энэ хөтөлбөр юмнуудыг бүгдээрээ л янз янзаар тал талаас нь харж ингээд нэгдсэн ойлголтод хүрсэн гэж ингээж харж байгаа. Тийм учраас энийгээ л явуулъя гэж байгаа. Бидэнд 1 өдөр ч үнэтэй байгаа учраас энэ

2024 оны сүүлийн хэдхэн сарыг бас бүтээн байгуулалтын жил болоосой. Тэр нь гэхдээ бидэнд үнэхээр том төслүүд маань бэлэн биш байна. Тийм учраас бэлтгэл ажлаа хангаад тэгээд ирэх жил бүтээн байгуулалтын улирал эхэлмэгц ажлуудаа явуулья гэдэг ийм л их том амбиц, зорилго байгаа юм. Та энэ талаас нь нэг хараадхараарай. Хэрвээ бид энэ зээлийн ашиглалтуудаа өндөр болгох, энэ зээл өр нэмэх гээд байгаа асуудал ерөөсөө огт биш шүү. Өрийн хязгаарт чинь байдгаараа л байж байгаа. Харин ч бид нар бүр өрөө нэрлэсэн үнээр тооцъё гээд доороос нь шахаад, энийг чинь улам л нарийн, улам л их төвөгтэй болгож олон улсын стандарт руу нийцүүлж байгаа юм. Ингээд баахан зээл авчхаад юун шинээр авах битгий хэл авчхаад тэрийгээ ашиглаж чадахгүй ийм хязгаарлалтууд дотор орчхоод байгаа. Тэгээд авчихсан зээлийнхээ ашиглалтыг нь нэмье, тэр хэмжээгээрээ жил бүр 2 хувиар төлөөд явъя гэдэг хэд хэдэн ийм хязгаарлалт ийм түгжээгээ найдвартай хийгээд авчихсан, эрсдэл гарахааргүй ингээд явж байгаа. Та өөр намын сайд гээд үнэмшихгүй байгаа бол бас манай Шадар сайд бас нэмээд мэдээлэл өгчихвөл их сайн байна.

Урсгал зардал яагаад орж ирээгүй юм гээд. Яахын урсгал зардлыг оруулж. Урсгал зардал гэхээр та цалин нэмээд л эсвэл халамж нэмээд л эсвэл ингээд л бүгд л нэмэх юм болоод ороод ирнэ. Бид нарын урсгал зардал нэмэх бол 1 дүгээр зорилго биш. Эдийн засаг энэ төлбөрийн тэнцэл гээд дунд, урт хугацааны энэ макро хөгжлүүдээ харсан, энийг тэтгэдэг, хөгжлийг тэтгэж байдаг, чирч байдаг энэ дэд бүтцийн хөрөнгө оруулалтууд чинь номер 1 чухал асуудал юм. Энэ дэд бүтцээ хийснээр бид нар тэр дээр хийгдэх баялаг бүтээгчдийн хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжих энэ орчноо сайжруулах, хөрөнгө оруулалтуудын өртгийг бууруулах ийм зорилгоор энэ зам тээвэр, дэд бүтэц, эрчим хүч гээд энэ бүгдийг номер 1 эрэмбэлж ингэж оруулж ирж байгаа юм. Та бас миний ойлголтоор бол бизнесмен

хүн, эдийн засгийн дээд сургууль төгссөн хүн энэ талаар ингээд хэлэхээр их амархан ойлгох байх.

Тусгай шаардлагуудыг гэж байгаа юм та. Тусгай шаардлага чинь байхгүй болчихсон байна. Өөрчлөх юм нь байхгүй болчихсон байна. Энэ байхгүй болчихсоныг нь эргээд сэргээж байгаа байхгүй юу. Эргээд сэргээж байгаа юм. Энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг одоо цаашидаа Улс төрийн зөвлөл гэж нэрлэмээр байгаа юм. Эдгээр улс төрийн зөвлөлийнхөн маань улс төрчдийнхөө захиалгаар нэг ийм байхгүй болчихсон шаардлагууд дээр юм зохиож ургуулж тавиад ингээд яриад, өчигдрөөс хойш нэг ийм мэдэгдэл хийгээд байгаа юм. Тэр л танд шууд очоод байх шиг байна. Байхгүй болчихсон тэр төсвийн шинэчлэл хийсэн гээд байгаа хүмүүс энийг байхгүй болгочихсон. Тэрийг нь буцааж оруулж ирж байгаа юм шүү харин. Харин буцааж оруулж ирэхдээ энийг зөв томъёоллоор их зөв гаргаад явчихвал бид цаашидаа та бидэнд хэрэгтэй ийм юм байгаа юм шүү.

Д.Амарбаясгалан: Тэргүүн шадар сайд Гантөмөр нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Уг нь Түвшин гишүүн бүртгэлийн хүн, тооны хүн. Энэ тоонуудыг харвал их ойлгомжтой л байгаа юм л даа. Хардаад байх шаардлага байхгүй. Төсвийн эрсдэл бол байгаа. Манай эрсдэл бол ойлгомжтой. Нүүрсний экспорт зогсох уу, зогсохгүй юу гэдэг л эрсдэл байгаа. Хэрвээ нүүрсний экспорт зогсох юм бол бид нар яаралтай арга хэмжээ л авчих ёстой. Түүнээс энэ ингээд айхтар зарлага шинээр бүтээж байгаа зүйл алга. Би түүрүүн хэлсэн өнөөдөр хэлэлцээд ингээд дуусчих гэж байгаа юм биш шүү дээ гишүүн ээ. Одоо энэ чинь ирэх 7 хоногт яг төсвийн хэлэлцүүлэг хэдэн удаа явдаг вэ тэр журмаараа л явна. Үйл ажиллагааны хөтөлбөр чинь ялгаа байхгүй дэгээрээ л явна. Түүнээс өнөөдөр ингээд батлаад л, маргааш чуулган хаагаад ийм зүйл бол байхгүй.

Тийм учраас энэ хуулийнхаа нюансыг их сайн харах хэрэгтэй.

Д.Амарбаясгалан: Гантөмөр сайдад 1 минут нэмье.

Л.Гантөмөр: Яах вэ би өөрөө нөгөө Түвшин гишүүний боловсрол өндөр боловсролтой хүн учраас би бас ойлгочих байх гээд тайлбарлахыг хичээж байна л даа. Өр бол өөрчлөгдөхгүй. Бид өр нэмэхгүй. Угаасаа гэрээ хийгээд авчихсан төслүүддээ зориулаад авчихсан зээлийн эрхийг л нээж байгаа юм. Эрхийг нээж байгаа юм. Эх үүсвэр нь тодорхой. Дэлхийн банк, Азийн банк, юу байдаг юм. Тэр Энэтхэгийн Засгийн газрын гээд ийм дандаа хөгжлийн зээлүүдийн эрх 950 тэрбум дээр нээгдэж байна гэж та ойлгоорой. 1 их наяд бол хот бонд гаргаад аваад хэрэглэчихсэн. Тэгэхээр дахиад та нөгөө эх үүсвэр болоод мөнгөнийх нь нийлүүлэлт дээр санаа зовж байгаа байх. Энэ бол эргэлтэд орчихсон. Тийм учраас 3,1 их наядар өсөж байгаагийн 2 нь бол ингээд эх үүсвэр талдаа та аюулгүй. Хот бол өөрийнхөө бондыг эргээж төлөх үүрэг хүлээчихсэн. Улаанбаатар хот аваад.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя.

Ө.Шижир: Бүгдэд нь шөнө дундын мэнд хүргэе. Тэгээд бид нар улсын төсөв, улсын төсвийн тодотгол гээд үүнтэй холбоотой асуудлыг жил бүр ярихад яг л энэ сэдвүүд байнга л давтагддаг л даа. 76 байсан ч адилхан, 126 байсан ч яг адилхан байна. Тэгээд би Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ганц асуулт асуух гэсэн юм. Жил бүр ингээд бид нар яг энэ асуудлыг л байн байн ярьдаг. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань өөрөө төсвийн тогтвортой байдал нь тогтворгүй байхад гарч байгаа энэ санал, дүгнэлт, зөвлөмжүүд чинь хэрэгжихгүй бол яадаг юм бэ гэдгийг асуумаар байгаа юм. Зүгээр ингээд бид нар шүдгүй арслан гээд ингээд өнгөрөөдөг юм уу, аль эсвэл араас нь ямар нэгэн

төсвийн тухай процесс явдаг юм уу гэдгийг ойлгомоор байгаа юм. Одоо асуумаар байгаа юм. Яагаад ингээд асуугаад байна вэ гэхээр жишээ нь төсөв чинь тодотгол хэлбэрээр 2021 онд 3 удаа, 2022 онд 2 удаа, 2024 онд ингээд дахиад 3 дахь удаагаа буюу сүүлийн 3-4 жил 8 удаа ингээд тогтвортой байдал чинь өөрчлөгдөж байна л даа. Тэгэхээр энийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань юу гэж хардаг юм бэ.

Дараагийнх нь 2023 оны улсын төсөв чинь 2022 оны улсын төсвөөсөө 34 хувь, 2024 оны улсын төсөв 2023 оны улсын төсвөөсөө 31 хувь буюу нийтдээ 2022 оноос хойш өнөөдрийн төсөв 65 хувиар тэлсэн байгаа. Өссөн гэсэн үг. Улсын төсвийн тэлэлт гэдэг чинь өөрөө бол нөгөө талаасаа Засгийн газрын зардал, төрийн зардал л даа. Тэгэхээр энэ дээр энэ зөвлөл маань ямар байр суурьтай байдаг юм гэдэг асуудал байна. Тэгээд ер нь бол улсын төсвийн зардал өөрөө ингээд жил бүр өсөж байгаа нь яг бодитоор бидэнд нүдэнд харагдаж, гарт баригдахуйц ямар ямар үйл явдлууд өрнөв. Эхний нь.

Дараагийнх нь бид нар халамжаас хөдөлмөр лүү шилжих процесс өөрөө энэ их хөрөнгө оруулалт маань ямар үр дүнд хүрсэн юм бэ. Халамжийн тогтолцоо 2016 оны нийгмийн халамжийн сангаар тухайн жил 285 тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2024 онд 2,4 их наяд буюу 9 дахин өссөн байгаа юм. Тэгэхээр энэ их улсын төсвийн зардал чинь өөрөө эргээд урсгал зардал халамж руу яваад байгаа юм биш биз дээ гэсэн болгоомжлол байна. Тэгэхээр энэ дээр Тогтвортой байдлын зөвлөлөөс асууж байгаа. Тэгээд төсөв томрохын хэрээр яг иргэдийн худалдан авах чадвар амьдрах нөхцөл байдал хэр сайжирсан бэ гэдэг бас нэг асуудал байгаа. Халамж 9 дахин ихэссэн юм бол 9 дахин сайжирсан юм уу. Төсөв 65 хувь нэмэгдсэн юм бол 65 хувь дахиад сайжирсан юм уу гэдэг.

Дараа нь дахиад 2021 оны төсвийн нийт зардал өөрөө 13,9 их наяд төгрөг байсан бол одоо 27,4 болчхож байгаа юм. Одоо тодотголоор 3,1 нэмэгдээд, 16,6 их наяд буюу дахиад 2 дахин өссөн байгаад байдаг. Тэгээд энэ мэтчилэн төр өөрөө нөгөө зардлаа өсгөх нэрийдлээр хувийн хэвшлийн орон зайг улам хумиад байгаа юм. Тэгэхээр энэ дээр одоо байн байн ингээд өөрчлөгдөөд жилд 3 удаа өөрчлөгдөөд байгаа төсвийн тогтвортой байдлаа энэ зөвлөл маань яг яаж хардаг юм. Энэ зөвлөмж хэрэгжихгүй бол яадаг юм. Засгийн газраас өргөн барьж байгаа төсөл Их Хурлаас баталж байгаа энэ төсөл гэхэд та хэдийн энэ өгсөн зөвлөмж.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмэлт 1 минут өгье.

Ө.Шижир: Тэгээд нийцэхгүй бол яадаг юм бэ гэдэг асуулт байгаа. Одоо энэ дээр бол энэ бүх гишүүд тараасан байлгүй дээ. Энэ дээр бол ерөөсөө болно гэсэн өгүүлбэр нэг ч байхгүй байна лээ шүү дээ. Давсан байна, хэтэрсэн байна, болохгүй байна, ингэж зөвлөж байна гэсэн юмнууд байгаад байгаа юм. Тэгэхээр одоо Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань сая 2024 онд хуульчлагдаад ингээд албан ёсны бүтэц болчихсон. Одоо Их Хурлын төсвийг тогтвортой байлгах, түүнийг хэрэгжүүлэх маш том чиг үүрэгтэй юм байна лээ шүү дээ. Тэгээд энэ чиг үүрэг чинь хэрэгжихгүй байна шүү дээ. Тэгэхээр яадаг юм бол. Татан буугддаг юм уу, аль эсвэл илүү хүчтэй бүтэцтэй болдог юм уу. Тэр дээр зөвлөлөөс хариулт өгөөч.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Жавхлан сайд.

Б.Жавхлан: Үгүй ээ, яах вэ. Би саналаа хэлчихье л дээ. Хоёулаа би ч бас гишүүн, та ч гишүүн. Би танд бас мэдээлэл өгье л дөө. Энэ Тогтвортой байдлын зөвлөлийг энэ хийсэн үйлдлээс нь харах юм би л лав итгэхээ байлаа. Энэ яг улс төрчдийн захиалгаар улс төрийн зөвлөл шиг юм болж ажиллаж байна.

Өчигдөр жишээ нь тэр Төсвийн байнгын хороо дээр орж ирж тийм мэдэгдэл хийх дэг байхгүй. Дэг байхгүй. Хүрээний мэдэгдэл дээр ямар ч дүгнэлт гаргах, унших, тараах ийм дэг байхгүй байхгүй юу. Тийм байхад орж ирж баахан үймүүлсэн. Тэрийгээ баахан тарааж өгөөд ингээд яваад байна лээ. Энэ бол маш том дэг зөрчсөн юм байгаа юм.

Дээрээс нь 6 сарын 5-нд батлагдсан тэр хуулиуд дотор энэ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль дээр байдаг 2 том шаардлагаа байхгүй болгочихсон. Одоо хууль нь тийм байгаа байхгүй юу. Одоо хууль нь тийм байсаар. Тэр хууль дээр хийсэн тэр дүгнэлт гэж уншсан зүйл нь бүр шал худлаа юм уншаад явчхаж байгаа юм. Одоо байхгүй юм дээр дүгнэлт хийгээд, ингээд явчихсан. Бүр тусгай шаардлага аваад хаячихсан байхад. Уг нь энэ тусгай шаардлагуудаа энэ 6 сарын 5-нд аваад хаячихсан байна. Одоо ийм эрсдэл үүсчихсэн байна шүү. Юун дараагийнх нь ярих манатай гэж зөвлөмж өгсөн бол их зөв байх байсан. Тийм учраас энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд итгэх арга алга. Тэгэхээр одоо яадаг юм байгаа юм. Одоо бид чинь өрийн хязгаар нь байхгүй болчихсон учраас бид 2025 оныхоо төсвийг бооход одоо яаж боох нь маш тодорхойгүй байдал үүсчихсэн. Одоо энийг л яаралтай засаж өгөх хэрэгтэй байгаа юм. Энэ саналуудыг бол бид оруулж ирсэн байгаа.

Д.Амарбаясгалан: Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Пунсалмаа: Том мега төслүүдийг бүгдийг нь дэмжиж байгаа. 1 асуулт байна.

2024 оны төсвийн тодотголын хүрээнд 27 их наяд төгрөг төсвийн зардалд бол батлагдсан байсан. Тэрийг 3,1 их наяд төгрөгөөр буюу 11,4 хувийн өсөлтөөр энэ зардал нэмэгдэж байгаа юм. Эдийн засгийн үр өгөөжийг заавал ер нь тооцож байдаг. Тэгэхээр энэ 11,4 хувьтай тэнцэхүйц ажлын байр хэдэн

хувь нэмэгдэж байгаа вэ. Дээрээс нь энэ томоохон төслүүд дээр дотоодын аж ахуйн нэгжүүд бас хэрхэн хамрагдаж орж ирж, үүний өгөөж нь энэ 11,4 хувьтайгаа харьцуулахад байгаа ямар байгаа вэ. Үүнтэй ижилхэн бас бүх төслүүд өөрийн цаг хугацаатай, хэмжих нэгжтэй байдаг. Тэгэхээр энэ 149 төсөл буюу 120 их наяд төгрөгийн 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн эдгээр төслүүд 2024 онд ажлынхаа гүйцэтгэлийн хэдэн хувьд хүрэх вэ, 2025, 2026 ондоо хэдэн хувьдаа хүрэх вэ гээд хувиудаа тооцоолоод, тухайн цаглавар хугацаандаа ажлын байр хэдэн хувьд нэмэгдсэн байх юм. Цалин хэдэн хувь нэмэгдсэн байх юм. Дотоодын үйлдвэрлэгч нарын тухайн төсөлд оролцож байгаа байдлын үр дүн хэдэн хувь өссөн байх вэ. Энэ тал дээр цаглавар гаргаж тооцсон зүйл байгаа юу гэж асууя.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд. Санжаадорж 3 дугаар микрофон.

М.Санжаадорж: Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Энэ удаагийн тодотголоор зарлагыг 3 их наяд төгрөгөөр бол нэмж оруулж ирж байгаа. Энэ орж ирж байгаа тодотгол нь бүгд хөгжлийн томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгаа. Нөгөө талдаа бид урсгал зардлаа бол нэмж орж ирээгүй. Хөгжлийн томоохон хөтөлбөрүүд маань өөрөө эргээд эдийн засагт хувийн хэвшилээ дэмжих хамгийн том боломжийг олгодог. Эдгээр төслүүд маань хэрэгжиж эхлээд явах юм бол мэдээж хэрэг ажилгүйдэл энэ дээр буурна. Мэдээж хэрэг компаниудын ашиг орлого нэмэгдэнэ. Нөгөө талдаа бол мэдээж хэрэг бид бас эрсдэлийг тооцож байгаа. Энэ дээр валютын нөөцийн асуудал ч байдаг юм уу, халаалт ч байдаг юм уу эдгээр тооцоонуудыг хийж байгаа. Энэ тооцоонууд дээр тооцооллууд макро эдийн засгийн тооцооллыг бол оруулж ирсэн байгаа. Үүний өмнө бидний

хэлэлцсэн нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл дээр бид макро тооцооллыг бол оруулж ирсэн байгаа. Эдийн засгийн өсөлт мөн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг бас оруулж ирсэн байгаа. Анх дотоодын нийт бүтээгдэхүүнийг 74 их наядаар бид тооцож байсан. Төсвийн тодотголоор бол 79 их наяд руу очно гэсэн тооцоолол явж байгаа. Гэхдээ ихэнх энэ төслүүд маань 2 дугаар хагаст хийж байгаа энэ төслүүд маань хамгийн том нөлөөллүүд нь ойролцоогоор хагас жилийн дараа буюу ирэх оны зунаас энэ нөлөөллүүд нь, эффектүүд нь илүү ихээр орж ирэхээр тооцоолол харагдаж байгаа. Тэгэхлээр 2025 оны төсвөө бид нар удахгүй 15 хоногийн дараа Улсын Их Хуралдаа өргөн мэдүүлнэ. Энэ дээрээ энэ тооцоонууд маань илүү тодорхой болж харагдана гэж бид найдаж байгаа. Энэ тодотголоор бид нар эдийн засгаа идэвхжүүлж байгаа энэ тооцоогоо илүү дэмжсэн 2025 оны төсвийн төслийг оруулж ирэхээр энэ дээр илүү тооцоо нь нарийвчилж гарна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн Шадар сайд Гантөмөр сайдын микрофоныг өгье. Нэмж хариулъя.

Л.Гантөмөр: Манай гишүүд сонсож байгаа бол 3 зүйлийг хэлмээр байна. 1 дүгээрт төсөв бол дандаа ашигтай батлагдах нь. Энийг хуульчлах гэж байна гэдгийг та бүхэн ойлгогчоорой.

2 дугаарт хөгжлийн зээл дээрээ жсоохон зай гаргаж байгаа юм байна. Яагаад төсөв байнга ашигтай батлахын төлөө ингээд тогтвортой байдлын хуульд хүрч байна вэ гэхээр орж ирж байгаа орлогоо ашиглах гээд байгаа юм байна гэдгийг л та нар ойлгогчих. Та бүхэн маань ингэж ойлгож хүлээж аваарай. Орж байгаа орлогоо ашиглах гээд байгаа юм байна. Энийг ашиглахгүй байя гэхээр бид нар дандаа хөгжлийн өнөөдөр байгаа энэ уул уурхайн өсөлтийг бид нар эдийн засгийн өсөлт болгож чадахгүй ийм нөхцөл байдалд байгаад байна гэдгийг л

та бүхэн маань ойлгоод өгмөөр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 минут.

Л.Гантөмөр: Анхаарах асуудал бол байгаа. Одоо бид нар энэ орон нутагт бонд гаргах эрх өгчихсөн. Үүний хяналтыг бүрэн барих хэрэгтэй. Энэ бол Засгийн газрын үүрэг байх ёстой. Дахиад нэг анхаарах юм байгаа юм. Хөгжлийн зээл дээрээ Их Хурал бүрэн хяналтаа тавьж байх хэрэгтэй. Энэ хоёроо бид нар ингээд бүрэн хянаад явчих юм бол ямар нэгэн байдлаар тийм нэг айхтар зээл аваад, улс орноо өрөнд оруулах гэж байгаа, өрөнд оруулахын төлөө түгжээ мулталж байгаа ажил энд хийгээгүй шүү. Тийм нэг буруу орчуулга явчихсан байна шүү. Аягүй буруу орчуулга явчихсан байна.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

Б.Жавхлан: Пунсалмаа гишүүний асуултад зүгээр нэмж мэдээлэл өгье. Монгол Улсын эдийн засгийг зөвхөн төсвөөр харж болохгүй шүү. Том ийм макро дүгнэлт хийе гэж байгаа бол дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ тоог бас их сайн харах хэрэгтэй. Үндсэн тоо чинь ер нь тэнд юм байгаа юм. Дотоодын нийт бүтээгдэхүүн өсөөд өөрөөр хэлбэл эдийн засгийн суурь дотоодын нийт бүтээгдэхүүнийг бий болгож байгаа баялаг бүтээгч нарын энэ оролцоо, үр өгөөж чинь гүйцэтгэл нь өндөр болоод байгаа байхгүй юу. Тэгээд 2021 онд манай Засгийн газар хүлээж авч байхад 36 их наяд байсан дотоодын нийт бүтээгдэхүүн маань 4 жилийн дараа 2,1 дахин буюу бараг 80 их наяд хүрлээ. 80 их наяд хүрлээ. Энийг дагаад төрийн үйлчилгээ бас тэр хэмжээнд бас нэмэгдэж байна л гэж харах хэрэгтэй. Дотоодын нийт бүтээгдэхүүн 2 дахин өссөн. Энэ өсөлтийг зүгээр нэг дэмжсэн зүйл нь төсөв. Өөр маш олон дэмжигч ийм эдийн засгийн оролцогч нар байгаа.

Д.Амарбаясгалан: Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

М.Энхцэцэг: Та бүхэнд шөнийн мэнд хүргэе. Ингээд бид бүхэн хоолоо, нойроо хасаад улс орныхоо төлөө зүтгэж байгаа учраас улсын маань ирээдүй сайхан байна гэж бодож байна. Би эрчим хүчний сайд болон Эрүүл мэндийн сайд 2-оос 2 асуулт асууя гэж бодож байна. Бид бүхэн нэг зүйлийг хамтдаа маш сайн ойлгосон. Юу гэхээр эрчим хүчний салбарыг бид өнөөдөр түрүүлэн хөгжүүлж байж л бусад төслүүдийн тухай, бусад бүтээн байгуулалтуудын тухай ярих боломжтой болно гэдгийг бол бид ч мэдэж байгаа мөн нийгэм ч тийм хүлээлттэй, тийм ойлголттой байгаа. Тэр утгаараа би эрчим хүчний салбарт хамгийн их хөрөнгө оруулалт тусгагдсан тийм төсөв орж ирэх байх гэсэн хүлээлттэй байлаа. Гэвч дүр зураг арай ондоо харагдаж байна. Ганц том тоо нь болохоор тарифын шилжилттэй холбоотой 130 тэрбумаас өөр том тоо энэ салбар дээр бол харагдахгүй байна. Харин Улаанбаатар хот эрчим хүчний салбарын 2 асуудлыг шийдэж өгч байгаа юм байна. Энэ бас сайшаалтай байна. Тэгэхээр бид өнөөдөр хэлэлцсэн мөрийн хөтөлбөртөө эрчим хүчний салбарт нийт 2620МВт-ын хүчин чадалтай 10 дулааны цахилгаан станцуудыг барина. Дулааны цахилгаан станц 2, 3, 4-ийг өргөтгөнө гээд том том мөрийн хөтөлбөрүүдийг тусгаж орж ирсэн. Энэ станцуудыг барихад их хугацаа ордог. Тэгэхээр ядаж энэ станцуудын бэлтгэл ажил буюу ТЭЗҮ-г нь хийх, зураг төслийн төсвийг боловсруулах ажлыг энэ оны төсөвт тусгаж болохгүй юм уу гэсэн ийм асуултыг Эрчим хүчний сайдаа тавих гэсэн юм.

Мөн яг Улаанбаатар хотын гаргаад байгаа шиг бондыг эрчим хүчний салбар гаргаж болохгүй юм уу. Тэгээд энэ батарей станцууд гээд өчнөөн асуудлууд байгаа.

Эрүүл мэндийн сайдаас 1 асуулт тавья. Архангай аймгийн Тариат суманд

би сая очлоо. Тэнд Японы санхүүжилтээр эмнэлгийн барилгынх нь өргөтгөлийг жилийн өмнө барьж өгсөн байна. 1 тэрбум төгрөгийн санхүүжилт гаргаад. Энэ төсөл дээр бол Монголын талын хүлээсэн үүрэг нь дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх байсан юм байна. Тэгтэл Монголын тал хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй, одоо хүртэл тэр дэд бүтцийн асуудлыг нь шийдэж өгч чадахгүйгээс болоод Японтой хамтарсан энэ төсөл дуусахгүй байгаа ийм асуудал байгаа юм байна лээ. Тэгэхээр энийг шийдэж өгвөл зүгээр санагдаж байсан. Учир нь болохоор мэдээж энд чинь ингээд 2 асуудал хөндөгдөж байгаа. 1 нь болохоор гаднын улстай хамтарсан төслийн хүрээнд Монголын тал үүргээ хүлээхгүй байна гэдэг чинь хамтын ажиллагаа нөлөөлж байгаа. 2 дугаарт нь Тариатын эмнэлэг нь болохоор тэр бүсийнхээ аймгуудын эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг маш том үүрэг рольтой ийм эмнэлэг. Тэгэхээр ард түмний эрүүл мэндийн асуудал бас энэ дээр маш чухал тавигдаж байгаа. Тэгэхээр энийг онцгойлон анхаарч өгөх нь зүйтэй юм болов уу. Энэ дээр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эрчим хүчний сайд Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Энэ төсвийн тодотгол дээр эрчим хүчний сайдын татаасны хэмжээг 131 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх ийм шийдвэр орж ирсэн. Энэ бол бараг сүүлчийн татаас гэж ойлгож болно. Энэ оны 11 сарын 1-ээс бид нар цахилгаан эрчим хүчний тарифаа нэмэгдүүлж чадах юм бол цаашид шөнийн эрчим хүчний татааснаас бусад бүх татаасыг салбар өөрөө даагаад явах ийм тооцоолол хийгдэж байгаа. Эрчим хүчний тарифаа нэмэгдүүлж чадах юм заавал төсвөөс дэмжлэг авахгүйгээр эрчим хүчний салбар өөрийнхөө төслийнхөө бэлтгэл ажлуудыг бүрэн хийгээд явах бололцоотой.

2 дугаарт бид нар тарифаа манай салбарт хөрөнгө оруулаад ашиг олдог хэмжээнд нэмэгдүүлж чадах юм бол улсад өр үүсгэхгүйгээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарын эх үүсвэрийг манай салбар луу татаж оруулах бололцоо байгаа учраас ийм ажил хийгдэж байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар 2,3 орчим их наяд төгрөгийн эрчим хүчний салбар өртэй байна. Энэ төрийн өмчтэй компаниудын өр шүү. Үүнээс 470 орчим тэрбум төгрөгт богино хугацаатай өр төлбөр. 1,8 их наяд нь бол урт хугацаатай өр төлбөрүүд байгаа. Яг Эрчим хүчний сайдын тухайд гадаад зээлийн ашиглалт гэж яриад байгаа энэ гадаад зээ зээлийн тусламжаар яг өнөөдрийн байдлаар 750 орчим сая долларын гэрээнүүд хийгдчихсэн байгаа. Энэ маань удахгүй ойрын 2, 3 жилийн дотор манай салбарын өр болж нэмэгдэнэ. Зээл болж нэмэгдэх ийм нөхцөл байгаа учраас тарифыг бол их ухаалаг олон зүйлийг тооцож хийх ийм шаардлага үүсэж байгаа. Энэ одоо 3 минутын асуулт хариултын горимоор эрчим хүчний салбарт байгаа энэ хүндрэлүүдийг бүрэн ойлголт өгөхөд хэцүү байгаа учраас маргааш 14 цаг цагаас манай Эрчим хүчний яам дээр ирж, эрчим хүчний салбарт байгаа нөхцөл байдал ... ажиллахаас аргагүй шүү дээ. Доржханд Шадар сайд тэргүүтэй хүмүүс манай яам дээр ажиллах юм. Маргааш 14 цагаас ... ирж ойлголцооч гэдэг. Түүнээс биш төсвийн орон зайгаар эрчим хүчний салбарт хуримтлагдсан хүндрэлийг бол шийдэх ямар ч бололцоо байхгүй байгаа.

Д.Амарбаясгалан: Тэргүүн шадар сайд Гантөмөр сайдын микрофоныг өгье. Нэмж хариулна.

Л.Гантөмөр: Дахиад буруу ойлгочих вий гээд тодруулж байгаа юм. Нийт эрчим хүчний салбарт одоо манай энэ зарцуулах гэж байгаа 3,1 их наяд төгрөгөөс эрчим хүчний салбарт зарцуулж байгаа нь 681 тэрбум байгаа шүү. 682 тэрбум төгрөгийг эрчим хүчинд зарж байгаа юм. Бөөрөлжүүтийн 300,

Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын 254, тэр шилжилтийн 126, батарей чинь хэд билээ. Дахиад 300 гээд тэгэхээр энэ чинь бараг 980 нь болохоор эрчим хүчний салбарт зарцуулж байна шүү Энхцэцэг гишүүн ээ.

Дулааны станцаа нэмэх юм бол бүр ингээд аваад явчихна. Тэгэхээр та бүхэн зөвхөн барилга замд зарцуулж байгаа юм шигээр ингэж буруу ойлгож болохгүй гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Эрүүл мэндийн сайд Мөнхсайхан сайд хариулъя.

Т.Мөнхсайхан: Гишүүний асуултад хариулъя. Ер нь энэ сум, аймаг орон нутгуудад бас тодорхой багахан хэмжээний төсөв мөнгө шийдчихвэл ашиглалтад орчихоор ийм нэлээн хэдэн бүтээн байгуулалтууд байгаад байгаа юм. Гэхдээ энэ удаагийн тодотголоор бол илүү их цаашидаа үр өгөөж өндөртэй, томоохон мега төслүүд рүүгээ хөрөнгө оруулалтаа хийнэ ээ гэдэг ийм шийдэлтэй байгаа учраас энэ ашиглалтад орох дөхсөн энэ барилгуудын үлдэгдэл санхүүжилтийг 2025 оны буюу ирэх оны төсөв дээр шийдэхээр ер нь шийдлүүдийг нь бүгдийг нь гаргаад тусгаад явж байгаа гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Энхцэцэг гишүүн тодруулга авъя гэж байна.

М.Энхцэцэг: Баярлалаа. Тийм ойлгож байгаа Гантөмөр сайдын тайлбарыг бол ойлгож байгаа. Миний асуусан гол асуулт болохоор нөгөө хамтарсан мөрийн хөтөлбөр суулгасан том эх үүсвэрүүдийн бэлтгэл ажлыг хангах ТЭЗҮ, зураг төслийг энэ оны тодотгол дээр суулгаж болохгүй юм уу гэж асуулт байсан.

2 дахь нь болохоор бас нэмээд саяын гаргасан бонд бол хот дээр байсан учраас эрчим хүчний салбар дээр бас бонд босгох боломж байдаггүй юм уу гэсэн ийм л 2 асуулт байсан юм. Тэгээд хэдүүлээ

маргааш 14 цагт энийг ярих юм байна гэж ойлголоо. Баярлалаа 2 сайддаа.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн алга байна. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалан: Төсвийн тодотголоор 3 гаруй их наяд төгрөгийн тодотгол орж ирж байна. Тэгээд энэ мөнгөн дүнгийн дийлэнх нь бол нийслэл хоттой холбоотой дүнгүүд байна. Нийслэлийн газар чөлөөлөлт 584 тэрбум, нийслэлийн бонд 1 их наяд гэх мэтчилэн. Тэгээд дийлэнх төсөв нь бол нийслэл дээр тавигдаж байна. Тэгээд яах вэ, нийслэл дээр бол маш олон тулгамдсан асуудлууд байгаа учраас мөнгө тавиад явах нь зөв. Гэхдээ энэ дээр хотын даргаас тухайлж асуух нь нийслэлийн газар чөлөөлөлт гээд байгаа 584 тэрбум төгрөг ер нь яг ямар учиртай мөнгө вэ. Тэгээд хагас их наядыг бол бид нар ийм газар чөлөөлөлтөд зарцуулах гэж байгаа юм байна. Тэгээд энэ Сэлбэ дэд төвийн 2206 нэгж талбарыг чөлөөлөхөд шаардлагатай нөхөн олговрын зардал гэсэн зүйл танилцуулга дээр орж ирсэн. Тэгэхээр энэ яг гэрээнүүд нь хийгдсэн юм уу. Хэчнээн эзэмшигчтэй, хэчнээн гэрээ хийгдэх шаардлагатай байгаа юм. Үнэлгээг нь ер нь бол яаж тохирч байгаа юм. Тэгээд цаашидаа үүний үр дүнд ер нь яг бид нар хэдэн янданг устгах вэ. Хотын асуудал яг ямар хэмжээнд шийдэгдэх вэ гэдэг ийм асуултыг хотын даргаас асуумаар байна.

2 дугаарт бас нийслэлийн бонд дээр бол Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станцад дамжуулан зээл олгоно гэсэн шийдвэр гарсан байгаад байгаа. Тэгээд яах вэ хувийн хэвшлийн явж байгаа төсөл дээр заавал хот дамжуулан зээл олгох шаардлагатай байсан юм уу. Тэд нар бас арилжааны шугамаар өөрсдөө зээл аваад явах боломжгүй байсан юм уу. Нэгэнтээ эхэлчихсэн төсөл учраас нийслэлтэй холбоотой иймэрхүү асуудлууд байна.

2 дугаарт нь болохоор малчин хоршооны зээлийн хүүгийн зардал гээд бас 126,7 тэрбум төгрөгийн зардал орж ирж байна. Тэгэхээр энэ малчин хоршооны зээлийн хүүгийн зардал гэдэг нь бас яг хэдэн зээлдэгчийн зээлийн хүүгийн зардал вэ. Нийт олгосон зээлийн хэмжээ нь хэд вэ. Тэрийг бас асууя. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Чойжилсүрэн сайд хариулъя. Чойжилсүрэн сайдын микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Бөөрөлжүүтийн цахилгаан станцад Улаанбаатар хот 300 орчим тэрбум төгрөгийг дамжуулан зээлдүүлэх ийм үйлчилгээ, тусламж гэх юм уу хамтарч ажиллаж байгаа юм. Ер нь бол манай эрчим хүчний салбар нэн ялангуяа нүүрсний эх үүсвэр барихад барууны улс орнууд бол ерөнхийдөө Парисын хэлэлцээрийн дагуу нүүрсний төслүүдийг санхүүжүүлэхгүй байгаа.

2 дугаарт дээрээс нь дараагийн хүндрэл бол 2021 оны намар 9 сард НҮБ-ын 176 дугаар чуулган дээр Хятад Улсын төрийн тэргүүн Си Жиньпин дарга Хятад улсын газар нутгаас гадна нүүрсний цахилгаан станцыг санхүүжүүлэхгүй гэдэг ийм мэдэгдэл хийчихсэн. Энэ улс төрийн мэдэгдлийг дагаад Хятадын бүх төрийн шийдвэрүүд гарчихсан ийм нөхцөл байдалд байгаа юм. Тийм учраас нүүрсний төсөл дээр эх үүсвэр гадаад дотоодоос босгоход бол урьд нь байсан одоогоос 10 жилийн өмнөх нөхцөлтэй байдалд харьцуулжгүй хүнд нөхцөл байдалд байгаа юм. Энэ 300 орчим тэрбум төгрөгийн бондыг дамжуулан зээлдүүлж байж ямар ч байсан энэ 2024 оны 10 дугаар сар гэж байгаа юм. Магадгүй жоохон ажил нь хойшиллоо гэхэд 12 сарын 1-ээс өмнө 150МВт-ын блок ашиглалтад оруулах, ирэх жилийн 10 сарын 1 гэхэд 2 дахь 150МВт-ын блокийг ашиглалтад оруулахад энэ төслийг хэрэгжүүлж байгаа компани мөнгөн урсгалын дутагдалд орчхоод байгаа юм. Тийм

учраас хотын дарга маань энийг ойлгоод Сангийн сайд засгийн түвшинд бүгдийг нь ойлгуулаад энэ ажил хийгдсэн Жаргалан гишүүн ээ. Үүнээс өөр ойрын хугацаанд бид нар ашиглалтад оруулчих эх үүсвэр байхгүй байна. Харамсалтай нь. Ямар нэгэн цахилгаан станцыг эхлүүлээ гэхэд дор хаяж 30 сар, цаашилаад 36, 40 сарын хугацаа шаардагддаг учраас манай хэрэглээний өсөлт маань ийм хэмжээний хугацааг хүлээх бололцоо гарахгүй байгаа юм.

Д.Амарбаясгалан: 2 дугаар микрофон хотын дарга хариулъя.

Х.Нямбаатар: Би гишүүний асуултад хариулъя. Энэ жил бид нар Сэлбэ дэд төв дээр газар чөлөөлөлтөд одоогийн байдлаар 294,3 тэрбум төгрөгийг газар чөлөөлөлтөд зарцуулаад байна. Одоо бид нар энэ ондоо төсвийн тодотгол батлагдсан тохиолдолд нийслэл төсвөө тодотгоод, дахиж 150 тэрбум төгрөгийг зөвхөн Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлтөд зарцуулахаар төлөвлөж байгаа. Өнөөдрийн байдлаар захирамж нь гараад, гар дээрээ мөнгөө авсан 1200 иргэн байна. Ирэх 7 хоногт үлдсэн 100 гаруй иргэн үлдэгдэл төлбөрүүдээ авна. Үүнээс цааш бид нар дахиад энэ ондоо 150 тэрбум төгрөгийг газар чөлөөлөлтөд зарцуулна гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Бондын 500 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаар ярья. Дарга аа, энэ хугацаа дуусчихлаа.

Д.Амарбаясгалан: Нэмэлт минут өгье.

Х.Нямбаатар: 500 биш ер нь 1 их наядаар нь би тоймлоод хэлчихье. Энэ 1 их наядаас 600 тэрбум төгрөг нь эрчим хүчний төсөл дээр санхүүжиг байгаа. Сая Чойжилсүрэн сайд маш тодорхой хэлсэн. Парисын уур амьсгалын өөрчлөлтийн хэлэлцээрт нэгдээж орсон улс орнууд хүрэн төсөлд санхүүжилт олгохгүй байгаа. Тэгээд бид арга буюу дотоодоосоо бонд босгож, эрчим хүчний станцад хөрөнгө оруулалт хийж байгаа.

Эргэн төлөлтийг нь уг төсөл хариуцна. Төслийг хот барьцаалсан байгаа. 300 тэрбум төгрөгөөр нь батарей станц байгуулаад, тендер шалгараад, гэрээ хийгдэж байна. Энэ төсөл 11 сарын сүүлээр дуусна. Шууд төв эрчим хүчний шугамд энэ төсөл дуусмагцаа эрчим хүчээ нийлүүлнэ. Үлдсэн 400-ын 270 замын төсөл байгаа. Үлдсэн нь Туул нэг коллектор, сангийн бусад төслүүд байгаа.

Д.Амарбаясгалан: Пүрэвийн Батчимэг гишүүн асуулт асууя.

П.Батчимэг: Цомхон бүтээмжтэй төртэй байхын тулд эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагчдын тоог жил бүр 10 хувиар, 10 хүртэл хувиар бууруулах, төрийн анхан болон дунд шатын нэгж дэх ажлын байрны давхардлыг арилгана гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ олон төрийн албан хаагчдын ажлын байрны давхардлыг яаж арилгах юм. Тэнд төрийн албан хаагчдын давхардалд ороод, цомхотголд орчихсон, бүтцийн өөрчлөлтөөр цомхотголд орчихсон албан хаагчдын ар гэрийн амьдрал, ахуй нөхцөлийг нь яаж тооцох юм бол. Анхан шатын нэгж дээр төрийн ажил байгууллагуудын ажил бол явдаг гэж ярьдаг. Дунд шатын байгууллага дээр нэгж дээр бол ажил удааширалтай, хойрго. Тэнд авлигын асуудал хүртэл яригддаг. Тэгэхээр энэ ажлын байрны давхардал гэдэг юмыг яаж, хэдий хугацаанд бууруулж давхардлыг арилгах юм бол гэдэг асуулт байна.

Энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотойгоор төсвийн тодотголыг хэлэлцэж. Мөн өргөн барьж байгаа энэ олон мега төслүүд ирэх 4 жилд эдийн засгийн үр өгөөжөө өгөх, хөгжилд хөтлөх энэ төслүүдийн хүрээнд дунд хугацааны бодлогын баримт бичгүүд, төсөөллүүд, төсвийн төсөөллүүд орж ирж байна. Тэгэхээр энэ түрүүний Сангийн сайдын ярьсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийг

үгүйсгэсэн байдалтай сая та хэлэх шиг боллоо. Тэгэхээр яагаад энэ дүгнэлт, зөвлөмж гарч байгаа энэ том ажлыг та үгүйсгэх болов гэдэг нэг асуудал.

Миний харж байгаагаар, уншиж танилцсанаар бол энд маш ийм сайн оновчтой тийм дүгнэлт, зөвлөмж гаргачихсан байх шиг санагдаж байгаа юм. Жишээ нь энэ олон төслүүд, мега төслүүдийг хийхэд ямар нэгэн суурь судалгааг хэдий хугацаанд авч хэрэгжүүлсэн юм бол. Гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагуудын судалгааг авсан юм уу. Ямар суурь судалгаа авсан бэ гэдгийг бас асуумаар байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сангийн сайд. Батчимэг гишүүнд 1 минут нэмж өгье. Нэмэлт цагаараа асууя.

П.Батчимэг: Зам, тээврийн сайдаас асуух асуулт байна. Энэ Гашуунсухайт-Ганц мод, Сэхээ-Шивээ хүрэн, Ханги мандал гээд энэ 3 төмөр замын асуудал ер нь хэзээ шийдэгдэж, хэзээ энэ төмөр замыг холбох вэ. Та нэг тайлбар өгөөч.

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

Б.Жавхлан: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Тэр ажлын байрны давхардлыг манай Хэрэг эрхлэх газраас хариулчихвал их сайн байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтэд яах вэ Засгийн газраас дүгнэлт өгөөд байх нь ч хаашаа юм. Зүгээр би гишүүнийхээ хувиар ч тэр, энэ Улсын Их Хурлын бүтцийн байгууллагын гаргаж байгаа Улсын Их Хурлын гишүүдэд хандаж гаргаж байгаа энэ зөвлөмж, дүгнэлт дээр би өөрийнхөө бодлыг бас хэлчих эрх бас үүрэгтэй болов уу гэж ингэж бодож байна. Тэгээд миний ганц итгэхгүй байгаа зүйл Төсвийн тогтвортой байдлын зөвлөл маань одоо хүчин төгөлдөр байгаа хууль дээр үндэслэж аливаа дүгнэлтээ гаргах ёстой.

Энэ бол ерөнхий суурь зарчим шүү дээ. Гэтэл тэр хууль нь өөрөө 2 тусгай шаардлага нь байхгүй болчихоод байхад, байгаа мэт тэрийг ярьж, тэр дүрмийн хүрээнд зөрчилтэй байна гэдэг дүгнэлт нь өөрөө буруу болчихож байгаа байхгүй юу. Энд ерөөсөө дөрөвхөн шаардлага л байдаг юм. Дөрөвхөн шаардлага. Орлого, зарлага, алдагдал, өр гээд. Гэтэл өр, алдагдал 2 гээд хамгийн суурь 2 шаардлага. Энэ 2-ыг хуулиар хамгийн сүүлдээ 6 сарын 5-нд төсвийн шинэчлэл гэж яригдаад байгаа тэр өөрчлөлтөөр энэ шаардлагаа бүр байхгүй болгочоод байхад, тэр суурь хууль дээр дүгнэлт гаргахдаа нөгөөдүүл нь байгаа мэт яриад ингээд дүгнэлт гаргачихаар чинь хэдүүлээ тэр дүгнэлтийг зөв гэх үү, буруу гэх үү. Энийг та ч гэсэн бас нэг тунгаагаарай. Би бол энийг буруу гэж үзэж байна. Гишүүний хувьд, эдийн засагч хүний хувьд ч тэр. Уг нь эхлээд ийм 2 тусгай шаардлага чинь байхгүй болчихжээ эрхэм гишүүд ээ, эхлээд энийгээ өөрчлөд буцаагаад тавьчихъя. Ингээд тавьчихаад харах юм бол гээд ингэж яримаар юм. Гэтэл бид энийг чинь тодотголоор оруулж ирэхдээ харин бүр түрүүлээд энийгээ зас. Энэ тусгай шаардлагуудыгаа буцаагаад сэргээ. Ингэж явж болохгүй. Энэ чинь жинхэнэ завхрал болох нь гэж ингэж оруулж ирж байгаа юм шүү. Энэ талаас нь хараадхаарай.

Төслүүдийн суурь судалгаа гэж байна. Энэ төслүүд бол үнэхээр бүгдээрээ цоо шинэ том төслүүд. Бид нар хэзээ ч ийм төслүүдийг бид өөрсдөө барьж аваад, ингээд нухаад хийгээд эхэлнэ гэж бол ойрын жилүүдэд бол ер нь бодож байгаагүй. Төсөөлж байгаа ч үгүй. Харин энэ боломж өнөөдөр бидэнд бас бий болж байна гэж харж байгаа. Одоо Улсын Их Хурлын шинэ сонголт, бүтэц, Засгийн газрын хамтарсан байдал энэ бүхэн ард түмэн бидэнд даалгавар өгч байна л гэж ингэж харж байгаа. Тийм учраас ерөөсөө яг бэлтгэл ажлаасаа хангахаасаа эхлээд, суурь судалгаагаа хийхээс эхлээд л бидэнд зардал мөнгө хэрэгтэй. Тэгээд энэ мөнгөө тавьж байгаа байхгүй юу. Тэрнээс яг

хөрөнгө оруулалтын, бүтээн байгуулалтын ажил бол энэ яг одоохондоо хараахан биш. Тийм учраас энэ жилдээ бид нар ядаж бэлтгэл ажлаа хангаад, тэгээд яг таны хэлж байгаа ишг суурь судалгаануудаа гаргаж аваад, нөгөө даалгавруудаа гаргаж аваад яг бүтээн байгуулалтад оролцох нөхдүүдийг урих нь байна шүү дээ. Энэ чадаж магадгүй гээд. Тэгэхдээ барьж хэлж ярих юмтай болчихоо л гэсэн ийм л алхам юм байгаа юм. Энэ хагас энэ сүүлийн хагас жилд төсвийн тодотголоор хийх гэж байгаа зүйл маань.

Тэгээд түрүүн Пунсалмаа гишүүн асуусан, Батчимэг гишүүн ч бас асуулаа. Тэр ажлын байрын давхардалд яах вэ зүгээр бид нар сая ухааж байгаад нэг ийм тоо гаргаж ирлээ. Сая ковидын үеэр бид хүн амынхаа тоог их сайн нарийн тоолж авсан. Нөгөө 300 мянгыг данс руу нь хийх гэж байхад 1 ч хүн үлдээхгүй хийхийн тулд тэрхэн хооронд 100 мянган иргэнээр нэмэгдчихсэн шүү дээ. Тэр бүгдийг тоолоод авсан юм. Тэгээд 3 сая 460 мянган хүн амтай 2 жилийн өмнө тийм байсан. Эндээс яг хөдөлмөрийн насны.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайдад 1 минут нэмж өгье.

Б.Жавхлан: Хөдөлмөрийн насны 2 сая 200, үүнээс 300 мянга нь гадаадад байгаа. Гадаадад Солонгост байна. Баруун Европт байна. Америкт байна. Оюутнууд бас мөн орно. Ингээд яг Монголд аж төрөөд цалингийн системээр, и баримтаар дамжиж суутган татварт бүртгүүлээд цалингийн системээр ажлын байраа тоолуулж байгаа 1 сая 200 мянган иргэн байдаг юм. 1 сая 200 мянган иргэн. 2 жилийн өмнө ажилгүйдэл Статистикийн ерөнхий хорооны ажилгүйдлийг харах юм бол 2 жилийн өмнө 8,9 бараг 9 хувь руу очиж байсан. Хамгийн сүүлийн тоо 2024 оны 6 сар хагас жилийн байдлаар 5,8 болж буурчээ. 5,8 болж буурч. Тэгээд энэ чинь 5,8, 8,9 гэж 3 хувь буурсан байна. 3 хувь

гэдэг чинь 30 гаруй 1 сая 200-аас 36 мянга. 36 мянган ажлын байр. Энэ бас бага тоо биш шүү. Бага тоо биш. Бид өнгөрсөн 4 жил ковидын үеэр 100 гаруй мянган ажлын байр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Батчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ Гашуунсухайт-Ганц мод, Сэхээ-Шивээ хүрэн, Ханги мандалд гээд ингээд 3 төмөр зам оччихсон ийм бэлэн төсөл байгаа юм. Энэ 3 төмөр зам бол холбогдож байж манай нүүрсний экспорт 100 саяд хүрнэ. Дээрээс нь бас эдийн засгийн үр өгөөж нь бас нэлээдгүй өснө гэж тооцож байгаа юм. Тэгэхээр Гашуунсухайт-Ганц модыг эхэлж холбож байж, бусад боомтууд холбогдоно гэдгийг урд хөрш бол бараг шууд хэлдэг юм. Тийм учраас манай Монгол талаас ажлын хэсэг гараад тэгээд Хятадын тал нь бол Гашуунсухайт-Ганц модны боомт дээрээ яг хариуцаж хийх компани нь Чайна Энерджи компани байдаг. Тэгээд ер нь энэ төсөл өөрөө манайх анх бол бараг 10-аад жилийн өмнө эхлүүлсэн. Манайх өөрсдөө хүсэлт.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайдад 1 минут нэмж өгье.

Б.Дэлгэрсайхан: Тэгээд энэ бид хэлсэндээ хүрээгүйгээс болоод энэ төсөл бараг 10 гаруй жил гацаж, гацаж, өнгөрсөн 2 жилийн өмнө бид одоо наанаас нь төмөр замаа аваачиж барьсан боловч нэлээд зөрчихсөн. Тэгэхээр зэрэг одоо энэ нэмэлт ажил зөрсөн ажиллагааг хийхийн тулд ер нь 700-800-аад сая доллар гарах юм. Нэмэлт зардал. Тэгэхээр энийг урд хөршийн Чайна Энерджи компани хийхийн тулд 3-4 болзол тавьдаг юм.

1 дүгээрт бол нүүрсний олборлолтоо бид бол өөрсдөө хийнэ. Энэ 700-800 мянган сая долларын бидэнд төлөх ёстой шүү дээ. Тэгэхээр эндээ бол

нүүрсний олборлолтоо бол бид өөрсдөө хийнэ.

2 дугаарт нүүрсээ өөрсдөө тээвэрлэнэ.

3 дугаарт бол одоо бидний биржийн зарж байгаа үнээс 5-6 хувийн доогуур үнээр авна гэдэг ийм болзол тавьдаг юм. Тэгэхээр энийг.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: 1 удаа 1 минутаар сунгаж хариулна. Тэгвэл 1 минутаар нэмчихье.

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ, би яагаад энийг зориуд яриад байгаа юм гэхээр манай гишүүд маань бүгдээрээ энийг мэдэж байгаасай гэж бодож байгаа юм. Бид энэ 3 болзлыг биелүүлэхгүй бол энэ зам холбогдохгүй юм. Тэгэхээр энэ зовлон жаргалыг та бүгдэд хэлж бас Их Хурлаасаа зөвшөөрөл авч байж энийг цаашаа ярих уу, тохирох уу гэдэг асуудлаа шийдэхгүй бол манай Монгол-Хятадын Засгийн газар хоорондын комиссын дарга Гантөмөр дарга ч энийг эхэлж очиж ярина. Араас нь миний бие одоо дэд даргын хувьд, дээрээс нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Учрал бид 2 энэ Хятадын талтай энэ асуудлаар хэлэлцээ хийх учраас Их Хурлынхаа гишүүдэд бас энийг албан ёсоор мэдээлчихье гэж бодож байна. Тэгээд би Батчимэг гишүүнийг асуусанд бас талархаж байна. Яагаад гэвэл энийг бид бүгдээрээ мэдэж байх ёстой. Тэгэхгүй бол дараа нь янз бүрийн хууль бус юм болчих вий гэж болгоомжилж байгаа юм гэдгийг албан ёсоор хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Нэрээ өгье. Лувсанжамц, Уянгахшиг, Бейсен гишүүнээр тасаллаа. Лувсанжамц гишүүн үгээ хэлье.

Г.Лувсанжамц: Маши товчхон ярьчихъя. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай хуулийн төслийг дэмжиж байна. Дэмжиж байгаа шалтгаануудаа хэлье.

3.1.1-ийн улсын төсвийн хөрөнгө оруулалт, Хөшигийн хөндийн Туннел, Go-Mongolia гүүр, Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор зэрэг Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтыг хурдасгах төслүүд байна. Эдгээр төслүүдийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг маш сайн боловсруулах, амжилттай хэрэгжих судалгааг хийлгэх хэрэгтэй гэж бодож байна.

Мөн 25км радиустай Богд-Уулыг тойрох шинэ их тойруу хурдны замын зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт нь хурдны замаас гадна их багтаамжийн нийтийн тээвэр буюу шинэ нисэхээс Яармаг, 120-ийн тэмээтэй хөшөө, Сэлбэ дэд төв, зуслангийн бүсийг холбох урт хугацаандаа Налайхтай холбогдох LRT-ийн үр ашгийн тооцооллыг хамтад нь тусгаж, харьцуулалт хийх хэрэгтэй гэж бодож байна. Ингэхээр яах вэ гэхээр Яармагийн замын түгжрэлийг Шинэ нисэх рүү ирж, очиж байгаа гадаад, дотоодын жуулчдын хөдөлгөөн их нөлөөлж байгаа болохоор цаашидаа бид нар жилдээ 2 сая жуулчин авъя гэж байгаа бол энэ их багтаамжийн нийтийн тээврийг шийдэх ёстой болов уу гэж бодож байна. Энэ дээр анхаарч ажиллаасай гэсэн саналтай байна.

2 дугаарт нь болохоор Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолборын хувьд эрчим хүчний хэмнэлттэй ногоон барилгын стандартаар барина гэж байна. Энийг 2 гараа өргөөд дэмжиж байна. Эрс тэс уур амьсгалтай манай улс ногоон хөгжил, пассив барилгын стандартад нэн анхаарах хэрэгтэй байгаа. Засгийн газар нь үүнийгээ түүчээлээд цаашидаа сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлгийн барилгыг пассив стандартад хүргэх зайлиггүй хэрэгтэй. Жишээ нь сургуулийн барилгын урсгал зардлын 80 хувийг нь халаалтын зардал эзэлж байгаа.

Өдөр Гантөмөр сайд хэлж байсан. Пассив стандартыг Засгийн газрын хөтөлбөрт чухалчилна гээд. Түүрүүн сая Мөнхтуяа гишүүн бас багш, ажилчдын цалинг нэмэх асуудлыг хөндсөн. Бид нар нийгмийн үйлчилгээний барилгын халаалтын урсгал зардлыг хэмнэж байж, багш, эмч, ажилчдын цалинг нэмэх боломж бүрдэнэ гэдэгт итгэлтэй байгаа шүү.

Эцэст нь 3.2.2 дээр Сэлбэ дэд төвийн газар чөлөөлөлт, бүтээн байгуулалт, 12 мянган айлын орон сууц зэрэг нийслэлийн утаа, түгжрэлийг шийдэх төслүүдэд дорвитой төсөв тавьж байгаад баяртай байна. Ийм 3 үндэслэлээр энэ хуулийн төслийг дэмжиж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гончигдоржийн Уянгахушиг гишүүн үг хэлье.

Г.Уянгахушиг: Та бүхэнд энэ үдшийн мэнд хүргэе. Энэ дээр нэг ойлгомжгүй байдал үүсээд байна. Юу вэ гэхээр бид нар төсвийн төсөл хэлэлцэж байгаа учраас Дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5-д заасны дагуу санал хураалт явуулах ёстой. Энэ нь юу вэ гэхээр төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна гэж байгаа. Гэтэл өнөөдөр яг хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хуулийн шалгууруудад бол энэ төсвийн тодотгол маань нийцээгүй байгаа гэж ойлгосон. Өөрөөр хэлбэл Үндэсний аудитын газрын дүгнэлт дээр энэ нэмэлт, өөрчлөлт оруулсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тэр шалгуурт бол нийцэж байна гэдэг дүгнэлт байгаад байгаа юм. Нөгөө талаасаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гаргасан дүгнэлт дээр яг одоогийн байгаа шалгуурт бол нийцээгүй байна гэж байгаа юм.

Нөгөө талаасаа яг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.2.1.2 бол одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ иц, энэ талаасаа харахаар бид нар одоо санал хураалт явуулаад, энэ төсвийн тодотгол маань одоогийн байгаа хуулиудад нийцэж байна гээд санал өгөөд дэмжчихээр Их Хурлаараа хууль зөрччих гээд байна.

Тийм учраас энэ талаас хэрвээ энэ төсвийн тодотгол одоогийн хуульд нийцэж оруулж ирэх бол одоогийнхоороо хэлэлцэж болж байна. Хэрвээ энд нийцүүлэхгүйгээр буюу тодорхой хэмжээний төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчилж байж болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа өөрчилж байж энэ төсвийн тодотгол маань нийцэж орж ирэх юм гэх юм бол бид нар өнөөдөр тэр нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн хэлэлцэх тухай хэлэлцээд л баталчихсан байгаа. Тэгэхээр тэр хууль батлагдсаны дараа энэ төсвийн тодотгол маань орж ирэх ёстой юм биш үү гэдэг ийм л санал байгаад байна.

Д.Амарбаясгалан: Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70.5-д заасны дагуу төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулахаар байгаа.

Тэгэхээр эхний ээлжид гишүүдийн ирцийг бүртгээд, өглөө ирцэд орсон гишүүдээс хэдэн гишүүн санал хураалтад орох боломжтой байгаа талаар санал хураалт явуулж үзье. Тэгээд байгаа гишүүдийн ирц хэдтэй байгааг санал хураалт явуулаад үзээдэхье. Тийм ирц хэд байгааг шалгах санал хураалт явуулъя. Зөвшөөрснөөр дарна. Туршилтын санал хураалт шүү. Энэ чинь алдаа гарчихлаа

шүү. Энэ санал хураалт алдаатай болчихлоо. Цуцлаад дахиж санал хураалт явуулъя. Туршилтын санал хураалт ирц бүртгэх. Шинээр эхлүүлбье. Энэ бас төхөөрөмж дээр асуудал гарч байх шиг байна. Байгаа гишүүдийн санал гарахгүй байна.

Тэгэхээр ингэе Дэгийн тухай хуулийн 10.12 дахь заалтаар хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэсэн дэгийн заалт байгаа. Тэгэхээр санал хураалтыг 1 дэх өдрийн өглөө 10 цагаас чуулганы хуралдаан зарлаж, санал хураалтыг явуулна.

01.07 цаг.

Дараагийн асуудалд орёе. Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу 4 дэх асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх асуудал орно.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, дэгийн байнгын хорооны дарга Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баярбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан бөгөөд тус өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж, Улсын Их Хурал 1 танхимтай, 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж заасан. Ийнхүү Улсын Их Хурлын 126 гишүүн бүхий Улсын Их Хурлыг сонгох сонгууль 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр улс орон даяар

явагдаж, сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улсын Их Хурал 2024 оны 7 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлээд байна.

Улсын Их Хурлаас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг 2024-2028 онд бүрэн эрхээ хэрэгжүүлэх Улсын Их Хурал үйл ажиллагаандаа хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалтад Улсын Их Хурал нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг хаврын чуулганаар хэлэлцэн, улсын төсвийн гүйцэтгэлийг батлахаар мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй уялдуулан хэлэлцэнэ гэж тус тус заасан хэдий ч энэ онд Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жил тохиосон учраас Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганыг 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр завсарлуулж, дээр дурдсан хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж амжаагүй байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсэгт заасны дагуу 2020-2024 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүдийн хэлэлцүүлгийн аль шатад байгаагаас үл хамааран хууль санаачлагчид нь буцаасан. Иймээс хуульд хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь тусгайлан заасан зарим асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгууль явагдах жилд өмнөх Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж амжаагүй тохиолдолд шинээр бүрдэж, бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурал хэлэлцэн

шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлд хэлэлцэн шийдвэрлэх хугацааг нь хуульд тусгайлан заасан асуудлыг Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн жилийн хаврын чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол шинээр бүрдсэн Улсын Их Хурал тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болох зохицуулалтыг нэмэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Батсүмбэрэл, Сайнзориг, Тэмүүжин, Энхтуяа, Цогтбаатар нараас 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдөр өргөн мэдүүлснийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслийн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа танилцуулна. Индэрт урьж байна.

А.Ариунзаяа: Эрхэм Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар, Батсүмбэрэл, Сайнзориг, Тэмүүжин, Цогтбаатар, Энхтуяа нараас 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Ёс зүй, дэгийн байнгын хороо 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы үеэр Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг өөрчилж өөрсдөө тогтоох санал

гарч байсныг дурдан асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал уг хуульд тодорхой хугацаа зааж өгөх, Улсын Их Хурлын гишүүн Рэгдэл тухайн хуулийг удаагийн шинжтэйгээр баталж мөрдүүлэх нь зүйтэй гэдэг саналыг тус тус хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Асуулт Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Б.Батбаатар: Энэ Их хурлын дэгийн тухай хууль өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор Улсын Их Хуралд сонгуулиар нэр дэвшиж өрсөлдсөн улс төрийн нам, эвсэл 5 субъект байгаа. Энэ 5 субъектээс 3 нь бүлэггүй байгаад байгаа юм. Нөгөө бүлгийн хязгаар босго тавьсан тоог. Тийм болохоор нэгэнт Дэгийн тухай хууль хэлэлцэж байгаа дээрээ үүн дээр Их Хурлын дарга анхаарал

тавиад, ажлын хэсэг гаргаад бүлэгтэй болох ажлыг хийвэл яасан юм. Амарбаясгалан даргаас асууж байна.

Д.Амарбаясгалан: Би чинь хариулах эрхгүй шүү дээ. Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга хариулна. Баасандорж дарга хариулъя.

Б.Баасандорж: Баасандорж. Батбаатар гишүүний асуултад хариулъя. Сая Баярбаатар нарын гишүүдийн өргөн барьсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа. Сая Батбаатар гишүүний ярьж байгаа асуудал бол Их Хурлын тухай хуулийн бүлэг байгуулахтай холбоотой асуудлыг ярьж байна. Тэгэхээр Их Хурлын тухай хуулийн асуудлыг энэ хэлэлцэж байгаа асуудлаар яриагүй учраас энэ дээр хэлэлцэх боломжгүй гэж үзэж байна. Дэгийн хуулийн асуудлыг ярьж байгаа.

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн тодруулъя.

Б.Батбаатар: Иргэний Зориг Ногоон нам, Үндэсний Эвсэл, ХҮН нам. Би бол 118-ын бүлэгт бол нэг шаардлага тавиад л байгаа шүү дээ. Яах вэ, энэ Их Хурал өөрөө процессоо гүйцээгээд явахаар асуудал байна уу, үгүй юу гэдэг дээр нь анхаарал тавина. Цэц дээр очих ёстой юу, үгүй юу гэдэг дээр нь анхаарал тавина. Уг нь нэгэнт сонгуулийн үр дүнгээр парламентын босгыг даваад ороод ирсэн учраас бүлэгтэй болох тал дээр нь бид нар яах вэ юу саяын тэр дэгийн тухай хууль дээр асуудал байхгүй гэж үзэж байвал төслийг нь санаачлаад оруулчхаж болно л доо. Тэгээд яаралтай горимоороо яг үүнтэй адилхан ингээд хэлэлцэх талд нь Их Хурлын даргыг анхаарч үзээсэй гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Анхаарч үзье. Бас тэгээд хэдүүлээ ажлын хэсэг байгуулах боломжтой эсэх, судлах, дүгнэх тэр чиглэл дээр хамтарч ажиллая.

Дараагийн хүн Өлзийхүүгийн Шижир гишүүн алга байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу Улсын Их Хурлын гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Нэр ирсэн үү. Батын Батбаатар гишүүн үг хэлэх юм байна. Татаж байна. Индэр дээрээс очиж үг хэлэх ёстой. Нэрээ татлаа. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулах ёстой байгаа.

Тэгээд өмнөх асуудлын нэгэн адилаар Дэгийн тухай хуулийн 10.12 дахь заалтыг үндэслээд 1 дэх өдрийн 10 цагт хуралдах Улсын Их Хурлын чуулганаар санал хураалтыг явуулна.

01.07 цаг.

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлт.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

О.Мөнхсайхан: *Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,*

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн

Эрдэнэбулган, Гангабаатар, Мөнхсайхан, Энхтуяа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлтээ хийв. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 2 дугаар сарын 9-ний өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар дүгнэлт нь нийт 28 нүүр, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 16 нүүр болсон учраас та бүхэнд дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж, тогтоох эсэхийг бүхэлд нь уншиж сонсоё.

Үндэслэл. Монгол Улсын Их Хурлаас 2017 онд Цагдаагийн албаны тухай хуулийг баталсан. Тус хуулийн 4 дүгээр бүлэгт цагдаагийн байгууллага, алба хаагчийн тодорхой үйл ажиллагаа явуулах журмыг тусгаж, энэ хүрээнд 26 дугаар зүйлээр түр саатуулах ажиллагааг зохицуулжээ. Тус зүйлийн 26.1 дэх хэсэгт цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, цэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно гэж түр саатуулах ажиллагааны үндэслэл, хугацааны хязгаарыг тогтоож, харин 26.2 дахь хэсэгт энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно гэж заасан байна. Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан цагдаагийн алба хаагчийн зүгээс хэрэгжүүлэх түр саатуулах ажиллагаа нь хүний бие махбодын эрх чөлөөг хасдаг тул түүнийг

явуулах үндэслэл, журам нь тодорхой, хуульчлагдсан, тохирсон шүүхийн хяналтад байх шаардлагатай. Гэтэл түр саатуулах буюу хүний эрх чөлөөг хасахтай холбогдсон асуудлыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын баталсан хэм хэмжээний акт, журмаар зохицуулж байгаа нь үндсэн эрхийг зөвхөн хуульд заасан тодорхой үндэслэл журмаар хязгаарлах Монгол Улсын Үндсэн хуулийн шаардлагад нийцэхгүй байна.

Түүнчлэн мөн зүйлийн 26.2 дахь хэсгээр цагдаагийн алба хаагч түүнийг түр саатуулах байранд хүргэх хүртэл хэчнээн ч урт хугацаа зарцуулж, түр саатуулах байр гэдэгт өөр өөр агуулгаар ойлгож болох тодорхойгүй байдлыг үүсгэж түр саатуулах ажиллагааг үзэмжээрээ буюу дур мэдэн явуулах эрсдэлтэй байна. Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлиггүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуур тавигддаг.

Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасан хүнийг түр саатуулж болох хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцох зохицуулалт нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгод үйлчлэхээр уялдаатай байна. Гэвч бие махбодын эрх чөлөөг хэт урт хугацаагаар өргөн хүрээнд хасах боломж олгосон нь үндсэн эрхэд хамгийн бага халдсан арга хэмжээ биш байх бөгөөд улмаар зайлиггүй байх зарчим хангагдаагүй байна.

Мөн зүйлийн 26.2 дахь хэсэг нь гэмт хэрэгт холбогдоогүй байгаа хүнийг тус зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан хэт ерөнхий үндэслэлээр 6 цагаас илүү урт хугацаагаар түр саатуулах нь үүний цаана зөрчигдөж буй бие махбодын эрх чөлөөнөөс дээгүүр ашиг сонирхол гэж үзээгүй байх тул тэнцвэрийн зарчимд нийцэхгүй байна.

Иймд тус зүйлийн 26.2 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтаар баталгаажсан халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчиж, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгээр хүлээсэн үүргээ төр биелүүлээгүй гэж үзэхээр байна.

Түр саатуулах ажиллагааг хуулиар зөвшөөрсөн тохиолдолд энэ нь эрх чөлөөг хасах бусад ажиллагаа, тухайлбал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүнийг баривчлах, цагдан хорихтой адил түвшний тодорхой үндэслэлд, нарийвчилсан журам, төвийг сахисан бодитой хяналтаар хэрэгжихээр хуульчлагдсан байх учиртай. Гэтэл Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу хүнийг түр саатуулж, эрх чөлөөг нь хасахдаа эрх зүйн тодорхой байдлыг болон тохирсон байх зарчмыг алдагдуулж, цагдаагийн алба хаагч уг арга хэмжээг хэт ерөнхий үндэслэлээр явуулахаар хуульчилсан нь үзэмжээрээ буюу дур мэдэн хэрэгжүүлэх эрсдэл үүсгэж байна. Өөрөөр хэлэх юм бол Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн үндэслэл нь 2017 оны Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн эрх чөлөөг хасах арга хэмжээний үндэслэлтэй давхацсан шинжтэй. Хэт ерөнхий байгаа учраас эрх зүйн тодорхой байдал алдагдаж цагдаагийн алба хаагч аль хуулийнх нь дагуу эрх чөлөөг хасахаа үзэмжээрээ дур мэдэж шийдвэрлэх, улмаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо дахь хүний эрхийг хамгаалсан нарийвчилсан журмаас зайлсхийх зорилгоор түр саатуулах ажиллагааг урвуулан ашиглах боломжтой байна.

Түүнчлэн түр саатуулах ажиллагаанд шүүхийн үр нөлөөтэй хяналт хэрэгжихээргүй байх бөгөөд одоогийн хяналтын тогтолцоо нь төвийг сахисан бодитой байх шаардлагад нийцэхгүй байна. Тухайлбал, уг хуулийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж заасан ч түр

саатуулагдсан нь хууль ёсны эсэхийг хянуулахаар шүүхэд гомдол гаргах зэрэг эрхээ хэрхэн хэрэгжүүлэхийг нарийвчилсан журам хуульчлаагүй байна. Уг гомдлыг шүүх хойшлуулахгүйгээр шийдвэрлэх талаар тусгаагүй байна.

Мөн саатуулагдсан хүнд холбогдох үндсэн эрхийг баталгаатай эдлүүлэх нарийвчилсан зохицуулалтыг хуульчлаагүй байна. Тухайлбал, уг хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэхээр ерөнхий заасан ч хэзээ мэдэгдэх тухай, ялангуяа түр саатуулсан шалтгаан, үндэслэлийг түр саатуулсан үед нь мэдэгдэх талаар тусгайлан хуульчлаагүй байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт хүнийг түр саатуулсан даруй тухайн хүний талаар 18 насанд хүрсэн гэр бүлийн гишүүн, өмгөөлөгч, ойр дотнын хүнд нь мэдэгдэхээр заасан ч эдгээр хүмүүст юуг мэдэгдэх тухай, тухайлбал, түр саатуулсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэх тухай тодорхой үүрэгжүүлээгүй байна.

Уг хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт цагдаагийн алба хаагч нь авсан арга хэмжээтэй холбогдсон хүнд өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй гэж заасан ч хэзээ тайлбарлаж өгөхийг хуульчлаагүй учраас эдгээр эрхийг баталгаатай эдэлнэ гэдгийг нь саатуулах үед нь буюу нэн даруй тухайн хүнд ойлгомжтойгоор мэдэгдэх шаардлага хангагдаагүй байна.

Түүнчлэн, түр саатуулсан шалтгаан, үндэслэлийг гэр бүлийнхэн болон өмгөөлөгчдөө мэдэгдэх, тэдгээртэй холбоо тогтоох, баривчилсан эсвэл саатуулсан нь хууль зөрчсөн эсвэл дур мэдсэн эсэхийг шүүхээр хянуулах, гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ

эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, зүй бус хандсан, эсвэл эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уг эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах эрхийг мэдэгдэх талаар тодорхой тусгаагүй байна.

Иймээс Цагдаагийн албаны тухай хуулийн түр саатуулах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчимд нийцэхгүй байна.

Монгол Улсын үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон Монгол Улсын үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь.

Нэг. Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтад халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгаа бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Хоёр. Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно гэж заасныг Үндсэн хуулийн цэцийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2024 оны 6 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Гурав.Энэ дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд
Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар,
О.Мөнхсайхан, Э.Энхтуяа.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Баасанжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг 2024 оны 6 сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2024 оны 8 сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг агуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Н.Алтанхуяг, Х.Баасанжаргал, Д.Цогтбаатар нар үг хэлж, байр сууриа илэрхийлсэн.

Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, сэрдэгдэж байгаа хүнийг нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно.” гэж заасан бөгөөд 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт “энэ хуулийн 26.1-д заасан хугацааг түр саатуулах байранд хүргэснээс эхлэн тооцно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшигөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасныг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 3 дугаар дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооны саналаар санал хураалт явагдах ёстой. Тэгээд өмнөх асуудлын нэгэн адил Дэгийн тухай хуулийн 10.12 дахь заалтыг үндэслэн 19-ний өдрийн 10 цагт үргэлжлэх Улсын Их

Хурлын нэгдсэн чуулганы хуралдаан дээр санал хураалтыг явуулна. 19-ний өдрийн 10 цаг хүртэл чуулганы нэгдсэн хуралдаан завсарласныг мэдэгдье.

01.30 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ